

БАХАУЛЛА  
БА ШИИՆԻ ԶՐՄԻ



ՀԱՅԿԱՍՏԱՆԻ  
ՄԱՐԿԱԿԱՆ  
ՊԱՐԿԱՆ

Յ.Զ. ԶՍՏԵՄՈՒՄԻ

© Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга

*Англи хэлнээс орчуулав.*

*Гурав дахь хэвлэл*

**Ж.Э.Эселемонг**  
**Бахаулла ба шинэ эрин**

Цаасны хэмжээ: 60x84 1/16  
Хэвлэлийн хуудас: 19.25 х.н.х

Хэвлэсэн тоо: 1500

Эхийг “Кармел” хэвлэлийн газарт бэлтгэж,  
“Бэмби сан” ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Улаанбаатар хот

2014 он

---

## ОРШИЛ

1914 оны 12 дугаар сард миний бие Абдул-Бахатай уулзаж учирсан хэсэг нөхөдтэй ярилцаж, танилцуулгын товхимол авч уншсанаар анх Бахайн сургаалтай танилцсан билээ. Би тэр даруй уг сургаалын бүрэн дүүрэн хүч чадал, гоо үзэсгэлэнг мэдэрсэн бөгөөд өөр бусад шашны номлолыг бодвол орчин үеийн ертөнцийн агуу их шаардлага хэрэгцээнд илүү бүрэн дүүрэн тохирч байгаа юм шиг санагдсан юм. Хожим илүү нухацтай судалснаар миний итгэл улам бэхжин гүнзгийрсэн билээ.

Эл хөдөлгөөний талаар илүү ихийг мэдэх хүсэлдээ автан ном зохиол нэлээд хайсан боловч харамсалтай нь төдийлөн олдоогүй тул бусдын эрэл хайгуулд тус больюу гэсэн үүднээс өөрийн дуулж мэдсэн бүхнээ ном болгон эмхэтгэхээр шийдсэн юм. Дайны дараа Палестинтэй харилцах харилцаа дахин сэргэхэд би Абдул-Бахад захидал бичиж, номынхоо эхний есөн бүлгийн нооргийг хавсарган явуулсан юм. Хэсэг хугацааны дараа надад маш эелдэг бөгөөд урам хайрласан хариу ирсэн бөгөөд номынхоо бүрэн гар бичмэлтэй хамт Хайфад хүрэлцэн ирэхийг урьсан байлаа. Энэхүү урилгыг би сэтгэл дүүрэн хүлээн авч 1919-1920 оны өвөл хоёр сар гаруй Абдул-Бахагийн гэрт зочлох агуу их завшаан тохиолдсон юм. Энэ хугацаанд Абдул-Баха надтай энэхүү номын талаар хэд хэдэн удаа ярилцсан бөгөөд түүнийг сайжруулах талаар үнэтэй зөвлөгөө өгсөн юм. Түүнчлэн гар бичмэлээ хянан найруулсны дараа түүнд явуулбал Перс хэл рүү орчуулан уг номыг дахин уншиж, шаардлагатай бол дахин хянан засварлаж болох юм хэмээн санал болгосон билээ.

Тийнхүү номын хяналт, орчуулга түүний зөвлөсөн ёсоор явагдсан бөгөөд Абдул-Баха насан хутгийг олохынхоо өмнө зай засваргүй ажлынхаа дундуур гурван бүлэг гаруйг нь (I, II, V ба III бүлгийн хагас) хянан засварлаж өгсөн юм. Абдул-Баха номыг бүхэлд нь хянаж чадсан бол энэхүү номны үнэ цэнэ асар ихээр нэмэгдэх байсан тул ингэж чадаагүйд би гүнээ харамсаж явдаг юм. Гэхдээ гар бичмэлийг бүхэлд нь Английн Бахайчуудын Үндэсний Чуулгын хорооноос хянаж, мөн тус Чуулгаас эрхлэн

хэвлүүлсэн билээ. Энэ ажлыг гүйцэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан хатагтай Е.Ж.Розенберг, Клаудиа С.Клоулс, ноён Мирза Литфулла Хаким, Рой Вильгельм, Маунтфорт Миллс болон сайхан сэтгэлтэй бусад олон иайз нөхдөдөө талархал илэрхийлье.

Араб, Перс нэрүүдийн галиглалын хувьд гэвэл, саяхан Шоги Эффендигээс Бахайн ертөнц даяар мөрдөхийг санал болгосон галигийн системийг ашигласан болно.

Ж.Э.Эсслемонт  
Фэйрфорд, Култс, Абердин



---

## ГАРЧИГ

ОРШИЛ	.....3
БҮЛЭГ	
1. БАЯРТ МЭДЭЭ	..... 6
2. ЭХЛЭЛ ТАВИГЧ БАБ	.....16
3. БАХАУЛЛА-БУРХАНЫ АЛДАР	.....29
4. АБДУЛ-БАХА: БАХА-Н ЗАРЦ	.....58
5. БАХАЙ ГЭЖ ЮУ ВЭ?	.....79
6. МӨРГӨЛ	..... 98
7. ЭРҮҮЛ МЭНД БА АНАГААХ ЁС	.....112
8. ШАШНЫ ЭВ НЭГДЭЛ	.....128
9. ЖИНХЭНЭ СОЁЛ ИРГЭНШИЛ	.....146
10. ЭНХ ТАЙВАНД ХҮРЭХ ЗАМ	.....171
11. ЯНЗ БҮРИЙН СУРГААЛ НОМЛОЛ	.....191
12. ШАШИН БА ШИНЖЛЭХ УХААН	.....214
13. БАХАЙН ХӨДӨЛГӨӨНД БИЕЛТЭЭ ОЛСОН ЗӨГНӨЛ АЙЛДВАРУУД	.....230
14. БАХАУЛЛА, АБДУЛ-БАХА НАРЫН МЭРГЭН ЗӨГНӨЛ	.....254
15. ӨНГӨРСӨН БА ИРЭЭДҮЙ ТӨГСГӨЛИЙН ҮГ	.....273 ..... 305

## Нэгдүгээр Бүлэг

### БАЯРТ МЭДЭЭ

*“Дэлхий бүх ард түмний хүсэн мөрөөдсөн Амлагдсан Элч залран ирлээ. Бүх хүн ард Үүдэл нээлтийг хүсэн хүлээж байсан бөгөөд Бахаулла болбоос хүн төрөлхтний агуу их багш, соён гэгээрүүлэгч бөлгөө”*

Абдул-Баха

#### Түүхийн Агуу Их Үйл Явдал

Түүхийн хуудаснаа өгүүлсэн “хүний дэвшил”-ийн замыг судалж үзвээс хүний хөгжил дэвшлийн гол хүчин зүйл бол цаг үеийнхээ үзэл бодлоос дээгүүр зогсож, урьд өмнө нь хүн төрөлхтөнд мэдэгдээгүй байсан үнэнийг нэгч хүмүүс үе үе дэлхий ертөнцөд тодордог явдал юм гэдэг нь ойлгогдоно. Шинийг зохион бүтээгч, аливааг анхлан үүсгэгч, суут ухаантан, зөнч мэргэн эдгээр хүмүүсээс дэлхий ертөнцийн өөрчлөлт хувьсалт нэн тэргүүнд шалтгаална. Карлайлын хэлснээр:

*“Дээд Мэргэн ухааныг эзэмшсэн, урьд өмнө нь үл мэдэгдэж байсан оюун санааны Үнэнийг өөртөө агуулсан Хүмүүн нь энэ Үнэнийг олоогүй арван хүн юм уу арван мянга ч биш, харин ийм Үнэнийг олоогүй бүх хүмүүсээс илүү хүчтэй байх бөгөөд ямар ч бамбай, ямар ч цайз цохилтыг нь дааж чадахааргүй Тэнгэр диваажингийн сэлэмтэйн адил хүмүүсийн дунд сахиусан тэнгэрийн соронзон хүч чадлыг цацруулна... Үүнийг бид эгэл, маш эгэл үнэн гэж боддог бус уу.” “Signs of the Times”*

Энэхүү үнэний олон нотолгоог бид шинжлэх ухаан, урлаг соёл, дуу хөгжмийн түүхээс хардаг боловч агуу их хүний нөлөө, илгээмж нь шашинд байдаг шиг хаана ч тийм тодорхой байдаггүй. Хүмүүсийн оюун санааны амьдрал, ёс суртахуун доройтох бүх цаг үед хүмүүсийн дундаас хамгийн гайхамшигт, нууц оньсого мэт зөнч мэргэн хүмүүн тодордог билээ. Түүнийг түшин жолоодох, бүрэн ойлгох, хариуцлагаас нь хуваалцах нэгч хүний тусламжгүйгээр тэрээр бүх дэлхийн эсрэг ганцаараа яг л

сохор хүмүүсийн дунд байгаа цорын ганц хараатай хүний адил үнэн ба буяны дууллыг өргөхөөр босдог байна.

Зөнч мэргэдийн дотроос зарим нь онцгой суу билгийг эзэмшсэн байдаг. Хэдэн зуун болоод Кришна, Зороастр, Моисей, Есүс, Мухаммед зэрэг агуу Тэнгэрлэг Айлдагч Дорнын тэнгэрт оюун санааны Нар болон мандаж, хүмүүсийн харанхуй бодол ухааныг гэгээрүүлж, нойрмог зүрх сэтгэлийг нь сэргээдэг. Шашны эдгээр үндэслэгчдийн хэн нь илүү агуу вэ гэдэг асуудлаар бидний санал бодол ямар ч байлаа гэсэн Тэд хүн төрөлхтнийг соён гэгээрүүлэхэд хамгийн хүчирхэг хүчин зүйл болж байсан гэдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Тэдний айлдаж буй үгс өөрсдөөс нь гарч байгаа бус, харин тэднээр дамжин илэрч байгаа Үүдэл нээлт, тэдний тээж яваа Тэнгэрлэг илгээмж юм гэдэгт бүгд дуу нийлдэг. Тэдний айлдвар судруудад дэлхийн агуу их багш “сайн цагийн эхэнд” заларч, тэдний үйл хэргийг үргэлжлүүлж, цэцэглүүлэн хөгжүүлж, газар дэлхий дээр энх тайван, шударга ёсны ноёрхлыг тогтоож, бүх улс түмэн, шашин, омог үндэстнийг нэгэн гэр бүлд нэгтгэж, “*нэг Эзэнтэй нэгэн сүрэг*” бий болж, бүгд Бурханыг танин мэдэж, Бурханыг хайрлана гэж зөгнөн айлдсан байдаг юм.

“Хүн төрөлхтнийг Гэгээрүүлэгч” хожмын өдрүүдэд залран ирэх нь хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн агуу үйл явдал болох ёстой нь мэдээж. *Энэхүү Гэгээрүүлэгч үнэн хэрэгтээ залраад байгаа бөгөөд Түүний Үүдэл нээлт тодорч, ном сударт бичигдсэн тул үнэнийг эрэлхийлэгч хүмүүн “Эзэн тэнгэрийн Өдөр” гэгээрч, “Буяны нар” мандсаныг харах боломжтой боллоо гэдгийг Бахайн Хөдөлгөөн дэлхий дахинаа зарлан тунхаглаж байна.* Хэдийгээр уулын оройд хүрсэн цөөн хэдэн хүн л Ялгуусан Гэрлийн тойргийг олж харсан боловч түүний цацраг нь тэнгэр газрыг гэрэлтүүлэн уулын цаанаас цухуйж, тал хөндийг дүүрэн гийгүүлж, хамаг бүхэнд амьдрал хайрлаж, замыг нь зааж байна.

### Өөрчлөгдөж буй Дэлхий ертөнц

Арван есдүгээр зуун болон хорьдугаар зууны эхэн үед<sup>1</sup> хуучин эрин үхлийн заагт хүрч, шинэ эрин үе төрөх гэж дуншиж буй нь

<sup>1</sup> Уг номыг Дэлхийн Нэгдүгээр Дайны дараахан үед бичсэн юм.

хэн бүхэнд тодорхой байлаа. Өөрсдийн бүтээсэн эвдэрхий балгас дунд материализм, хувиа хичээх үзлийн хуучирсан зарчим, хуучин сектант (шашны явцуу үзэл-орч) ба хэт патриот (эх оронч) атгаг сэжиг, үзэн ядах үзэл балран алга болж, оронд нь ах дүүгийн барилдлагаа, олон улсын найрамдлын шинэ шүтлэгийн шинж тэмдгүүд хаа сайгүй илэрч, хуучин холбоо сүлбээ, хуучин хил хязгаарыг устгаж байна. Хүний амьдралын салбар бүрт урьд өмнө нь үзэгдэж байгаагүй асар их өргөн хувьсгалт өөрчлөлт гарч байна. Гэхдээ хуучин эрин арай мөхөөгүй, шинэ эрин үетэй амь наана, там цаана гэж тэмцэлдэж байна. Нүгэл, муу муухай явдал асар их хэмжээнд үй олноороо оршоор байгаа боловч түүнийг шинэ эрч хүч, шинэ итгэл найдвар сөрөн зогсож байна. Үүлнүүд асар зузаан, аюултай байгаа хэдий ч гэрэл гэгээ түүнийг нь нэвтлэн задалж, хөгжил дэвшлийн харгуйг гийгүүлж, урагшлах замыг тагласан нүх сүв, саад тогтор бүхнийг илрүүлж байна.

Арван наймдугаар зуунд байдал өөр байлаа. Тэр үед газар дэлхийг бүрхсэн оюун санааны болон ёс суртахууны доройтлыг гэрлийн нэг ч цацраг гийгүүлж чадахтай үгүйтэй байв. Энэ бол үүрийн цолмон гэгээрэхийн өмнөх гүн харанхуй цаг байсан бөгөөд үлдсэн цөөхөн хэдэн дэнлүү, лаа гэрэл цацруулж байсан ч бүх л харанхуйг гэрэлтүүлэх чадалгүй болсон үе байв. “Агуу Фредерик” номондоо арван наймдугаар зууны талаар Карлайл ингэж бичиж байжээ:

*“Ямар ч түүхгүй, тун бага эсвэл ямар ч түүхтэй байж чадахааргүй зуун байлаа. Худал хуурмаг явдлаар элбэг баян ийм зуун... урьд нь хэзээ ч байгаагүй! Худал хуурмаг байгаагаа ухамсарлахаа больж, улмаар худал хуурмаг явдал өсөн бойжиж, эрин зуун өөрөө худал хуурмагт умбаж, худал хуурмагаар яс махандаа шингэтэл дүүрсэн байсан бөгөөд Францын хувьсгал үүнийг зогсоох ёстой байв.... Энэ бол ийм зуунд яг тохирсон төгсгөл байсанд би их баярлаж байна.... Учир нь, хүмүүний сул үлбэгэр, мунхаг үр садад хөөрхийлөлтэй байдалд бүгдээрээ живэхгүйн тулд Тэнгэрлэг Үүдэл нээлт дахин шаардагдаж байсан юм”- “Агуу Фредерик”, 1-р дэвтэр, 1-р бүлэг*

Арван наймдугаар зуунтай харьцуулах юм бол өнөөгийн эрин цаг харанхуйн дараах үүрийн цолмон, өвлийн дараах хавар цаг

лугаа адил юм. Дэлхий ертөнцөд шинэ амьдрал буцалж, шинэ үзэл санаа, шинэ итгэл найдвар дүүрч байна. Хэдхэн жилийн өмнө биелэшгүй мэт санагдаж байсан хүсэл мөрөөдөл эдүгээ хэрэгжин биелжээ. Хэдэн зууны дараа л биелмээр байсан бусад зүйлс эдүгээ өдөр тутмын “ахуйн асуудал” болон хувираад байна. Бид агаарт нисч, усан доогуур аялж байна. Бид гэрлийн хурдаар дэлхийг тойрон бие биедээ илгээмж явуулж байна. Хэдхэн арван жилийн дотор бид тоолж баршгүй олон гайхамшгийг бүтээжээ.

### Буяны Наран

Дэлхий ертөнц гэнэт ингэж сэргэсний учир шалтгаан юунд байв? Энэ нь Ариун Сүнс Зөнч мэргэн Бахауллагаар дамжин тодорсны ач юм хэмээн Бахайчууд итгэдэг. Бахаулла 1817 онд Перс улсад мэндлээд 1892 онд Ариун Газар таалал төгссөн юм.

Бахаулла айлдахдаа, нар, байгаль дэлхийд гэрэл гэгээ авч ирдгийн адил Зөнч мэргэн буюу “Бурханы Тодруулагч” нь оюун санааны ертөнцийн Гэрэл гэгээг бидэнд авч ирдэг гэсэн юм. Бодит нар газар дэлхийг ээж, байгалийн бодгаль биесүүдийг өсгөн хөгжүүлдгийн адил Тэнгэрлэг Тодруулагч буюу Үнэний Наран хүмүүний зүрх сэтгэлийн ертөнцийг гийгүүлж, хүмүүний ухаан бодол, ёс суртахуун, зан чанарыг нь хүмүүжүүлдэг юм. Байгаль дэлхийн нарны цацрагууд хамгийн харанхуй, сүүдэртэй газруудыг хүртэл нэвт гэрэлтүүлж, нарыг амьдралдаа үзээгүй амьд амьтдад ч хүртэл илч дулаан, амьдрал хайрлах нөлөөтэйн адил Бурханы Тодруулагчаар дамжин Ариун Сүнс нь хамаг бүхний амьдралд нөлөө үзүүлж, Зөнч мэргэний нэрийг дуулаагүй газарт ч хүртэл хүмүүсийн оюун бодолд онгод хайрладаг. Энэ бол оюун санаагаар үхэгсэд амь орж, Тэнгэрлэг шашнуудын Мөн чанар шинэчлэгдэж, “*шинэ тэнгэр диваажин, шинэ газар дэлхий*” бий болох Сэргэн мандалтын өдөр болой.

Гэхдээ байгалийн ертөнцөд хавар цаг ирэхэд юм бүхэн өсөн өндийж, шинэ амьдрал сэргэдэг хэдий ч хуучин, үеэ өнгөрөөсөн зүйлс нуран устдаг жамтай. Учир нь, цэцэгсийг дэлбээлүүлж, мод ургамлыг нахиалуулдаг мөнөөх нар нь мөн хэрэгцээгүй болж үхсэн зүйлсийг задраан устгадаг. Энэхүү нар өвлийн цас

мөсийг хайлуулж, үер, салхи шуургыг буулгаж, газар дэлхийг ариусган шинэтгэдэг. Оюун санааны ертөнцөд ч мөн адил. Оюун санааны нар нь мөн адил нөлөөллийг үзүүлж, юм бүхнийг өөрчлөн шинэчилдэг. Тийнхүү Сэргэн мандалтын Өдөр нь мөн Шүүлтийн Өдөр болж, үнэний авлига, худал хуурмаг бүхэн, хуучирч элэгдсэн үзэл санаа ба зан заншил нь орхигдон устаж, атгаг сэжиг, ялгаварлан гадуурхах үзэл, мухар сүсгийн цас мөс хайлж, он удаан жилийн турш хөлдүү хэвээр байсан эрч хүч шинээр чөлөөлөгдөж, дэлхий ертөнцийг бүхэлд нь хувьсгадаг.

### Бахауллагийн Ариун үүрэг

Бахаулла удаа дараалан маш тодорхой зарлан тунхаглахдаа, *"Би бол бүх улс түмний он удаан жил хүсэн хүлээсэн соён гэгээрүүлэгч бөгөөд өмнө нь байсан бүхнээс халин шашны өмнөх хэлбэрүүдийг нэгтгэн, нэгэн тэнгис далайд нийлүүлэх гайхамшигт Гоо Жавхлангийн суваг юм"* хэмээн айлджээ. Тэрээр дэлхий даяар Эв Нэгдлийн бат бэх үндэс суурийг тавьж, зөнч мэргэдийн зөгнөн айлдаж, яруу найрагчдын мөрөөдөн дуулсан газар дэлхий дээр энх тайван, сайн санаа залрах ялгуусан тэр эрин үеийг эхлүүлсэн юм.

Үнэнийг бие даан эрэлхийлэх, хүн төрөлхтний эв нэгдэл, шашин шүтлэг, омог үндэстэн, өрнө дорны улс түмнүүдийн эв нэгдэл, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн эрх тэгш ёс, шударга ёс, үнэн мөн тогтох, шашин шинжлэх ухаан хоёр эвлэрэх, ялгаварлан гадуурхах үзэл ба мухар сүсэг устах, олон улсын шүүх байгуулагдах, нэгдмэл хэл яриа бий болох, эрдэм мэдлэг нийт олноо түгэн дэлгэрэх гэх мэт өдий төдий сургаал нь арван есдүгээр зууны сүүлийн хагаст Бахауллагийн мутраар тоо тоймшгүй ном сударт нээгдсэн бөгөөд зарим сургаалыг Тэрээр дэлхийн хаад удирдагч нарт хандаж бичсэн байдаг юм.

Амьдралын бүхий л сэдвийг хөндсөнөөрөө өвөрмөц хосгүй Түүний илгээмж нь цаг үеийн шинж тэмдэг, хэрэгцээ шаардлагатай гайхалтай нийцэж байгаа юм. Хүмүүсийн өмнө тулгамдаж буй асуудлууд нь хэзээ ч ийм олон, хоорондоо зөрчилтэй байсангүй. Дэлхийд агуу багш байх шаардлага хэзээ ч ийм хурц тавигдаж



байсангүй. Магадгүй, ийм багшийг хэзээ ч ингэж итгэл дүүрэн хүсэн хүлээж байгаагүй байж болох юм.

### Зөгнөл айлдварын биелэл

*"Хорин зууны өмнө Христ залран ирэхэд, Иудейчүүд хэдийгээр Түүний залрахыг хүсэн хүлээж, өдөр шөнөгүй нулимс асгаруулан: "Бурхан минь, Мессиягийн Үүдэл нээлтийг түргэтгэж өгч хайрла" хэмээн залбирч байвч Үнэний Наран үүрийн цолмон болон гэгээрэхэд тэд Түүнийг үгүйсгэж, Түүний эсрэг дайсагнан босож, эцэст нь тэрхүү тэнгэрлэг Сунс, Бурханы Үгийг цовдлон хороож, ариун сударт бичсэнээр Түүнийг Вельзевул буюу чөтгөр шүглэсэн нэгэн хэмээн нэрлэжээ. Ингэсний учир нь тэдний хэлж байгаагаар бол: "Тора" сударт тодорхой заасанчлан Христийн Үүдэл нээлт нь хэд хэдэн шинж тэмдгийг илэрхийлэх ёстой. Хэрэв эдгээр шинж тэмдэг илэрч чадахгүй бол өөрийгөө Мессия гэж хэлсэн хүн хууран мэхлэгч болно. Эдгээр шинж тэмдэг нь гэвэл, нэгдүгээрт Мессия үл мэдэгдэх газраас ирэх ёстой, гэвч энэ хүний гэр Назаретад байдаг гэдгийг бид бүхэн мэднэ. Назаретаас ямар нэгэн сайн юм гарна гэж байх уу даа? Хоёрдугаарт, Тэрээр төмөр ташуур барин захирах ёстой, өөрөөр хэлбэл сэлэмтэй байх ёстой атал энэ Мессияд болохоор ямар ч төмөр зүйл алга. Бас нэгэн нөхцөл бол Тэрээр Давидын сэнтийд залран, Давидын ноёрхлыг тогтоох ёстой. Одоо тэгсэн чинь, энэ хүн ямар нэгэн сэнтийд залрах байтугай суух гудас ч үгүй байна. Өөр нэгэн нөхцөл бол Мессия "Тора"-гийн хуулиудыг дэлгэрүүлэх ёстой. Гэтэл энэ хүн тэрхүү хуулиудыг үгүйсгэж, тэр ч байтугай өөрийгөө зөнч мэргэн хэмээж, янз бүрийн ид шид үзүүлж, хүн "шабат" өдрийг зөрчвөл үхэх ял тулгагдах ёстой гэж "Тора"-д бичсэн байтал "шабат" өдрийг зөрчлөө. Бас нэгэн шинж тэмдэг нь юу байх вэ гэвэл, Мессия ноёрхсоноор шударга ёс тогтоож, буянт сайхан чанар хүмүүсээс гадна амьтны ертенцөд ноёрхож, могой, хулгана хоёр нэг нүхэнд амьдарч, бүргэд, ятуу хоёр дундаа нэг үүр засч, арслан зээр хоёр нэг бэлчээрт бэлчээрлэж, чоно хурга хоёр нэг горхиноос ус уух ёстой. Гэтэл одоо шударга бус байдал, дарангуйлал газар аван, тэр ч бүү хэл, тэрээр өөрөө цовдлогдлоо шүү дээ! Өөр нэгэн болзол нь Мессия залрах үед Иудейчүүд элбэж*

хангалуун амьдралтай болж, дэлхийн бүх ард түмнийг ялах ёстой байтал одоо тэд туйлын гутамшигт байдалд амьдарч, Ромын эзэнт гүрний боолууд болсон байна шүү дээ. Тэгэхлээр энэ хүн яаж “Тора”-д зөгнөн айлдсан Мессия байж чадах юм бэ?” гэж байв.

“Тэрхүү Бурханы хүмүүн үнэнхүү “Тора”-д зөгнөн амласан Хүмүүн мөн байсан атал тэд ингээж Үнэний Наранг үгүйсгэжээ. Гэвч тэд тэдгээр шинэж тэмдгийн учир утгыг ойлгодоггүй байсан тул Бурханы Үгийг цовдлон хороожээ. Бахайчууд эдүгээ тэдгээр шинэж тэмдгүүдийг Христ илэрхийлсэн гэж үздэг, гэхдээ Иудейчүүдийн ойлгож байсан тэр утгаар биш, учир нь “Тора”-д бичсэн дүрслэл нь ёгтлол байсан юм. Жишээлбэл, ноёрхох тухай шинэж тэмдэг байна. Бахайчуудын хувьд Христийн ноёрхол нь хурмаст тэнгэрийн эгүүрдийн ноёрхол болохоос биш хоромхон зуур үргэлжлэх Наполеоны ноёрхол биш юм. Учир нь хоёр мянган жил орчим Христийн ноёрхол оршиж ирсэн бөгөөд одоо ч хүртэл оршоор байгаа ба үүрдийн үүрд тэрхүү Ариун Хүмүүн сэнтийд залрах болно.

“Үүний адил бусад шинэж тэмдэг нь мөн биелсэн болой. Гэвч Иудейчүүд анзаарч ойлгоогүй юм. Христ тэнгэрлэг гоо жавхлангаараа заларснаас хойш эдүгээ хорин зуун өнгөрсөн хэдий ч тэд одоог хүртэл Мессияг хүсэн хүлээж, өөрсдийгөө үнэн, Христийг худал хэмээн тооцож байна” гэж Абдул-Баха энэ бүлэгт зориулан бичжээ.

Хэрэв Иудейчүүд Христэд итгэсэн бол Тэрээр тэдэнд зөгнөл айлдварын үнэн утга учрыг тайлбарлаж өгөх байсан. Тэдний жишээнээс сургамж аван, Хожмын өдрийн Соён гэгээрүүлэгч Бурханы Тодруулагчийн талаарх зөгнөл айлдвар биелсэнгүй гэж үзэхийн өмнө зөгнөл айлдварыг хэрхэн тайлбарлах талаар Бахауллагийн Өөрийнх нь бичсэн үгийг судалцгаая. Учир нь, ихэнх зөгнөл айлдвар нь “нуугдмал” байдаг бөгөөд Үнэн Соён Гэгээрүүлэгч Өөрөө л тэрхүү нуугдмал айлдварыг нээж, үгийн цогцолборт агуулагдсан тэрхүү жинхэнэ утга учрыг нь үзүүлэх ёстой юм.

Бахаулла өнгөрсөн үеийн зөгнөл айлдварын талаар олонтаа тайлбарлаж бичсэн боловч зөвхөн үүнд Түүний зөнч мэргэн

чанарын нотолгоо нь оршдоггүй юм. Нар мэдрэх чадвартай бүхэнд өөрийгөө өөрөөрөө нотолдог. Нар мандахад бид энд түүний гийж байгаа эсэхийг шалган тогтоох шаардлагагүй, нар өөрөө өөртөө нотолгоо болдог. Бурханы Тодруулагч залрах нь мөн нарны адил юм. Өмнөх зөгнөл айлдвар нь бүгд арилж мартагдсан байсан ч оюун санааны мэдрэмжээ нээсэн хүн бүхэнд Тэрээр Өөрийн биеэр хангалттай элбэг нотолгоо болдог.

### **Зөнч мэргэн чанарын нотолгоо**

Бахаулла Өөрийн мэдэгдэл, шинж тэмдгийг сохроор хүлээж авахыг хэнээс ч шаардаагүй юм. Харин ч Тэрээр аливаа зүйлийг сохроор хүлээж авахын эсрэг анхааруулгыг Өөрийн сургаалын төвд тавьсан бөгөөд хүн бүхнийг мэлмий, сонороо нээж, оюун ухаанаа дайчлан айх зүйлгүйгээр бие дааж үнэнийг эрэлхийлэх хэрэгтэй гэж айлдсан юм. Тэрээр Үүдэл нээлтийнхээ талаар бүрэн дүүрэн судлахыг бидэнд захисан бөгөөд сургаал бүтээл болон хүмүүсийн амьдрал, зан чанарт үзүүлж байгаа нөлөөг нь зөнч мэргэн чанарынхаа дээд нотолгоо болгосон юм. Энэ чанарыг тодорхойлохоор Түүний дэвшүүлсэн шалгуур нь өмнөх агуу Элч нарын шалгууртай адил билээ. Моисей хэлсэн нь:

*“Хэрэв зөнч мэргэн Эзэн тэнгэрийн нэрийн өмнөөс үг хэлээд үг нь биелээгүй бол тэр үгийг Эзэн тэнгэр хэлээгүй, гэвч зөнч мэргэн тэр үгийг итгэл дүүрэн хэлжээ. Тэгвэл та нар түүнээс бүү эмээ.” “Дөүторономи”, 18:22*

Христ уг шалгуурыг мөн л эгэл үгээр тайлбарлаж, түүгээр Өөрийн сургаалын үнэн худлыг шалгахыг айлджээ. Тэрээр хэлсэн нь:

*“Хонины арьс нөмөрсөн араатан чонотой адил хуурамч зөнч мэргэдээс болгоомжлогтун. Чи тэднийг үр жимсээр нь танина. Хүмүүс усан үзмийг үүргэнээс, манжинг лошгоноос хураадаг бшүү? Сайн мод бүр сайн үр жимс өгдөг бол хуурамч мод муу үр жимс өгдөг. ... Тиймээс үр жимсээр нь чи тэднийг танина”* Матай, 7:15-20

Дараачийн бүлгүүдэд бид Бахауллагийн зөнч мэргэн чанар эдгээр шалгуурыг давж байгаа эсэхийг, Түүний айлдаж сургасан

зүйлс биеллээ олсон эсэх, Түүний үр жимс нь сайн байв уу, муу байв уу, өөрөөр хэлбэл Түүний зөнч үгс биелсэн эсэх, зарлиг айлдвар нь бодитоор тогтоогдсон эсэх, Түүний насан туршдаа хийж гүйцэтгэсэн үйл хэрэг нь хүн төрөлхтний хөгжил дэвшил, соёл гэгээрэл, ёс суртахуунд хувь нэмрээ оруулж чадав уу, үгүй юу гэдгийг үзүүлэхийг хичээх болно.

### Судалгаанд тохиолдох бэрхшээл

Энэхүү Үйл хэргийн талаар үнэн ойлголтонд хүрэхийг эрмэлзэж байгаа хүний замд элдэв бэршээл тохиолдох нь ойлгомжтой. Ёс суртахууны болон оюун санааны бусад сургаалын адил Бахай Шүтлэгийг буруугаар ойлгуулсан явдал бий. Бахаулла болон Түүний дагалдагчдын амссан аймшигт мөрдлөг хавчлага, зовлон зүдгүүрийн талаар анд нөхөд нь ч, атаат дайсан нь ч санал нэг байдаг. Гэхдээ нэг талаас уг Хөдөлгөөний үнэ цэнэ, Үндэслэгч нарынх нь шинж чанар, сүсэгтэн олных нь үг болон нөгөө талаас үгүйсгэгчдийн яриа туйлын ялгаатай юм. Яг л Христийн үед байсан шиг. Есүс цовдлогдсон тухай болон Түүний шавь нарыг мөрдөн хавчиж, хороосон тухай Христийн ч тэр, Иудейн ч тэр түүхчид санал нийлдэг боловч Христ, Моисей болон бусад Зөнч мэргэдийн зөгнөл айдварыг биелүүлж, сургаалыг нь хөгжүүлсэн гэж сүсэгтнүүд нь магтсан байхад үгүйсгэгчид нь Христ тэдгээрийн хууль айлдварыг зөрчсөн тул үхвээс зохино гэж үзсэн байна.

Шашинд ч тэр, шинжлэх ухаанд ч тэр, “үнэт эрдэнийн сувдан сондор”-ыг авахын тулд өөрт байгаа бүхнээ золиослож, ялгаварлан гадуурхах элдэв атгаг санаа бодол, мухар сүсгээсээ татгалзсан, даруу төлөв бөгөөд хичээнгүй эрэлч хүн л үнэний нууцыг тайлдаг жамтай. Бахай Шүтлэг болон түүний бүрэн дүүрэн ач холбогдлыг ойлгохын тулд бид чин сэтгэлээсээ үнэнд тэмүүлж, эрлийнхээ замд туйлбартай байж, тэнгэрлэг удирдамжинд итгэл найдвараа даатган судлах хэрэгтэй. Уг Шүтлэгийн Үндэслэгч нарын сургаал бичмэлд бид энэхүү оюун санааны агуу сэргэн мандалтын нууц оньсогыг тайлж, үнэ цэнийг нь дүгнэх түлхүүрийг олох нь магад. Харамсалтай нь сургаал Перс, Араб хэлээр бичигдсэн байх тул эдгээр хэлд нэвтрээгүй суралцагчдад бас бэрхшээл учирч болох

юм. Учир нь зөвхөн сургаалын багахан хэсэг л Англи хэл рүү орчуулагдсан бөгөөд олон орчуулга утга чанарын хувьд тийм ч төгс төгөлдөр биш байгаа юм. Гэхдээ түүхийн мэдээлэл хийгээд орчуулгын дутагдлаас үл хамааран энэхүү Үйл хэргийн хүчирхэг, бат бөх үндэс суурийг бүрдүүлсэн амьн чухал үнэн сургаал нь тодорхойгүй байдлын<sup>1</sup> манан дундаас сүрлэг өндөр уул болон сүндэрлэж байна.

### Номын зорилго

Номын дараах бүлгүүдэд бид Бахай Шүтлэгийн түүх болон сургаалын хосгүй онцлог шинжийг аль болох өргөн дүүрэн хамарч, аль болох тодорхой дэвшүүлэн тайлбарлахыг оролдох бөгөөд уншигч та түүний ач холбогдлын талаар зөв үнэн дүгнэлтийг хийж, цаашид бие даан улам гүнзгий судлах эрмэлзэл төрөх буй заа.

Үнэнийг эрэлхийлэх явдал хэдийгээр маш чухал боловч амьдралын цорын ганц зорилго биш, мөн амьдралын төгсгөл ч биш юм. Үнэн гэдэг олсон даруйд музейд авч ирэн лацдаж, ангилан каталогт оруулж, цэвэрлэн ариутгаад үзмэр болгон тавиад орхих зүйл огт биш билээ. Үнэн гэдэг хүмүүсийн зүрх сэтгэлд үрээ үндэслүүлж, амьдралд нь үр жимс хайрладаг бөгөөд хүмүүс эрлийнхээ үр дүнд шагнал хүртдэг юм.

Тиймээс зөнч мэргэний үүдэл нээлтийг түгээн дэлгэрүүлэхийн жинхэнэ зорилго нь үнэн үгэнд нь итгэн сүсэглэсэн хүмүүс зарчим сургаалынх нь дагуу амьдралаа зохиож, баярт мэдээг түгээн цацаж, Бурханы Хүсэл зориг тэнгэр диваажинд суудлаа зассан шиг энэ газар дэлхий дээр биелэх тэрхүү ерөөлт өдрийг ойртуулахад оршино.

<sup>1</sup> Бахаулла, Абдул-Баха нарын Сургаал бичмэлийг перс, араб хэлнээс хөрвүүлсэн Шогн Эффендигийн хосгүй орчуулгууд одоо бий. Эдгээр орчуулгын бүтээл нь мөн Бахай Шүтлэгийн түүх, засаг захиргааны журмын үндсэн зарчим, хөгжлийн талаар Шогн Эффендигийн өөрийнх нь бичсэн бүтээл туурвилын хамт уг Шүтлэгийг судлах явдлыг Др. Эссемонтын цаг үед байсныг бодвол асар их хөнгөвчилж өгсөн байна.

## Хоёрдугаар бүлэг

### ЭХЛЭЛ ТАВИГЧ БАБ

*“Дарлагч этгээд Бурханы үр садын дунд Бурханы Гэрэл гэгээг унтрааж, хүн төрөлхтнийг Гоо жавхланта Буян хишигт Эзэн тэнгэрийн энэ цаг үед Хурмастын Амьдралын Гол мөрнөөс хагацаах гэсэндээ хорвоо ертөнцийн Хайрт Хүмүүний амийг бүрэлгэсэн юм” Бахаулла “Раист илгээсэн Бичиг”*

### Шинэ Үүдэл нээлтийн Өлгий нутаг

Бахай Үүдэл нээлтийн эх орон болсон Перс улс дэлхийн түүхнээ онцгой байр суурь эзэлж ирсэн билээ. Ид цэцэглэж байх үедээ Перс орон улс үндэстнүүдийн хатан хаан нь байсан бөгөөд түүнтэй соёл иргэншил хүч чадал сүр жавхлангаараа эн зэрэгцэх өөр улс орон байсангүй. Перс улс энэ дэлхийд агуу хаад, төрийн удирдагч, зөнч мэргэд, яруу найрагч, гүн ухаантан, суут зураач нарыг төрүүлсэн бөгөөд Зороастр, Кийр, Даарий, Хафиз, Фирдоуси, Саади болон Омар Хаяам зэрэг Персийн хөвгүүд нь тэдгээр суутнуудын зөвхөн хэдхэн нь юм. Гар урчуудынх нь ур чадвар дэлхийд өрсөлдөгчгүй, хивс, ган бүтээгдхүүн, ваар савны хосгүй урлалаараа дэлхийд алдартай байлаа. Перс улс тийнхүү Ойрхи, Дорнод Дундад Азийн аль ч газар нутагт агуу алдрынхаа ул мөрийг үлдээсэн юм.

Гэвч 18, 19 дүгээр зууны үед энэ ард түмэн туйлын доройтолд орсон ажээ. Эртний яруу алдар нь эргэлт буцалтгүй алдагдсан мэт байлаа. Засгийн газар нь авлига, санхүүгийн завхралд умбаж, зарим эрх мэдэлтнүүд нь сул дорой байхад зарим нь харгис хэрцгий чанараараа ад шулам гэлтэй болсон байв. Лам санваартан нар нь үл эвлэрсэн, муйхар зантай, хүн ард нь харанхуй бүдүүлэг дээрээ мухар сүсэгт автсан байв. Ихэнх хүмүүс Мухаммедын дагалдагч<sup>1</sup>дын “Шиит”-ийн бүлэглэлд багтаж байсан боловч

<sup>1</sup> Мухаммедын дагалдагч – Исламын шашныг шүтдэг хүнийг Мухаммедын дагалдагч буюу Мусульман гэнэ-орч



үлэмж тооны Зороастрчууд, Иудейчүүд, Христчүүд болон бусад шүтлэгтнүүд бас байлаа. Тэд бүгд л тэнгэрлэг сургаалыг дагаж, нэг л Бурханыг шүтэж, хайр ивээл, эв нэгдлийг хичээн амьдрах ёстой атал бие биеэ үгүйсгэн буруутгаж, нэг шашны бүлэглэл нь нөгөөгөө бузар булай, буруу номтон хэмээн үзэн ядаж байлаа. Бие биеэ хараан зүхэж, үзэн ядах явдал туйлдаа хүрсний улмаас бороотой өдөр Иудей, Зороастрын шашинтан хоёр хүн гудамжаар явахад маш аюултай байдаг байв. Учир нь хэрэв тэдний нойтон хувцас Мухаммедын дагалдагчид хүрэх юм бол тэр Мусульман хүн бузарлагдсан хэрэг болох бөгөөд нөгөө хүн магадгүй амь насаараа ч энэ доромжлолыг нөхөж өгөх шаардлага гарч болзошгүй тийм байдал тогтсон байв. Мухаммедын дагалдагч Иудей юм уу, Зороастр эсвэл Христийн шашинтан хүнээс мөнгө авах юм бол тэр мөнгөө халаасандаа хийхээс өмнө угаадаг заншилтай байв.

Хэрэв Иудей хүний хүүхэд нь Мусульман гуйлгачинд аягатай ус өгч байхыг эцэг нь харвал тэр аягыг түлхэж унагаах нь магад. Яагаад гэвэл түүний хувьд буруу номтон хүнд халамж үзүүлж байснаас хараал хүртсэн нь дээр ажээ. Мусульманчууд ч гэсэн өөрсдөө үй олон урсгалд хуваагдаж, хоорондоо тэмцэлдэж, заримдаа бүр дайн дажинд ч хүрч байлаа. Зороастрчууд ийм маргаан тэмцэлд нэг их оролцдоггүй байсан боловч бусдаас тусдаа амьдарч бусад шашны хүмүүсээс зайлсхийж явдаг байв.

Нийгмийн байдал нь мөн ялгаагүй итгэл найдвар алдран уналтанд орсон байлаа. Боловсролыг үл тоомсорлож өрнөдийн шинжлэх ухаан, соёл урлагийг шашинд харшилсан бузар зүйл гэж үздэг байв. Шударга ёсыг гажуудуулж, хулгай дээрэм бол хэвийн үзэгдэл байсан бөгөөд зам харгуйгаар аялах нь туйлын аюултай байв. Эрүүл ахуйн нөхцөл байдал ч мөн сэтгэл хирдхийлгэмээр гажуудалд орсон байв.

Гэсэн ч энэ бүхнийг үл харгалзан Перст оюун санааны амьдрал арай мөхөж унтраагүй байлаа. Газар дэлхийн бузар булай явдал, мухар сүсгийн дунд энд тэнд хааяа ариун гэгээн хүмүүс байдаг байсан бөгөөд тэд Есүсийг залрахаас өмнө амьдарч байсан Анна, Симеон нар шиг Бурханыг зүрх сэтгэлдээ хайрладаг байсан юм.

Олон ийм хүмүүс Бурханы амлагдсан Элчийг хүлээж, Түүний залран ирэх цаг ойртсон гэдэгт итгэл дүүрэн байв. Шинэ эрин үеийг бэлгэдсэн Зарч Баб бүхий л улс орныг өөрийн сургаалаар догдлуулах тэр үед Перс орны байдал ийм байлаа.

### Амьдралын эхэн үе

Хожим нь “Баб” (“Үүд”) хэмээх өргөмжлөл авсан Мирза Али Мухаммад нь өмнөд Персийн Шираз хотноо М.Э.1819 оны 10 дугаар сарын 20-нд<sup>1</sup> мэндэлжээ. Тэрээр Сиид овогтон байсан бөгөөд өөрөөр хэлбэл, зөнч мэргэн Мухаммед (Магомет- орч.)-ын үр удмын хүн байв. Түүний эцэг нь нэртэй худалдаачин хүн байсан ба хүүгээ мэндэлсний дараахан насан өөд болсон ажээ. Хүүг эхийн талын нагац ах болох Ширазын нэгэн худалдаачин ивээлдээ авч өсгөн бойжуулжээ.

Хүүхэд байхдаа Тэрээр уншиж сурч анхан шатны уламжлалт эрдэм ухаанд суралцжээ<sup>2</sup>. Тэрээр арван таван настайгаасаа эхлээд асран тэтгэгчийнхээ хамт, дараа нь Персийн булангийн эрэгт орших Буширт амьдардаг бас нэгэн нагац ахынхаа хамт худалдаа наймааны ажил эрхлэх болсон байна.

Идэр залуу насандаа Тэрээр ер бусын үзэсгэлэнт дүр царайтай, эелдэг элэгсэг зан байдалтай туйлын шүтлэгтэй эрхэм даруу зан араншинтайгаараа алдаршсан байв. Тэрээр Исламын шашны

<sup>1</sup> А.Х.1235 он, Мухаррамын анхны одөр

<sup>2</sup> Энэ талаар нэгэн түүхч ингэж бичжээ: “Дорнодын олон хүмүүс, тэр дундаа Бабын дагалдагч нар (одоо Бахайчууд) бодохдоо, Баб ямар ч боловсрол эзэмшээгүй, гэтэл Мулла нар түүний нэр хүндийг унагаахын тулд түүнийг өөрт байгаа бүх эрдэм ухаанаа сургууль соёлд сурснаас олж авсан гэж хэлдэг байсан гэж үздэг байв. Энэ талаар бид гүнзгий судалсны дүнд Баб бага байхдаа богино хугацааны турш Шейх Мухаммед (мөн Абид гэж нэрлэсэн) хэмээх хүний гэрт очиж персээр уншиж бичихийг заалгадаг байсныг олж мэдсэн юм. “Баяан” судартаа “Аяа, Мухаммед, Аяа Миний багш!...” гэж бичсэн байсан нь Баб багынхаа багшид хандсан хэрэг юм.

“Гэхдээ гайхалтай нэгэн зүйл гэвэл, Бабын багш байсан Шейх овогт тэр хүн шавийнхаа үнэнч дагалдагч болсон бөгөөд Бабын нагац ах (Хажн Синд Али) нь ч яг эцэг шиг нь байсан мөртөө мөн түүний үнэнч дагалдагч болж, эцэст нь Бабын үйл хэргийн төлөө амьнасаа зориулсан байна. “Эдгээр оньсого мэт зүйлийг үнэнийг эрэлхийлэгчдэд зориулж хэлж байгаа юм. Харин бид бол Баб ердөө анхан шатны боловсрол л эзэмшсэн бөгөөд Түүний хосгүй суу билиг, эрдэм ухаан түүнд Бурханаас заяагдсан байсан юм гэдгийг сайн мэдэх билээ”

мөргөл, мацаг, бусад ёс жаягийг чандлан сахидаг байсан бөгөөд зөвхөн ёс дэгийг нь дагадаг төдийгүй Зөнч мэргэний сургаалын үзэл санаагаар амьдардаг байжээ. Тэрээр хорин хоёр настайдаа гэрлэсэн байна. Энэ гэрлэлтээс нэг хүү төрсөн боловч Баб олон нийтийн үйл хэргээ эхлэх анхны жил нялх балчраараа таалал төгссөн юм.

## Тунхаглал

Хорин таван нас хүрэнгүүт Тэрээр тэнгэрлэг зарлигийг даган “Эрхэм дээд Бурхан Түүнийг Баб байхаар сонгон авчээ” гэж зарлан тунхагласан байв. “Аянчны Хүүрнэл”<sup>3</sup> номонд ингэж бичсэн байдаг. Үүнд:

*“Баб” хэмээх өргөмжлөлөөр тэрээр юуг хэлэх гээд байсан бэ гэвэл, тэрээр алдрын бүрхэвчний цаана нуугдмал ямар нэгэн агуу Хүмүүний гоо жавхлангийн элч, тэр агуу Хүмүүн болбоос хэмжээлшгүй их төгс төгөлдөр удвистай бөгөөд Түүний хайрын холбоонд тэрээр бат холбогдсон юм гэдгийг ойлгуулах зорилготой байв.” “Аянчны Хүүрнэл” (Бабын Үйл хэрэг), х. 3*

Тэр үед тэнгэрлэг элч залран үзэгдэнэ гэж итгэх явдал ялангуяа “Шэйх” нэртэй шашны бүлэглэлийн дунд давамгайлж байсан бөгөөд энэ бүлэглэлийн Мулла Хуссейн-и-Бушруи хэмээгч нэгэн суу билигт хүмүүнд Баб анх Өөрийн ариун үүргийг илчлэн хэлжээ.

<sup>3</sup> Энэ талаар нэгэн түүхч ингэж бичжээ: “Дорнодын олон хүмүүс, тэр дундаа Бабын дагалдагч нар (одоо Бахайчууд) бодохдоо, Баб ямар ч боловсрол эзэмшээгүй, гэтэл Мулла нар түүний нэр хүндийг унагаахын тулд түүнийг өөрт байгаа бүх эрдэм ухаанаа сургууль соёлд сурснаас олж авсан гэж хэлдэг байсан гэж үздэг байв. Энэ талаар бид гүнзгий судалсны дүнд Баб бага байхдаа богино хугацааны турш Шейх Мухаммед (мөн Абид гэж нэршсэн) хэмээх хүний гэрт очиж персээр уншиж бичихийг заалгадаг байсныг олж мэдсэн юм. “Баяан” судартаа “Аяа, Мухаммед, Аяа Миний баги!...” гэж бичсэн байсан нь Баб багынхаа багшид хандсан хэрэг юм.

“Гэхлээ гайхалтай нэгэн зүйл гэвэл, Бабын багш байсан Шэйх овогт тэр хүн шавийнхаа үнэнч дагалдагч болсон бөгөөд Бабын нагац ах (Хажн Сидд Али) нь ч яг эцэг шиг нь байсан мөртөө мөн түүний үнэнч дагалдагч болж, эцэст нь Бабын үйл хэргийн төлөө амь насаа зориулсан байна. “Эдгээр оньсого мэт зүйлийг үнэнийг эрэлхийлэгчдэд зориулж хэлж байгаа юм. Харин бид бол Баб ердөө анхан шатны боловсрол л эзэмшсэн бөгөөд Түүний хосгүй суу билиг, эрдэм ухаан түүнд Бурханаас заяагдсан байсан юм гэдгийг сайн мэдэх билээ”

Энэ тунхаглал болсон цагийг “Баяан” хэмээх Бабын сударт А.Х.<sup>1</sup> 1260 оны Жамадиул Аввал сарын 5 дахь өдрийн (өөрөөр хэлбэл, М.Э. 1844 оны 5-р сарын 23) нар жаргаснаас хойш хоёр цаг, арван нэгэн минут гэж тодорхойлон заасан байдаг. Абдул-Баха нь мөн яг тэр шөнө мэндэлсэн бөгөөд гэхдээ мэндэлсэн цаг нь тодорхой биш юм. Сэтгэл догдлон хэд хоногийн турш судалсны дараа Мулла Хуссейн шийтгүүдийн хүсэн хүлээж байсан Бурханы элч залран ирлээ гэдэгт бат итгэлтэй болжээ. Энэ үнэнийг төдийлөн удалгүй түүний зарим нөхөд бас олж мэдсэн байна. Хэсэгхэн хугацааны дараа Шэйхүүдийн ихэнх нь Бабыг хүлээн зөвшөөрч, Бабын дагалдагч нар болцгоожээ. Ийнхүү зөнч мэргэн залуугийн алдар нэр Перс орны газар нутгаар хээрийн гал мэт хурдан түгэж эхлэв.

### Бабын хөдөлгөөн дэлгэрсэн нь

Бабын анхны арван найман шавийг (Өөртэй нь нийлээд арван ес) “Амьдралын Үсгүүд” гэж нэрлэх болжээ. Тэрээр эдгээр дагалдагч нараа Перс, Туркестаны янз янзын газар нутагт Өөрийн залран ирсэн тухай мэдээг түгээхээр илгээжээ. Тэрээр Өөрөө Мекка руу мөргөлчлөх аян замдаа гарч, тэнд 1844 оны 12-р сард очиж, Өөрийн ариун үүргийг олны өмнө ил тод тунхаглажээ. Буширт буцаж очоод Баб өөрийгөө зарлан тунхаглахад олны сэтгэл ихэд догдолсон байна. Түүний уран үгс, яруу тод сургаал бичвэр, Түүний эгэл бус мэргэн ухаан, эрдэм мэдлэг, эр зориг, бүхнийг хувьсгах эрмүүн тэмүүлэл нь дагалдагчдынх нь сэтгэл зүрхийг нь ихэд бадрааж байсны хажуугаар Исламын уламжлалт шашныхны дунд сэрэмжлэх дайсагнах хандлагыг ихэд төрүүлж байлаа. Шиит эрдэмтэд Түүнийг тасралтгүй үгүйсгэж, буруу номтныг ямар нэгэн аргаа дарах хэрэгтэй гэж Фарс хотын захирагч Хуссейн Хан хэмээгч харгис дарангуйлагчийг ятгаж байв. Үүний дараагаар Баб урт удаан хугацаагаар шорон гянданд хоригдож, байцаагдан шүүгдэж, элдэв янзаар доромжлуулж, зовлон бэрхшээлийг хангалттай амссаны эцэст 1850 онд цаазаар авахуулан амь насаа алдсан юм.

<sup>1</sup> Бабын Үйл хэргийг дүрслэн бичсэн “Аянчны хүүрнэл”, Оршлыг Е.Г.Браун

## Бабын уриа дуудлага

Залуу хүмүүн Өөрийгөө Баб хэмээн зарлахын хажуугаар мөн Мухаммадын зөгнөн айлдсан Михди (Махди) мөн хэмээн зарлахад Түүнийг эсэргүүцэх хөдөлгөөн хоёр дахин ширүүсэв. Шиитүүд Михди хэмээгчийг мянган жилийн өмнө залран ирснээ учир битүүлэг байдлаар алга болсон 12-р Имам<sup>2</sup> байх ёстой гэж итгэн сүсэглэдэг байжээ. Тэд Түүнийг амьд дүрээрээ дахин ирнэ гэж итгэж байсан агаад Христийн үед Иудейчүүд Мессия залран ирэх зөгнөл айлдварыг хэрхэн тайлбарлаж байсны адил Михдигийн ноёрхол, алдар, ялалт, залран ирэх шинж тэмдгийг шууд бодит утгаар нь тайлбарладаг байв. Тэд Түүнийг тоо тоймшгүй цэрэг хүчийг дагуулан, газар дэлхийд ноёрхлоо тогтоон, үхэгсдийг амьдруулна гэх зэргээр төсөөлж байжээ. Эдгээр бүх шинж тэмдгүүд ёсчлон илрээгүй тул шиитүүд Бабыг Иудейчүүд Христийг үгүйсгэсэнтэй адил эрс үгүйсгэн зүхсэн байна. Бабчууд эдгээр шинж тэмдгүүдийг харин зүйрлэсэн утгаар нь ойлгож, Бурханаас Амлагдсан хүмүүний ноёрхол далдын чанартай, Түүний алдар газар дэлхийнх бус харин оюун санааных, Түүний байлдан дагуулалт нь хүмүүсийн зүрх сэтгэлийг эзэмдсэн байлдан дагуулалт болно гэж үзэж байлаа. Бабын гайхамшигт амьдрал сургаал, няцашгүй итгэл бишрэл, бууршгүй үнэнч сэтгэл болон алдаа дутагдал, харанхуй мунхагийн булшинд хорогдсон хүмүүсийг оюун санааны шинэ амьдралд хөтлөн дагуулах тэр хүч чадалд нь Түүний тунхаглалын үнэний нотолгоог олж байсан юм.

Гэвч Баб Өөрийгөө Михди гэж зарласнаар зогссонгүй. Тэрээр Өөртөө “Ноктэе Ула” буюу “Анхдагч Цэг” хэмээх ариун өргөмжлөлийг авчээ. Энэ өргөмжлөлт нэрээр Мухаммед мэргэнийг шавь нар нь нэрлэдэг байсан ажээ. Тэр ч бүү хэл, Иمامууд өөрсдөө “Анхдагч Цэг”-г захирагдан, түүнээс эрх мэдэл доогуур байлаа. Баб уг өргөмжлөлийг Өөртөө авснаар Өөрийгөө Мухаммедтай эн зэрэгцүүлж, шашны агуу Үндэслэгч нарын эгнээнд тавьсан хэрэг байсан учраас Иудейчүүд Христийг буруутгасны адил шиитүүд Түүнийг нэр зээлдэгч хуурамч этгээд

<sup>2</sup> А.Х.-Анно Гежирос -гежрын он тооллын (Мухаммед Меккагаас Медина руу дүрвэсэн цагаас эхэлж тоолно, М.Э.622 он)

хэмээн тооцож байв. Баб түүнчлэн нарны жил дээр үндэслэн цаг тооны шинэ бичгийг зохиож, Өөрийн тунхаглалын жилээс Шинэ Эрин үеийг эхлүүлжээ.

### **Хяхан хавчилт ширүүссэн нь**

Бабын эдгээр тунхаглалын үр дагавраар анги давхарга ялгалгүй баян ядуу, эрдэмтэй эрдэмгүй маш олон хүмүүс богино хугацааны дотор Түүний сургаалыг сэтгэл шулуудан хүлээн авч байсан тул үүнд дарамт үзүүлэн, хяхан хавчих оролдлого улам шийдэмгий болж ширүүсч байлаа. Сүсэгтнүүдийн гэр оронг галдан, тонон дээрэмдэж байв. Эмэгтэйчүүдийг нь булаан баривчилж Тегеран, Фарс, Мазиндаран зэрэг хотуудад сүсэгтнүүдийг олноор алан хядаж байлаа.

Олон ч хүний толгойг цавчиж, тэднийг дүүжилж, их бууны аманд хүлэн буудаж, шатааж, олон хэсэг болгон тасдан цавчих зэргээр хороож байв. Хавчин гадуурхах гэсэн эдгээр бүх оролдлогыг үл харгалзан Бабын хөдөлгөөн харин улам өсөн өрнөж байсан юм. Үнэндээ энэхүү хяхан хавчилтын үр дүнд сүсэгтнүүд итгэл бишрэлдээ улам гүнзгийрч байлаа. Учир нь үүгээр Михди залран ирэх зөгнөл айлдвар жинхэнэ ёсоор биеллээ олж байсан юм. Тийнхүү шийтүүдийн үнэн гэж үздэг Жабир-ын нэгэн домогт ингэж бичсэн байдаг. Үүнд:

“Мойсейн төгс билиг, Есүсийн нандин чанар, Иобын тэсвэр тэвчээр бүгд түүнд оршино. Түүний гэгээнтнүүд өөрийн цаг үед доромжлогдон гадуурхагдаж, Турк, Депаимитүүдийн толгойгоор бие биедээ бэлэг сэлт барьдаг байсан шиг тэдний толгойгоор мөн бэлэг сэлт барьж, тэднийг шатаан, амийг нь бүрэлгэж, айлган сүрдүүлнэ. Газар дэлхий тэдний цусанд живж, эмс хүүхнүүд нь орь дуу тавин, уйлан хайлна. Энэ бол үнэнхүү миний гэгээнтнүүд болой.” *“Бабын Шинэ түүх”, орч.-Професор Э.Г.Браун, х.132*

### **Бабын Баатарлаг үхэл**

1850 оны 7-р сарын 9-ний өдөр Баб гучин нэгэн насандаа мөрдөн хавчигчдын мухар сохор уур хилэнд өртөн амь насаа



алдсан юм. Түүнтэй цуг баатарлаг үхлийг нь амсая гэж гуйж шалсан үнэнч дагалдагч залуу Ага Мухаммед Алигийн хамт Бабыг цаазалжээ.

Тебриз хотын хуарангийн хуучин талбай дахь цаазын тавцан руу аваачин, үд дунд болохоос хоёр цагийн өмнө Мухаммед Алигийн толгойг хайрт эзнийх нь цээжинд наалдуулан, хоёулаш хооронд нь сугаар нь олсоор холбосон байлаа. Армен хороо цэрэгт гал нээж тушаал өгөв. Буун дуу нэгэн удаа дуугарлаа. Дарины угаа замхарсны дараа харгал Баб түүний дагалдагч хоёул амьд байсан юм. Бууны сум хүлсэн олсыг л оносон тул тэр хоёр өчүүхэн ч бэргэлгүй газар ойчсон байжээ. Тэр үед Баб ойролцоо байсан ороонд очин нэгэн нөхөртөйгөө ярьж суухыг нь олж, үд дундын үед тэднийг баривчилж цаазын тавцан руу дахин аваачив. Түрүүнд болсон гайхамшигт, ид шидийн юм шиг явдлыг харсан Армен цэргийн хороо тушаалыг дахин гүйцэтгэхээс татгалзан, улмаар өөр нэгэн цэргийн хороог дуудан авч ирж, гал нээж тушаал өгөв. Энэ удаа буудалт нь бүтэмжтэй болж, Баб, Мухаммед Али хоёрын бие суманд хэн нь хэн бэ гэдгийг танихын аргагүй болтлоо нэвт буудагдсан байлаа. Гэвч тэр хоёрын нүүр царайнд огтхон ч сум тусаагүй байсан юм.

Энэ аймшигт гэмт хэргийг үйлдсэнээр Тебризийн талбай хоёр дахь Гольгоф<sup>1</sup> болжээ. Бабын дайснууд ялагтандаа бах нь ханаж, Бабын шүтлэгийн модны үндсийг тасалсан юм чинь тэр мод удахгүй хатаж үхнэ гэж бодож байлаа. Гэвч тэдний ялалт удаан үргэлжилсэнгүй! Үнэний модыг бодит сүхээр хэзээ ч цавчин унагаж чадахгүй гэдгээ тэд ойлгоогүй байсан юм. Тэдний үйлдсэн гэм нь энэхүү Үйл хэрэгт улам эрч хүч нэмсэн гэдгийг тэд мэдэж байсан ч болоосой. Бабын баатарлаг үхэл нь Түүний Өөрийнх нь хүсэл мөрөөдлийг биелүүлж, дагалдагчдад нь улам их хүч хайрлав. Тэдний оюун санааны урам зориг, эрч хүчийн гал

<sup>1</sup> Шийтүүдийн хувьд Имам гэдэг нь Зочч мэргэн Мухаммедын залгамжлагч бөгөөд түүнийг сүсэгтэн бүр дагах ёстой аж. Иمامын үүргийг арван нэгэн хүн гүйцэтгэж байсан бөгөөд эхнийх нь Зочч мэргэний үеэл болон хүргэн хүү болох Али байлаа. Ихэнх шийтүүдэд мөн арван хоёр дахь Имам байх бөгөөд түүнийг Имам Михди гэж нэрлэдэг. Имам Михди А.Х. 329 онд хүүхэд байхдаа газар доорх нэгэн хонгилд орон алга болсон гэж үздэг бөгөөд тэрээр сайн цагийн эхэнд дахин заларч, буруу номтнуудыг гэтгэж, адис ерөөлт эрин үеийг авч ирнэ гэсэн домог байдаг ажээ.

маш бадрангуй асаж байсан гул хяхан хавчилтын ширүүн сапхинд улам ч бадран асав. Галыг унтраахыг хэдий нинээ оролдовч гал дөл төдийчинээ хөөрөн асаж байлаа.

### Кармел Уулан дахь Шарил

Баб амь үрэгдсэний дараа шарилыг нь үнэнч андын шарилын хамт хотын хананы гадна талд жалганы захад хаясан байв. Хоёр дахь шөнө Бабчууд шарилыг нууцаар авч явсан бөгөөд олон жилийн турш Перст нууцаар хадгалж байгаад эцэст нь аюул сөрөн, бэрхшээлийг даван шарилыг нь Ариун Газарт хүргэж ирсэн юм.

Шарилыг Кармел уулын нэгэн сайхан энгэрт Илия агуйнаас холгүй, Бахаулла амьдралынхаа сүүлчийн жилүүдийг өнгөрөөсөн, одоо Бахауллагийн шарил нь байрладаг тэр газраас хэдхэн бээрийн зайтай орцуулжээ. Бахауллагийн шарил дээр ирж мөргөл үйлдэхээр дэлхийн өнцөг булан бүрээс ирдэг мянга мянган мөргөлчид Бахауллагийн замыг засагч хайрт Бабын Бунханд залбирахаа бас мартдаггүй.

### Бабын сургаал бичмэл

Бабын туурвисан сургаал ном бичмэл нэн олон бөгөөд урьдчилан судалж бясалгалгүйгээр элдэв тайлбар, сургаал болон мөргөлийг яруу хэлээр туйлын хурдан туурвидаг байсан нь Түүний тэнгэрлэг суу билгийн нэгэн нотолгоо байсан юм.

Түүний төрөл бүрийн сургаал айлдварын утга санааг дараах байдлаар тоймлож болно. Үүнд:

*"Эдгээрийн зарим нь (Бабын сургаал бичмэлүүд) Коран судрын бадаг мөрүүдийн талаар бичсэн тойм, тайлбар, зарим нь мөргөл, хүүрнэл, мөн л Кораны зарим хэсгүүдийн учрыг тайлсан сэнхрүүлэл байв. Харин зарим нь Бурханы нэгдлийн тухай олон талын сургаал сургамж, анхааруулга, эргэцүүлэл, хүний зан чанарыг төгөлдөржүүлэх уриалга, газар дэлхийн дур хүслээс ангижирч, Бурханы онгодыг санагалзах тэмүүллийг агуулж байв.*

Гэхдээ Түүний үндсэн туурвилын зорилго, мөн чанар Түүний цорын ганц зорилго, хүсэл мөрөөдөл нь удахгүй залран ирэх тэрхүү Бодит үнэнийг магтан мандуулж, тодорхойлон тайлбарлахад оршиж байлаа. Учир нь Тэрээр Өөрийн залран ирснийг зөвхөн баярт зар мэдээг авчрахад, өөрийн мөн чанарыг удахгүй ирэх Тэр хүмүүний хавьгүй илүү төгс билгийг гэрчлэхэд оришино гэж үздэг байсан юм. Үнэндээ ч Тэрээр Түүнийг өчүүхэн хором ч зогсолтгүй өдөр шөнөгүй магтан мандуулж, өөрийн бүх дагалдагч нартаа Түүнийг залран ирэхийг хүсэн хүлээхийг захидаг байсан бөгөөд “Би болбоос тэрхүү хүчирхэг судрын үсэг, тэрхүү хязгааргүй далайн дусал билээ. Тэрээр залран ирэх тэр үед миний үнэн мөн чанар, миний оньсого нууц, зөн бишиг бодит биеллээ олж тодорхой болно. Тэгээд энэхүү Шашны үр үндэс ахуйн хөгжлийнхөө үе шатыг давж, “нэн төгс төгөлдөр хэлбэр”-ийг олж “Бүтээгч нараас хамгийн төгс төгөлдөр Бурхан тэнгэр адистат болтугай” гэсэн үгийг өөртөө шингээнэ” гэж сургаал бичигтээ туурвисан юм. Тэрээр Тэр хүмүүний гал дөлд өөрөө дүрэлзэн шатаж, Түүнийг магтан дуурсах явдал нь Махку цайзан дахь гүн харанхуй шөнөөр түүнд гэрэлт дэнлүү болдог байсан ба Түүнийг магтан дуулах нь Чихриг шорон дахь хүнд бэрхшээлтэй үед нь түүнд мөнхийн дагуул болдог байлаа. Тийнхүү тэрээр оюун санааны гэгээрлийг олж, Түүний дарсанд согтож, Түүнийг бодон санах баяр жаргал олсон юм. “Аянчны хүүрнэл” (Бабын Үйл хэрэг), х.54

### Бурханаас Тодрох Хүмүүн

Баб бээр загалмайлагч Иоантай ижил төстэй байсан боловч Бабын байр суурь зөвхөн Зарч, Эхлэл тавигч төдий биш байлаа. Тэрээр Өөрөө Бурханы тодруулагч ба хэдийгээр Түүний шашин нь хэдхэн жилийн настай байсан ч бие даасан шашныг Үндэслэгч байсан юм. Бахайчууд итгэхдээ, Баб, Бахаулла нар нь Бахай Шүтлэгийн Ихэр үндэслэгчид байсан гэж үздэг бөгөөд Бахауллагийн дараах үгс нь үүнийг гэрчилнэ:

“Энэхүү эрхэм дээдийн гайхамшигт Үүдэл нээлтийг Миний өмнөх Тунхаглалаас тусгаарлаж байгаа цаг хугацааны богионохон

үе нь ямар ч хүн тайлахааргүй оньсого, ямар ч хүний оюун ухаан ойлгохооргүй нууц юм. Энэ үеийн үргэлжлэх хугацааг урьдчилан тогтоосон байсан бөгөөд Миний Нуугмал Сударын агуулгыг мэдэжээс нааш хэн ч үүний учир шалтгааныг олж мэдэж чадахгүй юм.”:

Бахауллагийн тухай дурдахдаа Баб үнэнхүү чин сэтгэлээсээ хандан *“Бурханаас тодрох тэр Хүмүүн” залрах тэр цаг үед: “Түүний туурвисан нэг бадаг мөрийг сонсоод нэгэнтээ давтаж унших нь Баяан судрыг (Бабын туурвил) мянгантаа давтан уншсанаас хавьгүй дээр буюу.”*—“Аянчны хүүрнэл” (Бабын Үйл хэрэг), х. 349) гэж айлдсан байна.

Баб Өөрийн онгод урмын цорын ганц эх үүсвэр, Өөрийн цорын ганц хайр болох “Бурханы Тодруулах тэр Хүмүүн”-д замыг нь өчүүхэн ч гэсэн тэгшлэн засахын тулд ямар ч зовлон бэрхшээлийг туулахдаа аз жаргалтай хүн гэж Өөрийгөө тооцдог байсан юм.

### **Сэхээрэлт, Диваажин ба Там**

Бабын сургаалын чухал хэсгийг “Сэхээрэлт”, “Шүүлгийн Өдөр”, “Диваажин”, “Там” гэсэн нэр томъёоны талаарх Түүний тайлбар эзэлдэг. Сэхээрэлт гэдэг нь Үнэний Нараны шинэ Тодруулагч залран ирэхийг хэлнэ гэж Тэрээр айлдсан юм. Үхэгсдийг амилуулах гэдэг нь харанхуй мунхаг, цалгар назгай, шунал тачаалын булшинд унтагсдыг оюун санаагаар нь сэрээх явдал юм. Шүүлтийн Өдөр нь Бурханы шинэ Тодруулагчийн Өдөр бөгөөд энэ Тодруулагчийн үүдэл нээлтийг хүлээж авсан, эсвэл үгүйсгэснээр хонь хурга, ямаа ишигнээс ялгагдах юм. Учир нь, хонин сүрэг Сайн Малчины дуу хоолойг таньж, Түүнийг дагадаг. Диваажин болбоос Бурханыг таньж, Бурханыг хайрлахын баяр баясгалан бөгөөд улмаар хүн хамгийн төгс төгөлдөр төрхөө олж, үхлийн дараа Бурханы Хаант улсад нэвтэрч, мөнхийн амьдралыг хүртдэг гэж Бурханы Тодруулагч туурвижээ. Там бол Бурханыг таньж мэдэхүйн буян хишгээр дутагдах, улмаар тэнгэрлэг төгс төгөлдөр чанарт хүрч чадалгүйгээр Мөнхийн ивээлийг алдахыг хэлнэ. Баб айлдахдаа эдгээр

нэр томъёо нь үүнээс өөр утгыг илэрхийлэхгүй гэсэн юм. Тиймээс материаллаг бие махбод үхсэнээ амилах, материаллаг диваажин ба там зэрэг ойлголт нь ердөө л хий төсөөллийн үр дагавар юм. Баб хүнд үхлийн дараах амьдрал гэж байдаг бөгөөд хойт насны амьдралдаа хүн хязгааргүй орчинд төгс төгөлдөр чанарт тэмүүлэн хөгжин дэвшдэг хэмээн сургажээ.

### **Нийгмийн болон Ёс зүйн сургаалууд**

Баб Өөрийн дагалдагч нарыг ах дүүгийн хайр, эелдэг элэгсэг харьцаагаараа эрхэм гойд байх ёстой гэдгийг сургаал бичмэлдээ захисан байдаг. Мөн ашиг тустай эрдэм ухааныг хөгжүүлэх шаардлагатай. Анхан шатны боловсрол нь ерөнхий шинж чанартай байна. Ирэх шинэ болоод гайхамшигт Эрин үед эмэгтэйчүүд илүү эрх чөлөө эдэлнэ. Ядуусыг нийтийн сан хөмрөгөөс тэтгэнэ, гэвч гуйлга гуйхыг хориглоно. Түүнчлэн согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно гэжээ.

Бабын үнэнч дагалдагч хүний уриа дуудлага нь шагнал горьдох юм уу шийтгэлээс эмээх зүйлгүй, ариун цагаан хайр байх ёстой. “Баяан” судартаа Тэрээр ийнхүү айлджээ:

*“Сүсэг бишрэл чинь галд хөтлөн аваачсан шиг Түүнийг сүсэглэн бишрэх чинь өчүүхэн ч төдий үл хувирах тийм хэмжээнд Бурханд сүсэглэ. Хэрэв чи эмээсэндээ Бурханыг шүтэх юм бол энэ нь Бурханы ариун босгонд үл таашаагдах буюу.. Түүнчлэн, хэрэв чиний харц Диваажинд чиглэж, чи диваажинд хүрэхийг горьдон Бурханд сүсэглэвээс Түүний бүтээлийг Өөртэй нь эн зэрэгцүүлсэн хэрэг болно.”* “Персийн Бабчууд”, 2-р дэвтэр, Проф. Э.Г.Браун, 21-р боть, х.931.

### **Зовлон бэрхшээл ба Ялалт**

Сүүлчийн ишлэл нь Бабын амьдралд ноёрхож байсан бүхий л үзэл санааг илтгэж байна. Бурханыг таньж мэдэх, хайрлах, Түүний шинж чанарыг тольдон тусгах, Түүний Тодруулагчийг

залран ирэхэд нь замыг нь засах-энэ бүхэн Бабын амьдралын цорын ганц зорилго хүсэл нь байсан юм. Хайр нь бүхий л айдсыг тонилгосон тул Тэрээр үхэл зовлонгоос үл айдаг байсан бөгөөд амь насаа зориулах явдал нь Хайртынхаа хөлд сөгдөх хүслийг нь улам бадрааж байсан юм.

Тэнгэрлэг Үнэнийг тайлагч энэхүү бадрангуй соён гэгээрүүлэгч, Бурханыг болон зон олныг хайрлагч энэхүү ариун гэгээн сайхан Хүмүүнийг Өөрийнх нь цаг үеийн шашин шүтлэгтэй хүмүүс тийм ихээр үзэн ядаж, бүр амийг нь бүрэлгэж чадсан нь тун хачирхалтай билээ! Үнэнхүү Бурханы Ариун Элч, Зөнч мэргэн хүнийг үл анзаарна гэдэг бол тэд санамсартай санамсаргүйгээр атгаг сэжиг үзэлдээ автан билгийн нүдээ нээгээгүйтэй холбоотой юм. Түүнд энэ газар дэлхийн агуу нэр алдар байгаагүй ба оюун санааны хүч чадал, эрхшээл ноёрхлоо энэ дэлхий ертөнцийн ямар ч тусламжгүйгээр хамгийн ширүүн хүчтэй эсэргүүцлийг сөрөн зогсож, ялан дийлснээс өөр юугаар нотлох байсан билээ? Амьдралын зовлон зүдгүүр, хүнд бэрх цохилт, дайснуудын хорсол занал, хуурамч найз нөхдийн урвалт-энэ бүхэнд үл шантран тайван гэвчиж, энэ бүхнээс дээгүүр зогсож, бүхнийг уучлан өршөөж, адислан ивээснээс өөрөөр Тэнгэрлэг Хайраа хэрхэн илэрхийлэх байсан билээ?

Баб тэвчсэн, Баб ялсан. Мянга мянган хүн Түүнд хайраа зориулж, Түүнд үйлчлэхийн тулд амь амьдрал, хамаг бүхнээ золиослосон юм. Тэрээр хүмүүсийн зүрх сэтгэлийг хичнээн их эзэмдсэнд хаад ноёдууд атаархах буй заа. *“Бурханаас тодрох тэр Хүмүүн”* залран ирээд Эхлэл тавигч Бабын үнэнч хайрыг хүлээн авч, Түүнд Өөрийн Алдараас хувь хүртгээсэн юм.



## Гуравдугаар бүлэг

### **БАХАУЛЛА-БУРХАНЫ АЛДАР**

*“Хүсэн хүлээж буй чи бүү алгуурла, Тэрээр ирсэн болой. Түүний Аршун Асар ба түүнд орших (Түүний) Алдарыг харагтун. Энэ болбоос шинээр тодорсон Эртний Алдар болой.”-Бахаулла*

#### **Бага балчир нас**

Хожим нь Бахаулла (Бурханы Алдар) хэмээх өргөмжлөл хуртсан Мирза Хусейн Али нь Визирь буюу төрийн сайдын алба хашиж байсан Нур нутгийн Мирза Аббасын ууган хүү байв. Тэрээр баян чинээлэг, нэр хүндтэй гэр бүлийн хүү байсан бөгөөд олон хамаатан садан нь Персийн засгийн газар, иргэний болон цэргийн албанд өндөр албан тушаал хашиж байсан юм. Тэрээр Персийн нийслэл Тегеран хотод 1817 оны 11-р сарын 12-ны өдрийн үүр цайх, нар ургахын хооронд мэндэлжээ. Тэрээр ямар ч сургууль соёлд яваагүй бөгөөд гэртээ бага зэрэг эрдэм ном заалгажээ. Гэсэн хэдий ч хүүхэд байхдаа гайхамшигтай мэргэн ухаан, эрдэм мэдлэгээрээ гайхагддаг байв. Идэр залуу байхад нь эцэг нь насан өөд болж, Тэрээр дүү нараа асарч, гэр бүлийнхээ эдлэн газрыг захирах болсон юм.

Бахауллагийн ууган хүү Абдул-Баха нэгэн удаа Эцгийнхээ залуу насны тухай дараах зүйлийг зохиолчид өгүүлжээ:

*“Хүүхэд ахуй байхаасаа тэрээр туйлын эелдэг өгөөмөр сэтгэлтэй хүн байсан юм. Тэрээр ихэнх цагаа цэцэрлэгт хүрээлэн, хээр талд өнгөрүүлж, эрүүл агаарт байх дуртай байлаа. Бусдын сэтгэлийг татах ер бусын увдисыг нь хүн бүхэн мэдэрдэг байв. Түүнийг хүмүүс ямагт тойрон хүрээлж, Сайд, шүүхийн албат нар байнга хүрээлдэг байсан бөгөөд хүүхдүүд ч Түүнд их хайртай байлаа. Тэрээр арван гурав, арван дөрвөн настай байхаасаа эрдэм ухаанаараа олонд алдаршжээ. Тэрээр ямар ч сэдвээр цэц булаалдаж, ямар ч асуудлыг шийдэж чаддаг байлаа. Томоохон цуглааны үеэр Тэрээр элдэв асуудлаар Улама (удирдагч Мулла*

нар) нартай ном хаялцаж, шашины нарийн төвөгтэй асуудлаар тайлбар хэлдэг байв. Бүгд л Түүнийг ихэд хүндэтгэн сонсдог байлаа.

“Бахауллаг хорин хоёр настай байхад эцэг нь нас эцэслэж, засгийн газраас Бахауллаг Персийн уламжлалт ёсоор эцгийнхээ яамны албан тушаалыг өвлөн авахыг хүссэн боловч Тэрээр татгалзсан юм. Тэгэхэд нь Ерөнхий Сайд: “Түүнийг орхи. Ийм албан тушаал түүнд багадана. Түүнд үүнээс агуу зорилго бий. Би түүнийг ойлгож чаддаггүй юм, гэхдээ тэрээр ямар нэгэн өндөрлөг агуу үйл хэрэг гүйцэтгэх хувь тавилантай гэдэгт би итгэлтэй байна. Түүний бодол санаа биднийхтэй адилгүй. Түүнийг зонд нь орхи.” хэмээжээ.

### **Бабын дагалдагч хэмээн шоронд хоригдсон нь**

1844 онд Баб Өөрийн ариун үүргийг тунхаглахад, Бахаулла хорин долоон настай байсан бөгөөд шинэ Шүтлэгийн Үйл хэргийг зоригтойгоор хүлээн авч, удсан ч үгүй уг хөдөлгөөний хамгийн нөлөө бүхий аймшиггүй удирдагчдын нэг болсон юм.

1852 онд Бабчуудын хувьд аймшигт үр дагаврыг авчирсан нэгэн үйл явдал болоход Бахаулла Үйл хэргийнхээ төлөө хоёр ч удаа хоригдож, нэг удаад бүр жанчуулан тамлуулж байжээ. Бабын баатарлаг үхлийн гэрч болсон Садык хэмээх залуу дагалдагч гутран гуниглаж, эцэст нь хайрт Эзнийхээ өшөөг авахаар шийджээ. Тэрээр Шахын амь насанд халдсан байна. Гэхдээ сумны оронд тэрээр буугаа бутархай сумаар сумласан байсан тул Шах хүнд гэмтэл аваагүй юм. Тэгэхлээр нь мөнөөх залуу Шахт ойртон мориноос нь угз татан буулгасан даруйд эрхэм дээдсийн зарц нар түүнийг тэр дор нь буудан алжжээ. Энэ үйлдлийн бурууг Бабын бүхий л дагалдагч нарын нийгэмлэгт тохож, аймшигт алан хядлага үүгээр эхэлсэн юм. Наян Бабчуудыг Тегеранд ой гутам байдлаар тамлан тарчлааж алжжээ. Бусад олон дагалдагчдыг нь шорон гянданд хорьсон бөгөөд тэдний дотор бас Бахаулла байлаа. Тэрээр хожим нь бичихдээ:

“Бид энэ нүгэлт үйлдэлтэй огтхон ч холбоогүй байсан ба Бидний буруугүйг шүүх маргаангүй нотолсон билээ. Гэсэн хэдий

ч, тэд Биднийг баривчилж, гав гинжээр дөнгөлж, тэр үеийн Шахийн ордон байсан Нияваранагаас Тегеран уруу тууж аваачсан юм. Цэрэг хуягуудад туугдаж, гав гинжинд дөнгөлүүлж нүцгэн явж байх үед морь унасан нэгэн муу санаат хуяг Видний малгайг цохиж унагаасан тул бас толгой нүцгэн явах болсон юм. Дүрсэлж бичихийн аргагүй муухай газар бид дөрвөн сар хоригдсон юм. Энэхүү Хэлмэгдсэн Хүмүүн ба Түүний адилаар хэлмэгдсэн бусад хүмүүс газар доорх шоронгийн харанхуй бөгөөд хавчиг нүхэнд хоригдсон билээ. Бид анх тэнд хүрээд тас харанхуй хонгилоор явж, тэндээсээ гурван эгц шатаар бууж, хоригдох газартаа хүрсэн юм. Шорон тас харанхуйд умбаж, тэнд хулгайч, алуурчин, их замын дээрэмчид гээд бараг зуун тавин хүн хоригдож байлаа. Зай завсар муутай байсан ч Бидний орж ирсэн тэр хаалганаас өөр гадагшаа гарах нүхгүй байв. Тэр муухай газрыг бийрээр дүрслэн бичихийн аргагүй, үмхий заваан үнэрийг нь хэлээрээ дүрслэн хэлэхийн ч аргагүй, Тэр хүмүүст өмсөх хувцас ч байсангүй, хэвтэх ор ч байсангүй. Муухай үнэртэй, харанхуй тэр газар Бидэнд учирсан бэрх зовлонг гагцхүү Бурхан л мэднэ.

“Тэр шоронд хоригдож байхдаа бид өдөр шөнөгүй Бабчуудын үйлс болон нөхцөл байдлын галаар бясалгаж, ийм эрхэм зорилготой, ийм эрдэм ухаантай буянт хүмүүс Эрхэм дээдсийн эсрэг тийм гутамшигтай бодлогогүй хэрэг үйлдэж хэрхэн чадаваа гэж эргэцүүлэн бодож байсан юм. Энэхүү Хэлмэгдсэн Хүмүүн тийм учраас шоронгоос суллагдсаны дараа эр зориг шулуудан энэ хүмүүсийг ухааруулан сэнхрүүлэхээр шийдсэн юм.

*Нэг шөнө зүүдэнд минь: “Үнэнхүү, Бид Чамайг Өөрөөр чинь болон Бийрийн чинь хүчээр ялагч болгон өргөмжлөнө. Өөрт учирсан зовлондоо бүү гутар, айхын ч хэрэггүй. Учир нь, Чи аюулгүй байна. Мөдхөн Бурханыг таньж мэдсэн хүмүүсийн зүрх сэтгэлийг сэргээн амьдруулдаг Чиний Алдар нэр болон Чиний хүчээр Чамд туслах газар дэлхийн эрдэнэс болсон хүмүүсийг Бурхан нээн сэргээх болмой.” гэсэн гайхамшигтай үгс тал талаас дуулдсан юм.” гэжээ. (Бахаулла, “Чонын бэлтгэрт илгээсэн бичиг”, х.20-21)*

### **Багдадад цөлөгдсөн нь**

Тэр аймшигт шоронд тэд дөрвөн сар хоригдсон боловч Бахаулла болон Түүний нөхөд сэтгэл санаагаар ердөө ч унаагүй, сэргэлэн цовоо хэвээр, туйлын аз жаргалтай байсан юм. Бараг өдөр бүр тэдний дотроос нэг юм уу хэд хэдэн хүмүүсийг тамлан тарчлааж, цаазаар авдаг байсан ба бусад нь ч хэзээ нэгэн цэгт өөрсдийнхөө ээлжийг ирнэ хэмээн хүлээдэг байв. Яргачид ирж, хэн нэгнийг нь аваачихаар нэрийг дуудахад тэр хүн баярласандаа болон бараг бүжиглэх шахдаг байсан ба Бахауллагийн гарыг үнсэн, бусад нөхөдтэйгээ тэврэлдэн салах ёс гүйцэтгээд баатарлаг үхлээ баяр хөөртэйгээр угтдаг байв.

Эцсийн эцэст Бахаулла Шахын амь насанд халдахад ямар ч холбоогүй байсан нь нотлогдож, Оросын элчин сайд Түүний гэм буруугүйг бас гэрчилжээ. Бахауллагийн биеийн байдал туйлын хүнд байсан тул удахгүй нас барна хэмээн бүгд бодож байлаа. Тийм учраас цаазаар авахын оронд Шах Түүнийг Месопотами дахь Ирак уруу цөлөх тушаал өгсөн байка. Хоёр долоо хоногийн дараа Бахаулла Ирак уруу гэр бүл болон цөөн хэдэн дагалдагчдын хамт аян замд гарчээ. Тэд замдаа өвлийн хүйтэнд даарч, элдэв саад бэрхшээлтэй учирч, Багдадад туйлын ядарч туйлдсан байдалтай иржээ.

Бие нь тэнхэрмэгц Бахаулла сонирхсон хүмүүст сургаал дэлгэрүүлж, сүсэгтнүүдийг зоригжуулан, тэдэнд зөвлөгөө айлдаж эхэлсэн бөгөөд удсан ч үгүй Бабчуудын дунд энх тунх, аз жаргал дахин сэргэжээ. Гэхдээ ийм байдал удаан үргэлжилсэнгүй. Бахауллагийн эцэг нэгт дүү Субх-и-Азал хэмээх Мирза Яхья Багдадад ирж, элдэв хорон явуулга явуулж, Бабчуудын дунд яс хаяж, Христийн шавь нарын дунд үүссэнтэй адил хагарал бутралыг бий болгосон байна. Энэ хагарал нь хожим Адрианопольд улам гаарсан бөгөөд Бахауллагийн сэтгэлийг ихэд зовоож байсан юм. Түүний амьдралын хамаг зорилго нь дэлхий ертөнцийн хүн ардын дунд эв нэгдлийг тогтоох явдал байсан билээ.

## Хоёр жил эзгүй хээр

Багдадад ирснээс хойш нэг жилийн дараа Бахаулла нэг ээлжийн хувцаснаас өөр юу ч авалгүй Сулеймание-гийн эзгүй хээр лүү явжээ. Энэ үеийнхээ тухай Тэрээр “*Китаб-и-Иган*”<sup>1</sup> судартаа бичсэн байдаг. Үүнд:

“Энэ газар нутагт ирсэн анхны үед Бид ойртож буй үйл явдлын шинж тэмдгийг урьдчилан мэдээд, энэ газрыг орхин одохоор шийдсэн юм. Бид аглаг эзгүй хээрт хүрч, тэнд орь ганцаар хоёр жил амьдарлаа. Бидний нүднээс зовлон харууслын нулимс асгарч, цус хурсан Бидний зүрхэнд тарчлал зовлонгийн далай давалгаалан булгилж байв. Олон ч шөнө Бид хоолгүй хонож, олон ч одөр биеийн амар үзээгүй билээ. Миний зүрх сэтгэлийг гартаа атгасан Түүний нэрийг барин өчсү! Зовлон зүдгүүр, дуусаагүй хүнд бэрхийг амссан ч Бид туйлын баяр жаргалтай байсан бөгөөд Бидний бие жаргал баяслын далайд умбаж байв. Учир нь, орь ганцаар байхдаа Бид хэний ч хохирол, ашиг тус, хэний ч эрүүл энх, өвчин зовлонг үл мэдэрч байсан юм. Дэлхий ертөнц ба түүнд орших бүхнийг умартан Бид ганцаар гагцхүү Өөрийн сэтгэл санаатай л ярилцаж байлаа. Гэвч тэнгэрлэг хувь заяа нь зуурдын хорвоогийн хамгийн өргөн ойлголтоос ч дээгүүр, Бурханы зарлигийн сумыг хүний мэргэн ухаанаар дийлэшгүй гэдгийг Бид мэдээгүй байсан юм. Хэн ч Бурханаас заяасан заяа төөргөөсөө хальж чадахгүй, хэнд ч Бурханы хүсэл таалалд хүлцэхээс өөр зам байхгүй билээ. Бурханы нэрийг барин тангараглахад, Бид энэ нутгаас хэзээ ч явахгүй гэж хатуу шийдсэн байсан ба ойр дотны хүмүүстэйгээ удахгүй уулзана гэж найддаггүй байлаа. Үнэнч сүсэгтнүүдийн дунд эв түнжин хагарахын шалтгаан болохгүй юмсан, анд нөхдөд саад бэрхшээл учруулахгүй юмсан, хэнд ч хор хохирол, хэний ч зүрх сэтгэлд уйтгар гуниг авчрахгүй юмсан гэсэндээ Бид холдон зайлсан юм. Үүнээс өөр зорилт Бидэнд байгаагүй, үүнээс өөр арга бидэнд байгаагүй. Гэсэн ч хүн бүр өөрийн хүсэл эрмэлзлэлийн хойноос хөөцөлдөж байтал эцэст нь Нуугдмал Эх үүсвэрээс Биднийг ирсэн газар луугаа эргэж

<sup>1</sup> Энэ үе нь 1853 оны эхэн буюу Баб Өөрийгөө тунхагласнаас хойш есон жилийн дараах үе юм. “Китаб-и-Иган” буюу Иган Судар нь “Үл Эргэлзэхүйн Судар” гэсэн утгатай.

*буцахыг дуудсан юм. Өөрийн хүсэл зоригийг Түүний хүсэл зоригт даатгаад бид Бурханы зарлигийг дагасан болой.*

*"Буцаж ирээд бидний үзсэн зүйлийг ямар ч үзгээр дүрсэлж бичихийн аргагүй байлаа! Хоёр жил Биднийг эзгүй байх хооронд дайснууд Биднийг устгах гэж тасралтгүй бөгөөд цуцалтгүй тэмцсэн гэдгийг бүгд гэрчилнэ."*-"Китаб-и-Иган", х. 152-161

## Мулла нарын эсэргүүцэл

Бахауллаг буцаж ирсний дараа нэр алдар нь улам ихээр цуурайтаж, хол ойроос хүмүүс Багдадад ирж, Түүнтэй уулзаж, сургаал айлдварыг нь сонсдог байжээ. Иудейчүүд, Христийн шашинтнууд, Зороаструуд, Исламын шашинтнууд шинэ сургаалд сонирхолтой болов. Гэвч Мулла нар хүйтэн хөндий хандлага гаргаж, Түүнийг нураах гэж тасралтгүй оролдож байв. Нэгэн удаад Мулла нар өөрсдийнхөө дундаас нэг санваартанг Бахауллаг байцаахаар илгээжээ. Тэр Мулла Бахауллагийн мэргэн цэцэн яриа, сургуульд сурснаар олж аваагүй суу билигт нь гайхаш тасарч, эрдэм мэдлэг, ухаанаараа Бахаулла хосгүй юм гэж хүлээн зөвшөөрчээ. Гэхдээ түүнийг явуулсан Мулла нар Бахаулла хэрэв үнэхээр Зөнч мэргэн хүн мөн юм бол ямар нэгэн ид шидийг Тэрээр үзүүлж чадсан тохиолдолд тэд Түүний ариун үүргийг хүлээн зөвшөөрч, Түүнийг эсэргүүцэхээ болих ёстой, харин хэрэв Бахаулла тэр ид шидийг үзүүлж эс чадваас тэд Түүнийг нэр зээлдэгч хуурамч этгээд хэмээн үзэж болно гэсэн амлалтанд гарын үсэг зурах болзол тавив. Хэрэв Мулла нар үнэнийг олж мэдэх зорилготой байсансан бол энэ боломжийг алдахгүй л байх байсан. Гэвч тэд огт өөр бодолтой байлаа. Үнэнээр ч бай, худлаар ч бай тэд энэ хэргийг өөрсдийн талд шийдэхийг хүсч байв. Тэд үнэнээс эмээж, энэ халз дуудлагаас зугтжээ. Гэхдээ энэхүү ялагдал нь тэднийг уг хавчигдсан шашныхныг устгахын тулд шинэ шинэ явуулга хийхэд түлхсэн байна. Багдад дахь Персийн Ерөнхий консул бас тэдний талд орж, Бахаулла Исламын шашинд хор хөнөөл учруулах явдал нь гаарч байна хэмээн удаа дараалан Шахт гомдол мэдүүлж, Перс оронд муу нөлөө үзүүлж байгаа тул Түүнийг хаа нэгтээ хол алслагдсан газар цөлөх ёстой гэж итгүүлжээ.



Исламын санваартан нарын өдөөн хатгалга, явуулгаар Перс, Туркийн засгийн газрууд энэхүү хөдөлгөөнийг унтраахын тулд хүчээ нэгтгэж байсан бэрх эгзэгтэй энэ үед Бахаулла ер ажралгүй тайван хэвээр байж, сүсэгтэн олноо урамшуулан зоригжуулж, арилшгүй хосгүй сургаалаа айлдсаар байсан юм. “*Эрдэнийн Нуугдмал Үгс*” хэрхэн бичигдсэн талаар Абдул-Баха дурссан байдаг. Бахаулла Тигр мөрний эргээр олонтаа зугаалдаг байжээ. Зугаалаад буцаж ирэхдээ Тэрээр туйлын баяр баясгалангай харагддаг байсан бөгөөд мэргэн сургамж айлдсан уянгын сайхан эрдэнэ мэт үгсээ туурвидаг байв. Энэ үгс нь өвдөж шаналсан олон ч зүрх сэтгэлд тус дэм, анагаах эм нь болсон юм. Олон жилийн турш “*Эрдэнийн Нуугдмал Үгс*”-ийн гагцхүү хэдхэн гар бичмэл хувь нь л байдаг байсан бөгөөд дайснуудын гарт үл өртөөсэй хэмээн тэдгээрийг туйлын хянамгай хадгалдаг байлаа. Гэвч одоо энэхүү бяцхан ном нь Бахауллагийн бичвэр туурвилаас хамгийн нэрд гарсан нь гэж хэлж болох бөгөөд түүнийг бөмбөрцгийн өнцөг булан бүрт уншиж байна. *Иган Судар* бол Багдадад амьдарсан сүүлийн хугацаандаа (1862-1863) Бахауллагийн туурвисан бас нэгэн алдартай бүтээл юм.

### **Багдадын ойролцоох Ризван<sup>1</sup> цэцэрлэгт айлдсан Тунхаглал**

Удаан хэлэлцсэний дараа Персийн засгийн газрын хүсэлтээр Туркийн Засгийн газар Бахауллаг Константинопольд дуудах тушаал гаргажээ. Энэ мэдээг дуулаад сүсэгтэн олон ихэд гуниглан түгшиж, хайрт Удирдагчийнхаа гэр лүү яаравчлан очиж, үй олноороо хүрээлсэн байсан тул Бахауллагийн гэр бүл тэмээн жин ирэхийг хүлээх зуураа хотын захад орших Нажиб Паша-гийн цэцэрлэгт арван хоёр хоногийн турш буудалласан юм. Чухамхүү энэ арван хоёр хоногийн үеэр (1863 оны 4-р сарын 22-оос 5-р сарын 3-ныг хүртэл буюу Бабын тунхаглалаас хойш арван есөн жилийн дараа) Бахаулла Өөрийгөө Бабын зөгнөн хэлсэн Бурханы сонгосон Хүмүүн, бүх л Зөнч мэргэдийн Амласан Хүмүүн гэж

<sup>1</sup> Энэ үе нь 1853 оны эхэн буюу Баб Өөрийгөө тунхагласнаас хойш есөн жилийн дараах үе юм. “Китаб-и-Иган” буюу Иган Судар нь “Үл Эргэлзэхүйн Судар” гэсэн утгатай.

цөөн хэдэн дагалдагч нартаа зарлан тунхагласан юм. Энэхүү дурсамжтай үйл явдал болсон цэцэрлэг нь Бахайчуудын хувьд “Ризваны Цэцэрлэг” хэмээн алдаршсан бөгөөд тэнд Бахауллагийн өнгөрүүлсэн эдгээр арван хоёр өдрийг “Ризваны Баяр Наадмын өдрүүд” гэж жил бүр тэмдэглэдэг болсон юм. Тэрхүү хүнд бэрх өдрүүдэд Бахаулла огтхон ч уйтгар гунигт авталгүй, харин туйлын баяр жаргал, хүч чадлыг цацруулж байсан юм. Сүсэгтэн олон нь ч мөн баярлан цэнгэж, сэтгэл нь улам оргилж, олон түмэн Түүнд хүндэтгэл үзүүлэхээр бараалхаж байв. Багдадын нөлөө бүхий бүх иргэд, тэр дундаа Хотын захирагч өөрөө тэрхүү Цөллөгдөгчтэй салах ёс гүйцэтгэхээр ирсэн ажээ.

### Константинополь ба Адрианонополь

Бахаулла, Түүний гэр бүлийнхэн ба хорин зургаан шавь нараас нь бүрдсэн хэсэг хүмүүс Константинополь руу гурваас дөрвөн сарын дараа дахин нүүх болж, энэ удаад өмнөх аяллыг бодвол энэ нь хамгийн хүнд хэцүү аялал байлаа. Ихэнх өдөр цас тасралтгүй хаялж, тэд дулаан хувцас хунар, хоол хүнсээр тун тарчиг байсан учир маш ихээр зүдэрч явсан юм. Адрианопольд өнгөрүүлсэн анхны өвөл Бахаулла, Түүний гэр бүлийнхэн нийлээд арван хоёр хүн тохь тухгүй, хорхой шавьж үүрлэсэн гурван өрөө нэгэн жижиг байшинд амьдарч байв. Хавар нь тэдэнд арай тохилог байр олгожээ. Тэд Адрианопольд дөрвөн жил хагас гаруй болсон байна. Энд байхдаа Бахаулла Өөрийн сургаалыг номлох ажлаа дахин эхлэж, олон дагалдагчидтай болжээ. Тэрээр Өөрийн ариун үйл хэргийг ил тодоор зарлаж, *ихэнх Бабчуудын зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд тэр үеэс хойш тэднийг Бахайчууд гэж нэрлэх болсон юм.* Гэвч Бахауллагийн эцэг нэгт дүү Мирза Яхьяагаар толгойлуулсан цөөнх бүлэг Бахауллаг эсэргүүцэж, хуучин дайсан болох шийтүүдтэй хүчээ хавсарган Түүнийг устган нураах бодол агуулж байлаа. Улмаар асар их зовлон зүдгүүр тэдэнд нүүрлэж, эцэст нь Туркийн Засгийн газраас Бабчууд болон Бахайчуудыг Адрианополиос хөөж, Бахаулла ба Түүний дагалдагчдыг Палестины Акка хот уруу цөлсөн бөгөөд

гэд (Набил<sup>1</sup>ын бичсэнээр) 1868 оны 8 дугаар сарын 31-нд тэнд хүрсэн юм. Мирза Яхья тэргүүтэй хүмүүсийг Кипр лүү явуулсан байна.

### Хаадад илгээсэн Захидлууд

Энэ үед Бахаулла Туркийн Султан, Европын олон хаад, Ромын хамба лам болон Персийн Шахт өөрийн алдартай захидлуудаа илгээсэн юм. Хожим “*Китаб-и-Агдас*”<sup>2</sup> номондоо Тэрээр бусад хаад удирдагч нар, Америкийн Ерөнхийлөгч нар, шашны тэргүүн лам нарт жинхэнэ үнэн шашин, шударга захиргаа ба олон улсын энх тайвныг тогтооход бүх хүч чармайлтаа зориулахыг уриалсан юм. Шахт илгээсэн захидалдаа Тэрээр дарлагдсан Бабчуудыг эрч хүчтэйгээр өмгөөлөн зогсож, тэднийг хяхан хавчиж буй хүмүүстэй нүүр тулан уулзуулахыг хүссэн байдаг. Энэхүү хүсэлтийг нь болгоогоогүй гэдгийг хэлэх нь илүүц биз ээ. Бахауллагийн уг захидлыг хүргэж өгсөн идэр залуу үнэнч Бахай Бади-г баривчлан, улайссан туйпуугаар арьсыг нь шарж аймшигтайгаар тамлан алсан юм!

Мөнхүү захидалдаа Бахаулла Өөрийн зовлон зүдгүүр, хүсэл тэмүүллийн талаар үнэхээр сэтгэл хөдөлгөм байдлаар өгүүлсэн байдаг:

*“Хаан минь, хэний ч нүд хараагүй, хэний ч чих сонсоогүй зүйлийг Бурханы замналд би олж харсан билээ. Анд нөхөд минь надаас урваж, зам минь хавчигдаж, аюулгүй амгалан эх булаг минь ширгэж, энх тунх амьдралын минь тал шарлан гундсан билээ. Юутай олон гай гамшиг учирсан билээ, юутай олон гай гамшиг учрах бол! Миний араас хорт могой даган мөлхөж байхад би Хүчирхэг, Гоо жавхланта Бурхан уруу дөхөж байна. Мэлхийнээс минь урсах нулимсанд хэвтэр минь норжээ. Гэвч би өөрийн тухай эс шаналнам! Бурханыг барин тангараглахад, Эзэн тэнгэрийн минь замналд миний биеийг чам дээр цовдлоосой*

<sup>1</sup> Шүтлэгийн эхэн үеийн түүх “Үүрийн цолмонг гэтэлгэгчид” номын зохиолч. Тэрээр өөрөө эдгээр үйл хэргийн заримд нь оролцож байсан бөгөөд эхэн үеийн олон сүсэгтнүүдтэй танил байв.

<sup>2</sup> “Ризван” – диваажин гэсэн утгатай

билээ!!” гэж зүрх сэтгэлээрээ хэлэлгүй нэг ч модыг би өнгөрч явсангүй. Тийм ээ, яагаад гэвэл хүн төрөлхтөн мансуурч, буруу замаар явж буйг би харж байгаа боловч тэд үл мэднэ. Тэд өөрөдийн дур тачаалыг өргөмжилж, Эзэн Бурханаа өөрсдөөсөө холдуулж, Бурханы Зарлигаар тоглоом тохуу хийж байна. Тэд өөрсдийгөө сайн яваа, аюулгүй, энх байдлын өлгийд амгалан байгаа хэмээн эндүүрч байна. Гэвч тэдний бодож байгаагаас байдал эсрэг байна. Маргааш тэд одоо үгүйсгэж байгаа зүйлээ харах болно.

“Бид цөлөгдсөн хамгийн алс энэ нутгаас (Адрианатоль) нүүж Аккагийн шоронд очих гэж байна. Тэдний хэлж байгаагаар, тэр бол дэлхийн хамгийн алс орхигдсон хот, гоо үзэмжээрээр хамгийн муу муухай хот, уур амьсгалаараа хамгийн ой гутмаар, усны хувьд хамгийн бохир, шар шувууны үүр болоход таарах хот, шар шувууны хашигираанаас өөр чимээ сонсогдохгүй хот ажээ. Чухам ийм хотод тэд энэхүү Зарцыг хорьж, баяр баясгалангийн үүд хаалгыг бидний емнө хааж, амьдрах үлдсэн хугацаанд энэ орчлонгийн амьдралын сайн сайхныг биднээс холдуулах гэж санаархаж байна. Бурханыг барин тангараглахад, бие тэнхээ минь сульдэн доройтож, өлсгөлөн намайг устгавч, хатуу хад чулуу хэвтэр минь болж, элсэн цөлийн араатан ан амьтад миний анд нөхөд болсон ч би гундахгүй, шийдэмгий зоримог хүмүүсийн адил би Өмнөх Оршихуйн Хаан, улс үндэстнүүдийг Бүтээгч Бурханы хүч чадалд тэвчээртэй байх болно. Бүх л нөхцөлд би Бурханд талархал өргөнө. Тэрээр бүх хүмүүсийн нүүр царайг Хүчирхэг, Гоо Жавхланта Өөртөө чин сэтгэлээс ханддаг болгох болтугай хэмээн... Түүний буян хишгээс гуйн найдах болно. Үнэнхүү Тэрээр Өөрийг нь хүсэн мөргөн залбирч буй тэр хүмүүнд хариу өгч, өөрийг нь дуудаж буй тэр хүмүүнд ойр байх болно. Бид энэхүү харанхуй гай зовлонг Түүний ариун хутагт нарыг хурц сэлэм, нэвтлэх сумнаас хамгаалах бамбай болгохыг Түүнээс бид хүсэн залбирч байна. Зовлон бэрхшээлийн ачаар Түүний гэрэл гийж, Түүний магтуу тасралтгүй туяаран цацарнам. Энэ бол өнгөрсөн эрин үеүдэд ч ашигласан Түүний арга мөн болой.” Аянчны хүүрнэл (Бабын Үйл хэрэг), х. 146, 147

## **Аккад хоригдсон нь**

Тэр үед Акка (Акр) бол хамгийн адгийн гэмт хэрэгтнүүдийг Туркийн Эзэнт гүрний өнцөг булан бүрээс авчран хорьдог байсан шоронгийн хот байлаа. Далайгаар хүнд хэцүү амсан байж аялж ирсэн Бахаулла болон Түүний дагалдагч нарыг оролцуулаад эрэгтэй, эмэгтэй, хүүхэд хөгшин нийт наяс наян дөрвөн хүмүүс цэргийн хуарангийн цайзанд хоригдсон юм. Тэр бол туйлын бохир заваан, муу муухай газар байлаа. Тэнд ор дэр ч байхгүй, тав тухыг бий болгох юу ч алга байлаа. Өгч байсан хоол нь туйлын муу байсан тул хэсэг хугацааны дараа хоригдлууд өөрсдөө хоол хүнс худалдаж авах зөвшөөрөл гуйжээ. Эхний хэдэн хоногт хүүхэд багачуудын тасралтгүй уйлан бахирах дуунд бараг унтахын аргагүй байв. Хумхаа, цусан суулга болон бусад өвчин түргэн дэлгэрч, хоёроос бусад нь өвчилсөн байлаа. Хоёр нь өвчнөөс болж нас барж, үлдсэн хүмүүсийн зовлон зүдгүүр дүрслэхийн аргагүй хэцүү байсан юм.

Энэ аймшигт байдал хоёр жил гаруй үргэлжилсэн бөгөөд энэ үеэр нэг ч Бахай хүнийг шоронгийн хаалганы гадна гарахыг зөвшөөрдөггүй байсан боловч хуяг харгалзагчаар маш сайн харгалзуулсан дөрвөн хүн л өдөр тутам хоол худалдан авахаар гардаг байв.

Хуарангийн байшинд хоригдож байх үед эргэж ирсэн хүмүүсийг оруулахгүй тас хорьдог байлаа. Ираны хэд хэдэн Бахайчууд хайрт Удирдагчтайгаа уулзахын тулд алс хол газраас явган явж ирсэн боловч тэднийг хотын дотор орохыг зөвшөөрөөгүй юм. Тэд хотын гадна талын гурав дахь жалганы цаана задгай энгэр дээрээс Бахауллагийн амьдарч байсан өрөөний цонх уруу хардаг байжээ. Тэрээр цонхоороо тэднийг хардаг байсан ба тэд Түүний барааг холоос олж харчихаад уйлж, амь биеэ золиослон үйлчлэн зүтгэх шинэ эр зоригоор дүүрэн гэр гэртээ буцдаг байсан юм.

## **Хорио зөөлөрсөн нь**

Эцэс сүүлдээ тэдний хорио зөөлөрчээ. Бахауллаг гэр бүлтэй нь хамт нэгэн байшинд байрлуулж, бусад хүмүүсийг хотын амбааран

байшингуудад байрлуулжээ. Бахаулла энэ байшинд долоон жил хоригдсон юм. Түүний хоригдож байсан өрөөний хажуугийн жижигхэн өрөөнд гэр бүлийн эрэгтэй, эмэгтэй нийт арван гурван хүн чадах ядахаараа чихцэлдэн амьдрах ёстой байлаа! Энэ байшинд эхэн үед тэд зай завсар муу, хоол хүнс дутмаг, амьдралын наад захын тав тухаар дутагдаж байсны улмаас ихэд зүдэрч байсан юм. Хэсэг хугацааны дараа гэхдээ тэдний мэдэлд нэмэлт хэдэн өрөөг өгсөн бөгөөд харьцангуй тухтай амьдрах боломжтой болжээ. Бахаулла дагалдан явагсдынхаа хамт хуарангийн байрнаас гарсны дараа айлчлан ирэгсэд тэдэнтэй уулзах боломжтой болсон агаад Эзэн хааны засгийн эрх баригчдаас тогтоосон хатуу дэглэм үе үе чангардаг байсан боловч аажим аажмаар зөөлөрсөн юм.

### Шоронгийн хаалга нээгдлээ

Хорионы дэглэм туйлын хүнд байсан ч Бахайчууд гутарч шантардаггүй, ямагт амгалан тайван итгэлээр дүүрэн байсан юм. Аккагийн хуарангийн байранд хоригдож байхдаа Бахаулла хэсэг нөхдөдөө ингэж бичиж байжээ:

*“Бүү айгтун. Энэ үүд хаалга нээгдэх болно. Кармел Уулан дээр Миний асар зоогдож, туйлын их баяр жаргал ирэх болно”*

Энэ үг нь дагалдагчдынх нь хувьд үнэхээр тайтгарал болж байсан бөгөөд биелэх цаг нь ирэхэд үгчлэн биелсэн юм. Шоронгийн үүд хаалга хэрхэн нээгдсэн тухай Абдул-Бахагийн хэлснийг Түүний зээ хүү Шогн Эффендигийн орчуулснаар илэрхийлбэл дээр буй заа:

*“Бахаулла байгалийн гоо үзэсгэлэн, хөдөө нутгийн байгальд дуртай байсан юм. Нэг өдөр Тэрээр ингэж хэлсэн юм. “Би ногоон байгалийг есөн жилийн турш үзсэнгүй. Хөдөө нутаг бол сэтгэлийн ертөнц, харин хот бол бие махбодын ертөнц билээ.” Энэ үгийг нь би шууд бусаар дуулж мэдээд Түүний хөдөө нутагт хайртайг нь ухаараад энэ мөрөөдлийг биелүүлэхийн төлөө хийсэн бүхэн маань амжилттай болно гэдэгт би итгэлтэй байсан юм. Тэр үед Аккад Мухаммед Паша Сафватын гэрт очиж уулзаж, “Паша, та өргөөгөө хоосон орхиж, өөрөө Аккад юунд амьдарна вэ?” гэж*



хэлбэл тэрээр хариулахдаа: “Би тахир дутуу хүн. Хотоос гарч явж чадахгүй. Хэрэв тийшээ очвол ганцаардаж, найз нөхдөөсөө холдоно.” гэв. Би түүнд ингэж хэлсэн юм. “Та энд байгаа юм чинь өргөө чинь хоосон байна. Түүнийгээ бидэнд түрээслээч.” Тэр миний саналд ихэд гайхсан боловч удалгүй зөвшөөрсөн юм. Би байшинг жилийн таван фунтээр маш хямдхан түрээсэлж аваад таван жилийн төлбөрийг шууд төлж, гэрээ хийсэн билээ. Би өргөөг засварлаж, цэцэрлэгийг нь янзалж, халуун усны газар баруулахаар ажилчид илгээсэн юм. Мөн Адист Гоо Жавхлангийн хэрэгцээнд зориулан сүйх тэрэг бэлдсэн билээ. Нэг өдөр би өргөөг оөрийн нүдээр үзэхээр шийдлээ. Бид хотын хаалганы гадна ямар ч нөхцөлд гарч болохгүй гэж удаа дараа зарлиг буулгасан байсан ч би хотын хаалгаар гараад явсан юм. Харуулууд зогсож байсан ч намайг гарч явахад татгалзаагүй тул би шууд өргөө лүү чиглэн явсан юм. Дараачийн өдөр нь харуул цэргүүд хаалганы хоёр талд зогсож байсан хэдий ч би хэсэг нөхөд, албаны хүмүүсийн хамт хотоос ямар ч байцаалт, саадгүй гарч явлаа. Бас нэгэн өдөр би цайллага зохион байгуулж, Бахжи дахь шилмүүст модны сүүдэр дор ширээ засч, хотын нэр нөлөө бүхий хүмүүс болон албаны хүмүүсийг урьсан юм. Орой нь бид бүгд хот уруу цугтаа буцаж ирсэн билээ.

“Нэг өдөр Адист Гоо Жавхлангийн ариун орчинд нь очиж, “Мазрай дахь өргөө болон түүнд Таныг хүргэж өгөх сүйх тэрэг бэлэн боллоо,- гэж хэлсэн юм. (Тэр үед Акка юм уу Хайфад сүйх тэрэг байдаггүй байлаа). Тэрээр явахаас татгалзан: “Би чинь хоригдол хүн” гэж хэлэв. Хожим нь би Түүнээс дахин гуйсан боловч мөн л хариултыг сонссон юм. Би болохгүй болохоор нь гурав дахь удаа гуйсан боловч Тэрээр бас л “Үгүй!” гэж хариулав. Би тэгэхлээр нь цаашид гуйхыг зүрхэлсэнгүй. Гэвч Аккад маш нэр нөлөө бүхий нэгэн Исламын Шейх хүн амьдардаг байлаа. Тэр хүн Бахаулаг ихэд хайрладаг байсан бөгөөд Тэрээр ч тэр хүнийг бас хайрлан хүндэтгэдэг байсан юм. Би тэр Шейх хүнийг дуудаад байдлыг тайлбарласан билээ. “Та зоригтой хүн. Та өнөө орой Түүн дээр очиж, хөлд нь сөгдөж, гараас нь атгаж, хотоос гарч явна гэж зөвшөөртөл нь гарыг нь бүү тавь.” гэж би түүнд хэлэв.

Тэр бол араб хүн байсан юм... Тэр хүн шууд Бахаулла дээр очоод Түүний хөлд нь сөгдөж, Адист Гоо Жавхлангийн гарыг нь атган үнсэж, ингэж хэлжээ. "Бурхан өршөөг! Таныг хоригдол болгох хүч чадал хэнд байна? Та Өөрөө л Өөрийгөө шоронд байлгаж байгаа шүү дээ. Та өөрөө л хоригдоно гэж шийдсэн тул одоо таныг энэ хотоос явж, өргөөнд очиж амьдрахыг би гуйя. Тэр бол маш үзэсгэлэнтэй, ногоон газар шүү. Мод ургамал нь хичнээн сайхан, жүрж жимс нь яг л галын бөмбөлөг шиг!" Адист Гоо Жавхлан урьдын адил татгалзаж, "Би бол хоригдол учраас болохгүй" гэж хэлэхэд Шейх Түүний гарыг атган үнслээ. Бүтэн цагийн турш тэрээр гуйж шалсаар байжээ. Эцэст нь Бахаулла, "Хэйли хуб (маш сайн)" гэж хэлээд Шейхийн тэвчээр, тууштай сэтгэлийг шагнажээ. Шейх над дээр баяр хөөр болсоор ирж, Ариун Гэгээнтэн зөвшөөрлөө гэсэн баярт мэдээг дуулгасан юм. Абдул-Азизын хатуу чанд тушаалаар би Адист Гоо Жавхлантай уулзаж ярилцах хориотой байсан боловч дараачийн өдөр сүйх тэрэг хөллөж, Түүнийг өргөөнд нь аваачиж өгсөн юм. Хэн ч надад саад хийгээгүй шүү. Би Түүнийг тэндээ үлдээж, өөрөө хот уруу эргэж ирсэн билээ.

"Хоёр жилийн турш Тэрээр тэрхүү сэтгэл булаам сайхан газар амьдарсан. Дараа нь Бахжид хэмээх өөр газар луу нүүхээр шийдсэн юм. Тэр үед Бахжид нэгэн халдварт өвчин гарч, байшингийн эзэн айсандаа гэр бүлээ аваад тэр газраас явсан бөгөөд байшингаа хэний ч хамаагүй гарт үлдээхэд бэлэн байсан юм. Бид байшинг маш бага үнээр түрээслэж, сүр хүч, үнэн ноёрхлын үүд хаалга өргөн нээгдсэн юм. Бахаулла хэдийгээр хоригдол нэртэй байсан боловч (Султан Абдул-Азизын аймигт зарлигийг хэзээ ч халаагүй юм) үнэн хэрэгтээ амьдралдаа нэр төртэйгээр биеэ авч, эрхэмсэг дээд хүн байсан бөгөөд асар их тэсвэр тэвчээр үзүүлсэн тул хүн бүхэн Түүнийг хайрлан хүндэлж, Палестины удирдагч нар Түүний нэр нөлөө, хүч чадалд атаархдаг байсан юм. Захирагч, мутасарриф нар, генерал, орон нутгийн албат нар Түүнтэй уулзах аз завшааныг хичээнгүйлэн эрэн хүсдэг байсан агаад Тэрээр ховорхон удаад л хүсэлтийг нь болгоодог байлаа.

“Нэг удаа хотын Захирагч нэгэн генералын хамт Адист Гоо Жавхлантай уулзах тушаалыг дээд байгууллагаас авсан гэсэн үндэслэлээр ийм завшааныг эрэн хүсчээ. Хүсэлтийг болгоосон бөгөөд цуг ирсэн генерал нь маш тарган Европ хүн байсан агаад тэрээр Бахауллагийн эрхэмсэг дүр төрхийг харан алмайрч; хаалганы хажууд шалан дээр өвдөглөж суусан хэвээр үлдэжээ. Хоёр зочны алмайрал их байсан тул Бахаулла тэднийг хэд хэдэн удаа “наргиле” татахыг урьсны дараа л ухаан орж тамхийг авсан боловч уруулаараа жаахан хүргээд хажуу тийш нь тавьж, гараа эвхэн туйлын даруу хүлцэнгүй, хүндэтгэлтэй байдлаар суусанд тэнд байсан хүмүүс гайхжээ.

“Анд нөхдийнх нь хайр бишрэл, албаны хүмүүс болон нэр нөлөө бүхий хүмүүсийн зүгээс үзүүлсэн анхаарал хүндэтгэл, мөргөлчид болон үнэнийг эрэлчдийн тасралтгүй цуваа, эргэн тойронд нь шлэрч байсан бишрэл сүсэг болон үйлчилгээ буяны оюун санаа, Адист Төгс үзэсгэлэнгийн эрхэмсэг бөгөөд хаан хүний гэмээр дүр төрх, Түүний зарлиг лүндэнгийн үр нөлөө, Түүний оргилуун үнэнч шавь нарын тоо хэмжээ - энэ бүхэн болбоос Бахаулла бол хоригдол бус үнэн хэрэгтээ Хаадын Хаан юм гэдгийн гэрч болж байсан билээ. Хоёр дарангуйлагч хаан, хоёр бүрэн эрхэт удирдагч Түүний эсрэг хандаж байвч тэдний шоронд хоригдож байхдаа хүртэл Тэрээр тэдэнд хамгийн тушаангуй байдлаар хандаж байсан агаад Бахжид Тэрээр хунтайж лугаа адил амьдарч байсан юм. Тэрээр: “Үнэнхүү, хамгийн адгийн энэ шорон Эдений Диваажин болон хувирчээ.” гэж олонтоо хэлдэг байв.

“Үнэхээр ч ийм зүйлийг дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш хэн ч үзээгүй бөлгөө.”

### **Бахжи дахь амьдрал**

Хүнд хэцүү бэрхшээлээр дүүрэн анхны жилүүддээ ядуу зүдүү, хатуу хүнд байдалд Бурханыг хэрхэн магтан мандуулахыг Тэрээр үзүүлсэн шиг Бахжид амьдарч байсан хожмын он жилүүддээ алдар гавьяаг олсон баян чинээлэг байдалдаа Бурханыг хэрхэн магтан мандуулахыг бас харуулсан юм. Хэдэн зуун мянган

үнэнч дагалдагчид асар их хэмжээний мөнгө хөрөнгийг Түүний гарт хандив болгон өргөснийг Тэрээр захиран зарцуулах ёстой байлаа. Бахжи дахь Түүний амьдрал хэдийгээр хаан хүнийх шиг байсан гэх боловч энэ үгийг хамгийн эрхэм дээд утгаар нь материаллаг сүр жавхлан буюу хээнцэр тансаг байдалтай байсан хэмээн ойлгож болохгүй юм. Адист Гоо Жавхлан ба Түүний гэр бүлийнхэн туйлын энгийн даруу маягаар амьдардаг байсан бөгөөд тэр айлд тансаг гоёлын төлөө мөнгө зарцуулна гэдгийг мэддэггүй байлаа. Гэрийнх нь хажууд сүсэгтнүүд “Ризван” хэмээх нэртэй үзэсгэлэнтэй сайхан цэцэрлэгийг байгуулсан бөгөөд тэнд Тэрээр олон өдөр, бүр долоо хоног дараалан өнгөрүүлж, шөнөдөө цэцэрлэг доторх нэгэн жижиг байшинд хоноглодог байлаа. Заримдаа Тэрээр нэлээн хол ч явдаг байвы. Тэрээр Акка ба Хайфад хэд хэдэн удаа очсон бөгөөд нэг бус удаа Аккагийн хуаранд хоригдож байхдаа урьдчилан зөгнөсөнчлөн Кармел Уулан дээр асар майхнаа зассан юм. Бахаулла ихэнх цагаа мөргөл бясалгалд өнгөрүүлж, Ариун Судар бичгээ бичиж, Сургаал бичгээ туурвиж, анд нөхдийг оюун санаагаар боловсруулан гэгээрүүлдэг байв. Энэхүү агуу үйлст нь бүрэн эрх чөлөөг олгохын тулд Абдул-Баха бусад бүх ажлыг зохицуулж, тэр ч бүү хэл Мулла нар, яруу найрагчид, Засгийн газрын гишүүдтэй уулздаг байсан юм. Тэд бүгдээрээ Абдул-Бахатай уулзахдаа баяртай байсан бөгөөд түүний гайлбар, айлдварт ямагт сэтгэл ханамжтай байдаг байсан юм. Тэд хэдийгээр Бахауллагатай Өөртэй нь уулзаагүй ч Түүний хүүтэй уулзсанаар Бахауллаг эчнээ хүндлэн найрсагаар ханддаг байсан билээ. Учир нь, Абдул-Бахагийн төрх байдал тэдэнд Эцгийнх нь байр суурийг ойлгуулж чадсан юм.

Дорно дахины нэр судлаач, Кеймбриджийн их сургуулийн сүүлийн үеийн Эдвард Профессор Г.Браун нь Бахауллаг Бахжид байхад 1890 онд очиж уулзсан бөгөөд дараах байдлаар өөрийн сэтгэгдлийг бичиж үлдээжээ:

*“Намайг дагуулж явсан хүн намайг гутлаа тайлах зуур хэсэг хүлээж зогслоо. Дараа нь гарын түргэн хөдөлгөөнөөр тэрээр хөшгийг нээж, намайг дотоги оруулан хөшгийг буулгалаа. Ингээд би нэгэн том өрөөнд ороод ирчихсэн байлаа. Өрөөний хоймор*

хэсэгт нэгэн намхан буйдан байсан бөгөөд хаалганы эсрэг талд хоёр юм уу гурван сандал тавьсан байв. Би хэдийгээр хаашаа явж байгаа, хэнтэй уулзах гэж байгаагаа бүдэг бадагхан гадарлаж байсан ч (надад ямар ч тодорхой зүйл хэлж өгөөгүй байсан юм) гайхаж балмагдсан байдалд нэг хоёр хором өнгөрөхөд өрөөнд би ганцаараа биш гэдгээ мэдэрч эхэлсэн юм. Буйдан ханатай нийлсэн тэр буланд хайр бишрэл татмаар гайхамшигтай нэгэн хүн сууж байх агаад тэр хүн дервишүүдийн хэлдгээр “таж” гэдэг толгойн өмсгөл (гэхдээ ердийн бус загвар өндөртэй) өмссөн байсан бөгөөд “таж”-ийн амсраар жижигхэн цагаан тюрбан ороосон байв. Ширтэж байсан тэр нүүр царайг би дүрсэлж явч дийлэхгүй ч хэзээ ч мартаж чадахгүй. Хурц тод мэлхий нь хүний сэтгэлийг голд нь ортол уншиж байгаа мэт байх бөгөөд өтгөн хөмсөг нь хүч чадал, эрх сүрийг нь илтгэж, тас хар үс болон дүрсэлж бичихийн аргагүй хээнцэр маягаар бараг бүсэлхий хүртлээ унжсан сахалд нь нуугдавч духан дээрх үрчлээс, царай нь нас сүүдрийг нь илчилж байлаа. Хэний өмнө зогсож байсныг минь асуух нь шүүц биз ээ. Ван ноёдуудын атаархлыг төрүүлж, эзэн хаадуудыг харамслын санаа алдуулах тийм их хайр бишрэлийг хүлээсэн Хүмүүний өмнө би мэхийн ёслолоо.

“Зөөлөн намуухан дуугаар тэрээр намайг суухыг урьж, ингээж хэлэв: “Бурханы авралаар та зорьсондоо хүрлээ!... Та цөлөгдсөн хоригдолтой уулзахаар иржээ... Бид энэ дэлхий ертөнцөд сайн сайхныг хүсч, улс үндэстнүүдэд аз жаргалыг ерөөдөг, гэвч тэд биднийг тэмцэл зөрчлийг өдөөгч, хорьж цөлөгдөхөөр гавьяатай гэж үзэх юм... Бүх улс үндэстнүүд нэг л сүсэг бишрэлтэй, бүх хүмүүс ахан дүүс шиг болох ёстой. Хайр хүндэтгэл, эв нэгдлийн холбоо хүмүүний үрсийн хооронд бэхжиж, шашны ялгаа зөрчил зогсож, үндэстэн ястны хоорондын тэмцэл халагдах ёстой. Ингээж бодоход юу нь болохгүй байна?... Гэсэн ч ингэ... болно. Үр ашиггүй эдгээр тэмцэл, гай гамшиг таригч дайн дажин өнгөрч, “Хамгийн Агуу Энх Тайван” ирнэ... Европт та нарт энэ бас хэрэгтэй биш гэж үү? Христ ингээж зөгнөн айлдаагүй гэж үү?... Гэвч танай хаад удирдагч нар хүн төрөлхтөнд аз жаргалыг авчрахын оронд, хүмүүн төрөлтийг устгах арга замаар шүү

*эрх чөлөөтэйгөөр эд баялгаа арвижуулж байна... Энэ бүх тэмцэл, цус асгаралт, зөрчил маргаан зогсох ёстой. Бүх хүмүүс нэг л ард түмэн, нэг л гэр бүл болох ёстой... Хүн өөрийн орныг хайрласандаа биш харин бүх дэлхийг хайрласандаа алдар гавьяа олог...*"

*"Миний санан дурсаж байгаагаар бусад олон үгийн дотор би Баха-гаас ийм л үгсийг дуулсан юм. Эдгээрийг уншсан хүмүүс сайтар тунгаан бодож, ийм номлол сургаал нь үхэлтэй тэнцэх үү, эвийн холбоонд хургэх үү, дэлхий ертөнц эдгээрийг дэлгэрүүлснээр үр ашиг олох нь уу, эсвэл алдан эндүүрэх үү гэдгийг бодож олог."* Аянчны Хүүрнэл (Бабын Үйл хэрэг)-ийн оршил хэсэг, х. 39.

### **Тэнгэрт хальсан нь**

Тийнхүү Бахаулла амгалан тайван байдалд насныхаа намрыг эдэлж байтал 1892 оны 5-р сарын 29-нд Тэрээр хижиг өвчин тусч далан таван насандаа тэнгэрт хальсан юм. Түүний туурвисан хамгийн сүүлийн Сургаал бичиг дотор Түүний Гэрээслэл нь байсан бөгөөд түүнийгээ Өөрийн гараар бичиж, гарын үсэг тамгаа тавьсан байсан юм. Насан өөд болсноос нь хойш есөн хоногийн дараа ууган хүү нь Гэрээслэл бичгийн лацыг гэр бүлийн гишүүд болон цөөн хэдэн анд нөхдийн дэргэд нээж, богинохон боловч гайхамшиг тэр баримт бичгийн агуулгыг зарласан юм. Уг Гэрээслэл ёсоор Абдул-Баха нь эцгийнхээ төлөөлөгч бөгөөд Түүний Сургаалыг номлон тайлбарлагчаар томилогдож Бахауллагийн гэр бүлийнхэн төрөл садан ба сүсэгтэн олон Абдул-Бахад хандан Абдул-Бахагийн үгийг дагах ёстой болсон юм. Энэ Гэрээслэлийн ачаар аливаа хагарал бутралаас аврагдаж, Үйл Хэргийн эв нэгдэл хамгаалагдсан юм.

### **Бахауллагийн Зөнч мэргэн мөн чанар**

Бахауллагийн Зөнч мэргэн мөн чанарын талаар тодорхой ойлголттой болох нь чухал билээ. Түүний үг айлдварыг бусад тэнгэрлэг "Тодруулагч" нарын үг айлдварын адил хоёр хувааж болох юм. Нэгэнд нь Тэрээр бусад хүмүүст хандаж хэлэх



сургаалыг Бурханаас хүлээн авсан хүний хувьд айлдаж байхад нөгөөд нь Тэрээр Бурханыг Өөрийг нь төлөөлөн өчдөг юм.

“*Китаб-и-Иган*”-д Тэрээр бичихдээ:

“*Мөнхийн ариун гэгээн Эх булгаас ундран цацрах Гэрэлт Элч бүр нь хоёр байр суурьтай гэж бид өмнөх хуудсуудад нэгэнт батлан хэлсэн билээ. Тэдгээр байр суурийн нэг нь амин чухал эв нэгдлийн байр суурь бөгөөд “Бид тэдний хооронд ямар ч ялгаа гаргахгүй” гэж тайлбарласан билээ.* (Коран 2:136) *Нөгөө нэг байр суурь нь ялгааны байр суурь бөгөөд энэ нь биет орчлон болон түүний хязгаарлагдмал чанартай хамаатай зүйл юм. Энэ утгаараа Бурханы Тодруулагч бүр өөр өөр нэрээр алдаршиж, ямар нэгэн онцгой шинж чанарыг илэрхийлж, ямар нэгэн тодорхой ариун үүргийг хэрэгжүүлж, тодорхой нэгэн Үүдэл нээлтийг айлддаг бөлгөө. Тэрээр хэлсэн нь: “Зарим Шавь нарыгаа бусад Шавь нараас давуу байхыг Бид соёрхсон юм. Заримтай нь Бурхан харилцан ярьж, заримыг нь Тэрээр дээш өргөн дэвжээсэн байдаг. Түүнчлэн бид Мари-гийн Есуст тодорхой шинж тэмдгийг олгож, Түүнийг Ариун Сүнсээр бэхжүүлсэн юм.”* (Коран 2:253)...

*Тийнхүү тэдний нэг нэгдмэл чанар болон тэнгэрлэг ангижралын үүднээс авч үзвэл, Тэнгэрлэг, Эрхэм дээд тэнгэрт дангаар орших, Дотоод Мөн чанар зэрэг Бурханы шинж чанар Ахуйн тэдгээр Мөн чанар болсон Элч нартай холбогдон илэрч ирсэн, илэрч ч байна. Учир нь Тэд бүгд л Тэнгэрлэг Үүдэл нээлтийн хаан ширээнд заларч Тэнгэрлэг Нууцсын суудалд суусан бөлгөө. Тэд залран тодорсноор Бурханы Үүдэл нээлт нээгдэж тэдний өнгө зүсээр Бурханы Гоо үзэсгэлэн танигддаг ажгуу. Тийнхүү Тэнгэрлэг Ахуйн эдгээр тодруулагч нарын өмнөөс Бурханы өөрийнх нь үг айлдвар ундран гарч байгаа болой.*

*Тэднийг хоёр дахь байр суурийнх нь үүднээс, өөрөөр хэлбэл тэдний ялгаа, онцлог бодит хязгаарлагдмал чанар, шинж төрх ба хэм хэмжээний байр суурийнх нь үүднээс авч үзвэл тэд буян үйлдэх туйлын үзэл санаа, амьдралд нь тохиолдох асар их зовлон гачигдал ба өөрийгөө бүрэн огоорсон сэтгэлийг илтгэж байдаг. Тэрээр айлдахдаа:*

"Би болбоос Бурханы Зарц боол, би болбоос та нарын хүмүүн буюу" гэж хэлсэн байдаг... Бурханы эдгээр тодруулагчийн хэн нь ч "Би бол Бурхан" гэж зарлан тунхаглах аваас Тэрээр үнэнхүү үнэн үг ярьсан болох бөгөөд үүнд эргэлзэх зүйл огтгүй болно. Учир нь тэдний үүдэл нээлт, тэдний шинж чанар алдар нэрээр дамжин Бурханы үүдэл нээлт, Бурханы алдар нэрс шинж чанарууд нь дэлхий ертөнцөд тунхаглагдаж байдаг гэдэг нь олонтаа давтагдаж нотлогдсон билээ. Тийнхүү Тэрээр айлдсан нь: "Тэдгээр цацраг нь Чинийх бус Бурханых бөлгөө." (Коран 8:17) Тэрээр мөн хэлэхдээ: "Үнэн хэрэгтээ Чамд үнэнчээ тангараглагсад чухамхүү Бурханд үнэнчээ тунхагласан хэрэг юм." (Коран 48:10) гэсэн байна. Тэдгээр Тодруулагчдын хэн нэгэн нь "Би болбоос Бурханы Элч" хэмээн дуу хоолойгоо гаргавал, Тэрээр хэлэхдээ: "Мухаммед та нарын дунд ямар ч хүний эцэг биш, гэвч Тэрээр Бурханы Элч болой" гэжээ. Энэ үүднээс шинжиж үзвээс тэд бол тэрхүү хувиришгүй Мөн чанар болсон төгс Хаан эзний Элч нар бөлгөө. Хэрэв тэд "Би бол Зөнч мэргэдийн Түлхүүр болой" гэж бүгд зарлаваас тэд үнэнхүү бүдэгхэн сүүдэр төдий ч эргэлзэх зүйлгүй үнэнийг хэлсэн хэрэг билээ. Учир нь, тэд бүгд нэг л хүмүүн, нэг л сэтгэл санаа, нэг л сүнс, нэг л ахуй, нэг л үүдэл нээлт юм. Тэд бүгд "Эхлэл" ба "Төгсгөл", "Анхны" ба "Эцсийн", "Үзэгдэхүй" ба "Нуугдмал" гээд Сүнсний Дотоод Сүнс хийгээд Мөн чанаруудын Мөнхийн Мөн чанар болсон Түүнд хамаарах бүхний тодрол илэрхийлэл билээ. Тиймээс тэд: "Бид Бурханы шадар зарц нар болой" (Коран 33:40) гэж хэлбэл энэ нь тодорхой бөгөөд маргашигүй үнэн баримт болно. Яагаад гэвэл, тэд зарлан тодрохдоо ямар ч хүний үзүүлж үл чадах тийм их буян үйлдэж үйлчлэх туйлын сэтгэлийн илэрхийлэл болж чадсан билээ. Тийнхүү Ахуйн энэхүү Мөн чанар бологсад өнө эртний, ашид мөнхийн гэгээн чанарын тэнгис далайн ёроолд шумбаж байхдаа, эсвэл Тэнгэрлэг нууцсын нэн сүрлэг өндөрлөгөөр дүүлэн тэнүүчилж байхдаа өөрсдийн айлдсан үгийг Тэнгэрлэг Дуу хоолой буюу Бурханы Өөрийнх нь Дуудлага хэмээн зарлаж ирсэн юм.

Мэргэн гярхай билгийн нүдээ нээж сайтар ажваас, ийм их агуу байр суурийг эзэлсэн атлаа Бүхнийг захирагч, Тусгаар

тогтногч Бурханы өмнө тэд өөрсдийгөө туйлын өчүүхэн дорой хэмээн үзэж байсныг хүлээн зөвшөөрөх болно. Тэд өөрсдийгөө юу ч биш, өөрсдийг нь тэрхүү Өргөөнд дурсах явдлыг Бурханыг үл хүндэтгэсэн зүйл хэмээн үзэж ирсэн гэж би бодном. Учир нь ийм Өргөөнд “би” үзлийн өчүүхэн ч гэсэн шивнээ бол өөрийн эрхийг довийлгох, тусгаар тогтнохын нотолгоо юм. Тэрхүү өргөөнд нэвтрэгсдийн үзэлд ингэх нь харамсалтай нүгэл гэм болдог аж. Түүний байх Орчинд Түүнээс өөр зүйлийг дурсаж дурьдах, хүний зүрх сэтгэл, хэл яриа, оюун ухаан, сэтгэл зүрх нь Хамгаас Хайртаас өөр зүйлийн хойноос завгүй хөөцөлдөж, хүний мэлмий нь Түүний гоо үзэсгэлэнгээс өөр зүйлийг ширтээж, хүний сонор Түүний Дуу хоолойноос өөр аялгууг шимтэн сонсож, хөл нь Түүний замаас өөр замаар алхлан гэлдэрвэл юутай шүү харамсалтай болох билээ.

Энэ өдөр Бурханы сэвшээ үлээж, Түүний сүнс бүх л юмсыг эзэмдэжээ. Түүний буян хишгийн ундрал ийм ариун тул үзэг бийр хөшиж, үг хэл дуугарах чадалгүй болно. Энэхүү байр суурийн буянаар тэд өөрсдийгөө Тэнгэрлэг Дуу хоолой гэх мэтээр нэрлэж ирсэн бол Элчийн байр суурийн үүднээс тэд өөрсдийгөө Бурханы Элч нар гэж зарлаж иржээ. Тохиолдол бүрт тэд тухайн үйл явдлын шаардлагад нийцэх айлдварыг дуусгаж эдгээр тунхаглалыг Өөрсөдтэйгээ холбож, эдгээр тунхаглал нь Тэнгэрлэг Үүдэл нээлтийн орчноос авхуулаад орчлон дэлхий, Тэнгэр орчлонгоос эхлээд газар дэлхийн оршин тогтнол хүртэл хамарч байдаг юм. Тийнхүү тэдний айлдсан айлдвар бүр нь Тэнгэрлэг орчлон, Эзэн тэнгэр, Зөнч мэргэн, Элч, Асран тэтгэгч, Анхны шавь, Буян үйлчилгээнд хамааралтай бүхий л айлдвар нь өчүүхэн ч гэсэн эргэлзээ төрөх үл үндэсгүй үнэн юм. Тиймээс Үл үзэгдэх орчлонгийн Тодруулагч нар болон Ариун гэгээн тэнгэрийн Үүрийн туяа бологсдын хэлсэн айлдвар ялгаатай буйд хүний сэтгэл санаа самуурч, оюун ухаан төврөгдөхөө болиосой хэмээсэндээ Өөрийн учирлалд дэмжлэг болгон Бидний иш татсан эдгээр үгст анхаарал хандуулваас зохилтой. “Китаб-и-Иган”, х 176-181

Бахаулла хүмүүний үүднээс хэлэхдээ, Өөрийн байр суурийг “Бурханы өмнө арчаагүй хоосон”, туйлын хүлцэнгүй хүмүүний

байр суурь гэж хэлдэг. Бурханы Тодруулагчийг бусад хүмүүсээс ялган онцолдог зүйл бол өөрийгөө огоорох. Түүний туйлын сэтгэл ба Түүний төгс төгөлдөр хүч чадал юм. Бүхий л нөхцөлд Тэрээр “Гэсэн хэдий ч миний бус Таны хүсэл таалал биелнэ” гэж Гетсеманы цэцэрлэгт Есүсийн хэлдэг шиг хэлж чадна. Бахаулла “*Шахт илгээх захидал*”-даа ингэж бичсэн байдаг:

*“Хаан минь! Бид бусад хүмүүсийн л адил хэвтэртээ нойрсон байтал, Ээ, Хамгаас Жавхлантын зөвлөн сэвшээ Намайг үлээж, бүхий л эрдэм мэдлэгийг зааж сургасан юм. Энэ бол Надаас гарч буй зүйл биш харин Бүхнээс Хүчирхэг, Бүхнийг Мэдэгч, Бурханаас гарч буй зүйл болой. Тэрээр Намайг газар дэлхий ба тэнгэр диваажингийн хооронд Дуу хоолойгоо өндөрсгөхийг болгоосон бөгөөд ингэснээр ухаант хүмүүн бүрийн нүднээс нулимс мэлмэрүүлэх зүйл Надад тохиолдсон юм. Хүмүүсийн дунд буй өнөөгийн эрдмийг Би судалж сураагүй, Би тэдний сургуульд ч суралцаагүй... Энэ бол Хамгаас Хүчтэй, Хамгаас Магтуут Эзэн тэнгэрийн чинь салхи үлээн хийсгэсэн олон навчнуудын л нэг юм. Энэхүү хүчтэй ширүүн шуурга мандаж байхад энэ навч хөдөлгөөнгүй байж чадна гэж үү. Үгүй, Хамаг бүхний эзэн тэнгэр Түүнийг барин тангараглая! Тэд түүнийг үлээн хийсгэнэ. Зуурдын мөхөлт нь Мөнхөд Орших Түүний өмнө юу ч үгүй хоосон зүйл болой. Түүний бүхнийг эзэгнэгч дуудлага Надад хүрч, бүх хүмүүсийн дунд Түүний магтууг өргө хэмээн Намайг үг хэлүүлсэн юм. Би Түүний зарлиг айлдагдахад яг л үхсэн мэт байлаа. Энэрэнгүй, нигүүлсэнгүй Эзэн тэнгэрийн чинь хүсэл тааллын мутар Намайг хувьсган өөрчилсөн бөлгөө. Дээд доод ялгалгүй бүх хүмүүсийн эсэргүүцлийг өдөөх байдалар ямар нэгэн хүн өөрийн хүслээр үг хэлж чадна гэж үү? Үгүй ээ, Бийрэнд мөнхийн нууцыг зааж сургасан Түүний нэрийг барин тангараглая. Бүхнээс Хүчирхэг, Хамгаас Чадалтай Түүний буян хишгээр бэхжсэн түүнийг аврагтун. “Лаух-и-Султан” (Персийн хаанд илгээсэн захидал), “Амлагдсан өдөр ирлээ” номонд иш татсанаар, х. 40-41*

Есүс хутагт шавь нарынхаа хөлийг угааж өгдөг байсан шиг Бахаулла заримдаа дагалдагч нарынхаа хоол ундыг хийж, бусад доорд ажил үүргийг нь гүйцэггэж өгдөг байжээ. Тэрээр зарц

нарынхаа зарц байсан бөгөөд үйлчлэн зүтгэх үйлсдээ л алдар нэр олдог байсан агаад шаардлагатай бол нүцгэн шалан дээр ч унтаж, дан ганц талх усаар ч хооллож, тэр ч бүү хэл Өөрийнх нь хэлдгээр “өлсгөлөн хэмээх тэнгэрлэг тэжээлээр” хооллохдоо сэтгэл хангалуун байдаг байлаа. Байгаль дэлхий, хүмүүний мөн чанар, ялангуяа ариун гэгээнтэн, зөнч мэргэн, амь биеэ золиослогсдыг хайрлан биширдэг байсан нь Түүний төгс даруу байдлыг илтгэж байсан юм. Түүний хувьд хамгийн багаас хамгийн том хүртэл бүх л юм Бурханы л шинж тэмдэг байсан билээ.

Түүний хувь хүний мөн чанарыг Бурхан, Тэнгэрлэг Айлдагч, Бийр хэмээн сонгон авсан юм. Тэрээр хосгүй их бэрхшээлийг даван туулах болсон нь Өөрийнхөө хүсэл тааллаар бус байлаа. Есүсийн хэлснээр: “Эцэг минь, хэрэв боломжтой бол энэ аягыг надаас зайлуулж өгнө үү” гэдэг шиг Бахаулла: “Өөрийн нэгэн айлдагч илтгэгч хүмүүн байсансан бол Бид Өөрсдийгөө ийнхүү хүмүүсийн зүгээс хяхалт хяналт, доромжлол, гүтгэлэг гүжирдэлтэнд өртүүлэхгүй байх байсан билээ” (Ишрагатын Бичиг) гэжээ. Гэвч тэнгэрлэг дуудлага тод бөгөөд тушаангуй байсан тул Тэрээр Түүнд захирагдсан юм. Тийнхүү Бурханы хүсэл таалал Түүний хүсэл таалал болж, Бурханы таашаал Түүний таашаал болж хувирсан бөгөөд гэрэлт сэтгэл, хүлцэнгүй байдлаар ийнхүү тунхагласан юм.

“Үнэнхүү би хэлье: Бурханы замналд учрах бүхэн болвоос сэтгэл санааны эрхэм мөрөөдөл бөгөөд зүрхний эрхэм хүсэл юм. Түүний замналд амсах үхлийн хор болвоос цэвэр нандин бал бурам, энэ замд учрах зовлон бэрхшээл бүхэн болвоос болор тунгалаг усны дусал юм” —Бахаулла, Чонын бэлтрэгт илгээх Сургаал бичиг, х. 17

Бидний дурдсанчлан бусад тохиолдолд Бахаулла “Бурханы нэрийн өмнөөс” ярьдаг. Ингэж айлдаж байхдаа Түүний хувийн мөн чанар бүрэн уусаж, бүрмөсөн орхигддог. Түүгээр дамжин Бурхан Өөрийн бүтээл хамаг амьтантай ярилцаж, Өөрийн хайрыг тэдэнд таниулж, Өөрийн шинж чанарыг зааж сургаж, Өөрийн хүсэл тааллыг мэдэгдэж, тэдний даган мөрдөх Өөрийн хуулийг зарлан тунхаглаж, тэднийг үнэнч хайр, буянт үйлчилгээнд уриалан дууддаг юм.



Бахауллагийн сургаал бичмэлд үг айлдвар нэг хэлбэрээс нөгөөд үе үе шилжиж байдаг. Заримдаа хүн ярьж байгаа мэт, дараа нь ямар ч завсарлагагүйгээр Бурхан нэгдүгээр биеэс ярьж байгаа мэт болдог. Хүний байр сууринаас айлдаж байхдаа ч Бахаулла Бурханы Элч шиг, Бурханы хүсэл таалалд бүрэн дүүрэн өөрийгөө зориулсан хүний амьд жишээ мэт ярьдаг. Түүний бүхий л амьдрал бол Ариун Сүнсээр амьдран тэтгэгдсэн юм. Тиймээс Бахауллагийн амьдрал сургаал дахь хүмүүний болон тэнгэрлэг шинж чанарын хооронд ямар нэг огцом ялгаа гаргах нь боломжгүй юм. Бурхан Түүнд ийнхүү айлджээ:

*“Хэлэгтүн: “Миний сүмд Бурханы Сүмээс өөр юу ч харагдахгүй, миний гоо үзэсгэлэнд Түүний Гоо үзэсгэлэнгээс юу ч үгүй, миний биед Түүний Биеэс өөр юу ч үгүй, надад Түүнээс өөр юу ч үгүй бөгөөд миний хөдөлгөөн бол Түүний Хөдөлгөөн, миний хүлээн зөвшөөрөл болвоос Түүний Хүлээн зөвшөөрөл ба миний бийрэнд Эрхэм нандин, Өргөмжит дээд Түүний Бийрээс өөр юу ч үгүй”*

*“Хэлэгтүн: “Миний сэтгэлд Үнэнээс өөр юу ч оришж байгаагүй агаад миний дотор Бурханаас өөр юуг ч эс харах бөлгөө” - “Сурагул-Хайкал, х.30*

## Түүний Ариун Үүрэг

Энэ ертөнцөд Бахауллагийн заларсан зорилго болбоос Эв нэгдлийг авчрах, Бурханд бөгөөд Бурханаар бүхий л хүн төрөлхтөнийг нэгтгэсэн Эв нэгдлийг авчрах явдал юм. Тэрээр ийнхүү айлдсан нь:

*“Эрдэм мэдлэгийн Модноос ургасан Хамгаас гайхамшигт үр жимс болбоос ийм өргөмжит үг бөлгөө: Та нар бүгд болбоос нэг л Модны үр жимснүүд, нэг л Мөчрийн навчнууд. Зөвхөн эх орноо хайрладгаараа ямар ч хүмүүн өөртөө бүү бардаг, харин өөрийн төрлийг хайрладаг тэр хүмүүн бадартугай”*

Өмнөх үеийн Зөнч мэргэд газар дэлхий дээр энх тунх амьдрал тогтож, хүмүүсийн дунд сайн санаа дэлгэрнэ гэдгийг урьдчилан хэлсэн бөгөөд тэд энэ үеийг түргэн ирүүлэхийн төлөө өөрсдийн



амьдралыг зориулсан билээ. Гэвч тэд бүгдээрээ хэлэхдээ энэ бүхэн гагцхүү хожмын өдрүүдэд “Эзэн тэнгэр залрахад” л биелж, муу санаатан шүүгдэж, сайн санаатан шагнагдана гэж тодорхой айлдсан бөлгөө.

Ертөнцийг аварч, муу ёрын сүнс Ахриманыг даван дийлж, буян ба энх тайвны ноёрхлыг тогтоох Шах Бахрам гурван мянган жил үргэлжлэх тэмцэл зөрчлийн дараа л ирнэ гэж Зороастр урьдчилан хэлсэн билээ.

Моисей зөгнөн хэлэхдээ, Израйлийн үр сад шорон цөллөгт он удаан жил өнгөрүүлж, хяхан хавчигдаж, дарлагдан зовсны дараа Эздийн Эзэн тэнгэр заларч, тэднийг бүх л улс үндэстнүүд дундаас цуглуулан дарлагчдыг устгаж, Өөрийн Ханлиг улсыг газар дэлхий дээр байгуулна гэсэн юм.

Христ айлдсан нь: “*Би дэлхий рүү энх тайвныг илгээх гэж ирсэн хэмээн бүү бод. Би энх тайван бус харин сэлэм илгээх гэж ирсэн юм*” (Матай х. 34) Үүгээр Христ “Эцгийнхээ Алдараар” Хүмүүний үр залран ирэх хүртэл дайн дажин, зовлон зүдгүүрийн үе үргэлжлэнэ гэж айлдан зөгнөсөн билээ.

Мухаммед “Иудейчүүд болон Христчүүдийн гэм нүглээс болж Аллах тэнгэр тэдний хооронд дайсагнал, үзэн ядах сэтгэлийг суулгаж, энэ нь Тэрээр бүхнийг шүүхээр залран ирэх Сэхээрэлтийн Өдөр хүртэл үргэлжилнэ” хэмээн зарлан тунхаглажээ.

Харин нөгөө талаас Бахаулла, Тэрээр болбоос эдгээр бүх Зөнч мэргэдийн Амласан Нэгэн бөгөөд энх тайвны хаанчлал бодитоор тогтох эрин үеийг авчрагч Тэнгэрлэг Тодруулагч юм гэж тунхагласан юм. Энэ мэдэгдэл бол урьд өмнө нь сонсогдож байгаагүй онцгой өвөрмөц мэдэгдэл агаад цаг үеийн шинж тэмдэг бөгөөд агуу зөнч мэргэдийн зөгнөл айлдвартай эн дүйцэж байгаа юм. Бахаулла хосгүй тодорхой, бүрэн дүүрэн хэлээрээ хүн төрөлхтний энх тайван, эв нэгдлийг авчирна гэдэг ямар утга учиртай болохыг тайлан нээсэн билээ.

Бахауллаг тодорсноос хойш өнөөг хүртэл урьд өмнө нь үзэгдэж байгаагүй ихээр дайн дажин, гамшиг сүйрэл гарч байсан нь үнэн билээ. Гэхдээ чухамдаа “Эзэн тэнгэрийн агуу бөгөөд аймшигт

Өдөр"-ийн үүр гэгээрэх үед ийм л юм болно гэж бүх зөнч мэргэд зөгнөсөн бөгөөд ингэснээр” Эзэн тэнгэр залрах” нь удахгүй болох явдал төдийгүй нэгэнт биелсэн баримт гэдгийг харуулж байна. Христийн зүйрлэсэнчлэн, Үзэсгэлэнт цэцэрлэгийн Эзэн тэнгэр эхлээд муу санаат тариачдыг өрөвдөлтэйгээ устгаад дараа нь цэцэрлэгийг бусдад эзэмшүүлж, тэд Түүнд зориулан улирлын үр жимсийг тордон ургуулах юм. Энэ нь Эзэн тэнгэрийг залран ирэхэд хар санаат тариачдын адил олон зуун жилийн турш дэлхийг сүйтгэн, үр жимсийг үгүйрүүлсэн харгис дарангуйлагч засгийн газрууд, ховдог шунахай, үл эвлэрэгч санваартан нар, эсвэл харгис ширүүн удирдагчид аймшигт гамшиг гайг эдлэнэ гэсэн үг биш үү?

Дэлхий дээр аймшигт үйл явдал юутай ч эн зэрэгцэхээргүй сүйрэлт гайг гамшиг байсаар байгаа боловч “мөдхөн эдгээр үр ашиггүй тэмцэл маргаан эдгээр сүйрэлт дайн дажин замхран арилж Агуу их Энх тайван залран ирнэ” гэж Бахаулла бидэнд батлан хэлж байна. Дайн тэмцэл туйлдаа хүрч, тэвчихийн аргагүй их гайг авчирч байгаа тул хүн төрөлхтөн түүнээс ангижрах уу, эсвэл арилан устах уу гэдгээ шийдэх ёстой.

“Сайн цаг” ирсэн ба түүний хамт Амлагдсан Аврагч ирлээ!

### **Түүний Сургаал бичмэлүүд**

Бахауллагийн сургаал бичмэлүүд хүрээ хязгаарын хувьд хамгийн бүрэн төгс бөгөөд хүний амьдралын хувийн болоод нийгмийн үе шат бүрийг нэг бүрчлэн тусгаж, амьдралын материаллаг хийгээд оюун санааны ойлголтуудыг тайлбарлаж, эртний ба орчин үеийн судар бичгүүдийг танилцах наад захын боломж бололцоогүй байсан мөртлөө маш үнэмшилтэй бөгөөд жинтэй байдлаар цээжээрээ иш татан тайлбарладаг байсан юм. “*Чонын бэлтрэгт илгээх Бичиг*”-тээ Тэрээр “*Баяан*” судрыг амьдралдаа ер уншаагүй гэж бичсэн байдаг боловч Өөрийн сургаал бичмэлдээ Бабьн үүдэл нээлтийн талаар ямар их төгс төгөлдөр мэдлэг ойлголттойгоо харуулан бичсэн байдаг. (Урьд үзсэнчлэн, “*Баяан*” хэмээх судар нь “*Бурханаас тунхаглах Хүмүүн*”-ий

адисаар бүтсэн юм гэж Баб хэлсэн билээ). 1890 онд Профессор Эдуард Грэнвилль Браунтай уулзаж, тус бүр нь 20-30 минутын дөрвөн ярилцлага өгснөөс өөр өрнөдийн ямар ч гэгээрсэн сэтгэгч нартай уулзаж ярилцах боломж бололцоо Түүнд ер олноогүй ч Тэрээр өрнөдийн ертөнцийн нийгэм, улс төр, шашны асуудлуудыг бүрэн ойлгодог байсан нь сургаал бичмэлээс нь харагддаг бөгөөд дайснауд нь ч хүртэл Түүний мэргэн цэцэн ухаан бол хосгүй юм гэдгийг хүлээн зөвшөөрөхөд хүрдэг байсан билээ. Тэрээр он удаан жил хагуу нөхцөл байдалд хоригдож байсан тул Түүний сургаал бичмэлд агуулагддаг арвин баялаг эрдэм мэдлэг нь сурах бичиг судалснаас, эсвэл ердийн нэг багшаас суралцсанаар олж авсан биш харин ямар нэг оюун санааны эх үүсвэрээс олж авсан мэдлэг юм гэдэгт эргэлзээ төрөхгүй юм.

Заримдаа Тэрээр өөрийн нутаг нэгтнүүдийн эх хэл болох орчин цагийн перс хэлээр бичдэг байв. Энэ перс хэл нь ихэнхдээ араб хэлтэй холилдсон хэл юм. Заримдаа, тухайлбал, эрдэмтэн Зороаструудад хандаж хэлэхдээ, хамгийн цэвэр сонгодог перс хэлээр бичдэг байв. Тэрээр араб хэлийг адил төгс эзэмшсэн байсан бөгөөд араб хэлээр бичихдээ заримдаа маш энгийн хэлээр, заримдаа Коран судрын хэлтэй дүйцэхүйц сонгодог хэлбэрээр бичдэг байв. Тэрээр ном эрдэмд ер суралцаагүй мөртлөө эдгээр хэлүүдийг тэгж төгс давамгай эзэмшсэн байсан нь гайхамшигтай зүйл байлаа.

Түүний сургаал бичмэлийн заримд *“Аянчин хүн мунхаг байлаа ч түүндээ ер алдахгүй”* (Исайя, 35:8) гэдэг шиг ариун гэгээн зам мөрийг маш энгийн хэлээр тайлбарласан байдаг. Гэтэл зарим сургаал бичмэлд нь яруу найрагч, гүн ухаанч эрдэмтэн хүн л зүй ёсоор үнэлэн дүгнэж чадах яруу найргийн зүйрлэл төсөөлөл, философийн гүн гүнзгий сургаал, Ислам, Зороастр болон бусад шашны судар бичиг хийгээд перс, араб уран зохиолын бүтээл домог түүхүүдээс дурьдсан хэсэг арвин их байдаг. Харин бусад сургаал бичмэлдээ Тэрээр оюуны санааны амьдралын дээд үе шатуудын талаар бичсэн байдгийг зөвхөн эхний үе шатуудаас давсан хүмүүс л ойлгох чадвартай юм. Түүний зохиол бүтээлүүд гэдэг бол жинхэнэ ёсоор үнэнийг эрэгч хүмүүсийн бүх л

шаардлага хэрэгцээ, таашаал сонирхолд нийцүүлсэн тансаг арвин идээ будаагаар дүүрэн ширээ лүгээ адил юм.

Чухамдаа ийм учраас Бахауллагийн Үйл хэрэг эрдэмтэн мэргэн, өндөр соёл боловсролттой хүмүүс, оюун санаанлаг яруу найрагчид болон алдар суутай зохиолчдын дунд маш хүч нөлөөтэй байсан билээ. Тэр ч бүү хэл, суфи болон бусад урсгалын тэргүүлэгчид ба зохиол бүтээл бичдэг байсан улс төрийн зүтгэлтнүүд Түүний туурвил бүтээлд их татагдаж байсан юм. Учир нь, тэдгээр нь тансаг уран хэл, оюун санааны гүн гүнзгий утга төгс байдлаараа бусад бүх зохиолчдын бүтээлүүдийг хавьгүй хол давж байсан юм.

### **Бахайн Үзэл санаа**

Алс холын Акка хотод хоригдож байсан хэдий ч Бахаулла тэндээсээ зөвхөн төрөлх Перс орныхоо төдийгүй дэлхий ертөнцийн сэтгэл санааг голд нь ортол долгиуулж байсан юм. Түүнийг болон итгэн дагагчдыг нь амьдруулан тэтгэж байсан тэрхүү үзэл санаа эелдэг зөөлөн, тэсвэр тэвчээр төгс байсан боловч гайхалтай их хүч, хязгааргүй агуу чадал тэнхээтэй үзэл санаа байсан юм. Тэр нь боломжгүй санагдаж байсан бүхнийг бүтээн биелүүлж, хүний мөн чанарыг өөрчилсөн билээ. Түүний үр нөлөөнд татагдсан хүмүүс цоо шинэ хүн болжээ. Тэд хайр ивээл, сүсэг бишрэл, оргилуун тэмүүллийг олж, үүнтэй жинлэн харьцуулах юм бол газар дэлхийн баяр жаргал, уй гашуу бол тоос шороо мэт тэдэнд санагдаж байлаа. Тэд Бурхан тэнгэрт сүсэглэн итгэж, аймшиггүй зориг хүчийг өөрсдөдөө агуулж байсан тул туйлын тайван амгалан байдлаар, үгүй ээ, бүр баяр баясгалантайгаар насан туршдаа зовлон зүдгүүр эдлэх, эсвэл харгис хэрцгийгээр амь үрэгдэх хувь тавилангаа угтан авдаг байсан юм.

Хамгийн гайхамшигтай нь гэвэл, тэдний зүрх сэтгэл шинэ амьдралын баяр баясгалангаар бялхаж байсан тул дарлан зовоогчиддоо хар мууг санан, өшөө авах бузар бодол төрөх зай завсар үгүй байсан юм. Тэд хүчирхийлэл, өөрсдийгөө хамгаалан тэмцэх явдлаас бүрэн татгалзаж, харин ч хувь тавиландаа баярлаж,

энэхүү шинэ гайхамшигтай Үүдэл нээлтийг хүлээн авч, түүний үнэнийг гэрчлэхийн төлөө амь амьдралаа зориулах, цусаа урсгах хувьтайдаа өөрсдийгөө хамгийн азтай хүмүүс гэж бодож байсан юм. Эрхэм дээд, Өнө Мөнхийн, Хамгаас хайрт Бурхан хүмүүний хэлээр тэдэнтэй ярилцаж, тэднийг Өөрийн шадар зарц нар, анд нөхөд гэж нэрлэж, Өөрийн Ханлиг улсыг энэ газар дэлхий дээр байгуулан тогтоож, дайн дажинд, тэмцэл маргаанд талхлагдан почирдсон дэлхий ертөнцөд Энх тайвны үнэлж баршгүй их буян хишгийг авчрахаар ирсэн тул тэд баярлан цэнгэхээс өөр аргагүй байсан биз ээ.

Бахауллагийн тэтгэн амьдруулсан шашин шүтлэг ийм л байлаа. Тэрээр Бабын зөгнөн айлдсан ёсоор Өөрийн ариун үүргийг зарлан тунхаглаж, Түүний өмнөх агуу их Элчийн нөр их хөдөлмөрийн ачаар Түүнийг морилон ирснийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн, өөрсдийн мухар сүсэг, атгаг үзлээс ангижирсан, цэвэр ариун зүрх сэтгэл, нээлттэй саруул оюун ухаанаар Бурханаас амлагдсан Алдрын Тодруулагчийг хүсэн хүлээж байсан мянга мянган хүмүүс байлаа. Бахаулла туйлын ядуу зүдүү, гав гинжинд дөнгөлүүлчихсэн, амьдралын хатуу хүнд нөхцөл, эдэлж амсаж байсан зовлон доромжлол нь Эзэн тэнгэрийнх нь Оюун санааны Алдрыг тэдний нүднээс нуух чадалгүй байлаа. Үгүй ээ, газар дэлхийн эдгээр харанхуй нөхцөл байдал нь Түүний жинхэнэ Сүр жавхланг улам л тодотгон харуулж байсан юм.

## Дөрөвдүгээр бүлэг

### АБДУЛ-БАХА: БАХА-Н ЗАРЦ

*"Миний Ахуйн далай ширгээж, Миний Үүдэл нээлтийн Судар жаргах аваас Өнө эртний Үндсээс мөчирлөсөн-Бурханы томилсон Түүн рүү хандагтун."*

*Бахаулла, "Китаб-и-Акдас"*

#### Бага нас

Хожим Абдул-Баха (өөрөөр хэлбэл Баха-н Зарц) хэмээн өргөмжлөгдсөн Аббас Эффенди нь Бахауллагийн ууган хүү байлаа. Тэрээр 1844 оны 5 дугаар сарын 23-ны шөнө дундаас өмнөхөн, Баб Өөрийн ариун үүргээ тунхагласан яг тэр шөнө Тегеран хотод мэндэлжээ.

Абдул-Баха есхөн настай байхдаа ч эцэгтээ үнэнч хайртай байсан бөгөөд тэр үед эцгийг нь Тегераны гянданд хорьжээ. Зандалчид гэр орныг тонон дээрэмдэж, тэднийх эд хөрөнгөө бүрэн алдаж, ядуугийн туйлд хүрсэн байлаа. Нэг өдөр шоронгийн хашаанд орж, Хайрт эцгийгээ салхинд гарах үеэр нь харах зөвшөөрөл олдсон тухайгаа Абдул-Баха хуучлан ярьсан юм. Бахаулла тэр үед аймшигтай ихээр өөрчлөгдөж, бараг явах чадалгүй болтлоо сульдан доройтсон байжээ. Үс, сахал нь ширэлдэж, хүнд төмөр гинжинд даруулснаас болж хоолой хүзүү нь хавдаж шархалсан, гав гинжиндээ дарагдан нуруу нь бөгтийсэн байжээ. Энэ явдлыг нь хараад өрөвч сэтгэлтэй жаал хүүгийн ухаанд хэзээ ч арилахгүй сэв суужээ.

Багдадад амьдарч байсан анхны жил буюу Бахаулла Өөрийн ариун үүргээ нээлтгэйгээр тунхаглахаас арван жилийн өмнө тэр үед ердөө есхөн настай Абдул-Баха хурц соргог ухаанаараа эцгийгээ Бабчуудын хүсэн хүлээж байсан Амлагдсан Элч гэдгийг аль хэдийн нээн ухаарсан байжээ. Түүнээс хойш жар орчим жилийн хойно үүнийг хэрхэн бүх л биеэрээ мэдэрсэн тэр агшин мөчийг ингэж дурсан тайлбарласан байна:



“Би болбоос Адист Төгс үзэсгэлэнгийн шадар зарц билээ. Багдадад би хүүхэд байлаа. Чухам тэр үед, тэр газар Тэрээр надад Өөрийн Сургаал үгийг айлдаж, би Түүнд итгэсэн юм. Түүнийг Сургаал үгээ надад хэлэнгүүт би Ариун Өлмийд нь сөгдөж, Түүний Зам мөрд өөрийн цусыг өргөн барихыг Түүнээс залбиран гуйсан юм. Золиослол! Энэ үг надад юутай тансаг амттай санагддаг гээч! Үүнээс илүү агуу Буян хишиг надад үгүй! Түүний төлөө энэ хоолойгоо гинжлүүлж, Түүний хайрын төлөө энэ хөлөө хүлүүлж, Түүний Үйл хэргийн төлөө энэ биеэ тамлуулж, тэнгис далайн гүн ёроолд живүүлэхээс илүү алдар гавъяа надад үгүй санагдана! Үнэн хэрэгтээ бид болбоос Түүний чин үнэнч хайрлагч нар юм бол, үнэн хэрэгтээ би Түүний чин үнэнч шадар зарц юм бол өөрийн амь амьдралыг, өөрийнхөө хамаг бүхнийг Түүний Адислал Босгонд зориулан золиослох ёстой билээ. “ Мирза Ахмед Сохрабын өдрийн тэмдэглэл, 1914 оны 1 дүгээр сар.

Яг энэ үеэс эхлэн анд нөхөд нь Түүнд Бахауллагаас хайрласан “Бурханы Оньсого” гэсэн өргөмжлөлөөр нь дууддаг болжээ. Чухамхүү энэ нэрээр Тэрээр Багдадад амьдарч байх үед олонд алдаршсан байлаа.

Эцэг нь аглаг хээр газар луу хоёр жилээр явахад Аббас сэтгэлээр туйлын их унажээ. Түүний цорын ганц тайтгарал нь Бабын Сургаал бичгүүдийг хуулан бичиж, ой тойндоо цээжлэн тогтоож, ихэнх цагаа ганцаарчлан бясалгахад зориулдаг байв. Эцэг нь эргэж ирэхэд хүү баярлан жаргажээ.

### Залуу нас

Тэр үеэс хойш Тэрээр эцгийнхээ хамгийн ойр дотны нөхөр, мөн хамгаалагч нь болсон байлаа. Хэдийгээр нас залуу ч гайхалтай мэргэн цэцэн ухаанаа харуулсан бөгөөд эцэгтэй нь уулзах гэж ирсэн үй түмэн хүмүүсээс ярилцлага авдаг байжээ. Хэрэв тэд үнэхээр үнэнийг эрж хайх гэсэн эрмэлзэлтэй байвал тэднийг эцэгтэйгээ уулзуулдаг, харин өөр зорилготой байвал Бахауллаг хохироохыг тэдэнд зөвшөөрдөггүй байв. Олон ч удаа Тэрээр иймэрхүү зочин гийчдийн тавьсан асуултанд хариулж,

бэрхшээлийг нь шийдэхэд нь Эцэгтээ тусалсан юм. Жишээлбэл, Али Шаукат Паша хэмээх суфичуудын толгойлогч хүн Исламын нэгэн сударт байдаг “Би болбоос Далд Оньсого” гэсэн үгийг тайлбарлахыг хүсэхэд Бахаулла “Бурханы Оньсого” Аббас уруу харж, тайлбарыг бичиж өгөхийг хүсчээ. Тэр үед дөнгөж арван тав юм уу арван зургаан настай байсан хүү тэр дор нь тайлбар бүхий маш чухал сургаалыг бичиж өгөхөд үнэнхүү ойлгомжтой байсанд Паша гайхжээ. Уг сургаал бичиг эдүгээ Бахайчуудын дунд түгээмэл нэгэн сургаал бөгөөд Бахай Шүтлэгээс гадуур ч олон хүмүүс түүнийг сайн мэддэг юм.

Барагцаалбал энэ үеэс Аббас сүм дуганд байнга очдог болсон бөгөөд тэнд Тэрээр эрдэмтэн мэргэн хүмүүстэй шашны олон асуудлаар ярилцдаг байжээ. Тэрээр хэзээ ч сургууль коллежид суралцаж яваагүй бөгөөд цорын ганц багш нь эцэг нь байсан байна. Тэрээр чөлөөт цагаараа морь унах үнэхээр дуртай байжээ.

Бахаулла Багдад хотын ойролцоох нэгэн Цэцэрлэгт Өөрийн Тунхаглалыг хийсний дараа Абдул-Баха эцэгтээ урьд өмнөхөөс ч илүү үнэнч бишрэлтэй болсон юм. Константинополь хүрэх гэж алс холын замыг туулж янахдаа Тэрээр өдөр шөнөгүй Бахауллаг хамгаалж, Бахауллагийн суусан тэргийг мориороо дагалдан явж, хоноглосон майхныг нь манадаг байжээ. Эцгийгээ гэр орны ажил үүргээс аль болох чөлөөтэй байлгахыг хичээдэг байсан бөгөөд тэр айлын гол өмөг түшиг нь болж явав. Адрианопольд байх он жилүүдэд Абдул-Баха хүн бүрийн хайр хүндэтгэлийг хүлээсэн юм. Хүмүүст ихэд багшлан сургадаг байсан тул “Багш” гэсэн нэрээр алдаршжээ. Аккад хамт явсан ихэнх хүмүүс нь хижиг, хумхаа, улаан суулга өвчин туссан тул Тэрээр өвчтнүүдийг угаан цэвэрлэж, асран тордож, хооллон ундалж, тэднийг харж хандан, Өөрөө ч амрах завгүй байсан бөгөөд эцэст нь өөрөө сульдаж, улаан суулга туссан байв. Тэгээд бараг сар шахуу сэхэх үгүйтэй хэвтсэн юм. Адрианопольд байсан шиг бас Аккад хотын захирагчаас авахуулан үгээгүй ядуу гуйлгачин хүмүүс хүртэл бүх анги зиндааны хүмүүс бүгд Түүнийг хайрлан хүндэтгэдэг болсон байлаа.

## Гэрлэлт

Бахай Шүтлэгийн түүхч нэгэн Перс хүн Абдул-Бахагийн гэрлэлтийн тухай дараах дурсамжийг өгүүлжээ:

“Абдул-Бахаг идэр залуу байхад нь түүнд таарч тохирсон хүнтэй гэрлүүлэх тухай асуудал сүсэгтнүүдийн маш их сонирхлыг төрүүлж байсан бөгөөд олон хүмүүс ийм хүндтэй алдар хүндийг өөрийн гэр бүлд тохиогоосой гэж санагалзан хүсч байсан нь мэдээж. Гэвч удаан хугацааны турш Абдул-Баха гэрлэх хүсэлтэйгээ шлэрхийлээгүй тул энэ ямар учиртай болохыг хэн ч таамаглаж чадахгүй байв. Хожим нь Абдул-Бахагийн эхнэр болох хувьтай нэгэн охин буй нь тодров. Баб Исфаханд байхдаа эцэг эхэд нь Адис хүртээснээр тэр охин мэндэлсэн юмсанжээ. Охины эцэг Мирза Мухаммед Али нь “Баатруудын Хаан” ба “Баатруудын Хайрт” нарын нагац ах байсан бөгөөд охин Исфаханы хамгийн нэр цуутай, язгуур нэгэн гэр бүлд төрсөн ажээ. Бабыг Исфаханд байхад Мирза Мухаммед Али ямар ч хүүхэдгүй байсан бөгөөд эхнэр нь хүүхэдтэй болохыг ихэд хүсэн мөрөөддөг байжээ. Үүнийг дуулаад Баб өөрийн хоолноос таслан түүнд өгөөд эхнэртэйгээ хувааж идэхийг хүсчээ. Тэр хоёр хоолноос зооглосны дараахан эцэг эх болохыг хүссэн мөрөөдөл нь биелэх нь тодорхой болж, хэсэг хугацааны дараа охин төрсөн бөгөөд охиндоо Мунири Ханум гэж нэр хайрласан байна. Түүний дараа тэдэнд нэгэн хүү төрж, тэд хүүдээ Сийд Яхья гэж нэр өгсөн байна. Дараа нь бас хэд хэдэн хүүхэд төрүүлжээ. Ингээж байтал хэсэг хугацааны дараа Мунири Ханумын эцэг нас өөд болж, үеэл ах дүү нар нь Зиллус-Султан болон Мулла нарын гарт амь биеэ золиосолж, тэр айл асар их уй гашууд автан, Бахай шүтлэгтэн байсныхаа төлөө хяхан хавчигдаж байлаа. Иймээс Бахаулла Мунири болон түүний дүү Сийд Яхья хоёрыг аюулгүй тайван байхын тулд Аккад ирэхийг нь зөвшөөрсөн байна. Бахаулла ба түүний эхнэр, Абдул-Бахагийн ээж Навваб нар Мунирийг туйлын их онцон халамжилж байсан тул тэд түүнийг Абдул-Бахатай гэрлүүлэхийг хүсч байгаа нь хэнд ч илт болов. Эцэг эхийнх нь хүсэл бас Абдул-Бахагийн хүсэл болжээ. Тэрээр Мунирийг халуун дулаан хайраар хайрлаж байсан ба Мунир ч түүнийг ихэд хайрлаж байв. Удсан ч үгүй тэр хоёр гэр бүлийн холбоонд нэгдэн нийлжээ.”

Тэр хоёрын гэрлэлт туйлын эвлэг сайхан, аз жаргалтай байлаа. Тэдэнд төрсөн хүүхдүүд дундаас шорон гянданд хоригдсон он удаан жилийн зовлонг даван амьд үлдсэн дөрвөн охин байв. Охид нь өөрсдийн буянт үйлс, сайхан амьдралаараа тааралдсан хүн бүхнийхээ хайр хүндэтгэлийг хүлээж байсан юм.

## Гэрээсийн Төв

Өөрийг нь тэнгэрт хальсаны дараа Үйл хэргийг нь Абдул-Баха удирдан чиглүүлэх юм гэдгийг Бахаулла олон янзаар илэрхийлдэг байжээ. Нас барахаасаа олон жилийн өмнө Бахаулла “Китаб-и-Акдас”-гаа энэ талаар битүүлэг байдлаар дурьджээ. Тэрээр олон ч удаа Абдул-Бахаг “Миний Гэрээсийн Төв”, “Хамгаас Агуу Мөчир”, “Өнө эртний үндэстэй Мөчир” гэж нэрлэдэг байсан байна. Тэрээр Абдул-Бахаг мөн “Багш” гэж дуудаж заншсан байсан бөгөөд гэр бүлийнхээ бусад хүмүүсийг ч мөн адил түүнийг онцлон хүндэтгэхийг шаарддаг байсан юм. Бахаулла Өөрийн гэрээслэл бичигт бүгд Абдул-Бахад хандаж, захирагдах ёстойг тодорхой байдлаар зааварчлан гэрээсэлсэн юм.

“Адист Гоо жавхлан”(Бахауллаг гэр бүлийнхэн болон сүсэгтнүүд ингэж нэрлэдэг байв) Нас өөд болсны дараа Абдул-Баха Эцгийн заавар ёсоор Үйл хэргийн тэргүүн бөгөөд сургаал номлолын албан ёсны Тайлбарлагч болжээ. Гэвч үүнийг төрөл садан дотроос болон бусад хүмүүс дундаас цөөн хэд нь эсэргүүцэж, Субх-и-Азал Бахауллад хэрхэн хандаж байсан яг л тийм байдлаар Абдул-Бахагийн эсрэг хандах болжээ. Тэд сүсэгтэн олны дунд яс хаяхыг оролдож байсан боловч бүтэмжгүй байсан тул Абдул-Бахагийн эсрэг элдэв янзын гүтгэлэг гүжирдэлтийг Туркийн засгийн газарт мэдүүлж эхэлсэн байна.

Эцгийнхээ захисан ёсоор Абдул-Баха тэр үед Хайфагийн энгэрт орших Кармел Уулан дээр Бабын цогцсыг үүрд байрлуулах, мөн уулзалт цуглаан зохион явуулах зорилготойгоор нэгэн байшин бариулж байжээ. Гүтгэгчид засгийн эрх баригчдад мэдүүлэхдээ, Абдул-Баха Өөрийн дагалдагч нарын хамт уг байшинг бэхлэлт цайз болгож, түүндээ хоргодон засгийн газрын

эсрэг үйл ажиллагаа явуулж, хөрш зэргэлдээ орших Сирийн нутгаас эзлэхийг зорьж байна гэж байлаа.

### Хатуу дэглэм дахин сэргэв

Энэ бүхний болон бусад худал гүтгэлэг мэдүүлгийн үр дагавраар сүүлийн хорин жилийн турш Акка хотын эргэн тойронд хөдөө тосгодоор чөлөөтэй аялах бололцоотой байсан Абдул-Бахагийн гэр бүл 1901 онд шоронгийн хотын ханан дунд дахиад долоон жил гаруй хугацаанд хатуу дэглэмтэй хоригдох болжээ. Гэхдээ энэ нь Бахайн сургаалыг Ази, Европ, Америк даяар амжилттайгаар түгээхэд нь Түүнд саад болоогүй билээ. Ноён Хорас Холлей энэ үеийн талаар ингэж бичсэн юм:

*“Абдул-Бахаг багшаа, эсвэл анд нөхрөө гэж бодсон янз бүрийн арьс өнгөтэй, шашин шүтлэгтэй, янз бүрийн улс орноос ирсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс Түүний ширээнд хүндэт зочдын адил уригдан сууж, зурх сэтгэлдээ эргэцүүлэн бодсон нийгмийн, оюун санааны болон ёс суртахууны сургаалийн тухай асуудлаар асуун лавлаж, хэд хоног, тэр ч бүү хэл хэдэн сараар Түүний гэрт саатсаны дараа цоо шинэ онгод сэтгэлгээ, мэдлэгээр гэгээрч гэр гэртээ буцдаг байсан байна. Бүх л дэлхийд ийм зочломтгой айл өөр байгаагүй биз ээ.*

*Энэ байшингийн ханан дунд Энэтхэгийн кастын (нийгмийн бүлгүүдийн-орч) ялгаа хайлан устаж, Иудейчүүд, Христчүүд, Мусульманчуудын хоорондын үзэн ядах сэтгэл мартагдаж, бүлээн дулаан зурх сэтгэл, оргилуун эрмүүн санаа бодлын хуулиас өөр бусад бүх уламжлал таягдан хаягдаж, энэ гэрийн эзний эв нэгдлийг эрхэмлэсэн сэтгэлийн нөлөөнд хоригдсон байлаа. Энэ бол яг л Артур хаан ба Дугуй Ширээ шиг л байв... Гэхдээ тэрээр эрэгтэйчүүдийг ч тэр, эмэгтэйчүүдийг ч захирдаг Артур хаан байсан бөгөөд Тэрээр тэднийг сэлэм зэвсгээр биш харин Сургаал үгээр байлдан дагуулдаг байсан юм.”*

“Орчин үеийн нийгмийн шашин”, Хорас Холлей, х 171

Эдгээр он жилүүдэд Абдул-Баха маш олон сүсэгтэн, сонирхогчидтой захидлаар харилцдаг байсан билээ. Энэ ажилд нь

Түүнд охид нь болон хэд хэдэн орчуулагч, нарийн бичгийн дарга нар тусалдаг байв.

Абдул-Баха ихэнхи цагаа өвчин зовлонд нэрвэгдсэн хүмүүсийн гэр орноор эргэн тойрч өнгөрүүлдэг байсан юм. Акка хотын хамгийн ядуу хороололд “Багш”-аас илүү хүнийг хэнийг ч хүсэн хүлээдэггүй байсан билээ. Энэ үед Аккад очиж байсан нэгэн мөргөлчин ингэж бичжээ:

*“Абдул-Баха Баасан гараг бүрийн өглөө ядууст өглөг өгдөг заншилтай байжээ. Өөрийн хомс түрийвчнээс Тэрээр алгаа тоссон ядуу зүдүү хүн бүрт хишиг хүртээдэг байсан юм. Нэгэн өглөө бараг зуу шахам ядуус Абдул-Бахагийн байшингийн өмнөх талбай дээр зарим нь сууцгааж, зарим хэвтэцгээсэн байдалтай олуулаа дугаарлан цугласан байв. Үнэхээр дүрслэхийн аргагүй янз янзын олон хүмүүс байв. Эрэгтэй, эмэгтэй, хүүхэд томчуул, ядуу зүдүү, өвдөж зовсон, хувцас хунар муутай, туйлдаж цөхөрсөн, нилээн хэд нь тахир дутуу, сохор, хэлэхийн эцэсгүй ядуу гуйлгачид горьдлого өвөрлөн хүлээж байтал Абдул-Баха хаалгаараа гарч ирэв... Нэгнээс нөгөөд нь очиж, заримдаа урам хайрласан тайтгарлын үг хэлж, тоссон алганд нь жижиг зоос асган өгч, жижиг хүүхдийн царайг нь илж, хажуугаар өнгөрөхөд нь хормойноос нь зуурсан хөгшин эмэгтэйн гарыг атгаж, хараагүй хүмүүст гэрэл гэгээ хайрласан үгс хэлж, сульдан доройтсон хүмүүсийн мэндийг асууж, хайр энэрлийн үгээр мэнд дамжуулан хишиг хүртээж байсан юм. ” “Абдул-Бахаг харсан минь”, М.Ж.М., х.13*

Абдул-Бахагийн хувийн хэрэгцээ тун бага байсан юм. Тэрээр эрт босож ажлаа эхэлж, их оройтож унтдаг байв. Өдөрт хоёрхон удаа даруухан хооллодог байлаа. Хямдхан даавуугаар хийсэн хэдэн хувцастай байв. Тэрээр бусад хүмүүс гачигдан зовж байхад өөрөө тансаг чинээлэг амьдралд амьдрахыг ер хүсдэггүй байсан юм.

Тэрээр хүүхэд багачууд, цэцэг болон байгалийн гоо үзэсгэлэнд гуйлын их хайртай байжээ. Өглөө бүр зургаа долоон цагийн алдад гэр бүлээрээ хамтдаа өглөөнийхөө цайг уухаар цугладаг байсан бөгөөд Багш цайгаа уух зуур тэр айлын жижиг хүүхдүүд



мөргөл уянгалуулан уншдаг байв. Эдгээр хүүхдүүдийн тухай Ноён Торнтон Чейз ингэж хэлсэн байдаг:

*“Тийм эелдэг боловсон, бусдыг хайрлаж энэрсэн, элдэв ааш маяггүй, ухаалаг, хүүхдийн дуртай жижиг зүйлсэнд шунан дурладаггүй тийм хүүхдүүдийг би ер хараагүй.” “Галилеед”, х.51*

Акка дахь амьдралын нэгэн онцлог болсон “цэцэгсийн чимэг” нь мөргөлчин хүн бүрт анхилуун үнэрт дурсамжийг үргэлж авчирдаг юм. Хатагтай Лукас бичихдээ:

*“Багш цэцгийн үнэрийг үнэрлэх тэр үед Түүнийг царайг харахад үнэхээр гайхамшигтай байв. Хэлгий цэцэгний баглаан дотор нүүрээ умбуулахад нь цэцгийн үнэр Түүнд нэг юм хэлээд байгаа гэлтэй харагддаг байлаа. Нэгэн сайхан аялгууг чихээрээ олж мэдрэх гэж байгаа мэт анхаарлаа төвлөрүүлсэн байдаг байв” гэжээ. “Аккад очсон товч дурсамж”, х.26 Тэрээр үй түмэн зочиддоо үзэсгэлэнтэй анхилуун сайхан цэцэгс бэлэглэх дуртай байжээ.*

Ноён Торнтон Чейз Акка дахь шоронгийн амьдралын тухай өөрт нь үлдсэн сэтгэгдлийг ийнхүү дүрсэлжээ:

*“Бид тэрхүү “Хамгийн Агуу Шорон”-д амьдарч байсан Түүний нэгэн адил хоригдол болон тэрхүү ханан дунд таван өдрийг өнгөрүүлсэн юм. Тэр бол энх тайван, хайр, буян зүтгэлээр дүүрэн шорон байлаа. Хүн төрөлхтний сайн сайхан, дэлхий ертөнцийн энх амгалан, Бурханы Эрхт ёс болон Түүний үр сад болох хүмүүсийн эрхийг хүлээн зөвшөөрөхөөс өөр хүсэл, өөр мөрөөдөл үгүй байв. Үнэхээр жинхэнэ шорон, бачим уур амьсгал, зүрх сэтгэлийн мөрөөдөл, газар дэлхийн нөхцөл байдлын хүлээснээс хагацах хагацал гэдэг нь тэрхүү чулуун хэрэмний гадна талд байсан агаад харин дотор талд нь эрх чөлөө ба Бурханы Сүнсний ариун гэрэл туяа байсан юм. Зовлон гуниг, үймээн самуун, газар дэлхийн зүйлсийн талаар сэтгэл зовних явдал тэр дотор үгүй байлаа.” “Галилеед”, х.24*

Ихэнх хүмүүсийн хувьд шоронгийн амьдралын хүнд хэцүү нь зовлон гунигт гай гамшиг хэмээн санагдах бол Абдул-Бахагийн хувьд тэр бүхэн аймшигтай биш байлаа. Шоронд байхдаа Тэрээр ингэж бичжээ:

*“Намайг хоригдлоо, надад гай гамшиг тохиолдлоо хэмээн бүү гутар. Учир нь, энэ шорон болбоос миний үзэсгэлэнт цэцэрлэг, миний диваажин бөгөөд хүн төрөлхтний доторх миний ноёрхлын сэнтий юм. Шорон доторх миний зовлон бол буянт хүмүүсийн дунд алдаршсан миний диваажин бөгөөд хүмүүсийн дунд алдаршсан миний титэм бшээ.”*

*“Тавтай амгалан, амар тайван, амжилт дүүрэн, эрүүл энх, зугаа цэнгэл, баяр баясгалан байсан цагт хүн бүхэн жаргалтай байж чадна. Харин зовлон гуниг, хүнд хэцүү, өвчин эмгэгтэй үедээ жаргалтай, сэтгэл хангалуун яваа хүн бол буянтан язгууртан болохын нотолгоо юм.”* “Абдул-Бахагийн сургаал бичгүүд, 2-р боть, х. 258, 263

### **Туркийн тагнан тогтоох комиссууд**

1904 болон 1907 онуудад Абдул-Бахагийн эсрэг мэдүүлсэн мэдүүлгийн дагуу шалган тагнах комиссуудыг Туркийн засгийн газар томилжээ. Түүний эсрэг худалч гэрчүүд худал мэдүүлэг өгсөн байлаа. Абдул-Баха тэдгээр гүтгэлгийг няцаахын хамт шүүхээс шийдсэн ямар ч ялыг эдлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн юм. Тэд Түүнийг гянданд хорьсон ч, гудамжаар гулдран чирсэн ч, хараан доромжилсон ч, Түүн үрүү нулимж, чулуугаар нүүлгэсэн ч, элдвээр гутаан гүтгэсэн ч, дүүжлэх юм уу буудаж алсан ч Тэрээр жаргалтай хэвээр байх болно гэдгээ зарлан хэлсэн юм.

Шалган тогтоох комиссын ажиллагааны хооронд Тэрээр ердийн амьдралаараа туйлын амгалан тайван амьдарч байсан бөгөөд цэцэрлэгтээ жимсний мод тарьж, нэр төр, оюун санааны эрх чөлөөгөөр гэрэлтэн гийж, баяр хуримд оролцож байлаа. Италийн консул Түүнийг хүссэн боомт уруу аюулгүй гаргаж өгье гэж хүссэн боловч Тэрээр талархал илэрхийлээд хатуу татгалзжээ. Учир нь, ямар үр дагавартайгаас үл хамааран Тэрээр Өөрийгөө аврах юм уу дайснуудаасаа зугатах гэж хэзээ ч оролдоогүй Баб болон Адист Гоо жавхлангийн зам мөрийг дагах ёстой байсан юм. Гэсэн хэдий ч Тэрээр ихэнх Бахайчуудыг Аккагийн ойр орчим газраас явж, аюулаас зайлсхийхийг уриалсан бөгөөд Өөрөө хувь

тавилантайгаа учрахаар цөөн хэдхэн үнэнч дагалдагч нарын хамт ганцаар үлджээ.

1907 оны өвлийн эхэн үед Аккад шалган тогтоох сүүлчийн комиссын гишүүн болох хээл хахуульд автагч дөрвөн хүн хүрэлцэн ирсэн байлаа. Тэд нэг сарын дараа "шалгалт"-аа дуусгаад Константинополь руу явж, Абдул-Бахагийн эсрэг мэдүүлгийн үнэн зөв нь нотлогдсон тул Түүнийг цөлөх юм уу цаазлах ёстой гэж зөвлөсөн тайлан дүгнэлтийг бэлтгэн зэхсэн байжээ. Тэд Туркт буцаж очингууд тэнд хувьсгал гарчээ. Тэр дөрөв хуучин дэглэмийн талд байсан учир амиа аврахын тулд зугатах болсон байна. Залуу Туркчууд засгаа тогтоож, Османы эзэнт гүрний улс төрийн болоод шашны бүх хоригдлууд суллагдсан юм. 1908 оны 9 дүгээр сард Абдул-Баха шоронгоос суллагдаж, дараачийн жил Султан Абдул-Хамид өөрөө хоригдол болжээ.

### Өрнөдөд хийсэн Аялал

Чөлөөлөгдсөнийхээ дараа Абдул-Баха сургаал дэлгэрүүлж, захидал бичиж, ядуу зүдүү хүмүүсийг халамжлах ариун амьдралаа үргэлжлүүлж байсан бөгөөд ганцхан зүйл өөрчлөгдсөн нь Тэрээр Аккагаас Хайфад аялж, Хайфагаас Александрия руу 1911 оны 8 дугаар сар хүртэл аялсан юм. Түүний дараагаар Тэрээр өрнөдийн ертөнцөд анх удаа айлчилжээ. Өрнөдөд хийсэн аяллуудынхаа үеэр Абдул-Баха төрөл бүрийн үзэл бодолтой хүмүүстэй уулзаж учирч байсан бөгөөд *"Бүх хүмүүстэй баяр баясгалан, гэрэл цацруулан уулзаж, эвсэг байгтун"* гэсэн Бахауллагийн зарлигийг бүрэн дүүрэн биелүүлж явсан юм. Тэрээр 1911 оны 9 дүгээр сарын эхээр Лондон хотод очсон бөгөөд тэндээ нэг сар өнгөрүүлэхдээ сонирхсон хүмүүст өдөр тутам яриа хийж, бусад өөр ажил гүйцэтгэснээс гадна Сити Темплд Р.Ж.Кэмпбеллын сүмийн цуглаан, Вестминстерын Гэгээн Жон сүмд хамба лам Уилберфорсын цуглааны өмнө үг хэлж, мөн хотын даргатай өглөөний зоог барьж байжээ. Тэрээр дараа нь Парис руу явж, тэнд олон үндэстэн ястны, зүсэн бүрийн сонсогчдын өмнө өдөр тутам яриа илтгэл хийж байсан юм. 12 дугаар сард Тэрээр Египет уруу буцаж ирсэн бөгөөд дараачийн хавар нь Америк анд

нөхдийн хүсэлтийг болгоож, Америкийн Нэгдсэн Улсыг зорин 1912 оны 4 дүгээр сард Нью-Йорк хотод хүрсэн байна. Есөн сарын турш Америкийг хөндлөн гулд туулж, дээд сургуулийн оюутнууд, Социалистууд, Мормончууд, Иудейчүүд, Христчүүд, Агностикууд<sup>1</sup>, Эсперантистууд, Энх тайвны холбооны гишүүд, Шинэ сэтгэлгээний клубын гишүүд, Эмэгтэйчүүдийг чөлөөлөх холбооны гишүүд гээд төрөл бүрийн үзэл бодолтой хүмүүст хандан үг хэлж, шашны урсгал бүлэглэл бүрийн сүм дуганд илтгэл тавьж, ингэх бүрдээ цугласан олны сэтгэлд нийцсэн, тухайн байдалд зохицсон үгийг хэлдэг байжээ. 12 дугаар сарын 5-нд Тэрээр Их Британийг зорин аян замдаа гарч, тэнд очоод зургаан долоо хоног өнгөрүүлэхдээ Ливерпуль, Лондон, Бристоль, Эдинбург хотуудад айлчилсан байна. Эдинбургт Тэрээр Эсперанточдын нийгэмлэг дээр уран яруу илтгэл тавьж, түүндээ өрнө, дорны хоорондын хамтын ойлголцлыг сайжруулахын тулд дорно зүгийн Бахайчуудыг эсперанто хэл сурахыг уриалж байжээ. Парис хотод хоёр сарын турш өдөр бүр ярилдлага өгч, хурал цуглаан дээр үг хэлсний эцэст Штутгартад очиж, Германы Бахайчуудтай хэд хэдэн амжилттай уулзалт хийжээ. Дараа нь Будапешт, Венад бас өөр хүмүүстэй уулзаж, 1913 оны 5 дугаар сард Египетэд эргэн ирж, 1913 оны 12 дугаар сарын 5-нд Хайфад буцаж иржээ.

### Ариун Газар луу буцсан нь

Тэр үед Абдул-Баха далан настай байсан бөгөөд он удаан жилийн турш цуцалтгүй хөдөлмөрлөж, эцэст нь өрнөдийн орнууд уруу айлчлан бие тэнхээ нь алжаасан тул хүч нилээн тамирдаж сульдсан байлаа. Буцаж ирснийхээ дараахан Тэрээр өрнө, дорнын сүсэгтнүүдэд хандаж дараах сэтгэл хөдөлгөм илгээлтийг бичсэн юм:

*“Анд нөхөд өө! Та нараас хагацан салах цаг минь ойртож байна. Би хийж чадах бүхнээ хийсэн. Би чадлынхаа чанад хүртэл Бахауллагийн Үйл хэргийн төлөө үйлчилсэн. Би амьдралынхаа он жилүүдэд өдөр шөнөгүй хөдөлмөрлөсөн билээ. Хайрт анд нар Үйл*

<sup>1</sup> “Агностик” гэдэг нь “мэдлэггүй” гэсэн утгатай. Агностик үзэл нь агейст буюу Бурхангүйн үзлийн нээгдэл оюунлаг бөгөөд илүү шуларга хэлбэр нь болдог-орч

хэргийн үүрэг хариуцлагыг өөрсдийн нуруун дээр үүрээсэй гэж би хичнээн их хүсэж байгаа билээ! Абха-н (Хамгаас Яруу алдарт гэсэн утгатай) Хаант улсыг тунхаглан зарлах цаг одоо ирлээ. Хайр ивээл, эв нэгдлийг тогтоох цаг одоо ирлээ! Бурханы анд нөхөд оюун санаагаараа эвсэн зохицох өдөр ирлээ!

Сүсэгтнүүдийн цуглаан уулзалтын үеэр хайр ивээл, эв нөхөрлөлийн дуухуур эгшиглээсэй хэмээн би өрнө зүгт, дорно зүгт, хойд зүгт, өмнө зүгт чих тавин сонсож байна. Миний амьдрах нас дуусах нь дөхөж байгаа тул үүнээс шүү баяр баясгалантай зүйл надад үгүй билээ.

Анд нөхөд маань гялалзан гялтганах сувдан хэлхээ мэт, очир амлаасан холбоос гинж мэт, нарны цацрагууд мэт, нэгэн талын сүрэг зээр мэт эв нэгдэлтэй байгааг харахыг би хүсэн тэмүүлж байна.

Ид шидийн алтан гургалдай тэдэнд дуу дуулж байна, тэд түүнийг нь сонсохгүй юм гэж үү? Диваажингийн шувуу жсиргээж байна, тэд дуулахгүй байна гэж үү? Абха-н Хаант улсыг сахиусан Тэнгэр тэднийг дуудаж байна, тэд чих тавин сонордохгүй юм гэж үү? Гэрээсийн Элч хүсэн гуйж байна, тэд анхааран чагнахгүй юм гэж үү?

Ай! Сүсэгтнүүд маань чин сэтгэл, шударга үнэнч байдлын бодит илэрхийлэл, хайр ивээл, эв найртай амьдралын үлгэр жишээ, эв нэгдэл, эв эеийн амьд бэлгэ тэмдэг болж байгаа тухай баярт мэдээг сонсохыг би хүсэн хүлээж байна.

Тэд миний зүрх сэтгэлийг баясгахгүй юм гэж үү? Тэд миний хүслийг илэрхийлэхгүй юм гэж үү? Тэд миний зүрх сэтгэлийн мөрөөдлийг биелүүлэхгүй юм гэж үү? Тэд миний дуудлагыг сонсохгүй юм гэж үү?

Би хүсэн хүлээж байна, тэвчээртэйгээр хүсэн хүлээж байна!"

Бахайн Үйл хэргийн дайснууд тэдний харгис явдалд Баб золиос болон мөхөхөд, Бахаулла төрөлх нутгаасаа хөөгдөж, насаараа хоригдол болоход, дараа нь Бахаулла тэнгэрт халихад баясан цэнгэж, найдвар горьдлого нь улам нэмэгдэж байсан билээ. Гэтэл Абдул-Баха өрнөдөд аялсныхаа дараа эргэж ирээд хүч тамирдан

доройтсоныг хараад тэд зорилгоо биелүүлэхэд нь боломж дахин олдлоо хэмээн горьдон баярласан ч тэдний горьдлого бүтэхгүй өнгөрөх тавилантай байсан юм. Маш удсан ч үгүй Абдул-Баха ингэж бичжээ:

*“Энэхүү эгэл хүний бие махбод, хүч эрчим байнгын ядран туйлдаж ачааллаа дийлэхгүй байсан нь мэдээж... Гэвч Мөрөөдөл болсон Түүний тусламж дэмжлэг нь сул дорой Абдул-Бахагийн Асран Хамгаалагч нь болж байсан юм... Зарим хүмүүс Абдул-Баха энэ ертөнцтэй сүүлчийн удаа салах ёс гүйцэтгэх гэж байна, түүний бие тэнхээ хомсдон доройтож, удалгүй энэ бүхний улмаас түүний амьдрал дуусах гэж байна хэмээн батлан хэлж байна. Энэ бол үнэнээс хол буй заа. Гэрээс зөрчигчид болон муу санаатнуудын нүдэнд гадна талаасаа бие махбод Адист зам мөрийнхөө эрхээр сульдэн тамирдсан мэт санагдаж буй боловч Бурханы авралаар, Адист Гоо жавхлангийн зөн билгээр оюун санааны хүчнүүд туйлын эрч хүчээ авч, оргилдоо хүрсэн байна. Бурханы авралаар эдүгээ Бахауллагийн адис, буян ивээлээр биеийн хүчнүүд ч хүртэл бүрэн сэргээж, тэнгэрлэг баяр баясгаланг хүртэж, эрхэм дээд баярт мэдээ гэрэлтэн гийж, төгс аз жаргал бялхан буцалж байна”* “Өрнөдийн Од”, 5-р боть, 14-р хэсэг, х. 213

Европын дайны үеэр болон дайны дараа Абдул-Баха үлэмж их ажлынхаа хажуугаар харилцаа холбоо дахин сэргэнгүүт онгод хайрласан сайхан захидлуудыг цуврал болгон бичиж илгээсэн нь дэлхий дахин дахь сүсэгтэнүүдийг үйлчлэн зүтгэх цоо шинэ сэтгэлгээ, эрэл тэмүүлээр дүүргэж өгсөн юм. Эдгээр захидлуудад урам онгод авсан Үйл хэрэг огцом хөгжин дэвшиж, хаа сайгүй Шүтлэг маань шинэ эрч хүч, урам зоригоор шингэсэн байлаа.

### **Хайфа дайны жилүүдэд**

Дайны өмнөх саруудад Абдул-Бахагийн зөнч мэргэн ухааныг илтгэсэн гайхамшигт нэгэн жишээ бий. Тайван жилүүдэд Хайфа хотод Перс болон дэлхийн бусад орнуудаас ирсэн маш олон мөргөлчид айлчилдаг байжээ. Дайн гарахаас зургаан сарын өмнө Хайфад амьдардаг нэгэн настай Бахай хүн Персээс ирсэн



хэдэн сүсэгтний Абдул-Бахатай уулзахыг хүссэн хүсэлтийг нь танилцуулсан байна. Абдул-Баха зөвшөөрөл олгоогүй бөгөөд түүнээс хойш Хайфад байсан мөргөлчдийн хүсэлтэнд тагталзаж байсан тул 1914 оны 7 дугаар сарын эцэс гэхэд ямар ч мөргөлчин хүн Хайфад үлдээгүй байв. 8 дугаар сарын эхний хэдэн өдөр агуу их дайн гэнэт дэгдсэн мэдээ дэлхий ертөнцийг донсолгож эхлэхэд Түүний болгоомжилсны учир тийнхүү тодорхой болсон юм.

Дайн эхлэхэд амьдралынхаа тавин таван жилийг цөллөг, шоронд өнгөрүүлсэн Абдул-Баха дахиад Туркийн засгийн газрын эрхэнд орсон юм. Сириэс цааших орнуудын анд нөхөд, сүсэгтнүүдтэй харилцах харилцаа бүрэн таслагдсан байсан ба Тэрээр Өөрийн цөөн хэдэн дагалдагчдын хамт дахин хүнд хэцүү нөхцөл байдалд унаж, хоол хүнс хомсдож, амь бие нь ч асар их аюул, бэрхшээлд унасан байв.

Дайны жилүүдэд Абдул-Баха Түүнийг хүрээлэн тойрсон хүмүүсийнхээ материаллаг болон оюун санааны шаардлага хэрэгцээг нь хангах үйлст завгүй ажиллаж байлаа. Тэрээр Өөрөө Тибериасны ойролцоо газар тариалангийн ажил эхлүүлж, ингэснээр тариа будаагаар гачигдахаа больж, Бахайчууд төдийгүй Хайфа, Акка дахь янз бүрийн шашин шүтлэгтэй зуу зуун ядуус Түүний ач тусаар өлсөх аюулаас аврагдсан юм. Тэрээр хүн бүхнийг хайрлан халамжилж, тэдний зовлон зүдгүүрийг нимгэлэх гэж чадах бүхнээ хийдэг байв. Тэрээр өдөр бүр зуу зуун ядуу хүмүүст бага хэмжээний мөнгө тараан өгдөг байв. Мөнгө зоосноос гадна Тэрээр талх өгдөг байлаа. Талх байхгүй үед финик жимс, эсвэл өөр ямар нэгэн юм өгдөг байжээ. Тэрээр сүсэгтэн олон ба ядуусыг тайтгаруулан туслахаар Акка хот уруу үе үе явдаг байлаа. Дайны үед Тэрээр өдөр тутам сүсэгтнүүдтэй уулзаж, Түүний тусламжтайгаар анд нөхөд тэрхүү хүнд хэцүү жилүүдэд аз жаргалтай, амгалан тайван амьдарч байсан билээ.

## Ноён Абдул-Баха Аббас, Британийн Эзэнт гүрний Шадар

1918 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 3 цагт, хорин дөрвөн цагийн турш байлдсаны эцэст хотыг Британи, Энэтхэгийн морин цэрэг эзлэн авч, Туркийн эрхэнд дайны хор уршгийг амссан он жилүүд түүгээр төгсгөл болсонд Хайфа хотынхон туйлын ихээр баярлан цэнгэж байлаа.

Британичууд хотыг эзэлж авсны дараагаар маш олон цэрэг офицерүүд, Засгийн газрын бүх зиндааны албан хаагчид, тэр ч бүү хэл, өндөр албан тушаалтан хүмүүс Абдул-Бахатай ярилцдаг болж, Түүний мэргэн цэлмэг яриаг сонсож, Түүний өргөн дэлгэр үзэл бодол, гүн гүнзгий дотоод сэтгэлгээ, эелдэг зөөлөн харьцаа болон чин үнэнч зочломтгой байдлыг нь биширдэг байв. Засгийн газрын төлөөлөгчид Абдул-Бахагийн эрхэм зан төрх, энх тайван, хүн ардын жинхэнэ элбэг хангалуун амьдралын төлөө хийсэн агуу их буянт үйлсийг нь үнэлж, Түүнд Британийн Эзэнт гүрний Шадар цол хүртээжээ. Цол хүртээх ёслолыг 1920 ны 4 дүгээр сарын 27-нд Хайфа хотын Цэргийн захирагчийн цэцэрлэгт гүйцэтгэсэн байна.

## Сүүлчийн жилүүд

1919-1920 оны өвөл энэхүү зохиогч Хайфад Абдул-Бахагийн гэрт хоёр сар хагасын хугацаанд зочилж, Түүний өдөр тутмын амьдралыг ажиглах аз завшаан тохиолдсон юм. Тэр үед бараг далан зургаан насыг зооглож байсан Абдул-Баха гайхалтай сэргэлэн цовоо хэвээр байсан бөгөөд өдөр бүр итгэхийн аргагүй их ажлыг нугалдаг байлаа. Үе үе ядарч тамирддаг байсан боловч Тэрээр гайхамшигтай тэнхээтэй байгаа хэвээр гэдгээ харуулж, Түүний тусламж хамгийн их хэрэгцээтэй байсан тэр хүмүүст үйлчлэн зүтгэдэг байв. Хувиршгүй тэсвэр тэвчээр, эелдэг зөөлөн, уужуу сайхан сэтгэлтэй зан чанарыг мэдэрч Түүний дэргэд байх нь үнэнхүү буян хишиг мэт байлаа. Шөнийн ихэнх хэсгийг мөргөл бясалгалд өнгөрүүлэх нь Түүний заншил байсан юм. Үдийн хоолны дараагаар хэсэгхэн зуур амрахаас бусад үед үүрийн

гэгээнээс авахуулан үдшийн бүрий хүртэл Тэрээр олон орноос ирсэн захидлуудыг уншин хариу бичиж, өрх гэрийнхээ болон Үйл хэргийн олонт талт ажил хэргийг хамааран завгүй байдаг байлаа. Үдээс жойш Тэрээр гадаа зугаалах юм уу машинаар явж, хэсэгхэн хугацаанд алжаалаа тайлдаг байв. Гэсэн хэдий ч тийм үедээ ч Тэрээр нэг юм уу хэд хэдэн мөргөлчдийн хамт явж, оюун санааны асуудлаар ярилцдаг байсан агаад ингэхдээ бас ядуусыг эргэн тойрох боломжийг алддаггүй байв. Гэртээ буцаж очсоныхоо дараа Тэрээр орой нь анд нөхдийг Өөрийн өргөөнд урьж уулздаг байсан юм. Үдийн хоолны үеэр ч, оройн хоолны үеэр ч Тэрээр хэд хэдэн мөргөлчин анд нөхдийг баясгаж, зочдоо баясгалантай, хошин алиа яриагаар зугаацуулахаас гадна төрөл бүрийн сэдвээр үнэтэй айлдвараа хэлдэг байжээ. “*Миний гэр орон бол инээд баяслын гэр юм*” гэж Тэрээр хэлдэг байсан бөгөөд тийм ч байсан юм. Тэрээр янз бүрийн өнгө зүстэй, үндэс угсаатай, шашин шүтлэгтэй олон хүмүүсийг зочломтгой найрсаг ширээнийхээ ард урин залж, эв нэгдэл, эв найрамдлын уур амьсгалаар зочлохдоо үнэнхүү их аз жаргал олдог байлаа. Тэрээр үнэндээ ч Хайфа дахь жижигхэн хамт олны төдийгүй мөн дэлхий дахины Бахайчуудын хувьд Хайрт эцэг нь байсан юм.

### **Абдул-Баха таалал төгссөн нь**

Амьдралынхаа сүүлчийн нэг хоёр өдөр Абдул-Бахагийн бие тэнхээ ихэд доройтсон байсан хэдий ч олон талт ажил үйлсээ огтхон ч завсарлалгүй үргэлжлүүлж байсан билээ. 1921 оны 11 дүгээр сарын 25-ны Баасан гарагт Тэрээр Хайфагийн сүмд үдийн мөргөлөө үйлдээд дараа нь уламжлал ёсоороо ядууст хишиг хүртээсэн юм. Үдийн зоогны дараа Тэрээр зарим нэг захидлыг дуудан бичүүлжээ. Амарсныхаа дараагаар Тэрээр цэцэрлэг дундуур зугаалж, цэцэрлэгч нартай ярилцсан байна. Орой нь тэр өдөр гэрлэсэн гэрийн нэгэн үнэнч хайрт зарцдаа адис хүртээн зөвлөгөө өгчихөөд Өөрийн өргөөнд урьдын адил анд нөхөдтэйгээ уулзжээ. Үүнээс хойш гурав хүрэхгүй өдрийн дараа 11 дүгээр сарын 28-ны Даваа гарагийн 01.30 минутанд Тэрээр амгалан тайван тэнгэрт хальсан юм. Хоёр охин нь Түүнийг хараад тайван нойрсож байна хэмээн боджээ.

Энэ гунигт мэдээ хот даяар түгэж, цахилгаан мэдээгээр дэлхийн өнцөг булан бүрт хүрэв. Дараачийн өглөө нь (11 дүгээр сарын 29-ний Мягмар гарагт) Түүний цогцсыг хөдөөлүүлжээ.

*“Ийм оршуулах ёслолыг Хайфа төдийгүй, Палестин даяараа урьд нь хэзээ ч үзэж байсангүй... Тийм их олон шашины шүтлэг, үндэстэн ястны олон хэлтэй мянга мянган хүмүүсийг нэгтгэсэн эмгэнэл туйлын гүн гүнзгий байлаа.*

*“Элчин сайд Сэр Герберт Самуэл, Иерусалимын захирагч, Финикийн захирагч, Засгийн газрын өндөр албан тушаалтнууд болоод Хайфа дахь олон орны Консулууд, янз янзын шашины нийгэмлэгүүдийн тэргүүнүүд, Палестины, Иудейн, Христийн, Мусульманы, Друз, Египет, Грек, Турк, Курд үндэстнийг төлөөлсөн нэр хүндтэй хүмүүс, түүнчлэн Америк, Европоос ирсэн ба нутгийн анд нөхөд нь гээд дээд доод зиндааны бүгд нийлээд арван мянга орчим эрэгтэй эмэгтэй, хөгшин залуу хүмүүс хайрт хүнээсээ хагацсанд эмгэнэн гашуудаж байсан юм... “Бурхан минь, Бурхан минь! Бид эцгээсээ хагацлаа, бид эцгээсээ хагацлаа!” гэж хүмүүсийн зүрх сэтгэл нэгэн дуугаар шимширч байв...*

*Тэд аажуухан алхалж Бурханы цэцэрлэг болох Кармел Уулан дээр гарчээ... Хоёр цаг хүлээсний дараа тэд Бабын шарилыг хүрээлсэн цэцэрлэгт хүрэв... Олон хүмүүс цуглан тойрон зогсож, Мусульманчууд, Христчүүд, Иудейчүүд зэрэг олон шашины төлөөлөгчдийн зүрх сэтгэл Абдул-Бахаг хайрласан оргилуун хайраар дүрэлзэж, зарим нь тухайн агшны сэтгэгдлээр, бусад нь урьдчилан бэлдсэн байдлаар өөрсдийн эмгэнэл харууслыг дуу хоолойгоороо шэрхийлэн хайрт хүнтэйгээ сүүлчийн удаа салах ёс гүйцэтгэсэн юм. Тэд Түүнийг энэхүү үймээн самуунт, уй гашуунт эрин үед хүмүүн төрөлхтнийг мэргэн сурган хүмүүжүүлэгч, тайтгаруулан тэтгэгч хэмээн нэгэн эвсэг дуугаар магтан дуулж байсан тул Бахай шүтлэгтнүүдийн хувьд хэлэх зүйл бараг үлдээгүй юм шиг санагдаж байлаа” “Абдул-Баха таалал төгссөн нь”, Хатагтай Бломфильд ба Шоги Эффенди.*

Мусульманы, Христийн, Иудейчүүдийн нийгэмлэгүүдийг төлөөлсөн нэр хүнд бүхий есөн төлөөлөгчид ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн Тэр хүний ариун гэгээн амьдралыг хайрлан биширдэг

тухай уран яруу, сэтгэл хөдөлгөм үг хэлсэн юм. Дараагаар нь шарилтай хайрцагийг нь аажуухан дамжуулан Түүнийг энгийн бөгөөд ариун газар нь үүрд нойрсуулан байрлуулсан юм.

Энэ бол бүхий л амьдралаа шашин, үндэстэн, хэл ярианы эв нэгдэлд зориулсан хүний гэгээн дурсгалыг хүндэтгэсэн зүй ёсны ёслол байсны зэрэгцээ Түүний амьдралын үйлс хэрэг талаар өнгөрсөнгүй, Түүнд онгод хайрлаж байсан Бахауллагийн үзэл санаа бөгөөд амьдрал үйлс нь дэлхий ертөнцөд түгэн тархаж, Мусьманчууд, Христчүүд болон Иудейчүүдийг олон зууны турш бие биеэс нь хөндийрүүлж ирсэн шашны явцуу бүлэглэл, анги давхарга хоорондын саад тотгор болон хүн төрөлхтний дунд орших бусад хагарал бутралыг нурааж эхэлж байна гэдгийн нотолгоо байсан юм.

### Сургаал бичмэл болон айлдварууд

Абдул-Баха үй түмэн сургаал бичмэл туурвисан бөгөөд тэдгээрийн ихэвчлэн сүсэгтнүүд болон сонирхогчдод хандан захидлын хэлбэрээр бичсэн байдаг. Түүний маш олон үг айлдварыг тэмдэглэж нийтэлсэн билээ. Акка ба Хайфад амьдарч байхад нь уулзаж учирсан мянга мянган мөргөлчид дундаас олон хүн өөрсдийн сэтгэгдлийг бичиж үлдээсэн бөгөөд эдгээрээс нилээн хэдийг нь хэвлүүлэн нийтэлсэн байдаг билээ.

Тиймээс Түүний сургаал бүрэн хадгалж үлдсэн бөгөөд тэдгээр нь маш өргөн хүрээний сэдвийг хамардаг юм. Тэрээр Эцгийгээ бодвол, өрнө, дорнын олон асуудлыг илүү дэлгэрэнгүй тайлбарлаж, Бахауллагийн ерөнхий сургаал зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар илүү дэлгэрэнгүйгээр зааж өгсөн юм. Хэд хэдэн сургаал бичмэлийг нь барууны ямар ч хэлэнд орчуулаагүй байгаа хэдий ч Абдул-Бахагийн сургаалын хамгийн чухал зарчмуудыг орчуулан нийтлүүлснээр хүмүүст гүн гүнзгий, бүрэн дүүрэн мэдлэг өгөхөд хангалттай болсон юм.

Абдул-Баха перс, араб, турк хэлээр ярьдаг байв. Өрнөдөд аялж байх үед Түүний үг айлдварыг үргэлж орчуулдаг байсан бөгөөд орчуулах явцад анхдагч гоо яруу хэллэг, хүч эрч гээгддэг байсан

хэдий ч Бурханы Сүнсний далдын хүч агуу байсан тул сонссон бүх хүний сэтгэлд хүрдэг байлаа.

### Абдул-Бахагийн Байр суурь

Адист Гоо жавхлангаас Абдул-Бахад онцгой өвөрмөц байр суурийг олгож, дараах сургаалдаа ингэж бичсэн юм:

*"Миний Ахуйн тэнгис далай ширгээж, Миний Үүдэл нээлтийн Судар дуусах болоход Бурханаас томилогдсон, энэхүү Өнө эртний Үндэсээс мөчир болон ургасан Түүн үрүү нүүр царайгаа хандуулагтун."*

Бахаулла дахин бичихдээ: "...Судар номоос үл ойлгох зүйлээ энэхүү хүчирхэг Сүргээс төрсөн Түүнээс асуун лавлагтун" гэжээ. Абдул-Баха Өөрөө ингэж бичжээ:

*"Китаб-и-Акдас"-т тодорхой бичсэний дагуу Бахаулла Гэрээсийн Төвийг Өөрийн Үгийг Тайлбарлагч болгосон юм. Энэ Гэрээс нь бат бөх, хүчирхэг Гэрээс тул цаг хугацааны эхэн үеэс авахуулан өнөөдрийг хүртэл ийм адил Гэрээсийг ямар ч шашны Эрин үе бий болгоогүй билээ."*

Абдул-Баха нь Бахауллагийн Шүтлэгийг Өрнө, Дорнод түгээн дэлгэрүүлэхдээ туйлын бүрэн зүтгэлийг үзүүлдэг байсан нь зарим тохиолдолд сүсэгтнүүд Абдул-Бахагийн байр суурийн талаар эргэлзэн төөрөгдөлд ороход хүргэдэг байв. Түүний үг яриа, ажил үйлсээс ундарч байгаа сүнсний ариун чанарыг нь ухаарч, уламжлалт номлол үеэ элээж, шашны шинэ нөлөө үйлчилж байгааг эргэн тойрондоо ажигласан зарим Бахайчууд Абдул-Бахаг Бурханы Тодруулагчтай адилтгаж, Түүнийг "Христийн хойт дүр" гэж магтах ёстой гэж үздэг байжээ. Бахауллад үйлчлэх Абдул-Бахагийн хүчин чадал нь Үнэний Нарыг тусгасан ариун толиноос цацарч байсан болохоос биш Нарнаас ундарч байгаагүй гэдгийг үл ойлгох ийм явдал Түүнд туйлын их гуниг авчирдаг байсан юм.

Үүнээс гадна өмнөх шашнуудаас ялгаатай нь гэвэл, Бахауллагийн Шүтлэг нь өөрийн дотор даян дэлхийн хүмүүн төрөлхтний нийгмийг хамрах хүчин чадалтай байсан юм. 1892 оноос 1921 он хүртэл Абдул-Бахаг байх үед Шүтлэг нь дэлхийн жинхэнэ ёсны эмх журмын чиглэлд өөрийн хөгжлийн



шат дараалсан үеүдийг туулан хөгжсөн юм. Ингэж хөгжихөд нь Абдул-Бахагийн чиглэл заавар байнга шаардлагатай байсан бөгөөд гагцхүү Абдул-Баха л энэ эрин үеийн газар дэлхийд ирсэн шинэ хүчирхэг урам онгодыг бүрэн дүүрэн ойлгож байсан юм. Абдул-Баха биет ертөнцөөс халин одсоны дараа Түүний гэрээслэл бичгийг нээж, Шүтлэгийн Асран тэтгэгч Шоги Эффенди уг гэрээслэлийн ач холбогдлыг тайлбарлах хүртэл Бахайчууд хайрт Багшийн удирдамжийг Бурханы Тодруулагчийн оюун санааны заавар лүндэнгийн адил үзэх нь бараг гарцаагүй байдаг байлаа.

Өнөөгийн Бахайчуудын дунд ийм оргилуун боловч гэнэн явдал байхгүй бөгөөд тэд Абдул-Бахагийн өвөрмөц онцгой шинж чанарыг өдрөөс өдөрт ухамсарлан дээдэлж, Түүний хосгүй буян зүтгэлийн нууц оньсогыг улам их ухаарах болсон юм. 1892 онд Үлгэр жишээ Тайлбарлан таниулагч нь бие махбодоороо цөлөгдөн хоригдсонтой холбогдон их сул дорой, арчаагүй чадалгүй мэт санагдаж байсан Шүтлэг нь түүнээс хойш няцашгүй их хүч чадлаар олон оронд нийгэмлэгүүдээ байгуулан босгож, уруудан доройтож буй соёл иргэншлийн сул талыг харан сэтгэлээр унасан хүн төрөлхтний ирээдүйг нээсэн цорын ганц сургаалаараа даван туулж байна.

Абдул-Бахагийн “Хүсэл зориг ба Гэрээслэл” нь Баб, Бахаулла болон Абдул-Баха нарын байр суурийн оньсогыг бүрэн дүүрэн тодорхойлон тайлж өгсөн юм:

*“Энэ бол Баха-и хүмүүсийн (Миний амьдрал тэдэнд зориулагдаг) сүсэг бишрэлийн үндэс суурь болой. Ариун Гэгээн, Өргөмжит Элч Баб болбоос Бурханы Эв нэгдэл, Нэг нэгдмэл чанарын Тодруулагч бөгөөд Өнө эртний гоо жавхлангийн Урьтал Элч бөлгөө. Ариун Гэгээн Абха-и Гоо жавхлан болбоос (Миний амьдрал Түүний үнэнч нөхдөд золиос болог) Бурханы Дээд Тодруулагч бөгөөд Бурханы Хамгаас Тэнгэрлэг Мөн чанарын Эх булаг юм. Бусад бүх хүмүүс болбоос Түүний шадар зарц нар бөгөөд Түүний зарлигийг дагах учиртай юм.”*

Аливаа хүн Шүтлэгийн тухай мэдлэгээ Абдул-Бахагийн ерөнхий Сургаал бичгүүд дээр суурилахыг чухалчилсан Абдул-Бахагийн энэ болон бусад олон үг айлдварууд нь сүсэг бишрэлийн эв нэгдлийг тогтоож, улмаар хувь хүмүүст хандаж, асуултанд нь

хариу өгсөн Абдул-Бахагийн Сургаал бичгүүдтэй холбоотойгоор үүдэн гарсан ойлголтын ялгаа нь түргэн арилсан юм. Түүнээс гадна Асран Тэтгэгч тэргүүтэй засаг захиргааны тодорхой журмыг байгуулснаар урьд өмнө нь хувь сүсэгтэн Бахайчуудаар дамжин орон нутгийн хэсгүүдэд хэрэгжиж байсан эрх мэдэл нь байгууллагаудад шилжсэн юм.

### **Бахайн Амьдралын Үлгэр жишээ**

Бахаулла болбоос Бурханы Үгийн Үүдэн Нээгч байсан билээ. Дөчин жилийн турш хоригдож байсан тул Тэрээр бусад хүмүүстэй уулзаж ярилцах боломж тун бага олдож байсан юм.

Тийм учраас Үүдэл нээлтийг тайлбарлаж, Бурханы Сургаалыг хэрэгжүүлэх, өнөөдрийн ертөнцтэй шууд харилцан Бахайн амьдралын үй түмэн шинж төрхийг харуулсан Агуу Үлгэр жишээ болох үүрэг Абдул-Бахад ноогдсон юм. Орчин үеийн амьдралын зав зайгүй үймээн дунд, өөрийгөө өргөмжлөн хайрлаж, материаллаг элбэг дэлбэг баялгийг төлөө хөөцөлдөн тэмцэх явдал хаа сайгүй ноёрхож байгаа ийм нөхцөл дунд Христ, Бахаулла болон бусад бүх Зөнч мэргэдээс хүмүүн төрөлхтөнд хандан айлдсан Бурханд бүрэн өөрийгөө зориулж, бусдын тусын төлөө үйлчлэн зүтгэх замаар амьдрах зам мөрийг дагах нь боломжтой юм гэдгийг Тэрээр харуулж чадсан юм. Нэг талаас элдэв янзын сорилт шалгуур, гай гамшиг, зовлон бэрхшээл, урвалт мэхлэлтийг амсаж, нөгөө талаас хайр ивээл, магтаал, чин зүтгэл, хайр хүндэтгэлийг хүлээн Тэрээр эргэн тойронд нь хүйтэн ширүүн шуурга шуурч, зуны тэнгис давалгаалан булгилж байхад Өөрөө хатуу тууштай, ер донсолсон шинжгүй хатуу хадан дээр зогсоо гэрэлт цамхаг лугаа адил байсан юм. Тэрээр сүсэг бишрэлийн амьдралаар амьдарсан, Өөрийн дагалдагчдыг ч энд, одоо ч тийм л амьдралаар амьдрахыг уриалж байна. Тэрээр үймээн самуунт ертөнцийн дунд Эв нэгдэл, энх тайвны Туг, Шинэ эрин үеийн Далбаа болон намирч, энэ үйл хэргийг дэмжсэн хэн боловч Шинэ Өдөрийн Сүнсээр тэтгэгдэх болно гэдгийг Тэрээр батлан амласан юм. Энэ бол өнгөрсөн цагийн Зөнч мэргэд, Ариун гэгээнтнүүдийг тэтгэж байсан нөгөө л Ариун Сүнс боловч тэрхүү Сүнсний шинэ эрин цагийн шаардлагыг хангасан хэлбэр бөлгөө.

## Тавдугаар бүлэг

### БАХАЙ ГЭЖ ЮУ ВЭ?

*“Хүн бүр үр жимс өгч байх ёстой. Үр жимсгүй хүн бол Ариун гэгээн Сүнсний (Христийн) айлдсанаар үр жимсгүй мод лугаа адил бөгөөд үр жимсгүй модыг түлшинд л хэрэглэдэг билээ”*

*Бахаулла “Диваажингийн үгс”*

Герберт Спенсер нэг удаа хэлэхдээ, улс төрийн ямар ч алхимиэр (юмсыг хувиргах ид шидийн хүч-орч) тугалган зөн билиг дотроос алтан зан төрхийг гаргаж болдоггүй гэсэн билээ. Үүний яг адил улс төрийн ямар ч алхимиэр тугалган хувь хүмүүсээс алтан нийгмийг гарган авч болохгүй юм. Өмнөх үеийн Зөнч мэргэдийн адил Бахаулла үнэнийг тунхаглаж, дэлхий ертөнцөд Бурханы Ханлиг улсыг тогтоохын тулд эхлээд уг Ханлиг улсыг хүмүүсийн зүрх сэтгэлд тогтоох ёстой гэж зааж сургасан юм. Тиймээс Бахайн сургаалыг шинжлэн судлахдаа бид хувь хүний зан төрхийн талаар сургасан Бахауллагийн айлдвар сургаалаас эхэлж, Бахай байх гэж чухам юу гэсэн үг вэ гэдэг талаар тод дүр зурагтай болохыг хичээнэ.

#### **Бахайн амьдралаар амьдрах нь**

Нэг удаа Абдул-Бахагаас “Бахай гэж хэн бэ?” гэж асуухад Тэрээр ингэж хариулсан юм:

*“Бахай хүн байна гэдэг бол бүх л дэлхий ертөнцийг хайрлах, хүн төрөлхтнийг хайрлаж, хүн төрөлхтөнд үйлчлэх, даян дэлхийн энх тайван ба даян дэлхийн ах дүүгийн барилдлагааны төлөө ажиллана гэсэн үг”* гэсэн юм.

Бас нэгэн тохиолдолд тэрээр Бахай хүнийг “Хүний бүх л төгс төгөлдөр чанарыг бодитоор эзэмшсэн хүнийг хэлнэ” гэжээ. Лондонд байхдаа нэгэн яриандаа Тэрээр аливаа хүн Бахауллагийн нэрийг дуулаагүй мөртөө Бахай байж болно гэж хэлсэн гэдэг. Тэрээр бас хэлэхдээ:

*“Бахауллагийн сургаалын дагуу амьдралаа зохиосон хүн бол нэгэнт Бахай хүн гэсэн үг. Нөгөө талаас өөрийгөө тавин жил Бахай гэж хэлж байгаа хүн амьдралаараа харуулаагүй бол Бахай биш юм. Муухай царайтай хүн өөрийгөө царайлаг гэж хэлбэл тэрээр хэнийг ч хуурч чадахгүй, хар арьстай хүн өөрийгөө цагаан гэж хэлбэл хэнийг ч хуурч чадахгүй, тэр ч бүү хэл өөрийгөө ч хуурч чадахгүй.” “Абдул-Баха, Лондонд”*

Гэхдээ Бурханы Элч нарыг мэдэхгүй байгаа хүн сүүдэрт ургаж байгаа ургамлын адил юм. Тэр ургамал нарыг мэдэхгүй боловч нарнаас бүрэн шалтгаалдаг. Агуу Зөнч мэргэд бол оюун санааны нар лугаа адил бөгөөд Бахаулла бол бидний амьдарч буй энэ цаг үеийн Наран юм. Өнгөрсөн цагийн нарнууд нь дэлхий ертөнцийг дулаацуулан тэтгэж байсан юм. Тэр үед нар ээгээгүй бол одоо газар дэлхий маань даарч хөрон мөхсөн байх байсан биз ээ. Гэсэн ч гагцхүү өнөөдрийн нарны туяа өмнөх үеийн нарны амьдруулсан тэр үр жимсийг бүрэн боловсруулж чадах юм.

### **Бурханд Бишрэн Үйлчлэх нь**

Бахайн амьдралыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд Бахауллагтай ухамсартайгаар бөгөөд шууд харилцах нь хонхон цэцэг юм уу сарнай цэцгэнд нарны гэрэл хэрэгтэйн адил чухал хэрэгтэй юм. Бахай хүн нь Бахауллагийн хувь хүний мөн чанарыг шүтэн биширдэггүй харин түүгээр дамжин тодорсон Бурханы Алдарыг бишрэн шүтдэг юм. Бахай хүн нь Христ, Мухаммед болон Бурханаас хүн төрөлхтөнд илгээсэн өмнөх бүх Элч нарыг дээдлэн хүндэлдэг боловч Бахаулла бидний амьдарч буй энэ шинэ эрин цагт Бурханы Илгээлтийг авчирсан, өмнөх Элч нарын үйл хэргийг хэрэгжүүлэн дуусгахаар ирсэн Дэлхийн Агуу Сурган хүмүүжүүлэгч Багш хэмээн хүлээн зөвшөөрдөг юм.

Хүн оюун сэтгэхүйгээрээ дэвшин итгэл үнэмшилд хүрснээр Бахай болдоггүй, мөн гадаад төрх зан байдлаараа ч Бахай болдоггүй. Бахаулла Өөрийн дагалдагч нарыг чин сэтгэлийг барьж, бүрэн бишрэн үйлчлэхийг шаарддаг. Гагцхүү Бурхан л ийм зүйлийг шаардах эрхтэй бөгөөд Бахаулла болбоос Бурханы

Тодруулагч ба Бурханы Хүсэл зоригийг Нээн тодруулагч юм. Өмнөх үеийн Тодруулагч нар ч энэ тал дээр мөн адил тодорхой байлаа. Христ хэлэхдээ: *“Аливаа хүн намайг дагахыг хүсвээс өөрийгөө үгүйсгээд загалмайгаа аван намайг дагаг. Учир нь, амиа аварсан хүн бол амиа алдана, харин миний төлөө амиа алдсан хүн бол амиа олно.”* гэсэн юм. Өөрөөр хэлбэл, Тэнгэрлэг Тодруулагч нар бүгдээрээ өөрсдийн дагалдагч нараас ийм бишрэл зүтгэлийг шаардаж байсан бөгөөд энэ шаардлагыг чин сэтгэлээс хүлээн зөвшөөрсөн цагт газар дэлхийн ямар ч эсэргүүцэл, зовлон зүдгүүр, хяхан хавчилт, сүсэгтнүүдийн зовлонг үхэл мөхлөөс үл хамааран тухайн шашин хөгжин цэцэглэж явсан гэдгийг шашны түүх тод томруун харуулж байгаа билээ. Нөгөө талаас бүрэн хүлцэн зүтгэхийн оронд үүнээс зайлсхийх юм уу дүр эсгэхийг оролдсон тохиолдолд шашин доройтдог билээ. Тухайн шашин нь цаг үеийн онцлог загвар болсон ч аврах, хувьсган өөрчлөх, гайхамшигт ид шидийг бүтээх хүч чадлаа алдаж байсан юм. Жинхэнэ шашин хэзээ ч тухайн цаг үедээ онцлог загвар болж байсангүй. Нэгэн өдөр Бурханы ивээлээр ийм болох болтугай. Гэхдээ Христийн өдрүүдэд *“Амьдралд хүргэгч хаалга нь хавчиг, зам нь нарийн бөгөөд энэ замаар явах хүн нь цөөн”* гэж хэлж байсан нь одоо ч үнэн билээ. Оюун санаагаар төрөх зам нь хүн байгаль дэлхийд төрөх замын адил хүмүүсийг нэг нэгээр нь ямар ч ачаагүйгээр хүлээн авдаг юм. Хэрэв ирээдүйд өнгөрсөн үеийг бодвол энэ замд олон хүн орвол энэ нь хаалга өргөн болсонтой холбоотой биш харин Бурханаас шаардаж буй “агуу золиослол”-ыг хүмүүс хийхэд улам шийдэмгий болсонтой холбоотой болох агаад он удаан жилийн гашуун туршлагынхаа ачаар хүмүүс Бурханы зам мөрийн оронд өөрсдийн замыг сонгосондоо харуусах болсонтой холбоотой болох юм.

### Үнэнийг Эрэлхийлэхүй

Бахаулла бүх дагалдагч нараасаа шударга ёсыг баримтлахыг шаарддаг бөгөөд шударга ёс гэдгийг Тэрээр ингэж тодорхойлжээ:

*“Мухар сүсэг, хуулбарлан дуурайх явдлаас чөлөөлөгдөж, улмаар Бурханы Тодруулагч нарыг нэг нэгдмэл чанарын мэлхийгээр*

*харж, бүх л асуудлыг хурц ухаанаар бодон эргэцүүлэх*” “Мэргэн ухаантны үгс”

Хүн бүр өөрөө Бахауллагийн биенд Бурханы Алдар тодорсон байгааг харж ухаарах ёстой билээ. Эс тэгвээс Бахай Шүтлэг нь тэр хүний хувьд ямар ч утга агуулгагүй нэр төдий л санагдах болно. Онч мэргэд үеэс үед хүн төрөлхтөнд хандахдаа хүмүүсийг нүдээ аних биш харин нээж, оюун ухаанаа дарах биш харин ашиглахыг уриалж ирсэн юм. Сохор итгэмтгий байдлаар биш харин тод хараа, чөлөөт сэтгэлгээ нь атгаг сэжиг үзлийн үүлийг замхруулан сохор дуурайлгын хүлээсээ таягдан хаяж, шинэ Үүдэл нээлтийн үнэнийг хүлээн зөвшөөрч ухаарахад нь тус болно.

Бахай болох хүн нь үнэний хойноос аймшиггүй эрэлч хүн байх ёстой бөгөөд өөрийн эрлийг гагцхүү материаллаг ертөнцөөр хязгаарлах ёсгүй юм. Түүний оюун санааны мэдрэмж биет мэдрэмжийнх нь адил үргэлж сонор соргог байх шаардлагатай. Тэрээр Бурханаас заяагдсан бүхий л хүчин чадвараа үнэнийг олоход ашиглаж, хангалттай шалтгаангүйгээр ямар ч юманд хоосон итгэх ёсгүй. Хэрэв түүний зүрх сэтгэл ариун, оюун ухаан нь элдэв атгаг сэжиг үзлээс ангид бол хичээнгүй эрэлч хүн Тэнгэрлэг Алдрыг ямар ч сүм дотор тодорсон байлаа ч хүлээн зөвшөөрөх болно. Бахаулла цааш нь айлдахдаа:

*“Хүн өөрөө өөрийгөө мэдэх ёстой, чухам юу түүнийг өргөмжлөлд эсвэл доромжлолд, нэр алдарт эсвэл гутамшигт, эд баялагт, эсвэл ядууралд хүргэх вэ гэдгийг мэдэх ёстой.”* “Таразат”

*“Бүхий л эрдмийн эх үүсвэр болбоос Бурханыг танин мэдэх мэдлэг, Түүний Алдар бадартугай! Энэ мэдлэгт Түүний тэнгэрлэг Тодруулагчийг таньж мэдэхгүйгээр хүрэхийн аргагүй.”* “Мэргэн ухаантны үгс”

Бурханы Тодруулагч болбоос Төгс төгөлдөр Хүмүүн, хүн төрөлхтний агуу Үлгэр дуурайл, хүн төрөлхтний модны Шилдэг Үр жимс бөлгөө. Бид Түүнийг таньж мэдэхээс нааш өөрсдөдөө буй агуу их нөөц чадавхийг таньж мэдэж чадахгүй билээ. Хонхон цэцэг хэрхэн ургадаг талаар Христ зүйрлэж, Соломон хаан эдгээрийн нэгэн шиг ганган хувцаслаж байсангүй гэж хэлсэн



билээ. Хонхон цэцэг анхандаа маш муухай сонгино хэлбэртэй үндэснээс ургадаг. Хэрэв хонхон цэцэг цэцэглэж байхыг хараагүй, эсвэл хосгүй гоо үзэсгэлэнтэй дэлбээ цэцгийг нь хэзээ ч хараагүй бол тэр үндсэн нуугдмал буй мөн чанарыг нь хэрхэн мэдэх байсан юм бэ? Бид үндсийг нь тун сайтар ажиглаж, шинжилж үзсэн ч цэцэрлэгч хүний ур хөдөлмөрөөр сэрдэг гоо сайхныг нь олж харж чадахгүй шүү дээ. Тийнхүү Бурханы Тодруулагчид нээгдсэн Бурханы Алдарыг харахаас нааш бид өөрсдөдөө болон бусад хүмүүст буй оюун санааны гоо үзэсгэлэнг олж мэдэж чадахгүй юм. Бурханы Тодруулагчийг таньж хайрлан Түүний сургаалыг даган мөрдсөнөөр бид бага багаар өөрсдийнхөө дотор буй төгс төгөлдөр нөөц чадавхийг ухамсарлах бөгөөд гагцхүү тэр л цагт амьдрал, орчлон хорвоогийн утга учир, зорилго бидэнд тодорхой болно.

## Бурханы Хайр

Бурханы Тодруулагчийг таньж мэднэ гэдэг нь бас Түүнийг хайрлахыг хэлнэ. Нэг нь нөгөөгүйгээр боломжгүй юм. Бахаулагийн айлдсанаар хүн энэ хорвоод бүтээгдсэний зорилго нь хүн Бурханыг таньж шүтэх явдал юм. Бахаулла Өөрийн нэгэн Илгээлт бичигт:

*“Зуурдын бүхий л зүйлс бүтээгдсэний шалтгаан бол хайр байсан агаад нэгэн алдартай сургаал үгэнд хэлсэнчлэн “Би болбоос нуугдмал эрдэнэ байсан тул өөрийгөө мэдүүлэхийг хүссэн юм. Тиймээс би өөрийгөө мэдүүлэхийн тулд хорвоог бүтээсэн юм” гэсэн байна. “Эрдэнийн Нуугдмал Үгс”-нд Тэрээр айлдахдаа:*

*“Аяа, Ахуйн үр!*

*“Намайг хайрлагтун, чингэвээс Би чамайг хайр өршөөлдөө багтааж чадму. Харин чи Намайг үл хайрлах аваас Миний хайр өршөөл чамд хүртээлгүй болмой, үүнийг зарц минь мэдтүгэй.”*

*“Аяа, Гайхамшигт Зөн билгийн үр!*

*“Намайг хайрлан сүслэх болов уу гэсэндээ Би чиний дотор Өөрийн оюун санааг үлээж оруулсан билээ. Юунд чи Намайг орхиж, хайр сүсэг чинь өөр бусдыг эрэн одов?” гэжээ.*

Бурханыг хайрлагч байх! Энэ л Бахай хүний амьдралын цорын ганц зорилго юм. Бурханыг өөрийн хамгийн дотнын анд, Хосгүй хайрт, хамгийн дотнын нөхрөө болгож, Түүний ахуйд баяр жаргалын дээдийг эдлэх! Бурханыг хайрлана гэдэг нь юм бүхнийг бас хүн бүхнийг хайрлана гэсэн үг, яагаад гэвэл энэ бүгд нь Бурханаас л гаралтай. Жинхэнэ Бахай хүн болбоос төгс хайрлагч байх ёстой. Тэрээр хүн бүрийг цэвэр ариун, оргилуун сэтгэлээр хайрлана. Тэрээр хэнийг ч үл үзэн ядна. Жинхэнэ Бахай хүн бол зүс царай бүрт Хайрт Бурханы дүрийг олж, хаана ч Түүний мөрийг олж сурсан байх тул хэнийг ч үл жигшинэ. Түүний хайр ямар ч шашны урсгал, үндэстэн, анги давхарга эсвэл арьсны өнгө гэдгийг ялгаварлаж мэдэхгүй. Бахаулла ийнхүү айлджээ:

*“Эртний сургаалд: “Эх орноо хайрлах хайр бол Бурханы Шүтлэгийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болой” гэж сургасан байдаг. Сүр жавхлангийн Хэл бээр харин Өөрийн тунхаглалын энэ эрин үед ийнхүү айлджээ: “Зөвхөн эх орноо хайрладаг хүн өөрөөрөө бахархах ёстой бус харин нийт дэлхий ертөнцийг хайрлан хамгаалдаг хүн л өөрөөрөө бахархах ёстой.” Энэ мэргэн сургаалын хүчээр Тэрээр хүмүүсийн зүрх сэтгэлийн жигүүрт шинэ эрч хүчийг хайрлан, нисэн дүүлэх шинэ замыг зааж өгч, Бурханы ариун судраас аливаа хязгаарлалтыг арилгасан болой” “Дэлхий ертөнцөд хандсан илгээлт”*

Тэрээр дахин айлдсан нь:

*“Өөрийн ахыг өөрөөсөө шүүд үзсэн хүн адистат билээ. Ийм хүн бол чухамхүү Бахай хүн мөн.” “Диваажингийн үгс”*

Абдул-Баха хэлэхдээ, бид *“Олон биенд байгаа нэгэн сүнс мэт нэгдмэл байх хэрэгтэй. Бид бие биеэ улам хайрлах тусам Бурханд улам ойртох болно”* гэсэн юм. Америкт нэгэн цуглаанд хандаж Тэрээр:

*“Бурханы Тодруулагч нарын тэнгэрлэг шашин шүтлэг нь ёс жаяг өөр боловч угтаа нэг юм. Гэрэл ямар өдрийн одноос цацрахаас үл хамааран хүн гэрэлд хайртай байх ёстой. Ямар хөрсөнд ургаж байгаагаас үл хамааран хүн сарнай цэцгийг хайрлах ёстой. Тэрээр ямар үүсэл гаралтайгаас үл хамааран*

үнэнийг эрэлхийлэгч байх ёстой. Дэнлүүнд дасал болох нь гэрлэнд хайртайгийн нэр биш, газар шороонд дасал болох нь зүйд нийцэхгүй, уг хөрснөөс ургах сарнай цэцгийг таалаг таашаах нь зүйтэй. Модонд үнэнч байх нь ашиггүй, харин үр жимсийг нь арчлан хайрлах нь үр өгөөжтэй. Ямар модонд ургаж, хаанаас олдсон нь хамаагүй тансаг амттай жимсийг таашаан амтлах ёстой. Хэний амнаас унаснаас нь үл хамааран үнэн үгийг сайшаан дэмжих ёстой. Ямар судар номонд сийлэгдсэнээс нь үл хамааран туйлын үнэнг хүлээн зөвшөөрөх ёстой. Бид атгаг сэжиг үзлийг бариваас дутагдал гачигдал, харанхуй бүдүүлэг байдлын эх үүсвэр болно. Шашин, улс үндэстэн, янз бүрийн арьстан хоорондын тэмцэл нь бүгд үл ойлголцоос бий болдог. Хэрвээ бид суурь үндэс зарчмыг нь нээн илрүүлэхийн тулд шашныг судлах аваас тэд хоорондоо нийцэн уялдаг гэдгийг ойлгох болно. Учир нь тэдний байр суурь үндэс болсон бодит байдал нь олон биш, нэг юм. Энэ арга замаар дэлхийн шашинууд эв нэгдэл, эвлэрэлд хүрч чадна” гэж хэлсэн байна. Тэрээр дахин ингэж айлджээ:

“Хайрт анд нарын хэн нь ч болов бусдыг хайрлах ёстой бөгөөд өөрийн эд баялаг, амь амьдралыг тэднээс үл харамлаж, бусдыг баяр жаргалтай болгохын төлөө чадах бүхнээ хийх ёстой. Гэвч бусад нь мөн адил өөрсдийгөө огоорон, өгөөмөр болох ёстой. Ингэснээр энэхүү Наран мандаж тэнгэрийн хаяаг бүрхэж, энэхүү Аялгуу бүх хүмүүсийг баясган цэнгүүлж, энэхүү тэнгэрлэг Эм өвчин эмгэг бүрийг анагааж, энэхүү Үнэний Сүнс хүн бүхний амьдралын эх сурвалж болох юм” “Бахауллагийн Илгээлт бичгүүд”, 1-р боть, х. 147

### Биеэ огоорох нь

Бурханд сүсэглэн үйлчилнэ гэдэг нь Бурханаас өөр бусад бүхнээс татгалзаж, өөрөөр хэлбэл, амиа хичээсэн, зуурдын ертөнцийн, тэр ч бүү хэл, нөгөө ертөнцийн дур хүслээс татгалзана гэсэн үг юм. Бурханы зам мөр нь эд баялаг ба үгүйрэл хоосрол, эрүүл энх ба өвчин эмгэг, орд харш ба шорон гяндан, сарнай цэцэрлэг ба тамлалын тавцанг аль алиныг нь дайран өнгөрч болно. Юутай ч гэсэн, Бахай хүн өөрийн хувь тавиланг “Баяр

баясгалантай, бэлэн байдлаар” хүлээн авах ёстой” юм. Биеэ огоорох гэдэг нь эргэн тойрноо огт ажихгүй, эсвэл муу муухай нөхцлийг үл тоомсорлоно гэсэн үг биш юм. Түүнчлэн энэ нь Бурханы бүтээсэн сайн сайхан зүйлсийг ч өөрөөс түлхэнэ гэсэн үг биш юм. Жинхэнэ Бахай хүн бол сэтгэлийн хөдөлгөөнгүй, эсвэл идэвхгүй үлбэгэр, эсвэл хэт биеэ огоорсон мухар сүсэгтэн байх ёсгүй. Тэрээр Бурханы зам мөрд үй түмэн сонирхлыг олж, үй түмэн ажил, үй түмэн баяр жаргалыг олно. Гэвч тэрээр зугаа цэнгэл, дур хүслийнхээ хойноос хөөцөлдөх юм уу Бурханаас хориглосон зүйлсийг хүсэн шунахын төлөө тэр замаасаа өчүүхэн ч гэсэн хазайхгүй. Аливаа хүн Бахай болоход Бурханы Хүсэл зориг түүний хүсэл зориг болдог. Учир нь Бурханаас ялгаатай байх ганц зүйлийг л тэрээр тэвчиж үл чадна. Бурханы замд түүнийг ямар ч алдаа дутагдал гутраахгүй, ямар ч зовлон бэрхшээл зоригийг нь мохоохгүй. Хамгийн зовлонг харанхуй өдрүүдийг нь хайрын гэрэл гэгээ гийгүүлж, зовлон зүдгүүрийг нь баяр баясгалан болгон хувиргаж, тарчлан тамлагдах тавиланг нь баяр хөөр болгон өөрчилнө. Амьдрал нь баатарлаг үйлсийн талбар болж, үхэл нь баяр баясгалангийн элч болно.

Бахаулла ийнхүү айлджээ:

*“Надаас өөр аль нэгэн зүйлд гич ургамлын өчүүхэн үр төдий хэмжээний хайрыг зурх сэтгэлдээ орогнуулсан тэр хүмүүс болбоос Миний Хаант улсад үнэндээ нэвтэрч үл чадна” “Суратул-Хайкал”*

*“Аяа, Хүмүүний үр!*

*Хэрэв чи Намайг хайрлах ахул өөрийнхөө өөрөөс холд, хэрэв Миний тааллыг хүсвэл өөрийнхөө тааллаар эс бол. Тэгвэл чи Миний дотор мөхөж, Би чиний дотор үүрд мөнх амьдарч чадмуу”*

*“Аяа, Миний Шадар зарц!*

*Энэ замбуулингаас холбоогоо тасалж, эгэл өөрийнхөө “би” гэсэн үзлийн шоронгоос сэтгэл санаагаа чөлөөл. Боломж бүрдсэн нэгэн цагийн завшааныг ашигла” “Эрдэнийн Нуугдмал Үгс”*

## Дуулгавартай байх

Бурханд сүсэглэн үйлчлэх нь бас Бурханы үүдэн нээсэн Зарлиг лүндэнг үг зарлигуудын утга учир нь ойлгогдохгүй байсан ч хамаагүй дагагч мөрдөж захирагдахыг шаарддаг. Далайчин хүн онгоцны ахмадын тушаалыг ягштал биелүүлдэг, ингэхдээ тэрээр тушаалынх нь ач холбогдлыг сайн мэдэхгүй байж болно, гэсэн ч тушаалыг хүлээн авахдаа сохроор хүлээн авдаггүй билээ. Тэрээр ахмад сайтар шалгалтыг хийж, онгоцыг удирдах талаар туршлагатай тул хангалттай шалтгаан олсны үндсэн дээр ийм тушаал өгч байгаа гэдгийг сайн мэднэ. Хэрэв ингэж итгэдэггүй байсан бол ахмадынхаа тушаалыг гүйцэтгэх нь тэнэг хэрэг байхсан биз ээ. Үүний адил Бахай хүн нь Авралын Ахмадын үгийг ягштал даган мөрдөх ёстой юм. Гэвч тэрээр эхлээд ахмадад итгэж болох нотолгоо хангалттай байгаа эсэхийг шалгаж үзэлгүйгээр даган мөрдөх юм бол бас л тэнэглэсэн хэрэг болно. Ийм нотолгоог нэгэнт олж авсан хойно зарлигийг нь дагахаас татгалзвал бүр ч илүү тэнэг хэрэг болох юм. Учир нь Мэргэн эзэнд ухаалаг бөгөөд нээлттэй байдлаар захирагдсанаар бид Түүний мэргэн ухаанаас ач тус олж, өөрсдөө ч энэ мэргэн ухаанаас хувь хүртэж чадах юм. Хэрэв Ахмад үргэлж мэргэн биш байдагсан бол, хэрэв багийнх нь ямар ч гишүүн түүнд захирагддаггүй байсан бол усан онгоц яаж боомтонд хүрч чадах, далайчид яаж онгоц удирдах эрдэм суралцаж чадах билээ? Христ “хүлцэн захирагдана гэдэг бол мэдлэгийн зам юм” гэж тодорхой заасан билээ. Тэрээр ийнхүү айлджээ:

*“Миний номлол бол минийх биш, харин Түүнээс надад илгээсэн номлол юм. Аливаа хүн Түүний хүсэл зоригийг биелүүлэх юм бол уг номлол Бурханых ч байсан, Би өөрөө ч хэлж байсан түүнийг ойлгож мэднэ”. Иоан, 6. 16-17*

Бахаулла ийнхүү айлджээ:

*“Бурханы зарлиг болгосон бүхнийг болон Алдарын Бийрийн Судар номонд нээн туурвисан бүхнийг хэрэгжүүлэхээс нааш Бурханы Шүтлэг, Бурханы мэдлэгийг бүрэн ойлгох боломжгүй юм”, - “Тажаллияат”*

Ягштал хүлцэн захирагдана гэдэг бол ардчиллын энэ үед тийм ч таашаагдах зүйл биш юм. Үнэндээ ч хэн нэгэн хүний хүсэл таалалд сохроор захирагдах нь туйлын аймшигтай хэрэг болно шүү дээ. Харин хүн төрөлхтний Эв нэгдэлд бүгд нэгд нэгэнгүй Тэнгэрлэг Хүсэл таалалтай бүрэн уялдан зохицсоноор хүрч чадах билээ. Тэрхүү хүсэл тааллыг бүрэн нээн тодруулж, хүмүүс бусад тэргүүтнээс татгалзаж, гагцхүү Тэнгэрлэг Элчид захирагдахаас нааш тэмцэл маргаан үргэлжилсээр байх агаад хүмүүс бие биеэ эсэргүүцэн дайтах явдал үргэлжлэх болно. Тэд хамтын уялдаатайгаар хамтдаа Бурханы Алдар ба нийтийн сайн сайхны төлөө ажиллахын оронд өөрсдийн ихэнх хүч чадлыг бусад ахан дүүсээ хорлохын төлөө зарцуулсаар байх болно.

### Үйлчлэн зүтгэхүй

Бурханд сүсэглэн үйлчилнэ гэдэг нь бусад хүмүүсийн тусын тулд үйлчлэхийг бас хэлнэ. Бид Бурханд үүнээс өөр замаар үйлчлэх боломжгүй. Хэрэв бид өөрсдийн нэгэн адил ахан дүүсээсээ нүүрээ буруулах юм бол энэ нь Бурханаас нүүрээ буруулсантай адил болно. Христ айлдахдаа: *“Чи үүнийг Миний ахан дүүсийн хэнийх нь ч төлөө хийгээгүй тул Миний төлөө хийгээгүйтэй адил”* гэсэн билээ.

Түүнчлэн Бахаулла ингэж айлджээ:

*“Аяа, Хүмүүний үр! Хэрэв чиний мэлмий энэрэл нигүүлслийн зүгт чиглэсэн бол өөрт тань ач тус болох зүйлсийг орхиж, хүн төрөлхтөнд ач тус болох зүйлст хандагтун. Хэрэв чиний мэлмий шударга ёсны зүгт хандах аваас өөртөө сонгох байсан зүйлийг хөрш анддаа сонсгогтун”.* - “Диваажингийн Үгс”

Абдул-Баха хэлсэн нь:

*“Бахайн Үйл хэрэгт аливаа урлаг, шинжлэх ухаан болон гар урлалын ажил мэргэжлийг мөргөн сүсэглэх үйлтэй эн тэнцүү үзнэ. Жишээлбэл, ширхэг цаасыг чадах чинээгээрээ өө сэвгүй хийхийн тулд нямбайлан, сэтгэл гарган хөдөлмөрлөж байгаа хүн Бурханд талархал өргөн буйтай адил юм. Товчоор хэлбэл, чин сэтгэлийнхээ гүнээс хүмүүн төрөлхтний тусын тулд гэсэн*



*сэтгэлээр гаргасан аливаа хичээл зүтгэл бол мөргөлийн үйлс мөн. Хүн төрөлхтөнд үйлчилж, хүн ардын хэрэгцээг хангана гэдэг бол мөргөлийн үйл юм. Буян үйлдэж, үйлчлэх нь мөргөл. Өвчтэй хүнд эелдэг зөөлөн хандаж, ямар ч ялгаварлан гадуурхах үзэл санааг үл агуулан; хүн төрөлхтний эв санааны нэгдэлд итгэсэн сэтгэлээр түүнийг эмчилж байгаа хүн бол Бурханд талархал өргөж буйн жишээ юм.” “Парист айлдсан айлдварууд”, х. 109-110*

### Сургаалыг зааж сургахуй

Жинхэнэ Бахай хүн бол Бахаулагийн сургаалд зөвхөн итгээд зогсохгүй мөн уг сургаал дотроос бүхий л амьдралдаа авч хэрэгжүүлэх удирдамж зөвлөгөөг олж авах бөгөөд өөрийнх нь хувьд ундарга булаг болсон тэрхүү мэдлэгээ бусад хүмүүстэй баяр баясгалантайгаар хуваалцах болно. Гагцхүү ингэж хуваалцсанаар тэрээр “Сүнсний хүч чадал ба буян ивээл”-ийг бүрэн дүүрэн хүртэж чадах билээ. Хүмүүс бүгдээрээ уран илтгэгч эсвэл чадварлаг зохиолч болж чадахгүй нь мэдээж, гэхдээ бүгдээрээ “Өөрсдийн амьдралын бодит жишээгээр бусдад сургаалыг зааж сургаж чадах юм.

Бахаулла ийнхүү айлдсан байна:

*“Бахай хүмүүс Эзэн тэнгэртээ ухаалаг мэргэн байдлаар үйлчлэн зүтгэж, бусдад өөрсдийн амьдралын жишээгээр зааж сурга, өөрсдийн ажил үйлсээр Бурханы Гэрэл гэгээг тодруулан илэрхийлэх ёстой юм. Ажил үйлсийн нөлөө бол үнэндээ үг ярианы нөлөөнөөс хавьгүй хүчтэй билээ... Багш хүний хэлсэн үг ярианы нөлөө нь санаа бодлынх нь ариун нандин байдал ба өөрөөсөө ангижрах сэтгэлээс нь хамаарна. Зарим нь зөвхөн үг яриагаар илэрхийлээд сэтгэл хангалуун болдог, гэвч үнэн үг нь ажил үйлсээр нотлогддог бөгөөд амьдралын жишээнээс шалтгаална. Ажил үйлс нь хүний байр суурийг илтгэн харуулна. Үг яриа нь Бурханы Хүсэл тааллын Амнаас ундрэн гарч, Сургаал бичгүүдэд тэмдэглэгдсэн тэр үгтэй нийцэн дүйх ёстой” “Мэргэн ухаантны үгс”*

Бахай хүн нь гэхдээ ямар ч тохиолдолд өөрийн үзэл бодлыг сонсохыг хүсэхгүй байгаа бусад хүмүүст хүчээр тулгаж болохгүй юм. Тэрээр хүмүүсийг Бурханы Хаант улсад хүчээр түлхэж оруулах биш харин тэдний сэтгэлийг татах ёстой юм. Тэрээр сүргээ хариулж буй сайн малчин хүний адил өөрийн сүргийг нохой, шилбүүрээр биш харин дуу хөгжмийн аргаар хариулан тайтгаруулж байгаа малчинтай адил байх ёстой юм.

Бахаулла “Эрдэнийн Нуугдмал Үгс”-дээ ийнхүү айлджээ:

*“Аяа, Тоосны үр!*

*Ангаж цангалаа гэж хүн хүсээгүй цагт рашаан аягалах хэрэггүйн адил, амрагийн хайранд автлаа гэж хүн хэлээгүй цагт адгаж яаран сэтгэлээ илчлэх хэрэггүйн адил, сургаалыг чинь сонсоё гэж хүмүүн хүсээгүй цагт амаа үл нээх нь суут мэргэний чанар болой. Сэтгэл зүрхнийхээ шимтэй хөрсөнд цэцэн ухаан, эрдэм мэдлэгийн үрийг тарьж, тэнгэрлэг мэргэний лянхуа цэцэг, тоос шорооноос бус, сэтгэл зүрхний угаас бадамлан нахиалтал түүнээ нууцлан хамгаал”*

“Иорагат” Сургаал бичигтээ Тэрээр бас ингэж айлдсан байна:

*“Аяа, Бахай хүмүүс ээ! Та нар болбоос Хайрын өдөр гэгээрэн мандах газрууд, Бурханы Буян ивээлийн эх булгууд билээ. Өөрсдийн хэл яриаг хараал үгээр юм уу хэн нэгнийг гутаан доромжлох муу үгсээр бүү бузарла, өөрсдийн мэлмийг сайшаалгүй муухай зүйлсээс хамгаалагтун. Өөрт буй зүйлээ (үнэн) харуулан үзүүл. Түүнийг чинь хүлээн авбал, зоршго чинь биелэх нь тэр. Хэрэв үгүй бол үгүйсгэсэн тэр хүнтэй маргалдах нь дэмий хоосон хэрэг. Түүнийг зөнд нь орхи, харин өөрөө Хамгаалагч, Дангаар Оршигч Бурхан өөд дэвшин дэвжигтүн. Уй гашуу, цаашилаад тэмцэл маргааны уг шалтгаан эс бологтун! Та нар Тэнгэрлэг Буян хишгийн модны сүүдэрт өсөн бойжиж, Бурханы хүссэн ёсоор ажиллаасай хэмээн найдаж байна. Та нар болбоос нэг модны үр жимснүүд, нэг далайн давалгаанууд билээ”.*

## Эелдэг боловсон байдал ба хүндэтгэл

Бахаулла ийнхүү айлджээ:

*“Ая, Бурханы хүмүүс ээ! Би та бүхнийг эелдэг зөөлөн байгаасай хэмээн уриалан дуудаж байна. Эелдэг зөөлөн чанар бол үнэндээ бүхий л эрхэм нандин чанарын магнай болой. Үнэн Зөв байдлын өмсгөлөөр өөрийгөө чимж, эелдэг зөөлөн чанарын гэрлээр гийсэн тэр хүмүүн адистат болой. Эелдэг зөөлөн чанарыг (эсвэл хүндэтгэлийг) эзэмшсэн тэр хүмүүн бол агуу их байр суурийг эзэмшмой. Энэхүү хэлмэгдсэн Хүмүүн бөгөөд бусад хүмүүс энэ чанарт хүрч, түүнээс зуурч, түүнийг даган мөрдөх болтугай гэж найднам. Энэ бол Хамгаас Агуу Алдрын бийрэн дороос ундрал гарсан Няцаашигүй зарлиг бөлгөө” “Дэлхий ертөнцөд илгээсэн Илгээлт бичиг”*

Тэрээр удаа дараалан айлдсан нь:

*“Дэлхийн бүх улс үндэстнүүд баяр баясгалан, анхилуун тансаг уур амьсгалаар бие биетэйгээ эвсэн найрамдагтун. Хүмүүс ээ, “Бүх шашны сүсэгтэн нарт баяр баясгалан, анхилуун сайхан сэтгэлээр хандагтун.”*

Абдул-Баха Америкийн Бахайчуудад хандсан нэгэн захидалд ингэж хэлжээ:

*“Болгоомжлогтун! Болгоомжлогтун! Хэн нэгний зүрхийг гомдоохоос болгоомжлогтун!*

*Болгоомжлогтун! Болгоомжлогтун! Хэн нэгний сэтгэлийг сэвтүүлэхээс болгоомжлогтун!*

*Болгоомжлогтун! Болгоомжлогтун! Хэн нэгэн амьтны итгэл найдварыг хөсөрдүүлэх шалтгаан болохбоос болгоомжлогтун!*

*“Хэрэв хэн нэгэн хүн өөр хүний зүрхийг гуниглуулан гомдоох юм уу хэн нэгний сэтгэлийг шархлуулах шалтгаан нь болсон юм бол тэр хүн энэ газар дэлхий дээр алхаж явснаас газар шорооны хамгийн гүн ёроолд өөрийгөө нуусан нь хавьгүй дээр буй заа.”*

Цэцэг нахиан дотор нуугдмал байдгийн адил Бурханаас гаралтай сүнс гадна талынх нь байдал хичнээн ширүүн дориун,

муу муухай ч гэсэн хүн бүрийн зүрхэнд нуугдаастай оршдог хэмээн тэрээр зааж сургасан билээ. Жинхэнэ Бахай хүн бол тиймээс цэцэрлэгч хүн ховор үзэсгэлэнтэй ургамалтай хэрхэн харьцдаг шиг хүн бүртэй тийм л эелдэг зөөлөн байдлаар адилхан харьцана. Тэрээр өөрөө тэвчээргүйгээр хөндлөнгөөс зоролцсоноор нахиаг цэцэглүүлж чадахгүй бөгөөд гагцхүү Бурханы нарны туяа л үүнийг хийж чадалтай гэдгийг сайн мэдэх тул харанхуйлан бүдгэрсэн бүх зүрх сэтгэл, өрх айл бүрт тэрхүү Амьдрал хайрлагч нарны гэрлийг авч ирэхэд өөрийнх нь зорилго оршино гэдгийг ухаардаг юм.

Абдул-Баха дахин ингэж хэлжээ:

*“Бахауллагийн сургаал дотор өршөөнгүй хандах, дайснаа хайрлах, муу санаатан хүнд сайныг ерөөн санахыг хүнээс шаардсан нэгэн сургаал буй. Энэ нь хүн өөр хүнийг дайснаа гэж бодоод түүнтэй нийцэн, түүнийг өршөөнө гэсэн үг биш юм. Хэрэв ийм бол энэ нь жинхэнэ хайр биш дүр эсгэсэн явдал төдий л болно. Үгүй ээ, ингэхийн оронд та нар өөрсдийн дайснуудыг анд нөхдөө хэмээн харж, өөрсдөд тань муу санаж байгаа хүмүүсийг сайн санаатан хүмүүс хэмээн харж, анд нөхөдтэйгээ харьцдаг шиг тийм л байдлаар харьцах ёстой юм. Та нарын илэрхийлж буй хайр, сайхан сэтгэл тань жинхэнэ байх ёстой бөгөөд зөвхөн уучлангуй хандлага биш юм. Учир нь, уучлангуй хандлагыг зүрх сэтгэлдээ шингээгээгүй бол энэ нь зүгээр л нэг дүр эсгэсэн хэрэг болно.” “Өрнөдийн Од”, 4-р боть, X. 191*

Ийм үг нь эхлээд бодоход дотроо зөрчилтэй ч юм шиг санагдаж болох юм. Гэхдээ гадна талдаа хүн бусдыг үзэн ядагч, муу санаатан хүн байж болно, гэсэн ч хүн бүрийн дотоод оюун санааны мөн чанарт, өөрөөр хэлбэл, өөрийнх нь жинхэнэ мөн чанарт гагцхүү хайр, сайн санаа оршдог гэдгийг бид ухаарна. Тийм учраас бид бүхэн хөрш анд нартайгаа харьцахдаа тэдний дотоод мөн чанар луу нь өөрсдийн сайн сайхан бодол, хайр ивээлийг хандуулах ёстой юм. Дотоод мөн чанарыг нь сэргээн амьдруулж чадвал тэр хүний гаднах төрх нь ч хувьсан өөрчлөгдөж, цоо шинэ болно.

## Нүглийг далдлагч нүд

Бахайн сургаалд бусдын дутагдлыг нь голчлон харах явдлыг хатуу хориглосон байдаг юм. Христ ч мөн адил үүнийг хатуу цээрлэсэн байдаг. Гэвч эдүгээ Уулан дээрх Айлдварыг “Төгс төгөлдөрийн Зөвлөгөө” гэж нэрлэн, эгэл жирийн Христчүүд энэ түвшинд хэзээ ч хүрч чадахгүй гэсэн ойлголт түгээмэл болсон юм. Бахаулла, Абдул-Баха нар энэ асуудлаар Өөрсдийн нь айлдвар бодитоор хэрэгжих ёстой гэж ойлгуулдаг. “*Эрдэнийн Нуугдмал Үгс*”-т ингэж бичсэн байдгийг бид уншина:

*“Аяа, Хүмүүний үр!*

*Өөрөө чи нүгэлтэн болбоос бусдын нүглийг бүү уудал. Энэхүү лүндэнг чи зөрчих аваас цээрлэгдэнэ гэдгийг Би гэрчилнэ.”*

*“Аяа, Ахуйи үр!*

*Өөрөө өөртөө хүсэшгүй ялыг бусдад бүү тох, хийгээгүйгээ хийсэн гэж бүү сайрх. Чамд хэлэх Миний лүндэн энэ болой, дагагтун!”*

Абдул-Баха бидэнд ингэж хэлжээ:

*“Бусдын алдаа дутагдлын талаар дуугүй байж, тэдний төлөө мөргөн залбирч, дутагдлаа засахад нь тэдэнд сайхан сэтгэлээр тусла.”*

*“Ямагт муу талыг биш сайн талыг харж байх. Хэрэв хүн арван сайн чанар, нэг муу чанартай бол арван сайн чанарыг нь харж, нэг мууг нь март. Хэрэв хүн арван муу чанар, нэг сайн чанартай бол нэг сайн чанарыг нь харж, арван мууг нь март.*

*“Бидний дайсан байсан ч өөр хүний тухай ганц ч болтугай эелдэг бус үг хэлэхийг өөрсдөдөө бүү зөвшөөр.”*

Нэгэн америк нөхөрт хандан Тэрээр ингэж бичсэн байна:

*“Хүний хамгийн адгийн чанар бөгөөд хамгийн муухай нүгэл болбоос бусдыг муучлан ярих, ялангуяа Бурханы сүсэгтнүүдийн амнаас ийм муу яриа гарах явдал юм. Хэрэв хов жиг ярианы үүд хаалгыг мөнхөд хаах ямар нэг арга зам байдагсан бол Бурханы сүсэгтнүүд нэгд нэгэнгүй бусдыг сайшаан магтахын тулд амаа нээдэг болох агаад ингэсэн цагт Ариун Гэгээн Бахауллагийн*

*сургаал түгэн дэлгэрч, хүмүүсийн зүрх сэтгэл гэгээрч, оюун санаа нь сэргэн мандаж, хүний ертөнц үүрдийн жаргалаа олох байсан билээ.* "Өрнөдийн Од", 4-р боть, х. 192

### **Даруу төлөв байдал**

Бид бусдын алдаа дутагдлыг үл анзааран, харин тэдний сайн сайхан чанаруудыг олж харахын зэрэгцээ нөгөө талаас өөрсдийн дутагдлыг олж харан, өөрсдийн сайхан чанарыг анзаарахгүй байх хэрэгтэй гэж Бахаулла зааж сургасан билээ. Бахаулла "Эрдэнийн Нуугдмал Үгс"-тээ ийнхүү айлдсан юм:

*"Ая, Ахуйн үр!*

*Өөрийнхөө алдас нүглийг умартаж, бусдын алдас нүглээр завгүй хөөцөлдөж болно гэж үү? Тиймийг цээрлүүлмү."*

*"Ая, Цагаачлагчид!*

*Намайг дурсаж байхын тулд хэл чамд заяасан. Түүгээр гүтгэлэг чалчиж бүү бузарла. Хэрэв Хар амиа бодохын гал чамайг эзэмдвэл бусдын бус өөрийн нүглийг сана. Та нарын хэн нь ч гэсэн өөрсдийгөө бусдаас илүү мэдэх буюу."*

Абдул-Баха хэлсэн нь:

*"Амьдрал тань Христийн Хаант улсын илэрхийлэл болтугай. Тэрээр захирагдах гэж ирээгүй, харин захирах гэж ирсэн бөлгөө... Бахауллагийн шашинд бүх хүмүүс болбоос шадар зарц нар, шадар шивэгчин нар, ах эгч дүү нар билээ. Хэн нэг нь өөрийгөө бусдаас жаахан илүү, бусдаас давуу гэж бодох юм бол өөрийгөө аюултай байдалд оруулж байгаа хэрэг бөгөөд ийм үл бүтэх бодлын үрийг өөрөөсөө зайлуулахаас нааш тэрээр Бурханы Хаант улсад үйлчлэх зэмсэг болж чадахгүй юм."*

*Өөрийгөө чамлах явдал бол хөгжил дэвшлийн шинж тэмдэг. Өөртөө сэтгэл хангалуун явдаг хүн бол Ад шулмын илэрийлэл, харин өөртөө сэтгэл хангалуун бус явдаг хүн бол энэрлийн шинж тэмдэг юм. Хэрэв хүнд мянган сайхан чанар байдаг бол тэрээр түүнээ харах ёсгүй. Харин өөрийн дутагдал, төгс төгөлдөр бус чанараа олж харах ёстой... Гэхдээ хүн хичнээн*



ч их хөгжин дэвшлээ ч тэрээр төгс төгөлдөр бус хэвээр байх агаад түүний өмнө ямагт зорин тэмүүлэх цэг байдаг. Тэр цэгийг олж харангуутаа тэрээр өөрийнхөө өнөөгийн нөхцөл байдалд сэтгэл хангалуун байхаа больж, тэр зорилгод хүрэхийг эрмэлзэн тэмүүлдэг. Өөрийгөө сайшаан магтах нь хувиа хичээх зангийн шрэл юм.” “Мирза Ахмад Сохрабын өдрийн тэмдэглэл”, 1914 он

Бид өөрсдийн алдас нүглийг олж харах, тэдгээрээс ангижрахыг чин сэтгэлээсээ тэмүүлэх ёстой боловч лам санваартан нарт болон бусад хүмүүст нүглээ наминчлах нь хориотой юм. “Баярт мэдээ” сургаалдаа Бахаулла ингэж айлджээ:

“Нүгэл үйлдсэн хүн Бурханаас өөр бусад бүхнээс зурх сэтгэлээ чөлөөлөөд ганцхан Бурханаас өршөөл гуйх ёстой. Шадар зарц нарын өмнө (хүмүүсийн өмнө) нүглээ наминчлах нь хориотой бөлгөө. Учир нь, энэ бол Тэнгэрлэг Өршөөлийн үйл хэргийг гүйцэлдүүлэх арга зам биш юм. Хүмүүсийн өмнө нүглээ наминчлах нь хүнийг гутаан доромжлох хэрэгт хотлох бөгөөд Бурхан болбоос (Түүний Алдар бадартугай!) Өөрийн шадар зарц нарыг доромжлогдоосой гэж хүсдэггүй юм. Үнэнхүү Тэрээр Энэрэнгүй, Буянт билээ. Нүгэл үйлдсэн хүн өөрийн болон Бурханы хооронд Энэрлийн далайгаас өршөөл гуйж, Өршөөлийн Тэнгэрээс уучлалт хүсэх ёстой юм.”

### Үнэнч шударга зан

“Таразат” сургаалдаа Бахаулла ингэж айлдсан байна:

“Үнэнхүү шударга үнэнч зан болбоос бүхий л дэлхий ертөнцөд энх амгалан авчрах үүд хаалга, Энэрэлт Бурханы ахуйн гоо жавхлангийн шинж тэмдэг юм. Үүнийг хүртсэн хэн боловч эд баялаг, тансаг чинээлэгт хүрсэн бөлгөө. Шударга үнэнч зан бол хүн төрөлхтний аюулгүй тайван амьдралд хүрэх агуу том үүд болой. Аливаа ажил хэргийн амжилт нь шударга үнэнч явдлаас шалтгаална, алдар гавъяа, нэр төр, эд баялгийн ертөнцүүд шударга үнэнч чанарын гэрэлд гийж байдаг юм...”

“Аяа, Бахай хүмүүс ээ! Шударга үнэнч чанар бол та нарын биенд тохирох хамгийн шилдэг өмсгөл бөгөөд та нарын тэргүүнд

нийцэх хамгийн гайхамшигт титэм бөлгөө. Тиймээс Хамгаас хүчирхэг Зарлиг буулгагч Бурханы Лүндэнг даган мөрдөцгөө. ”

Тэрээр дахин айлдсан нь:

“Сүсэг бишрэлийн зарчим бол үг яриагаа багасган, ажил үйлсээ ихэсгэхэд оршино. Үг яриа нь ажил үйлсээсээ ихэдсэн тэр хүний үл оршихуй нь оршихуйгаас нь дээр бөгөөд үхэл нь амьдралаас нь дээр гэдгийг мэдтүгэй. ” “Мэргэн ухаантны үгс”

Абдул-Баха хэлэхдээ:

“Үнэнч шударга зан чанар бол хүн төрөлхтний бүхий л эрхэм нандин чанарын үндэс суурь болой. Үнэнч шударга зан чанаргүйгээр бүхий л ертөнцөд хүний оюун санааны хөгжил дэвшил, амжилт бүтээл нь боломжгүй болно. Энэхүү ариун шинж чанарыг хүн эзэмшиж чадсан бол бусад бүх тэнгэрлэг чанарыг ч хэрэгжүүлж чадна” “Абдул-Бахагийн Сургаал бичгүүд”, 2-р боть, х. 459

“Үнэнч ба шударга зан чанарын гэрэл гэгээ та нарын дүр царайнаас цацарч, улмаар бүх хүмүүс ажлын болон зугаа цэнгэлийн үедээ хэлсэн үг тань итгэн найдаж болох үг гэдгийг мэдэх болно. Өөрийгөө умартаж, бүх нийтийн төлөө ажиллагтун.” (Лондонгийн Бахайчуудад хандаж хэлсэн үг, 1911 оны 10 дугаар сар) гэжээ.

## Өөрийгөө хөгжүүлэхүй

Бахаулла хүмүүст байнга сургахдаа, өөрсдийн дотор буй төгс төгөлдөр чанарыг нээн хөгжүүлж, жинхэнэ хүний хувьд ихэнхдээ шорон болдог гаднах хязгаарлагдмал төрхөөс ялгаатай дотоод жинхэнэ мөн чанараа бүрэн дүүрэн илэрхийлэх ёстой гэж айлддаг. “Эрдэнийн Нуугдмал Үгс”- тээ Тэрээр айлдсан нь:

“Аяа, Ахуйн үр!

Хүчин төгс мутраараа Би чамайг бүтээж, чадал төгс уран хуруугаараа чамайг барьж, Өөрийн гэрэл гэгээний бодгаль чанарыг чамд шингээсэн. Миний бүтээл төгс бүрдэж, Миний айлдвар заавал биелэхийн учир чи түүнд сэтгэл хангалуун бай, өөрийг бүү эрж хай. Үүнтэй бүү маргалд, бүү эргэлз. ”

“Аяа, Оюун санааны үр!

Би чамайг баян болгож бүтээсэн, юунд чи өөрийгөө ядуу болгоно вэ? Би чамайг гайхамшигт болгож бүтээсэн, юунд чи өөрийгөө гутаана вэ? Эрдэм мэдлэгийн мөн чанараар Би чамайг

буй болгосон, юунд чи Надаас өөр бусдаас гэгээрлийг эрнэ вэ? Хайр сэтгэлийн зуурмагаар Би чамайг цогцлуулсан, юунд чи бусадтай зууралдана вэ? Чи өөрийнхөө дотрыг өнгийн хар, тэгвээс агуу чадал бүрдэж, хотол төгссөн Намайг өөрийн дотор олж үзэх болно.”

“Аяа, Миний зарц!

Чи болбоос хашир хүний нүдээр ч үнэ цэнэ нь үл мэдэгдэх харанхуй хуйн дотроо хатаагдсан илд мэт. Зөвхөн өөрийгөө гэсэн санаа, дур хүслийн хуйнаасаа сугармагц хурц гэрэл мэт гялалзаж гайхамшигт үнэ цэнээ газар дэлхийд тунхагла.”

“Аяа, Миний анд нөхөр!

Чи болбоос Миний Ариуслын тэнгэрт гийсэн Өдрийн од, тиймээс газрын сүүдэрт дайруулж, гэрлээ бүү алд. Үүлэн чанадаас гялалзан гарч, амьдрал чимэглэх бүхнийг бэлэглэхийн тулд хайхрамжгүй зангийн нөмрөгөө хуу тат.”

Бахауллагийн Өөрийн дагалдагч нарт мөрдөхийг уриалж байгаа энэ амьдрал бол үнэнхүү буянтай амьдрал бөгөөд хүний боломж бололцооны өргөн хүрээнд үүнээс илүү эрхэм дээд, илүү гоо үзэсгэлэнтэй зүйл үгүй билээ. Өөрсдийн дотор буй оюун санааны дотоод мөн чанараа нээн хөгжүүлэх нь бид бүхэн Бурханаас төрсөн, Бурханд л эргэн очно гэсэн тэнгэрлэг үнэнийг ухамсарлан ойлгоно гэсэн үг юм. Бурханд эргэн очих нь Бахай хүний гайхамшигт зорилт бөгөөд энэ зорилтыг биелүүлэх цорын ганц зам бол Бурханаас сонгогдсон Элч нарт, ялангуяа бидний амьдарч буй энэ эрин үед илгээгдсэн Түүний Элч болох Шинэ Эрин үеийн Зөнч мэргэн Бахауллад хүлцэн захирагдах зам юм.

## Зургадугаар бүлэг

### МӨРГӨЛ

*"Мөргөл бол хүн бүрийг Тэнгэрт хүргэх шат юм." - Мухаммед*

#### **Бурхантай харилцах яриа**

*"Мөргөл бол Бурхантай харилцах яриа юм."* гэж Абдул-Баха хэлсэн юм. Бурхан Өөрийн санаа бодол, хүсэл тааллыг хүмүүст мэдүүлэхийг хүсэхдээ тэдэнтэй тэдний ойлгох хэлээр нь ярилцдаг бөгөөд ингэж ярилцахдаа Өөрийн ариун Зөнч мэргэдийнхээ амаар ярилцдаг юм. Эдгээр Зөнч мэргэд амьд сэрүүн байх үедээ хүмүүстэй нүүр тулан ярилцаж, тэдэнд Бурханы Илгээлтийг дамжуулан өгдөг бол тэнгэрт хальсны нь дараа сургаал нь домог тууль, тэмдэглэгдсэн судар бичгүүдээр дамжин хүмүүсийн оюун ухаанд хүрдэг. Гэвч энэ нь Бурхан хүмүүстэй ярилцах цорын ганц зам биш юм. "Сүнсний хэл" гэж байдаг агаад энэ хэл нь аливаа хэл бичгээс ангид бөгөөд үүгээр дамжуулан Бурхан хаана ч байсан, ямар ч үндэстний хэлээр ярьдаг байсан хамаагүй, үнэнийг эрэн хайж буй хүмүүсийн зүрх сэтгэлтэй харилцаж, тэднийг урамшуулан тэтгэдэг юм. Энэ хэлээр Бурханы Тодруулагч биет ертөнцөөс хальсныхаа дараа үнэнч сүсэгтнүүдтэйгээ харилцсан хэвээр байдаг билээ. Христ цовдлогдсоныхоо дараа ч өөрийн хутагт шавь нартайгаа ярилцаж, тэдэнд урам хайрлаж байсан гэдэг. Түүгээр ч үл барам, Тэрээр урьд өмнөхөөс ч илүү тэдэнд нөлөөлж байсан байна. Бусад Зөнч мэргэдийн хувьд ч энэ нь адил байв. Абдул-Баха энэхүү сүнсний хэлийн тухай ихийг айлдсан байдаг. Жишээлбэл:

*"Бид тэнгэрийн хэлээр, өөрөөр хэлбэл, сүнсний хэлээр ярих хэрэгтэй. Учир нь, сүнс ба зүрх сэтгэлийн хэл гэж бий. Бидний хэл элдэв янзын авиа, хашигираанаар өөрсдийгөө илэрхийлдэг адгуусан амьтны хэлээс өөр байдаг шиг энэ хэл бидний хэлээс өөр юм.*

*"Энэ бол Бурхантай ярилцах сүнсний хэл. Мөргөн залбирч байхдаа бид гадаад юмсаас өөрсдийгөө чөлөөлж, Бурхан луу*

ханддаг. Тэр үед бидний зүрх сэтгэл Бурханы дуу хоолойг сонсох шиг болдог. Үзгүйгээр бид Бурхантай харилцан ярьж, хариултыг нь сонсдог... Бид бүхэн жинхэнэ оюун санааны түвшинд хүрсэн цагт Бурханы Дуу хоолойг сонсох чадвартай болно.” (Этель Ж.Розенбергшн тэмдэглэлээс) :

Оюун санааны эрхэм дээд үнэнийг зөвхөн энэхүү сүнсний хэлээр л дамжуулан илэрхийлж болно гэж Бахаулла айлдсан билээ. Үүнд хэл бичгийн хэл үл нийцнэ гэсэн үг. “Долоон хөндий” хэмээх жижиг номондоо Бахаулла газар дэлхийн гэр орноосоо тэнгэрлэг гэр орон луугаа аялж буй нэгэн аянчны аяллын илүү дэвшингүй үе шатуудыг дүрслэн бичихдээ:

“Эдгээрийн талаар дүрслэн тайлбарлах гэвэл хүний хэл ярианы чадал хүрэхгүй агаад үг яриа хэтэрхий хүч мөхөс болно. Үзэг бийр ч энэ асуудал дээр ямар ч хэрэгцээгүй байх ба бэх ч бөөн хар зүйлээс өөр ямар ч үр дүн өгөхгүй... Гагцхүү зүрх сэтгэл л өөрийн мэдээж байгаа зүйлийг өөр зүрх сэтгэлд дамжуулан илэрхийлж чадна. Ийнхүү дамжуулах нь Элчийн үүрэг биш бөгөөд захидал бичигт ч агуулах боломжгүй юм” гэсэн байна.

### Сүсэглэн бишрэх хандлага

Бурхантай харилцах тийм оюун санааны түвшинд хүрэхийн тулд яах ёстойг Абдул-Баха ийнхүү тайлбарлажээ:

“Бид тэр нөхцөлд хүрэхийн тулд бүх л зүйлээс ба дэлхийн хүмүүсээс хөндийрөн тасарч, ганцхан Бурханд л хандах ёстой юм. Тийм нөхцөлд хүрэхэд хүнээс хичээл зүтгэл шаардагдах бөгөөд тэрээр түүнд хүрэхийн төлөө ажиллаж, тэмцэх ёстой юм. Бид тийм түвшинд хүрэхийн тулд материаллаг зүйлсийн талаар бага бодон хайхарч, харин оюун санааны зүйлсийн талаар илүү анхаарах ёстой. Нэгнээс холдох тусам нөгөөд нь бид илүү ойртоно. Сонголт хийх эрх биднийх.

“Бид оюун санааны мэдрэмж, дотоод мэлмийгээ нээж, улмаар юм бүхэнд Бурханы сүнсний шинж тэмдэг, үл мөрийг олж харах хэрэгтэй. Юм бүхэн бидэнд Сүнсний гэрэл гэгээг тусган өгч чадна”. (Этель Ж.Розенбергийн тэмдэглэлээс)

Бахаулла бичсэн нь:

*“Тэрхүү эрэлч... өдөр бүр үүрийн туяанаар... Бурхантай харилцаж, бүх л сэтгэл зүрхээрээ Хайртыгаа эрэх эрэлдээ хатуу тууштай байх ёстой. Тэрээр Бурханыг дурсах хайрын дөлөөрөө элдэв нүгэлт бодлоо унтраах... ёстой” “Бахауллагийн Сургаалын Дээжис”, СХХУ*

Үүний нэгэн адил Абдул-Баха ийнхүү хэлсэн байна:

*“Хүний оюун санаа түүний сэтгэл санаагаар дамжинухамсрыг нь гэрэлтүүлснээр хүн амьд бүхнийг өөртөө агуулах болдог... Гэвч нөгөө талаас хүн зүрх сэтгэл, оюун ухаанаа Тэнгэрлэг адис ивээлд нээлгүй, харин сэтгэл санаагаа өөрийн материаллаг тал уруу хандуулваас, бие махбодын шинж чанарууд нь давамгайлж, хүн дээд түвшнээсээ адгуусан амьтны доод түвшинд хальтран унана” “Парист айлдсан айлдварууд”, х. 56*

Бахаулла бас ингэж бичжээ:

*“Хэлэгтүн: Аяа, хүмүүс ээ, “би” үзлийнхээ хүлээснээс сэтгэл зүрхээ чөлөөлж, түүнээ Надаас өөр бусад бүхний уяаснаас ариусга. Намайг санан дурсах явдал нь бүх бузар бургтийг ариутгадаг гэдгийг мэдсүгэй... Шадар зарц минь, өөрийн олж авсан Бурханы шүлэг найргийг Түүнд ойр дотно бологсдын нэгэн адил эгшиглүүлж, чихэнд чимэгтэй аялгуу өөрийн чинь болон хүн бүхний сэтгэлийг уяруулан хайлуулаг. Бурханаас туурвисан шүлэг найргийг хэн тийнхүү өөрийн гэр оронд ганцаар давтан уншваас Хамгаас хүчтэн Бурханы сахиусан тэнгэрүүд тэр хүний амнаас гарсан үгсийн ариун эгшигийн дээгүүр тойрон ниснэ...” Бахауллагийн Сургаалын Дээжис”, СХХХҮИ*

### **Зуучлагч байхын шаардлага**

Абдул-Бахагийн айлдсанаар:

*“Газар дэлхийн агаар мандал нарны илч туяаг хүлээн авч цааш нь түгээн цацдагийн адил Тэнгэрлэг Сүр Жавхлангийн гэрэл гэгээг бүрэн дүүрэн хүлээн авч, түүнийг хүмүүний ертөнц даяар түгээн цацах Зуучлагч хүн ба Бүтээгч хоёрын хооронд байх шаардлагатай.” “Тэнгэрлэг гүн ухаан”*



“Хэрэв бид мөргөхийг хүсвэл ямар нэгэн зүйл дээр анхаарлаа төвлөрүүлэх ёстой. Хэрэв бид Бурханд хандах юм бол зурх сэтгэлээ тодорхой нэгэн төв рүү хандуулах шаардлагатай. Хүн Тодруулагчаар бус өөр аль нэгэн зүйлээр дамжуулан Бурханыг шүтэн бишрэх юм бол эхлээд Бурханы тухай ямар нэгэн дүр зургийг төсөөлөн бий болгодог бөгөөд тэр дүр зураг нь түүний бодол санаанаас урган бий болдог юм. Хязгаарлагдмал зүйл нь Хязгааргүй зүйлээ ойлгон таних чадваргүйн адил Бурханыг ийм замаар танин мэдэх боломжгүй юм. Хүн гагцхүү өөрийн оюун ухаанаар төсөөлж чадах зүйлээ л танин мэдэж чадна. Түүний танин мэдэж чадахгүй байгаа зүйл нь Бурхан биш юм. Бурханы тухай өөртөө бүтээсэн тэр ойлголт, дүр зураг нь ердөө хий төсөөлөл, зэрэглээ, хоосон үзэгдэл юм. Ийм ойлголт болон Эрхэм Дээд Ахуйн хооронд ямар ч холбоо үгүй.

“Хэрэв бид Бурханыг таньж мэдэхийг хүсвээс Түүнийг Христ юм уу Бахаулла зэрэг төгс төгөлдөр толинд олж харах ёстой. Энэ хоёр толины алинд нь ч тэрээр Тэнгэрлэг Наран туссан байхыг олж харна.

“Ертөнцийн нарыг бид түүний гоо жавхлан, гэрэл гэгээ, илч дулаанаар нь таньж мэддэг шиг Тодруулагчийн биенээс гэрэлтэн гийж байгаа Оюун Санааны Наран болох Бурханыг бид Түүний төгс төгөлдөр шинж чанар, гоо төгс үзэсгэлэн болоод гэрэл гэгээнийх нь сүр жавхлангаар таньж мэднэ.” (1909 Акка хотод Перси Вудкоктой ярилцсан ярианаас)

Абдул-Баха бас нэгэн тохиолдолд ингэж хэлжээ:

“Ариун Сүнс зуучлагч болохгүйгээр хүн Бурханы буян хишигийг шууд хүртэн авах боломжгүй. Мэдээжийн үнэнийг бүү үгүйсгэ. Учир нь багшгүйгээр хүүхэд эрдэм номд суралцаж болдоггүй нь ойлгомжтой бөгөөд эрдэм мэдлэг гэдэг бол Бурханы буян хишигийн нэг юм. Үүлэн дундаас хур бороо унахгүй бол хөрсөнд өвс ургамал ургаж чадахгүй. Тиймээс үүл нь тэнгэрлэг буян хишиг болон хөрс хоёрыг хооронд нь холбон өгч байгаа зуучлагч юм.... Хэрэв хүн гэрлийг эрэн хайхыг хүсвээс гэрэл гэгээ нь голч төвтэй бөгөөд тэр төвгүйгээр хүн хэзээ ч гэрэл гэгээг олж харахгүй юм... Христийн амьдарч байсан цаг үе рүү анхаарлаа хандуулагтун. Зарим хүмүүс

*Мессиягийн сургаалгүйгээр үнэнд хүрч болно гэж эндүүрч байсан билээ. Энэ эндүүрэл нь тэдний гачигдал дутагдлын эх үүсвэр болсон юм.* ” “Абдул-Бахагийн Илгээлт бичгүүд “, 3-р боть, х. 591, 592

Бурханы Тодруулагчид хандалгүйгээр Бурханыг бишрэн шүтэх гэж оролдож байгаа хүн газар доорх нүхэнд байгаа хүн өөрийн төсөөллөөр нарны гэрлийн сайхныг бишрэх гэж оролдож байгаатай адил юм.

### **Мөргөл үйлдэх нь зайлшгүй хийх ёстой үйл мөн**

Бахайчууд тодорхой нөхцөлтэйгээр мөргөл үйлдэх үүрэгтэй билээ. “*Китаб-и-Акдас*”-г Бахаулла ингэж айлдсан байна:

*“Бурханы шүлэг найргийг өглөө бүр, орой бүр өргөн дуулагтун. Тийнхүү дуулж буй хэн бүхэн Бурханы Тунхаглал, Түүний Гэрээслэлд үнэнчээ нотолсон амлалтаа хэрэгжүүлэхээс буцаагүй бөгөөд харин түүнээс замаа буруулсан хэн боловч Бурханаас нүүр буруулсан хэрэг мөн. Бурханаас эмээгтүн, аяа, хүмүүс ээ!*

*Өдөр шөнөгүй (армун Сургаалаас) хэт их унших ба хэт их ажил хийх чинь чамайг бардам занд бүү хүргээсэй. Ганц ч болов сургаал үгийг баяр баясгалан, цог бадрангүй дуулан унших нь Хүчирхэг Бурханы бүх Ном сургаалыг хайнга байдлаар уншихаас дээр. Бурханы Бичиг найргийг ядарч уйдаахгүй байх тийм өндөр урамтайгаар дуулан дууд. Сэтгэлээ цуцааж залхаалгүй, харин түүнийгээ сэргээн баясгагтун. Чингэснээр сэтгэл тань Үүдэл нээлтийн мэдлэгээр жигүүрлэн үнэн нотолгооны Үүрийн Цолмон гээгээрх газраар нисэн дүүлэх болмой. Энэ нь чамайг Бурханд ойртуулна гэдгийг анхаарагтун.”*

Абдул-Баха захидлаар харилцаж байсан нэгэн хүнд хэлэхдээ:

*“Аяа, оюун санааны анд нөхөр минь! Мөргөл бол шаардлагатай бөгөөд зайлшгүй үйлдэх ёстой үйл мөн гэдгийг мэдтүгэй. Хүн сэтгэцийн хувьд тахир дутуу, эсвэл ямар нэгэн давж гаршгүй их саад учирсан л биш бол ямар ч нөхцөлд энэ үүргээ орхигдуулах ёсгүй юм” гэжээ.* (“Абдул-Бахагийн Илгээлт бичгүүд”, 3-р боть, Х. 683)

Бас нэгэн хүн Түүнээс “Яагаад мөргөх ёстой юм бэ? Учир нь юунд байна вэ, Бурхан юм бүхнийг бүтээгээд бүх л ажил хэргийг хамгийн төгс замаар хэрэгжүүлдэг, тиймээс өөрийн хүслийг илэрхийлэн тусламж хүсэн залбиран гуйх ямар шаардлага байна вэ?” хэмээн асуусанд Абдул-Баха ингэж хариулсан байна:

*“Чадалгүй дорой нь Чадалтай. Нэгүеэс залбирал гуйх нь жам ёсон бөгөөд буян хишиг эрж хайж байгаа хүн Яруу алдарт буян хишигт Бурханаас гуйх ёстой гэдгийг үнэнхүү чи мэдэгтүн. Хүн Эзэн тэнгэртээ залбирч, Түүнд хандаж, Түүний тэнгис далайгаас буян хишиг эрэх аваас энэ нь тэр хүний зүрх сэтгэлд гэрэл гэгээ авчирч, мэлмийн харцанд нь гэгээрлийг бий болгож, сэтгэл санаанд нь амьдрал хайрлаж, ахуй биенд нь хөгжил дэвшил авчирдаг юм.*

*“Таны Алдар нэр болбоос намайг анагаагч” гэж Бурханд залбиран унших үедээ зүрх сэтгэл тань хэрхэн баясч, сэтгэл санаа нь Бурханы хайрын сүнсээр хэрхэн гийж, оюун бодол тань Бурханы Хаант улсад хэрхэн татагдаж байгааг анзааран ижаарай. Ингээж татагдсанаар хүний чадвар, чадавхи нь нэмэгддэг. Онгоц томорвол ус нь нэмэгддэг, ангаж цангах нь ихэсвэл хур борооны буян хишиг хүний сэтгэлд илүү их нийцдэг. Чухамдаа залбиран сүсэглэж, өөрийн хүслийг илэрхийлэн гуйхын нууц оньсого үүнд оршвой.”* (Амеркийн нэгэн сүсэгтэнд хандаж бичсэн захидлаас Али-Кули-Ханы орчуулснаар, 1908 оны 10 дугаар сар)

Бахаулла өдөр тутам заавал унших гурван мөргөлийг туурвисан билээ. Сүсэгтэн энэ гурвын аль нэгийг чөлөөтэй сонгон авч, Бахауллагийн заасан журмын дагуу унших үүрэгтэй юм.

## Нийтээр үйлдэх мөргөл

Бахауллагийн туурвисан өдөр тутам заавал унших мөргөлийг Бахайчууд ганцаар байхдаа уншдаг. Харин зөвхөн нас нөгчигсдөд зориулан унших мөргөлийг нийтээр уншиж болно гэж Тэрээр айлдсан байна. Ингэхдээ нэг сүсэгтэн хүн чангаар уншиж, бусад бүх хүмүүс зогсож байх ёстой юм. Энэ нь Исламын шашинд нийтээр мөргөл үйлддэг заншлаас өөр юм. Исламын шашинд

сүсэгтэн хүмүүс санваартан хүний ард эгнэн зогсож, санваартан мөргөлийг удирдан үйлддэг. Үүнийг Бахай Шүтлэгт хориглодог юм.

Бахаулла мэргэжлийн лам санваартан нарын эрх мэдлийг халснаар хамтдаа мөргөн сүсэглэн уулзалт цуглаанд ямар ч ач холбогдол өгөөгүй гэсэн үг биш билээ. Мөргөл уншихын тулд хамтдаа цуглахын ач холбогдлыг Абдул-Баха дараах үгээр илэрхийлжээ:

*“Би хүссэн үедээ Бурханд мөргөнө, зүрх сэтгэл маань Бурханд ойртсон тэр үедээ, аглаг хээр газар, хот сууринд, өөр хаана ч гэсэн би мөргөж болно. Тэгэхлээр би мөргөх ямар ч хүсэлгүй байтлаа бусад хүмүүсийн цугласан газар тусгай өдөр, тусгай цагт очиж, тэдэнтэй хамт мөргөлд нэгдэж яах юм бэ?”* гэж хэн нэгэн хүн хэлж болох юм.

*“Ингэж бодвол хий дэмий эндүүрэл болно. Учир нь, олон хүн цугтаа цугласан газар хүч нөлөө ч шүү байдаг. Цэргүүд ганц ганцаараа байлдах юм бол нэгдмэл нэг хүчтэй арми болж чадахгүй. Оюун санааны энэхүү дайнд бүх цэргүүд маань хамтдаа цуглаж, оюун санааныхаа хүсэл тэмүүлэлд нэгдэж, бие биедээ туслах юм бол тэдний мөргөл үнэнхүү сайшаалтай болно.”* (Этель Ж.Розенбергийн тэмдэглэлээс)

Үгээрээ Абдул-Баха мөргөл үйлдэх цуглааны ач холбогдлыг онцолж, Бурханд хамтдаа хандах аваас сүнс сэтгэл батжина гэж хэлэхдээ Бахайн мөргөлийг заавал нийтээрээ унших ёстой гэж хэзээ ч заагаагүй юм. Бахауллагийн туурвисан заавал унших мөргөлийг хувь хүн бүр өөрөө уншина. Аливаа мөргөлийг нийтээр унших нь Бахайн сургаал биш бөгөөд гэхдээ оршуулгын ёслолын үеэр унших ганц мөргөлийг л ийм байдлаар уншиж болох юм.

### **Мөргөл бол хайр сэтгэлийн хэл мөн**

Бурхан тэртээ тэргүй бүх хүмүүсийн зүрх сэтгэлийн мөрөөдлийг мэдэх тул мөргөл үйлдэж яах юм бэ гэж бодож байгаа хүнд Абдул-Баха ингэж хариу өгсөн байна:

“Хэрэв хүн найзаа хайрладаг бол хайраа илэрхийлэн хэлэх нь зүй ёсны хэрэг бус гэж үү? Найз маань өөрийг нь хайрлагдгийг минь мэднэ гээд хайраа илэрхийлэхгүй байж болно гэж үү?... Бурхан бүхний зүрх сэтгэлийг мэддэг нь үнэн боловч залбирах дотоод хүч бол байгалиас, Бурханд өгсөн хүний хайраас урган гардаг юм....

“Мөргөлийг заавал үгээр илэрхийлэх албагүй, мөн санаа бодол, хандлагаараа илэрхийлж болно. Хэрэв ийм хайр хүсэл үгүй бол хүчээр бий болгох гээд хэрэггүй. Хайр агуулаагүй үгс нь ямар ч утга илэрхийлэхгүй. Хэрэв хүн тантай ярихдаа ямар ч хайр сэтгэл, эсвэл хүсэл илэрхийлэхгүй, зүгээр л би ярих ёстой юм гэсэн үүднээс ярьж байвал та түүнтэй ярихыг хүсэх билүү?” (“Хоёр долоо хоногийн тойм” сонинд Е.С.Стивенсийн бичсэн нийтлэлээс, 1911 оны 6 дугаар сар)

Бас нэгэн яриандаа Тэрээр айлдсан нь:

“Хамгийн эрхэм ёсоор мөргөл үйлдэхдээ хүмүүс Бурханаас юм уу тамаас эмээсэндээ, эсвэл ямар нэгэн хишиг диваажинг горьдсондоо биш харин Бурханыг хайрласандаа л мөргөдөг... Хүн өөр нэгэн хүнд хайр сэтгэлтэй болоход хайртынхаа нэрийг дурсахгүй байж чадахгүй шүү дээ. Тэгвэл Бурханыг хайрласан хүн Түүний Алдарыг байнга дурсахгүй байж яаж чадах юм бэ... Буянт бурханлаг хүн Бурханыг дурсан магтахаас өөр юунд ч баяр жаргал, тайтгарлыг олохгүй” (Алма Робертсон ба бусад мөргөлчдийн бичсэн тэмдэглэлээс, 1900 оны 11-12-р сар)

### Гай гамшгаас ангижрахуй

Зөнч мэргэдийн сургаалд айлдсанаар аливаа өвчин эмгэг болон бусад гай гамшиг нь Тэнгэрлэг Зарлигийг үл биелүүлснээс болж тохиолддог. Тэр ч бүү хэл үер, шуурга, газар хөдлөлт зэрэг байгалийн гай гамшиг нь ийм л шалтгааны улмаас тохиолддог гэж Абдул-Баха шууд бус замаар илэрхийлсэн байдаг.

Гэхдээ алдас нүглийн үрээр тохиолдсон зовлон зүдгүүр нь өшөө хонзон авч буй явдал биш харин хүнийг сурган хүмүүжүүлэн анагаах зорилготой юм. Энэ бол зэвсэг замаасаа хазайлаа гэдгийг нь

хүнд ойлгуулах Бурханы дуу хоолой юм. Хэрэв учирсан зовлон нь аймшигтай их бол гэм нүглийн аюул аймшигтай их гэдгийг илтгэж байгаа хэрэг. Учир нь “нүглийн үр бол үхэл” бөлгөө.

Үл хүлцэн захирагдсаны төлөө гай гамшиг учирдгийн адил гай гамшгаас ангижрахын тулд хүлцэн захирагдах ёстой билээ. Энэ асуудлаар эргэлзэх зүйл үгүй юм. Бурханаас холдон нүүр буруулах нь гай гамшиг авчирна, харин Бурханд хандах нь адис хишиг авчрах нь дамжиггүй.

Бүхий л хүн төрөлхтөн болбоос нэг л бие махбод боловч хувь хүн бүрийн сайн сайхан байдал нь бусад хүмүүсийн зан төрхөөс биш харин гагцхүү өөрийнх нь зан төрхөөс шалтгаална. Хэрэв хэн нэгэн хүн гэм үйлдвэл бусад бүх хүмүүс их бага хэмжээнд хохирдог. Хэрэв хэн нэгэн хүн буян үйлдвэл бусад бүх хүмүүс ач тусыг нь хүргэнэ. Хүн бүр хөрш нөхрийнхөө ачааг ямар нэгэн хэмжээнд үүрэх ёстой бөгөөд хүн төрөлхтний сор болсон хүмүүс хамгийн их ачааг үүрсэн хүмүүс байдаг. Гэгээнтэн хүмүүс ямагт асар их зовлонг туулсан байдаг. Зөнч мэргэд туйлын ихээр зовж шаналсан байдаг.

*“Китаб-и-Иган”* Сударгаа Бахаулла ингэж айлдсан байдаг: *“Бурханы Зөнч мэргэн бүр ба Түүний дагалдагч нарт ноогдсон зовлон бэрхшээл, ядуурал хоосрол, өвчин эмгэг, хүнд хэцүүг та эргэлзээгүй дуулж сонссон биз ээ. Тэдний дагалдагч нарын толгойг авч бэлэг болгон бусад хот уруу илгээж байсан гэж та дуулсан байж таарна”.*

Энэ нь тэдгээр гэгээнтэн Зөнч мэргэд бусад хүмүүсийг бодвол илүү их шийтгэл хүлээх гэмтэй байсандаа биш юм. Үгүй ээ, тэд бусдын нүглийн төлөө өөрсдөө зовж, бусдын төлөө л зовж шаналахыг өөрсдөө хүссэн юм. Тэд өөрсдийн биш дэлхий ертөнцийн сайн сайхны төлөө сэтгэлээ зориулдаг байв. Хүн төрөлхтнийг жинхэнэ ёсоор хайрладаг хүн мөргөн залбирахдаа ядуу зүдүү амьдрал, өвчин эмгэг, зовлон бэрхшээлээс өөрөө ангижрахын төлөө биш харин бүх л хүн төрөлхтөн харанхуй мунхаг байдал, алдас нүгэл болон түүнээс үүдэх гай гамшгаас ангижраасай гэж мөргөнө. Хэрэв ийм хүн өөртөө эрүүл энх, эд баялгийг хүсэх бол Бурханы Хаант улсад үйлчлэн зүтгэхийн тулд



эрүүл энх, эд баялагтай байхыг хүснэ. Харин эрүүл саруул, баян чинээлэг байх боломжгүй бол тэрээр өөрийн тавиланг “Баяр баясгалантайгаар хүлээн авах” бөгөөд Бурханы Зам мөрд түүнд учрах бүхэн ямар нэгэн далдын мэргэн ухааныг агуулна гэдгийг сайн мэднэ. :

Абдул-Баха хэлэхдээ:

*“Зовлон бэрхшээл санамсаргүй зүйл биш бөгөөд тэдгээрийг хүмүүсийг боловсронгуй болгох гэж Бурхан илгээдэг амой... Харин зовж зүдрэх цагт доромжлол гутралаас ангижруулж чадах Диваажингийн Эцгээ дурсан үгүйлдэг... Хүнийг зэмлэн гэсгээх тусам оюун санааны хувьд буян нь арвиждаг”* гэсэн байна.

“Парист айлдсан айлдварууд”, х. 26

Анхандаа гэмгүй хүн нүгэлтэй хүмүүсийн төлөө зовж шаналах ёстой гэдэг нь шударга бус санагдаж болох юм. Гэвч хожмын ирээдүйд шударга ёс ноёрхох ёстой гэдгийг харуулахын тулд шударга бус байдал тодорхой харагдаж байгаа юм хэмээн Абдул-Баха батлан хэлж байна.

Тэрээр бичихдээ:

*“Дарангуйлагчдын гарт зовж шаналж буй нялх балчир үрс, сул дорой хүмүүсийн тухайд гэвэл... тэдгээр хүмүүс дараачийн ертөнцөд өөрсдийн шагналыг хүртэнэ... Зовлон бэрхшээл бол Бурханы агуу их ачлал энэрэл юм. Үнэнхүү Эзэн тэнгэрийн ачлал энэрэл энэ ертөнцийн бүх эд баялаг, тав тухтай амьдрал, зуурдын энэ орчлон дахь хөгжил өсөлтөөс илүү үнэтэй бөлгөө”* “Абдул-Бахагийн Сургаал бичгүүд”, 2-р боть, х. 337

## Мөргөл ба Байгалийн жам ёс

Зарим хүмүүсийн хувьд мөргөлийн хүч нөлөөнд итгэхэд бэрх байдаг. Яагаад гэвэл, энэ нь байгалийн хуультай харшилна гэж тэд боддог. Үүнийг тайлбарлахын тулд нэгэн зүйрлэл гаргая. Хэрэв төмрийн үртсэн дээр соронз байрлуулвал үртэс соронзонд наалдана. Энэ нь газрын татах хүчний хуультай харшлахгүй. Газрын татах хүч одоо ч гэсэн төмрийн үртсэнд үйлчилсээр байгаа. Харин газрын татах хүчний адил үйлчилгээтэй илүү

хүчтэй бодис байсан учраас ингэж тэр бодисонд тагагдахад хүрсэн байна. Бахайн үзэл бодлоор мөргөл нь дээд хүчнүүдийг тагдлаг юм. Эдгээр хүчнүүдийг харьцангуй бага судалжээ. Гэсэн ч энэ хүчнүүд нь байгалийн хүчнүүдийг бодвол үйлдэлдээ илүү чөлөөтэй гэж хэлэх шалтгаан үгүй шиг санагдана. Ялгаа нь гэвэл, оюун санааны хүчнүүдийг бүрэн дүүрэн судалж, туршилт шинжилгээ хийгээгүй учраас бидний үл мэдэх мунхаг байдлаас болж тэдгээрийн үйлдэл, илрэл нь сонин хачин мэт санагддаг.

Зарим хүмүүс бодохдоо мөргөл бол тийм ч их агуу үр дүнд хүргэж чадахгүй хүч мөхөс зүйл юм гэж эргэлздэг нь нэг хэцүү асуудал юм. Нэгэн зүйрлэл авч үзвэл асуудал арай ойлгомжтой болох байх. Усан санд байрлуулсан гоожуурын багахан хүчээр асар их усны хүчийг зохицуулан жолоодож болдог. Түүнчлэн усан онгоцны жижигхэн жолоогоор асар том хөлөг онгоцны хөдөлгөөнийг хянаж байдаг. Бахайн Шүтлэгт мөргөлийн хариуг авчирдаг тэр хүч бол Бурханы шавхагдашгүй хүч юм гэж итгэдэг. Хангагчийн үүрэг бол зөвхөн Тэнгэрлэг Буян хишгийн чиг зам, урсгалыг чөлөөлөхөд шаардлагагай тэрхүү багахан хүчийг бий болгох эсвэл өөрийг нь хэрхэн түшихийг сайн мэдэж байгаа хүмүүст хэзээд бэлхэн тэнгэрлэг буян хишгийг чиглүүлэхэд оршино.

### **Бахайн Мөргөлүүд**

Бахаулла, Абдул-Баха нар янз бүрийн тохиолдолд, янз бүрийн зорилгоор уншихад зориулсан тоо тоймшгүй олон мөргөлийг дагалдагч нартаа зориулан туурвисан билээ. Эдгээр айлдварт шингээстэй агуу үзэл санаа, гүн гүнзгий оюун санааны баялаг нь ухааран эргэцүүлэгч хүмүүн бүрийн сэтгэлийг хөндөх агаад гагцхүү тэдгээрийг өөрсдийн амьдралын онц чухал хэвшил болгон хэрэглэснээр ач холбогдлыг нь бүрэн ойлгож, хүч чадлыг нь сайтар ухаарч чадах юм. Харамсалтай нь, энэ номын маань зай бага тул зөвхөн цөөн хэдхэн богино мөргөлийг энд толилуулъя. Эдгээрээс өөр жишээнүүдийг уншигч авхай өөр номнуудаас эрж хайваас зохино.

"Бурхан минь! Өөрийн Гоо үзэсгэлэнг миний балин идээ, Өөрийн Ахуй байдлыг миний ундаа болгож хайрлаач. Миний итгэл найдвар Таны Хүсэл таалалд нийцэж, миний үйл ажиллагаа Таны Зарлиг лүндэнг даган мөрдөх болтугай. Миний буян үйлчилгээ Танд таашаагдаж, миний ажил үйлс Таны магт дуу болог. Зөвхөн Танаас тусламж эрж, миний гэр оронг зөвхөн Таны ариун Өргөө болгоход минь туслаач. Та бол Үнэт эрдэнэ, Хэзээд оришгч, Хайрлан халамжлагч билээ." - Бахаулла

"Бурхан минь ээ! Та Өөрийгөө таниулан шүтүүлэхийн төлөө намайг бүтээсэн билээ. Өчүүхэн би хүч мөхөс, үгээгүй ядуу, харин Та Хамгийг Чадагч, Хамгаас Баян билээ.

Танаас өөр Бурхан байхгүй. Та бол Зовлон зүдгүүрт нэрвэгсдийн Аврал, Эгнэгт Дангаар Оришгч нь билээ." - Бахаулла

"Бурхан минь! Бурхан минь! Өөрийн шадар зарц нарын санааг нэгтгэж, Өөрийн агуу зорилгын утга учрыг тэдэнд тайлж хайрлаач. Шадар зарц нар тань Таны зарлиг, сургаалыг чанд сахиж мөрдөх болтугай. Бурхан минь ээ! Тэдний үйл ажиллагааг дэмжиж, Таны үйл хэргийг урагшлуулах үйлсэд тэдэнд хүч тэнхээ хайрлаач.

Бурхан минь! Шадар зарц нараа бүү орхиоч. Тэдний алхаа гишгээг харин Өөрийн эрдэм мэдлэгийн гэрлээр удирдан чиглүүлж, хайр энэрлээр тэдний сэтгэл зүрхийг баясгаж хайрлана уу. Чухам Та бол тэдний Өмөг түшиг, Эзэн хаан мөн билээ." - Бахаулла

"Энэрэлт Бурхан минь! Та хүн төрөлхтнийг нэгэн сүргээр бүтээсэн билээ. Хамаг амьтан ах дүүгийн барилдлагаатай байх ёстой хэмээн Та айлдан соёрхсон билээ. Таны Ариун биеийн өмнө тэд Таны зарц бөгөөд хүн төрөлхтөн Таны цацар дор хоргодож байгаа билээ. Тансаг эд баялгаар бялхсан Таны ширээнд хамаг амьтан хуран цугларчээ. Таны ивээл хамаг амьтныг гийгүүлнэ.

Бурхан минь! Та хамаг амьтны өршөөл билээ. Та хамаг амьтныг хангагч, хамгаалагч билээ. Та хамаг амьтанд амьдрал хайрлагч билээ. Бас хүн бүрт авьяас чадвар хайрласан. Хамаг амьтан Таны Нигүүлсэнгүй сэтгэлийн далайд умбан байна.

Энэрэлт Эзэн минь! Хамаг амьтныг нэгтгэ! Бүх шашин өөр

хоорондоо зөвлөлдөж нэгдтүгэй. Улс үндэстнийг нэг нэгдмэл болгож хайрлана уу. Үүний ачаар хамаг амьтан өөрсдийгөө нэгэн гэр бүл, дэлхий ертөнцийг нэгэн гэр орон хэмээн ойлгох болно. Хамаг амьтан эгнэгт эв найртай хамтран аж төрөх болтугай.

Бурхан минь! Нэг нэгдмэл хүн төрөлхтний тугийг өндөрт өргөтүгэй.

Бурхан минь! Агуу их Амгаланг тогтоотугай.

Бурхан минь! Хамаг амьтны сэтгэл санааг нэг нэгдмэл болготугай.

Энэрэлт Эцэг Бурхан минь! Өөрийн хайр ивээлээр бидний сэтгэл санааг баясгаж хайрлана уу. Өөрийн удирдамжийн гэрлээр бидний мэлмийг гийгүүлж хайрлана уу. Өөрийн тансаг үгээр бидний сонорыг баясгаж хайрлана уу. Өөрийн бат цайзанд хорогдуул.

Та Хамгийг чадагч. Хамгаас хүчтэй билээ. Та Хамгийг Өршөөгч билээ. Та хүн төрөлхтний алдаа дутагдлыг Өршөөгч билээ." - Абдул-Баха

"Хүчирхэг Бурхан минь ээ! Би бол нүгэлтэн, харин Та бол нүглийг Өршөөгч билээ! Би бол алдаа дутагдалтай нэгэн, харин Та бол Энэрэнгүй билээ. Би алдас нүглийн харанхуйд байна, харин Та бол Өршөөл энэрлийн Гэрэл гэгээ билээ!"

Энэрэлт Бурхан минь ээ, миний нүглийг уучилж, Өөрийн хишгийг надад хүртээ. Миний алдаа дутагдлыг үл хайхарч, намайг орогнуулж, Тэсвэр тэвчээрийнхээ Оргил усанд намайг булхуулж, өвчин эмгэг бүхнээс минь анагааж хайрлана уу.

"Намайг ариусган цэвэршүүлж, ариун гэгээн буянаасаа хувь хүртээ. Чингэвээс уй гашиу, уйтгар гуниг замхран арилж, баяр баясгалан, аз жаргал намайг эзэмдэнэ. Итгэл алдран, гуньж цөхөрсөн байдлыг минь баяр хөөр, итгэл найдвар болгон хувиргаж, айдас аймшигийг эр зориг болгож хайрлана уу.

"Үнэнхүү Та болбоос Өршөөгч, Энэрэнгүй бөгөөд Та болбоос Өгөөмөр, Хамгаас Хайрт билээ!" Абдул-Баха

"Аяа, Нигүүлсэнгүй Бурхан минь!"

*Намайг сэрээж, ухааруулсанд тань Тандаа талархая. Та надад харах нүд, сонсох чих хайрлаж, намайг Өөрийн номын замд оруулан Өөрийн хаант улсад хөтлөн дагууллаа. Та надад зөв замыг зааж, Аврагчын хөлгөнд суухад минь туслалаа. Бурхан минь! Намайг туйлбартай үнэнч болгож, зориг хатуужил хайрла. Намайг хатуу ширүүн сорилтоос хамгаалж, Гэрээс зарлигийнхаа бат бөх цайзад хоргодуул. Та үнэнхүү Хүчтэн, Та бүхнийг Харагч, Та бүхнийг Сонсогч билээ. Нигүүлсэнгүй Бурхан минь ээ! Таны хайрын гэрлийг шил мэт тольдон тусгах тунгалаг сэтгэл зүрхийг надад хайрлаж, тэнгэрлэг хишгийн тань ундралаар энэ дэлхийг сарнай цэцгийн хүрээлэн болгон өөрчлөх чадалтай бодол ухааныг надад хүртээнэ үү.*

*Та бол Нигүүлсэнгүй, Энэрэнгүй билээ. Та агуу их буянт Бурхан билээ!”*

*Абдул-Баха*

Бахай Шүтлэгт мөргөл үйлдэхийг чухалд үздэг ч ямар нэгэн ёс жаяг дагахыг шаарддаггүй. Харин хүний бүхий л амьдрал мөргөлийн үйл шиг байх ёстой. Сүсэглэн бишрэх сэтгэлээр хийсэн аливаа ажил, Бурханы Алдар ба бусдын сайн сайханд зориулсан аливаа бодол, үг бөгөөд ажил үйлс нь жинхэнэ утгаараа мөргөл юм гэж Бахаулла айлдсан юм.

## Долдугаар бүлэг

# ЭРҮҮЛ МЭНД БА АНАГААХ ЁС

*“Нүүр царайгаа Бурханд хандуулах нь бие махбод, ухаан бодол, сэтгэл санааг анагаана.” - Абдул Баха*

### **Бие махбод ба сэтгэл санаа**

Хүний бие махбод бол сүнс сэтгэлийн хөгжил дэвшилд түр зуурын орогнол болж, орогнох шаардлага нь дуусахад хэрэггүй болдог гэж Бахайн сургаалд байдаг. Өндөгний хальс дэгдээхэйн хөгжилд түр зуурын ач холбогдолтой байдаг бөгөөд тэр шаардлага нь дуусахад хальж хагарч устдагтай адил юм. Хүний бие махбод бол мөнх чанаргүй бөгөөд атом молекулын нийлбэрээс бүрддэг тул аливаа нийлбэр зүйл цаг нь ирэхэд задран устдагийн адил задарч үгүй болдог.

Бие махбод бол сүнсний боол тул хэзээ ч сүнснийг захирах ёсгүй юм. Бие махбод нь хүлээцтэй, дуулгавартай бөгөөд үр ашигтай боол нь болох ёстой тул сайн зарцад хэрхэн ханддагтай адил хүний бие махбодод тэгж л хандах ёстой билээ. Бие махбодод зохих ёсоор хандахгүй бол элдэв янзын өвчин эмгэг, зовлон зүдгүүр үүрлэж, тэр нь боолд төдийгүй эзэнд нь хохирол учруулна.

### **Бүхий л амьдралын Нэгдмэл чанар**

Амьдралын үй түмэн хэлбэр, түвшин, үе шат нь угтаа нэг үндэстэй юм гэж Бахаулла сургасан билээ. Бидний биеийн эрүүл мэнд нь сэтгэцийн эрүүл мэнд, ёс суртахуун хийгээд оюун санааны эрүүл мэндтэй шууд холбоотойн сацуу хувь хүн ба нийгмийн эрүүл мэнд, түүгээр ч үл барам байгаль дэлхий дэх ан амьтан, ургамлын эрүүл мэндтэй холбоотой байдаг. Эдгээр бүх бүрэлдэхүүн хэсгүүд нь бидний төсөөлж байгаагаас ч хавьгүй илүү хэмжээгээр бие биендээ нөлөөлж байдаг.



Тийм учраас Бурханы Зөнч мэргэний зарлиг сургаалд тэр сургаал нь амьдралын аль салбартай холбогдож байгаагаас үл хамааран бие махбодын эрүүл энхтэй холбоотой зүйл зайлшгүй байдаг. Гэсэн ч тодорхой зарим сургаал нь бусдыг бодвол хүний бие махбодын эрүүл энх байдлыг шууд тайлбарласан байдаг агаад эдгээрээс одоо судалцгаая.

### Эгэл жирийн амьдрал

Абдул-Баха хэлсэн нь:

*“Эдийн засагч хандлага бол хүний элбэг хангалуун амьдралын үндэс суурь мөн. Үрэлгэн хүн ямагт зовлонд учирч явдаг. Аливаа хүн үрэлгэн байх нь уучилж болишгүй нүгэл юм. Бид шимэгч хорхой мэт бусдын хөдөлмөрөөр амьдрах ёсгүй. Хүн бүр оюуны юм уу биеийн хөдөлмөр эрхэлж цэвэр ариун хүнлэг бөгөөд шударга амьдралаар амьдрах ёстойн дээр ариун нандин чанараараа бусдад үлгэрлэх ёстой. Бусдын халааснаас гарсан мөнгөөр олон янзын тансаг амттай хоол идсэнээс өөрийн хөдөлмөрөөр олсон дан зүсэм талхаар хооллосон нь хавьгүй дээр билээ. Сэтгэл хангалуун хүний оюун бодол ямагт амгалан, зүрх сэтгэл нь тайван байдаг.”* “Бахайн судар бичмэлүүд”, х. 453

Амьтны махаар хооллох нь хориотой биш. Гэхдээ Абдул-Баха ингэж хэлсэн байдаг:

*“Ирээдүйн хоол хүнс бол жимс ногоо, тариа будаа байх болно. Мах идэхээ болих цаг ирнэ. Анагаах ухаан бол одоо дөнгөж хөгжлийнхөө нялх балчир үедээ явна. Гэсэн ч бидний хооллох хүнс бол хөрснөөс ургааж байгаа зүйлс юм гэдгийг анагаах ухаанаар нэгэнт нотолсон билээ”.* “Аккагийн гэрэлд өнгөрүүлсэн өдүүд”, Жулия М. Грунди

### Согтууруулах ундаа ба мансууруулах бодис

Өвчнийг эдгээхэд хэрэглэхээс бусад тохиолдолд хүнийг мансууруулан согтууруулах элдэв янзын бодис хэрэглэхийг Бахаулла хатуу хориглосон юм.

## Зугаа цэнгэл

Бахайн сургаал нь хэт мухар сүсэгт автах бус харин аливаад туйлшрахгүй даруу хандахыг сургадаг. Амьдралын материаллаг болон оюун санааны сайн сайхан, гоо үзэсгэлэнт зүйлсийг таашаан таалахыг урамшуулаад зогсохгүй зайлшгүй шаардлагатай гэж үздэг.

Бахаулла хэлэхдээ:

*“Чамд зориулан бүтээгдсэн тэр зүйлсээс бүү татгалз” гэсэн байдаг. Тэрээр бас дахин айлдахдаа: “Та нарын нүүр царайнд баяр цэнгэл, баяр баясал тодрон гэрэлтэх ёстой” хэмээжээ.*

Абдул-Баха ийнхүү хэлсэн юм:

*“Энэ хорвоод бүтээгдсэн бүхэн болбоос орчлонгийн титэм болсон хүмүүнд зориулагдан бий болсон болой. Тиймээс хун тэнгэрлэг хишиг ивээлд талархан өргөх ёстой. Материаллаг бүх эд баялаг бол бидэнд зориулагдсан бөгөөд бид энэ бүхэнд талархан өргөснөөр амьдрал бол тэнгэрлэг хишиг юм гэдгийг ухаарч сурна. Хэрэв бид амьдралыг жигших юм бол талархан баярлахгүй байна гэсэн үг. Оюун санааны оршин тогтнол болбоос тэнгэрлэг энэрэл хишигийн гадна талын шинэж тэмдэг юм. Тийм учраас бид жаргалтай байж, өөрсдийн цаг хугацааг өөрт буй бүхнээ үнэлэн цэгнэж, магтаал өргөхөд зарцуулах ёстой билээ” “Тэнгэрлэг гүн ухаан”, х. 104*

Бахай Шүтлэгт мөрийтэй тоглоомоор тоглохыг хориглодог нь бүх тоглоомонд хамаатай юу гэж асуухад Абдул-Баха ийнхүү хариулжээ:

*“Үгүй ээ, зарим тоглоом гэмгүй байдаг, зүгээр цаг нөхцөөн зугаацах үүднээс тоглосон бол хоргүй. Харин цаг нөхцөөх гээж тоглож байгаад цагийг дэмий үрэх аюул бий. Цагийг дэмий үрэх нь Бурханы Үйл хэрэгт зөвшөөрөгдөхгүй зүйл юм. Харин биеийн хүчийг нэмэгдүүлэх дасгал юм уу бусад хэлбэрийн амралт бол сайшаалтай зүйл юм” “Тэнгэрлэг орон зай”, х. 9*

## Цэвэр ариун байдал

“Акдас” судартаа Бахаулла ингэж айлджээ:

*“Хүн төрөлхтний дунд цэвэр ариун яв... ямар ч нөхцөлд цэвэр нандин ёсыг эрхэмлэж яв... хувцас хунартаа хир буртагийг хэзээ ч бүү агуул... Цэвэр ариун усанд орж бай... бохир усыг хэзээ ч бүү хэрэглэ... Үнэнхүү Бид та нарыг газар дэлхий дээрх Диваажингийн илэрхийлэл болохыг хүсч байна. Чингэвээс чи адист хүмүүний зүрх сэтгэлийг баярлуулахаар гэрэл туяа мэт цацрах болно”.*

“Бахайн нотолгоо” гэсэн номондоо Мирза Абдул-Фазл тэмдэглэхдээ эдгээр зарлиг нь ялангуяа дүрслэхийн аргагүй муухай бохир усыг гэр орондоо хэрэглэж, усанд орох, тэр ч бүү хэл уухад хэрэглэж, улмаар эрүүл ахуйн нөхцөл маш доройтож, өвчин эмгэгийн үүр болдог дорнын зарим орнуудад туйлын их чухал юм гэж бичсэн байдаг. Эрүүл ахуйн хувьд ийм бохир байдлыг ихэвчлэн тухайн оронд ноёрхогч шашнаас өөгшүүлдэг бөгөөд эл байдлыг гагцхүү Тэнгэрлэг Эрх мэдлийг эзэгнэгч хэмээн итгэгдсэн түүний Өрнөдийн зарим хэсэгт ч мөн адил ариун цэвэрч байдал нь бурханлаг чанарын нэг шинж юм хэмээн хүлээн зөвшөөрөх юм бол гайхамшигтай өөрчлөлтүүд гарах болно.

## Зөнч мэргэний Зарлиг лүндэнг дагахын ач холбогдол

Эгэл жирийн амьдралаар амьдрах, эрүүл ахуйн шаардлагыг хангах, согтууруулах ундаа, мансууруулах бодисоос татгалзах зэрэг хууль зарлигийг биелүүлэх нь эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө гэдэг олон үгээр тайлбарлалтгүй ойлгомжтой хэдий ч өнөөдөр энэ бүхнийг төдийлөн зохих ёсоор нэвтрүүлж чадахгүй байна. Хэрэв эдгээр сургаалыг нийтээр дагаж мөрддөг байсансан бол хүмүүсийн дотор буй үй түмэн халдварт өвчин арилан устах байсан билээ. Хамгийн наад захын ариун цэврийг сахиагүйгээс, согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэснээс болж үүсдэг өвчин эмгэг туйлын их билээ. Түүнчлэн эдгээр хууль зарлигийг биелүүлэх юм бол хүний эрүүл мэндэд сайнаар

нөлөөлөөд зогсохгүй мөн хүний зан чанар, төрх байдалд эерэг нөлөө үзүүлдэг юм. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хүний бие махбодод хор хөнөөл учруулан өвчин үүсгэхээсээ өмнө хүний ухамсарт муугаар нөлөөлдөг. Тиймээс эдгээрээс татгалзах нь зөвхөн биеийн эрүүл мэндэд сайн төдийгүй түүнээсээ илүү чухал хүний ёс суртахуун болон оюун санаанд агуу их ач тус өгөх юм.

Цэвэр ариун байдлын талаар Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Гадна талын ариун цэвэрч байдал нь хэдийгээр биет бодит зүйл боловч хүний оюун санааны чанарт асар ихээр нөлөөлдөг... Цэвэр ариун, хир буртаггүй байна гэдэг нь хүний оюун санаанд нөлөө үзүүлнэ”*- “Абдул-Бахагийн Илгээлт бичгүүд”, 3-р боть, х.585

Хүмүүс бэлгийн харьцаандаа ариун журмыг сахих ёстой гэсэн Зөнч мэргэдийн зарлиг сургаалыг нийтээрээ дагадаг байсан бол өвчний бас нэгэн ужиг шалтгааныг арилгаж чадах байсан билээ. Өнөөдөр хүүхэд багачуул, тэдний эцэг эх гээд буруутай буруугүй мянга мянган хүмүүсийн эрүүл мэндийг доройтуулан хохироож буй арьс өнгөний адгийн муухай өвчин тун удахгүй өнгөрсөн үеийн дурсамж болон үлдэх болно. Хүмүүс шударга ёсыг баримтлах, харилцан туслах, хөрш андаа өөрийгөө хайрладаг шигээ хайрлахыг сургасан Зөнч мэргэдийн зарлиг лүндэнг хэрэгжүүлдэг болбол нэг талаас хүнд хүчир хөдөлмөр, үгээгүй хоосон байдал, байр сууц хүрэлцэхгүй байгаа асуудал, нөгөө талаас зугаа цэнгэлийг хэт хөөх, бусдын хөдөлмөрийг мөлжиж залхууран суух, хэт тансаг чинээлэг байдал хоёулаа нийлээд хүний материаллаг, сэтгэл зүйн, ёс суртахууны амьдралыг устгахаа болино.

Моисей, Будда, Христ, Мухаммед, Бахаулла нарын айлдсан эрүүл ахуйн болон ёс суртахууны энгийн сургаалыг дагаж мөрддөгсөн бол өвчин эмгэгийг анагаахад дэлхийн бүх эмч, эрүүл мэндийн байгууллагуудын хийж гүйцэтгэсэн үр бүтээлээс ч илүү амжилтанд хүрэх байсан билээ. Үнэндээ эдгээр сургаалыг нийтээрээ даган мөрдөх юм бол нийтээрээ эрүүл энх сайхан амьдрах болно. Өвчнөөс болж нялх балчирдаа, эсвэл идэр залуу

насандaa амь насаа алдахын оронд хүмүүс өндөр насыг зооглож мөчирнөөсөө салан унахынхаа өмнө ид боловсордог үр жимс лугаа адил болно.

### **Зөнч мэргэн-Эмч**

Балар эрт цагаас авахуулан одоог хүртэл Зөнч мэргэдийн зарлиг сургаалыг дагаж мөрдөх нь нийтээр мөрдөх дүрэм гэхээсээ ховор үзэгдэл болсон, өөрийгөө хайрлах нь Бурхныг хайрлахаас илүү түгээмэл болсон, хязгаарлагдмал бөгөөд намын ашиг сонирхол нийт хүмүүн төрөлхтний ашиг сонирхлоос илүүд тооцогдсон, материаллаг эд баялаг хийгээд биеийн дур хүслийн хүн төрөлхтний нийгмийн ба оюун санааны сайн сайхан аж амьдралаас урьтал болгосон ийм ертөнцөд бид амьдарч байгаа билээ. Хатуу ширүүн өрсөлдөөн, тэмцэл, дарангуйлал, мөлжлөг, баян хоосны туйлшрал ноёрхож эдгээр нөхцлүүд нь сэтгэцийн болон биеийн өвчин эмгэгт хөтөлж байна. Үүний үр дагавараар хүн төрөлхтний мод өвчилж, уг модон дахь ширхэг навч бүр нь энэхүү өвчнөөс болон тарчилж байна. Хамгийн ариун гэгээн хүмүүс ч хүртэл бусдын нүглээс болж шаналж байна. Бүх улс үндэстэн, хувь хүмүүсийг, нийт хүмүүн төрөлхтнийг бүхэлд нь анагаах шаардлагатай билээ. Бахаулла өмнөх Элч нарын адилаар ийм эрүүл энх амьдралд хэрхэн хүрэх замыг заагаад зогсоогүй мөн эрүүл энх байдлаа алдсан бол хэрхэн түүнээ сэргээн авах аргыг зааж өгсөн юм. Тэрээр дэлхий ертөнцийн бие махбодын болон оюун бодлын өвчин эмгэгийг анагаах Анагаагч, Агуу их Эмч билээ.

### **Материаллаг аргаар анагаах нь**

Өнөөдөр Өрнөдийн ертөнцөд хүний өвчнийг сэтгэцийн болон оюун санааны аргаар анагаах талаар гайхалтай өөрчлөлтүүд гарч байна. Тэр ч бүү хэл, зарим хүмүүс 19-р зуунд өвчний тухай болон өвчнийг эмчлэх талаар материалист үзэл ноёрхож байсныг бүрэн жигшиж эсрэг тал руу туйлшран материаллаг эм тан, эрүүл ахуйн аргууд нь ямар ч үнэ цэнэгүй гэж дүгнэхэд хүрч байна.

Бахаулла болбоос өвчнийг анагаах материаллаг болон оюун санааны эм танг хоёуланг нь хүлээн зөвшөөрдөг. Тэрээр анагаах ухааныг хөгжүүлж, урамшуулан зоригжуулж, боловсронгуй болгож, улмаар анагаах бүх хэлбэрийг таарч нийцсэн хүрээнд нь бусдын төлөө ашиглах хэрэгтэй гэж сургасан юм. Бахауллагийн Өвчийнх нь гэр бүлийн хүмүүс өвчлөхөд Тэрээр мэргэжлийн эмч дууддаг байсан бөгөөд ингэхийг ч дагалдагч нартаа зөвлөдөг байв. *“Өвчин эмгэгт баригдвал чадварлаг эмчийн зөвлөгөө ав”* гэж Тэрээр хэлсэн юм. (*“Китаб-и-Акдас”*)

Энэ бол шинжлэх ухаан болон эрдэм номд хандах Бахай Шүтлэгийн ерөнхий хандлагад ч хамааралтай зарчим юм. Хүн төрөлхтний тусын төлөө бий болсон шинжлэх ухаан, эрдэм мэдлэгийн бүх салбаруудыг материаллаг талаас нь ч үнэлэн цэгнэж хөхүүлэн дэмжих ёстой юм. Шинжлэх ухааны ачаар хүн материйг захирдаг бол харанхуй бүдүүлэг байдлынхаа улмаас материйн боол болдог.

Бахаулла ийнхүү бичжээ:

*“Хэрэгцээтэй үед нь эмчилгээг бүү орхи, харин эдгэрсэн хойноо түүнийг үргэлжлүүлэх хэрэггүй. Өвчнийг хоолны дэглэм барих замаар эмчлэхийг хичээ, эмийг аль болохоор хэрэглэхгүй байх, шаардлагатай эм тан чинь ямар нэг өвс ургамлын бүтцэнд агуулагдаж байгааг мэдвэл түүнийг хэрэглэж, найрлагатай эм тарианы хойноос бүү хөөцөлд... Эрүүл байх үедээ элдэв эм бүү хэрэглэ, харин хэрэгцээтэй үедээ хэтрүүлэлгүй хэрэглэж байх нь чухал.”* “Эмчид хандаж бичсэн Илгээлт”

Нэгэнт Илгээлт бичихдээ Абдул-Баха бас ингэж бичсэн байдаг:

*“Үнэнийг эрэлхэгч минь ээ! Өвчнийг анагаах 2 арга байдаг: материаллаг болон оюун санааны. Эхний арга нь эмнэлгээр эмчлүүлэх арга, хоёрдахь нь хүн Бурханд мөргөн залбирах арга юм. Энэ 2 аргын аль алиныг нь хэрэглэвээс зохилтой... Гэсэн хэдий ч энэ 2 арга хоорондоо харшилдахгүй тул аль алиныг нь хослуулан хэрэглэх хэрэгтэй. Тиймээс чи эмнэлгийн анагаах удисыг үнэлэх ёстой, учир нь энэ бол бас л Бурханы хайр ивээлээр бий болсон*



*увидас бөгөөд Бурхан Өөрийн шадар зарц нарт ач тус хүргэхийн тулд өвчин анагаах энэ аргыг бий болгон хүртээл болгосон юм”- “Абдул-Бахагийн Илгээлт бичгүүд”, 3-р боть, х.587*

Абдул-Баха, хэрэв бид амьдралаа зохиохдоо байгалийн бус, ухаалаг бус аргыг хэрэглэхийн оронд байгалиас заяасан зөн билэг мэдрэмжээ ашиглаж чадах юм бол өөрт нийцэн тохирох хоол хүнс, эмийн ургамал жимс болон бусад эм танг амьтдын адил байгалиас зөв олж хэрэглэж сурна гэж сургасан юм. Анагаах ёсны талаар нэгэн сонирхолтой яриандаа (*“Учир нь тайлагдсан зарим асуудал”* - д буй)

Тэрээр ингэж дүгнэн хэлсэн байна:

*“Тийм учраас, хоол хүнс, жимс ногоогоор өвчнийг анагааж болно гэдэг нь тодорхой. Гэхдээ өнөөдөр анагаах ухаан бүрэн төгс хөгжиж чадаагүй байгаа учраас энэ бүхний учрыг тэр бүр хараахан тайлаагүй байна. Анагаах ухаан төгөлдөржих үед өвчнийг хоол хүнс, янз бүрийн үнэр амттай жимс ногоо болон төрөл бүрийн халуун, хүйтэн усаар эмчлэх цаг ирнэ.”* - “Учир нь тайлагдсан зарим асуудал” х.241

Анагаах арга нь материаллаг байсан хэдий ч анагаах хүч нь үнэндээ Тэнгэрлэг бөлгөө. Учир нь ургамал, эрдэс бодисын шинж чанар бол Тэнгэрлэг Ивээл хишгийн хэлбэр юм. *“Бүх юм Бурханаас хамаарна. Энэ бол Хурмастын анагаах хүчийг хүртээх өнгөн талын хэлбэр, арга зам юм.”*

## **Материаллаг бус аргаар анагаах нь**

Абдул-Баха мөн материаллаг бус аргаар эмчлэх олон янзын зам байдаг гэж сургасан. Өвчин халдварладагийн адил эрүүл энх байдал бас халдварладаг. Гэхдээ эрүүл мэнд бусдад халдварлах нь хамаагүй удаан бөгөөд маш бага нөлөөлөл үзүүлдэг. Харин өвчин халдварлах нь маш түргэн байдаг. Өвчин хэр түргэн эдгэх нь бас өвчтөний сэтгэл зүйн байдлаас ихээхэн хамаардаг. Энэ байдлыг нь тодорхойлоход “итгүүлэх” арга их чухал хэрэгтэй. Айдас түгшүүр, уур уцаар, санаа зовох зэрэг байдал нь эрүүл мэндэд хортой байдаг бол итгэл найдвар, хайр сэтгэл, баяр баясгалан зэрэг нь ач тустай.

Тийм учраас Бахаулла айлдсан нь:

*“Ямар ч нөхцөл байдалд сэтгэл хангалуун байх явдал хамгийн чухал, ингэснээр өвчин зовлон, ядарч туйлдсан байдлаас хамгаалагдаж чадна. Уй гашуу, уйтгар гунигт бүү авт, учир нь уйтгар шаналал нь асар их зовлон авчирдаг. Атаархах сэтгэл бие махбодыг идэж, уур хилэн элгийг шархлуулан хайлуулна. Арслан барын жишээг даган атаа жөтөө, уур хилэнгээс зайлсхийж яв.”*  
- “Эмчид илгээсэн Илгээлт”

Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Баярбаясгалан бидэнд жигүүр хайрладаг! Баярбаясгалантай байх үедээ бидний хүч чадал нэмэгдэж ухаан хурц болдог. Харин уйтгар гунигт автсан үед хүч тэнхээ маань барагдаж,.... ухаарах чадвар маань булингартдаг.”* - “Парист айлдсан Айлдварууд”

Сэтгэлээр эмчлэх бас нэг аргын тухай Абдул-Баха хэлэхдээ, *“Энэ арга нь эрүүл хүчтэй хүн, өвчтэй хүн дээр өөрийн оюун ухааныг бүрэн төвлөрүүлж, өөрийн оюун ухааны хүчээр өвчтэй хүнтэй харилцан холбоо тогтоож өвчнийг намдааж чадна гэсэн бүрэн итгэлтэйгээр бүхий л анхаарлаа төвлөрүүлэхэд оршдог. Эрүүл хүн өвчтнийг эдгэрүүлэхийн тулд бүх л чармайлтаа гаргаж, өвчтөн ч эдгэрнэ гэдэгт итгэлтэй болно. Сэтгэл зүйн энэ хөдөлгөөнөөс шалтгаалан мэдрэлийн эд эсүүд идэвхжин улмаар өвчин эдгэрэхийн эх сурвалж болдог.”* - “Учир нь тайлагдсан зарим асуудал” х.238

Гэхдээ өвчнөөс анагаах эдгээр бүх аргууд нь хүч нөлөөллийн хувьд хязгаарлагдмал байдаг бөгөөд ноцтой хүнд өвчний үед нөлөөлж чадахгүйд хүрч болно.

### Ариун Сүнсний хүч

Хүнийг өвчнөөс анагаах хамгийн хүчтэй арга бол Ариун Сүнсний хүч юм. *“Энэ нь ямар ч хавьталт, харах, цуг байх зэргээс хамаарахгүй бөгөөд ямар ч харилцаанаас шалтгаалахгүй юм. Өвчин нь хөнгөн ч бай, хүнд ч бай, биед нь хавьтаж хүрсэн ч бай үгүй ч бай, өвчтөн эмч хоёрын хооронд нягт холбоо үүссэн ч үүсээгүй ч бай Ариун Сүнсний хүчээр энэ анагаах үйлчлэгээ нь явагдана.”* - “Учир нь тайлагдсан зарим асуудал”

Хагагтай Эгель Розенбергтэй 1904 оны 10 дугаар сард ярилцахдаа Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Ариун Сүнсний хүчээр анагаах аргад анхаарлаа тусгайлан товлөрүүлэх юм уу харилцах ямар ч шаардлага байхгүй. Энэ арга бол зөвхөн ариун хүний хүсэл тэмүүлэл ба мөргөл залбирлаар л хэрэгжинэ. Өвчтэй хүн дорно зүгт байж байхад анагаагч хүн өрнө зүгт байж болно. Тэд бие биеэ танихгүй ч байж болно, гэвч ариун хүн өөрийн зүрх сэтгэлийг Бурханд хандуулж, мөргөж эхлэхэд өвчтэй хүн анагаагдана. Энэ бол Ариун Тодруулагч нар болон эрхэм дээд түвшинд хүрсэн хүмүүст л байдаг увидас хишиг болой”.*

Христ болон Түүний хутагт шавь нар ийм л увидастай байсан бөгөөд бүх л эрин үед ариун гэгээнтэн хүмүүсийг ийм увидастай байсан гэлцдэг. Бахаулла, Абдул-Баха нар хоёулаа ийм хүч увидастай байсан бөгөөд үнэнч дагалдагч нартаа ч ийм хүчийг амласан байдаг.

### Өвчтний хандлага

Оюун санааны хүчээр анагаахын тулд өвчтөн, анагаагч, өвчтний анд нөхөд болон нийт нийгмийн талаас хүлээх тодорхой нөхцөл шаардлага бий.

Өвчтөн хүний хамгийн нэн тэргүүний шаардлага бол зүрх сэтгэлээрээ Бурханд хандаж, түүний хүч чадал болон хүсэл тааллаар хамгийн мэргэн зам олдоно гэдэгт чин сэтгэлээсээ итгэх явдал юм. 1912 оны 8 дугаар сард Абдул-Баха нэгэн Америк эмэгтэйд ингэж хэлжээ:

*“Энэ бүх өвчин эмгэг удахгүй эдгэж, та бие махбодын болон оюун санааны хувьд төгс эрүүл энхийг олно... Бахауллагийн Буян хишигээр, Бахауллагийн Ивээлээр бүх юм таны хувьд сайн сайхан болно гэдэгт зүрх сэтгэлээрээ итгэл дүүрэн байгтун... Гэхдээ та нүүр царайгаа Абха-н Хаант улсад бүрэн хандуулж, Мэри Магдален Ариун гэгээн Христэд хандуулж байсан шиг тийм их төгс анхаарлыг тийш нь хандуулах аваас та бие махбодын ч, оюун санааны ч эрүүл мэндийг хүртэнэ гэдэгт итгэлтэй бай. Та*

*бол үнэ цэнэтэй хүн. Таны зүрх сэтгэл ариун цагаан учраас та үнэ цэнэтэй хүн гэсэн баярт мэдээг би танд дүүлгая... Итгэлтэй байгтун! Аз жаргалтай байгтун! Баясгалантай байгтун! Итгэн найд!.... ”*

Энэ эмэгтэйн хувьд Абдул-Баха Өөрөө түүнийг эрүүл энх болно гэж амласан хэдий ч, тухайн хүн итгэл бишрэлээрээ хүчтэй байсан ч Тэрээр хүн бүрт ийм амлалтыг өгч чадахгүй юм. Аккад байсан нэгэн мөргөлчин хүнд Тэрээр ингэж хэлжээ:

*“Өвчнөөс анагаах зорилгоор туурвисан мөргөлүүд нь оюун санааны болон материаллаг аргаар анагаахад хамааралтай юм. Хэрэв өвчтөнд тухайн өвчнөөс анагаагдах нь хамгийн зөв зам мөн бол тэрээр анагаагдана. Зарим хүмүүсийн хувьд тухайн өвчнөөс эдгэх нь бусад өвчний эх сурвалж болдог талтай. Тийнхүү Мэргэн ухаант Бурхан зарим мөргөлийг ёсоор нь хариулах зарлигийг өгдөггүй ажээ.*

*“Бурханы шадар шивээгчин минь ээ! Ариун Сүнсний хүч чадал болбоос материаллаг ба оюун санааны өвчин эмгэгийн аль алшныг нь анагаана”- “Аккад сурсан өдөр тутмын хичээл”, х.95*

Тэрээр бас нэгэн өвчтэй хүнд ингэж бичиж байжээ:

*“Үнэнхүү Бурханы Хүсэл таалал заримдаа хүн төрөлхтний үл мэдэх шалтгаанаар үйлчилдэг. Эх сурвалж, шалтгаан тодорхой болно. Бурханд итгэж, Түүнд захирагд, Бурханы Хүсэл таалалд хүлц. Үнэнхүү Бурхан тэнгэр тань Энэрэнгүй, Нигүүлсэнгүй, Өршөөнгүй бөгөөд чамд Өөрийн Энэрэлийг хүртээх болно.”- “Өрнөдийн Од”, 7-р боть, х.232*

Тэрээр айлдахдаа, оюун санааны эрүүл саруул энх байдал нь бие махбодын эрүүл энх байдлыг бүрдүүлдэг гэж сургасан юм. Гэвч бие махбодын эрүүл мэнд ч олон хүчин зүйлсээс хамааралтай бөгөөд тэдгээрийн зарим нь тухайн хүний хяналтаас гадуур байдаг. Хувь хүн хэдийгээр оюун санааны хандлагадаа туйлын үлгэр жишээч байлаа ч гэсэн бүх л тохиолдолд бие махбодын хувьд эрүүл энх байх баталгаа байхгүй юм. Хамгийн гэгээн эрэгтэй, эмэгтэй хүмүүс ч заримдаа өвчин тусдаг. Гэсэн хэдий ч, оюун санааны хувьд зөв хандлагатай байх нь

бидний төсөөлдгөөс илүү хэмжээнд бие махбодын эрүүл энх байдалд эерэгээр нөлөөлдөг бөгөөд маш олон тохиолдолд өвчнийг анагаах чадалтай юм. Абдул-Баха нэгэн англи эмэгтэйд бичихдээ:

*“Та биеэ сульданд доройтсон тухай бичжээ. Таны оюун санааны хүч бэхжин тэнхэрч, оюун санааны тэнхээгээр бие тань ч анагаагдаасай хэмээн би Бахауллагийн Буян хишгээс гуйх болно”* гэжээ.

Тэрээр бас нэгэн тохиолдолд:

*“Гэвч ямагт хурмаст тэнгэр өөд тэмүүлж, үй түмэн буян хишгийн дотор Бурханы тэнгэрлэг Буяны анагаах эмийг хүртэх хамгийн гайхамшигт хүч чадлыг Бурхан хүнд хайрлан заяасан билээ. Гэтэл юутай харамсалтай вэ! Энэ дээд хишигт талархахын оронд, хүн хайхрамжгүй зангийнхаа нөмөрт нойрссон хэвээр Бурханаас өөрт нь үзүүлж буй их энэрлийг үл тоомсорлон, гэрэл гэгээнээс өөрийн царайг буруулж, харанхуйн замаар замнасаар байна”* гэжээ - “Парист айлдсан Айлдварууд”, х.5

### **Анагаагч**

Оюун санааны аргаар анагаах хүч бүх л хүмүүст их бага хэмжээгээр заяасан байдаг нь эргэлзээгүй. Гэхдээ зарим хүмүүс тоон ухаан юм уу дуу хөгжимд онцгой авьяастай байдгийн адил бусад нь хүнийг анагаах онцгой авьяас увидастай байдаг. Эдгээр хүмүүс анагаах ухааныг амьдралынхаа үйлс болгодог. Харамсалтай нь сүүлийн хэдэн зуун жилд ертөнц хэт их материалист хандлагатай болсон тул оюун санааны аргаар анагаах боломжийг их хэмжээгээр орхигдуулсан юм. Бусад бүх авьяас чадварын адил анагаах увидаас хишгийг бас үнэлэн зөвшөөрч хамгийн дээд зэргээр хөгжүүлж, хүчирхэгжүүлэхийн тулд сурган боловсруулах ёстой юм. Өнөөдөр байгалиасаа хүнийг анагаах увидастай мянга мянган хүмүүс байдаг боловч тэдний авьяас нуугдмал байна. Хүнийг оюун ухааны болон оюун санааны аргаар анагаах нөөц чадавхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлсэн цагт анагаах ухаан нь өөрчлөгдөж, үр ашиг нь хэмжээлшгүй ихээр нэмэгдэнэ.

Энэхүү шинэ мэдлэг, хүч нь анагаагч хүний дотор оргилуун сүсэг бишрэл болон өвчтний итгэл найдвартай хослон, зохицох юм бол гайхамшигт үр дүн гарна.

*“Бид Бурханд итгэн найдах ёстой. Бүхнийг Анагаагч, Мэдэгч, Туслагч Түүнээс өөр Бурхан үгүй... Газар дэлхий ба диваажинд Бурханы харцнаас мултрах зүйл үгүй билээ.”*

*“Ая, эмч хүн минь! Өвчтэй хүнийг эмчлэн анагаахдаа юуны өмнө Бүхнийг шүүн тунгаах увидастай Бурханы нэрийг дурс, дараа нь шавь нараа анагаахын тулд Бурханаас заяасан зүйлийг ашигла. Амьдралаараа өчсүгэй! Намайг хайрлах Хайрын Дарсыг амталсан эмч хүн анагаах удвдсыг эзэмшиж, энэрэл хайр, итгэл найдвар дүүрэн байх болно. Биеийнхээ эрүүл энхийг бодож ийм эмч хүнд итгэн найд. Тэрээр өөрийн үйлст Бурханы адис хүртсэн болой.”*

*“Энэ эрдэм бол бүх л шинжлэх ухаан дотроос хамгийн чухал нь билээ. Яагаад гэвэл тооцот орчлонд Амьдрал хайрлагч Бурхан энэ ухааныг хүн олонд эрүүл мэндийг сахуулахын тулд бусад бүх шинжлэх ухааны эрдмийн дотор тэргүүн зэрэгт өргөмжилсөн билээ. Учир нь энэ бол та нар Миний Ялалтын төлөө эгцэн босох өдөр болой.”*

*“Хэлэгтүн: Бурхан минь, Таны алдар нэр болбоос намайг анагаагч, Таныг дурсан санах явдал намайг эдгээгч эм билээ. Танд ойр байх нь миний найдвар, Танд зориулсан хайр минь миний анд нөхөр билээ. Намайг энэрэх Таны нигүүлсэл бол намайг анагаагч бөгөөд энэ ба ирэх ертөнцөд намайг тайтгаруулагч билээ. Та бол үнэхээр Хамгаас Буянтан, Хамгийг Мэдэгч, Хамгаас Мэргэн нь билээ” - Бахаулла, “Эмчид илгээсэн Илгээлт”*

Абдул-Баха ингэж бичжээ:

*“Бахайн хайр шингэсэн, бүх л зүйлсийг умартсан тэр хүмүүний амнаас Ариун Сүнс сонсдож, амьдралын сүнс түүний зүрх сэтгэлийг дүүргэнэ... Амнаас нь сувдан хэлхээс мэт үгс ундарч, гар хүрэнгүүт бүх л өвчин эмгэг эдгэрнэ” —“Өрнөдийн Од”, 8-р боть, х.233*



“Аяа, ариун цагаан, оюун санааны хүмүүн минь ээ! Зүрх сэтгэлээрээ Бурханд хандаж, Түүнийг хайрлах хайраар зүрх тань цохилж, Түүний магтуу дуунд үйлчлэн биширч, Түүний Хаант улсыг ширтэж, баяр хөөр, хайр сэтгэл, хүсэл тэмүүлэл, баяр баясгалан, анхилуун тансаг үедээ Түүний Ариун Сүнснээс тусламж эрэгтүн. Бурхан чамд Өөрийн Ахуйгаар тусалж, өвчин эмгэгийг анагаах болно.

“Зүрх сэтгэл болон бие махбодыг анагаах үйлсээ үргэлжлүүлж өвчтэй хүмүүсийг эдгээхдээ Эрхэм дээд Хаант улсад хандаж, зүрх сэтгэлээ Агуу их Алдарын хүчээр болон Бурханы Хайрын сүнсээр анагаах увдис олохын төлөө чиглүүлэгтүн” “Абдул-Бахагийн Илгээлт бичгүүд”, 3-р боть, х. 628-629

### Бүгдээрээ хэрхэн тусалж чадах вэ

Өвчтнийг анагаах ажил нь гэхдээ зөвхөн өвчтөн, эмч хоёрыг хамаараад зогсохгүй мөн хүн бүрт хамаатай юм. Бүгдээрээ сэтгэл санаагаар, буянт үйлсээр, зөв амьдралаар, зөв бодлоор, мөргөл залбирлаар туслах ёстой. Учир нь, мөргөл бол бүхий л анагаах эм дотроос хамгийн хүчирхэг нь юм. “Бусдын төлөө мөргөн залбирах нь үр дүнтэй байх нь гарцаагүй” гэж Абдул-Баха хэлсэн юм. Өвчтний анд нөхдөд асар их үүрэг ногдоно. Учир нь, тэдний эерэг болон эсрэг нөлөө нь хамгийн шууд бөгөөд хүчтэй байдаг. Маш олон тохиолдолд хөөрхий өвчтний байдал нь ихэнхдээ эцэг эх, анд нөхөд, хөршүүдийнх нь хандлагаас хамаардаг билээ.

Нийгмийн гишүүд ч өвчин эмгэгт нэрвэгдсэн тохиолдол бүрт нөлөө үзүүлдэг. Хувь хүний хувьд тэр нөлөө нь тийм ч их биш мэт санагдаж болох боловч олон түмний дунд нөлөө нь хүчтэй байдаг. Нийгмийн “уур амьсгал”, өөрөөр хэлбэл, сүсэг бишрэл, материализм, буянт чанар, нүгэлт чанар, баяр баясал, гуниг гутралын аль нь ноёрхож байгаа нь тухай бүр хувь хүнд шууд тодорхойлоход чухал үүрэгтэй байдаг. Өнөөдрийн ертөнцөд хүн бүр төгс төгөлдөр эрүүл энх байдалтай болох нь боломжгүй боловч хүн бүр Ариун Сүнсний эрүүл энхийг хайрлагч хүч чадлын хувьд “суваг дамжлага” нь болж чадах бөгөөд ингэснээр

өөрийгөө болон өөртэйгөө учирч тааралдсан хүн бүрийг анагааж, ач густай нөлөө үзүүлж чадна.

Өвчтнийг анагаах нь Бахайчуудын хувьд нэгэн чухал үүргийн нэг бөгөөд үүний ач холбогдлыг удаа дараалан онцолсон байдаг. Өвчнөөс анагаахын төлөө унших олон сайхан мөргөлийг Бахаулла болон Абдул-Баха нар туурвисан билээ.

### **Алтан үе**

Өвчтөн, анагаагч, нийт нийгмийн уялдаа шүтэлцээтэй үйл ажиллагаагаар эрүүл энхийг авч ирэх материаллаг, сэтгэл санааны болон оюун санааны төрөл бүрийн арга барилыг зөв зохистойгоор ашиглаж чадвал Алтан Үе тогтож, Бурханы Хүч чадлаар “*бүх уй гашуу баяр баясгалан болж хувирна*”. “*Тэнгэрлэг Сургаалыг ойлгосон цагт бүх зовлон бэрхшээл арилан устана*” гэж Абдул-Баха хэлсэн юм.

Тэрээр дахин хэлэхдээ:

*Материаллаг ба тэнгэрлэг хоёр ертөнц хоорондоо харилцан зохицсон тэр цагт зүрх сэтгэл хурмастын чанартай болж, хүсэл тэмүүлэл ариун цагаан болж, төгс холбоос үүсэн бий болно. Тэр цагт энэхүү хүч төгс илэрхийллээ олно. Биеийн болон оюун санааны овчин эмгэг нь туйлын төгс байдлаар анагаагдана*”- “Абдул-Бахагийн Илгээлт бичгүүд”, 2-р боть, х.309

### **Эрүүл мэндээ зөв ашиглахуй**

Энэ бүлгийг дуусгахын өмнө биеийн эрүүл мэндээ хэрхэн ашиглах талаар Абдул-Бахагийн сургаалыг дурсах нь зүйтэй гэж бодлоо. Вашингтоны Бахайчуудад хандан бичсэн нэгэн Илгээлт бичигтээ Тэрээр ингэж бичжээ:

*“Бие махбодын эрүүл мэнд, сайн сайхныг Бурханы Орны замналд зориулбал, энэ нь үнэхээр магтууштай бөгөөд сайшаалтай хэрэг. Хэрэв энэ бүхнээ нийт хүмүүн төрөлхтний материаллаг ч атугай ашиг тусынх нь төлөө зориулж, буян болбол бас л зүйтэй хэрэг. Гэвч хүн эрүүл бие махбод, сайн сайхан*

*аж байдлаа адгуусан амьтан мэт гагцхүү биеийн жаргалыг хөөн, нүгэлт муухай шунал хүсэлд зарцуулбаас, эрүүл байхаас өвчтэй байх нь дээр, үгүй ээ, ингэж амьдарснаас үхсэн нь дээр биш үү. Хэрэв чи эрүүлийг хүсвэл, Бурханы Оронд үйлчлэхийн тулд эрүүл энх явахыг хүс. Чамд би дотоод сэтгэлийн ариусал, бат тууштай итгэл, эрүүл саруул бие, оюун санааны болон бие бялдрын хүч тэнхээг хүсч, түүнчлэн мөнхийн амьдралын оргил рашаанаас ундлан, тэнгэрлэг ивээлийг хүртэх болтугай гэж ерөөе”.*

## Наймдугаар бүлэг

### ШАШНЫ ЭВ НЭГДЭЛ

*“Аяа, газар дэлхий дээр оршин суугч хүмүүс ээ! Энэхүү Эрхэм Дээд Үүдэл нээлтийн онцгой давуу шинж чанар нь нэг талаас, бид Бурханы Ариун Номын хуудаснаас хүмүүний үрсийн дунд тэмцэл маргаан, хагарал бутралын эх сурвалж болсон бүхнийг арчиж, нөгөө талаас, эв эе, ойлголцол, бүрэн дүүрэн бөгөөд үүрдийн эв нэгдлийн үндсэн шаардлагыг бий болгосонд оршино.”*

*“Бахауллагийн сургаалийн дээжис”*

#### Арван есдүгээр зуун дахь Шашны хагарал бутрал

Дэлхий ертөнц шашны хувьд хамгийн их хагарал бутралтай байсан үе бол арван есдүгээр зуун байсан биз ээ. Олон зууны турш Зороастр, Моисей, Будда, Христ, Мухаммедын болон бусад томоохон шашны нийгэмлэгүүд мөр зэрэгцэн оршсоор ирсэн боловч хамтдаа уялдан шүтэлцэхийн оронд байнга дайтан тэмцэж, бие биеэ эсэргүүцэж ирсэн юм. Түүгээр ч үл барам, эдгээр шашнууд өөр дотроо ч хуваагдан бутарч, олон янзын урсгал бүлэглэл болж, эдгээр сект бүлэглэлүүд нь бие биеэ эсэргүүцэн ширүүн тэмцдэг билээ. Гэсэн ч Христ хэлэхдээ: *“Та нар бие биеэ хайрлах аваас бүх хүмүүс та нарыг Миний хутагт шавь нар гэдгийг мэдэх болно”* гэсэн бол Мухаммед: *“Та нарын энэ шашин бол нэг л шашин... Бурхан Ноад даалгасныг та нарт даалгасан ба Абрахам, Моисей, Есүс нарт “Энэ шүтлэгийг дагагтун, өөр дотроо бүү хуваагдан задар!” хэмээн даалгасан тэр шашныг Бид та нарт нээсэн бөлгөө”* гэжээ. Дэлхийн агуу шашин бүрийн үндэслэгч дагалдагч нараа хайр ба эв нэгдэлд уриалан дуудаж байсан боловч энэ зорилго нь ихээхэн хэмжээнд алдагдаж, бие биетэйгээ үл эвлэрэх, маргалдан тэмцэлдэх, хэлбэрдэн мэхлэх, хээл хахуульд автах, ариун сургаалын утга учрыг гажуудуулан хазайлгах, хагарал бутралд автах явдал түгээмэл болсон нь харамсалтай. Бахайн Эрин үеийг эхлэхэд шашны явцуу бүлэглэлүүдийн тоо хэмжээ түүхэнд урьд өмнөх үеийг бодвол хамгийн их байсан юм. Тэр үед

хүн төрөлхтөн ертөнцөд байж болох шашны бүхий л хэлбэрийн бүлэглэл урсгал, ёс жаяг, ёслол үйлдэх зан заншил, ёс суртахууны хэм хэмжээг сорин туршиж байгаа мэт санагдаж байлаа.

Үүний хажуугаар өөрсдийн эрч хүчийг байгалийн жам хуулийг аймшиггүйгээр судлан шинжлэхэд зориулж, сүсэг бишрэлийн үндэс суурийг судалж эхэлсэн хүмүүсийн тоо улам нэмэгдэж байсан билээ. Шинжлэх ухааны цоо шинэ мэдлэг түргэн тархаж, шинэ соргог бүтээлүүд амьдралын бэрхшээлтэй олон асуудлуудыг шийдэж эхэлсэн юм. Уурын усан онгоц, төмөр зам, захидал харилцааны систем, сонин хэвлэл зэрэг шинэ оновчтой бүтээлүүд гарсан нь үзэл бодлыг түгээн цацахад дөхөм болгож, олон ургалч үзэл санаа, амьдралын хэв маягууд хоорондоо харилцан шүтэлцэхэд асар ихээр нөлөөлсөн юм.

Тийнхүү “шашин, шинжлэх ухаан хоёрын зөрчил” нь ширүүн тэмцэл болон хувирсан юм. Христийн шашны ертөнцөд Библийг шүүмжлэгчид байгалийн шинжлэх ухаанчидтай хамтран Библийн эрх мэдэлтэй маргаж, зарим тохиолдолд олон зууны турш сүсэг бишрэлийн суурь үндэс хэмээн хүлээн зөвшөөрөгдөж байсан судар номыг үгүйсгэж байсан байна. Хүн амын ихэнх хэсэг нь сүм хийдийн номлол сургаалын талаар урам хугарч эхэлсэн байна. Лам санваартан нарын дундаас ч олон хүн ил буюу далдуур өөрсдийн шашны бүлэглэлийн дагадаг итгэл үнэмшилд эргэлзэх болжээ.

Үзэл бодлын мөргөлдөөн, үймээн самуун, өнгөрсөн үеийн догм номлолыг өнөө үеийн шаардлагад нийцэхгүй гэж үзэх хандлага, үүнтэй холбогдон илүү өргөн дүүрэн мэдлэг ойлголтонд хүрэх гэсэн оролдлого эрмэлзэл нь зөвхөн Христийн шашинтан орнуудад илрээд зогсоогүй мөн их бага хэмжээгээр өөр хэлбэрээр бүх улс үндэстэн, бүх шашны хүмүүсийн дунд харагдаж байсан юм.

## **Бахауллагийн Илгээлт**

Чухамхүү зөрчил үймээний байдал дээд цэгтээ хүрсэн тэр үед Бахаулла хүн төрөлхтөнд хандаж Өөрийн бүрэн дууг дуурсгасан юм.

*“Бүх улс үндэстнүүд шашин шүтлэгийн хувьд нэг, ахан дүүс шиг болж, хүмүүний үрсийн хооронд хайр ивээл, эв нэгдлийн холбоос нь батжиж, шашны ялгаа зөрчил арилж, үндэстэн ястны тэмцэл зогсохын тулд... Эцэ бүх маргаан тэмцэл, цус асгаралт, эв тунжингүй явдал эцэс болох ёстой. Бүх хүмүүс нэг төрөлхтөн, нэг гэр бүл мэт болох ёстой.”* (Профессор Браунд хэлсэн үгс)

Энэ бол үнэхээр гайхамшигт илгээлт билээ. Гэвч эдгээр сургаалыг хэрхэн хэрэгжүүлэх билээ? Мянга мянган жилийн турш Зөнч мэргэд эдгээр зүйлсийн талаар сургаал айлдаж, яруу найрагчид магтан дуулж, мэргэн цэцэн хүмүүс мөргөн залбирсан боловч шашны ялгаа зөрчил арилаагүй, тэмцэл дайн, цус асгаралт ч зогсоогүй билээ. Харин одоо гайхамшигт ид шид биелэх юм гэдгийг харуулах юм хаана байна? Бидний энэ эринд шинэ хүчин зүйл байна уу? Хүний мөн чанар урьд өмнөх шигээ л адил, цаашид ч адил биш байх болно гэж үү? Хэрэв хоёр хүн юм уу хоёр улс үндэстэн яг ижил зүйлийг хүсэх юм бол тэд түүнээ булаацалдан өнгөрсөн үед байлдаж байсан шиг ирээдүйд ч байлдахгүй гэж үү? Моисей, Будда, Христ, Мухаммед нар дэлхийг нэгтгэж чадаагүй юм бол Бахаулла чадна гэж үү? Өмнөх бүх шашнууд доройтон илжирч, олон янзын бүлэглэл болон хуваагдсан юм бол Бахай Шүтлэг ч мөн адил тавилантай байх биш гэж үү? Бахайн сургаалд эдгээр болон ийм бусад асуултанд ямар хариу өгсөн байдгийг харцгаая.

### **Хүний мөн чанар өөрчлөгдөх үү?**

Боловсрол, шашин хоёр нь хоёулаа л хүний мөн чанарыг өөрчилж болно гэсэн таамаглал дээр үндэслэдэг. Үнэндээ амьд бодгаль зүйлийн талаар хэлж болох нэгэн үнэн бол тэр зүйл байнга л өөрчлөгдөж байдаг явдал юм. Өөрчлөлтгүйгээр амьдрал гэж үгүй. Эрдэс бодис ч хүртэл өөрчлөлтөнд өртдөг. Ахуйн ертөнцийн түвшин ахих тусам өөрчлөлтүүд улам нарийн, улам төвөгтэй, улам гайхамшигтай болж ирдэг. Түүнчлэн бүхий л түвшин бодгаль зүйлсийн хөгжил дэвшилд бид хоёр янзын өөрчлөлтийг ажиглаж болно: нэг нь удаан, аажмаар явагдах,



бараг үл мэдрэгдэх өөрчлөлт, нөгөө нь хурдан, гэнэтийн, огцом өөрчлөлт. Сүүлчийн өөрчлөлтүүд нь хөгжлийн “эгзэгтэй, үе шатуудад” үзэгддэг. Эрдэс бодисын хувьд иймэрхүү эгзэгтэй үе шатууд нь тухайн бодис хайлах юм уу буцлах явцад үзэгддэг, жишээлбэл, хатуу бодис маань шингэн болох юм уу шингэн бодис хий болох явцад үзэгдэнэ. Ургамлын хувьд гэвэл, ийм эгзэгтэй үе шат нь үр задран үндэс болоход, эсвэл нахиа задран навч болоход харагдана. Амьтны аймагт ийм зүйлийг бид алхам тутамдаа ажиглаж болно. Жишээлбэл, өг эрвээхэй болох, эсвэл дэгдээхэй өндгөн дотроос цухуйн гарах, эсвэл хүүхэд эхийнхээ хэвлийгээс төрөх гэх мэт. Сүнсний амьдралын арай дээд түвшинд ч ижил төстэй хувьсалт өөрчлөлт байх агаад хүн “дахин төрж” бүх л мөн чанар нь зорилго, шинж чанар үйл ажиллагаагаараа өөрчлөгдөн хувьсдаг. Иймэрхүү эгзэгтэй үе шат нь тухайн зүйлд, эсвэл хэд хэдэн зүйлд нэгэн зэрэг нөлөөлдөг. Энэ нь жишээлбэл хаврын улиралд өвс ургамал гэнэт шинэ амьдралаа эхэлдэгтэй адил юм.

Доод түвшний бодгаль биесүүд заримдаа гэнэт урьд өмнөхөөс шинэ, илүү дүүрэн амьдралдаа шилждэгийн адил хүн төрөлхтний хувьд “эгзэгтэй үе шат”, “дахин төрөх” цаг нь ирээд байна гэж Бахаулла айлдсан юм. Тиймээс түүхийн эхэн үеэс өнөөг хүртэл ноёрхож ирсэн амьдралын хэв маяг түргэн, хэзээ ч буцахгүй байдлаар өөрчлөгдөж, хүн төрөлхтөн өтнөөс, шувуу өндөгнөөс төрдгийн адилаар урьд өмнөхөөс огт өөр шинэ амьдралынхаа эрин үед шилжин орох юм. Шинэ Үүдэл нээлтийн нөлөөллөөр хүн төрөлхтөн бүхэлдээ үнэний талаар шинэ ойлголтонд хүрч, нарны туяанд бүх л нутаг бүлээцдэг шиг бүх хүмүүс саяхан нэг цагийн өмнө харанхуй бүүдгэр орчинд юм бүхнийг хардаг байсан бол одоо юм бүхнийг тодоос тод үнэн байдлаар харах боломжтой болно. *“Энэ бол хүмүүний хүчин чадлын шинэ мөчлөг юм. Дэлхий ертөнцийн тэнгэрийн хаяа гэрэлтэж, дэлхий бүхэлдээ сарнайн цэцэрлэг, диваажин мэт болно”* гэж Абдул-Баха хэлжээ. Ийм сайхан дүр зургийг төсөөлөхийн тул байгальтай зүйрлэх нь зүйн хэрэг билээ. Өнгөрсөн цагийн Зөнч мэргэд бүгдээрээ нэгэн дуугаар ийм гайхамшигт өдөр ирэхийг зөгнөн хэлж байсан. Хүний үзэл санаа болон нийгмийн байгуулалтанд хувьсгалт өөрчлөлтүүд

нэгэнт гарч эхлээд байгаа нь цаг үеийн шинж тэмдгээс харагдана. Тиймээс байгальд бүх юм өөрчлөгддөг, зөвхөн хүний мөн чанар л өөрчлөгддөггүй гэсэн гутрангуй бодлоос өөр утгагүй зүйл бий гэж үү?

### **Эв нэгдэлд хүрэх Анхны алхам**

Шашны эв нэгдлийг хөхүүлэн дэмжихийн тулд Бахаулла туйлын их буян үйлдэж, эвлэрэнгүй хандахыг айлдаж, Өөрийн дагалдагч нарыг “бүх шашны сүсэгтэн нарт баяр баясгалантайгаар хандах ёстой” гэж уриалсан юм. Тэрээр сүүлчийн Хүсэл ба Гэрээслэлдээ айлдахдаа:

*“Тэмцэл зөрчлийг Түүний судар номонд хатуу хориглосон билээ. Хамгаас эрхэм энэхүү Үүдэл нээлтийн Эзэн тэнгэрийн зарлиг нь ийм бөлгөө. Уг зарлигийг Тэрээр таягдан халахгүй бөгөөд Өөрийн баталгааны чимгээр чимэглэсэн юм.*

*“Ая, ертөнцийн хүмүүс ээ! Бурханы Шашин бол хайр, эв нэгдлийн Шашин юм. Тиймээс түүнийг дайсагнал, тэмцэл зөрчлийн эх сурвалж бүү болгогтун... Баха-н хүмүүс хүмүүсийн зүрх цээжинд дүрэлзэн буй үзэн ядах, дайсагнах сэтгэлийн галыг ус лугаа адил унтрааж, “Зэ! Бүх юм Бурханых билээ!” гэсэн Ариун Уг, Яруу Алдарт Үгийг ямагт санаж явна гэсэн найдлагыг сэтгэлдээ тээнэм. Чухамхүү энэ ганцхан Үгээр ертөнцийн янз янзын шашны урсгалууд жинхэнэ эв нэгдлийнхээ гэрэлд хүрнэ. Үнэнхүү Тэрээр Үнэн үгийг хэлж, үнэн Замд хөтлөн дагуулна. Тэрээр Хүчирхэг, Гоо жавхлант, Гоо төгөлдөр билээ.” гэжээ.*

Абдул-Баха ийнхүү хэлсэн юм:

*“Бүгд атгаг сэжиг үзлээ таягдан хаяж, бие биеийнхээ сүм дуганд очих ёстой. Учир нь, мөргөл бишрэлийн эдгээр газруудад Бурханы Нэрийг дурдах ёстой юм. Бүгд Бурханыг шүтэх гэж цугласан тул ямар ялгаа байна аа? Хэн нь ч Ад шулмыг шүтдэггүй шүү дээ. Мухаммедчууд Христчүүдийн сүм, Иудейчүүдийн Синагогт (сүм-орч) очиж, нөгөөдүүл нь ч Мусульманы сүм дуганд очих ёстой. Тэд ямар ч үндэсгүй атгаг сэжиг үзэл, догм номлолынхоо улмаас бие биеэсээ хөндийрч байна. Америкт*

*байхдаа би Иудейн нэгэн Синагог сүмд очсон. Тэр сүм нь Христийн шашны сүмтэй адил байсан бөгөөд тэд Бурханыг хаа сайгүй л шүтэж явааг би харсан.*

*“Ийм олон газар очихдоо би тэнгэрлэг шашнуудын анхдагч үндэс суурийн талаар ярьж, тэнгэрлэг зөнч мэргэд болон Ариун Тодруулагч нарын жинхэнэ нотолгоог тэдэнд тайлбарласан. Би тэднийг сохор дуурайлтаасаа ангижрахыг уриалсан. Бүх тэргүүнүүд мөн адилаар бие биеийнхээ Сүм дуганд очиж, тэнгэрлэг шашнуудын үндэс суурь болон үндсэн зарчмуудын талаар ярилцах ёстой. Тэд туйлын эв нэгдэл, эв зохицолдоотойгоор бие биеийнхээ сүсэг бишрэлийн газруудад Бурханыг магтан биширч, фанатик (мухар сүсэг-орч) үзлээсээ ангижрах ёстой”. “Өрнөдийн Од”, 9-р боть, Дугаар 3, х. 37*

Анхны эдгээр алхмуудыг хийж, төрөл бүрийн шашны явцуу бүлэглэлүүдийн хооронд найрсаг, эвлэрэнгүй байдал тогтох юм бол ертөнцөд ямар их гайхамшигтай өөрчлөлт гарах билээ! Гэхдээ жинхэнэ эв нэгдэлд хүрэхийн тулд үүнээс илүү өөр нэгэн зүйлийг хийх ёстой юм. Учир нь, бүлэглэл хоорондын тэмдлийг халж, эвлэрэнгүй хандлагыг тогтоох нь маш чухал зүйл боловч жинхэнэ өөрчлөлтийг хийхэд хангалтгүй юм. Ингэснээр гол бэрхшээлийн эх сурвалжийг нь устгаж чадахгүй.

### **Эрх мэдлийн асуудал**

Шашны олон янзын төлөөлөгчид өнгөрсөн үед хоорондоо нэгдэх гээд чадаагүй нэг шалтгаан бол шашин бүрийн дагалдагч нар өөрсдийн шашныг үндэслэсэн үндэслэгчийг хамгийн дээд эрх мэдэлтэн гэж үзэн түүний хуулийг тэнгэрлэг хууль гэж тооцож байсантай холбоотой юм. Тиймээс өөр сургаал айлдаж байсан Зөнч мэргэнийг үнэний дайсан хэмээн буруутгаж байлаа. Нэг шашин дотор байсан олон сект бүлэглэлүүд нь ийм шалтгаанаар хоорондоо таарч тохирдоггүй юм. Бүлэглэл бүрийн төлөөлөгчид ямар нэгэн дэд эрх мэдэлтнийг дагаж, уг шашныг үндэслэсэн үндэслэгчийн Илгээлт сургаалын аль нэгэн хувилбар юм уу тайлбарыг Цорын ганц Жинхэнэ Шүтлэг хэмээн тооцож,

бусад бүх хувилбарыг худал хуурмаг гэж үздэг байв. Ийм байдал үргэлжилсээр байсан цагт эв нэгдэлд хүрэх нь боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Нөгөө талаас, Бахаулла сургахдаа, бүх Зөнч мэргэд Бурханы жинхэнэ сургаалыг авчирч байсан бөгөөд тус бүр нь Өөрийн цаг үед таарч тохирсон хамгийн эрхэм сургаалыг хүмүүст авчирч өгсөн ба дараа дараачийн залгамжлагч нарын авчрах сургаалыг хүлээн авахад нь бэлтгэх үүднээс хүмүүсийг сурган хүмүүжүүлж байсан гэсэн билээ. Тэрээр шашин бүрийн дагалдагч нарт уриалан, өөрсдийн шүтдэг Зөнч мэргэдийн Тэнгэрлэг Онгодыг үл үгүйсгэхийн зэрэгцээ бусад бүх Зөнч мэргэдийн Тэнгэрлэг Онгодыг бас хүлээн зөвшөөрч, улмаар бүх сургаал нь угтаа уялдаа шүтэлцээтэй нэгэн сургаалын хэсгүүд, бүгд хүмүүн төрөлхтөн соён гэгээрүүлэн нэгтгэх агуу төлөвлөгөөний хэсгүүд юм гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой гэж айлдсан юм. Бүх шашны урсгалын шүтлэгтэн нарыг бүх Зөнч мэргэд хүсэн тэмүүлж, түүний төлөө зовлон шаналлыг туулсан тэрхүү эв нэгдлийг тогтооход амьдралаа зориулснаар өөрсдийн Зөнч мэргэндээ хүндэтгэл үзүүлэхийг уриалан дуудсан юм.

Хатан хаан Викториад хандсан захидалдаа Бахаулла дэлхий ертөнцийг өвчин эмгэгт баригдсан хүнтэй зүйрлэсэн байв. Чадвар туршлагагүй эмчийн гарт эмчлэгдэж байсан тул өвчин эмгэг нь гаарсан байна хэмээн бичсэн байв. Түүнийг хэрхэн эмчлэх талаар Тэрээр ингэж айлджээ:

*“Нийт дэлхий ертөнцийг анагаах хүчирхэг эм хийгээд хамгийн чадалтай зэмсэг нь болбоос бүх хун ардууд нэгэн түгээмэл Үйл хэрэг, нэгэн нийтийн Шүтлэгт нэгдэн нийлэхэд оршино хэмээн Эзэн тэнгэрээс захирамжилсан билээ. Үүнийг гагцхүү чадварлаг, хамгаас хүчтэй, онгод билигт Эмчээс өөр хэн ч биелүүлж үл чадна. Энэ бол үнэнхүү үнэн бөгөөд бусад бүхэн болбоос алдаа билээ.”* - “Бахауллагийн Сургаалын Дээжис”, СХХ,х254

### **Хөгжин дэвших Үүдэл нээлт**

Шашны эв нэгдэлд хүрэхэд олон хүмүүсийн хувьд саад тотгор болж буй нэгэн зүйл нь олон янзын Зөнч мэргэдийн нээсэн

үүдэл нээлтүүд хоорондоо ялгаатай байдагт оршдог. Нэгэнд нь зөвшөөрсөн зүйлийг нөгөөд нь хориглосон байдаг юм чинь яаж хоёулаа зөв, яаж хоёулаа Бурханы Хүсэл тааллыг илэрхийлж чадах юм бэ? Үнэн бол мэдээжийн хэрэг Нэг бөгөөд хэзээ ч өөрчлөгдөж болохгүй. Тийм ээ, Туйлын Үнэн бол Нэг бөгөөд өөрчлөгдөж чадахгүй, гэвч Туйлын Үнэн бол хүний оюун ухаанаас хязгааргүй өргөн бөгөөд түүний тухай бидний ойлголт өөрчлөгдөж байх ёстой юм. Өмнө нь бид төгс бус ойлголттой байсан бол Бурханы ачаар тэр нь цаг хугацаа өнгөрөхийн эрхээр өөрчлөгдөж, илүү нийцтэй ойлголт болон хувирна. Персийн зарим Бахайчуудад хандаж бичсэн нэгэн Илгээлт бичигтээ Бахаулла:

*“Аяа, хүмүүс ээ! Анхлан суралцагчдад хөгжин дэвшихэд нь туслах үүднээс тэдний нөөц чадавхинд тааруулан Сургаал Үгийг нээдэг билээ. Ертөнцийн балчир үр Сүр жавхлангийн Ертөнцөд нэвтэрч, Эв нэгдлийн Өргөөнд суухыг нь дэмжих тийм хэмжээний сүүгээр тэжээн бойжуулах ёстой билээ.”* гэсэн байна.

Нялх балчир хүүхэд сүүгээр бойжин, сүү нь хожим арай хатуу чанартай хоол идэхэд нь хоолоо шингээхэд нь тус болдог. Тодорхой цаг үед тодорхой нэгэн сургаалыг өгсөн Зөнч мэргэний зөв бөгөөд өөр нэгэн цаг үед өөр нэгэн сургаал өгсөн өөр Зөнч мэргэний буруу гэж хэлэх нь дөнгөж төрсөн нялх хүүхдэд сүү хэрэгтэй учраас том болсон хүнд сүүнээс өөр юу ч хэрэггүй бөгөөд сүүнээс өөр юм идвэл хортой гэж хэлэхтэй адил болно! Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Тэнгэрлэг үүдэл нээлт бүр хоёр хэсэгтэй. Эхний хэсэг нь амин чухал хэсэг бөгөөд тэр нь мөнхийн ертөнцөд хамааралтай. Энэ бол Тэнгэрлэг үнэн ба амин чухал зарчмуудыг тайлбарласан хэсэг юм. Энэ бол Бурханы Хайрын илэрхийлэл юм. Энэ хэсэг нь бүх шашинд адил байх агаад хэзээ ч өөрчлөгддөггүй, хөдлөшгүй үнэн юм. Хоёр дахь хэсэг нь мөнхийн биш юм. Тэр нь бодит амьдрал, ажил хэргийг зохицуулдаг бөгөөд хүн өсөн хөгжиж, Зөнч мэргэн бүрийн амьдарч байсан цаг үеийн шаардлага өөрчлөгдөх тусам өөр өөр болдог. Жишээлбэл, Моисейн үед бага ч атугай хулгай хийсэн хүний гарыг бугуйгаар тасалдаг байв. Мөн нүдийг нүдээр, шүдийг шүдээр гэсэн хууль байсан агаад эдгээр хуулиуд нь*

*Христийн үед үл тохирох байсан тул халагдсан юм. Үүний нэгэн ажил гэр бүл салалт маш түгээмэл болж, гэрлэлтийн тогтсон хууль гэж байхаа больсон байсан тул Христ гэр бүл салалтыг хориглосон юм.*"

*"Цаг үеийн шаардлагын дагуу Ариун Гэгээн Моисей цаазаар авах ялыг тогтоосон хууль гаргасан билээ. Тэр үед ийм хатуу шийтгэлгүйгээр нийгэмлэгийг хамгаалж, нийгмийн аюулгүй байдлыг тогтоох нь боломжгүй байсан юм. Учир нь, Израилийн үр сад Тах аглаг газар амьдарч, тэнд ямар ч шүүх, торгууль шийтгэл гэж байгаагүй юм. Гэвч ийм хууль нь Христийн үед тийм их шаардлагатай байсангүй. Шашны хоёр дахь хэсэг хэрхэн хөгжсөн тухай түүх тийм чухал биш юм, яагаад гэвэл энэ нь зөвхөн амьдралын хэв заншилтай холбоотой юм. Гэвч Бурханы шашны үндэс суурь нэг бөгөөд Ариун Гэгээн Бахаулла энэ үндэс суурийг шинэчлэн тогтоосон юм."* – "Тэнгэрлэг гүн ухаан"

Бурханы шашин бол Нэг Шашин бөгөөд бүх Зөнч мэргэд нь энэ шашныг л сургаж байв. Гэвч энэ бол өсөн хөгжиж буй амьд зүйл болохоос биш амьгүй, хөдөлгөөнгүй зүйл биш билээ. Моисейн сургаалд бид Нахиаг харж, Христэд Цэцгийг харна. Харин Бахаулла бол Үр жимс нь байв. Цэцэг ургахдаа нахиаг устгадаггүй бөгөөд үр жимс нь цэцгийг устгадаггүй, харин гүйцээдэг. Цэцэг ургахын тулд нахиа задрах ёстой, үр жимс урган боловсрохын тулд дэлбээ нь унах ёстой. Нахиа, эсвэл цэцгийн дэлбээ нь хэрэггүй байсан болоод унасан хэрэг үү? Үгүй ээ, тухайн үедээ хэрэгтэй байсан, тэдгүйгээр үр жимс гарахгүй байсан шүү дээ. Тийм учраас янз бүрийн зөнч мэргэн сургаалын хувьд иймэрхүү байдлаар үеэс үед гаднах төрх нь өөрчлөгдөж ирсэн бөгөөд үүдэл нээлт бүр нь өмнөх үүдэл нээлтийнхээ үргэлжлэл байсан ба тэд хоорондоо зөрчилтэй юм уу салангид биш харин Нэг л Шашны түүхэн дэх янз бүрийн үе шатууд байсан юм. Тэр нь эхлээд үр, дараа нь нахиа, дараа нь цэцэг, харин одоо үр жимсээ боловсруулах үе шатанд ороод байна.



## Зөнч мэргэд Алдаа мадаггүй байдаг нь

Зөнч мэргэний байр суурийг олсон хүн бүр Өөрийн ариун Үүргийн талаар хангалттай нотолгоотой байдаг агаад хүмүүс түүнийг хүлцэнгүй дагаж, Тэрээр өмнөх сургаалыг халах, өөрчлөх буюу нэмэх эрхтэй байдаг юм. “Иган”-д Тэрээр бичсэн нь:

*“Өөрийн зарц зардас нарт удирдамж олгохын тулд хүмүүсийн дундаас нэг хүмүүнийг сонгон онцлоод нэг талаас Түүнд Өөрийн тэнгэрлэг гэрчлэл өгөхөөс татгалзаж, нөгөө талаас Өөрийн сонгосон тэр Хүмүүнээс холдлоо хэмээн Өөрийн хүмүүст хатуу ширүүн шийтгэлийг хүлээлгэх нь Хамгаас Буян хишигт Бурханы гоо жавхлан болон Түүний хайрын зөн билгээс юутай хол билээ! Үгүй ээ, хамаг бүхний Эзэн тэнгэрийн түмэн буян хишиг нь ямар ч цаг үед Тэнгэрлэг мөн чанарын Тодруулагч нараар дамжин газар дэлхий ба туун дээр оршигч бүхэнд хүртээгдэж байсан билээ.”*

*Гэсэн ч Үүдэл нээлт бүрийн зорилго нь хүн төрөлхтний бүхий л зан чанарт хувьсгалт өөрчлөлт хийж, энэ өөрчлөлт дотоод болон гадаад амьдралд нь нөлөөлж, гадна талаараа ч ,дотоод талаараа ч илэрхийлэгдэхэд оршдог биш гэж үү? Учир нь, хүн төрөлхтний зан чанар өөрчлөгдөхгүй юм бол Бурханы нийтлэг Тодруулагч нар ямар ч хэрэггүй байх байсан нь тодорхой.”* “Китаб-и-Иган”

Бурхан болбоос Цорын ганц алдаа мадаггүй Эрх мэдэлтэн бөгөөд бүх Зөнч мэргэд бас алдаа мадаггүй юм. Учир нь тэдний Илгээлт бол тэднээр дамжуулан дэлхий ертөнцөд илгээгдсэн Бурханы Илгээлт юм. Тэрхүү Илгээлт сургаал нь нөгөө буюу өөр Зөнч мэргэний авчирсан өөр Илгээлт сургаалаар солигддог.

Бурхан болбоос ертөнцийн өвчин эмгэгийг зөв оношилж, таарамжтай эм тангаар эмчилж чадах агуу Эмч билээ. Нэг цаг үед тохируулан хэрэглэсэн эм тан дараагийн цаг үе гэхэд өвчтний байдал өөр болчихсон байдаг учраас тохирохоо больдог. Эмч өөр эм бичиж өгчихөөд байхад хуучин эмийг нь хэрэглээд байвал эмчид үл итгэсэн байдал гаргаж буйтай адил юм. Одоогоос гурван мянга гаруй жилийн өмнө ертөнцийн өвчин эмгэгийг анагаахын тулд Моисейн өгсөн анагаах эм нь одоо хоцрогдон

хуучирсан гэж Иудейчүүдэд хэлэх юм бол хүнд цохилтонд орох нь мэдээж. Есүсийн өгсөн анагаагч сургаал дээр Мухаммед ирж шаардлагатай нэмэлтийг оруулсан юм гэж Христчүүдэд хэлэх юм бол бас л цочирдоно. Түүнчлэн Баб, Бахаулла нар ирээд Мухаммедын зарлиг хуулийг халах ёстой байсан учраас халсан юм гэвэл Мусульман хүн ч бас цочирдоно. Харин Бахай үзэл баримтлалаар бол, Бурханд жинхэнэ ёсоор сүслэх гэдэг нь Бурханы БҮХ л Зөнч мэргэдийг дээдлэн хүндлээд Бурханы хамгийн сүүлд, орчин үед зориулан ирүүлсэн Зөнч мэргэний авчирсан Зарлиг сургаалыг даган мөрдөхийг хэлнэ. Ингэж сүслэснээр чухамдаа жинхэнэ Эв нэгдэлд хүрч чадах юм.

### Эрхэм Дээд Тодруулагч

Бусад Зөнч мэргэдийн адилаар Бахаулла Өөрийн Ариун үүргийг хамгийн алдаа мадаггүй байдлаар тунхагласан зарласан билээ.

Христийн шашинтнуудад хандаж бичсэн “Лаух-и-Акдас” илгээлт бичигтээ Тэрээр ийнхүү айлджээ:

*“Үнэнхүү Эцэг залран ирж, Бурханы Ханлиг улсад та нарт амлагдсан тэр зүйлийг биелүүллээ. Энэ бол тэр үед та нар сонсож дийлээгүйгээс Хүүгийн нууцлан орхисон тэр Үг болой. Цаг хугацаа өнгөрч, товлосон Цаг ирэхэд Бурханы Хүсэл тааллын Тэнгэрийн хаяанаас тэр Үг гэрэлтэн гийлээ. Хүүгийн Чуулган минь (Христчүүд), санагтун! Түүнийг өөрсдөсөө бүү холдуул, харин түүнээс зуур. Энэ бол та нарын хувьд өмнө чинь байгаа бүхнээс ч хавьгүй дээр буй заа... Үнэнхүү, Үнэний Сүнс та нарыг Үнэнд хөтлөн дагуулахаар залран ирлээ. Үнэнхүү, Тэрээр Өөрөөсөө ярьж байгаа бус харин Бүхнийг Мэдэгч, Мэргэн ухаантан Бурханаас ярьж байна. Тэрээр Хүүгийн алдаршуулан мандуулсан Нэгэн болой... Өөрсдийн өмнө байгаа бүхнээ орхиж, Хүчирхэг, Үнэнч Түүнээс болгоосон тэр зүйлийг авагтун, газар дэлхийн хүмүүс ээ.”*

1867 онд Адрианополиос Ромын хамба ламд бичсэн захидалдаа Тэрээр айлдсан нь:

*“Алдаршуулан мандуулж байгаад мандуулагдаж байгаа тэр Нэгнээсээ холдож, сүсэглэн биширч байгаад Сүсэглэгдэн биширэгдсэн тэр Нэгнээсээ холдох вий хэмээн болгоомжлогтун. Хүчирхэг, Бүхнийг мэдэгч Эзэн тэнгэрийг харагтун! Тэрээр ертөнцийн амьдралыг төвхнүүлэн түүнд оршин суугч бүхнийг нэгтгэхээр залран ирлээ. Аяа, хүмүүс ээ, Үүдэл нээлтийн Үүрийн туяа гэгээрэх газар луу ирцгээ! Нэг цаг ч болтугай бүү алгуурла! Та нар Евангели (Христийн шашны ариун судар-орч) судрыг сайн мэдэх хэрнээ Алдрын Эзэн тэнгэрийг харах чадалгүй байна гэж үү?*

*“Ийм байдал та нарт үл нийцнэ шүү, эрдэмтэн мэргэд ээ! Хэрэв та нар үүнийг үгүйсгэж байгаа юм бол ямар нотолгоогоор Бурханд итгэнэ вэ? Нотолгоогоо дэлгэн харуул...”*

Христийн шашинтнуудад хандаж бичсэн эдгээр захидалдаа Евангели сударт амлагдсан зүйлүүд нь биелснийг Тэрээр зарласан шигээ мөн бусад Ариун Судруудад зөгнөн айлдсан тэр зүйл нь бас биелэгдсэн гэдгийг Мусульманчууд, Иудейчүүд, Зороаструудад хандаж зарласан юм. Тэрээр бүх хүмүүсийг олон янзын сүрэг болон хуваагдаж, олон янзын нөмөрт шахцалдсан Бурханы хонин сүрэг хэмээн нэрлэж тийм байдлаар л хандсан юм. Тэрээр хэлэхдээ, Түүний илгээлт сургаал болбоос Сайн Малчин Бурханы Дуу хоолой бөгөөд Бурхан сайн цагийн эхэнд тарж бутарсан хонин сүргээ нэгэн сүрэг болгож, тэдний хооронд үүссэн аливаа саад тотгорыг арилгаж, “нэг л сүрэг, Нэг л Малчин байх ёстой” хэмээн зарлаж байна гэсэн юм.

## **Шинэ нөхцөл байдал**

Зөнч мэргэдийн дунд Бахауллагийн эзлэх байр суурь бол урьд өмнө нь хэзээ ч байгаагүй өвөрмөц онцлог байр суурь билээ. Учир нь, Түүнийг залран тодрох үед дэлхий ертөнцийн байдал урьд өмнө нь байгаагүй өвөрмөц онцлог байсан юм. Шашин, шинжлэх ухаан, урлаг соёл, соёл иргэншил урт удаан хөгжлийн үйл явцыг туулсны эцэст Эв нэгдлийн сургаалыг хүлээн авахад боловсрон бэлэн болсон юм. Өмнөх зуунуудад ертөнцийн эв нэгдэлд хүрэхэд

саад болж байсан элдэв янзын тотгорууд Бахауллаг тодорсны дараа нурахад бэлэн болж, 1817 онд Бахауллаг мэндэлсний дараа, ялангуяа Түүнийг сургаалаа зарлан тунхаглаж эхэлснээс хойш эдгээр саад тотгорууд гайхалтай хурдтайгаар нурж эхэлсэн юм. Энэ түүхэн баримтын талаар эргэлзэх зүйл үгүй биз ээ.

Өмнөх Зөнч мэргэдийн амьдарч байсан үед дан ганц газар зүйн саад тотгороос болж дэлхий ертөнц нэгдэх боломжгүй байсан билээ. Эдүгээ ийм саад нэгэнт үгүй болсон байна. Хүн төрөлхтний түүхэнд анх удаа гараг дэлхийн хоёр өнцөгт амьдарч байгаа хүмүүс хоорондоо хурдан түргэн харилцаж байна. Өчигдөр Европт болсон явдлыг өнөөдөр дэлхийн тив бүрийн хүмүүс дуулчихсан байна. Өнөөдөр Америкт хийсэн яриа маргааш Европ, Ази, Африкт дуулдана.

Бас нэгэн маш чухал саад тотгор нь хэлний ялгаа байлаа. Гадаад хэлд суралцаж эхэлснээс хойш энэ саад тотгор ихээхэн хэмжээнд арилж, удахгүй олон улсын туслах хэл бий болж, дэлхийн бүх сургуулиудын хөтөлбөрт орно гэж таамаглах шалтгаан байгаа билээ. Тэр цагт энэ саад бүр мөсөн устана.

Гурав дахь саад тотгор бол шашин хоорондын үл эвлэрэх хандлага, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах үзэл юм. Энэ саад тотгор ч бас арилж эхэлж байна. Хүмүүсийн сэтгэлгээ илүү нээлттэй болж, боловсрол явцуу санваартан нарын гараас мултран бие дааж байна. Хамгийн хязгаарлагдмал явцуу хүрээнд ч хүртэл шинэ, илүү чөлөөтэй үзэл санаа нэвтэрч чадаж байна.

Тийм учраас Бахаулла бол өөрийн сургаалыг харьцангуйгаар цөөн хэдхэн жилийн дотор гараг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж чадсан анхны агуу Зөнч мэргэн юм. Маш богинохон хугацаанд Бахауллагийн амин чухал сургаал нь Өөрийнх нь эх хэлнээс олон янзын хэл рүү орчуулагдаж, эрэгтэй эмэгтэй, хүүхэд том хүнгүй дэлхийн бүх хүнд хүртээлтэй болсон юм.

### **Бахай Үүдэл нээлтийн бүрэн дүүрэн чанар**

Бахайн Үүдэл нээлт нь дэлхийн бусад шашин шүтлэгийн дотроос юугаараа өвөрмөц онцлог чанартай вэ гэвэл, түүний эх

бичмэл, судар номууд нь бүрэн бүтэн байдлаараа хадгалагдсан явдал билээ. Христ, Моисей, Зороастр, Будда, Кришна нарын үгийг тэмдэглэсэн гэгдэх судар номууд нь маш цөөн байдаг агаад орчин үеийн бодит амьдралаас урган гарах олон асуудлуудад хариу өгч чаддаггүй юм. Эдгээр шашны үндэслэгч нарыг хэлсэн гэгдэх зарим үгсийг хожим нь гажуудуулан, жинхэнэ утгаас нь өөрчилсөн нь илт байдаг. Мусульманчуудын хувьд гэвэл, тэд Коран болон бусад судруудынхаа ачаар Зөнч мэргэн Мухаммедын амьдрал сургаалын талаар (Мухаммед болон Түүний хутагт шавь нарын ихэнх нь бичиг үсэггүй байсан хэдий ч) илүү өргөн эх сурвалжтай юм. Мухаммедын сургаалыг тэмдэглэн түгээхэд ашиглаж байсан арга барил нь олон талаараа хангалттай бус байсан учраас зарим үгс нь жинхэнэ утгаараа тэмдэглэгдсэн эсэх нь эргэлзээтэй юм. Үүний улмаас судар номыг олон янзаар тайлбарлаж, хоорондоо зөрчилтэй олон янзын үзэл бодол үүссэнээс хагарал бутрал гарч, Исламын шашин өмнөх бусад шашнуудын адил олон бүлэглэл болон хуваагдсан билээ.

Харин нөгөө талаас Баб, Бахаулла нар хоёулаа уран яруу, хүчирхэг хэлээр арвин их сургаал номлолыг бичиж үлдээсэн юм. Хоёулаа олон нийтээс тасархай, амьдралынхаа ихэнх хугацааг шоронд өнгөрүүлсэн тул (Өөрсдийн Ариун үүргийг тунхагласны дараа) ихэнх цагаа сургаал бичихэд зориулж байсны ачаар Бахай Үүдэл нээлт нь урьд өмнө шашны түүхэнд үзэгдэж байгаагүй тийм их жинхэнэ эх сурвалжит судар номуудтай болсон юм. Урьдын үүдэл нээлтэнд бүрхэг бүүдгэр байдлаар дурдсан олон үнэнийг тод тодорхой, бүрэн дүүрэн хэлээр тайлбарлаж, бүх Зөнч мэргэдийн ухуулан айлдаж байсан мөнхийн сургаал зарчмуудыг өнөөгийн ертөнцөд бий болсон, урьд өмнө нь хэзээ ч үзэгдэж байгаагүй их бэрхшээлтэй олон асуудлуудыг шийдэхэд ашиглах талаар зааж сургасан юм. Үүдэл нээлтийн жинхэнэ эх сурвалж нь ийм бүрэн төгс хэлбэрээр хадгалагдан үлдсэн явдал ирээдүйд үл ойлголцох явдал шинээр гарахаас урьдчилан сэргийлж, урьдын зуунуудад хагарал бутрал үүсгэж байсан хуучны үл ойлголцох явдлыг арилгах нь илэрхий билээ.

## Бахайн Гэрээс

Бахайн Үүдэл нээлт өөр нэгэн шинжээрээ бусдаас өвөрмөц онцлогтой юм. Бахаулла нас барахынхаа өмнө өөрийн бичмэл сургаалд өөрийн ууган хүү Абдул-Бахаг “*Мөчир*”, “*Хамгаас Агуу Мөчир*” гэж нэрлээд, түүнийг өөрийн залгамжлагч болон, өөрийн сургаалыг тайлбарлагчаар томилсон Гэрээслэлийг бичсэн бөгөөд түүндээ Абдул-Бахагийн өгсөн аливаа тайлбарыг Бахауллагийн Үгийн адил эн тэнцүү хүлээн зөвшөөрөх ёстой гэж захисан юм. Тэрхүү “*Хүсэл зориг ба Гэрээслэл*”-дээ Бахаулла ийнхүү айлджээ:

*“Хамгаас Ариун Судартаа Бидний нээн туурвисан тэр зүйлийг бодож санагтун: “Миний ахуйн тэнгис далай ширгээж, Миний Үүдэл нээлтийн Судар дуусахад нүүр царайгаа Бурханаас болгоосон, энэхүү Өнө эртний Үндсээс мөчирлөсөн Түүн рүү хандуулагтун.” Энэхүү ариун шад мөрт дурдсан нь Хамгаас Хүчирхэг Мөчирөөс өөр хэн ч биш юм (Абдул-Баха)”*

“*Мөчрийн Бичиг*”-гээ Бахаулла Абдул-Бахагийн байр суурийн талаар ингэж айлдсан байна:

*“Хүмүүс ээ, Түүнийг тодрон гарсанд Бурханд талархал өргөгтүн. Учир нь, Тэрээр та нарт заяасан хамгийн агуу Хишиг бөгөөд та нарт олгогдсон хамгийн төгс Буян болой. Түүнийг ачаар салж хугарсан яс болгон эдгэн сэргэнэ. Түүнд хандсан хэн боловч Бурханд хандсантай адил бөгөөд Түүнээс холдсон хэн боловч Миний Гоо үзэсгэлэнгээс холдож, Миний Нотолгоог няцааж, Миний эсрэг нүгэл үйлдсэнтэй адил бөлгөө.”*

Бахауллаг нас барсны дараа Абдул-Баха өөрийн гэрт байхдаа болон аялж явахдаа дэлхий ертөнцийн өнцөг булангаас ирсэн олон янзын үзэл бодолтой хүмүүстэй ярилцах завшаан тохиолдсон билээ. Тэрээр тэдний асуулт, тэдний тулгамдсан асуудал болон няцаалтыг сонсож, бүрэн дүүрэн тайлбар хариулт өгч байсныг нь бичигт тэмдэглэн үлдээсэн юм. Олон жилийн турш Абдул-Баха сургаалуудыг тайлбарлан орчин үеийн амьдралын олон янзын асуудлыг шийдэхэд эдгээр сургаалуудыг хэрхэн ашиглах талаар харуулах янз бүрийн ажлаа үргэлжлүүлсэн билээ. Сүсэгтэн олны дунд гарсан аливаа зөрчил маргааныг Түүнд мэдэгдэж, Тэрээр



тэднийг эрх мэдлээрээ шийдвэрлэж ирсэн тул ирээдүйд гарч болзошгүй үл ойлголцох явдлыг урьдчилан сэргийлж чадсан билээ.

Бахайн үйл хэргийг хамаарч, бүх үйл ажиллагааг нь хянан зохицуулж, хагарал бутралаас хамгаалж, үл ойлгогдох асуудлыг тайлбарлаж, сургаалын анхдагч утга санааг элдэв гажуу ойлголтоос хамгаалах зорилготойгоор дэлхийн нийт Бахайчуудын төлөөлөгчдийн Олон Улсын Шударга Ёсны Ордон байгуулах ёстойг Бахаулла бас захиж үлдээсэн юм. Энэхүү засаг захиргааны байгууллага нь ариун сургаалд дурдаж заагаагүй аливаа асуудлаар хууль тогтоол гаргахын зэрэгцээ өөрийн гаргасан хууль тогтоолыг халж, шинэ нөхцөл байдалд тохируулан шинэчлэх эрхтэй байдаг нь Бахай Шүтлэг ямагт өргөжин, цаг хугацааны шаардлагад нийцэж, яг л амьд бие махбод шиг байнга өөрчлөгдөн нийгмийн хэрэгцээнд тохирч хөгжинө гэдгийг харуулж байгаа юм.

Түүнчлэн ариун сургаалыг албан ёсоор тайлбарлах эрх нь зөвхөн албан ёсны тайлбарлагчид олгогдоно гэж Бахаулла тодорхой заасан билээ. Абдул-Бахагийн “Хүсэл зориг ба Гэрээслэл”-д энэ эрх нь Өөрийнх нь дараа Шүтлэгийн Асран тэтгэгч Шогн Эффендид шилжин ногдсон юм.

Мянгаас мянга гаруй жилийн дараа Бахауллагийн сүүдэр дор бас нэгэн Тодруулагч тодорч, Өөрийн ариун үүргийг хэрэгжүүлэх бөгөөд тэр хүртэл Бахаулла, Абдул-Баха, Асран тэтгэгч нарын сургаал болон Олон Улсын Шударга Ёсны Ордоны шийдвэрүүд нь нийт сүсэгтэн олны хувьд удирдамж чиглэл болж байх юм.<sup>1</sup> Ямар ч Бахай хүн сургаалыг өөр янзаар тайлбарлах юм уу тэнгэрлэг үүдэл нээлт гаргалаа хэмээн сект бүлэглэл үүсгэх эрхгүй билээ. Энэхүү зарлигийг зөрчсөн хэн боловч Гэрээс зөрчигч болох юм.

Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Үйл хэргийн нэгэн дайсан бол Бахауллагийн Үгийг тайлбарлах гэж оролдон өөрийн хүсэлд тохируулан утга санааг нь өөрчилж, өөрийгөө тохируулан дагалдагч нарыг цуглуулж, тусгай бүлэглэл үүсгэн, өөрийн байр суурийг дөвийлгөж, улмаар Үйл хэрэг дотор*

<sup>1</sup> Асран тэтгэгч, Даян Дэлхийн Шудрага Ёсны Ордоны талаар эцсийн бүлэгт илүү дэлгэрэнгүй үзэх болно.

хагарал бутрал үүсгээж буй тэр хүн мөн.” - “Өрнөдийн Од”, 3-р боть, х.8

Бас нэгэн Сургаал бичигтээ Тэрээр бичсэн нь:

*“Эдгээр хүмүүс бол (бутралыг дэмжигчид) дайны гадаргуу дээр цугласан хөөс мэт билээ. Гэрээсийн тэнгис дайнынаас нэгэн давалгаалж, Абха-н Ханлиг улсын хүчээр энэ хөөсийг эрэг үрүү хөөн зайлуула... Хувийн муу санаанаас үүссэн эдгээр үл бүтэх үзэл бодол арилан устана, харин Бурханы Гэрээс бол тогтвортой, аюулгүй үлдэнэ.”* - “Өрнөдийн Од”, 10-р боть, х.95

Хэрэв хүмүүс өөрсдөө хүсвэл шашныг орхиж болно. Энэ талаар Абдул-Баха ийнхүү хэлжээ: *“Бурхан Өөрөө хүнийг оюун санаанлаг болгох гэж албаддаггүй. Хүн чөлөөт сонголт хийх шаардлагатай.”* Энэхүү оюун санааны Гэрээсийн ачаар Бахайн нийгэмлэг дотор явцуу бүлэглэл үүсгэх боломжгүй юм.

### **Мэргэжлийн лам санваартан байхгүй**

Бахай Шүтлэгийн зохион байгуулалтын бас нэгэн онцлогийг энд дурдваас зохилтой бөгөөд энэ нь ямар ч лам санваартан байдаггүй явдал юм. Багш нарын зардалд сайн дураар хандив өргөх явдлыг дэмждэг бөгөөд тэдгээр багш нар Үйл хэргийнхээ ажилд бүхий л цагаа зориулдаг. Гэвч бүх Бахайчууд сургаалыг зааж сургах ажилд өөрсдийн хүч бололцоогоор оролцох ёстой бөгөөд лам хуврагын эрх үүргийг эдэлдэг тусгай хэсэг хүмүүс гэж Бахай Шүтлэгт байдаггүй юм.

Өнгөрсөн үед лам хувраг шаардлагатай байсан нь мэдээж. Учир нь, хүмүүс бичиг үсэгт тайлагдаагүй, харанхуй бүдүүлэг байсан учраас шашны талаар санваартан хүмүүсээс сургаал сонсож, шашны зан үйл, ёслол заншлыг хэрхэн биелүүлэх, хэрхэн шударга ёсыг тогтоох зэрэг олон асуудлаар лам нарын тусламжийг эрдэг байсан юм. Харин одоо цаг үе өөрчлөгдсөн билээ. Боловсрол бүх нийтийн түвшинд түргэн тархаж байгаа бөгөөд Бахауллагийн сургаалыг даган мөрдөх юм бол охид хөвгүүд бүгдээрээ сайн боловсролыг эзэмшинэ. Хүн бүр өөрөө Сургаалыг судалж, Амьдрал хайрлагч Рашаан уснаас өөрөө шавхаж, Оргил

ундрагаас хүртэх боломжтой. Нарийн төвөгтэй ёслол, зан үйлийг гүйцэтгэх тусгай мэргэжлийн анги давхарга Бахай Шүтлэгийн тогтолцоонд байдаггүй агаад шударга ёсыг зохицуулах үүрэг нь тийм зорилгоор байгуулагдсан байгууллагуудад ногдоно.

Хүүхдэд багш хэрэгтэй. Гэвч жинхэнэ багшийн зорилго нь сурагчийг бие даалгаж, өөрийн нүдээр харж, өөрийн чихээр сонсож, өөрийн ухаанаар ойлгоход нь туслах явдал юм. Үүнтэй нэгэн адил хүн төрөлхтнийг нас балчир байх үед лам санваартаа багш нар хэрэгтэй байсан бөгөөд тэдний гол үүрэг нь хүн төрөлхтнийг бие даалгаж, өөрсдийн нүдээр тэнгэрлэг зүйлсийг харж, өөрсдийн чихээр сонсож, өөрсдийн ухаанаар ойлгодог болоход нь бэлтгэх явдал байсан билээ. Одоо лам нар үүргээ гүйцэтгэсэн тул Бахайн багшийн үүрэг бол тэр ажлыг нь төгсгөж, хүмүүс Бурханаас өөр бусад бүхнээс чөлөөтэй, Бурханд, өөрөөр хэлбэл, Бурханы Тодруулагчид өөрсдөө шууд ханддаг болоход нь туслах ёстой юм. Бүгд нэгэн Төвд анхаарлаа чиглүүлсэн цагт сая зөрчил маргаан, үймээн самуун арилах бөгөөд бүгд тэр Төв рүү улам ойртох тусам бие биедээ ч улам ойртоно.

## Есдүгээр бүлэг

# ЖИНХЭНЭ СОЁЛ ИРГЭНШИЛ

*“Аяа, Бурханы хүмүүс ээ! Өөрсдийн хойноос бүү хөөцөлд. Дэлхий ертөнцийн сайн сайхан, улс үндэстнүүдийн боловсролын төлөө сэтгэл санаагаа зориулагтун.” - Бахаулла*

### **Шашиг бол Соёл иргэншлийн үндэс мөн**

Бахайн үзэл баримтлалаар бол хувь хүний болон нийгмийн амьдралын бэрхшээлт асуудлууд нь хэмжээлшгүй их нарийн төвөгтэй тул хүн эгэл жирийн ухаанаар тэдгээрийг зөв шийдвэрлэх чадалгүй юм. Зөвхөн Бүхнийг мэдэгч Бурхан орчлонгийн зорилгыг бүрэн дүүрэн мэдэх агаад тэр зорилгыг хэрхэн хэрэгжүүлэхийг сайн мэднэ. Зөнч мэргэдээрээ дамжуулан Тэрээр хүмүүст хүний амьдралын жинхэнэ зорилго болон хөгжил дэвшлийн зөв Замыг зааж өгдөг юм. Жинхэнэ соёл иргэншлийг бүтээн босгох явдал нь зөнч мэргэн Үүдэл нээлтгийн удирдамжийг үнэнчээр даган мөрдөхөөс шалтгаална.

Бахаулла ингэж айлджээ:

*“Шашиг дэлхий ертөнцийн эмх журам ба бүх бодгаль юмсын амгалан тайван амьдралд хүрэх хамгийн агуу зэмсэг юм. Шашины баганыг доройтуулснаар харанхуй мунхагийг өөгшүүлж, улам давруулан дэвэргэсэн юм. Шашины эрхэм байр суурийг гутаах нь муу санаатнууд улам хайхрамжгүй болоход нь нөлөөлж, эцэст нь эмх замбараагүй байдалд хөтлөнө....*

*“Өрнөдийн хүмүүсийн соёл иргэншлийн талаар бодоод үз. Энэ соёл иргэншил хүмүүсийн дунд үймээн дэгдээж, сэтгэл түгших байдлыг бий болгосныг ажиглаад үз. Муу муухай зэвсэг үйлдвэрлэж, урьд өмнө хэзээ ч үзэгдэж байгаагүй, хэзээ ч сонсогдож байгаагүй тийм харгис хэрцүгийгээр хүн ардын амийг хороож байна. Дэлхийн хүн ардууд Нэг л Шашины сүүдэр дор тодорхой асуудлаар нэгдмэл нэг бодолтой болохоос нааш ийм харгис ширүүн аймшигтай явдлыг өөрчлөх аргагүй билээ.*

*“Аяа, Баха-н хүмүүс ээ! Нээн туурвигдсан Зарлиг сургаал бүхэн болбоос дэлхий ертөнцийг хамгаалах хүчирхэг бат цайз юм.”- Диваажингийн Үгс”*

Европ болон нийт ертөнцийн өнөөгийн байдал олон жилийн өмнө бичсэн эдгээр үгс юутай үнэн байж вэ гэдгийг харуулж байна. Зөнч мэргэн хууль зарлигийг орхигдуулан Бурхангүй явдлыг өөгшүүлснээр эмх замбараагүй байдал, сүйрэл гамшиг нэн аймшигтай хэмжээнд тархсан тул хүний зүрх сэтгэл болон зорилгыг өөрчлөхгүйгээр нийгмийг өөрчлөн байгуулах нь туйлын боломжгүй асуудал юм. Жинхэнэ шашны амин чухал шинж чанар чухамдаа ингэж өөрчлөхөд л оршино.

### Шударга ёс

*“Эрдэнийн Нуугдмал Үгс” хэмээх жижигхэн номондоо Бахаулла зөнч мэргэн сургаалынхаа мөн чанарыг маш товчхон тоймлосон байдаг юм. Түүн доторх анхны зөвлөгөө болбоос хувь хүний амьдралд чиглэсэн сургаал байдаг:*

*“Цэвэр ариун, цэлмүүн найрсаг, цэгээн тунгалаг сэтгэлийг барь.”*

Дараагийн сургаал нь нийгмийн жинхэнэ ёсны амьдралд хамаатай амин чухал зарчмыг илэрхийлсэн байна:

*“Аяа, Оюун санааны үр!*

*Миний үзэлд бүхнээс эрхэмлэдэг зүйлийн дээд нь шударга ёс. Хэрэв Намайг хүсвээс шударга ёсноос нүүрээ бүү буруул, хэрэв Миний итгэлийг эрвээс шударга ёсыг бүү басамжил. Үүний ачаар бусдын нүдээр бус, өөрийнхөө нүдээр бүхнийг үзэж айл хөрийнхөө мэдлэгээр бус, өөрийнхөө мэдлэгээр бүхнийг танин мэдэж чадмуй. Үүнийг зүрх сэтгэлдээ тунгаааж бай. Үнэнхүү, шударга ёс бол чамд Миний барих бэлэг бөгөөд тэр нь Миний хайр өршөөлийн тэмдэг. Түүнийг хоёр мэлмийгээрээ цаг ямагт харж яв.”*

Нийгмийн амьдралын нэн тэргүүний зарчим бол хувь хүмүүс үнэнийг андуурлаас, зөвийг буруугаас ялгаж сурах, аливаа юмыг үнэн байдлаар харах явдал билээ. Оюун санааг болон нийгмийг

сохроулах, нийгмийн хөгжил дэвшилд хамгийн их саад болох зүйл бол хувиа хичээх үзэл юм. Бахаулла ийнхүү айлджээ:

*“Хайхрамжгүй зангийн үрс ээ! Ертөнц болон түүнд орших бүхнийг харахад хүний нүдэнд нимгэхэн талст л саад болдог. Тийм бол зүрх сэтгэлийн мэлмийг шуналт хүслийн зузаан хөшиг таглавал яах вэ гэдгийг бодоод үз!*

*“Аяа, хүмүүс ээ! Шунал тачаал, атаа жэстөөний харанхуй хүний сэтгэлийн гэрлийг яг л нарны туяаг үүл халхалдаг шиг харанхуйлан халхалдаг.”* (Зороастр гаралтай зарим Перс Бахайчуудад хандаж бичсэн нэгэн захидлаас)

Он удаан жилийн туршлагын ачаар хувиа хичээх үзэл бодол, үйл ажиллагаа нь нийгмийг сүйрэлд хүргэдэг агаад хүн төрөлхтнийг үгүй хийхгүйн тулд хүн бүр хөрш андынхаа хүслийг өөрийн хүслийн адил үзэж, өөрийн ашиг сонирхлыг нийт хүмүүн төрөлхтний ашиг сонирхолтой нийцүүлж явах ёстой гэсэн зөвч мэргэн сургаалын үнэнд улам их хүмүүс итгэж байна. Ингэснээр хувь хүний болон нийт нийгмийн ашиг сонирхол нь зүй ёсоор хамгаалагдаж чадна. Бахаулла айлдахдаа:

*“Аяа, хүмүүний үр! Мэлмий тань энэрэл нигүүлсэлд чиглэсэн бол өөрт тань ашигтай зүйлсийг орхиж, харин хүн төрөлхтөнд ашигтай зүйлсээс зуур. Мэлмий тань шударга ёс руу хандсан бол өөртөө сонгох байсан зүйлээ хөрш андаа сонгогтун.”*-  
“Диваажингийн үгс”

## **Засгийн газар**

Бахауллагийн сургаал нь нийгмийн жинхэнэ ёсны эмх журмын талаар хоёр янзын зүйлийг агуулдаг. Нэгдүгээрт, Бахауллагийн амьдарч байх үед оршин тогтнож байсан засгийн газруудын асуудал. Энэ асуудлыг Хаад ноёдод хандаж бичсэн илгээлт бичгүүдэд дурдсан байдаг. Хоёрдугаарт, Бахайн нийгэмлэгийн дотор өсөн хөгжих шинэ эмх журам юм.

Дараах хэсгүүдээс энэ хоёрын огцом ялгаа харагдана. Үүнд:

*“Цорын ганц үнэн Бурхан хүмүүсийн зүрх сэтгэлийг Өөрийн онцгой эзэмшил хэмээн үзэж ирсэн, хэзээд ч үзэх болмой. Түүний*



*Алдар бадартугай. Харин газар нутаг ч бай, далай тэнгис ч бай, эд баялаг ч бай, алдар гавъяа ч бай, бусад бүхнийг Тэрээр газар дэлхийн Эзэн хаад ноёдод даатгасан болой.” “Бахауллагийн Сургаалын Дээжис”, СЦ, х205-206*

*“Энэ Өдөр бүх хүмүүс Нэн Агуу Алдар нэрээс бат зуурч, хүн төрөлхтний эв нэгдлийг тогтоовоос зохилтой. Түүнээс өөр орогнол үгүй, дүрвэх газар ч үгүй билээ.” “Бахауллагийн Сургаалын Дээжис”, Сх 202*

Хэрэв бид “Бага Энх тайван”, “Агуу их Энх тайван” гэж Бахауллагийн айлдсан хоёр зүйлийн ялгааг ажиглаад үзэх юм бол дээрх үгсээс харагдсан хоёр янзын үзэл бодол хоорондоо нийцж буйг ойлгоно. Хаад ноёдод хандаж бичсэн илгээлтэндээ Бахаулла тэднийг хамтдаа нэгдэж, улс төрийн энх тайванд хүрэх арга хэмжээг авч, зэвсгээ хурааж, ядуучуудын хувь тавиланг хөнгөлж, зовлон зүдгүүрийг нь багасгахыг уриалсан байдаг. Гэвч хэрэв тэд цаг үеийн шаардлага хэрэгцээг хангахаас таггалзах юм бол дайн дажин дэгдэж, хуучин эмх журмыг нураах хувьсгал гарна гэдгийг Тэрээр маш тодорхой анхааруулан хэлсэн байдаг. Тиймээс Бахаулла нэг талаас:

*“Өнөөдөр хүн төрөлхтөнд юу хэрэгтэй вэ гэвээс, эрх мэдлийг баригчдад захирагдаж, мэргэн ухааны олс аргамжаанаас үнэнч тууштай зуурах явдал юм.” гэж хэлээд харин нөгөө талаас:*

*Энэ газар дэлхийн хоосон дэмий хээ угалз, чамирхлыг хурааж, Бурханаас огоот татгалзсан хүмүүс бол чухамдаа энэ ертөнцийг ч, ирээдүйн ертөнцийг ч алдсан буюу. Тун удахгүй Хүч чадлынхаа Мутараар Бурхан тэдний эзэмшил хөрөнгийг булаан авч, буян хишигийнхээ дээлийг тэднээс хуу татан авмой... Бид та бүхэнд цаг хугацаа товлосон бөлгөө, Аяа, ард түмнүүд ээ. Товлосон цагт Бурханд хандаж үл чадваас Тэрээр үнэнхүү уур хилэнт мутраа та нар дээр буулган, та нарыг бүхий л талаас уй гашуут зовлон зүдгүүр нөмрөх болмой...Зайлиггүй учрах чичирхийлэл, замбараагүйдлийн шинж тэмдэг эдүгээ илэрсэн байна. Учир нь, өнөө үед ноёрхож буй эмх журам туйлын төгс бус гэдэг нь нотлогдож эхэллээ... Бид газар дэлхий дээрх Чиний ялалтыг баталгаажуулж, Чам руу нүүр царайгаа хандуулах ямар ч хаан*

үл олдох ч гэсэн Өөрийн Үйл хэргийг хүмүүсээс өндөрт өргөмжлөх тангаргийг Бид Өөртөө өргөсөн болой.” “Бахауллагийн Сургаалын Дээжис”, СПх206, СIII х 213, CVIII, х213.СХх 215-216

“Агуу их Бие дэлхий ертөнцийн энх туйх, амар амгалан болон ард түмнүүдийнх нь хөгжил дэвшилийг хангах нөхцлийн тухай айлдахыг хүсэхдээ ингэж бичжээ: Өргөн дэлгэр, бүхнийг хамарсан хүн ардын цугларалт болохын зайлшгүй шаардлагыг даян дэлхийгээрээ ухамсарлах цаг ирэх ёсгой. Дэлхийн хаад тэргүүн нар түүнд оролцож, хүмүүсийн дунд дэлхийн Агуу Энх тайвны үндэс суурийг тавих арга замын талаар харгалзаж, ухаан бодлоо зориулах ёстой юм. Ийм энх тайвныг байгуулахын тулд газар дэлхийн ард түмнүүдийн энх амгалан байдлын төлөө Агуу Хүчнүүд хоорондоо эвлэрэлдэн нэгдэх ёстой билээ. Өөр нэг хааны эсрэг хэн нэгэн хаан зэвсгээ хурцлан дайрч давилаваас бүгд хамтдаа босож, түүнийг зогсоох хэрэгтэй.”- “Бахауллагийн Сургаалын Дээжис”, СХVII х 248

Энэхүү зөвлөгөөгөөрөө Бахаулла Бурханы энэ Өдөр нийтийн үүрэг хариуцлагыг биелүүлэх нөхцөл байдлыг нээсэн юм. Нэг талаас олон улсын эв санааны нэгдлийг уриалж, нөгөө талаас дайн тэмцэл үргэлжилсээр байсан цагт эрх мэдлээ алдана гэж удирдагч нарт анхааруулсан юм. Энэ анхааруулгыг орчин үеийн түүх нэгэнт нотолсон билээ. Өндөр хөгжсөн орнуудад сүйрлийн их гамшгийг авчирсан хөдөлгөөн болон дайн дажин дэгдэж, улмаар аль ч тал нь ялалтанд хүрэх боломжгүй болсноос энэ бүхэн харагдана.

“Та нар Агуу Их Энх тайвнаас татгалзсан бол өөрийн болон харьяат иргэдийнхээ байдлыг ямар нэгэн хэмжээгээр дээшлүүлэхийн тулд Бага Энх тайвнаас бат зуурагтун.” - “Бахауллагийн Сургаалын Дээжис”, СХIX, х254

“Нийт дэлхий ертөнцийг анагаах хучирхэг эм хийгээд хамгийн чадалтай зэмсэг нь болбоос бүх хүн ардууд нэгэн түгээмэл Үйл хэрэг, нэгэн нийтийн Шүтлэгт нэгдэн нийлэхэд оришино хэмээн Эзэн тэнгэрээс захирамжилсан билээ. Үүнийг гагцхүү чадварлаг, хамгаас хүчтэй, онгод билигт Эмчээс өөр хэн ч биелүүлж үл

чадна.” “Бахауллагийн Сургаалын Дээжис”, СХХх 254

Бага Энх тайван гэдэг нь улс орнуудын хооронд улс төрийн эв нэгдэл тогтохыг хэлдэг бол Агуу их Энх тайван гэж оюун санааны, улс төрийн болон эдийн засгийн хүчин зүйлүүдийг хамарсан эв нэгдлийг хэлнэ.

*“Удахгүй өнөөгийн эмх журам хуйлагдан хураагдаж, оронд нь шинэ эмх журам дэвсгэдэнэ.”* “Бахауллагийн Сургаалын Дээжис”, IV х7

Урьдын цагт засгийн газар зөвхөн гадна талын материаллаг асуудлыг л анхаардаг байлаа. Харин өнөөдөр засгийн газраас удирдан манлайлах чадвар, оюун санааны мэдлэг болон биеэ огоорсон зүтгэл шаардагдаж байна. Үүнийг гагцхүү Бурханд мэлхийн харцаа чиглүүлсэн тийм хүмүүс л ёсчлон биелүүлж чадна.

### Улс төрийн эрх чөлөө

Орон нутгийн, үндэсний, олон улсын түвшинд засгийн газарт төлөөлөгчийг сонгох хэлбэрийг Бахаулла хамгийн тохиромжтой хэлбэр гэж үздэг боловч хүмүүс хувь хүний болон нийгмийн хувьд хангалттай өндөр хэмжээнд хөгжсөн тохиолдолд л энэ нь боломжтой болох юм хэмээн өгүүлсэн билээ. Ямар ч боловсролгүй, хувиа хичээсэн, төрийн ажлыг хийх ямар ч туршлагагүй тийм хүмүүст гэнэт бүх эрх мэдлийг олгочих юм бол аймшигтай билээ. Эрх чөлөөг ухаалгаар ашиглаж мэдэхгүй хүмүүст эрх чөлөө олгохоос илүү аюултай зүйл үгүй.

Бахаулла “Китаб-и-Акдас”- таа ингэж айлджээ:

*“Хүмүүсийн оюун ухаан юутай богино гэдгийг бодоод үз. Тэд өөрсдөдөө хортой зүйлийг хүсэн гуйж, тэдэнд ач тустай зүйлээс холдон зайлах юм. Тэд үнэнхүү төөрөгдсөн бөлгөө. Зарим хүмүүс эрх чөлөөг хүсэн мөрөөдөж, түүгээрээ бахархаж буйг харж байна. Ийм хүмүүс бол мунхаг харанхуйн гүнд живсэн хүмүүс болой.*

*Эрх чөлөө нь эцэс сүүлдээ хэн ч унтрааж чадахгүй үймээний галд хүргэдэг болой. Ингээж та нарт Ухаант, Бүхнийг Мэдэгч*

*Бурхан анхааруулж байна. Эрх чөлөөний илэрхийлэл болон түүний бэлгэ тэмдэг нь адгуусан амьтан юм гэдгийг мэдтүгэй. Хүн харанхуй мунхаг байдал, элдэв зальт явуулгаас хамгаалагдаж чадах тийм хүрээ хязгаарт биеэ ᠗вч явбаас зохилтой юм. Эрх чөлөө нь хүнийг ёс суртахууны хэм хэмжээнээс халин, өөрийн мөн чанарыг алдахад түлхдэг. Энэ байдал нь түүнийг туйлын ихээр ялзруулан доройтуулж, хор нүгэлд хүргэдэг. Хамгаалан асрах малчны ивээлд байх шаардлагатай хонин сүрэг гэж хүмүүсийг үзвээс зохино. Энэ бол үнэн, чин үнэн болой. Бид зарим нөхдөл байдалд эрх чөлөөг сайшааж, бусад нөхцөлд буруушаана. Бид үнэнхүү Бүхнийг Мэдэгч билээ.*

*Хэлэгтүн: Жинхэнэ эрх чөлөө нь хүн Миний зарлиг лүндэнд хүлцэхэд оршино, үүнийг чи тун бага ухаарах юм даа. Хүмүүс хэрвээ тэдэнд зориулж Үүдэл нээлтийн Тэнгэрээс Бидний илгээсэн сургаалыг даган мөрдөх юм бол тэд гарцаагүй төгс төгөлдөр эрх чөлөөг олмой. Хамаг амьтдыг гийгүүлсэн Хүсэл зоригийнхоо Тэнгэрээс туурвисан бүхэнд нь Бурханы Зорилгыг ойлгон ухаарсан хүмүүн аз жаргалтай. Хэлэгтүн: Чи чухамхүү Мөнхийн Бурханд бүрэн хүлцэн үйлчилснээр л өөрт ач тустай эрх чөлөөг олж чадна. Ийм эрх чөлөөний тансаг амтыг мэдэрсэн хэн боловч түүнийг дэлхий хийгээд диваажинд ч ноёрхох эрх мэдлээр солихгүй.” “Бахауллагийн Сургаалын Дээжис”, CLIXx334,335*

Хөгжлөөр хоцрогдсон улс үндэстнүүдийн байдлыг сайжруулахад Тэнгэрлэг сургаал анагаах эм нь болж чадна. Эгэл жирийн хүмүүс ч тэр, төрийн албан хаагчид ч тэр эдгээр сургаалыг дагаж мөрдвөөс улс үндэстнүүд өөрсдийн хүлээснээс ангижирч чадна.

### **Удирдагчид ба Албат иргэд**

Бахаулла дарангуйлал мөлжлөгийг хамгийн муу муухай зүйл хэмээн жигшсэн байдаг.

*“Эрдэнийн Нуугдмал Үгс”-д:*

*“Аяа, Замбуулингийн дарлагчид!*

*“Би шударга бусыг нэгээхэн ч өршөөхгүй хэмээн өөртөө*

*андгайлсан тул дарангуйллаа зогсоогтун. Чандлан хадгалдаг Хүрдэндээ буцалтгүй бичиж, Алдрын тамгаараа тамгалсан гэрээслэл минь энэ буюу.”*

*Хууль тогтоомжийг гарган ашиглах эрхийг эдэлсэн тэдгээр хүмүүс нь: “Зөвлөлдөөний олноос чанга атгаж, хүмүүсийн аюулгүй тайван, элбэг хангалуун, амарлингуй жаргалтай амьдралд хүргэх тийм шийдвэрийг гарган хэрэгжүүл. Учир нь үүнээс өөр замаар ажил хэргийг зохицуулбал эв түнжин хагарч, үймээн самуун дэгдэхэд хүргэнэ.”*

**“Ертөнцөд илгээсэн Илгээлт”**

Нөгөө талаас жирийн ардууд хууль тогтоомжийг даган мөрдөж, шударга төр засгаа дээдлэн хүндлэх ёстой юм. Тэд боловсролыг дээдэлж, хүчирхийллээр бус харин сайн үлгэр жишээний хүчээр улс түмнийхээ ажил хэргийг сайжруулах ёстой юм. Бахаулла ингэж айлджээ:

*“Ийм нийгэмлэг оршиж буй улс орон бүхэнд тэд тус орныхоо засгийн газарт үнэнч шударгаар хандаж, түүнд захирагдах ёстой юм.” “Баярт мэдээ”*

*“Аяа, Бурханы хүмүүс ээ! Өөрсдийн биеийг итгэл хүлээсэн сайн сайхан чанараар чимэгтүн. Дараа нь сайн сайхан ажил үйлс, ёс суртахууныхаа ачаар Эзэн тэнгэртээ туслагтун. Үнэнхүү бид тэмцэл зөрчлийг Өөрийн Судар нам, Сургаал бичиг, Илгээлт сургаалдаа хориглосон билээ. Үүгээр бид та нарыг өргөмжлөн хөгжүүлэхийг хүссэн билээ.” - “Ишрагат”*

## **Томилолт ба Тушаал дэвшилт**

Хүмүүсийг ямар нэгэн албан тушаалд томилохдоо тухайн тушаалд хэр нийцэж байгааг нь л анхааран сонгох хэрэгтэй юм. Үүнээс биш ахмад настай байна уу, нийгмийн болон санхүүгийн байр суурь нь хэр вэ, төрөл садны болон найз нөхрийн холбоо зэргийг харгалзах ёсгүй юм.

*“Ишрагат” сургаалдаа Бахаулла ийнхүү өгүүлсэн юм:*

*“Тав дахь Ишраг (Цацраг) болбоос засгийн эрх баригчид албат иргэдээ сайн мэдэж, гавьяа зүтгэлээр нь хүмүүсийг албан зэрэг*

*олгох явдал юм. Удирдагч, дарга хүн бүр энэ асуудлыг хатуу чанд сахих ёстой юм. Ингэснээр хууран мэхлэгчид үнэнч шударга хүмүүсийн зайг эзлэх эсвэл үймээн дэгдээгчид асран халамжлагч нарын суудлыг эзлэх явдал гарахгүй билээ.”*

Эл зарчмыг нийтээрээ даган мөрдөх аваас манай нийгмийн амьдрал гайхалтай ихээр өөрчлөгдөнө гэдэг нь хэнд ч ойлгомжтой билээ. Хүн бүрийг авьяас чадварыг нь харгалзан албан тушаалд томилох юм бол тэр хүн ажилдаа сэтгэлээсээ хандаж, жинхэнэ бүтээлч сэтгэлгээтэйгээр ажиллаж, өөртөө болон дэлхий ертөнцөд ач тус хүртээх болно.

### Эдийн засгийн асуудлууд

Бахайн сургаалд баян ядуугийн эдийн засгийн харилцаанд дорвитой өөрчлөлт хийхийг онцлон заасан юм. Абдул-Баха энэ талаар ингэж хэлсэн байдаг:

*“Ядуурал устаж, хүн бүр өөрийн хэргэм тушаалын дагуу аль болох ая тухтай, хангалуун амьдрах тийм нөхцөл байдлыг бий болгох ёстой. Бидний дунд нэг талаас эд баялгаа даахаа больсон хүмүүс, нөгөө талаас юу ч үгүй өлсөж үхэх шахам амьдарч буй золгүй хүмүүс байна. Зарим нь хэд хэдэн гоёмсог орд харштай байхад зарим нь толгой хоргодох газаргүй байна... Байдал ийм байгаа нь маш буруу тул үүнийг анагаах шаардлагатай. Анагаах ажилд маш анхааралтай хандваас зохино. Амьдралын хэрэгцээг хүмүүст туйлын эн тэнцүү хуваарилснаар анагаахгүй юм. Ижил тэнцүү байдал гэдэг бол хоосон мөрөөдөл! Энэ бол амьдралд нийцэхгүй асуудал. Ижил тэнцүү байдлыг бий болголоо ч гэсэн тэр нь цаашид үргэлжилж чадахгүй бөгөөд тэгш тэнцүү байдал боломжтой байсансан бол дэлхий ертөнцийн бүхий л эмх журам устаж үгүй болно. Хүн төрөлхтний ертөнцөд тогтсон эмх журмын хуулийг дагах ёстой. Чухамхүү диваажин тэнгэр ийнхүү хүн ертөнцөд зарлиг болгосон билээ... Хүн төрөлхтөн цэрэг армийн нэгэн адил дотроо жанжин, хошууч, бага дэслэгч, байлдагч гээд өөр өөрийн үүрэг хариуцлага бүхий хүмүүсээс бүрддэг гэж хэлж болно. Дэг журамтай зохион байгуулалтай*



*байхын тулд зэрэглэл зайлиггүй хэрэгтэй байдаг. Цэрэг арми дан ганц жанжин эсвэл дээрээ ямар ч удирдлагагүй дан ганц цэргүүдээс бүрдэхийн аргагүй...*

*“Зарим нь хязгааргүй баян байхад зарим нь туйлын ядуу байгаа явдлыг хянан сайжруулах нэгэн байгууллага хэрэгтэй. Баялгийг хязгаарлах нь чухлын ажил мөн ядуурлыг хязгаарлах нь маш чухал. Аливаа туйлшрал нь сайнд хүргэхгүй нь ойлгомжтой... Ядуурал туйлдаа хүрч, бүр өсгөлөнд хүргэж байгаа нь хаа нэгэн газар дарангуйлал байна гэсний шинж тэмдэг юм. Энэ явдлын эсрэг хүмүүс тэмцэж, асар олон хүмүүсийн сүйрэлт ядуурлын зовлон гасланд унасан энэ нөхцөл байдлыг нэн даруй өөрчлөх ёстой.*

*“Баячууд элбэг дэлбэг хөрөнгөнөөсөө бусадтай хуваалцаж, зүрх сэтгэлээ ариусгаж, энэрэн нигүүлсэх ёсыг даган, амьдралын наад захын хэрэгцээгээр гачигдан тарчилж байгаа тэдгээр хүмүүст санаа сэтгэл тавих ёстой.*

*“Эд баялаг, шунах хүслийн туйлшралыг хязгаарлах ямар нэгэн тусгай хууль байваас зохино... Улс орнуудын засгийн газрууд бүх хүмүүст тэгш тэнцүү, шударгаар ханддаг Тэнгэрлэг Хуулийг санах хэрэгтэй... Үүнийг хийхээс нааш Бурханы Хууль зүй ёсоор мөрдөгдөхгүй.” - “Парист айлдсан Айлдварууд”, х. 93-94*

## **Нийтийн хөрөнгө санхүү**

Хот тосгон, дүүрэг бүр санхүүгийн асуудлыг өөрийн хүрээнд шийдэж, нийт улс орны зардалд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байх нь зүйтэй гэж Абдул-Баха санал болгосон байдаг билээ. Орлогын нэгэн чухал эх үүсвэр бол хүн амын дэвшингүй орлогын татвар юм. Хэрэв хүний орлого наад захын зардлаас нь хэтрэхгүй байвал тэрээр татвар төлөх ёсгүй юм. Харин орлого нь шаардлагатай зардлаас илүү байх тохиолдолд татвар төлөх ёстой бөгөөд татварын хэмжээ нь орлогын илүүдэл нэмэгдэх тусам нэмэгдэх ёстой байдаг.

Нөгөө талаас хэрэв хүн өвчний улмаас, эсвэл ургац муу байсан ч юм уу өөрөөс нь үл шалтгаалах ямар нэгэн шалтгаанаар зардлаа хийх орлогоо олж чадаагүй бол өөрийгөө болон гэр бүлээ

гэжээхэд дутагдаж байгаа хэмжээний хөрөнгийг улсаас хангах ёстой юм.

Улсын орлогын бусад эх үүсвэр байж болно. Жишээлбэл, гэрээслэл болгон үлдээсэн өв хөрөнгө, уурхай, үнэт олз, сайн дурын хандив гэх мэт. Үүний хажуугаар улсын зардал дотор бас тахир дутуу, өнчин өрөөсөн, хэлгүй дүлий, хараагүй хүмүүсийг тэтгэх, сургууль соёлын газруудыг байгуулах, нийтийн эрүүл мэндийг хангах зэрэгт олгох буцалтгүй тусламж орох ёстой. Ингэснээр бүхний сайн сайхан, тав тухтай амьдралд баталгаажина.

### **Сайн дураар хуваалцах нь**

“Бат бөх энх тайвны төв байгууллага”-д хандаж бичсэн нэгэн захидалдаа Абдул-Баха 1919 онд ингэж хэлж байжээ:

*“Бахауллагийн сургаал дотор хүн төрөлхтний бусад гишүүдтэй өөрийн эд хөрөнгөөс сайн дураар хуваалцах нэгэн сургаал бий. Ингэж сайн дураар хуваалцах нь хуулиар албадсан тэгш эрхээс хавьгүй илүү бөгөөд хүн бусдыг өөрөөсөө илүүд үзэж, бусдын төлөө өөрийн амьдрал ба эд хөрөнгийг золиослоход орших юм. Гэвч үүнийг хүчээр тулгаж, заавал биелүүлэх хууль болгох ёсгүй юм. Үгүй ээ, харин ч хүн Перст байгаа Бахайчуудын адил сайн дураараа, өөрийн хүслээр эд хөрөнгө, амьдралаа бусдын төлөө зориулж, хөрөнгө мөнгөө ядуучуудын төлөө чин сэтгэлээсээ зориулах ёстой юм.”*

### **Бүх нийтийн ажил**

Бахауллагийн эдийн засгийн талаар айлдсан хамгийн чухал нэгэн сургаал бол хүн бүхэн бусдад ашиг тустай ямар нэгэн ажил эрхлэх явдал юм. Хүний нийгэм дотор бусдын хөдөлмөрийг шимэн мөлжигч гэж байх ёсгүй. Тэрээр хэлэхдээ:

*“Хүн бүр ямар нэгэн урлаг, худалдаа наймаа зэрэг ажил мэргээжил эзэмшвээс зохино. Ажил мэргээжил эзэмшихийг бид Цорын ганц Бурханыг сүсэглэн бишрэх үйлтэй эн тэнцүү болгосон болой. Аяа, хүмүүс ээ, Энэрэл нигүүлсэл болон Түүний*

*Ивээл хишигийн талаар тунгаан бясалгаж, өглөө үдэш бүр Түүнд талархал өргөгтүн.*

*“Үнэт цагаа залхуу хойрго байдалд бүү үрэгтүн. Өөрт болон бусдад ашиг тустай зүйлийг эрхлэгтүн. Тэнгэрийн заадсаар нь мэргэн ухаант айлдварын өдрийн од гэрэлтэн туяарч буй Сургаал бичигт ийнхүү айлдсаныг болгоогтүн. Бурханы мэлмийд хамгийн их цээрлэл хүртдэг хүмүүс нь залхууран сууж, гуйлга гуйдаг хүмүүс юм. Материаллаг арга замын чөдөр тушаанд баригдалгүй, бүх л итгэл найдвараа хамаг хэрэгцээг Хангагч Бурхан тэнгэрт даатгагтүн.” - “Баярт мэдээ”*

Өнөөгийн ертөнцөд ажил эрхэлж байгаа хүмүүс үнэт эрч хүчээ бусад хүмүүсийн зүтгэл чармайлтыг сүйтгэн үгүйсгэж, бусадтай тэмцэлдэн өрсөлдөхөд зарцуулж байгаа билээ. Ингэхдээ бас маш хор хөнөөлтэй арга замыг ашиглаж байна! Хэрэв бүх хүмүүс ажиллаж хөдөлмөрлөдөг бол, хэрэв оюуны болон биеийн ажил хөдөлмөр бүр нь Бахауллагийн айлдсаны дагуу хүн төрөлхтөнд ач тустай бол эрүүл энх, тав тухтай, эрхэм сайхан амьдралд хэрэгцээтэй бүхэн хүн бүхэнд хангалттай байх болно. Тэр цагт ядуусын хороолол, өлсгөлөн, гуйланчлал, аж үйлдвэрийн боолчлол, эрүүл мэндэд хортой хүнд хөдөлмөр гэсэн ойлголт үгүй болох билээ.

### **Эд баялгийн ёс зүй**

Бахайн сургаалд зөв замаар олж, зөв зарцуулагдсан эд баялаг бол хүндтэй бөгөөд сайшаалтай гэж заасан байдаг. Хүмүүсийн үзүүлсэн ажил үйлчилгээг зохих ёсоор урамшуулан шагнах ёстой юм. “Таразат” сургаалдаа Бахауллаг ингэж хэлсэн байна:

*“Баха-н хүмүүс хэн нэгэнд зохих ёсны шагнал урамшуулал өгөхөөс татгалзах ёсгүй бөгөөд авьяас чадвартай хүмүүсийг хүндлэх ёстой юм... Хүн шударга ярьж, ашиг тусын үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх ёстой.”*

Мөнгө хүүлэх талаар Бахауллаг “Шрагат” Илгээлт бичигтээ айлдсан нь:

*"Ихэнх хүмүүс энэ асуудлыг шаардлагатай гэж үздэг. Учир нь, ямар ч хүү байхгүй бол наймааны ажил бүтэлгүй болдог ажээ... Өөр нэгэн хүнд "Кард-и-хасан"-ы зарчмаар ("сайн зээл" гэсэн утгатай, хүүгүй, хугацаагүй зээл гэсэн үг) мөнгө зээллүүлэх хүн ховор олдоно. Тиймээс шадар зарц нарын тусын тулд Бид "мөнгө хүүлэх" ажлыг хүмүүсийн дунд буй өнөөгийн бусад ажил хөдөлмөрийн нэгэн адил хүчинтэйд тооцсон юм. Өөрөөр хэлбэл, мөнгийг хүүлэх нь хууль ёсны бөгөөд ариун хөдөлмөр гэсэн үг юм. Гэвч энэ асуудалд хэм хэмжээ, шударга ёсыг баримтлаваас зохино. Алдарын Бийр Өөрийн Ахуйн Мэргэн ухаанаар тунгааж, мөн шадар зарц нарынхаа тусын тулд хэмжээ хязгаарыг Өөрөө тогтоохоос зайлсхийсэн бөлгөө. Бурханы анд нөхөд шударгаар ажиллаасай хэмээн уриалан дууднам. Ингэснээр Түүний хайрт шавь нарын энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэл нь бие биедээ хандах болно...."*

*"Эдгээр асуудлыг зохицуулахыг Шударга Ёсны Ордоны гишүүдэд даатгасан болой. Тэд ингээж зохицуулахдаа цаг үеийн шаардлага хэрэгцээг харгалзаж, шударга ёсыг баримтлаваас зохино."*

### **Аж үйлдвэрийн боолчлолыг таслан зогсоох нь**

*"Акдас" судартаа Бахаулла боолчлолыг халсан бөгөөд Абдул-Баха цааш нь тайлбарлахдаа энэ боолчлолд нь бас аж үйлдвэрийн боолчлол орно хэмээн зааж, аж үйлдвэрийн боолчлол нь Бурханы Хуулийн эсрэг үйл гэж айлдсан билээ. 1912 онд Америкийн Нэгдсэн Улсад аялж байхдаа Тэрээр америкчуудад хандан ингэж өгүүлжээ:*

*"1860 оноос 1865 оны хооронд та нар гайхамшигтай зүйлийг хийсэн. Та нар хүн боолчлох ёсыг халсан. Харин өнөөдөр түүнээс ч илүү гайхамшигт зүйлийг хийх хэрэгтэй. Та нар аж үйлдвэрийн боолчлолыг халах хэрэгтэй..."*

*"Эдийн засгийн бэрхшээлт асуудлуудыг шийдэхэд хөрөнгө хөдөлмөрийн эсрэг, хөдөлмөр хөрөнгийн эсрэг тэмцэх биш,*

*тэмцэл маргаан гаргах биш харин хоёр талаас сайн дураараа сайн санаа өвөрлөх ёстой юм. Тэгсэн цагт жинхэнэ бөгөөд бат бөх шударга ёс тогтоно...”*

*“Бахайчуудын дунд дээрэмдэн тонох, ашиг хонжоо хайх, шударга бусаар хандах, Засгийн газрын эсрэг бослого гаргаж, хувьсгалт эсэргүүцэл илэрхийлэх явдал байдаггүй...”*

*“Ирээдүйд хүмүүс бусдын хөдөлмөрийг мөлжсөнөөр асар их баялаг хуримтлуулах боломж үл олдоно. Эд баялгийг сайн дураар хуваарилан зарцуулах болно. Хүмүүс гэхдээ үүнд аяндаа аажмаар, өөрсдийн хүслээр хүрэх болно. Үүнийг дайн байлдаан, цус асгаруулалтаар биелүүлж үл болно.” - “Өрнөдийн Од”, 7-р боть, 5-р хэсэг, х. 147*

Найрсаг зөвлөлдөөн ба хамтын ажиллагаа, шударга түншлэл, ашгийг тэнцүү хувааж авах зарчмыг дагаснаар хөрөнгө ба хөдөлмөрийн аль алиных нь ашиг сонирхлыг хамгаалж чадна. Ажил хаялт, эсэргүүцлийн хатуу ширүүн тэмцэл нь аж үйлдвэрт эсрэгээр нөлөөлөөд зогсохгүй мөн нийгэмд ч хор хөнөөлтэй. Тиймээс засгийн газрын үүрэг нь маргааныг ийм зэрлэг балмад байдлаар шийдвэрлэх явдлаас урьдчилан сэргийлэх арга зам хайхад оршино. 1912 онд Нью Хемпширын Дублин хотод Абдул-Баха ийнхүү хэлжээ:

*“Одоо би та нарт Бурханы хуулийн талаар ярьж өгье. Тэнгэрлэг хуулийн дагуу ажиллагсдад зөвхөн цалин өгснөөр зогсож болохгүй юм. Харин тэднийг тухайн ажилд түнш болгох хэрэгтэй. Нийгэмчлэлийн асуудал бол маш хүнд асуудал. Үүнийг ажил хаях юм уу цалин нэмэгдүүлснээр шийдэж чадахгүй. Дэлхийн бүх засгийн газрууд нэгдэж, зөвлөл байгуулаад энэ зөвлөлийн гишүүдийг улс орнуудын парламент болон нэр хүндтэй хүмүүсээс сонгоно. Эдгээр гишүүд нь мэргэн ухаан, хүч чадлыг барин нэг талаас хөрөнгөтнүүд асар их алдагдалд унахгүй, нөгөө талаас ажилчид дутагдал гачигдалд орохгүй байх тийм төлөвлөгөөг зохиох хэрэгтэй. Тэд хэм хэмжээг баримтлан хууль тогтоож, ажилчин хүмүүсийн ч тэр, хөрөнгөтөн хүмүүсийн ч тэр эрхийг хамгаалах болно гэдгийг нийтэд зарлах хэрэгтэй. Ийм нэгэн ерөнхий хуулийг тогтоочихоод байхад хоёр талын хүслээр*

*ажил хаялт гарвал дэлхийн бүх засгийн газрууд түүнийг хамтын хүчээр таслан зогсоох ёстой. Эс тэгвээс ялангуяа Европт эмэ нь майх их гай гамшигт хүргэнэ. Аймшигтай зүйл тохиолдоно.*

*†Европын дайны хэд хэдэн шалтгааны нэг нь энэ асуудал юм. 'Эд хөрөнгө, уул уурхай, үйлдвэр байгууламжуудыг эзэмшигч хөрөнгөтнүүд өөрсдийн орлогоос ажилчидтайгаа хуваалцаж, ашигийнхаа тодорхой хувийг ажилчиддаа хуваарилах ёстой юм. Ингэснээр ажилчид нь цалингаасаа гадна үйлдвэрийн нийт ашгаас хувь хүртэж, ажилдаа чин сэтгэлээсээ улам их чармайлттай хандах болно.' "Өрнөдийн Од", 8-р боть, 1-р хэсэг, х. 7*

### **Гэрээслэл ба Өв хөрөнгө**

Хүн өөрийн эд баялгийг амьд сэрүүн үедээ хүссэн байдлаараа зарцуулах эрхтэй гэж Бахаулла айлдсан байдаг. Гэвч хүн бүр нас барахынхаа өмнө гэрээслэлээ үлдээж, түүндээ үлдсэн эд хөрөнгийг нь хэрхэн зарцуулан хуваарилах талаар захих ёстой гэсэн билээ. Хэрэв хэн нэгэн хүн ямар нэгэн гэрээслэл үлдээлгүй нас барсан бол эд хөрөнгийнх нь үнэ цэнийг тодорхойлоод долоон ангид тодорхой хувь хэмжээтэйгээр хуваарилан өгөх ёстой байдаг. Үүнд: талийгаачийн үр хүүхэд, эхнэр буюу нөхөр, эцэг, эх, ах дүү, эгч дүү, багш нь багтана. Эдгээрт олгогдох хувь хэмжээ нь дээрх дарааллаар багасна. Эдгээрээс аль нэг нь үгүй бол тэр хүнд олгогдох ёстой хувь нь нийтийн орлого болж, ядуу зүдүү, өнчин, бэлэвсэн хүмүүст зарцуулагдах юм уу эсвэл нийтийн тустай ажилд зарцуулагдана. Хэрэв талийгаач өв залгамжлах хүнгүй байсан бол бүх эд хөрөнгийг нь нийтийн санд шилжүүлнэ. Бахауллагийн хуульд хүн өөрийн бүх хөрөнгийг нь тодорхой нэгэн хүнд өвлүүлж үлдээхийг хориглосон зүйл байдаггүй. Гэхдээ Бахайчууд өөрсдийн гэрээслэлийг бичихдээ өв хөрөнгөө үлдээх талаар Бахауллагийн гаргасан дээрх загварыг ямагт санаж байх болно.



## Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн Тэгш эрх

Бахауллагийн нийгэмтэй холбоотой хамгийн чухал зарчмын нэг бол эмээпэй хүн эрэгтэй хүний адил эрх эдэлж, адил боловсрол эзэмшиж, амьдралдаа адил боломж бололцоотой байх явдал юм.

Эмэгтэйчүүдийг хөгжүүлэхэд онц шаардлагатай арга зам бол бүх нийтийн боловсрол билээ. Охид хөвгүүд адил боловсрол эзэмших ёстой. Түүгээр ч үл барам охидын боловсрол бол хөвгүүдийн боловсролыг бодвол илүү чухал байдаг. Яагаад гэвэл, охид хожмын хойно эх болох агаад эх хүний хувьд хойч үеийг хүмүүжүүлэгч багш болдог. Хүүхэд багачууд бол яг л нялх ногоо ургамал, мөчир мэт билээ. Хар багаас нь зөв хүмүүжүүлбэл мөчир тэгшхэн ургана. Харин хүмүүжил нь буруу байсан бол мөчир муруй болно. Хүүхэд багадаа ямар хүмүүжил олно том болсон хойноо ч түүний үрийг амсдаг. Тэгэхлээр охидыг ухаалгаар сайтар хүмүүжүүлэх нь ямар чухал вэ гэдэг нь үүнээс харагдана.

Өрнөдийн орнуудаар аялж явахдаа Абдул-Баха олон удаа энэ асуудлаар Бахайн сургаалыг тайлбарладаг байв. 1913 оны 1 дүгээр сард Лондон хотын Эмэгтэйчүүдийн Эрх Чөлөөний Холбооны нэгэн уулзалтан дээр ийнхүү айлдсан байна:

*“Хүн төрөлхтөн бол хоёр жигүүртэй шувуу шиг юм. Нэг жигүүр нь эрэгтэй, нөгөө жигүүр нь эмэгтэй. Хоёр жигүүр хоёулаа хүчтэй хөгжсөөгүй, нэг л хүчээр нэгдээгүй бол шувуу тэнгэрт нисэн дүүлж чадахгүй. Энэ эрин үеийн үзэл санаагаар эмэгтэйчүүд амьдралын бүхий л салбарт өөрсдийн үүргийг гүйцэтгэхийн тулд хөгжин дэвшиж, эрэгтэйчүүдтэй эн зэрэгцэх ёстой билээ. Тэд эрэгтэйчүүдтэй адил түвшинд хүрч, адил эрхийг эдлэх ёстой. Энэ бол Бахауллагийн хамгийн амин чухал зарчмын нэг бөгөөд бас миний чин сэтгэлийн мөрөөдөл юм.*

*“Зарим эрдэмтэд хэлэхдээ, эрэгтэй хүний тархи эмэгтэй хүнийхээс илүү хүнд байдаг тул энэ нь эрэгтэй хүний давуу байдлыг нотлож байна гэдэг. Гэвч бид эргэн тойрноо харах юм бол жижиг толгойтой учраас тархины хэмжээгээр жижиг хүмүүсийг харж, тэд ямар их ухаалаг, ямар их ойлгох чадвартайг нь бишрэнэ. Харин том толгойтой бөгөөд хүнд тархитай бусад*

хүмүүс илүү мунхаг байгаа нь харагдана. Тийм учраас тархины жин хэмжээ нь хүний ухаан, давуу байдлыг тодорхойлох хэмжүүр биш юм.

“Эрэгтэйчүүд өөрсдийн давуу байдлыг нотлохдоо дэвшүүлдэг хоёр дахь учир баримт бол эмэгтэйчүүд эрэгтэйчүүд шиг их амжилтанд хүрч чадаагүй гэдэг. Энэ бол түүхийг ер харгалзан үзээгүй тун хөөрхийлөлтэй учир баримт. Хэрэв тэд түүхийг сохөж харах юм бол, агуу их эмэгтэйчүүд амьдарч, маш агуу зүйлст хүрч байсныг ойлгож, мөн өнөөдөр ч олон тийм эмэгтэйчүүд амьдарч, гайхамшигтай амжилт бүтээлд хүрч байгааг ухаарах болно.”

Абдул-Баха энд Зенобия болон өнгөрсөн түүхийн бусад агуу эмэгтэйчүүдийн амжилт бүтээлийг дүрслэн тайлбарлаад хутагт шавь нарын сүсэг бишрэл ганхаж доройтсон байтал сүсэг бишрэлээрээ аймшиггүй үнэнч хэвээр үлдсэн Мэри Магдаленийг эцэст нь уран яруу хэлээр магтан сайшаасан юм. Тэрээр цааш үргэлжлүүлсэн нь:

“Манай эрин үеийн эмэгтэйчүүд дотор Курратул-Айн хэмээх Исламын нэгэн лам хүний охин бий. Бабыг тодрох үед тэр эмэгтэй туйлын гайхалтай эр зориг, хүч чадлыг харуулж, түүнийг үгийг сонссон хүн бүр гайхаж биширдэг байлаа. Персийн эмэгтэйчүүдийн өнө эртний зан заншлыг үл харгалзан тэрээр нүүрнийхээ гивлүүрийг хуу татан хаясан бөгөөд тэр үед эмэгтэй хүн эрэгтэй хүмүүстэй ярилцах нь бүдүүлэг гэж тооцогддог байсан боловч тэрээр тэр үеийнхээ хамгийн эрдэмтэй мэргэн эрэгтэй хүмүүстэй зоригтойгоор ярилцаж, уулзалт бүрийн үеэр тэрээр тэднийг мэргэн цэцэн ухаанаар ялдаг байсан юм. Персийн засгийн газар түүнийг баривчлан хорьсон билээ. Гудамжаар явж байхад нь хүмүүс түүн үрүү чулуу нүүлгэж, түүнийг буруу номтон хэмээн яллаж, нэг хотоос нөгөөд цөлж, алж тална хэмээн сүрдүүлдэг байсан боловч тэрээр эгч дүү нарынхаа эрх чөлөөний төлөө үйлсдээ хатуу үнэнч хэвээр үлдсэн юм. Тэрээр хяхан хавчилт, зовлон бэрхшээлийг агуу их зориг тэвчээртэйгээр тэсвэрлэж, шоронд байхдаа ч хүртэл хүмүүсийг өөрийн шүтлэгт оруулж байжээ. Персийн шадар сайдын гэрт

хоригдож байхдаа тэрээр: “Та намайг хүссэн аргаараа алж болно, гэвч эмэгтэйчүүдийн хөгжлийг зогсоож чадахгүй” гэж хэлсэн юм. Эцэст нь эмгэнэлт амьдрал нь эцэс болсон юм Түүний цэцэрлэгт авчран боож алжээ. Тэр үед гэвч тэрээр хуримаа хийх гэж байгаа мэтээр хамгийн тансаг гоё хувцсаа өмссөн байв. Тийм их сүр жавхлан, эр зоригтойгоор тэр эмэгтэй амьдралаа өгч, тааралдсан хүн бүрийг гайхуулан бишрүүлдэг байлаа. Тэрээр үнэнхүү агуу баатарлаг эмэгтэй байсан юм. Өнөөдөр Персийн Бахайчуудын дунд хөдлөшгүй зориг хатуужлыг харуулж, яруу найрагчийн агуу уддисыг эзэмшсэн олон эмэгтэй бий. Тэд туйлын уран цэцэн бөгөөд олон хүмүүсийн өмнө үг хэлдэг.

“Эмэгтэйчүүд дэвшин хөгжих ёстой. Тэд шинэслэх ухаан, уран зохиол, түүхийн мэдлэгээ нэмэгдүүлж, хүн төрөлхтний төгс төгөлдөрийг эзэмших ёстой. Удахгүй тэд тэгш эрхээ хүртэнэ. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүд биеэ нэр төртэй авч яваа, иргэний болон улс төрийн амьдралыг сайжруулж байгаа, дайн дажны эсрэг тэмцэж байгаа, эрх тэгш харьцааг шаардаж байгааг нь харан тэдний чадварыг үнэлэн дүгнэх болно. Та нар амьдралын бүхий л үе шатанд дээшлэн дэвших болтугай гэж би хүсч байна. Чингэвээс Мөнхийн алдрын титэм тэргүүнийг тань чимэглэх болно.”

### Эмэгтэйчүүд ба шинэ эрин үе

Эмэгтэйчүүдийн үзэл баримтлалыг зүй ёсоор хүлээн авч, эмэгтэй хүн нийгмийн үйл хэрэгт өөрийгөө зохих ёсоор илэрхийлж эхэлсэн тэр цагт эрэгтэй хүн ноёрхож байсан урьд үед орхигдсон олон асуудлаар, үүнд эрүүл мэнд, хүний зан чанар, энх тайван, хувь хүний амьдралыг үнэлэх зэрэг олон асуудлаар хөгжил дэвшил гарна. Эдгээр салбарт хөгжил дэвшил гарах нь маш өргөн хүрээнд нөлөөлж, асар их ач тусыг бий болгоно. Абдул-Баха хэлсэн нь:

“Өнгөрсөн цагт ертөнцийг хүч чадал эзэгнэж, эр хүн эм хүнийг өөрийн бие махбод болон оюун ухааны дээрэнгүй бөгөөд харгис чанараараа ноёрхож байсан билээ. Гэвч одоо энэ харьцаа

*нэгэнт өөрчлөгдөж, хүч чадал доройтож, эмэгтэй хүнд илүү байх оюун ухааны сонор соргог чанар, сэтгэлийн зөн билиг, хайр ивээл болон буяны оюун санааны чанарууд улам улам дэвжин дээцилж байна. Тиймээс шинэ эрин зуунд эрэгтэй хүний нөлөө багасч харин эмэгтэй хүний үзэл санаа илүүтэй шингэж, тодруулан хэлбэл, соёл иргэншлийн эр, эм элементүүд илүү тэнцвэртэй болно.*”  
“Өрнөдийн Од”, 8-р боть, 3-р хэсэг, х.4

### **Хүчирхийллийн аргуудаас татгалзах нь**

Эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийг хангах болон бусад асуудлыг дэвшүүлэхдээ хүч хэрэглэх аргаас татгалзахыг дагалдагч нартаа Бахаулла уриалсан билээ. Нийгмийг өөрчлөн байгуулах Бахайн арга барилыг Перс, Египет, Сирийн Бахай эмэгтэйчүүд тодоос тод харуулж чадсан юм. Эдгээр орнуудад Мусульман эмэгтэйчүүд гэрээс гарахдаа нүүрээ тагласан нөмрөг өмсдөг аж.<sup>1</sup> Баб шинэ эрин үед эмэгтэйчүүд ийм гутамшигт заншлаас ангжирна хэмээн айлдсан билээ. Харин Бахаулла дагалдагч нартаа зөвлөхдөө, ёс суртахууны хувьд ноцтой зөрчил л байхгүй бол цуг амьдарч байгаа хүмүүсээ хэцүү байдалд оруулахгүйн тулд, мөн бусад хүмүүсийн зүгээс эсэргүүцэлд автахгүйн тулд хүн ардыг гэгээрэх хүртэл тогтсон заншилтэй эвлэрэх хэрэгтэй гэж хэлж байсан юм. Тиймээс Бахай эмэгтэйчүүд хэдийгээр нүүрээ таглах нь соён гэгээрсэн хүмүүст үл нийцсэн заншил гэдгийг ойлгож байсан ч мухар сүсэгтнүүдийн үзэн ядалт, эсэргүүцлийг өдөөхгүйн тулд нүүрээ нийтийн өмнө нээдэггүй юм.

Зан заншилтай ингэж эвлэрч байгаа нь айж эмээсэндээ биш харин боловсролын хүч чадал болон жинхэнэ шашны амьдрал хайрлагч нөлөөлөлд бүрэн итгэж байгаагийн илэрхийлэл юм. Энэ орнуудад амьдарч байгаа Бахайчууд өөрсдийн цаг завьг үр хүүхдүүдийнхээ боловсрол хүмүүжил, ялангуяа охидын хүмүүжил болон Бахайн үзэл санааг хөхүүлэн дэлгэрүүлэх ажилд зориулдаг. Тэд оюун санааны амьдрал хүмүүсийн дунд өсөн дэлгэрэх тусам

---

<sup>1</sup> Ойрхи Дорнодын зарим орнуудад энэ заншил аажим аажимаар мартагдаж байгаа юм. Эдгээр орнуудад Бахай эмэгтэйчүүд нүүрээ халхалсан нөмрөг өмсөх шаардлагагүй болсон юм.

утга учиргүй ийм зан заншлууд хавар болохоор нахиан дотроос цэцэг навч дэлгэрэн гардаг. шиг аажмаар халагдана гэдгийг сайн мэддэг.

## Боловсрол хүмүүжил

Хүмүүсийг сурган хүмүүжүүлж, тэдний дотоод зан чанарыг хөгжүүлэн сайжруулах нь ертөнц үүссэн тэр цагаас хойш бүхий л Ариун Зөнч мэргэдийн эрхэм дээд зорилго байсан бөгөөд Бахайн сургаалд боловсролын ач холбогдол, хязгааргүй их боломж бололцооны талаар маш тодорхой бичсэн байдаг. Багш хүн бол соёл иргэншлийг дэлгэрүүлэх хамгийн хүчирхэг зэмсэг бөгөөд багшийн ажил хамгийн эрхэм дээд үйл юм. Боловсрол хүмүүжил эхийн хэвлийгээс эхэлдэг бөгөөд хүний амьдрал шиг хэзээ ч дуусашгүй зүйл юм. Боловсрол хүмүүжил бол зөв шулуун амьдралын чухал шаардлага бөгөөд хувь хүний ба нийгмийн сайн сайхны үндэс суурь билээ. Зүй ёсны боловсрол хүмүүжил нийтийн хүртээл болж чадвал хүн төрөлхтөн өөрчлөгдөн хувьсаж, дэлхий ертөнц диваажин болон хувирна.

Өнөө үед маш сайхан хүмүүжилтэй боловсролтой хүн гэдэг бол ховор үзэгдэл бөгөөд бараг хүн бүр л ямар нэгэн үл бүтэх атгаг сэжиг үзэл, буруу бодол санаа, ойлголт, муу зуршлыг хар багаасаа олж эзэмшсэн байдаг. Бурханыг зүрх сэтгэлдээ хайрлах, амьдралаа Бурханд зориулах, хүн төрөлхтний тусын төлөө үйлчлэхийг амьдралынхаа хамгийн эрхэм зорилго гэж санаж, бүхний сайн сайхны төлөө өөрийн хүч авьяасыг хөгжүүлэх ёстой гэж бодох тийм үзлээр багаасаа хүмүүжсэн хүн маш цөөхөн байдаг. Гэвч сайн боловсрол хүмүүжил олгох амин чухал элементүүд байна. Тоо бодлого, хэл зүй, газар зүй, хэлний эрдмийг тархиндаа цээжлэх нь хүнийг эрхэм зорилготой, ач тустай амьдралтай болгоход харьцангуй бага нөлөө үзүүлдэг. Бахаулла айлдахдаа боловсрол бүхий л талыг хамарсан байх ёстой гэсэн юм.

*“Эцэг хүн бүр хүүхдүүдээ эрдэм болон сургаал бичигт сурацуулах ёстой хэмээн зарлиг болгосугай... Хэн боловч баян*

*мөртөө энэ зарлиг лүндэнг үл хайхарсан бол Шударга Ёсны Ордоны итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөс хүүхдүүдийнх нь боловсролд шаардлагатай хэмжээний хөрөнгийг түүнээс нэхэмжилсүгэй. Бусад тохиолдолд (хэрвээ эцэг эх нь ингэх чадалгүй бол) Шударга Ёсны Ордонд энэ асуудлыг шийдэх үүрэг ноогдоно. Бид үнэнхүү түүнийг (Шударга Ёсны Ордоныг) ядуу зүдүү, зовж зүдэрснийг халамжлан тэтгэх газар болгосон болой."*

*"Өөрийн болон өрөөлийн хүүхдийг сурган, боловсрол олгосон хэн боловч Миний хүүхдүүдэд боловсрол олгосонтой адил буюу."* - "Ишрагат" Илгээлт бичиг"

*Эрэгтэй эмэгтэй хүмүүс худалдаа наймаа, газар тариалан юм уу бусад ажил төрлөөрөө олж авсан хөрөнгө хөлнийхөө тодорхой хэсгийг итгэлтэй нэгэн хүнд даатган хүүхэд багачуудын боловсрол хүмүүжилд зарцуулах ёстой юм. Тэр даатгасан хөрөнгийг Шударга Ёсны Ордоны итгэмжит төлөөлөгчдийн заавраар хүүхдийн боловсролд зарцуулна."* - "Ертөнцөд илгээсэн Илгээлт бичиг"

## **Төрөлхийн зан чанарын ялгаа**

Бахайн үзэл баримтлалаар бол, хүүхдийн зан чанар нь багшийн хүсэл тааллаар ямар ч хэлбэр хэвэнд ордог баримтлын шавар мэт биш юм. Үгүй ээ, хүн бүр анхнаасаа Бурханаас заяасан зан чанарын онцлогтой бөгөөд түүнийг зөвхөн тодорхой нэгэн замаар л хамгийн сайн тал уруу нь хөгжүүлж чадна. Хүн бүхний хувьд энэ зам нь өөр өөр байна. Яг адилхан авьяас чадвартай адилхан хоёр хүн гэж байхгүй. Тийм учраас сайн хүмүүжүүлэгч хүн бол хоёр хүнд яг адилхан чанарыг эзэмшүүлэх гэж хэзээ ч оролдохгүй. Үнэндээ ийм багш хүн бол ямар нэгэн хэвийг хэн нэгэн хүний зан чанарт хүчээр тохируулах гэж оролдохгүй юм. Харин ч залуу хүүхдийн хөгжиж буй мөн чанарыг эелдэг зөөлөн байдлаар хамгаалан дэмжиж, сайшаан урамшуулж, шаардлагатай оюун санааны тусламж тэжээлийг нь өгнө. Багш хүний ажил бол яг л янз янзын ургамал ногоог арчилдаг цэцэрлэгчийн ажилтай төстэй юм. Нэг ургамал нь нарны туяанд их дуртай бол нөгөө



нь сүүдэрт ургах дуртай байх жишээтэй. Нэг нь усны захад ургаж байхад нөгөө нь хуурай хөрсөнд ургана. Нэг нь элсэн цөлд ургадаг бол нөгөө нь шаварлаг хөрсөнд илүү ургана. Тус бүрийнх нь шаардлага хэрэгцээнд таарч тохируулан арчлах юм бол төгс төгөлдөр байдал нь бүрэн илэрч чадна. Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Боловсрол хүмүүжил нь хүмүүн төрөлхтөнд асар их нөлөө үзүүлдэг гэдгийг Зөнч мэргэд хүлээн зөвшөөрдөг хэдий ч хүмүүс оюун ухаан, ойлгох чадвараараа анхнаасаа өөр өөр байдаг хэмээн тэд хэлдэг. Нас чацуу, нэг үндэстэн, нэг нутгийн, нэг гэрийн хэдэн хүүхэд нэг багшаар заалгасан мөртөө оюун ухаан, ойлгох чадвараараа харилцан өөр байдгийг бид ажигладаг. Гаднах лавай нь хичнээн их боловсорсон байсан ч (өнгөлөгдсөн) хэзээ ч гялалзсан сувд болж чадахгүй. Хар чулуу хэзээ ч дэлхийг гийгүүлсэн үнэт чулуу болж чадахгүй. Өргөстэй ургамал хичнээн их боловсрол хөгжлийг олсон ч адистат мод болж чадахгүй. Өөрөөр хэлбэл, хүмүүжил нь хүний үнэт чулууны жинхэнэ мөн чанарыг хэзээ ч өөрчилж чаддаггүй, гэвч гайхалтай нөлөөллийг үзүүлдэг. Энэхүү агуу хүчээр хүний дотор нуугдмал байсан эрхэм нандин зан чанар, нөөц чадавхи нь нээгдэн хөгжинө.”* “Абдул-Бахагийн Сургаал бичгүүд”, 3-р боть, х. 577

### **Зан чанарыг төлөвшүүлэх нь**

Хамгийн чухал нэгэн зүйл бол хүний зан чанарыг хүмүүжүүлэн төлөвшүүлэх явдал билээ. Үүнд хэлж ярихаасаа илүү эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч, хамт амьдардаг хүмүүсийн үлгэр дуурайл нь хамгийн их чухал үүрэг гүйцэтгэнэ.

Бурханы Зөнч мэргэд бол хүн төрөлхтний агуу сурган хүмүүжүүлэгч нар байдаг бөгөөд тэдний сургаал зөвлөгөө, амьдралынх нь үлгэр дуурайлыг хүүхэд ойлгох насандаа хүрэнгүүтээ оюун ухаандаа шингээж авах ёстой. Ялангуяа ирээдүйн соёл иргэншлийг бүтээн босгох тэр үндэс суурийг нээж өгсөн Дээдийн Дээд Сурган хүмүүжүүлэгч Бахауллагийн үг маш чухал.

Тэрээр айлдсан нь:

*“Алдарын Бийрийн туурвисан сургаалыг хүүхдүүддээ зааж сургагтун. Агуу хүч чадлын тэнгэрээс илгээгдсэн тэр сургаалыг тэдэнд зааж сурга. Энэрэлт Бурханы Илгээлт бичгүүдийг цээжилж, Маширикул-Аскар дотор хамгийн уянгалаг хоолойгоор эгшиглүүлэхэд нь тэдэнд тусал.”* - “Өрнөдийн Од”, 9-р боть, 7-р хэсэг, х.81.

### **Урлаг соёл, шинжлэх ухаан, гар урлал**

Урлаг соёл, шинжлэх ухаан, гар урлал болон бусад ашиг тустай мэргэжилд суралцах нь туйлын чухал бөгөөд шаардлагатай юм. Бахаулла энэ талаар ингэж айлджээ:

*“Боловсрол бол хүний жигүүр агаад түүний хөгжил дэвшлийн шат мөн. Боловсрол олох нь хүн бүрийн үүрэг бөгөөд гэхдээ үгээр эхэлж, үгээр төгсдөг тийм эрдэм ухаан биш харин хүн төрөлхтөнд үр өгөөжөө өгөх тийм эрдэм ухааны мэдлэгийг олох хэрэгтэй юм. Шинжлэх ухаан, урлагийн мэдлэгийг эзэмшигчид нь дэлхийн хүмүүсийн дунд агуу үүргийг гүйцэтгэнэ. Үнэндээ ч, хүний жинхэнэ баялаг нь мэдлэгтээ оршдог. Эрдэм гэдэг нь хүний алдар гавьяа, сайн сайхан хангалуун байдал, баяр бахдал, аз жаргалын нэр юм”* - “Тажаллияат” Илгээлт бичиг

### **Гэмт хэрэгтнийг шийтгэх нь**

Гэмт хэрэгтнийг шийтгэх талаар Абдул-Баха нэгэн яриандаа дараах үгийг хэлжээ:

*“Гэхдээ хамгийн чухал зүйл бол хүмүүс ямар ч гэмт хэрэг үйлдэхээргүй тийм хүмүүжлийг олох явдал юм... Ингэснээр гэмт хэрэг үйлдэх нь тэдний хувьд хамгийн хүнд цээрлэл, хамгийн дээд шийтгэл, зовлон болох юм. Тиймээс, шийтгэл хүлээхүйц гэмт хэргийг хүмүүс үйлдэхээ болино.*

*“Жишээлбэл, хэннэгэн хүн бусдыг дарлан мөлжиж, шархдуулан гэмтээж, эсвэл буруутган хэлмэгдүүлсний төлөө хэлмэгдсэн хүн харуу өгч байгаа бол энэ нь өшөө бөгөөд өршөөгдөшгүй юм...”*

Хэрэв Амр Зайдыг гутаан доромжлоход, Зайд Амрыг хариулан доромжлох ёсгүй. Яагаад гэвэл, хэрэв тэгвэл энэ нь өшөө болох агаад туйлын жигшүүртэй явдал болно. Үүнд гарах цорын ганц ялгаа нь гэвэл, нэг нь эхлээд нөгөө нь сүүлд үйлдэгдсэн явдал юм.

“Харин нийгэм бол өөрийгөө хамгаалах эрхтэй. Цаашилбал, нийгэм нь алуурчныг үзэн ядаж, гадуурхдаггүй. Харин бусдын аюулгүй байдлыг хамгаалахын үүднээс түүнийг шоронд хорин шийтгэдэг.

“Тийнхүү Христ: “Баруун хацар дээр чинь хэн нэгэн хүн алгадвал, зүүн хацраа ч тавьж өг” гэж хэлэхдээ хүмүүсийг битгий хувийн өшөө хонзон авч байгаасай гэж сургасан юм. Хэрэв Чоно хонин сүрэг рүү дайрч, сүргийг устгахыг эрмэлзэж байвал, үүнийг зөвшөөрөх ёстой гэж Тэрээр хэлээгүй билээ. Үгүй ээ, хэрэв Чоно хонин сүрэг дотор нь орж, устган сүйтгэх гэж байгааг Христ мэдвэл үүнийг зогсоох байсан нь гарцаагүй юм...

“Нийгмийн зохион байгуулалт нь ... шударга ёсон дээр тулгуурладаг. Тэгвэл Христ өршөөн уучлах ёстой гэж сургасан нь өөр орныхон танай орныг дайрч, гэр орныг чинь шатааж, эд хөрөнгий чинь булааж, эхнэр хүүхэд, хамаатан садныг чинь алж хороон нэр хүндийг чинь гутааж байвал та эдгээр дээрэнгүй хүмүүсийн өмнө хүлцэнгүй байж, муу муухай үйлдэл хийхийг нь зүгээр хараад зогсоож байх ёстой гэсэн үг биш юм. Үгүй ээ, Христийн хэлсэн сургаал нь хоёр хүн бие биедээ хэрхэн хандах ёстой талаар хэлсэн сургаал юм. Хэрэв нэг нь нөгөөгөө цохих юм бол гэмтээж шархадсан нэг нь нөгөөгөө уучлах ёстой гэсэн үг юм. Харин нийгэм, олон нийт бол хүний эрхийг хамгаалах ёстой... Бас нэгэн зүйлийг энд хэлбээс зохино. Нийгэм өдөр шөнөгүй эрүүгийн хууль тогтоомжийг боловсруулж, залхаан цээрлүүлэх төрөл бүрийн зэвсэг, арга хэрэгсэл бэлдэн зохион байгуулахад цагаа зарцуулж байна. Тэд шорон гяндан барьж, гав гинж хийж, цөллөгийн газруудыг байгуулж, төрөл бүрийн эрүү шүүлтийн арга хэрэгслийг зохиож, үүгээрээ тэд гэмт хэрэгтнүүдийг хүмүүжүүлж чадна гэж бодож байна. Үнэн хэрэгтээ тэд үүгээрээ ёс суртахууныг улам доройтуулж, хүний зан чанарыг гажуудуулж байгаа юм. Нийгэм харин ингэхийн оронд өдөр

*шөнөгүй туйлын их хичээл чармайлттайгаар хүмүүсийг соён гэгээрүүлж, өдрөөс өдөрт шинжлэх ухаан, эрдэм мэдлэгийг нэмэгдүүлж, эрхэм нандин зан чанарыг хүмүүст төлөвшүүлж, ёс суртахууныг хөхүүлэн дэмжиж, нүгэл гэмийг жижгшүүлж, гэмт хэрэг дахин гарахгүй байхын төлөө ажиллах ёстой юм.* ' - "Учир нь тайлагдсан зарим асуудал " х 250-253

### **Сонин хэвлэлийн Нөлөө**

Эрдмийг дэлгэрүүлэх, хүн ардыг соён гэгээрүүлэхэд сонин хэвлэл чухал үүрэгтэй билээ. Зөв чиглүүлэн ашигласан тохиолдолд сонин хэвлэл нь соён гэгээрүүлэх асар их чадалтай гэдгийг Бахаулла хүлээн зөвшөөрсөн билээ. Тэрээр ингэж айлдсан юм:

*"Энэ өдөр газар дэлхийн нууц оньсого тайлагдаж, нүдний өмнө илт тод болжээ. Хурдан гарах сонин хэвлэлийн хуудаснаа ертөнц дэлхий тольдон тусна. Сонин хэвлэл нь янз бүрийн улс үндэстнүүдийн үйл ажиллагааг харуулж, тэдгээрийг дүрслэхийн сацуу бас сонсгож байна. Сонин хэвлэл сонсох, харах, ярих чадвартай толь лугаа адил бөгөөд гайхамшигтай үзэгдэл ба агуу их матери билээ."*

*"Гэвч сонины зохиолч эрхлэгчид ялгаварлан гадуурхах үзэл, хувийн шунал хүслээсээ татгалзан ариусч, тэгш шударга ёсны хээ угалзаар өөрийгөө чимэглэвээс зохилтой. Тэд тухайн асуудлыг аль болох бүрэн дүүрэн судалж, баримт мэдээг үнэн байдлаар нь олж мэдэж, мөн үнэн байдлаар нь бичих ёстой. Энэхүү Хэлмэгдсэн хүний хувьд гэвэл, сонин хэвлэлд нийтэлсэн мэдээлэл ихэнхдээ үнэний хувьгүй байна. Тушаал хэргэмээр өндөр зэрэгт хүрсэн хүн хэл яриагаар шударга, зан чанараар үнэнч бол энэ нь эрдмийн тэнгэрт мандсан наран лугаа адил болно."* - "Таразат" Илгээлт бичиг.

## Аравдугаар бүлэг

### ЭНХ ТАЙВАНД ХҮРЭХ ЗАМ

*“Өнөөдөр энэхүү боол дэлхий ертөнцийг сэргээн амьдруулж, газар дэлхийн гадаргуу дээр оршин буй бүхнийг эв нэгдэлд нэгтгэхээр ирсэн нь гарцаагүй билээ. Бурханы хүсэж таалсан бүхэн биелэх бөгөөд газар дэлхийг та нар Абха-н Диваажин лугаа адил болсныг харах болно.”*

*- Бахаулла “Раист шгээсэн бичиг”*

#### Эв эеийн оронд зөрчил тэмцэл

Өнгөрсөн зууны турш эрдэмтэн мэргэд ургамлын болон амьтны аймаг дахь амьдралын төлөө тэмцлийг судлахад хэмжээлшгүй их цагаа зарцуулсан бөгөөд олон эрдэмтэд байгалийн доод түвшний ертөнцөд түгээмэл жам ёсыг хүний нийгмийн амьдралыг судлахад удирдлага болгон авсан байна. Энэ замаар гэд хүний нийгэмд байгаа өрсөлдөөн тэмцэл нь амьдралын наад захын хэрэгцээ бөгөөд нийгэм дэхь сул дорой гишүүдийг ичгүүр сонжуургүйгээр алж устгах нь улс үндэстнүүдийг цэвэршүүлэн сайжруулахад шаардлагатай арга хэмжээ юм хэмээн бодоход хүрсэн байна. Бахаулла харин бидэнд, хэрэв бид хөгжил дэвшлийн явцад илүү өндөр түвшинд хүрэхийг хүсч байгаа юм бол амьтны аймгаас жишээ авахын оронд харцаа урагш бөгөөд дээш нь чиглүүлж, адгуусан амьтнаас биш харин бидэнд удирдлага хайрласан Зөнч мэргэдээс үлгэр дуурайл авах ёстой хэмээн сургасан юм. Зөнч мэргэдийн бидэнд сургасан эв нэгдэл, эв эе, энэрэх сэтгэлийн зарчим нь амьдралын төлөө адгуусан амьтны тэмцэлд үйлчлэх зарчимтай эсрэг тэсрэг тул хоорондоо эвлэрч үл чадна. Тиймээс бид тэр хоёрын хооронд сонголт хийх ёстой билээ.

Абдул-Баха айлдсан нь:

*“Байгаль ертөнцөд ноёрхдог нэгэн хүч бол амьдралын төлөө тэмцэл билээ. Энэ тэмцлийн үр дүнд хүчтэй нь амьд үлдэнэ. Хүчтэй нь амьд үлдэх энэ хууль бол бүхий л бэрхшээл зовлонгийн эх сурвалж болдог. Энэ бол дайн байлдаан, тэмцэл зөрчих,*

үзэн ядалт, хүмүүс хоородын дайсгалын эх сурвалж болдог. Байгалийн ертөнцөд дарангуйлал, хувиа хичээл явдал, харгислал, мөлжлөг, бусдын эрхийг гадуурхах явдал болон бусад эсрэг үзэгдлүүд нь амьтны аймгийн шинж чанарууд болж байдаг. Тиймээс байгалийн ертөнцийн шаардлага хүмүүний үрсийн дунд чухал байр эзэлсээр байсан цагт амжилт, хөгжил цэцэглэлт боломжгүй юм. Байгаль дайнч, байгаль бол цус сорогч, байгаль бол дарангуйлагч бөгөөд байгаль бол Хүчирхэг Бурханыг үл мэдрэнэ. Тийм учраас эдгээр харгис шинж чанар нь амьтны аймагт ердийн үзэгдэл байдаг билээ... “Тийм учраас хүн төрөлхтний Эзэн тэнгэр агуу их хайр энэрлийг үзүүлж, Зөнч мэргэдээ шгээн тодруулж, Ариун Судар номоо нээн туурвиж, улмаар хүн төрөлхтөн тэнгэрлэг боловсролыг эзэмшсэнээр байгалийн сөрөг үзэгдэл болон мунхаг бүдүүлгийн харанхуйгаас ангижран төгс эрхэм чанар хийгээд оюун санааны шинж төрхийг олж, энэрэнгүй сэтгэлийн эх булаг болоосой хэмээн хүссэн юм...

“Харамсалтай нь, улс үндэстнүүд бие биедээ харанхуй бүдүүлэг тэр үзэл, байж болшгүй зөрчил тэмцэл, дайсгах зарчмыг зуун мянган удаа харуулж, улмаар нийт хөгжил дэвшилээ саатуулан зогсоож байна. Тэнгэрлэг соёл иргэнийлийн зарчмыг бүрэн мартагнаж, Зөнч мэргэдийн сургаалыг үл тоомсорлосноос болж ийм доройтол бий болсон юм.” - “Өрнөдийн Од”, 8-р боть, х. 15

### **Агуу их Энх тайван**

Бүх эрин зуунд Бурханы Зөнч мэргэд “газар дэлхий дээр хүмүүсийн дунд энх тайван, сайн санаа тогтох эрин үе ирнэ” гэж зөгнөн айлдаж байсан билээ. Бахаулла хамгийн гайхамшигтай итгэлтэй үгээр эдгээр зөгнөл айдварыг батлан хэлж, удахгүй биелнэ хэмээн амлаж байсныг бид мэднэ. Абдул-Баха хэлэхдээ:

“Энэхүү гайхамшигт цаг хугацааны мөчлөгт газар дэлхий хувьсан өөрчлөгдөж, хүн төрөлхтөн энх амгалан, гоо сайхан аж төрнө. Маргаан хэрүүл, аллага таллагын оронд энх тайван, үнэн мөн, эв эе ноёрхож, улс орон, ард түмэн, үндэстэн ястнуудын



хооронд хайр ивээл, найрсаг харилцаа бий болно. Хамтын ажиллагаа, эвийн холбоо тогтоож, эцэст нь дайн дажин бүрмөсөн дарагдана... Даян дэлхийн энх тайван өөрийн асрыг газар дэлхийн голд босгож, Амьдралын Адист Мод Өрнө, Дорныг сүүдэрлэх тийм өргөн хүрээнд мөчрөө дэлгэнэ. Хүчтэй, дорой, баян, ядуу, хоорондоо тэмцэлдэгч бүлэглэл, эв түнжигн муутай улс үндэстнүүд чоно хурга, бар шиг, арслан тугал шиг байснаа туйлын хайр, нөхөрлөл, шударга тэгш ёсоор бие биетэйгээ харьцах болно. Дэлхий ертөнц шинжлэх ухаан, ахуйн амьдралын бодит үнэний тухай мэдлэг болон Бурханы тухай мэдлэгээр дүүрэх болно." - "Учир нь тайлагдсан зарим асуудал"

### Шашны ялгаварлан гадуурхах үзэл

Агуу их Энх тайвныг хэрхэн тогтоох талаар илүү тодорхой ойлгохын тулд эхлээд өнгөрсөн цагт дайн дажин юунаас болж үүсэж байсныг судлаад, дараа Бахаулла үүнийг хэрхэн шийдэхийг сапал болгосон талаар үзэцгээе.

Дайн дажин үүсэх хамгийн түгээмэл нэгэн шалтгаан бол шашнаар ялгаварлан гадуурхах үзэл байсан билээ. Бахайн сургаалд энэ талаар хэлэхдээ, янз бүрийн шашин, шашны урсгалуудын хүмүүсийн хооронд үүсч байсан дайсагнал, зөрчил тэмцэл нь ямагт жинхэнэ шашнаас биш харин шашин хэмээн дүр эсгэсэн элдэв янзын худал хуурмаг үзэл, хуулбарлан дуурайх явдал болон буруу ойлголтоос үүсч байсан гэсэн байдаг.

Парист байхдаа айлдсан нэгэн айлдваргаа Абдул-Баха дараах зүйлийг хэлжээ:

"Шашин бол зөн олны зүрх сэтгэлийг нэггээж, газар дэлхийн хөрснөөс дайн дажинг хөөн зайлуулж, бурханлаг шинж чанарыг бий болгож, хүн бүрийн зүрх сэтгэлд амьдрал, гэрэл гэгээг авчрах учиртай. Хэрэв шашин нь бие биеэ үл ойлгох, үзэн ядах сэтгэл болон хагарал бутралын шалтгаан болж байвал тийм шашин байснаас байхгүй нь дээр бөгөөд ийм шашнаас татгалзах нь үнэнхүү бурханлаг үйл болно. Аливаа эмний утга учир нь хэн нэгнийг эмчлэн анагаахад орших нь тодорхой. Харин тухайн эм

*өвчинг улам даамжруулж байвал тийм эмийг хэрэглээгүй байсан нь дээр биз дээ. Хайр ба эв нэгдлийн эх үүсвэр болж чадахгүй шашин бүр шашин биш юм.*” “Парист айлдсан айлдварууд”, х. 78

Тэрээр дахин хэлсэн нь:

*“Хүний түүхийн эхэн үеэс авахуулан өнөөг хүртэл дэлхийн олон шашинуудын дагалдагч нар бие биеэ худал хуурмаг хэмээн буруутгасаар ирсэн билээ. Тэд байнга бие биеэсээ цэрвэж, хоорондоо хөндий хүйтэн, үзэн ядах, дайсагнах харьцааг үүсгэж байсан юм. Шашны дайны талаар бодоод үз... Шашны хамгийн аймшигтай нэгэн дайн болох Загалмайтны аян дайн нь хоёр зуун жил үргэлжилсэн. Заримдаа Загалмайтнууд Мухаммедын дагалдагчдыг алж талж, тонон дээрэмдэж, баривчлан олзолсноо ачаар ялж байв. Харин заримдаа Мусульманчууд ялалтанд хүрч, булаан эзлэгчдийн дунд үхэл, сүйрлийг үүсгэж байв. Тийнхүү тэд хоёр зууны турш дайтаж, нэг бол ширүүн тулалдаж, нэг бол бууж өгч, иймэрхүү байтал Европоос ирсэн фанатик үзэлтнүүд хойноо үнсэн товрог үлдээн эх нутагтаа буцтал өөрсдийнх нь улс орон мөн үймээн самуунд автсан байсан билээ. Энэ бол “Ариун дайн” гэгдэх дайн байлдааны зөвхөн нэг л жишээ юм.*

*“Шашны олон дайн болж байлаа. Христийн шашны протестант бүлэглэлийнхэн болон католик шашинтнуудын хооронд үүссэн тэмцэл дайны улмаас есөн зуун мянган Протестант хүн амь үрэгдсэн билээ... Хичнээн нь шорон гянданд хатаж үхсэн болоо! Олзлогсодод хэрхэн харгис ханддаг байсан болоо! Тэгээд энэ бүхэн шашны далбаан дор болж байсан гээч!*

*“Христийн шашинтан Мусульманчууд, Иудейчүүдийг ад шульмын гаралтай, Бурханы дайснууд хэмээн үзэж байв. Тиймээс тэд Иудейчүүдийг хараан зүхэж, хяхан хавчдаг байв. Үй олон Иудейчүүд алагдаж, гэр орон нь шатаж, үр хүүхэд нь боол болсон билээ. Иудейчүүд ч Христийн шашинтнуудыг буруу номтон хэмээн үзэж, Мусульманчуудыг дайсан бөгөөд Моисейн хуулийг сүйтгэн хорлогч гэж боддог байв. Тийм учраас тэд өшөө хонзонгоо авахыг уриалж, өнөөг хүртэл тэднийг хараан зүхдэг юм.*

*“Дорно зүгт Бахаулагийн гэрэл гэгээ мандахад Тэрээр хүн төрөлхтнийг нэг нэгдмэл болгоно гэж амласан билээ. Тэрээр бүх л хүн төрөлхтөнд хандан: “Та нар бол нэг л модны үр жимснүүд. Хоёр мод гэж байхгүй. Тэнгэрлэг энэрлийн нэг мод бий. Нөгөө нь ад шулмын мод юм.” гэсэн юм... Тийм учраас бид бие биедээ туйлын их хайрыг үзүүлэх ёстой. Бид ямар ч хүнийг ад шулмын хүн гэж үзэх ёсгүй бөгөөд бүх л хүмүүсийг Бурханы шадар зарц нар хэмээн тооцох ёстой. Зарим нь үл мэдэж байгаа тул тэднийг чиглүүлэх сургах хэрэгтэй... Харин зарим нь харанхуй бүдүүлэг байгаа тул тэднийг боловсруулах хэрэгтэй. Зарим нь балчир хүүхдүүд тул буурь суурь суухад нь тэдэнд туслах хэрэгтэй. Зарим нь өвчин эмгэгтэй, тэдний ёс суртахууны байдал туйлын хүнд байгаа тул ёс суртахууныг ариусган анигаах хэрэгтэй. Гэвч өвчтэй хүнийг өвчтэй хэмээн үзэн ядаж болохгүй, хүүхдээс балчир байна хэмээн хөндийрч болохгүй, эрдэм мэдлэггүй байна хэмээн харанхуй бүдүүлэг хүнийг жигшиж болохгүй. Тэднийг сурган хүмүүжүүлж, хайраар туслах хэрэгтэй. Бүх л хүн төрөлхтөн Бурханы ивээл дор туйлын аюулгүй тайван, дээд зэргийн аз жаргалтай амьдрахын тулд чадах бүхнээ хийх ёстой.” “Өрнөдийн Од”, 8-р боть, х. 76*

### **Үндэстэн ястнаар болон улс орноор ялгаварлан гадуурхах үзэл**

Хүн төрөлхтний эв нэгдлийг сургасан Бахайн номлол сургаал нь дайн дажин үүсгэдэг бас нэгэн шалтгаан болох үндэстэн ястнаар ялгаварлан гадуурхах үзлийг үндсээр нь халсан юм. Тодорхой зарим үндэстний хүмүүс өөрсдийгөө бусдаас давуу хэмээн тооцож, “хүчтэй нь дийлнэ” гэсэн зарчмаар бүх юмыг өөрсдөдөө булаан авч, давуу байдлаа ашиглан бусдыг мөлжин, сул дорой үндэстнүүдийг дарлан, тэр ч бүү хэл, устгаж байна. Дэлхийн түүхэнд хар толбо суулгасан явдал нь эл зарчмыг ашиглаж, бусад үндэстнийг дарлан устгасан явдал билээ. Бахайчуудын үздэгээр аль ч үндэстэн ястны хүмүүс Бурханы мэлмийд тэгш тэнцүү юм. Бүгд л өөрийн гэсэн гайхамшигт дотоод чанартай. Харин тэр чанарыг нь хөгжүүлэхийн тулд зохих ёсны боловсрол шаардлагатай байдаг. Улс үндэстэн бүр өөр

үндэстнийг хохироохын оронд нийт хүн төрөлхтний ниймгийн бүх гишүүдийн аж амьдралыг сайжруулахад хувь нэмэр оруулж чадах юм.

Абдул-Баха ингэж хэлсэн байна:

*“Арьсны өнгөөр ялгаварлан үзэх явцуу үзлийг авч үзье. Энэ үзэл бол хоосон төсөөлөл, мухар сүсэг төдий юм. Бурхан биднийг нэг л ард түмэн болгон бүтээсэн... Эрт урьдын цагт мөн газар нутгийг хуваасан хил зааг ч гэж байгаагүй ба газар дэлхийн нэг хэсэг нэг ард түмний эзэмшилд, нөгөө хэсэг нь нөгөө ард түмний эзэмшилд байна гэсэн ялгаа зааг байгаагүй байжээ. Бурханы мэлхийн өмнө янз янзын үндэстэн, арьстан гэсэн ялгаа байдаггүй. Хүмүүс тэгвэл ийм ялгаварлан гадуурхах үзлийг зохион бий болгох ямар хэрэгтэй байсан юм бэ? Хий дэмий төсөөллийн улмаас үүсэн дайныг бид дэмжиж болно гэж үү? Бурхан хүмүүсийг бие биенийгээ алж устгаасай гэж бүтээгээгүй. Бүх л үндэстэн, омог, шашны бүлэглэл, анги давхаргууд Тэнгэрлэг Эцгийнхээ Ивээл хишигийг эн тэнцүү хүртдэг.*

*“Хүмүүсийн хооронд байдаг цорын ганц ялгаа бол Бурханы номонд хэр үнэнч, дуулгавартай байгаа явдал юм. Зарим нь галт бамбар мэт байхад зарим нь хүн төрөлхтний тэнгэрийн од лугаа адил гэрэлтэж байна.*

*“Ямар үндэстэн, итгэл үнэмшил, арьсны өнгөтэйгээс үл хамааран хүмүүн төрөлхтнийг хайрлагч хүмүүс л чухамдаа бусдаас давуу хүмүүс юм.” - “Парист айлдсан айлдварууд”, х. 90-91*

Үндэстэн ястнаар ялгаварлан гадуурхах явцуу үзлийн хажуугаар мөн улс төрийн явцуу үзэл бөгөөд үндсэрхэг үзэл нь мөн адил хор хонөөлтэй юм. Явцуу үндсэрхэг үзлийн оронд дэлхий ертөнцийг нэг улс орон хэмээн үзсэн илүү өргөн хүрээний үндсэрхэг үзэл чухал болоод байна. Бахаулла ийнхүү айлджээ:

*“Эртний сургаалд: “Эх орноо хайрлах хайр бол Бурханы Шүтлэгийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болой” гэж сургасан байдаг. Сүр жавхлангийн Хэл бээр харин Өөрийн тунхаглалын энэ эрин үед ийнхүү айлдаж байна: “Зөвхөн эх орноо хайрладаг*

*хүн өөрөөрөө бахархах ёстой бус харин нийт дэлхий ертөнцийг хайрлан хамгаалдаг хүн л өөрөөрөө бахархах ёстой.”*

*Энэ мэргээн сургаалын хүчээр Тэрээр хүмүүсийн зүрх сэтгэлийн жигүүрт шинэ эрч хүчийг хайрлан, нисэн дүүлэх шинэ замыг зааж өгч, Бурханы ариун Судраас аливаа хязгаарлалтыг арилгасан болой.” - “Ертөнцөд илгээсэн Илгээлт бичиг”*

### **Газар нутаг булаацалдах нь**

Хоёр буюу түүнээс дээш улс орнууд хоорондоо газар нутгаа булаацалдсанаас болж олон дайн гардаг. Эзэмшил хөрөнгөө булаацалдаж, бие биеийнхээ эд хөрөнгөнд шунах явдал бол улс үндэстнүүд төдийгүй хувь хүмүүсийн хооронд тэмцэл хэрүүлийг үүсгэх эх сурвалж болж ирсэн билээ. Бахайн сургаалаар газар нутаг бол хувь хүмүүс юм уу ганц нэг улс үндэстэнд биш харин бүхий л хүн төрөлхөнд хамаатай зүйл юм. Үгүй ээ, газар нутаг ганцхан Бурханых бөгөөд бүх хүмүүс бол тэр газрыг эзэмшигчид нь юм.

Бенгазийн тулалдааны талаар Абдул-Баха ингэж хэлсэн нь бий:

*“Бенгазийн тулалдааны тухай мэдээ зүрхийг минь өвтгөж байна. Хүний харгислал энэ дэлхий дээр орисоор байна гэдэгт би үнэхээр гайхах юм! Өглөөнөөс орой хүртэл бие биенээ алж талан, төрөл нэгт хүмүүсийнхээ цусыг урсгана гэж байж болох уу даа! Тэгээд юуны төлөө гэж тэрвэ! Газрын нэг өчүүхэн хэсгийг эзэмших гэж! Адгуусан амьтад ч хүртэл илүү үнэмшилтэй шалтгаанаас болж хоорондоо эвдрэлцдэг биш билүү? Тэднээс дээд хөгжлийн ертөнцөөс гаралтай мөртөө хэсэгхэн газрын төлөө өөрсдийн адил хүмүүсээ алж талж, зовлон гашууг авчиртлаа өөрсдийгөө гутаасан тэдгээр хүмүүс юутай гутаашиг вэ! Хамаг амьтнаас хамгийн өндөр хөгжилтэй нь хамгийн доод хэлбэрийн матери болох газар шорооны төлөө хоорондоо байлдаж байна!*

*“Газар шороо нь зөвхөн ганц хүний эзэмшил бус бүх л хүмүүний эзэмшил юм шүү. Газар шороо нь хүний орон гэр бус харин түүний були болой...”*

*“Хэн нэгэн байлдан дагуулагч нь хэдий агуу байлаа ч, тэрээр тэдгээр олон сүйрч нурсан газар нутгаас зөвхөн очүүхэн хэсэг болох өөрийн булинаас өөр юуг ч үүрдийн эзэмшилдээ үлдээж үл чадна.*

*“Хэрэв хүн олны аж байдлыг сайжруулж, соёл иргэнийг дэлгэрүүлэх... зорилгод илүү их хэмжээний газар нутаг шаардлагатай болж, мэдээж, нутаг дэвсгэрээ энх тайвны замаар өргөтгөж болох юм. Гэвч дайн дажин бол хувь хүмүүсийн хувийн ашиг сонирхлыг хангахын тулд үүсдэг билээ. Хэдхэн хүний материаллаг ашгийн төлөө тоолж баршгүй олон айлыг зовлон нөмөрч, зуу зуун эрэгтэй эмэгтэй хүмүүсийн элэг зүрх шимширдэг биш үү?...*

*“Сэтгэл зүрхнийхээ бодол санааг хайр ивээл ба эв нэгдэлд зориулагтун хэмээн би та нарын хүн бүрт үүрэг болгож байна. Дайн дажны тухай бодол төрөх аваас түүнийг энх тайвны тухай илүү хүчтэй бодлоор эсэргүүцэгтүн. Үзэн ядах сэтгэл улам хүчтэй хайрлах сэтгэлийн дор унтрах ёстой... Энэ дэлхийн цэргүүд алж талахаар сэлэм зэвсгээ гаргахад Бурханы дайчид гар гараасаа барилцаг! Зүрх сэтгэлийн сэвгүй ариун үнэнч байдлын хүчээр Бурханы нигүүсэл хүмүүний бүх л харгис хэрцгий явдлыг устгаг! Энх тайван бол хүрэх боломжгүй оргил гэж бүү бодогтун. Учир нь Бурханы Гэгээн саруул санаанд боломжгүй зүйл гэж үгүй. Хэрэв та сэтгэлийнхээ гүнээс ертөнцийн бүх л үндэстэн оронтой нөхөрлөхийг хүсэх аваас тэрхүү зөв бодол санаа тань ертөнц даяар түгэн дэлгэрч, бусдын ч хүсэл болж, улам хүч аван өссөөр эцсийн эцэст бүх л хүмүүн төрөлхтний зүрх сэтгэлийг эзэмдэнэ.” - “Парист айлдсан айлдварууд”, х. 10-11*

### **Бүх нийтийн хэл**

Дайн тэмцлийн гол эх сурвалжуудыг судалж, тэдгээрээс хэрхэн зайлсхийх талаар нэгэнт үзсэн бол одоо Агуу их Энх тайванд хүрэхэд шаардлагатай хэмээн Бахауллагаас санал болгосон хэд хэдэн зарчмыг судалж үзье.



Эхний зарчим бол бүх нийтийн туслах хэлийг бий болгох явдал юм. Бахаулла энэ талаар “Акдас” Судартаа болон бусад олон Илгээлт бичигтээ дурдсан байдаг. Тийнхүү “Иирагат” Илгээлт бичигт ингэж бичсэн байна:

*“Зургаа дахь Иираг (Цацраг) болбоос хүмүүсийн хоорондын Эв эе, Эвийн холбоо болой. Эв холбооны гэрэл туяагаар дэлхий ертөнцийн бүс нутгууд бүхий л цаг үед гэгээрэн гийж байсан бөгөөд түүнд хүрэх хамгийн агуу арга замын нэг болбоос бие биеийнхээ бичиг соёл, хэл яриаг ойлгох явдал юм. Үүнээс өмнө Өөрийн Сургаал бичигт Би Шударга Ёсны Ордонь Итгэмжит төлөөлөгч нарт одоо оршин буй аль нэгэн хэлийг сонгох юм уу шинэ хэлийг зохиох, түүнчлэн ийм маягаар бас түгээмэл нэгэн бичиг үсэгтэй болж, дэлхийн бүх сургуулиудад эдгээрийг зааж сурган, улмаар дэлхий ертөнцийг нэгэн нутаг, нэгэн гэр орон мэт болгохыг даатган захирамжлсан билээ.”*

Бахауллагийн энэхүү сургаал анх удаа ертөнцөд хүртээл болоход Польшид Людовик Заменгоф хэмээх нэгэн хүү байсан юм. Тэр хүү дээрх сургаалыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх тавилантай байжээ. Бараг хар багаасаа эхлэн тэрээр бүх нийтийн түгээмэл хэлийг зохиох мөрөөдөлтэй болсон бөгөөд нэр их хөдөлмөрийнхөө үрээр “Эсперанто” хэмээх хэлийг зохиож, тэр хэл олон жилийн сорилтыг давж, олон улсын харилцааны үр дүнтэй хэрэгсэл болохоо нотолсон билээ. Энэ хэлийг сурахад Англи, Франц, Герман хэлийг сурахад шаардлагатай цагийн хорин хувийг л зарцуулахад болно.

Парисын эсперанточдын хүлээн авалтан дээр 1913 оны 2 дугаар сард Абдул-Баха ингэж хэлж байжээ:

*“Өнөө үед Европт зөрчил маргаан гарч байгаагийн нэг гол шалтгаан бол олон янзын хэл-байгаа явдал билээ. Энэ хүн герман, нөгөө нь итали хүн, тэр хүн англи, нөгөө хүн франц гэх мэтчилэн бид ярьдаг. Тэд хэдийгээр нэг л үндэстэн боловч хэлний ялгаанаас болж хоорондоо харилцахад нь саад учирдаг. Хэрэв олон улсын туслах хэл гэж байдаг бол тэд бүгдээрээ нэг л үндэстэн мэт байх болно.*

*Ариун Гэгээн Бахаулла олон улсын хэлний талаар дөч гаруй*

жилийн өмнө бичиж байсан юм. Тэрээр хэлэхдээ, “олон улсын хэл бий болохоос нааш дэлхийн олон янзын хэсгүүд хоорондоо нэгдэж үл чадна, учир нь бид эдгээр үл ойлголцох байдал нь хүмүүс хоорондоо харилцахад нь саад тотгор болдог бөгөөд эдгээр үл ойлголцох явдлыг олон улсын туслах хэлгүйгээр арилгах боломжгүй”

“Ерөнхийд нь яривал, Дорно зүгийн ард түмэн тэр аяараа Өрнөдөд болж буй үйл явдлын талаар бүрэн ойлголт аваагүй байдаг бөгөөд Өрнөдийн хүмүүс ч Дорнын хүмүүстэй харьцан ойр дотно болж чаддаггүй юм. Тэдний бодол санаа хайрцаган дотор хавчигдаж байдаг. Олон улсын хэл тэр хайрцгийг нээх түлхүүр нь болно. Хэрэв түгээмэл нэгэн хэлтэйсэн бол Өрнөдөд хэвлэсэн номнуудыг тэр хэл үрүү амархан орчуулаад дорно зүгийн хүмүүс тэр номнуудыг агуулгыг сайн мэддэг болно. Үүний нэгэн адил дорно зүгт гарсан номнууд тэр хэл рүү орчуулснаар өрнөдийн хүмүүст үр өгөөжөө өгнө. Дорно, өрнө хоёрыг холбои нэгтгэх чухал арга зам бол түгээмэл нэгэн хэлтэй болох явдал билээ. Энэ нь газар дэлхийг нэгэн хамтын нийгэмлэг болгои хувиргана. Энэ нь хүмүүний үрсийн хооронд хайрын эх сурвалж болно. Энэ нь янз бүрийн үндэстэн ястнуудын хооронд найрамдал нөхөрлөлийг авчрах эх үүсвэр болно.

“Доктор Заменгоф<sup>1</sup> “Эсперанто” хэлийг зохиосонд одоо Бурханд талархал өргөө. Энэ хэл нь олон улсын харилцааны хэрэгсэл болох ирээдүйдтэй хэл байна. Энэ хүн ийм сайхан хүчин чармайит гаргасан явдалд бид бүгдээрээ талархах ёстой юм. Учир нь энэ үйлсээрээ тэрээр бусдын тусын төлөө үйлчилжээ. Дэмжигчдийн цуцалтгүй их хөдөлмөр, биеэ огоорсон зүтгэлээр “Эсперанто” хэл бүх нийтийх болж чадна. Тиймээс бид бүхэн энэ хэлийг судалж, аль болох өргөн түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй. Улмаар өдрөөс одөрт энэ хэл улам их хүлээн зөвшөөрөгдөж, дэлхийн бүх улс үндэстэн, орнууд түүнийг баталж, төрийн бүх сургуулиудын хөтөлбөрт орж чадна. “Эсперанто” хэл ирээдүйн олон улсын хурал цуглааны хэл болон батлагдах болтугай хэмээн найдаж байна. Тэгвэл хүмүүс ердөө хоёрхон хэл сурах л

---

<sup>1</sup> Заменгофын охин Лидия идэвхтэй Бахай болсон нь сонирхолтой юм.

*шаардлагатай болно. Нэг нь өөрсдийн төрөлх хэл, нөгөө нь олон улсын туслах хэл. Тэр цагт дэлхийн хүмүүсийн хооронд төгс холбоо үүсэн бий болно. Өнөөдөр янз бүрийн улс түмнүүдтэй харилцах нь юутай хэцүү бэрхшээлтэй байгааг бодоод үз. Хэрэв хэн нэгэн хүн тавин хэл сурсан ч аль нэгэн оронд очоод хэлийг нь мэдэхгүй байж болно шүү дээ. Тийм учраас та нар туйлын их чармайлт гаргаж, “Эсперанто” хэлийг өргөн дэлгэр түгээх болтугай хэмээн би найдаж байна.”*

“Эсперанто” хэлний талаар хэлсэн эдгээр үгс нь тун тодорхой бөгөөд урам хайрласан үгс байна. Гэсэн ч Бахауллагийн заавар удирдамжийн дагуу Шударга Ёсны Ордон уг асуудлаар шийдвэр гаргахаас нааш Бахай Шүтлэг “Эсперанто” юм уу өөр аль нэгэн амьд буюу зохиомол хэлийг бусдаас онцлох ёсгүй юм. Абдул-Баха Өөрөө энэ талаар ингэж хэлжээ:

*“Эсперанто хэлийг зохиоход зориулсан хайр ба хичээл зүтгэл нь талаар өнгөрөхгүй. Гэсэн ч ганихан хүн бүх нийтийн түгээмэл хэлийг зохиож чадахгүй.” “Абдул-Баха Лондонд”, х.95*

Ямар хэлийг сонгох вэ, тэр хэл нь амьд хэл байх уу, эсвэл зохиомол хэл байх уу гэсэн асуудлаар дэлхий улс үндэстнүүд хамтын шийдвэр гаргах ёстой.

## Улс үндэстнүүдийн түгээмэл холбоо<sup>2</sup>

Бахауллагийн ухуулан сургасан бас нэгэн зарчим бол олон улсын энх тайвныг хамгаалах улс үндэстнүүдийн түгээмэл холбоог байгуулах асуудал билээ. Аккагийн шоронд хоригдолд байхдаа<sup>3</sup> Хатан хаан Викторияд хандаж бичсэн захидалд Тэрээр айлдсан нь:

*“Аяа, газар дэлхийн удирдагч нар аа! Хоорондоо эвлэрэн нэгдэгтүн. Чингэвээс өөрсдийн нутаг дэвсгэр, эзэмшил газраа сахин хамгаалах хэмжээнээс хэтэрсэн зэвсэг хураах шаардлага хэрэгцээгүй болно. Бүхнийг Мэдэгч, Үнэнч Түүний зөвлөгөөг ойшоохгүй өнгөрөх вий хэмээн болгоомжлогтун.*

<sup>2</sup> Энэхүү хэсэгт Нэгдсэн Үндэстний Байгууллагын тухай өгүүлсэн юм

<sup>3</sup> 1868-1870

*“Газар дэлхийн Хаад нар аа, нэг нэгдмэл бологтун. Учир нь, чингэснээр та нарын хооронд маргаан зэрчлийн шуурга намдаж, ард түмэн тань амгалан тайвныг олно. Үүнийг та нар ухаартугай. Та нарын аль нэг нь нөгөөгийнхөө эсрэг зэвсгээ далайваас та нар бүгдээрээ түүний эсрэг босогтун. Учир нь, ингэх нь шударга ёсонд нийцэх болой.”* - “Бахауллагийн Тунхаглал”, х. 13

1875 онд Абдул-Баха улс үндэстнүүдийн дэлхий дахины холбоо байгуулагдахыг зөгнөн хэлжээ. Ийм холбоог байгуулах гэсэн цуцалтгүй оролдлого хийгдэж байгаа өнөө үед<sup>1</sup> энэ нь нэн сонирхолтой юм. Тэрээр ингэж бичиж байжээ:

*“Буян зүтгэл, шийдэмгий тэмүүлээрээ өргөн олны дундаас гэрэлтсэн үлгэр дуурайл болсон эрхэм нандин эрмэлзэлтэй, нэр алдар бүхий тодорхой тооны удирдагч нар нийт хүмүүн төрөлхтний сайн сайхан, аз жаргалын төлөө шийдэмгий эр зориг, цэвэр тунгалаг зорилготойгоор Даян Дэлхийн Энх Тайвны Үйл хэргийг тогтоохоор эгцлэн босох тэр үед жинхэнэ соёл иргэнишл туг далбаагаа дэлгэн намуруулах болно. Тэр удирдагч нар энх тайвны үйл хэргийг ерөнхий зөвлөлдөөний сэдэв Болгож, дэлхий улс үндэстнүүдийн хоорондын холбоог байгуулахын төлөө чадах бүхнээ хийх ёстой юм. Тэд бат бөх зөвшилцөл гэрээг байгуулж, уг гэрээний зүйл заалт нь жинтэй, зөрчишгүй бөгөөд тодорхой байх ёстой. Тэд уг гэрээг бүхий л ертөнцөд зарлан тунхаглаж, нийт хүмүүн төрөлхтний дэмжлэг шийдвэрийг олж авах ёстой. Энэхүү эрхэм нандин, дээд үйл хэрэг нь газар дэлхийн бүх оршин суугчдын хувьд ариун хэрэг болох ёстой. Хүн төрөлхтний бүх хүчнүүд Хамгаас Агуу энэхүү гэрээсийн бат бөх, үүрд мөнх чанарыг баталгаажуулахын тулд дайчлагдах ёстой. Энэхүү бүхнийг хамрагч баримт бичигт улс орон бүрийн хүрээ хязгаар, хил заагийг ойлгомжтойгоор тогтоож, засгийн газруудын харилцааг зохицуулах зарчмуудыг тодорхой зааж, олон улсын бүхий л хэлэлцээр, зөвшилцлүүд баталгаажсан байх ёстой. Үүний нэгэн адлаар засгийн газар бүхний зэвсгийн хэмжээг хатуу хязгаарлах ёстой. Учир нь, аль нэгэн орны дайны бэлтгэл, зэвсэгт хүчний хэмжээг нэмэгдүүлэхийг зөвшөөрөх юм бол бусад*

<sup>1</sup> Зохиогч энэ хэсгийг 1919-1920 онд бичжээ.

засгийн газруудын сэжгийг төрүүлж болзошгүй юм. Энэхүү эрхэм баримт бичгийн үндэс суурь нь болсон амин чухал зарчмыг маш тодорхой зааснаар хожим аль нэгэн засгийн газар аль нэгэн заалтыг нь зөрчих аваас бусад бүх засгийн газрууд түүнийг номхруулж, түүгээр ч үл барам, бүх л хүн төрөлхтөн өөрт буй бүх хүчийг ашиглан тэр засгийн газрыг устгахаар шийдвэрлэх ёстой юм. Энэхүү нэн агуу анагаагч эмийг дэлхий ертөнцийн өвдөж шаналсан биенд ашиглаваас ертөнц өвчин эмгэгээсээ ангижирч, үүрд мөнх аюулгүй тайван болох нь дамжиггүй.” - “Тэнгэрлэг Соёл иргэншлийн нууц”, х. 64-65

Дэлхийн энх тайвныг тогтооход амин чухал хэмээн Бахауллагаас айлдсан тэр байгууллагын түвшинд хараахан хүрч чадахгүй байгаа өнөөгийн Улс үндэстнүүдийн Холбооны<sup>1</sup> бүтцэнд олон дутагдал буйг Бахайчууд ажиглаж байна.

1919 оны 12 дугаар сарын 17-нд Абдул-Баха ингэж хэлсэн юм:

“Өнөө үед даян дэлхийн энх тайван бол нэн чухал ач холбогдолтой асуудал боловч уг асуудлын үндэс суурь баталгаажисж, байгуулалт нь бат болж, барилга байгууламж нь бөх болохын тулд ухамсрын нэгдэл бол нэн тэргүүний чухал зүйл юм... Улс үндэстнүүдийн Холбоо бий болсон хэдий ч даян дэлхийн энх тайвныг байгуулах чадал хараахан суугаагүй байна. Гэсэн ч Ариун Гэгээн Бахауллагийн дүрслэн тайлбарласан Дээд Шүүх нь энэхүү ариун үйл хэргийг хэрэгжүүлэхэд туйлын их хүч чадалтай байх болно.”

## Олон улсын шүүх

Маргаан шийдвэрлэх олон улсын шүүхийг байгуулан улмаар улс үндэстнүүдийн хооронд үүсэх аливаа маргаантай асуудлыг шийдэхийн тулд дайн байлдаан хийхийн оронд шударга ёс, учир шалтгаанаар таслан шийдвэрлэх ёстой хэмээн Бахаулла айлдсан билээ.

Мохонкт болсон Олон улсын шүүхийн талаарх Бага хурлын Нарийн бичгийн даргад 1911 оны 8 дугаар сард илгээсэн захидалдаа Абдул-Баха ингэж бичжээ:

*“Одоогоос тавь орчим жилийн өмнө “Акдас” судартаа Бахаулла хүмүүсийг даян дэлхийн энх тайвныг тогтоохыг уриалж, бүх улс түмнүүдийг олон улсын шүүхийн тэнгэрлэг хуралдаанд уриалан дуудаж, улмаар хял хязгаар, үндэсний нэр төр, эд хөрөнгийн асуудлууд болон улс үндэстнүүдийн амин чухал ашиг сонирхлыг шударга ёсны шүүхээр таслан шийдвэрлэж, ямар ч улс үндэстэн гаргасан шийдвэрийг няцаан үгүйсгэх ёсгүй хэмээн зөгнөн айлдсан юм. Хоёр улс орны хооронд ямар нэгэн маргаан гарах юм бол уг маргааныг энэхүү олон улсын шүүхээр хэлэлцүүлж, хоёр хүний хоорондын асуудлыг шүүгчээр шийдүүлдгийн адил шийдвэрлүүлэх хэрэгтэй юм. Аль нэгэн улс орон ямар ч цаг үед ийм нэгэн шийдвэрийг зөрчих аваас бусад бүх улс орнууд энэ эсэргүүцлийг таслан зогсоохын тулд хамтын хүчээрээ босох ёстой юм.”*

Мөн 1911 онд Парист ингэж айлджээ:

*“Дэлхийн улс орон бүрээс сонгогдсон гишүүдээс, улс үндэстэн бүрийн ард түмэн, засгийн газруудаас бүрдсэн Дээд Шүүх байгуулагдах болно. Энэхүү агуу Зөвлөлийн гишүүд эв зөийг хичээн хуран цугларна. Олон улсын шинж чанартай бүхий л маргаан, асуудлыг энэ Шүүхэд дэвшилгүй бөгөөд түүний үүрэг нь дайн үүсэх шалтгааныг зайлуулахад оршино.”* - “Парист айлдсан айлдварууд”, х. 95

Улс үндэстнүүдийн Холбоо байгуулагдахаас бараг хорин таван жилийн өмнө Гаагад Олон улсын байнгын шүүх ажиллаж байсан (1900) бөгөөд олон улсын олон гэрээ хэлэлцээрийг багалж байсан боловч ихэнх нь Бахауллагийн зөгнөсөн тэр шаардлагад бүрэн дүүрэн хүрч чадаагүй юм. Хоёр томоохон гүрний хооронд бүхий л маргаантай асуудлыг хөндсөн ямар ч хэлэлцээр байгуулаагүй билээ. “Амин чухал ашиг сонирхол”, “нэр төр”, “тусгаар тогтнол” зэрэг асуудалтай холбогдсон маргаан зөрчлийг санаатайгаар орхигдуулж ирсэн юм. Түүнээс гадна, баталсан хэлэлцээрт уг хэлэлцээрийн заалтуудыг мөрдүүлэх талаар ямар ч баталгааг оруулаагүй байсан нь харамсалтай. Бахайн сургаалд нөгөө талаас хил хязгаар, үндэсний нэр төр, амин чухал ашиг сонирхлын асуудлуудыг тодорхой багтаасан байх ёстойг



заасан байдаг бөгөөд шүүхийн уг хэлэлцээрүүд нь дэлхийн Улс үндэстнүүдийн Холбооны баталгааг агуулж байх ёстой гэж үздэг. Эдгээр зарчмуудыг бүрэн дүүрэн хэрэгжүүлсэн тэр цагт олон улсын шүүх олон сайхан боломж бололцоогоо нээж, зохих түвшинд хүрч, үүний ачаар дайны аюул бүрмөсөн устана.

### **Зэвсэг хязгаарлах нь**

Абдул-Баха хэлсэн нь:

*“Нэгэн ерөнхий хэлэлцээр зөвшилцлийг хийснээр дэлхийн бүх засгийн газрууд нэгэн зэрэг зэвсгээ хураах ёстой билээ. Нэг нь зэвсгээ хурааж байтал бусад нь хураахаас татгалзвал таарахгүй. Дэлхийн улс үндэстнүүд энэхүү нэн чухал асуудлаар хоорондоо зөвшилцөлд хүрч, ингэснээр хүнийг алж талах хөнөөлт зэвсгээс хамтдаа ангижрах ёстой юм. Нэг улс үндэстэн зэвсгийн хүч, цэрэг дайны зардлаа нэмэгдүүлэх юм бол бусад улс үндэстнүүд ч мөн адил энэхүү галзуу солиотой өрсөлдөөнд жинхэнэ буюу хийсвэр ашиг сонирхлынхоо үүднээс оролцохоос өөр аргагүйд хүрнэ.”* “Мирза Ахмад Сохрабын өдрийн тэмдэглэл”, 1914 оны 5 дугаар сарын 11-14

### **Эсэргүүцэл үзүүлэхгүй байх тухай**

Бахай Шүтлэгтнүүд Бахауллагийн зарлигаар биеэ хамгаалах зорилгоор ч гэсэн өөрсдийн ашиг сонирхлын төлөө зэвсэг биедээ авч явах ёсгүй юм. Перс оронд олон мянган Бабчууд болон Бахайчууд шүтлэгийнхээ төлөө харгис хэрцгийгээр амь насаа алдсан юм. Үйл хэрэг дөнгөж хөгжиж эхлэсэн анхан үед олон тохиолдолд Бабчууд өөрсдийгөө болон гэр бүлийнхнийгээ сэлмийн хүчээр баатарлагаар хамгаалах шаардлага гардаг байсан билээ. Бахаулла гэвч үүнийг хориглосон юм. Абдул-Баха энэ талаар ингэж бичсэн байна:

*“Бахаулла тодрохдоо өөрийгөө хамгаалах зорилгоор ч байтугай ийм арга замаар үнэнийг зарлан тунхаглахыг хориглоно хэмээн айлдсан юм. Тэрээр зэвсгийн хуулийг халж, “Ариун дайн”-ыг хорьсон юм. “Хэрэв чи өөрөө алагдвал, бусдыг алснаас хавьгүй*

дээр буюу” гэж Тэрээр айлдсан юм. Эзэн тэнгэрийн Үйл хэргийг үнэнч шавь нарын хатуу тууштай итгэлээр түгээн цацах ёстой. Үнэнч шавь нар энэ ертөнцийн зүйлсээс харцаа холдуулж, туйлын ангижирсан сэтгэлтэйгээр Бурханы Үгийг өргөмжлөхийн тулд аймшиггүй эр зоригтойгоор эгцэн босоож, Эзэн тэнгэрийнхээ төлөө Түүний хүч чадлын ачаар үйлчлэн зүтгэх аваас тэд Үнэн Үгийн ялалтанд хүрэх болно. Эдгээр адистат хүмүүс өөрсдийн цусаар Үйл хэргийн үнэнийг гэрчилж, өөрсдийн чин сүсэг бишрэл, буян зүтгэл, үнэнч тууштай сэтгэлээр батлан нотлоно. Эзэн тэнгэр Үйл хэргийг түгээн дэлгэрүүлэхэд нь тэдэнд тусалж, үл номхрогчдыг номхруулан дарна. Бид Түүнээс өөр хамгаалагч үл хүснэ, өөрсдийн амь амьдралыг гартаа атган бид дайсныг угтан харж, үхлийг тэврэн авна.” (уг номонд зориулан Абдул-Баха бичив)

Үйл хэргийг эсэргүүцэн хавчигч нэгэн хүнд хандаж Бахаулла дараах зүйлийг туурвижээ:

“Энэрэлт Бурхан минь! Энэ хүмүүст хөнөөх зэвсэг хэрэггүй. Учир нь тэд дэлхий ертөнцийг өөрчлөн байгуулахад өөрсдийгөө зориулам. Тэдний цэрэг хүч болбоос буянт үйлс, тэдний зэвсэг болбоос чиг шулуун төрх байдал, тэдний жанжин болбоос Бурханаас эмээх сэтгэл бөлгөө. Шударгаар шүүн тунгаагч тэр хүмүүн буянаар дэлгэрэг. Бурханы үнэн зөвөөр өчсү! Эдгээр хүмүүсийн тэсвэр тэвчээр, амгалан тайван байдал, даруу хүлцэнгүй сэтгэл хангалуун байдал нь үнэнхүү их тул тэд шударга ёсны шлэрхийлэл болж, тэдний тэсвэр хатуужил үнэнхүү агуу байсан тул тэд алахын оронд өөрсдөө алагдахыг шүүд үзсэн юм. Энэ ямар хүмүүс байсан бэ гэвэл, ертөнц дэлхийгээс хэлмэгдэж, түүхэнд урьд өмнө хэзээ ч тэмдэглэгдэж байгаагүй их, аль ч ард түмэн урьд өмнө нь хэзээ ч үзэж байгаагүй их зовлон зүдгүүрийг амссан хүмүүс билээ! Ийм уй гишүүт зовлон бэрхшээлд хүлцэж, зовлонгоос ангижрах гэж гараа сунган гуйхаас татгалзах тийм их хүчийг чухам хаанаас олно вэ? Ийм хүлцэнгүй, амарлингуй тайван байдал хаанаас гарна вэ? Жинхэнэ шалтгааныг Алдарын Бийрээс өдөр шөнөгүй тавьсан тэр хориг цээрээс, бүх л хүн төрөлхтийг Эзэн тэнгэр Түүний хүч чадлын ачаар хэрэгжүүлсэн Бидний эрх мэдлээс олж харж болмой.”

Бахауллагийн үл эсэргүүцэх бат бөх бодлого нь нэгэнт үр дүнгээрээ батлагдсан билээ. Перс оронд баатарлагаар амь үрэгдсэн сүсэгтэн хүн бүрийн оронд Бахай Шүтлэг зуун шинэ сүсэгтэнтэй болж байсан бөгөөд тэдгээр баатрууд Эзэн тэнгэрийн өлмийд сөгдөн амь амьдралынхаа титмийг таягдан хаяхдаа харуулж байсан тэр их баяр баясгалан бол тэд ямар ч үхлээс айхгүй, тэд тийм сайхан баяр жаргалтай шинэ амьдралыг олж авсан бөгөөд түүнтэй харьцуулах юм бол энэ газар дэлхийн зугаа цэнгэл бол тоос шороо лугаа адил, аймшигт тамлал зовлон бол агаар мандал шиг хөнгөн юм гэдгийг дэлхий ертөнцөд тод томруунаар батлан харуулсан юм.

### Шударга дайн

Христийн адил Бахаулла Өөрийн дагалдагч нарыг хувь хүмүүсийн хувьд ч, хамт олны хувьд ч хорлолыг үл эсэргүүцэх хандлагыг баримталж, дайснаа өршөөхийг айлдан зөвлөсөн хэдий ч шударга бус явдал, дарангуйлал мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх нь нийгмийн үүрэг юм гэж айлдсан билээ. Хэрэв хувь хүмүүсийг хяхан хавчиж, тарчлаан зовоож байвал дайснаа уучлан өршөөж, эсэргүүцэл тэмцлээс зайлсхийх нь тухайн хувь сүсэгтэн хүний эрх юм. Харин нийгэм бүхлээрээ аллага таллага, шударга бус байдлыг зүгээр өнгөрөөж үл болно. Буруу үйлдлээс урьдчилан сэргийлж, гэмт хэрэг үйлдэгсдийг шийтгэх нь сайн засгийн газрын үүрэг.<sup>1</sup> Энэ нь улс үндэстнүүдийн нийт нийгэмлэгт ч хамааралтай. Хэрэв нэг улс нөгөө улсыг хохироож байвал бусад бүх улс үндэстнүүд нийм дарангуйллыг таслан зогсоох ёстой. Абдул-Баха бичихдээ:

*“Зарим тохиолдолд дайнч самуун омгууд хүн олныг нь алан хядахын тулд зэрлэгээр тухайн орон руу дайран давшлаваас улс орноо хамгаалах арга хэмжээ авах нь ... үүрэг болой.”* - “Парист айлдсан айлдварууд”, х.114

Урьдын ёсоор бол аль нэгэн улс өөр нэгэн улсыг дайран давшлавал, бусад улс орнууд дундыг баримтлан сууж, өөрсдийнх

<sup>1</sup> Гэмт хэрэгтнийг шийтгэх тухай 9-р бүлгээс харна уу

нь ашиг сонирхол шууд хөндөгдөх буюу аюулд учирсан тохиолдолд л оролцдог байлаа. Тиймээс дайралтаас хамгаалах бүхий л хариуцлага нь дайралтанд өртсөн улс оронд ногддог байв. Тухайн орон хичнээн сул дорой байсан ч хэнд ч хамаагүй байлаа. Бахауллагийн сургаал энэ байдлыг өөрчилж, аливаа улс орныг хамгаалах хариуцлага зөвхөн тухайн оронд бус мөн бусад бүх оронд тус бүрд нь болон нийтэд нь ногдоно гэж заасан юм. Бүхий л хүн төрөлхтөн болбоос нэг л нийгэм хамт олон учир нэг улс оронд халдвал нийт дэлхийн нийгэмлэгээр халдлагыг таслан зогсоох ёстой юм. Эл сургаал номлолыг нийтээрээ хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөх юм бол нэг улс орон нөгөө улс оронд халдах оролдлого хийхийнхээ өмнө ганцхан улс биш дэлхийн эсэргүүцэлтэй тулгарна гэдгээ урьдчилан мэдэх бөгөөд энэ ухамсар нь хамгийн дайнч самуун улс түмнийг ч тэр дайн байлдаан эхлэхээс сэрэмжлүүлж чадна. Энхийг сахиулагч улс үндэстнүүдийг баг бөх холбоо тогтсон тэр цагт дайн өнгөрсөн цагийн дурсамж болон үлдэнэ. Олон улсын эмх замбараагүй байдлын хуучин нөхцлөөс олон улсын эв санааны нэгдлийн өнөөгийн нөхцөлд шилжих энэ шилжилтийн үед харгис ширүүн дайн бас л гарах нь болзошгүй бөгөөд ийм тохиолдолд олон улсын шударга ёс, эв нэгдэл, энх гайвныг хамгаалах үүднээс цэрэг зэвсгийн нэгдсэн арга хэмжээ авах нь зүй ёсны хэрэг болж болох юм. Абдул-Баха ийм тохиолдлын талаар бичсэн нь:

*“...зарим тохиолдолд дайн бол энх тайвныг тогтоох хүчирхэг үндэс болж, сүйтгэл нь өөрчлөн байгуулалтын арга хэрэгсэл болж болох юм. Жишээлбэл, хэн нэгэн эрхэм зорилготой жанжин хүн харгислагчийн давшилтыг няцаан зогсоох үүднээс өөрийн цэрэг армийг хөдөлгөх юм уу хагарч бутарсан улс орон, ард түмнийг нэгтгэхийн төлөө байлдааны талбарт гавъяа байгуулан шударга үнэний төлөө тэмцвэл уур хилэн мэт санагдаж байгаа тэр зүйл нь угтаа энэрэл нигүүлсэл болж, өнгөн талдаа дарангуйлал мэт харагдаж байгаа зүйл нь угтаа шударга ёсны мөн чанар болж, энэ дайн байлдаан нь энх тайвны түшиг тулгуур болж болох юм. Өнөөдөр агуу удирдагч нарт нийцэн тохирох үүрэг бол даян дэлхийн энх тайвныг тогтоох явдал юм. Учир нь, чухам үүнд л*

хүн ардуудын эрх чөлөө оршино.” - “Тэнгэрлэг соёл иргэншлийн нууц”, х. 70-71

### Өрнө, Дорнын эв нэгдэл

Даян дэлхийн энх тайвныг тогтооход тус болох бас нэгэн хүчин зүйл бол Өрнө, Дорно хоёрыг холбож өгөх явдал билээ. Агуу их Энх тайван гэдэг бол дайсагналыг зогсооход орших төдийгүй мөн урьд өмнө нь алслагдмал байсан ард түмнүүдийн эвийн холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэн, арвин их үр өгөөжийг авчрахад орших юм. Парист айлдсан нэгэн айлдвартаа Абдул-Баха ингэж өгүүлжээ:

*“Урьдын цагт мөн одоо ч гэсэн Үнэний оюун санааны Нар ямагт дорно зүгээс мандаж ирлээ... Моисей дорно зүгт хүмүүст сургаалаа айлдаж тэднийг дагуулж байжээ. Дорнын тэнгэрийн заадсаар мөн Христ Эзэн заларчээ. Мухаммедыг Бурхан мөн л Дорнын ард түмэнд илгээсэн. Баб Дорно зүгт орших Перс нутагт амьдарч байжээ. Бахаулла бас л Дорнодод амьдарч, сургаалаа айлдаж байсан байна. Ингэхлээр шашны бүх л Багш нар Дорнын ертөнцөд ирж байжээ. “Гэвч Христийн Нар Дорно зүгт мандсан боловч энэ Нарны гэрэл туяа нь Өрнөдөд хүрч, тэнд алдрын гэрэл нь улам тод томруун гэрэлтэж байжээ. Христийн Сургаалын тэнгэрлэг гэрэл гэгээ өрнөдийн ертөнцөд илүү хүчтэй гийж, төрсөн газар нутгаасаа тэнд илүү хурдан өсчээ.*

*“Өнөө үед Дорнын ертөнцөд материаллаг хөгжил дэвшил шаардагдаж байгаа бөгөөд харин Өрнөдийн ертөнцөд оюун санааны баялаг дутагдаж байна. Тиймээс Өрнөдийнхэн Дорнын гэгээрлээс хувь хүртэж оронд нь өөрийн шинэжлэх ухааны мэдлэгээ өгвөөс зохино. Ийм бэлэг сэлтээр солилцох хэрэгцээ шаардлага өнөө үед бий болоод байна. Нэг нэгэнтэйгээ ийнхүү хуваалцах нь агуу зохицол, эв эеийг бий болгож, бүх хүмүүс нэгдэж, төгс төгөлдөр чанар цогцлон бүрдэж, хүч төрөлхтний үндэс тулгуур батэсжж, энэ дэлхий ертөнц Бурханы шинэ чанаруудыг тусгах гэрэлт толь болно.*

*“Өрнө, Дорнын ард түмнүүд бид энэхүү агуу зорилгыг биелүүлэхийн тулд өдөр шөнөгүй, үнэн сэтгэлээсээ тэмцээж, газар дэлхийн улс үндэстнүүдийн хооронд эв нэгдлийг цогцлон бий болгох ёстой. Чингэвээс хүн бүрийн зүрх сэтгэл сэргэн булгилж, хүн бүрийн нүд өргөн нээгдэж, хамгийн гайхамшигт хүчин бүрдэж, хүн төрөлхтний аз жаргал баттай болно... Энэ болбоос газар дэлхийд залрах диваажин болох бөгөөд энэ үед бүхий л хүн төрөлхтөн хамтран Алдарын Вант улсын эв нэгдлийн асар дор хамтран цуглах болно.” - “Парист айлдсан айлдварууд”, х.5-6*



## Арван нэгдүгээр бүлэг

### ЯНЗ БҮРИЙН СУРГААЛ НОМЛОЛ

*“Цаг үе, эрин үе бүхэнд тэнгэрлэг бүх номлол сургаал нь тухайн цаг үеийнхээ шаардлага хэрэгцээний дагуу өөрчлөн хувьсдаг, харин Хайрын хууль бол оргил ундрага лугаа адил үргэлж бургшлж байдаг бөгөөд хэзээ ч өөрчлөлтөнд автдаггүй.”*

Бахаулла

#### Сахил хүртсэн амьдрал

Бахаулла Мухаммедын алил Өөрийн дагалдагч нарыг даяанчлан амьдрахыг хориглосон билээ. Гуравдугаар Наполеонд бичсэн Илгээлт бичигтээ Түүний ийнхүү бичсэнийг бид уншна:

*“Хэлэгтүн: Аяа, лам хуврагууд аа! Сүм дуган дотроо бүү хорогдогтун. Миний тааллаар сүм дуган дотроосоо гарч ирэн өөртөө болон бусдад ач тустай үйлсийг бүтээгтүн. Ийнхүү Шүүлтийн Өдрийн Эзэн тэнгэр Тэрээр та нарт зарлиг болгож байна. Миний хайрын бат цайзанд хорогд. Ингээж хорогдох нь та нарт нийцэн тохирох буюу, үүний мэддэг болоосой. Өөрийн байшин гэрт өөрийгөө хорьж байгаа тэр хүн бол үнэнхүү үхдэл лүгээ адил бөлгөө. Хүн бол хүн төрөлхтөнд ач тусаа өгөх зүйлийг хийж бүтээх нь зохистой. Үр жимсээ өгөхгүй байгаа модыг түлшинд хэрэглэхэд таарах буюу. Ийнхүү Эзэн тэнгэр тань захирамжлан тушааж байна. Тэрээр үнэнхүү Хүчирхэг, Буян хишигт билээ. Тиймээс өөрийнхөө дараа үр удмаа үлдээхийн тулд гэрлэгтүн. Бид үнэнхүү садар самууныг та нарт хориглож, үнэнч явдлыг дэмжсэн болой. Харин та нар өөрсдийн дур хүслийг дагаж, Бурханы номыг ардаа орхисон биш үү? Бурханаас эмээж, мунхаг явдлаа орхигтун. Миний газар дэлхий дээр байгаа хүмүүн Намайг санан дурсах юм бол Миний шинж чанар, Миний алдар нэр хэрхэн нээгдэх билээ? Тунгаан бодогтун. Өөрийгөө Түүнээс халхавчаар таглан тусгаарлаж, гүн нойрондоо дугжирч байгаа хүмүүсийн нэг бүү бол. Гэрлээгүй тэр хүмүүн болбоос (Есүс Христ) урван*

*тэрслэгчдийн хавчлагаар амьдрах гэргүй, хорогдох газаргүй байсан юм. Түүний гэгээн чанар та нарын итгээж төсөөлдөг зүйлээс бүрддэггүй, харин Бидэнд хамааралтай зүйлсээс бүрддэг бидээ. Газар дэлхийн бүх хүмүүсийн хоосон төлөөлөөс хавьгүй өндөрт дүүлэх Түүний байр суурийн талаар ойлгохын төлөө залбиран гүй. Ухааран ойлгосон хүмүүс адистай.*”

Христийн шашны зарим бүлэглэлүүд лам санваартан хүн даяанч байх ёстой бөгөөд гэрлэх ёсгүй гэж тогтоосон байдаг. Гэтэл Христ Өөрийн дагалдагч нарыг гэрлэсэн хүмүүс дундаас сонгож байсан бөгөөд Тэрээр дагалдагч нарынхаа хамт Өөрөө буянт үйлсийг идэвхтэй бүтээж, хүн ардтай ойр дотны харилцаа холбоотой байсан нь сонин биш гэж үү?

Коран сударт ингэж бичсэн нь бий:

*“Мэри-гийн хүү Есуст Бид Евангелийг өгч, Түүнийг даган шүтсэн хүмүүст эелдэг зөөлөн, энэрэнгүй сэтгэлийг зүрх сэтгэлд нь хайрласан юм. Харин сахилт амьдралын хувьд гэвэл, тэд түүнийг өөрсдөө зохиосон. Гагцхүү Бурханы таалалд нийцэхийг хүсэхийг л Бид тэдэнд айлдсан боловч тэд түүнийг зүй ёсоор биелүүлсэнгүй.”* (Коран, IVii.27)

Эрт дээр үед сахил хүртсэн амьдралыг зөвтгөх шалтгаан байсан байж болох боловч ийм шаардлага байхаа больсон гэж Бахаулла зарласан юм: Үнэндээ ч Бурханд сүсэглэж, буянт олон хүмүүс нийгмээс тасарч, эцэг болох үүргээ үл биелүүлэх аваас ард түмний оюун санаа сүсэг бишрэлийн хувьд мөхөл доройтолд орно.

## Гэрлэлт

Бахайн сургаалд нэг эхнэр, нэг нөхөртэй байхыг заасан байдаг бөгөөд гэрлэлтийн нөхцөл бол хоёр талын эцэг эхийн зөвшөөрөл байх ёстой юм. “Акдас” Сударт Бахаулла ийн айлджээ:

*“Баяан” Сударт (Бабын Үүдэл нээлтийн судар) уг асуудал нь зөвхөн хоёр талын зөвшөөрлөөр хязгаарлагддаг билээ. Бид хүмүүсийн хооронд хайр ивээл, эв нөхөрлөл, эв нэгдлийг бий болгохыг хүссэн тул гэрлэлт нь мөн эцэг эхийн зөвшөөрлөөс*

*хамаарах ёстой бөгөөд ингэснээр дайсагнал, хөндий хүйтэн харьцаанаас зайлсхийх ёстой гэж айлдсан бөлгөө.”*

Энэ талаар Абдул-Баха нэгэн сонирхогч хүнд ингэж бичжээ:

*“Гэрлэлтийн талаар бол Бурханы хуульд ингээж айлдсан байдаг. Нэгдүгээрт та сүйт хүнээ сонгон авч, дараа нь эцэг эх хоёрын зөвшөөрлөөс шалтгаална. Таныг сүйт хүнээ сонгож авахаас өмнө эцэг эх тань оролцож үл болно.”* - “Абдул-Бахагийн Сургаал бичгүүд”, 3-р боть, х.563

Бахауллагийн энэхүү хуулийн ачаар Христ, Исламын шашинтай орнуудад зүйр ёгт жишээнд орсон хадмын талын төрөл садантай муу харьцаатай байх явдал Бахайчуудын хувьд бараг байдаггүй бөгөөд гэр бүл салалт ч мөн адил ховор үзэгдэл юм гэж Абдул-Баха хэлсэн байдаг. Гэрлэлтийн асуудлаар Тэрээр мөн ингэж бичжээ:

*“Бахай гэрлэлт гэдэг бол хоёр талын эвийн холбоо, эелдэг хайрын нэр юм. Тэд гэхдээ бие биеийнхээ зан чанарыг сайтар танихын тулд туйлын анхааралтай хандах ёстой. Энэхүү мөнхийн холбоог бат бөх гэрээсээр баталгаажуулах ёстой бөгөөд түүний зорилго нь эв эе, нөхөрлөл, эв нэгдэл болон мөнхийн амьдралд хүрэхэд орших ёстой билээ...”*

*“Жинхэнэ ёсны Бахайн гэрлэлтэнд хоёр тал бие биетэйгээ оюун санаагаар ч тэр, бие махбодоор ч тэр бүрэн нэгдэж, Бурханы бүх ертөнцүүдэд мөнхийн нэгдэлд хүрэн бие биеийнхээ оюун санааны амьдралыг сайжруулах ёстой юм. Энэ бол Бахайн гэрлэлт юм”* - “Абдул-Бахагийн Сургаал бичгүүд”,

Бахайн гэрлэх ёслол тун энгийн байх агаад ганцхан шаардлага байдаг нь сүйт хоёр дор хаяж хоёр гэрчийг байхад *“Бид чухамхүү Бурханы зарлигийг дагана”* гэсэн тангаргийг хэлэх ёстой юм.

## Гэр бүл салалт

Гэр бүл салалтын талаар Зөнч мэргэдийн заавар зарлиг тухайн үеийн нөхцөл байдалтай холбогдон өөр өөр байсан билээ. Бахайн сургаалд гэр бүл салалтыг хэрхэн үздэг талаар Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Анд нөхөд (Бахайчууд) эхнэр нөхөр хоёр бие биеэ жигшин зэвүүцэх ямар нэгэн зүйл гарсан л биш бол гэр бүл салалтаас зайлсхийх ёстой юм. Бие биеэ жигшин зэвүүцэх болсон тохиолдолд Оюун Санааны Чуулгад мэдэгдэн тэд гэрлэлтээ цуцлахыг шийдээж болох юм. Тэд нэг жилийн турш тэсвэр тэвчээрийг үзүүлэн хүлээх ёстой. Хэрэв энэ жилийн дотор тэр хоёр эвлэрч чадахгүй бол гэрлэлтээ цуцалж болно... Бурханы Ханлиг улсын үндэс суурь нь эв найр, хайр ивээл, нэгэн санаа, харилцаа холбоон дээр түшиглэдэг болохоос биш зөрчил маргаан, ялангуяа эхнэр нөхөр хоёрын зөрчил маргаан дээр түшиглэдэггүй. Хэрэв аль нэг нь гэр бүл салах шалтгаан болох юм бол тэр хүн үнэнхүү их зовлон бэрхшээлд унаж, туйлын их гай гамшигт өртөн гүн гүнзгий гутралд орох болно.”* (Америкийн Бахайчуудад хандаж бичсэн захидлаас)

Гэр бүл салалтын талаар мөн бусад асуудлаар Бахайчууд мэдээжийн хэрэг Бахайн сургаалаа даган мөрдөхөөс гадна тухайн орныхоо хууль журмыг дагаж мөрдөх учиртай.

### **Бахайн хуанли**

Янз бүрийн ард түмнүүд цаг хугацааг хэмжиж, өдөр сарыг тогтоох янз бүрийн арга барилтай байсан бөгөөд тэдгээрийн зарим нь одоог ч хүргэл үйлчилдэг. Жишээлбэл баруун Европт Грегорийн, Зүүн Европт Юлианы, Иудейчүүдийн дунд Иудейн, Мусульманчуудын дунд Мухаммедын хуанли тус тус үйлчилж байдаг.

Баб өөрийн зарлан тунхагласан эрин үеийн ач холбогдлыг онцлон шинэ хуанлиг нээсэн юм. Энэ хуанли нь Грегорийн хуанлитай адил билгийн биш аргын тоололтой юм.

Бахайн жил нь 19 сартай бөгөөд сар бүр 19 хоногтой (нийт 361 хоног). Үүн дээр “Завсрын өдрүүд” (ердийн жилд дөрвөн хоног, өндөр жилд таван хоногтой) нь арван найм дахь ба арван ес дэх сарын хооронд тохиосноор Бахайн жил нь аргын жилтэй тэнцдэг. Баб саруудыг Бурханы шинж чанарын нэрээр нэрлэсэн юм.

	Араб нэр	Орчуулга	Анхны өдөр
1	Баха	Цог заль	3-р сарын 21
2	Жалал	Алдар	4-р сарын 9
3	Жамал	Гоо үзэсгэлэн	4-р сарын 28
4	Азамат	Сүр жавхлан	5-р сарын 17
5	Нур	Гэрэл	6-р сарын 5
6	Рахмаг	Энэрэл	6-р сарын 24
7	Калимаг	Үгс	7-р сарын 13
8	Камал	Төгстөгөлдөр	8-р сарын 1
9	Асма	Нэр алдар	8-р сарын 20
10	Изат	Хүч чадал	9-р сарын 8
11	Машияат	Хүсэл зориг	9-р сарын 27
12	Илм	Эрдэм мэдлэг	10-р сарын 16
13	Кудрат	Сүр хүч	11-р сарын 4
14	Кол	Айлдвар	11-р сарын 23
15	Масаил	Асуулт	12-р сарын 12
16	Шараф	Алдар гавьяа	12-р сарын 31
17	Султан	Ноёрхол	1-р сарын 19
18	Мулк	Эрхшээл	2-р сарын 7
19	Ала	Сүрлэг	3-р сарын 2

Бахайн Шинэ жил нь Персийн шинэ жилийн адил хаврын өдөр шөнө тэнцсэн өдөр (3-р сарын 21) тохиодог бөгөөд Бахайн Эрин нь Бабын Тунхаглалын өдрөөс (1844 оны 5-р сарын 23) эхэлдэг. Ойрын ирээдүйд дэлхийн бүх улс түмнүүд нэгэн түгээмэл хуанлиг дагах шаардлага урган гарч ирнэ.

Тиймээс эв нэгдлийн шинэ эрин үед түгээмэл нэгэн хуанлиг сонгон авахдаа аль ч ард түмэн, улс орны шаардлагад нийцсэн тийм хуанлиг сонгон авна. Бабын зохиосон энгийн бөгөөд тохиромжтой хуанлигаас илүү тохиромжтой цаг тооны бичгийг олоход бэрх биз ээ. Бахайн хуанлийн саруудыг дээр харуулсан болно.

## Оюун Санааны Чуулгууд

Абдул-Баха Өөрийн ариун үүргийг дуусгахаасаа өмнө Бахауллагийн Сургаал бичмэлд зөгнөн айлдсан засаг захиргааны журмыг хөгжүүлэх үндэс суурийг нь тавьж өгсөн юм. Оюун Санааны Чуулга хэмээх байгууллагын ач холбогдлыг харуулахын тулд Абдул-Баха нэгэн номны орчуулгыг Өөрийн биеэр хянан засварласан мөртөө Каирын Оюун Санааны Чуулгаас батлах ёстой хэмээн бичиж байжээ.

Оюун Санааны Чуулга гэдэг нь жил бүр Бахайн нийгэмлэг дотроос сонгогддог есөн хүний бүрэлдэхүүнтэй байгууллага бөгөөд нийгэмлэгийн зүгээс хийх аливаа хамтын үйл ажиллагааны бүх асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий байгууллага юм. Энэ нэр бол түр зуурын нэр бөгөөд ирээдүйд Оюун Санааны Чуулгууд нь Шударга Ёсны Ордон гэсэн нэртэй болно.

Бусад шашны сүмүүдийг бодвол Бахайн байгууллагууд нь шашны гэхээсээ илүү нийгмийн шинж чанартай байгууллагууд юм. Өөрөөр хэлбэл, Бахайчуудын хооронд гарч буй аливаа асуудал маргааныг зөвлөлдөөний хуулиар шийдвэрлэж, нийгэмлэг дотор эв нэгдэл болон шударга ёсыг байгуулах зорилготой юм. Оюун Санааны Чуулга нь лам санваартны үүрэг гүйцэтгэдэггүй боловч сургаалыг түгээн дэлгэрүүлэх, нийгэмд тустай ажил хөдөлмөрийг уриалах, хурал цуглааныг зохион байгуулах, эв нэгдлийг хамгаалах, Бахайн өмч хөрөнгийг захиран зарцуулах, олон нийт болон бусад Бахай нийгэмлэгүүдтэй тус нийгэмлэгийн Бахайчуудыг төлөөлөн харилцах зэрэг үүргүүдийг гүйцэтгэдэг юм.

Орон нутгийн болон үндэсний түвшний Оюун Санааны Чуулгын мөн чанарыг уг номын эцсийн бүлэгт Абдул-Бахагийн “Хүсэл зориг ба Гэрээслэл”-ийн тухай хэсэгт илүү дэлгэрэнгүй тайлбарласан болно. Энэ байгууллагын талаар Шоги Эффенди ингэж тодорхойлжээ:

*“Сургаалын асуудлыг удирдан чиглүүлэх, арга замыг нь олж хайх, өргөжүүлэх, бэхжүүлэх асуудал нь Үйл хэргийн ашиг сонирхолтой амин чухал ач холбогдолтой боловч энэ асуудал нь*



эдгээр Чуулгуудын анхаарлыг татах цорын ганц асуудал биш юм. Бахаулла, Абдул-Баха нарын Илгээлт бичгүүдийг сайтар судалж үзвэл Үйл хэргийн ашиг сонирхолд чамгүй ач холбогдолтой бөгөөд орон нутаг бүрийн анд нөхдөөс сонгогдсон төлфөлөгчдийн зүй ёсны анхаарлыг татах бусад үүргүүд байдаг нь тодорхой болно.

Тэд анхаарал халамж, сонор сэрэмжийг хадгалан, мэргэн цэцэн, сонор соргог байж муу санаатан дайсны дайралт давшилтаас Сургаалын Сүмийг байнга өмгөөлөн хамгаалах үүрэгтэй.

Тэд анд нөхдийн дунд найрсаг, эвсэг харьцааг хөхүүлэн дэмжиж, үл итгэх, хүйтэн хөндий байдлын өчүүхэн ч гэсэн үл мөрийг зүрх сэтгэл бүрээс зайуулж, харин Үйл хэргийн ажил үйлст идэвхтэй, чин сэтгэлээр хамтран ажиллах явдлыг баталгаажуулан дэлгэрүүлвээс зохилтой.

Тэд ямар ч цаг үед ядуу зүдүү, өвчин зовлонтой, тахир дутуу, өнчин өрөөсөн, бэлэвсэн хүмүүст арьсны өнгө, анги давхарга, итгэл үнэмшилээс нь үл хамааран тусч гараа сунгахын тулд чадах бүхнээ хийх ёстой.

Тэд өөрт буй бүх л аргаар залуучуудын материаллаг болон оюун санааны гэгээрлийг хөхүүлэн дэмжиж, хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлэх арга замыг хангаж, боломжтой бол Бахайн боловсролын байгууллагуудыг байгуулж, тэдгээрийн ажлыг хянан зохион байгуулж, хөгжил дэвшлийг нь хангах үүрэгтэй.

Тэд анд нөхдийн тогтмол уулзалт цуглаан, баяр, ойн тэмдэглэлт өдрүүд болон хүн ардын нийгэм, оюун сэтгэхүй болон оюун санааны ашиг сонирхолд үйлчлэн зүтгэх тусгай цуглаан хурлыг зохион байгуулах үүрэгтэй.

Үйл хэрэг маань дөнгөж нялх балчир байгаа энэ цагт тэд Бахайн ном зохиолын орчуулгын ажлыг хянаж, Бахайн бүхий л ном зохиолыг боловсон нямбай байдлаар хэвлүүлж, нийт хүн ардад түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй.”

Нийгмийн тэргүүн магнайд байгаа хувь хүмүүст даруу төлөв, хариуцлагатай зан чанар хандлагыг хөгжүүлж чадах оюун санааны бишрэлийн хүч чадал өнөөдөр дутагдаж байгаатай холбогдуулан

орчин үеийн соёл иргэншил доройтон задарч байгаа энэ үед Бахайн байгууллагууд ямар их үүрэг хариуцлагыг нуруунд үүрч болохыг таамаглаж болох юм

### **Бахайн тэмдэглэлт өдөр, Баяр, Мацаг барилт**

Наурузын баяр (Бахайн Шинэ жил), 3-р сарын 21

Ризваны баяр (Бахауллагийн Тунхаглал), 4-р сарын 21 - 5-р сарын 2

Бабын Тунхаглал, 5-р сарын 23<sup>1</sup>

Бахаулла тэнгэрт хальсан өдөр, 5-р сарын 29

Баб баатарлагаар амь үрэгдсэн өдөр, 7-р сарын 9

Бабын мэндэлсэн өдөр, 10-р сарын 20

Бахауллагийн мэндэлсэн өдөр, 11-р сарын 12

Гэрээсийн өдөр, 11-р сарын 26

Абдул-Бахагийн тэнгэрт хальсан өдөр, 11 -р сарын 28

Мацаг барилтын сар, 3-р сарын 2-ноос эхлэн арван есөн хоног

### **Баярууд**

Бахай Шүтлэгтэн хүмүүс өөрсдийн баяр баясгалан, хөөр бахдлаа жилийн турш олон янзын баяраар илэрхийлдэг. Египетийн Александрия хотод 1912 онд Наурузын баярын үеэр Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Бурханы ариун хуулинд, цаг үеийн мөчлөг эрин үе бүхэнд адистат баяр, цэнгэл, амралтын өдрүүд байдаг билээ. Ийм өдрүүдэд худалдаа наймаа, аж үйлдвэр, газар тариалан зэрэг ажил хөдөлмөрөө зогсоох хэрэгтэй юм.*

*“Бүгд хамтдаа цэнгэлдэн баярлаж, уулзалт цуглаан зохион байгуулж, нэгэн чуулган мэт болж, үндэстний нэгдэл, эв эгийн санаа хүн бүхний нүдэнд илт болох ёстой.*

*“Энэ өдөр болбоос Адистат өдөр учраас түүнийг үл тоомсорлож үл болохоос гадна зүгээр цэнгэл баярыг тэмдэглэх өдөр болох ёстой юм.*

<sup>1</sup> Энэ өдөр нь бас Абдул-Бахагийн мэндэлсэн өдөртэй давхцдаг

*"Ийм өдрүүдэд хүн ардын мөнхийн ач тус, үнэ цэнийг хүртэх байгууллагуудыг байгуулж болно..."*

*"Өнөөдөр хүн ардыг удирдан чиглүүлэхээс өөр илүү үр бүтээл гэж үгүй билээ. Бурханы анд нөхөд ийм нэгэн өдөр Бахайчууд төдийгүй бүхий л хүн төрөлхтөнд хүрэх буянт сайхан үзэл санааг үлдээх ёстой юм. Ийм гайхамшигт эрин үед буянт үйлсийг хүн төрөлхтөн даяараа бүтээх ёстой. Учир нь энэ бол Бурханы энэрэл нигүүлслийн илэрхийлэл юм. Тиймээс Бурханы анд нөхөд бүгдээрээ хүн төрөлхтний хувьд Бурханы энэрэл болох болтугай хэмээн би найдаж байна."*

Науруз (Шинэ жил), Ризваны баяр, Баб, Бахаулла нарын Мэндэлсэн өдөр, Бабын Тунхаглал (бас Абдул-Бахагийн мэндэлсэн өдөр) зэрэг өдрүүд нь Бахайчуудын хувьд жилийн хамгийн баярт өдрүүд юм. Перст энэ баярыг тэмдэглэхдээ баяр найр, зугаалга зохион байгуулж, тухайн үйл явдалд тохирсон илтгэл яриа хийдэг юм. 18 дах ба 19 дэх саруудын дунд Завсрын өдрүүд тохиодог бөгөөд эдгээр өдрүүдэд анд нөхдийг урин зочилж, бэлэг сэлт өгч, ядуу зүдүү хүмүүст өглөг өгдөг.

Бабын баатарлагаар амь үрэгдсэн өдөр болон Бахаулла, Абдул-Баха нарын тэнгэрт хальсан өдрүүдийг нийцтэй цуглаан хурал зохион байгуулж, мөргөл сургаалаас эгшиглүүлэн тэмдэглэдэг.

## Мацаг

Завсрын өдрүүдийн баярын дараагаар арван ес дэх сар буюу мацаг барих сар эхэлнэ. Энэ арван ес хоногийн турш нар мандахаас нар шингэх хүртэл хоол унднаас тагталздаг. Мацаг барилтын сар нь 3-р сард өдөр шөнө тэнцсэн өдрөөр төгсдөг учраас мацаг барих үеэр бөмбөрцгийн өмнө талд хавар, хойд талд намар тохиодог. Хэзээ ч зуны халуунд, эсвэл өвлийн хүйтэнд мацаг барьдаггүй. Мацаг барих улиралд нар жаргах, нар шингэхийн хоорондох хугацаа нь дэлхий даяар ойролцоогоор ижил байдаг байдаг, өөрөөр хэлбэл, өглөөний 6 цагаас оройны 6 цаг хүртэл үргэлжилдэг. Хүүхэд багачууд, тахир дутуу хүмүүс, аялж яваа хүмүүс, мөн хөгшин настай, сул дорой биетэй хүмүүс

(үүнд хөл хүндтэй, хөхүүл эмэгтэйчүүд мөн орно) мацаг барихаас чөлөөлөгдөнө.

Бахайн сургаалын дагуу ингэж тогтмол үед мацаг барих нь хүний биеийн эрүүл мэндэд сайнаар нөлөөлөөд зогсохгүй мөн оюун санааны эрүүл энх байдалд нөлөөлнө. Учир нь, мацаг барихдаа Бахайчууд зөвхөн материаллаг хоол унднаас татгалзаад зогсохгүй мөн биеийн элдэв дур хүсэл, тачаалаас татгалзаж, нэг үгээр Бурханаас өөр бусад бүх зүйлсээс татгалздаг юм. Абдул-Баха ийнхүү хэлжээ:

*“Мацаг барилт бол бэлгэ тэмдэг мөн. Мацаг барилт нь бие махбодын элдэв дур хүслийг тэвчихийг бэлгэдэж байгаа юм. Бие махбодын мацаг барилт нь энэ тэвчлийн бэлгэ тэмдэг хийгээд сануулга юм. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, хүн бие махбодын дур таашаалаа тэвчихийн адил өөрийн “би” гэсэн үзлийн таашаал, дур хүслээ тэвчинэ гэсэн үг. Гэвч зөвхөн хоол унднаас татгалзах нь оюун санаанд яаж ч нөлөөлж чадахгүй. Энэ бол зөвхөн бэлгэ тэмдэг, сануулга төдий юм. Ийм биш байсан бол энэ бүхэн ямар ч ач холбогдолгүй байх байсан. Энэ зорилгоор мацаг барих нь зөвхөн хоол унднаас татгалзах явдал биш юм. Хоолны хувьд хэт их юм уу хэт бага идэхээс зайлсхий гэсэн алтан хууль бий. Хэм хэмжээ гэж байх шаардлагатай. Энэтхэгт нэгэн шашины бүлэг байдаг. Тэд хоолноос туйлын байдлаар татгалзах номлолтой тул идэх хоолоо аажмаар багасган, эцэст нь юу ч идэхээ больдог байна. Гэвч үүнээс болж тэдний оюун ухаан хохироход хүрнэ. Хоол дутагдсанаас болж бие ухаан сул болсон хүн Бурханд үйлчлэх чадалгүй болно. Тэрээр тод ч харж чадахгүй.”* (“Хоёр долоо хоногийн тойм” сонинд Е.С.Стивенс иш татав, 1911 оны 6 дугаар сар)

### Уулзалт цуглаанууд

Хамтдаа сүсэглэн мөргөх, сургаалыг судлан бясалгах, Шүтлэгийнхээ хөгжил дэвшлийн талаар зөвлөлдөн ярилцах зорилгоор сүсэгтэн олон тогтмол уулзалт цуглаан хийх нь маш чухал ач холбогдолтой гэж Абдул-Баха хэлсэн билээ. Өөрийн нэгэн Илгээлт бичигт Тэрээр ингэж бичжээ:

“Бурханы анд нөхөд болон Энэрэлт Түүний шадар шивэгчин нарын дунд эв эеийн холбоо, эв найрамдал өдрөөс өдөрт нэмэгдэхийг Бурханы Хүсэл таалал шийдэн захирамжисан билээ. Үүнийг хэрэгжүүлээгүй цагт ажил хэрэг ямар ч замаар өөдлөн дэвшихгүй! Зөн олны эвийн холбоо, эвсэг харилцааны хамгийн шилдэг арга зам болбоос Оюун Санааны Уулзалтууд юм. Энэ асуудал бол тун чухал бөгөөд тэнгэрлэг буян ивээлийг татах соронзон билээ.” - “Абдул-Бахагийн Сургаал бичгүүд”, 1-р боть, х.125

Бахайчуудын оюун санааны уулзалтын үеэр улс төр болон газар дэлхийн аахар шаахар асуудлын талаар ярилцахаас зайлсхийх нь зүйтэй. Сүсэгтнүүдийн цорын ганц зорилго нь Тэнгэрлэг Үнэнийг бусдад зааж сургах, өөрсдөө суралцах, Тэнгэрлэг Хайраар зүрх сэтгэлээ дүүргэх, Тэнгэрлэг Хүсэл зоригийг илүү төгс сэтгэлээр хүлцэн дагах, Бурханы Ханлиг улс залран тогтохыг хөхүүлэн дэмжихэд оршино. 1912 онд Нью-Йоркт байхдаа айлдсан нэгэн айлдваргаа Абдул-Баха хэлсэн нь:

“Бахайн цуглаан бол Хурмастын Цуглаан болох ёстой. Уг цуглаан нь Хурмастын Цуглааны гэрэл гэгээгээр гийх ёстой. Хүмүүсийн зүрх сэтгэл болбоос Үнэний Нарны гэрэл туяаг тусгасан толь лугаа адил болох ёстой. Сэтгэл зүрх бүр утасны нэг үзүүр нь зүрх сэтгэлийн гүнд, нөгөө нь Хурмастын Чуулгантай холбогдсон илгээлт мэдээллийг солилцож байх цахилгаан мэдээний өртөө мэт болох ёстой юм. Ийм замаар Абха-н Ханлиг улсын онгод тэжээл ирж, бүхий л ярианд эв эеийн харьцаа давамгайлах болно... Та нарын дунд хэр их зөвшилцөл, эв нэгдэл, хайр ивээл тогтоно, төдий чинээ Бурханы хишиг та нарт очиж, Адист Гоо жавхлан Бахаулла та нарыг дэмжин туслана.”

Нэгэн Илгээлт бичигтээ Тэрээр бас ингэж хэлжээ:

“Эдгээр цуглааны үеэр гаднах орчны ярилцлагаас бүрэн татгалзаж, гагцхүү сургаал үгсийг уншин эгшиглүүлж, Бурханы Үйл хэрэгтэй холбоотой асуудлаар ярилцаж, жишээлбэл, нотолгоог тайлбарлаж, тод илэрхий баталгааг ойлгуулж, Хайрт Бурханы шинэ тэмдгийг эрж хайхад л зориулахад анхаарлаа хандуулах ёстой. Цуглаанд оролцох гэж байгаа хүмүүс очихынхоо

*өмнө туйлын цэвэр ариун хувцас хунар өмсөж, Абха-н Ханлиг улсад хандсаны дараа сая туйлын даруу төлөв байдалтайгаар цуглаанд орвоос зохино. Тэгээд сургаал бичмэлүүдээс уншиж байх үеэр анир чимээгүй суувал зохино. Хэн нэг нь үг хэлэхийг хүсвэл эелдэг боловсон байдлаар бусдын зөвшөөрлийг авсны дараа уран яруу, цэцэн цэлмэг үгээр бодлоо илэрхийлвээс зохино.”*

### **Арван ес хоногийн баярууд**

Абдул-Бахаг тэнгэрт хальснаас хойш Бахайн засаг захиргааны журам хөгжсөн билээ. Арван ес хоногийн баярыг Бахайн сар бүрийн эхний өдөр тэмдэглэж, энэ баярын үеэр хамтаар Ариун судар номоос уншин бясалгаж, мөргөл үйлдэхээс гадна Бахайн ажил үйлсийнхээ талаар зөвлөлдөн ярилцаж, анд нөхөд чөлөөтэй харилцан нөхөрлөдөг юм. Энэ баярын үеэр Оюун Санааны Чуулга нь нийт сүсэгтэн олонд тайлангаа тавьж, ажлын төлөвлөгөө болон шашныхаа үйл хэргийг илүү үр дүнтэйгээр зохиож явуулах талаар санал бодлоо илэрхийлэн дэвшүүлэхийг тэднээсээ уриалдаг.

### **Машрикул-Аскар**

Сүсэг мөргөлийн орднуудыг сүсэгтэн олон улс орны хот бүрт барих ёстой гэж Бахаулла зааварчлан захисан юм. Эдгээр орднуудыг Тэрээр “*Машрикул-Аскар*” гэж нэрлэсэн бөгөөд энэ нь “*Бурханы магтуу мандсан газар*” гэсэн утгатай юм. Машрикул-Аскар нь есөн талтай, бөмбөгөр оройтой, хэв загвар, хийцийн хувьд аль болох үзэсгэлэн төгс ордон байх ёстой юм. Уг ордныг усан оргилуур, мод ургамал, цэцэг ногоо дэлгэрсэн хүрээлэнд байгуулж, эргэн тойронд нь боловсрол, буяны болон хүмүүнлэгийн ач холбогдолтой барилга байгууламжуудыг байгуулах учиртай билээ. Ингэснээр сүм дотор Бурханд сүсэглэн мөргөх явдал нь ямагт байгаль дэлхий, соёл урлаг, нийгмийн нөхцөл байдлыг сайжруулах бодит ажил үйлстэй нягт холбогдож байх ёстой юм.

Перс оронд одоог хүртэл Бахайчууд ийм сүсэг мөргөлийн ордон байгуулах боломжгүй байгаа юм. Анхны Машрикул-



Аскарыг Оросын Ашхабад хотод барьсан юм.<sup>1</sup> Абдул-Баха хоёр дах мөргөлийн ордны тулгын чулууг 1912 онд Америкт аялж байхдаа Чикаго хотоос хэдэн бээрийн газар Мичиган нуурын эрэг дээр тавьж өгсөн юм.<sup>2</sup>

Өрнөдийн энэхүү “эх ордон”-д зориулан Абдул-Баха дараах зүйлийг айлдсан юм:

*“Яг энэ мөчид Америкийн Маширикул-Аскарыг барих Санд дэлхий улс орон бүрээс сүсэгтэн олон өөрсдийн чадал чинээгээр хандивыг тасралтгүй илгээж байгаад Бурханд талархал өргөнөм... Адамын өдрөөс өнөөг хүртэл Азийн хамгийн алслагдмал улсаас Америк руу хандив илгээж байгаа ийм явдлыг хүн төрөлхтөн үзээгүй билээ. Энэ бол Бурханы Гэрээсийн хүч чадлын ач юм. Үнэнхүү энэ бол ухаант хүмүүсийн гайхал бишрэлийг төрүүлсэн үйл хэрэг билээ. Бурханы сүсэгтнүүд улам их өгөөмөр сэтгэлийг үзүүлж, барилгыг барихад улам их хөрөнгө мөнгө цуглуулна гэдэгт найдаж байна... Хүн бүр өөрийн хүслийн дагуу л хийх эрх чөлөөтэй. Хэн нэгэн хүн мөнгөө өөр юманд зориулахыг хүсвэл зориулна биз. Түүнд ямар нэгэн байдлаар бүү саад хий, гэвч энэ цаг үед хамгийн чухал зүйл бол Маширикул-Аскарыг барих явдал гэдэгт итгэлтэй бай.*

*Энэхүү барилгын нууц бол үнэнхүү агуу бөгөөд одоо энэ нууц нь тайлагдах болоогүй байна. Гэвч түүнийг барьж байгуулах ажил өнөө үеийн хамгийн чухал үйлс болой. Маширикул-Аскар болбоос өөртөө чухал чухал барилга байгууламжуудыг хавсруулан агуулах ёстой бөгөөд тэдгээр нь нэн тэргүүний ач холбогдолтой. Эдгээр байгууламжууд нь: ончин хүүхдийн асрах газар, ядууст үйлчлэх эмнэлэг эмчилгээний газар, тахир дутуу хүмүүсийг асрах газар, дээд боловсролын сургууль, айчлагчдыг хүлээн авах буудал байх болно. Үүний дараа хот бүрт агуу их Маширикул- Аскар босох ёстой. Маширикул-Аскар дотор өглөө бүр мөргөл үйлдэнэ. Тэр сүм дотор орган хөгжим гээж байхгүй болно. Түүний ойролцоо орших барилгуудад баяр наадам, буян үйлчилгээ, хурал цуглаан, олон нийтийн цуглаан уулзалт, сүсэг бишрэлийн уулзалтыг*

<sup>1</sup> Энэ өдөр нь бас Абдул-Бахагийн мэндэлсэн өдөртэй давхцдаг

<sup>2</sup> Анхны Мөргөлийн ордон 1948 оны газар хөдлөлтөнд ихээхэн нурж гэмтсэн тул хэдэн жилийн дараа бүр мөсөн нураах болжээ.

зохион байгуулах болно. Харин Сүм дотор ямар ч хөгжимгүйгээр мөргөлийг эгшиглүүлэн дуулах болно. Сүмийнхээ үүд хаалгыг бүх хүн төрөлхтөнд нээгтүн.

“Сургууль, эмнэлэг, буудал, асрамжийн газар, дээд сургууль, аспирантурын барилга болон бусад буяны барилга байгууламжуудыг байгуулсан тэр цагт үүд хаалга бүх улс үндэстэн, бүх шашины хүмүүст нээлттэй болно. Ямар ч ялгаварлан гадуурхах явдал үгүй болно. Арьсны өнгө, үндэстэн ястнаас үл хамааран хүн бүрт энэ буяны үйлсийг хүртээнэ. Үүд хаалга нь бүх хүн төрөлхтөнд өргөн нээгдэж, ямар ч атгаг сэжиг үзэлгүйгээр хүн бүхнийг хайрлана. Гол барилгыг мөргөл, сүсэг бишрэлд зориулна. Тийнхүү...шашин бол шинэслэх ухаантай уялдаж, шинэслэх ухаан нь шашинтай түншилж, хоёулаа нийт хүмүүн төрөлхтний материаллаг оюун санааны буян хишгийг арвижуулах болно.”

### Үхлийн дараах амьдрал

Бие махбодын амьдрал бол бидний оршин тогтнолын үр хөврөлийн үе шатыг төлөөлдөг гэж Бахаулла бидэнд хэлсэн юм. Тиймээс бие махбодоос салснаар хүний сүнс илүү өргөн дүүрэн, илүү эрх чөлөөтэй амьдралыг угтан авч, шинээр мэндэлнэ гэсэн үг. Бахаулла ингэж бичжээ:

...“Хүний сүнс бие махбодоосоо салангуутаа Бурханы дэргэд очих хүртэл зогсолтгүй хөгжин дэвшиж, ямар ч эрин зуун, цаг үеийн хувьсгал, энэ дэлхий ертөнцийн өөрчлөлт, боломж бололцоонд өөрчлөгдөхөөргүй тийм нөхцөл байдалд очдог байна. Сүнс нь Бурханы Ханлиг улс, Түүний эзэрхэл, Түүний ноёрхол ба хүч чадал оршоор байсан цагт оршоор байх болно. Сүнс нь Бурхан болон Түүний шинэ чанарыг илэрхийлж, Түүний хайр халамж, буян хишгийг нээх болмой. Ийм эрхэм байр суурийн гоо сайхныг зүй ёсоор дүрслэх гэж оролдох гэтэл Миний Бийр хөдөлж үл чадна. Энэрэлийн Мутар уг сүнсэнд шингэх тэр их алдар гавьяаг ямар ч хэлээр зүй ёсоор илэрхийлж үл чадах, газар дэлхийн ямар ч хүч дүрсэлж үл дийлэх билээ. Хэн нэгний сүнс бие махбодоосоо

салах тэр мөчид дэлхийн хүмүүсийн хоосон төсөөллөөс ариуссан байвал юутай адистат билээ. Ийм сүнс Бүтээгчийнхээ Хүсэл зоригийн дагуу амьдран хөгжиж, эрхэм дээд Диваажинд нэвтрэн орох болмой. Тэнгэрийн Дагинас, сүрлэг харшийн торшин суугчид түүнийг тойрон эргэлдэж, Бурханы Зөнч мэргэд ба сонгомол Элч нар түүнтэй ханьсахыг хүснэ. Тэдэнтэй сүнс харилцан хөөрөлдөж, түүнийг бүх хорвоо ертөнцийн Эзэн тэнгэр Бурханы замналд ийнхүү мөнхрүүлсэн тэр зүйлийн талаар дурсан ярих болмой. Дээд тэнгэр хийгээд газар дэлхийн Эзэн тэнгэр Бурханы ертөнцүүдэд ийм сүнсэнд учрах хувь заяаг хэнд ч болов хэлэх юм бол тэр хүн тэр даруй сэтгэл хөөрч, энэхүү нэн эрхэм, ариун хийгээд үзэсгэлэнт бодь хутгыг хүртэх гэж бүх л сэтгэлээрээ тэмүүлэн яаравчлах болно... Үхлийн дараах сүнсний мөн чанарыг хэзээ ч дүрслэх боломжгүй бөгөөд хүмүүсийн нүдэнд бүрэн шинэж чанарыг нь нээх нь үл нийцэх бөгөөд үл зөвшөөрөгдмү. Бурханы Зөнч мэргэд ба Элч нарын доош шлгээгдсэний цорын ганц зорилго болбоос хүн төрөлхтнийг Үнэний чиг шулуун Замд оруулах явдал бөлгөө. Тэднийг нээн тодруулсан зорилго нь гэвээс хүмүүсийг гэгээрүүлж, үхэх цаг нь ирэхэд дээдийн ариун цагаан зүрх сэтгэлийг барин, бүрэн ангижирсан байдлаар Дээд Тэнгэрийн суудал өвд дүүлэхэд нь туслах явдал юм. Эдгээр сүнсүүдийн цацруулах гэрэл нь чухамхүү дэлхий ертөнцийн хөгжил дэвшлийг тэтгэж, хүн ардыг нь дэвжээн дээшлүүлж ирсэн билээ. Тэд ахуйн ертөнцийг эсгээдэг хөрөнгө лугаа адил бөгөөд дэлхийн соёл урлаг, гайхамшигт бүтээлийг нээн амьдруулагч хүчин юм. Тэдний ачаар буян хишгийн хур бороо хүмүүсийг ундаалж, газар дэлхий дээр үр жимс цэцэглэн боловсордог. Аливаа юм учир шалтгаан, хөдөлгөгч хүч болон амьдрах зарчимтай байх ёстой билээ. Эдгээр сүнс болон ангижралын бэлгэ тэмдгүүд нь ахуйн ертөнц агуу их хөдлөн хөгжих түлхэц болж ирсэн бөгөөд цаашид ч болох юм. Тэнгэрийн ертөнц бол энэ дэлхийн ертөнцөөс өөр бөгөөд энэ дэлхий эхийн хэвлий дэх ертөнцөөс өөр байдгийн адил ялгаатай юм.” - “Бахауллагийн Сургаалын Дээжис”, XXXix 155-157

Үүний нэгэн адил Абдул-Баха ингэж бичсэн байна:

“Газар дэлхийн амьдралдаа үл анзаардаг байсан нууц

*оньсогыг хүн хурмастын ертөнцөд очоод нээх бөгөөд тэнд очоод тэрээр үнэний нууцыг ойлгон мэдэх болно. Түүгээр ч үл барам тэнд тэрээр урьд нь уулзаж учирч явсан хүмүүсийг таньж, тэднийг олно. Ариун мэлхийн харцтай, дотоод сэтгэлийн буянтай хүмүүсийн ариун сүнс нь гэрэл гэгээний Ханлиг улсад очоод бүх нууцыг мэдэж, агуу сүнс бүрийн мөн чанарыг гэрчлэх буян хишигийг илэрхийлэх болно. Тэд тэр ч бүү хэл тэр ертөнцөд Бурханы Гоо сайхныг харах болно. Үүнтэй нэгэн адил тэд Бурханы бүх анд нөхдийг олно, эрт дээр үеийн болон саяхны анд нөхдийг Хурмастын цуглаанд цугласан байхыг олж харна.*

*“Хүмүүсийн хоорондын ялгаа нь мэдээжийн хэрэг зуурдын энэ орчлонгоос тасарсны дараа ч адил байна. Гэвч энэ ялгаа нь газар нутгаас хамаарахгүй харин сэтгэл ухамсраас шалтгаална. Учир нь Бурханы Ханлиг улс бол орон зай, газар нутгаас ангид юм. Энэ бол огт өөр ертөнц, огт өөр орчлон юм. Харин одоо та тэнгэрлэг ертөнцүүдэд оюун санаанлаг хайрт шавь нар бие биеийгээ таньдаг, бие биетэйгээ нэгдэхийг хүсдэг, ингээж хүсэхдээ оюун санаагаар нэгдэхийг хүсдэг гэдгийг мэдтүгэй. Мөн түүнчлэн хэн нэгнийг хайрлаж байсан хайр Бурханы оронд үл мартагдах агаад материаллаг ертөнцдөө амьдарч байсан амьдралаа ч мартахгүй.” “Абдул-Бахагийн Сургаал бичгүүд”, 1-р боть, х.204*

### **Там ба диваажин**

Бахаулла, Абдул-Баха нар бусад шашны сургаалд там диваажин хоёрыг тайлбарласан тайлбарыг бэлгэ тэмдгийн чанартай гэж хэлсэн юм. Жишээлбэл, хорвоо орчлон бүтээгдсэн тухай дүрсэлсэн Библийн түүхийг үгчлэн ойлгох ёсгүй гэж хэлж байсан юм. Бахаулла, Абдул-Баха нарын сургаснаар “диваажин” гэдэг бол төгс төгөлдөр байдал, харин “там” гэдэг төгс бус байдал юм. Диваажин бол Бурханы хүсэл таалалд болон бусад хүмүүстэй эвсэн зохицох явдал, харин там бол ийм эвсэл зохицол дутагдаж байгаа явдал юм. Диваажин бол оюун санааны амьдралын нөхцөл, харин там бол оюун санааны үхэл юм. Хүн энэ ертөнцөд амьдарч байхдаа диваажин там хоёрын аль алинд нь оршиж

болно. Диваажингийн баяр баясгалан гэдэг оюун санааны баяр баясгалан, тамын зовлон бол ийм баяр баясгалангүй байх явдал юм.

Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Тэд итгэл бишрэлийн гэрэл гэгээний ачаар эдгээр нүгэл гэмээсээ ангижирч, Бодит үнэний нарны гэрэл туяагаар гэрэлтэж, бүхий л эрхэм нандин чанарыг эзэмшихээрээ энэхүү агуу их хишигийг хүндлэн дээдэлж, жинхэнэ диваажинд байгаагаа ухаардаг. Үүний нэгэн адил тэд оюун санааны шийтгэл гэдгийг... материаллаг ертөнцөд урхилагдаж, Бурханаас холдож, харгис бурангуй, харанхуй мунхаг байх, биеийн дур тачаалд автагдах, адгуусан шинж төрхөө дагах, худал ярих, бусдыг дарангуйлан мөлжсх, харгислан хэрцгийлэх, энэ дэлхийн явдалд орооцолдох зэрэг адгийн доод чанарыг эзэмших, ад шулмын хүсэл бодлыг агуулах явдал хэмээн ойлгодог. Тэдэнд үүнээс аймшигтай шийтгэл, там гэж үгүй билээ...*

*“Нөгөө ертөнцийн шагнал хишиг бол энэ ертөнцөөс халин одсоныхоо дараа оюун санаа, сүнсний ертөнцөд олж авсан төгс төгөлдөр чанар ба энх амгалан... оюун санааны гоо жавхлан, Бурханы Ханлиг улсын төрөл бүрийн бэлэг хишиг бөгөөд зүрх сэтгэл, сүнсний хүсэл мөрөөдлийг олох, мөнхийн ертөнцөд Бурхантай уулзан учрах явдал юм. Үүнтэй нэгэн адил нөгөө ертөнцийн шийтгэл нь, өөрөөр хэлбэл, нөгөө ертөнцийн тамлал зовлон болбоос онцгой тэнгэрлэг адис хишиг ба туйлын их буян ивээлийг үл хүртэж, оршин тогтнолын хамгийн доод шатанд унах явдал юм. Эдгээр тэнгэрлэг хишгээс хүртэх хувьгүй хүн бол хэдийгээр үхсэнийхээ дараа амьдарсаар байх боловч үнэнийг эрхэмлэгч бусад хүмүүсийн хувьд үхсэнтэй адил юм.*

*“Нөгөө ертөнцийн баялаг бол Бурханд ойр байх явдал юм. Түүгээр ч зогсохгүй, Тэнгэрлэг өргөөнд ойр байгаа хүмүүс бусдын төлөөнөө мөргөх эрхтэй нь тодорхой бөгөөд энэ эрхийг Бурхан зөвшөөрдөг юм... Нүгэл гэм болон үл сүсэглэх байдалд насан эцэслэсэн хүмүүсийн хувь заяа ч өөрчлөгдөж болно. Өөрөөр хэлбэл, тэдгээрийг Бурхан шударга ёсны хуулиараа бус, харин энэрэнгүй сэтгэлээрээ өршөөж болно. Яагаад гэвэл, өршөөл*

*ивээлийг түүнийг хүртэх гавьяа хийгээгүй байсан ч өгдөг, харин шударга ёсны цээрлэлийг юу хийсэнд нь тааруулан хүртээдэг. Тэдгээр хүмүүсийн төлөө энд залбирах хүч бидэнд заяасан байдаг ба Бурханы орон богино нөгөө ертөнцөд ч мөн энэ хүчийг эзэмшсээр байх болно... Тийм учраас тэр ертөнцөд тэд ч дэвшин хөгжинө. Энд тэд Бурханд залбиран наминчласнаар гэрэл эгзээг хүртэж чадахын адил тэнд ч мөн ершөөл уучлалыг эрж, наминчлан залбирч болно...*

*“Энэхүү материаллаг хэлбэрийг олохоос өмнө ч, энэ хэлбэрийг орхисны дараа ч төгс төгөлдөр чанарт хөгжил дэвшил гардаг, нөхцөл байдалд хөгжил дэвшил гардаггүй... Төгс хүмүүнээс эрхэм зүйл гэж үгүй билээ. Гэхдээ хүн энэ түвшинд хүрснийхээ дараа төгс чанар эзэмшихдээ улам хөгжин дэвших нөхцөл байдлаас шүү өндөр нөхцөл байдал гэж байхгүй юм. Хүн гагцхүү хүн төрөлхтний байдалдаа хөгжин дэвшинэ, учир нь, хүмүүний төгс төгөлдөр чанар нь хязгааргүй юм. Тиймээс хүн хичнээн их эрдэм номтой байсан ч түүнээс шүү эрдэм номтой байхыг бид төсөөлж чадна. Ийнхүү хүн төрөлхтний төгс төгөлдөр чанар дуусашгүй их тул хүн энэ ертөнцөөс халин одсон ч улам төгс төгөлдөр болохын төлөө хөгжин дэвшиж болно.” “Учир нь тайлагдсан зарим асуултууд” х.209, 215-216, 219-220*

### **Хоёр ертөнцийн нэгдэл**

Бахауллагийн тунхагласан хүн төрөлхтний эв нэгдлийн сургаал нь зөвхөн энэ ертөнцөд амьд байгаа хүмүүст хамаарахгүй, мөн нөгөө ертөнцөд байгаа сүнснүүдэд ч хамаарна гэсэн юм. Энэ газар дэлхий дээр амьдарч байгаа хүмүүс төдийгүй оюун санааны ертөнцөд оршин байгаа бүхэн нэг л нэгдмэл цогц бие махбодын хэсгүүд тул хоорондоо нягт холбоо зохицолтой, салшгүй хэсгүүд билээ. Нэг ертөнц нөгөө ертөнцтэйгээ оюун санаагаар холбогдон харилцах явдал бол байгалийн жам ёсны эсрэг зүйл биш харин гарцаагүй байнгын үйл явц билээ. Оюун санааны чадвараар төдийлөн сайн хөгжөөгүй хүмүүс энэхүү амин чухал холбоог ойлгох чадваргүй байдаг. Харин оюун санааны чадавх мэдрэмж хөгжих тусам цаад ертөнцөд байгаа сүнснүүдтэй харилцах нь



илүү тодорхой, ухамсартай болдог. Зөнч мэргэн, ариун гэгээн хүмүүсийн хувьд сүнсний ертөнцтэй ярилцах нь энэ дэлхий дээр хүмүүстэй ярилцдагийн адил ердийн үзэгдэл байдаг.

Абдул-Баха ингэж айлджээ:

*“Зөнч мэргэдэд үзэгдсэн зүйлс нь зүүд биш байдаг бөгөөд тэдгээр нь харин сүнсний бодит үзэгдэл байдаг. Тэд жишээлбэл: “Би тийм маягын хүн харсан. Би тэгж хэлэхэд, тэр надад ийм хариулт өгсөн” гэж ярьдаг. Энэ үзэгдэл бол зүүд нойронд нь үзэгдсэн үзэгдэл биш юм. Энэ нь зүүд зэрэглээ адил нүдэнд нь үзэгдсэн сүнсний үзэгдэл юм.*

*“Оюун санаанлаг гэгээн хүмүүсийн дунд оюун санааны ухаарал, нээлт, харилцаа холбоо байдаг агаад тэдгээр нь аливаа хий дэмий төсөөлөл сэтгэмжээс чөлөөтэй агаад цаг хугацаа, байр, орон зайнаас ангид юм. Тийнхүү Евангелид бичсэнээр Табор Ууланд Моисей, Элиа нар Христ дээр хүрч ирсэн байдаг. Энэ нь биет уулзалт байгаагүй, харин биетээр уулзсан байдлаар дүрслэгдсэн оюун санааны уулзалт байсан юм гэдэг нь тодорхой... Эдгээр үзэгдэл нь бодит үнэн бөгөөд хүмүүсийн оюун ухаан, бодол санаанд гайхамшигтай үр өгөөжтэй бөгөөд зурх сэтгэлийг татдаг.”* - “Учир нь тайлагдсан зарим асуултууд “Iххi х 234-236

Сэтгэхүйн далд хүчин чадал гэж байдгийг хүлээн зөвшөөрөхийн хажуугаар Тэрээр ийм нөөц чадлыг цаг нь болоогүй байхад албадан хөгжүүлэх гэж оролдож хэрхэвч болохгүй гэж хэлсэн юм. Бид хэрэв Зөнч мэргэдийн тавьж өгсөн оюун санааны хөгжил дэвшлийн зам мөрийг дагах аваас ийм чадвар цаг нь ирэнгүүт аяндаа хөгжин нээгдэнэ.

Тэрээр мөн ингэж айлджээ:

*“Энэ ертөнцөд байхдаа сүнсний далдын хүчийг хөөцөлдөн оролдох нь ирээдүйн ертөнцөд сүнсний нөхцөл байдалд саад болдог. Эдгээр хүчнүүд нь бодит хүчнүүд боловч ихэнхдээ энэ орчлонд идэвхтэй биш байдаг. Эхийн хэвлийд байгаа хүүхэд нүд, чих, гар, хөл зэрэг эрхтнүүдтэй байдаг. Материаллаг ертөнц дэх амьдралын бүхий л зорилго болбоос тэдгээр хүчнүүдийн идэвхтэй үйлчилдэг Бодит үнэний ертөнцөд хүрэх явдал юм.*

*Тэр хүчинүүд тэр ертөнцөд л хамааралтай байдаг.”* (Хатагтай Бактоны тэмдэглэлээс, Абдул-Бахагийн хянаснаар)

Зүгээр зугаацах юм уу сониуч зандаа хөтлөгдөн талийгаач болсон сүнснүүдтэй харилцах гэж оролдох нь зохисгүй хэрэг юм. Харин тэрхүү хөшигний нэг талд оршигсад нь нөгөө талд оршигсдыгоо хайрлан, тэдэнд тусалж, тэдний төлөө мөргөн залбирах үүрэгтэй юм. Бахайчууд нас нөгчигсдийн төлөө мөргөл үйлдэх үүрэгтэй билээ. Хатагтай Э.Ж.Розенбергт 1904 онд Абдул-Баха ингэж хэлж байжээ:

*“Үр дүнтэй залбиран мөргөх буян нь дээд хөгжилд хүрсэн хүмүүс болон Бурханы Тодруулагч нарт байдаг төгс төгөлдөр чанар юм. Есүс Христ энэ ертөнцөд амьдарч байхдаа Өөрийн дайснуудын өмнөөс өршөөл гуйн мөргөн залбирдаг хүчтэй байсан бөгөөд одоо ч тийм хүчтэй нь ойлгомжтой. Абдул-Баха талийгаач болсон хүний нэрийг дурдахдаа “Бурхан түүнийг өршөөг!” гэх мэтийн үг хэлэлгүйгээр хэзээ ч дурдаж байсангүй. Зөнч мэргэдийн дагалдагч шавь нар ч мөн адил талийгаач сүнснүүдийн өршөөлийн төлөө мөргөн залбирах хүчийг агуулсан байдаг. Тиймээс Бурханыг үл мэддэг туйлын мунхаг байсан хүмүүс үүрд зовлон зүдгүүр, гачигдал дутагдалд өртөж явах тавилантай хэмээн бид бодож болохгүй юм. Тэдний төлөө үр дүнтэйгээр залбирал гуйн мөргөх хүч ямагт байдаг...”*

*“Энэ ертөнцийн баячууд ядууст тусалж болохын адил нөгөө ертөнц дэх баячууд ядууст тусалж болно. Аль ч ертөнцөд юм бүхэн болбоос Бурханы бүтээл бөлгөө. Тэд ямагт Бурханаас шалтгаалан хамаарч байдаг. Тэд хэзээ ч дангаар оридоггүй, оршиж чадах ч үгүй. Тэдэнд ямагт Бурхан хэрэгтэй байдаг учраас тэд хэдий чинээ мөргөн залбирна, төдий чинээ баян болно. Тэдний эд баялаг, эд хөрөнгө юунд оршино вэ? Нөгөө ертөнцөд тусламж дэмжлэг гэдэг нь ямар утгатай вэ? Энэ нь залбирал гуйлт юм. Хөгжлөөр дорой сүнснүүд эхэн үедээ оюун санаагаар баян сүнснүүдийн мөргөл залбирлын ачаар хөгжин дэвшинэ. Харин дараа нь тэд өөрсдийнхөө мөргөл залбирлаар цаашид хөгжин дэвшинэ.”*

Дахин Тэрээр ингэж хэлсэн байна:

*“Тэнгэрт хальсан хүмүүс дэлхий дээр амьдарч байгаа хүмүүсээс өөр шинэ чанартай байдаг боловч энэ хоёр ертөнц бүр мөсөн салаагүй байдаг юм. Мөргөл үйлдэж байх үед байр суурь, нөхцөл байдлын холилдоон үүсдэг. Тэд чиний төлөө мөргөдөг шиг ч ч тэдний төлөө мөргө. ” Абдул- Баха Лондонд “, х. 97*

Энэ амьдралд байхдаа Шинэ Үүдэл нээлтийг дуулж амжаагүй сүнснүүдэд түүний талаар итгэл бишрэл, хайр ивээлийн замаар мэдэгдэж болох эсэх тухай асуухад Абдул-Баха ингэж хариулжээ:

*“Тийм ээ, бололгүй яахав! Чин сэтгэлийн мөргөл бол өөрийн гэсэн нөлөөтэй байдаг агаад нөгөө ертөнцөд ч асар ихээр нөлөөлдөг. Тэнд байгаа хүмүүсээсээ бид хэзээ ч тасардаггүй. Жинхэнэ ёсны нөлөө бол энэ ертөнцөд биш харин тэр ертөнцөд байдаг. ” “Мэри Хэндфорд Фордын тэмдэглэл”, Парис, 1911*

Нөгөө талаас Бахаулла ингэж бичиж байжээ:

*“Өөрт ногдсон номын дагуу амьдарсан тэр хүмүүний төлөө Хамгаас хайрт, магтаал сайшаалт Бурханы Зарлиг лүндэнгээр Агуу чанарын Оройд оршин суугчид, Эрхэм дээд Диваажингийн хүмүүс болон Хурмастын Чуулган мөргөн залбирах болно. ” (Али Кули Ханы орчуулгаар)*

Аливаа хүний зүрх сэтгэл тэнгэрт хальсан нөхөр лүүгээ өөрийн эрхгүй тэмүүлдгийн учир юунд вэ гэсэн асуултанд Абдул-Баха ингэж хариулсан байна:

*“Сул дорой нь хүчтэйгээ түших нь Бурханы орчлонгийн хууль юм. Таны тэмүүлж байгаа тэр хүмүүс тань магадгүй Бурханы Хүчийг танд дамжуулагч зуучлагчид байж болох юм. Газар дэлхий дээр ч мөн адил бүх хүмүүсийг чухамхүү Цорын ганц Ариун Сүнс бэхжүүлэн тэтгэдэг билээ”-”Абдул-Баха Лондонд”, х.97*

## **Муу ёр гэж оршдоггүй**

Бурханы нэгдлийн тухай Бахайн сургаал номлолын гүн ухаанд зааснаар бодит муу ёр гэж зүйл байдаггүй юм. Зөвхөн ганц л Хязгааргүй гэж байна. Цорын ганц тэр хүчнээс өөр ямар нэгэн хүч энэ хорвоо дээр байдагсан бол тэр Ганц хүч бол хязгааргүй байж чадахгүй юм. Харанхуй гэдэг нь гэрэл байхгүйгийнх юм уу эсвэл

гэрэл бага байгаагийн шинж байдгийн адил муу ёр гэдэг сайн чанар байхгүй байгаагийн, эсвэл сайн чанар сул хөгжсөний илрэл юм. Муу хүн гэдэг бол сайн тал нь сул хөгжсөн хүнийг хэлнэ. Хэрэв тэр хүн хувиа хичээсэн бол хувиа хичээх зан нь түүний муу ёрт тал биш юм. Учир нь, аливаа хайр бол, тэр ч бүү хэл өөрийгөө хайрлах хайр бол тэнгэрлэг байдаг. Тэр хүний муу чанар нь юунд оршиж байгаа вэ гэвэл, өөртөө чиглэсэн энэ хайрыг нь зүй ёсоор чиглүүлээгүй бөгөөд түүнд бусдыг болон Бурханыг хайрлах хайр дутагдаж байгаад оршиж байгаа юм. Тэр хүн өөрийгөө хамгийн давуу амьтан гэж үзээд тэжээмэл нохойг илдэг шиг өөрийгөө эрхлүүлэн илж, улмаар нохойноос ч дор болдог байна.

Нэгэн захидалдаа Абдул-Баха ингэж бичжээ:

*“Абдул-Баха хэсэг сүсэгтнүүдэд хэлэхдээ, муу ёр гэж оршдоггүй, тэр ч байтугай муу ёр гэдэг хоосон хөндий зүйл юм гэж хэлсэн нь туйлын үнэн зүйл юм. Учир нь, хүний хамгийн адгийн муу ёрт чанар бол зөв замаас хазайж, үнэнээс өөрийгөө халхалдаг явдал юм. Алдаа гэдэг бол удирдамж дутагдсаны шинж, харанхуй гэдэг бол гэрэл байхгүйн шинж, харанхуй бүдүүлэг гэдэг бол эрдэм мэдлэг дутагдсаных, худалч хуурмаг гэдэг бол үнэнч шударга зан дутагдсаных, сохор гэдэг хараагүйнх, дүлий гэдэг бол сонсголгүйнх билээ. Тиймээс, алдаа, сохор, дүлий, харанхуй бүдүүлэг гэсэн зүйлс нь хоосон хөндий, үл орших зүйлс юм.”*

Тэрээр дахин ингэж айлджээ:

*“Анх бүтээгдэх үед хүнд муу чанар гэж байхгүй, бүх юм нь сайн сайхан байдаг. Зарим хүмүүст төрөлхийн муу чанар гэж байдаг боловч энэ нь мөн чанартаа тийм биш юм. Жишээлбэл, дөнгөж төрсөн нялх хүүхдэд шунал, уур хилэн, ааш аранийн муугийн шинж тэмдэг байна гэж бодъё. Тэгвэл тэр хүний мөн чанарт сайн муу хоёр тал төрөхөөс нь эхлээд байна гэсэн үг. Энэ бол байгаль орчлонгийн хуулийн эсрэг зүйл болно. Үүний харуу нь юу вэ гэвэл, шунал гэдэг бол нэг юмыг улам ихээр хүсэх чанар. Хэрэв энэ чанарыг зөв талаар нь ашиглах юм бол маш сайн зан чанар юм. Тиймээс хэрэв хүн мэдлэг ухаан эзэмших, эсвэл энэрэнгүй, өгөөмөр, шударга болохыг хүсэн эрмэлзэж, үүнд түүний бүх шунал чиглэгдвэл энэ нь туйлын сайшаалтай зүйл*

*болно. Түүнчлэн хэрэв тэрээр уур хилэн, муухай ааш аранишингаа цусайд шунагч зэрлэг араатан шиг дарлан мөлжигчдийн эсрэг ашиглах юм бол туйлын сайшаалтай хэрэг болно. Гэвч эдгээр зан чанараа зөв зүйлд ашиглахгүй бол үнэхээр зэмлэл хүлээхүйц болно. Энэ нь хүний бүх чанарт хамаарна. Хүний чанар нь амьдралын үнэт баялаг билээ. Хүн тэднийг хууль бус буруу зүйлд ашиглавал туйлын их жигшүүртэй юм болно. Тиймээс байгалийн бүтээл гэдэг бол анхнаасаа сайн сайхан байдаг нь ойлгомжтой.”* - “Учир нь тайлагдсан зарим асуудал”, х. 201-202

Муу муухай гэдэг бол ямагт хүний амьдралд сайн сайхан зүйл дутагдаж байдагтай холбоотой юм. Хүний доод чанар нь тэнцвэргүйгээр хөгжсөн бол үүнийг засаж залруулахын тулд муу чанарыг нь арилгах гэж оролдох биш харин сайн талыг нь ихэсгэх гэж оролдох хэрэгтэй. Ингэснээр зохих тэнцвэр бий болно. “*Та нарт Би амьдрал хайрлаж, та нар тэр амьдралаа улам их арвин хэмжээгээр хүртээсэй гэсэндээ Би ирсэн*” гэж Христ хэлсэн. Тийм ч учраас бидэнд хэрэгтэй зүйл бол жинхэнэ амьдрал, жинхэнэ ёсны амьдралаа нэмэгдүүлэх явдал! Бахаулагийн сургаал ч Христийн сургаалтай ижил. Тэрээр хэлэхдээ, “*Өнөөдөр энэхүү Боол дэлхий ертөнцийг амьдруулан сэргээхээр ирсэн*” (Раист илгээсэн Бичиг) гэж хэлсэн билээ. Өөрийн дагалдагч нарт хандан Тэрээр: “*Намайг дагагтун. Чингэвээс Бид та нарыг хүн төрөлхтнийг сэргээн амьдруулагч болгоно.*” (Ромын хамба ламд илгээсэн Илгээлт бичиг)

## Арванхоёрдугаар бүлэг

### ШАШИН БА ШИНЖЛЭХ УХААН

*“Мухаммедын хүргэн хүү Али хэлэхдээ: “Шинжлэх ухаантай нийцэх зүйл бол мөн шашинд нийцнэ” гэжээ. Хүний оюун ухаан ойлгож хүлээж авах чадваргүй зүйлийг шашин бас хүлээн зөвшөөрөх ёсгүй. Шашин, шинжлэх ухаан хоёр мөр зэрэгцэн хөгжих ба шинжлэх ухаанд эсрэг шашин бол үнэн биш юм.” “Парист айлдсан айлдварууд” х. 78*

#### Төөрөгдлөөс болж зөрчил үүсдэг

Бахауллагийн нэгэн үндсэн сургаал бол жинхэнэ шинжлэх ухаан, жинхэнэ шашин хоёр уялдан нийцэж байх тухай сургаал юм. Үнэн бол нэг л байдаг бөгөөд зөрчил гарах тохиолдол бүр нь үнэнээс болж байгаа биш харин алдаа төөрөгдлөөс болж үүсдэг. Хуурамч шинжлэх ухаан, хуурамч шашин хоёрын хооронд олон зууны турш тэмцэл зөрчил гарч ирсэн бөгөөд тэдгээр зөрчлүүдийг сайтар ажиглаад үзвэл бүгд харанхуй мунхаг байдал, хоосон дэмий санаа бодол, агаа жөтөө, явцуу үзэл, үл эвлэрэнгүй зөрүүд гөжүүд хандлага юм уу шашин, шинжлэх ухаан хоёрын алиных нь ч үзэл санаанд үл нийцэх шалтгаанаас болж гарч байсан нь харагдана. Учир нь, энэ хоёрын үзэл санаа бол нэг юм. Гекслигийн хэлснээр, *“Гүн ухаанчдын агуу үйлс нь тэдний оюун ухааны үр бүтээл байсан гэхээсээ илүү шашны эрхэм үзэл санаа тэдний оюун ухааныг чиглүүлж байсны үр бүтээл юм. Тэд үнэнийг нээхдээ чухамдаа учир зүйн ухаалаг сэтгэлгээгээрээ биш харин тэсвэр тэвчээр, хайр, үнэнч чанар болон өөрийгөө огоорох сэтгэлээрээ нээсэн юм.”* Математикч Буль ингэж хэлсэн байна: *“Геометрийн дүгнэлт бол мөн чанартаа мөргөн залбирах үйл явц: хязгаарлагдмал зүйлсийн талаар ойлголт өгөхийг хязгаарлагдмал ухаан Хязгааргүй ухаанаас гүйн залбирах үйл явц юм.”*

Шашин, шинжлэх ухааны агуу их зөнч мэргэн хүмүүс хэзээ ч бие биеэ үгүйсгэдэггүй байв. Чухамдаа эдгээр агуу соён гэгээрүүлэгч нарын шавь нар сургаалынхаа үзэл санааг биш харин



үг үсгийг шүтэн биширдэг байсан тул хожмын Зөнч мэргэдийг хяхан хавчиж, хөгжил дэвшлийг эрс ширүүн эсэргүүцэн няцаадаг байсан юм. Тэд өөрсдийн дагадаг шашны сургаалыг судалж, өөрсдийн хязгаарлагдмал ухаандаа тохируулан түүний онцлог шинжийг туйлын нарийн төвөгтэйгээр тодорхойлсон байдаг. Тэр бүхэн л тэдний хувьд цорын ганц үнэн гэрэл гэгээ байжээ. Хэрэв Бурхан Хязгааргүй буян хишгээрээ бөмбөрцгийн өөр нэгэн өнцгөөс гэрэл илгээж, онгодын тэр дэнлүү өөр зөнч мэргэний гарт урьдынхаас илүү асан дүрэлзэж байсан бол шинэ гэрлийг угтан авч, цоо шинэ сэтгэлээр хамаг гэрэл гэгээний Эцэгтээ талархал өргөн шүтэн бишрэхийн оронд тэд уурлан ундуйцаж, тэвдэн сандардаг байжээ. Учир нь, энэ шинэ гэрэл гэгээ бол тэдний тооцоотой үл нийцэж байсан байна. Тэр гэрэл тэдний ойлголтонд үл нийцсэн өнгөтэй, үл нийцсэн газраас гэрэлтэж байсан тул бүх л арга чаргаар түүнийг унтраах ёстой гэж үзэж байжээ. Тэгж унтраахгүй бол хүмүүсийг буруу номын замаар хөтлөн дагуулах нь байна хэмээн айн сүрддэг байжээ! Зөнч мэргэдийн дайснуудын олонхи нь ийм бодол сэтгэлгээтэй, сохорчуудын сохор удирдагч нар байсан бөгөөд өөрсдийн үнэн гэж бодож байгаа тэр зүйлийнхээ хийсвэр ашиг сонирхлын төлөө шинэ, илүү өргөн дүүрэн үнэнийг няцаан үгүйсгэж байсан юм. Харин нөгөө хэсэг хүмүүс нь тэднийг бодвол ухаан дорой байсан тул хувиа хичээсэн үзлийнхээ улмаас үнэний эсрэг тэмцэж, эсвэл оюун санаагаар үхсэн мэт идэвхгүй үлбэгэр байсан тул хөгжил дэвшлийн замыг тагладаг байсан байна.

### **Зөнч мэргэдийг хяхан хавчиж байсан нь**

Шашны агуу Зөнч мэргэдийг анх тодрох үед нь хэзээд жигшин зэвүүцэж, няцаан доромжилдог байсан билээ. Тэд болон тэдний анхны шавь нар хэзээд энэ зэвүүцлийнх нь золиос болж, өөрсдийн эд баялаг, амь амьдралаа Бурханы замналд золиослодог байсан юм. Бидний амьдарч байгаа энэ үед ч бас ийм л байна. 1844 оноос хойш Баб, Бахаулла нарын олон мянган дагалдагчдыг харгис хэрцгийгээр тамлан алж, тэдний дундаас олон хүн шорон гянданд хоригдож, харь нутагт цөлөгдөж, эд баялгаа булаалган

доромжлогдож ирсэн билээ. Хамгийн сүүлийн үеийн энэ шашин өмнөх шашнуудаас хавьгүй ихээр “цусанд загалмайлагдаж”, өнөөг хүртэл тамлал зовлон үргэлжилсээр байна. Шинжлэх ухааны зөнч мэргэн хүмүүст ч адил зүйл тохиолдож байлаа. 1600 онд дэлхий нарыг тойрдог хэмээн сургалаа гэж Жордано Бруног буруу номтоноор зарлаж, амьдаар нь шатаасан билээ. Хэдхэн жилийн дараа гарамгай гүн ухаанч Галилей мөн л энэ тавиланг угтах байсан тул уг сургаалаасаа өөрөө татгалзжээ. Хожмын үед дэлхий ертөнц зургаан мянган жил ч хүрэхгүй хугацааны өмнө зургаан өдрийн дотор бүтээгдсэн гэсэн Ариун Судрын сургаалыг няцаалаа хэмээн Дарвин болон орчин үеийн геологийн ухааны анхдагч эрдэмтдийг эрс шийдэмгийгээр буруутган зүхэж байжээ. Гэхдээ шинжлэх ухааны шинэ ололт нээлтийг эсэргүүцэх явдал дан ганц шашнаас гарч байсангүй. Шинжлэх ухаан дотор ч мөн адил хуучин үзэлтнүүд мөн л шашны хуучинсаг үзэлтнүүдийн адил хандлагатай байв. Колумбыг тэр үеийн шилдэг гэгдэж байсан эрдэмтэн мэргэд шоолон тохуурхаж, хэрвээ усан онгоцууд ертөнцийн нөгөө өнцөгт хүрч чадах юм бол тэд дахин дээшээ мацаж буцан ирж чадахгүй гэж өөрсөндөө нотолж байжээ. Цахилгааны тухай шинжлэх ухааныг анх нээсэн Гальваниг үе тэнгийнх нь эрдэмтэд зэмлэж, “мэлхийний бүжгийн багш” гэж шоолдог байсан байна. Цусны эргэлтийн талаар нээлт хийсэн Гарвейг мэргэжил нэгт нөхөд нь бас шоолон тохуурхаж, номыг гажуудуулсан хэмээн буруутган эрдмийн хүрээлэнгийн гишүүнээс хөөсөн байна. Стивенсон моторт хөдөлгүүрийг анх нээхэд Европын математикчид уг нээлтийг сайтар судлан үзэхийн оронд хөдөлгүүр нь хэзээ ч гөлгөр замаар хүнд ачааг үүрэн хөдөлж чадахгүй, яагаад гэвэл дугуйнууд гөлгөр гадаргуун дээр хальтирч байрнаасаа ч хөдөлж чадахгүй гэж нотлохыг олон жилийн турш оролджээ. Эдгээр олон жишээнүүд дээр эрт дээр үеийн болон орчин түүхэн баримтаас, тэр ч бүү хэл, манай үеийн туршлагаас ч хэмжээлшгүй олон бусад жишээнүүдийг нэмж дурдаж болох билээ. “Эсперанто” хэлийг зохиосон доктор Заменгоф олон улсын гайхамшигтай хэл зохиосныхоо төлөө Колумб, Гальвани, Стивенсон нарын адил мөн л эсэргүүцэл, мунхаг тэнэг хандлагатай тулгарч явж байжээ. Эсперанто ч хүртэл

дөнгөж 1887 онд зохиогдсон мөртөө өөрийн гэсэн золиослогдсон баатруудтай билээ.

### Эвлэрлийн эрин зуун

Сүүлийн тавь орчим жилийн турш цаг үеийг өөрчлөн тохинуулах олон өөрчлэлт гарч, Үнэний шинэ Гэрэл гэгээ мандан гарч, өнгөрсөн үеийн зөрчил тэмцэл үеэ өнгөрөөсөн билээ. Өнөөдөр тэгвэл хэдхэн жилийн өмнө шашныг ертөнцийн хөрснөөс хөөн зайлуулна гэж онгирон тохуурхаж байсан тэр олон материалист, бурхангүйн үзлийн догм номлогчид хаана байна? Өөрсдийнх нь номлолыг хүлээн зөвшөөрөөгүй хүмүүсийг тамын галд унан тарчлана гэж зөгнөж байсан тэр шажин номлогчид хаана байна. Тэдний дэгдээсэн үймээн самууны цуурай өнөөг ч хүртэл сонсогдож байгаа боловч тэдний ноёрхол нь түргэн нурж, номлол нь ч хүчин мөхөсдөж байна. Эдүгээ урьдын цагт шуугиулж байсан тэр номлолууд нь жинхэнэ шашин ч биш, жинхэнэ шинжлэх ухаан ч биш байсныг бид харж байна. Орчин үеийн нээлт бүтээлийг судалсан ямар эрдэмтэн хүн “элэг шүүс ялгаруулдгийн адил тархи бодол санаа ялгаруулдаг” гэдэгт итгэх юм бэ? Эсвэл хүний бие махбод ялзран доройтох нь бас хүний сэтгэл санаа ялзран доройтоход хүргэнэ гэдэгт хэн итгэх юм бэ? Хүний бодол санаа чөлөөтэй байхын тулд сэтгэхүйн болон оюун санааны амьдралын дээд орчинд дүүлж, зөвхөн материаллаг ертөнцөөр хязгаарлагдах ёсгүй гэдгийг бид мэднэ. Байгаль дэлхийн тухай бидний мэдэх мэдлэг бол ирээдүйн танин мэдэх мэдлэг ухааны тэнгис далай дотор зөвхөн нэг дусал төдий л юм гэдгийг хэн бүхэн мэднэ. Тиймээс бид гайхамшигт ид шид энэ ертөнцөд биелэх боломжтой гэж үзэхдээ тэр нь байгалийн жам ёсыг зөрчине гэж бодохгүй харин бидний үл мэдэх бас олон хүчнүүд энэ хорвоо дээр байж болзошгүй хэмээн таамаглаж байгаа хэрэг юм. Яг л урьд нь бид цахилгаан, рентгены хүч гэж байдгийг мэддэггүй байсан шиг бидний мэдэхгүй олон юм байж болно. Нөгөө талаас өнөөдөр манай шашны тэргүүн нарын дотор ертөнц дэлхий зургаахан хоногийн дотор бүтээгдсэн гэдэгт хүн итгэснээр авралд хүрнэ гэж хэлэх, эсвэл “Их нүүлт”

номонд Египетэд тархсан тахал өвчнийг дүрсэлж бичсэнийг яг тэр утгаар нь үгчлэн ойлгох, эсвэл дайснуудаа хөөхөд нь Жошуад туслахын тулд нар тэнгэрт хөдөлгөөнгүй зогсож байна гэх (дэлхий эргэлдэхээ больсон гэх), эсвэл гэгээн Афанасийгийн сургаалыг хүлээн зөвшөөрөөгүй хүн “үүрд мөнх устан мөхнө” гэдэгт итгэх хүн байна гэж үү? Иймэрхүү итгэл үнэмшлийг янз бүрийн хэлбэрээр илэрхийлж болно, гэвч яг тэр утгаар нь үгчлэн хүлээн авах хүн байхгүй биз дээ? Иймэрхүү үлгэр домгийг хүмүүс шууд утгаар нь ойлгож, зүрх сэтгэл, оюун ухаандаа тээж явдаг цаг одоо нэгэнт өнгөрч байна. Ийм хоцрогдсон үзэл бодол, догм номлолыг замхруулж, жинхэнэ үнэнийг ил гаргахад асар их үүрэг гүйцэтгэсэн шинжлэх ухаанч эрдэмтдэд шашны ертөнц талархах ёстой. Гэвч амьдрал бол дан ганц махан бодь биш, үл үзэгдэх ертөнц нүдэнд харагдах ертөнцөөс илүү агуу гэдгийг ертөнцөд харуулж, оюун санааны амин чухал үнэнийг нотолсон жинхэнэ ёсны ариун гэгээнтэн хүмүүст шинжлэх ухааны ертөнц бүр ч илүү талархах ёстой билээ. Эдгээр эрдэмтэд, сэцэн мэргэд бол мандах нарны анхны цацрагийг хүртэж, дор байгаа ертөнц дэлхийд тусган тольдсон уулын оргилууд лугаа адил байсан билээ. Харин одоо энэ нар маань нэгэнт өндөрт мандаж, түүний цацраг бүх л дэлхийг гийгүүлж байна. Бахауллагийн сургаалаас бид хүний зүрх сэтгэл, оюун ухааны шаардлагыг хангаж, шашин, шинжлэх ухаан хоёрыг нэгтгэсэн гайхамшигт үүдэл нээлтийг олж авсан билээ.

### Үнэнийг эрэлхийлэхүй

Үнэнийг хэрхэн эрэлхийлэх талаар айлдсан Бахайн сургаалд шашин, шинжлэх ухаан хоёрын уялдаа холбоог маш тодорхой тайлбарласан байдаг. Хүн бүхий л атгаг сэжиг, ялгаварлан гадуурхах үзлээ таягдан хаяж, сэтгэл санааны эрх чөлөөтэйгээр үнэнийг эрэн хайх ёстой юм.

Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Үнэнийг олохын тулд бид өөрсдийн элдэв ялгаварлан гадуурхах атгаг сэжиг, өчүүхэн хуурмаг төсөөллөөсөө ангижирч,*

шинийг хүлээн авахад бэлэн нээлттэй бодол ухаантай байх нь нэн чухал. Бидний тагш “би” гэсэн үгээр дүүрэн байх юм бол түүнд амьдралын рашаан ус хийх ямар ч зай завсар үгүй болно. Өөрийн бодлыг зөв, бусдын бодлыг буруу гэж төсөөлдөг үзэл нь эв нэгдэлд хүрэх замд учрах хамгийн уришигт саад тотгор байдаг бөгөөд үнэн нэг л байдаг тул үнэнийг олоход эв нэгдэл зайлшигүй шаардлагатай...

“Ямар ч үнэн зүйл өөр нэгэн үнэнтэй зөрчилдөх учиргүй. Ямар ч чийдэнгээс асааж байлаа гэсэн гэрэл бол ямагт сайн байдаг. Сарнай цэцэг ямар ч цэцэрлэгт ургасан үзэсгэлэн гоо төгөлдөр. Од мичид Дорноос ч бай, Өрнөөс ч бай ялгаагүй адилхан гэрэл цацруулна. Атгаг сээжгээсээ чөлөөлөгддөгтүн. Тэгсэн цагт ямар тэнгэрийн хаяагаар мандсан ч Үнэний Нарыг чи бишрэх болно. Үнэний Тэнгэрлэг гэрэл Есүс Христэд гэрэлтэж байсан бол мөн Моисей ба Буддад бас гэрэлтэж байсан юм гэдгийг та ойлгох болно... “Үнэнийг эрэлхийлэх” гэдгийн утга санаа үүнд оршино.

“Энэ нь бас бид урьдын үзэл бодлоо орхин, үнэнд хүрэх замд маань саад болж байгаа бүхнийг зайлуулна гэсэн үг юм. Хэрэв шаардлагатай бол, эрдэм мэдлэгээ бүр эхнээс нь дахин олохоос ч айх хэрэггүй. Ямар нэгэн шашин юм уу хүнд зориулсан хайр маань биднийг мухар сүсэгтэн болтол нүдийг маань таглах ёсгүй. Энэ бүх хүлээнээс чөлөөлөгдсөний дараа эрх чөлөөтэй оюун ухаанаар бид зорилгодоо хүрч чадна.” “Парист айлдсан айлдварууд”, х. 82-83

## Жинхэнэ агностицизм<sup>1</sup>

Бурханы мөн чанарыг хүний оюун ухаанаар танин мэдэхийн аргагүй гэдэг талаар Бахайн сургаал нь шинжлэх ухаан ба гүн ухаантай санал нэг байдаг. Томас Гексли, Герберт Спенсер нар анхдагч эх сурвалжийн мөн чанарыг танин мэдэж болохгүй гэж сургаж байсантай адил Бахаулла “Бурхан бүхнийг танин мэднэ, Түүнийг хэн ч танин мэдээж ул чадна” гэж сургасан юм. “Тэнгэрлэг мөн чанарт хүрэх зам хаалттай, жим нь явахын эцэсгүй” билээ.

<sup>1</sup> Агностицизм-[фил.] - эвлэршгүй, эсрэг тэсрэг үзэл-орч

Учир нь, хязгаарлагдмал нь Хязгааргүйгээ хэрхэн таньж чадах, далайн нэгхэн дусал бүх л далайг хэрхэн багтааж чадах, хумхын тоос бүх л орчлонг хэрхэн агуулж чадах билээ. Гэсэн ч бүхий л орчлон болбоос Бурханы илэрхийлэл юм. Усны нэгхэн дусалд тэнгис далай мэт өргөн утга учир агуулагдаж, хумхын тоосны нэг ширхэг дотор хамгийн цэцэн мэргэн эрдэмтний оюун ухаанд үл дийлдэх бүх л орчлонгийн ач холбогдол оршино. Материйн мөн чанарыг судлагч химич, физикчид массаас молекулд, молекулаас атомд, атомаас электрон гэх мэтчилэн судлахдаа алхам тутамдаа бэрхшээлтэй учирч, эцсийн эцэст хамгийн хурц оюун ухаан ч цаашаа илүү гүн нэвтэрч чадахаа больж, үл ойлгогдох нууцаар үүрд бүрхэгдсэн Хязгааргүйн өмнө чадалгүйгээ ухаарна.

*“Цуурсан ханан дотор ургасан цэцэг чамайг ханан дотроос сугалан авч, үндэстэй чинь цуг гартаа атганам. Бяцхан цэцэг чи юу юм бэ, үндэс чинь юу юм бэ гэдгийг би ойлгож чаддагсан бол эцсийн эцэст хүн гэж юу вэ, Бурхан гэж юу вэ гэдгийг ойлгож чадах сан.”* - Теннисон

Хэрэв ханан дотор ургасан цэцэг, материйн өчүүхэн ширхэг атом нь хамгийн хурц ухаантан хүний ой ухаанд ойлгогдохооргүй их нууц оньсого шиг юм бол хүн бүх л орчлонг ойлгож чадна гэж үү? Хүн хамаг бүхний эх сурвалж болсон Хязгааргүй Бурханыг тодорхойлон дүрсэлж чадна гэж үү? Бурханы мөн чанарын талаарх шашны элдэв таамаглал хийх нь үр ашиггүй, мунхаг явдал юм.

### **Бурханы тухай мэдлэг**

Түүний мөн чанар нь ойлгогдохгүй ч гэсэн буян хишгийнх нь илэрхийлэл хаа сайгүй илэрхий байна. Анхдагч эх сурвалжийг таньж мэдэж чадахгүй ч гэсэн үр нөлөө нь бидний чадвар бүхэнд мэдрэгдэж байна. Зураачийн бүтээлийг харснаар зураачийн тухай мэдэж болдог шиг орчлонгийн аль нэг талыг мэдсэнээр, жишээлбэл, байгаль юм уу хүний мөн чанарыг мэдсэнээр, нүдэнд харагдах болон үл харагдах зүйлсийг мэдсэнээр Бурханы үр бүтээлийг таньж, Тэнгэрлэг үнэнийг эрэлч хүн Түүний Алдрыг жинхэнэ ёсоор таньж мэднэ.



*“Бурханы Алдарыг тэнгэр тунхаглаж, Түүний үр бүтээлийг диваажин харуулна. Нэг өдөр нөгөө өдөрт үг дамжуулж, нэг шөнө нөгөө шөнөд мэдлэгийг үзүүлнэ.”* Сүлд дуулал 19, 1-2

## **Тэнгэрлэг Тодруулагчид**

Бүх юмс үзэгдэл Бурханы буян хишгийг их бага хэмжээгээр тодруулан илэрхийлнэ, бүх бодгаль юмс нарны гэрэлд гийж, түүний цацраг туяаг их бага хэмжээгээр тусгана. Хөөний жаахан хэсэг нарны туяаг бага тусгана, чулуу түүнээс арай илүү тусгана, тэгвэл шохойн жижигхэн хэсэг бүр ч илүү тусгана. Гэсэн ч энэ бүх тусгалд бид гэрэлт нарны өнгө, хэлбэрийн ул мөрийг олж хардаггүй. Харин төгс толинд нарны хэлбэр өнгө тэр аяараа тусдаг бөгөөд тэр тусгалыг харах юм бол яг л нарыг харж байгаагай адил байдаг. Бурхан бидэнтэй харилцахдаа мөн л ийм замаар харилцдаг. Чулуу бидэнд Тэнгэрлэг шинж чанарын талаар ямар нэгэн зүйлийг илэрхийлж чадна, цэцэг бол арай илүү илэрхийлнэ, амьтан бол гайхамшигтай мэдрэхүй, зөн билиг, хүч чадал, хөдөлгөөнөөрөө бүр ч илүү илэрхийлнэ. Хамгийн доод түвшний хүмүүс ч гайхамшигт Бүтээгчийн гайхамшигт чанарын талаар олон зүйлийг илэрхийлж чадна. Харин яруу найрагч, мэргэн цэцэн, суут ухаантан хүмүүсээс бид илүү их илэрхийллийг олж хардаг бол агуу их Зөнч мэргэд болон шашны Үндэслэгч нар нь хүн төрөлхтөнд Бурханы хайр ивээл, мэргэн ухааныг тольдон тусгах төгс толинууд юм. Бусад хүмүүсийн толь бол хувиа хичээх, атгаг сэжиг үзлийн тоос тортогт халгартсан байдаг. Харин Зөнч мэргэдийн толь бол цэвэр ариун, ямар ч өө сэвгүй байдаг бөгөөд Бурханы Хүсэл тааллыг л тольддог. Тийнхүү тэд хүн төрөлхтний агуу их соён гэгээрүүлэгч болдог байна. Тэднээр дамжин ирэх Тэнгэрлэг сургаал болон Ариун Сүнсний Хүч чадал нь хүн төрөлхтний хөгжил дэвшлийн эх сурвалж болдог бөгөөд Бурхан хүмүүст бусад хүмүүсээр дамжуулан тусална. Амьдралын арай илүү түвшинд хүрсэн хүн бүр арай доод түвшинд байгаа бусад хүмүүстээ туслах ёстой, харин хамгийн дээд түвшинд байгаа хүмүүс нь бүх л хүн төрөлхтнийг дэмжин туслагч нар юм. Бүх хүмүүс хоорондоо сунадаг олсоор холбогдсон юм шиг байгаа биз!

Хэрэв хүн бусад хүмүүсийн түвшнээс арай өндөрт гарвал олс чангарна. Хуучны нөхөд нь түүнийг доош нь чангаахыг хүсэвч адилхан тэнхээгээр тэрээр тэднийг дээш нь татна. Тэрээр дээшлэх тусам бүх л ертөнц түүнийг доош нь чангааж байгааг улам мэдрэх бөгөөд тэнгэрлэг дэмжлэгээс ч улам их зуурна. Энэ тэнгэрлэг дэмжлэг нь түүнд түүний дээр буй цөөн хэдэн хүмүүсээр дамжин ирнэ. Хамгийн дээд шатанд байгаа хүмүүс болбоос агуу их Зөнч мэргэд, Аврагч, Тэнгэрлэг “Тодруулагч” нар бөгөөд тэд өөрсдийн амьдарч байсан эрин үед бүх л дэлхийн ачааг ганцаараа нуруун дээрээ үүрч, ганцхан Бурханаас л дэмжлэг авч байсан юм. “Бидний нүглийн ачааг Тэрээр үүрсэн юм” гэж тэдний талаар хэлж болох билээ. Зөнч мэргэн бүр дагалдагчдынхаа хувьд “Зам, Үнэн, Амьдрал” нь байсан юм. Зөнч мэргэн бүр хүлээн авах чадвартай зүрх сэтгэл бүрт Бурханы буян хишгийг дамжуулагч суваг байсан юм. Зөнч мэргэн бүр хүн төрөлхтнийг өсгөн дэвшүүлэх тэнгэрлэг төлөвлөгөөнд өөрийн гэсэн үүргээ гүйцэтгэсэн билээ.

### **Орчлон Хорвоо бүтээгдсэн нь**

Бахаулла орчлон хорвоо бол цаг хугацааны эхлэлгүй хэмээн сургасан юм. Орчлон хорвоо бол Анхдагч Агуу Эх сурвалжаас мөнхийн үүсэлтэй билээ. Бүтээл нь хэзээд Бүтээгчийн эзэмшилд байсан бөгөөд байх ч болно. Ертөнц, тогтолцоо нь өөрчлөгдөж болно, гэвч орчлон үлдэнэ. Ямар нэгэн нийлбэрээс бүрдсэн аливаа зүйл цаг нь болоход задрах тавилантай байдаг боловч бүрэлдэхүүн хэсгүүд нь хэвээр үлддэг. Дэлхий ертөнц, цэцэг юм уу хүний бие махбод “хов хоосон зүйлээс” бүтдэггүй бөгөөд харин өмнө нь тархай бутархай байсан олон элементүүд нэгдсэнээр бүрдэж, өмнө нь нуугдмал байсан зүйлийг илт болгодог юм. Эдгээр элементүүд дахин задарч, хэлбэр алдагдах боловч ямар ч элемент хоосон болж хувирдаггүй. Шинэ нийлбэр, шинэ хэлбэрүүд ч хүртэл хуучин элементүүдийн балгас дээр тулгуурлан үүсдэг. Дэлхий бүтээгдсэний түүх бол зургаан мянга биш харин сая, түмэн жилээр тоологдоно гэсэн эрдэмтдийн дүгнэлтийг Бахаулла дэмжсэн билээ. Эволюцийн (хувьсал хөгжлийн-орч) онол бүтээлч хүч чадлыг үл үгүйсгэдэг. Харин ч

илэрхийллийнх нь арга барилыг дүрсэлдэг. Одон оронч, геологич, физикч, биологич нарын судалгааны үр дүнд аажим аажмаар илт болж буй материаллаг орчлонгийн бүтээгдсэн гайхамшигт түүх нь эртний судар номуудад өгсөн хялбаршуулсан дүрслэлээс илүү бидний гайхал бишрэлийг төрүүлдэг билээ. “Хуучин гэрээ”-н дэх эхлэлийн тухай нэгдүгээр дэвтэрт харин энэ түүхийн оюун санааны үндсэн утга учрыг бэлгэдлийн аргаар тайлбарласан байдаг. Энэ нь хамгийн хичээнгүй сурагчийн хичээгээд хичээгээд дүрслэн илэрхийлж чаддаггүй зүйлийн чадварлаг зураач багсаа хэдхэн удаа хүргээд л зохих илэрхийллийг гаргаж чаддагтай адил юм. Хэрэв материаллаг тал нь оюун санааны талыг халхалж байвал материаллаг тал байхгүй байсан нь дээр, харин оюун санааны үндсэн утга учрыг нэгэнт сайтар ойлгосон бол материаллаг нарийвчлалыг нь мэдсэнээр дүр зургийг улам гайхамшигтай, улам баян сүрлэг болгож, зүгээр нэг ноорог биш жинхэнэ уран бүтээл болгоно.

Абдул-Баха үүнтэй холбогдуулан ийнхүү хэлжээ:

*“Энэ орчлон дэлхий, энэ хязгааргүй огторгуй дэлхий бол эхлэлгүй гэсэн нэг гүн утга учир бүхий үнэнийг мэдтүгэй... Бүтээлгүй бүтээгч гэж байхгүй ба хэнд ч юу ч хангадаггүй хангагч байна гэж төсөөлөх боломжгүй юм. Учир нь, энэ бүх тэнгэрлэг алдар нэр, шинэ чанарууд нь эзэнтэй байж таарна. Хэрэв Бид ямар ч юм оршиж байгаагүй тийм цаг үеийг төсөөлөн бодох юм бол энэ төсөөлөл маань Бурханы тэнгэрлэг чанарыг үгүйсгэсэнтэй адил болно. Түүнчлэн, туйлын хоосон оршин тогтнол нь оршин тогтнол болж чадахгүй. Хэрэв юмс үзэгдэл ер оршиж байгаагүй бол тэд үүсэн бий болохгүй байсан. Тиймээс Эв нэгдлийн Мөн чанар (өөрөөр хэлбэл, Бурханы оршин тогтнол) үүрдийн мөнх байдгийн адил, өөрөөр хэлбэл, эхлэл төгсгөлгүй байдгийн адил оршихуйн энэ ертөнц, хязгааргүй энэ огторгуй дэлхий ч мөн эхлэл төгсгөлгүй гэсэн үг. Жишээлбэл огторгуй орчлонгийн нэгэн хэсэг нь юм уу нэгэн бөмбөрцөг нь оршиж эхлэх юм уу задран устаж болно, гэхдээ бусад хязгааргүй олон гараг эрхэс нь орисон хэвээр байна. Орчлон хэзээ ч задран устахгүй. Харин ч, оршин тогтнол нь мөнхийн бөгөөд дуусашгүй юм. Гараг*

*бүхэн эхлэлтэй юм бол бас төгсгөлтэй. Яагаад гэвэл, аливаа дан буюу хамтын нийлбэр, бүрдэл нь задрах жамтай. Цорын ганц ялгаа нь зарим нь хурдан задарч, зарим нь арай удаан задардагт оршихоо; биш ямар нэгэн нийлбэрээс бүрдсэн зүйл нь эцэстээ задрахгүй байх нь боломжгүй асуудал юм.* ” “Учир нь тайлагдсан зарим асуултууд” х. 168-169

### **Хүний хувьсал хөгжил**

Төрөл зүйл олон сая жилийн турш хөгжин хувьссан гэсэн онолтой хүний бие махбодын хөгжлийг холбож үзсэн биологчийн санааг Бахаулла бас дэмжсэн юм. Эхлээд маш энгийн, өчүүхэн жаахан хэлбэрээс эхлэн хүний бие махбод олон үе шат, олон цаг үеийг дамжин хувьсаж, улам нарийн төвөгтэй зохион байгуулалттай болж, өнөөг хүрсэн билээ. Хүн бүрийн бие махбод ийм үе шатуудыг даван туулж, өчүүхэн жаахан нялцгай биетээс бүрэн бүтэн хүн болон хөгжсөн билээ. Хэрэв энэ хөгжил нэг бие бие махбодын хувьд үнэн юм бол бүх хүн төрөлхтний хөгжил ч гэсэн ийм олон үе шатыг давсан хэмээн хүлээн зөвшөөрөхөд бид яагаад ичиж зовох ёстой юм бэ? Энэ бол хүн сармагчингаас үүссэн гэж хэлэхээс огт өөр зүйл юм. Хүний үр хөврөл эхэндээ загас шиг загалмайтай, сүүлтэй байсан байж болох юм. Гэхдээ хүний үр хөврөл хэзээ ч загас байгаагүй юм. Хүний үр хөврөл байсан. Тийнхүү хүний бие махбод янз бүрийн үе шатыг давж, удаан хувьсал хөгжилд өртөхдөө гадна талаараа янз бүрийн амьтантай төстэй байсан ч ямагт ирээдүйд бидний мэдэх өнөөдрийн хүн, тэр ч бүү хэл, өнөөдрийнхөөс ч илүү хүн болох хүртлээ хүний бие махбод хэвээрээ л байсан юм.

Абдул-Баха ингэж хэлсэн байна:

*“Гэвч энэ газар дэлхий өнөөгийнхөө хэлбэрээр нэгэн дор бий болчихоогүй харин янз янзын үе шатыг давж өнөөгийн төгс төгөлдөр байдалд хүрсэн юм...Хүн оршин тогтнолынхоо эхэн үед газрын хэвлийд эхийнхээ хэвлийд байдаг шиг үр хөврөлийн шатандаа байж байгаад аажмаар өсөн хөгжиж, нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт... шилжин хувьсаж, одоогийнхоо гоо төгс хэлбэрээ*

*олж, хүч чадалтай болсон юм. Эхэн үед тэрээр ийм гоо жавхланта, төгс сайхан байгаагүй ба энэ хэлбэр дүрс, гоо үзэсгэдэн, сүр жавхлангаа тэрээр бага багаар олсон гэдэг нь тодорхой... Энэ газар дэлхий дээр оршиж ирсэн хүний хөгжил нь анхнаасаа өнөөгийн энэ байдал, хэлбэр, нөхцлийг олох хүртлээ урт удаан хугацаанд хөгжиж... ирсэн юм. Гэвч хүн оршин тогтнолынхоо анхан үеэс онцгой зүйл байв... Урьд нь байж байгаад алга болсон зарим эрхтний ул мөр (хүний биед) байгаа нь тухайн төрөл зүйлийг тогтворгүй, хосгүй онцгой биш гэдгийг нотолж буй хэрэг биш юм. Энэ нь хүний хэлбэр, дүр загвар, эрхтнүүд хөгжин хувьссан гэдгийг л нотолж байгаа юм. Хүн ямагт онцгой зүйл байсан бөгөөд амьтан биш ямагт хүн байсан юм.” - “Учир нь тайлагдсан зарим асуултууд”х. 170-172*

Адам, Ева хоёрын түүхийн талаар Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Хэрэв бид энэ түүхийг олны тайлбарладаг маягаар яг шууд утгаар нь ойлгох юм бол үнэхээр сонин зүйл болно. Яагаад гэвэл, хүний оюун ухаан түүнийг хүлээн зөвшөөрч чадахгүй, төсөөлж ч чадахгүй. Учир нь, ийм зохион байгуулалт, ийм байдал, ийм яриа, ийм зэмлэл нь ухаант хүмүүнд, тэр байтугай Бурханы хувьд боломжгүй юм. Бурхан хязгааргүй орчлонг хамгийн төгс хэлбэрээр, тоо тоймшгүй оршин суугчдыг нь туйлын төгс тогтолцоотой, хүч чадал төгс байдалтайгаар зохицуулан төвхнүүлсэн Бурханы хувьд боломжгүй юм...*

*“Тиймээс модноос идээд Диваажингаас хөөгдсөн Адам, Ева хоёрын түүхийг бэлгэ тэмдэг хэмээн бодох ёстой юм. Үүнд тэнгэрлэг нууц, даян дэлхийн утга учир оршиж байгаа учир гайхалтай тайлбарыг өгч чадах юм.” - “Учир нь тайлагдсан зарим асуултууд”*

## **Бие махбод ба Сүнс**

Хүний бие махбод болон сүнсний тухай, үхлийн дараах амьдралын тухай Бахайн сургаал нь шинжлэх ухааны судалгаагай нийцэж байдаг юм. Энэ сургаалд үхэл бол шинэ төрөлт, бие махбодын шоронгоос ангижран илүү өргөн хүрээний амьдралд

дахин төрөх явдал гэж заадаг бөгөөд хойт насны амьдралд олох хөгжил дэвшил нь хязгааргүй юм гэж үздэг.

Энэ асуудлаар эрдэм шинжилгээний дүгнэлт судалгаа бага багаар хуримтлагдаж ирсэн бөгөөд энэ бүхнийг судалсан хамгийн шүүмжлэнгүй хандагч судлагчид хүртэл үхлийн дараа амьдрал үргэлжилж, ухамсарт сүнс материаллаг бие махбодоосоо салсны дараа амьдарсаар байдаг гэсэн баримтыг ямар ч эргэлзээгүйгээр тогтооход хангалттай нотолгоо байна гэж үздэг юм. Хүний Сэтгэл зүйн Судалгааны Нийгэмлэгийн судалгаа шинжилгээг тоймлон багтаасан “Хүний мөн чанар” гэсэн бүтээлд Ф.У.Х.Майерс ингэж бичжээ:

*“Олон жилийн ажиглалт, туршилт, дүгнэлт шинжилгээний үр дүнд миний бие болон бусад олон судлаачид энэ ертөнцөд амьдарч байгаа хүмүүсийн тархи ухааны хооронд төдийгүй мөн энэ ертөнцөд амьдарч байгаа хүмүүс болон нас барсан хүмүүсийн сүнснүүдийн хооронд чөлөөтэй бөгөөд телепатийн харилцаа үүсдэг гэсэн дүгнэлтэнд хүрсэн юм. Ийм нээлт бол олон бусад нээлтэнд үүд хаалгыг нээж өгсөн билээ...*

*“Худал хуурмаг явдал, өөрөө өөрийгөө хуурах, төврөгдөн эндүүрэх энэ явдлын дунд хойт насны ертөнцөөс үнэн зүйлс бас бидний ухаанд хүрдэг гэдгийг бид олж ажиглалаа...*

*“Бид ажиглалтынхаа үр дүнд эдгээр нээлтүүдийн ачаар энэ ертөнцөөс хальсан сүнснүүдийн талаар хэдэн зүйлийг дүгнэн тогтоосон юм. Хамгийн нэгдүгээрт, тэд нөгөө ертөнцөд мэргэн ухаан болон хайрд умбан хязгааргүй орчинд хөгжин хувьсаж байдаг хэмээн би итгэлээ. Энэ дэлхийн хайр үргэлжилдэг бөгөөд ихэнх нь дээд зэргийн хайраа сүсэг бишрэлд илэрхийлдэг аж... Муу муухай бол тэдний хувьд үл бүтэх утгагүй зүйл санагддаг учир нэг их айж эмээдэггүй ажээ. Муу муухайг ямар нэгэн аймшигт хүч гэж боддоггүй, харин бүхнийг хөндийрүүлэгч солиорол гэж үздэг бөгөөд дээд түвшний сүнснүүд гажуудсан сүнснүүдийг үүнээс авран чөлөөлөхийг чармайдаг байна. Тэнд тамын гал гэж үгүй, өөрийгөө танин мэдэх ба бусад сүнснүүдтэй нөхөрлөн ойртох нь шагнал, харин хөндийрөх нь шийтгэл гэдгийг ухаарна. Учир нь тэр ертөнцөд хайр хадгалагдан үлдэж, Ариун гэгээнтнүүдийн*



*нэгдэл бол өөрөө Мөнхийн Амьдрал болдог байна. Тэр ч байтугай, телепацийн (алсаас мэдрэх, онцгой чадвараар харьцах) хуулиас үзвэл, тэр нэгдэл бол энд одоо ч хүртэл хүчинтэй гэдэг нь харагдаж байгаа юм. Одоо ч гэсэн нас барсан сүнснүүдийн хайр бидний залбиралд хариу өгдөг шүү дээ. Одоо ч гэсэн бидний хайр дурсамж бол (хайр бол өөрөө мөргөл юм) тэдгээр талийгасч сүнснүүдийг улам дээшээ аялахад нь дэмжин бэхжүүлдэг.”*

Эрдэм шинжилгээний нарийн судалгаан дээр үндэслэсэн үзэл бодол ба Бахайн сургаал хоёр хоорондоо ямар их нийцэж байгаа нь үнэхээр гайхалтай.

### **Хүн төрөлхтний Эв нэгдэл**

*“Та нар болбоос нэг модны үр жимснүүд, нэг мөчрийн навчис, нэг цэцэрлэгийн цэцгүүд билээ.”* Энэ бол Бахауллагийн айлдсан хамгийн түгээмэл сургаал юм. Бас нэгэн сургаал бол:

*“Зөвхөн эх орноо хайрладаг хүн өөрөөрөө бахархах биш харин бүх л хүн төрөлхтнийг хайрладаг хүн өөрөөрөө бахархах ёстой.”*

Эв нэгдэл, хүн төрөлхтний эв нэгдэл, Бурханы бүтээлт хамаг бүхний эв нэгдэл бол Бахауллагийн сургаалын гол үзэл санаа. Энд ч мөн адил жинхэнэ шашин, шинжлэх ухаан хоёрын уялдаа илт харагдана. Шинжлэх ухаан улам хөгжих тусам орчлон дэлхийн эв нэгдэл, дэлхийн олон хэсгүүд бие биеэсээ харилцан хамаарах явдал улам их тодорхой болж байна. Одон орон судлаачийн ажил физикчийн ажилтай улам шүтэлцэж, биологич, сэтгэл зүйч хоёрын ажил уялдах гэх мэтээр уялдаа шүтэлцээ нэмэгдэж байна. Судалгааны аль нэгэн салбарт гарсан шинэ нээлт бүр нь өөр салбаруудад бас олон зүйлийг ойлгомжтой болгож байна. Физикийн шинжлэх ухаанд материйн эс ширхэг бүр өөр нэгэн эсийг өөртөө татаж байдаг гэж заасны адил сэтгэл зүйн ухаанд ч энэ орчлонд амьдарч байгаа хүн бүр бусад хүмүүст нөлөөлж, ямагт өөртөө татаж гэдгийг нотолсон билээ. “Харилцан туслалцаа” гэсэн номондоо хунтайж Кропоткин бичихдээ, адгуусан амьтнууд ч хүртэл амьдрахын тулд бие биедээ тусалдаг гэсэн байдаг. Харин

хүмүүс хоорондоо харилцан туслалцах явдал дайсагнах явдлаас хэр давамгайлж байгаагаас соёл иргэншлийн хөгжил дэвшил шалтгаалах юм. “Нэг нь нийтийнхээ төлөө, нийт нь нэгнийхээ төлөө” гэсэн уриа бол нийгмийг хөгжүүлэн цэцэглүүлэх цорын ганц зарчим билээ.

### Эв нэгдлийн эрин үе

Бид хүн төрөлхтний түүхэн дэх шинэ эрин үеийн босгон дээр ирээд байгааг бүх шинж тэмдэг илтгэж байна. Урьд нь залуу бүргэд бэртэгчин үзэл, материализмын баг бөх хатуу хаднаас зуурч байсан билээ. Далавчаараа дэвэн нисэх гэсэн бяцхан оролдлого тууштай биш байв. Гэвч ямагт дээшээ хөөрөхийг хүсэн мөрөөдөж байлаа. Хоцрогдсон номлол, хуучинсаг үзлийн хүлээсэнд улам улам их баригдаж байв. Харин одоо боолчлолын эрин зуун эцэс болж, хүн төрөлхтөн оюун санааны хайр ба үнэний дээд ертөнцүүдэд сүсэг бишрэл, ухаалаг сэтгэлгээнийхээ жигүүрээр жигүүрлэн дүүлэх цаг болжээ. Урьдынх шигээ адил газарт шигдэхээ болино. Учир нь, бүргэд өсөж том болж, жигүүр нь гүйцэд ургажээ. Тиймээ өргөн дэлгэр орчинд нисэн дүүлж, гайхалтай эрх чөлөөг мэдэрнэ. Гэхдээ ганц зүйл шаардлагатай нь нисэлт нь тууштай шийдэмгий байх ёстой. Хоёр далавч хүч тэнхээтэй байх төдийгүй мөн хоорондоо уялдан ажиллах ёстой.

Абдул-Баха ингэж хэлсэн билээ:

*“Нэгхэн далавчаар нисэж болохгүй шүү дээ. Хүн гагцхүү шашны далавчаараа дэвэн нисэх гэж оролдвол мухар сүсгийн намагт тэр даруй унах ба нөгөө талаас, тэрээр зөвхөн шинжлэх ухааны далавчаа дэвэн нисэх гэх юм бол хөгжсн дэвшилч чадахгүй, харин материализмын гүн намагт шигдэн орно.” “Парист айлдсан айлдварууд”, х.88*

Шашин, шинжлэх ухаан хоёрын уялдаа, төгс шүтэлцээ нь хүн төрөлхтний дээд амьдралын онц шаардлага билээ. Үүнд хүрч чадах аваас хүүхэд бүр шинжлэх ухаан, урлаг соёлын эрдэмд суралцахаас гадна мөн бүхий л хүн төрөлхтнийг хайрлах, Зөнч мэргэдийн сургаалд айлдсанчлан Бурханы Хүсэл тааллыг баяр

баясгалантайгаар даган мөрдөх талаар мөн адил суралцах болно. Тэгсэн цагт Бурханы Ханлиг улс энэ ертөнцөд тогтож, Түүний Хүсэл таалал диваажинд тогтсон шиг газар дэлхий дээр ч биелнэ. Тэгсэн цагт л Агуу их Энх тайван адис ивээлээ ертөнцөд түгээн цацна.

*“Шашин өөрийн мухар сүсэг, зан уламжлал, утга учиргүй догм номлолоосоо ангижран, шинжлэх ухаантай нийцэж чадвал, дэлхий ертөнцийг нэгтгэн ариусгагч агуу хүч чөлөөлөгдөн, бүхий л дайн дажин, эвдрэлцэл зөрөлдөөн, тэмцэл зөрчлийг хөөн зайлуулж, хүн төрөлхтөн Бурханы Хайрын хүч чадалд нэгдэх болно.”*- Абдул-Баха, “Парист айлдсан айлдварууд”, х.89

## Арван гуравдугаар бүлэг

# БАХАЙН ХӨДӨЛГӨӨНД БИЕЛЛЭЭ ОЛСОН ЗӨГНӨЛ АЙЛДВАРУУД

*“Агуу их Алдарын Тодруулагчийн (Бахаулла) хувьд гэвэл: Тэрээр болбоос Библи, Евангели, Коран зэрэг Бурханы бүхий л Ном сударт зөгнөгдөн амлагдсан Нэгэн болой.” Абдул-Баха*

### **Зөгнөл айлдварыг тайлбарлах нь**

Шашны зөгнөл айлдварыг тайлбарлах нь үнэнхүү хүнд бэрх асуудал бөгөөд эрдэмтэн мэргэдийн санал бодол энэ асуудал дээр маш их зөрдөг.

Энэ бол санамсаргүй хэрэг биш юм. Учир нь, нээн туурвигдсан тэдгээр сургаал бичмэлд хэлсэнчлэн олонхи зөгнөлийг цаг нь болох хүртэл ойлгохын аргагүй хэлбэрээр дүрсэлсэн байдаг бөгөөд биелэх цаг нь ирсэн ч түүнийг ариун цэвэр сэтгэлтэй, аливаа атгаг сэжиг үзлээс ангид тийм хүмүүс л урьтаж ухаардаг ажээ. Далд үзэгдлийг үзсэнийх нь дараа Даниэлд ингэж хэлсэн байдаг:

*“Даниэл чи үгийн утгыг далдлан эцсийн цагийг хүртэл номыг битүүмжлэгтүн. Олон хүн нааш цааш гүйнэ, энэ номын талаар мэдлэг ч нэмэгдэнэ. Би үүнийг дуулсан боловч учрыг нь ойлгосонгүй, ингэж лавлав: “Эзэн тэнгэр минь, энэ бүхний төгсгөл хэзээ ирэх бол? гэхэд тэрээр надад, “Даниэл, чи өөрийн замаар яв, учир нь эцсийн цаг хүртэл хэлэх үг далдлагдан битүүмжлэгдсэн болой.” гэв”. Даниэл хii, 4.9*

Бурхан цаг нь ирэх хүртэл зөгнөл айлдвараа битүүмжилж, тэдгээрийг айлдсан зөнч мэргэдэд ч утга учрыг нь тайлаагүй юм бол гагцхүү Бурханаас томилогдсон агуу Элч л уг битүүмжийг нээж, зөнч мэргэн ёгт сургаалын хүрдэнд буй нууц утга учрыг тайлж чадах нь хэмээн бид дүгнэж болох юм. Эдгээр зөгнөл айлдварын

түүх болон тэдгээрийг урьдын зуунуудад буруу тайлбарлан ойлгодог байсан талаар тунгаан бодохдоо зөнч мэргэдийн өөрсдийнх нь анхааруулгыг ямагт санаж, эдгээр айлдварын утга санаа боѳон хэрхэн биелэгдэх явдлын талаар шашин судлаачдын таамагласан зүйлсийг хүлээн авахдаа туйлын болгоомжтой байх ёстой нь мэдээж билээ. Нөгөө талаас, хэн нэгэн хүн гарч ирэн эдгээр зөгнөлийг биелүүлнэ гэж амлаж байвал түүний энэ өнгөлзлөгийг нээлттэй, элдэв атгаг сэжиггүй үзэлтэйгээр шүүн шалгах хэрэгтэй юм. Тэр хүн хэрэв нэр зээлдэгч, хууран мэхлэгч бол тэр нь удахгүй илэрч, ямар ч хор учруулахгүй. Харин Бурханы Элчийг хүсэн хүлээгээгүй маягаар, хүсэн хүлээгээгүй цагт хүрч ирлээ хэмээн гэрийнхээ үүднээс хөөсөн бол цээрлэл хүртэнэ.

Бахаулла болбоос бүхий л ариун Судруудад зөгнөгдөж байсан Амлагдсан Нэгэн мөнөөс мөн гэдгийг Түүний амьдрал, үг айлдвар нь нотолж байгаа билээ. Тэр Амлагдсан Элч болбоос зөгнөл айлдварын битүүмжийг нээж, тэнгэрлэг нууцсын “битүүмжтэй шилдэг дарс”-ыг нээн хүртээх Элч юм. Тиймээс Түүний тайлбарыг сонсож, өнгөрсөн цагийн зөнч мэргэдийн хэлж байсан далдын утга бүхий үгс нь ямар учиртай байж вэ гэдгийг Түүний тайлбар дээр үндэслэн судалцгаая.

### Эзэн тэнгэр залран ирэх тухай

“Хожмын өдрүүдэд” “Эзэн тэнгэр залран ирж”, “тэнгэрлэг үйл явдал хожим” болно хэмээн бүх Зөнч мэргэд хүсэн хүлээж, өөрсдийн хамгийн гайхамшигт магтуугаа дуулж байсан билээ. Тэгэхлээр “Эзэн тэнгэр залран ирнэ” гэдэг чухам юу гэсэн үг вэ? Бурхан аль ч цаг үед хамаг амьтантай цуг, хамаг бүхэнд, хамаг бүхний дээр оршиж ирсэн билээ. “Тэрээр амьсгалаас ч ойр, хөл гарнаас ч ойр” гэж хэлдэг шүү дээ. Тийм ээ, гэвч хүмүүс Бурханыг жинхэнэ дүрээр харж, сонсож чадахгүй, Түүний ахуйг ч мэдэрч чадахгүй учир Тэрээр Өөрийгөө нүдэнд харагдах хэлбэрээр тодруулж, хүмүүсийн хэлээр хүмүүстэй ярилцдаг юм. Өөрийн хамгийн дээд шинж чанаруудаа нээн илрүүлэх үүднээс Бурхан ямагт хүмүүнийг ашиглаж ирсэн билээ. Зөнч мэргэн бүр

Бурханы үгийг хүмүүст дамжуулдаг, Бурханы өмнөөс хүмүүстэй ярилцдаг зуучлагч байсан юм. Есүс нийм нэгэн зуучлагч байсан бөгөөд Христчүүд Түүний тодрон гарахад Бурханыг тодрон ирлээ хэмээн үзэж байсан нь зүй ёсны хэрэг юм. Түүний дүр царайнд гэд Бурханы Дүр царайг олж, Түүний амнаас Бурханы Дуу хоолойг сонсож байсан юм. Зөнч мэргэдийн айлдсанаар Эздийн Эзэн тэнгэр, Мөнхийн Эцэг, Ертөнцийг Бүтээгч, Анагаагч “үеийн эцэст” “залран ирнэ” гэж байгаа нь Өөрийнх нь тодрууллыг хэлсэн юм хэмээн Бахаулла бидэнд айлдсан билээ. Тэрээр Назаретын Есүс хүний дүрээр тодорсонтой адил энэ удаад гэхдээ илүү өргөн дүүрэн, илүү гайхамшигтай үүдэл нээлтийг авчран тодорч, Есүс болон өмнөх Зөнч мэргэд хүмүүсийн зүрх сэтгэл, ухаан бодлыг бэлтгэж байсан тэр цагийг үеийг авчирлаа хэмээн зарлан тунхагласан юм.

### Христийн тухай зөгнөл айлдвар

Мессияагийн ноёрхлын талаарх зөгнөл айлдварын утга учрыг ойлгоогүйнхээ улмаас Иудейчүүд Христийг няцаан үгүйсгэсэн билээ. Абдул-Баха ингэж хэлжээ:

*“Иудейчүүд одоог хүртэл Мессияаг залран ирнэ гэж хүлээн, ирэх өдрийг нь ойртуулахын тулд өдөр шөнөгүй Бурханд залбирсаар байна.*

*Христийг залран ирэхэд тэд: “Энэ хүн бол бидний хүсэн хүлээсэн хүн биш. Мессия ирэхдээ бүх л шинж тэмдгээрээ өөрийгөө жинхэнэ Христ гэдгээ нотлох болно... Мессия болбоос үл таних нэгэн хотоос залран ирнэ. Тэрээр Давидын сэнтийд заларч, гартаа ган сэлэм ба очир таяг барин ертөнцийг захирна! Тэрээр Зөнч мэргэдийн хуулийг ёсоор болгож Өрно, Дорныг эзэмшин дагуулж өөрийн сонгосон ард түмэн болох Иудейчүүдийг мандуулах болно. Тэрээр энх амгалангийн диваажинг авчирч, араатан амьтан хүртэл хүмүүнтэй дайсагнахаа болино. Чоно, хонь хоёр нэг горхиноос ус ууж,... Бурханы бүтээсэн амьд амьтан бүр амгалан тайван амьдарна...”*



*“Иудейчүүд ариун судруудыг болон уг судруудад айлдсан гайхамшигт үнэн айлдваруудыг ойлгодоггүй байсан тул тэд Христийн тухай ийнхүү бодож ярьдаг байв. Үг үсгийг нь тэд цээжээр мэддэг байвч амьдрал хайрлагч үнэн утга учрыг нь огт ойлгодоггүй байсан юм.*

*“Та нар чих тавин сонсвоос би үнэн учрыг дуулгая. Христ Назарет хэмээх хүмүүсийн мэдэх газраас ирсэн боловч Тэрээр бас Тэнгэрээс ирсэн байсан юм. Түүний бие Мэригээс төрсөн, харин Түүний оюун санаа Тэнгэрээс заяасан байсан болой. Түүний барьж явсан сэлэм нь гэвэл үнэнийг худлаас, буяныг нүглээс, үнэнч шударгыг худал хуурмагаас, гэрэл гэгээг харанхуйгаас ялган салгадаг хэл нь байв. Түүний энэхүү сэлэм нь үнэхээр хурц сэлэм байлаа! Түүний заларсан сэнтий бол Тэнгэрт үүрд мөнх орших мөнхийн суудал байсан амой. Энэ ертөнцийн юмс хуучирч алга болох боловч тэнгэрийн зүйлс үл хувирнам. Христ, Моисейн хуулийг шинээр тайларлаж баяжуулсан бөгөөд Зөнч мэргэдийн хуулийг биелүүлсэн билээ. Христийн Үгийн хүч Өрнө, Дорныг байлдан дагуулсан ба Түүний хаант улс бол мөнхийн амой. Түүнийг хүлээн зөвшөөрсөн Иудейчүүдийг Тэрээр магтан мандуулсан билээ. Тэд хэдийгээр ядуу дорой хүмүүс байсан боловч Христийг таньж мэдсэнээр агуу их хүч, алдар завъяаг олсон юм. Эвтэй найртай амьдрах амьтад гэдэг нь урьд хоорондоо дайтан эвдрэлцдэг байсан бол одоо бие биеэ өрөвдөн хайрлаж, Мөнхийн Ундарга болсон Христийн амьдралын рашаанаас уух болсон өөр шашин шүтлэгтэй, өөр өөр үндэстэн арьстан хүмүүсийг төлөөлж байгаа юм.” “Парист айлдсан айлдварууд”, х 28.29*

Ихэнх Христийн шашинтнууд Мессиягийн талаарх эдгээр зөгнөл айлдварыг Христтэй холбож үздэг билээ. Гэвч хожмын өдрийн Мессиягийн талаар тэдний олонх нь яг л Иудейчүүдийн адил хандлага гаргаж, зөгнөл айлдвар шууд утгаараа үг үсэггүй материаллаг байдлаар биелнэ гэж хүсэн хүлээж суудаг юм.

## Баб, Бахаулла нарын тухай Зөгнөл айлдварууд

Бахайн сургаалаар “үеийн эцэст”, хожмын өдрүүдэд” “Эздийн Эзэн тэнгэр”, “Мөнхийн Эцэг” залран ирнэ гэсэн зөгнөл айлдвар нь Есүс Христийг хэлж байгаа биш харин Бахауллаг залран ирэх тухай хэлсэн юм хэмээн үздэг. Исайягийн нэгэн алдартай зөгнөлийг жишээ болгон аваад үзье:

*“Харанхуйд алхсан хүмүүс агуу их гэрлийг харав. Үхлийн сүүдэр туссан нутагт оришигч хүмүүс дээр гэрэл тусав... Учир нь та Мидианы үед байсан шиг түүний ачааг... хугалж, нуруун дээрх ачаа, дарангуйлагчийнх нь савааг авсан билээ. Учир нь, дайчны тулалдаан бүр дуу шуугиан ихтэй, хувцас хунар нь цусанд хутгалдана. Гэвч энэ бол галанд шатан дүрэлзэх болно. Учир нь бидэнд хүүхэд төрж, хүү мэндэллээ. Засгийн газар түүний нуруун дээр тохогдож, алдар нэр нь ч Гайхамшигт, Зөвлөгч, Хүчирхэг Бурхан, Мөнхийн Эцэг, Энх тайвны Хунтайж гэсэн нэртэй байх болно. Түүний засаг нэмэгдэж, энх тайван арвижиж, үл дуусах агаад Давидын сэнтийд, өөрийн ханлиг улсад тэрээр заларч, түүнийг шударга ёсоор захирч, шударга ёс үүрд мөнх тогтоно. Эздийн Эзэн тэнгэрийн хүсэл энэ бүхнийг хийх болно.” - Исайя, ШЧ, 2.7*

Энэ бол Христийг зөгнөсөн гэх олон зөгнөлүүдийн нэг юм. Түүнд дотор буй олон үг нь Христэд хамаатай юм шиг санагдах боловч жаахан ч гэсэн илүү судлах юм бол Бахауллад илүү хамаатай нь харагдана. Христ нээрээ ч гэрэл гэгээ авчрагч Аврагч байсан, гэвч Түүнийг залран ирснээс хойш бараг хоёр мянган жилийн турш хүмүүс харанхуйд алхалж, Израилийн үр сад болон Бурханы олон ч бусад үр сад дарангуйлагчийн саваан дор айн дагжиж ирсэн билээ. Нөгөө талаас Бахайн эрин үеийн анхны хэдэн арван жилд үнэний гэрэл гэгээ Дорно, Өрнийг гэрэлтүүлж, Эцэг Бурханы сургаал болон хүмүүсийн ах дүүгийн барилдлагааны сургаал дэлхийн бүх оронд түгэж, цэрэг зэвсгээр хүчирхэг гүрнүүд нурж, дэлхий ертөнцийн нэгдлийн тухай ухамсар мөдхөн дарлагдан зовсон улс түмнүүд зовлонгоосоо ангижирна гэсэн

найдлагыг төрүүлж байна. 1914 оноос 1918 оныг хүртэл дэлхийг донсолгож байсан аймшигт дайнд элдэв янзын буу, бөмбөг, шингэн шатахуун тосыг хэрэглэж, үнэхээр “галанд шатан дүрэлзэж”<sup>1</sup> байв. Бахаулла Өөрийн сургаалд засгийн газар, засаг захиргааны талаар нилээн нухацтай тайлбарлан хэрхэн бэрхшээлүүдийг давахыг зааснаар Христийн хийж амжаагүйг хийж, “засгийн газрыг нуруун дээрээ үүрсэн” юм. Харин “Мөнхийн Эцэг”, “Энх тайвны Хунтайж” зэрэг алдар нэрийн тухайд гэвэл, Бахаулла олон удаа Өөрийгөө Эцгийн Тодруулагч гэж Христ, Исаяя нарын зөгнөн ярьж байсан нэрээр нэрлэж байсан бол Христ Өөрийгөө Хүү гэдэг байв. Бахаулла гүүнчлэн газар дэлхий дээр энх тайвныг тогтоох гэж ирсэн хэмээн хэлдэг байсан бол Христ “Би энх тайвныг биш харин сэлмийг авчрахаар ирсэн” гэж хэлсэн бөгөөд Христийн эрин үед дайн дажин, хагарал бутрал маш ихээр гарч байсан нь санамсаргүй хэрэг биш юм.

## **Бурханы Алдар**

“Бахаулла” гэсэн араб нэр нь “Бурханы Алдар” гэсэн утагтай бөгөөд уг нэрийн дор Амлагдсан Элч хожмын өдрүүдэд залран ирнэ хэмээн эртний Иудейн зөнч мэргэд зөгнөж байсан билээ. Тийнхүү Исаяягийн 1.5.ын 40 дүгээр бүлэгт ингэж бичсэн байна:

*“Миний ард түмнийг тайтгаруулагтун хэмээн Бурхан тань айлдаж байна. Дайн тэмцэл нь биелж, бурангуй явдал нь өршөөгдөж, хийсэн бүх нүглийнхээ төлөө Эзэн тэнгэрийнхээ мутраас хоёр дахин ихийг хүртлээ гэдгийг Иерусалимд хэлж, түүнийг тайтгаруулагтун. Аглаг цөлд түүний дуу сонсдож байна. Эзэн тэнгэрийнхээ замыг бэлтгэ, Бурханы маань төлөө элсэн цөлд зам мөрийг нь тэгш болго. Тал хөндий бүхэн өргөгдөж, уул овоо бүхэн доош сууж, мурий нь тэгш болж, арзгар хэсэг нь гөлгөр болно. Эзэн тэнгэрийн Алдар тийнхүү нээгдэж, амьд бүхэн түүнийг хамтаар харна.”*

---

<sup>1</sup> Дэлхийн 2-р дайн болж эцэст нь цөмийн бөмбөг хийгдсэн нь энэхүү зөгнөлийг бас давхар нотолж байгаа юм.

Дээр үзсэн зөгнөлийн адил үүний нэг талыг Христ болон Түүний зарч Загалмайлагч Иоан нар биелүүлсэн боловч бүрэн гүйцэд биелүүлж чадаагүй юм. Учир нь, Христийн үед Иерусалимын дайн дажин хараахан эхлээгүй байсан бөгөөд олон зууны турш доромжлогдон талхлагдах тавилан түүнийг хүлээж байсан юм. Харин Баб, Бахаулла нар залран ирснээр энэ зөгнөл илүүтэй биелж эхэлж байгаа бөгөөд учир нь Иерусалимд гэрэл гэгээтэй өдрүүд эхэлж, амгалан тайван, гайхамшигт ирээдүйн зөгнөл биелэх нь баталгаатай болсон байна.

Бусад зөгнөл айлдварт Израилийг Анагаагч, Эзэн тэнгэрийн Алдар Ариун Газар луу нар мандах дорно зүгээс ирнэ гэсэн байдаг. Бахаулла Перст тодорсон бөгөөд Перс бол Палестиныг бодвол дорно зүгийн нутаг бөгөөд Ариун Газарт Бахаулла ирж, амьдралынхаа сүүлчийн хорин дөрвөн жилийг өнгөрүүлсэн юм. Хэрэв Тэрээр тэнд эрх чөлөөтэй байхдаа очсон бол хүмүүс Түүнийг албаар зөгнөлийг биелүүлэх үүднээс ирсэн нэр зээлдэгч байна хэмээн хэлэх байсан байж магад. Гэвч Тэрээр Ариун Газарт цөлөгдөн ирсэн юм. Персийн Шах болон Туркийн Султан нар Түүнийг тийш нь цөлж ингэснээрээ Зөнч мэргэдийн зөгнөл айлдварыг биелүүлснээ мэдээгүй юм.

## Мөчир

Исайяа, Еремия, Эзекиэл, Захария нарын зөгнөл айлдварт Мөчир хэмээх нэгэн хүний тухай бас өгүүлсэн байдаг. Энэ нь Христийн тухай зөгнөсөн юм гэж Христчүүд боддог байсан боловч Бахайчууд энэ бол Бахауллаг хэлсэн юм хэмээн итгэдэг.

Мөчрийн тухай Библид байдаг хамгийн урт зөгнөл айлдвар нь Исайяагийн 11 дүгээр бүлгийн 1, 2, 5, 6, 9, 11, 12-т буй.

*“Иессейн шинээс мөчир гарч, түүний үндсээс Мөчир ургана. Тийнхүү Түүн дээр Эзэн тэнгэрийн Сүнс, мэргэн ухаан, оюун ухаарлын сүнс, айлдал зөвлөгөө, хүч чадлын сүнс, эрдэм мэдлэг, Бурханаас эмээх буян мөрийн сүнс буух болмой... Үнэн зөв Буян түүнийх болж, үнэнч сэтгэл түүний цулбуур болно. Чоно*

*хургатай хамтран аж төрж, барс ирвэс ишигтэй хамт хэвтэнэ. Тугал, арслангийн зулзага хоёр хамтдаа наадаж, жаахан хүүхэд тэднийг хөтлөн дагуулна... Тэд миний Ариун уулыг гэмтээх ч үгүй, устгах ч үгүй. Учир нь, тэнгис далайг ус бүрхдэг шиг газар дэлхий Эзэн тэнгэрийнхээ тухай мэдлэгээр дүүрнэ... Эзэн тэнгэр Өөрийн мутрыг дахин хоёр дах удаагаа өргөж, үлдсэн ард түмнээ цуглуулан, Ассири, Египет, Патрос, Хус, Элам, Сенаар, Емаф болон далайн арлуудаас цуглуулах тэр өдөр ирнэ. Тэрээр улс үндэстнүүдийн туг далбааг өндөрт зоож, Израилийн хөөгдөгсдийг цуглуулж, ертөнцийн дөрвөн зүгээс тарсан Иудейчүүдийг хамтад нь авчирна.”*

Мөчрийн талаарх дээрх болон бусад зөгнөл айлдваруудын тухай Абдул-Баха ингэж хэлсэн байна.

“Тэрхүү хосгүй Мөчир тодрон илрэх тэр өдөр болох нэгэн агуу үйл явдал бол улс үндэстнүүдийн дунд Бурханы тугийг өргөж, бүх улс түмэн, омог үндэстнүүд тэнгэрлэг эзэн Тэнгэрийн Мөчир болох тэнгэрлэг Далбаан дор цуглаж, нэгдмэл нэг үндэстэн болохыг илтгэсэн утгатай юм. Шашин шүтлэг хоорондын дайсагналцал, үндэстэн ястнууд хоорондын хүйтэн хөндий байдал, үндэсний зөрчил тэмцэл нь хүмүүсийн дотроос арилан устгана. Бүгд л нэг л шашин, нэг л шүтлэг, нэг л үндэстэн, нэг л ард түмэн болж, дэлхий хэмээх нэг л эх оронд аж төрөн амьдарна. Даян дэлхийн энх тайван, эвийн холбоо бүх улс орнуудын хооронд тогтож, тэрхүү хосгүй Мөчир бүх л Израиль орныг нэгтгэн цуглуулах бөгөөд энэ нь дорно, өрнө, баруун, өмнө, хойд зүгт тархан бутарсан еврей (Иудейн) хүмүүс бүгд Ариун Газар цуглана гэсэн үг юм.

“Одоо тэгвэл харагтун: энэ бүх үйл явдал Христийн эрин зуунд биелээгүй, улс үндэстнүүд Тэнгэрлэг Мөчрийн нэгэн далбаан дор нэгдээгүй. Харин Эздийн Эзэн тэнгэрийн энэхүү мөчлөгт бүх улс үндэстэн ард түмнүүд энэ туг далбаан дор нэгдээж байна. Үүний нэгэн адил бүх дэлхийгээр тарж бутарсан Израиль орон Христийн эрин зуунд Ариун Газарт дахин нэгдээгүй. Гэвч Бахауллагийн энэ мөчлөгийн эхэн үед уг тэнгэрлэг амлалт зөнч мэргэдийн судар намд айлдсанчлан биелж, Иудейчүүд Ариун

*Газар луу ирж байна. Тэд өөрсдийн бүтээсэн хот тосгондоо амьдарч өдрөөс өдөрт улам их хөдөлмөрлөснөөр эцэст нь бүх л Палестин тэдний эх орон болно.*”- “Учир нь тайлагдсан зарим асуултууд”

Дээрх зүйлийг Абдул-Баха бичсэнээс хойш Палестин орон Туркчуудын гараас мултарсан бөгөөд “Хамтын холбоотны хүчнүүд” Палестиныг Иудейчүүдийн орон болохоор шийдвэр гаргасан билээ.

Дэлхийн дайнаас хойш мөн хэдийгээр энх тайван, аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй байгаа ч улс үндэстнүүдийн холбоо бий болж, улс орнуудын дунд хамтын хариуцлага хүлээх шинэ үзэл санааг бий болгож, дэлхийн иргэншлийн талаар анхны хичээл сургамжийг олон хүмүүст олгосон билээ. Гэвч энэ бүхэн төдийлөн амжилттай болохгүй байгаа нь өдрөөс өдөрт эрч хүчээ авч, хуучин эмх журам халиран одох тусам бат хүчтэй алхаагаа эхлээд буй Бахауллагийн Шинэ эмх журам шаардлагатайг илтгэж байгаа юм.

## Бурханы Өдөр

”Өдөр” гэсэн үг нь “Бурханы Өдөр”, “Хожмын өдөр” гэсэн хэллэгт “Эрин үе” гэсэн утгатай юм. Шашны агуу үндэслэгч нар бүгд ийм нэгэн “Өдөр”-тэй байлаа. Тус бүр нь нар лугаа адил байв. Зөнч мэргэний сургаал нь өөрийн гэсэн үүрийн цолмонтой байсан агаад сургаалынх нь үнэн мөн чанар хүмүүсийн оюун бодол, зүрх сэтгэлийг улам улам гийгүүлэн гэрэлтүүлснээр эцэст нь үр нөлөөллийнхөө хувьд оргилд хүрдэг байсан байна. Түүний дараагаар аажим аажимдаа харанхуйлж, сургаалыг нь буруу зөв тайлбарлан гажуудуулж, бүрхэг харанхуйн суудэр дэлхийг нөмрөх тэр үед шинэ өдрийн наран манддаг байна. Бурханы Дээд Тодруулагчийн өдөр бол “Хожмын өдөр” юм. Яагаад гэвэл, энэ өдөр хэзээ ч дуусахгүй, хэзээ ч шөнөөр солигдохгүй юм. Түүний наран хэзээ ч шингэхгүй, энэ ба нөгөө ертөнцийн бүх хүмүүсийг гэрэлтүүлж байх болно. Үнэндээ ч оюун санааны аль ч нар хэзээ



ч жаргаж байсангүй. Моисей, Христ, Мухаммед болон бусад Зөнч мэргэдийн нар илч нь буураагүй хэвээр тэнгэрт мандаж байна. Гагцхүү энэ дэлхийн үүлнүүд тэдгээрийн гэрэл туяаг газар луу тусгахгүйгээр халхалсан байна. Бахауллагийн Дээд Наран болбоос эцэст нь эдгээр харанхуй үүлнүүдийг замхруулж улмаар бүх шашны хүмүүс бүх Зөнч мэргэдийн тусгасан гэрэлд баясан цэнгэж, бүхий л Зөнч мэргэдийн тольдон тодруулсан нэг л Бурханыг магтан дуулна.

## Шүүлтийн өдөр

Агуу их Шүүлтийн Өдөр ирэх тухай Христ ёгт үгийг ашиглан ихэд бичсэн байдаг. Жишээлбэл, *“Хүний Үр Эцгийнхээ алдраар залран бууж, хүн бүрт хийсэн үйлээр нь шан хүртээнэ”* (Матай, 16:27) гэсэн. Тэрээр энэ Өдрийг ургац хураах улиралтай адилтгаж, зэрлэг шарилжийг шатааж, тариа будаагаа хураана хэмээсэн юм.

*“Тийнхүү... үеийн эцэс болно. Хүний Хүү нь сахиусан элч нараа илгээж, тэд нь нүгэл хилэнцтэн хийгээд хууль бусаар үйлдэгчдийг цуглуулан түүний хаант улсаас гаргана. Тэднийг галтай зууханд хаях бөгөөд тэнд уйлах хийгээд шүдээ хавирах болно. Тэр үед үлэнч зөв нь тэдний Эцэгийн хаант улсад нар мэт гэрэлтэх буй.”* Матай, 13,40.43

“Үеийн эцэс” гэсэн үгийг Библийн албан ёсны хувилбарт дээрх болон бусад төстэй хэсэгт ашигласан нь олон хүмүүс Шүүлтийн Өдөр ирэхэд дэлхий гэнэт устана гэж ойлгоход хүрсэн байна. Гэвч энэ бол алдаа юм. Уг үгийг жинхэнээр нь орчуулбал *“эрин үеийн оргил буюу төгсгөл”* гэсэн утгатай юм. Христ Эцгийн Ханлиг улсыг энэ дэлхий дээр ч, тэнгэр диваажинд ч байгуулна хэмээн сургасан билээ. Тэрээр *“Ханлиг улс тань ирлээ. Хүсэл таалал нь тэнгэр диваажинд ч, газар дэлхий дээр ч биелнэ”* хэмээн залбирахыг сургасан. Цэцэрлэгийн тухай сургаалт зүйрлэлд Цэцэрлэгийн Эзэн тэнгэр Эцэг хүрэлцэн ирж, муу санаатан тариаланчдыг устгах агаад харин цэцэрлэгийг (дэлхийг) устгалгүйгээр өөр тариаланчдыг авчран тэд өөр өөрсдийн

улиралд Түүнд зориулан үр жимс ургуулж өгч байгаагаар дүрсэлсэн байдаг. Тэгэхлээр газар дэлхий устахгүй, харин дахин шинэчлэгдэнэ гэсэн үг. Христ тэр үеийн талаар өөр нэгэн газар: *"Хүний Хүү Алдарынхаа сэнтийд залрах үед дахин шинэчлэгдэнэ"* хэмээн айлдсан байна. Гэгээн Питер энэ тухай "сэхээрэх цаг үе", "бүх юмс өөрчлөн шинэчлэгдэх энэ үеийн тухай ертөнц дэлхий анх эхэлсэн тэр үеэс хойш Түүний бүхий л Ариун Зөнч мэргэд айлдсан" хэмээн хэлсэн байна. Тиймээс Христийн айлдсан тэр Шүүлтийн Өдөр гэдэг бол Исаяя болон Хуучин гэрээн дэх бусад зөнч мэргэдийн зөгнөсөн тэр Эцэг, Эздийн эзэн тэнгэр залран ирж, муу санаатнууд аймшигтайгаар шийтгэгдэж, шударга ёс тогтож, газар дэлхий ба диваажинд буянт ёс захирах тэр цаг үетэй адил гэдэг нь ойлгомжтой.

Бахайн сургаалаар бол Бурханы Тодруулагч залран ирэх үе нь Шүүлтийн Өдөр байдаг бөгөөд харин эрхэм дээд Тодруулагч Бахаулла залран ирэх нь бидний амьдарч буй энэ цаг үеийн мөчлөгт агуу их Шүүлтийн Өдөр болдог. Христ, Мухаммед болон бусад Зөнч мэргэдийн дуурсгасан бүрэн дуу болбоос Тодруулагчийн дуудлага бөгөөд энэ дуудлагыг тэнгэр диваажин ба газар дэлхий дээр оршигч амьтай амьгүй бүхэн сонсдог юм. Бурханы Тодруулагчаар дамжуулан Бурхангай учран уулзах тавилан болбоос Түүнтэй учирч, Түүнийг танин мэдэж хайрлахын Диваажингийн үүд хаалгаар орж, Түүний бүтээлт бүх амьтантай хайраар амьдрах тэр хүмүүст ногддог юм. Харин Бурханы Тодруулагчийн нээж өгсөн Бурханы замаас илүү өөрийнхөө замыг дагасан хүмүүс хувиа хичээх нүгэл, алдаа дутагдал, дайсагналын тамд өөрсдийгөө унагаах юм.

*Агуу Сэхээрэлт* Шүүлтийн Өдөр бол бас Сэхээрэлтийн Өдөр, үхэгсдийн амилах өдөр юм. Коринфачуудад хандаж бичсэн анхны илгээлтэнд Гэгээн Павел ингэж хэлжээ:

*"Харагтун, би чамд нэгэн нууцыг тайлъя: бид унтаж нойрсохгүй, харин нэгхэн мөчийн дотор, нүд ирмэхийн зур, сүүлчийн бүрэн дуугаар өөрчлөгдөнө. Учир нь бүрэн дуу дуугарч, үхэгсэд амилж, бид бүгд өөрчлөгдөнө. Учир нь энэ нүгэлтэн нь нүгэлгүй болж, энэ үхэлт нь үхэлгүй мөнх болно". Кор, 15, 51.53*

Үхэгсэд амилах тухай эдгээр үгсийн талаар Бахаулла “Китаби-Иган”- д ингэж бичжээ:

*“амьдрал”, “үхэл” гэсэн үгсийг Судар бичгүүдэд ашиглахдаа сүсэг биширэлийн амьдрал ба сүсэггүй бурхангүйн үзэл гэсэн утгаар ашигласан бөлгөө. Ихэнх хүмүүс эдгээр үгсийн утга учрыг ойлгож чадаагүйдээ Бурханы Тодруулагчийг няцаан жигшиж, Түүний тэнгэрлэг удирдамжийн гэрлийг дагах буянаас өөрсдөө татгалзаж, мөнхийн Гоо жавхлангийн жишээг дагахаас дургүйцсэн юм.*

*“Та нар дахин төрөх ёстой” гэж Есүс хэлсэн билээ. Тэрээр дахин хэлсэн нь: “Хүн ус ба Сүнснээс төрөөгүй л бол Бурханы Ханлиг улсад нэвтэрч үл чадна. Махан бодоос л төрсөн бол махан бод. Сүнснээс төрсөн бол сүнс” (Иоан 3,5.6) гэсэн юм. Эдгээр үгсийн зорилго бол шашны эрин үе бүхэнд төрсөн хэн боловч Сүнснээс төрсөн бөгөөд Ариун гэгээн Тодруулагчийн амьсгалаар амьдарсан бөгөөд “амьдрал” ба “сэхээрэлт”-ийг олсон тэрээр Бурханы хайрын “диваажинд” нэвтрэн орсон гэсэнд оришино. Харин ийм хүмүүсийн дунд ороогүй хэн боловч “үхэл”, “хагацал”-ыг амсаж, сүсэггүй мунхагийн “гал” ба Бурханы “цээрлэл”-ийн тамд шатмой.*

*“Эрин үе, эрин зуун бүхэнд Бурханы Зөнч мэргэд болон тэдний сонгомол шавь нарын зорилго болбоос “үхэл”, “сэхээрэлт”, “шүүлт” гэсэн ойлголтуудын оюун санааны ач холбогдлыг батлан айлдахад оришиж ирсэн... Чи тэнгэрлэг мэдлэгийн тунгалаг уснаас ганцхан ч болов дуслыг хүртэж чадваас жинхэнэ амьдрал бол махан бодын амьдрал бус харин сүнсний амьдрал юм гэдгийг даруй ойлгон ухаармой. Учир нь махан бодын амьдрал хүнд ч, амьтанд ч ялгаагүй байдаг бол сүнсний амьдрал болбоос гагцхүү сүсэг биширэлийн далайнаас амсаж, үл эргэлзэхүйн үр жимснээс хүртсэн ариун сэтгэл зүрхэнд л байдаг юм. Ийм амьдрал үхэл гэдгийг үл мэднэ, ийм оришин тогтнол ашид мөнхийн титмийг эзэмшинэ. “Үнэн сүсэгтэн хүн болбоос энэ ертөнцөд ч, ирээдүйн ертөнцөд ч амьдарна” гэсэн үгтэй адил буюу. Хэрэв “амьдрал” гэсэн үгээр энэ газар дэлхийн амьдралыг хэлдэг байсан бол*

үхэл түүнийг эзэмдэн авна гэдэг нь тодорхой". "Китаб-и-Иган" х.74,76,78

Бахайн сургаалаар Сэхээрэлт гэдэг нь ердийн бие махбодтой ямар ч холбоогүй юм. Хүний бие махбод нэгэнт үхсэн л бол тэр чигээрээ үхнэ. Задарч устаад, атом хэсгүүд нь хэзээ ч хуучны хэлбэр дүрсэндээ орохгүй.

Харин сэхээрэлт гэдэг бол хүн Бурханы Тодруулагчийн хайрласан Ариун Сүнсний хишгийг хүртэн оюун санааны шинэ амьдралд төрөхийг хэлнэ. Энэ тохиолдолд түүний амилан босч байгаа тэр булш болбоос Бурханыг үл хайхарсан мунхаг харанхуйн булш байсан юм. Сэрж өндийсөн тэр нойр нь болбоос олон хүмүүс Бурханы Өдрийн үүрийн цолмонг хүлээж байна хэмээн оюун санааны зогсонги байдалд орсон явдал юм. Эл үүрийн цолмон газар дээр амьдарч буй үхсэн амьд бүх хүмүүсийг гэрэлтүүлдэг боловч оюун санаагаар үхсэн тэр хүмүүс түүнийг мэдрэх чадалгүй сохор байдаг. Сэхээрэлтийн Өдөр гэдэг нь хорин дөрвөн цаг үргэлжлэх өдрийг хэлээгүй, харин эдүгээ эхэлж, өнөөгийн ертөнцийн мөчлөг дуусах хүртэл үргэлжлэх эрин үеийг хэлнэ. Өнөөгийн соёл иргэншлийн ул мөр гараг дэлхийн хөрснөөс бүрмөсөн устан арилсан ч энэ эрин үе үргэлжилсээр байх болно.

### **Христ эргэж ирсэн нь**

Бурханы ирээдүйн Тодруулагчийн талаар Христ олон удаа гуравдугаар биеэс хэлсэн байдаг. Харин зарим тохиолдолд нэгдүгээр биеийн өмнөөс хэлсэн байдаг. Жишээлбэл: *"Би чамд байрыг чинь засаж өгөхөөр явна. Би яваад байрыг чинь засаж өгөхөөр бол би дахин эргэн ирж, чамайг өөртөө хүлээн авна."* (Иоан, 14, 2) Үзэгдлийн нэгдүгээр бүлэгт Есүс тэнгэрт халихынхаа өмнө хутагт шавь нартаа хэлэхдээ: *"Та нараас холдон тэнгэрт хөөрч байгаа энэ Есүс тэнгэрт явсан тэр л замаараа дахин эргэж ирнэ"* гэснийг уншиж болно. Энэ болон бусад ижил төстэй айлдваруудыг уншсан Христчүүд Хүмүүний Хүү "тэнгэрийн үүлэн дундаас гайхамшигт алдраар" бууж ирнэ хэмээн итгэж, хоёр мянган жилийн өмнө Иерусалимын гудамжаар алхаж,

загалмайн цовдлуулан цусаа асгаруулсан мөнөөх Есүсийг яг тэр дүрээр нь дахин олж харна хэмээн хүсэн хүлээдэг юм. Тэд Түүний гар хөлөн дээрх хадаасны ул мөр болон Түүний бөөрөн дэх жадны ул мөрийг өөрсдийн гараар гэмтгэрч үзнэ хэмээн хүлээдэг. Гэвч Христийн хэлсэн өөрийнх нь үгсийн талаар жаахан ч болтугай тунгаан бодож үзвэл ийм санаа бодол нь буруу гэдгийг нотлоод өгнө. Христийн үед амьдарч байсан Иудейчүүд Элияг эргэж ирэх талаар мөн ийм л бодолтой байсан учир Есүс тэдний эндүүрлийг тайлбарлаж, “Элия эхлээд ирнэ” гэсэн зөгнөл нь биелэхдээ урьдын Элия өөрийн дүрээр эргэж ирээгүй харин түүний оронд “Элиягийн сүнс, хүч чадлыг эзэмшин” Загалмайлагч Иоан ирсэн юм хэмээн нотолж байв. Христ цааш нь хэлэхдээ, “*Хэрэв та нар үүнийг зөвшөөрвөл, энэ бол ирэх ёстой байсан Элия мөнөөс мөн гэдгийг ойлгоно. Сонсох чихтэй хүн байвал сонсогтун.*” хэмээжээ. Тиймээс Элия “эргэж ирнэ” гэдэг бол өөр эцэг эхээс төрсөн өөр хүн Бурханы мөн л сүнс, хүч чадлыг эзэмшин ирнэ гэсэн үг байсан юм. Тэгэхлээр Есүсийн энэ үгийг Христ эргэж ирэх асуудал дээр бас ашиглаж болох юм. Христ эргэж ирэхдээ өөр эхээс төрсөн өөр хүн боловч бас л Христийн адил Бурханы Сүнс ба Хүч чадлыг харуулсан хүний дүрээр эргэж ирнэ гэсэн үг юм. Христ “эргэн ирэх” зөгнөл нь Баб болон Бахаулла тодорсноор биелсэн юм хэмээн Бахаулла айлдсан байдаг. Тэрээр ингэж айлджээ:

*“Нарны тухай бодогтун. Хэрэв нар одоо “Би өчигдрийн нар байна” гэж хэлэх юм бол тэрээр үнэнийг хэлнэ. Тэрхүү нар цаг хугацааны дарааллыг эргэцүүлэн тооцоолоод, би өчигдрийнхөөс өөр нар байна гэж хэлбэл бас үнэнийг хэлнэ гэсэн үг. Үүний мөн адил, хэрэв бүх өдрүүд угтаа нэг л өдөр бөгөөд хоорондоо адилхан гэвэл энэ зөв бөгөөд үнэн юм. Гэвч тэдгээр нь нэр, шинж тэмдгээрээ ялгагдаж өөр байдаг гэвэл бас л үнэн. Хэдийгээр тэд адил ч, хэн ч өдөр бүр өөрийн гэсэн шинж тэмдэг, онцлог чанартай гэдгийг хүлээн зөвшөөрнө. Ийм л байдлаар Бурханы гэгээн Тодруулагч нарын ялгаа болон эв нэгдлийн шинж чанарыг ойлгогтун. Чингэвээс чи ялгаа болон эв нэгдлийн нууцлаг чанарын талаар Хамаг алдар нэр, Шинж чанарыг бүтээгч Бурханаас өгсөн битүү дохиог ой ухаандаа ойлгон тунгааж, янз бүрийн*

цаг үед тэрхүү мөнхийн Гоо үзэсгэлэн ямар учраас өөр өөр нэр, өргөмжлөлтэй байсныг нээн олмой". "Китаб-и-Иган" х.14-15

Абдул-Баха ийнхүү хэлжээ:

*"Христ хоёр дах удаагаа ирнэ гэсэн нь хүмүүсийн бодож байгаа шиг тийм утгатай биш харин Түүний дараагаар ирнэ хэмээн амлагдсан тэр Нэгэнийг хэлж байгаа юм. Тэрээр хамаг ертөнцийг хүрээлэн ивгээсэн Бурханы Ханлиг улс ба Бурханы Хүч чадлыг агуулан хүрч ирнэ. Энэ ноёрхол бол хүмүүсийн зүрх сэтгэл, сүнсэнд оршихоос биш материт ертөнцөд хамаарахгүй. Учир нь, материаллаг ертөнц болбоос Эзэн тэнгэрийн мэлмийд жижиг ялааны нэгхэн далавчийн дайнд ч хүрэхгүй гэдгийг мэдэхийг хүсвэл мэдтүгэй! Үнэнхүү Христ эхлэлгүй эхэн үеэс Түүний Ханлиг улстай ирсэн бөгөөд мөнхийн мөнх хүртэл Түүний Ханлиг улстай л ирнэ. Яагаад гэвээс, энэ утгаараа "Христ" гэдэг бол Тэнгэрлэг Мөн чанар, хурмастын эгэл жирийн Мөн чанар хийгээд эхлэл төгсгөлгүй Нэгжийн илэрхийлэл болгоо. Энэ нь цагийн мөчлөг бүхэнд цухуйж, ургаж, мандаж, жаргадаг." - "Абдул-Бахагийн Сургаал бичгүүд" х.138*

## Эцсийн Цаг үе

Христ ба Түүний хутагт шавь нар Хүмүүний Хүү Эцгийнхээ алдраар "эргэж ирэх"-ийн олон шинж тэмдгийг дурдсан байдаг. Христ ингэж айлджээ:

*"Иерусалим хот цэрэг армид бүслэгдсэн байхыг та нар харвал үгүйрэл хоосрол тун ойрхон байна гэдгийг мэдтүгэй... Учир нь энэ бол өшөө авалтын өдрүүд байх агаад бичигт үлдсэн бүх зүйлс биеллээ олох болно. Учир нь тус нутагт аймшигтай их сүйрэл дайрч, аймшигтай их цээрлэлийг ард түмэнд нь хүртээнэ. Тэд тийнхүү сэлмийн ирэнд автан унаж, бүх улс үндэстэнд боолчлогдон олзлогдоно. Иерусалим тэгээд буруу номтнуудын цаг эцэс болох хүртэл тэдний хөлд гишгэгдэнэ." Луух, 21, 20.24*



Тэрээр дахин хэлэхдээ:

*“Та нар хэнд ч мэхлэгдэхгүйн тулд хичээгтүн. Юу хэмээвээс, олон нь миний нэрээр ирж “Би бол Христ” хэмээн өгүүлэн олныг хуурна. Бас та нар дайн болон дайны сургийг сонсох боловч бүү айгтун. Юу хэмээвээс, энэ бүх зүйлс нь заавал учрах болно. Харин эцэс нь арай болоогүй. Бас үндэстэн нь үндэстний эсрэг, хаант улс нь хаант улсын эсрэг босож, бас газар газарт өлсгөлөн болж, газар хөдлөх болно. Харин энэ бүгд нь гай зовлонгийн эхэн болой. Тэгээд тэд та нарыг гай зовлонд тушаан, та нар алагдаж, миний нэрийн төлөө гэсэн бүх үндэстэн үзэн ядагдана. Тэр цагт олон нь нүгэлд унаж, нэг нэгнээ тушааж, нэг нэгнээ үзэн ядах болно. Бас олон худал зарлагууд гарч олныг хуурах болно. Бас хууль бус нь дэлгэрэх тул олны хайр хүйтэн болно. Харин эцэс хүртэл тэвчигч нь аврагдана. Тэнгэрийн хаант улсын сайхан мэдээ нь хамаг улсад гэрч болохын тулд бүх дэлхийд тунхаглагдана. Тийнхүү эцэс нь ирнэ.”* Матай, 24, 4.14 гэжээ.

Эдгээр хэсгүүдэд Христ маш тодорхой үгээр ямар ч учир битүүлэг шинжгүйгээр Хүмүүний Хүү заларч ирэхээс өмнө болох үйл явдлыг зөгнөн тодорхойлсон байна. Христ эдгээр үгийг айлдсанаас хойш олон зуун өнгөрч, энэ бүх шинж тэмдэг нь бүгд биелжээ. Дээрх хоёр хэсгийн төгсгөлд нь Тэрээр ирэх цагийн шинж тэмдэг болох үйл явдлыг дурджээ. Эхний тохиолдолд Иудейчүүд цөлөгдөхөө больж, Иерусалим сэргэн босно гэсэн бол сүүлчийн хэсэгт нь Евангели судрыг бүх л дэлхийд номлон дэлгэрүүлнэ хэмээжээ. Энэ хоёр зөгнөл хоёулаа манай үед биелэгдэж буй нь сонирхолтой. Хэрэв эдгээр зөгнөлийн хэсэг нь бусад зөгнөлийн адил үнэн юм бол, бид тэгвэл Христийн айлдаж байсан тэр “үеийн эцэс”-г амьдарч байгаа гэсэн үг болох нь.

Сэхээрэлтийн Өдөр ирэхээс өмнө болох үйл явдлын талаар Мухаммед Коран судартаа ингэж бичсэн байна:

*“Аллах тэнгэр айлдсан нь: “Есүс минь! Үнэнхүү Би чамайг үхүүлж, Өөртөө ойртуулан өргөмжилж, үл итгэгчдийн ял зэмлэлээс чамайг чөлөөлж, чамд итгэгчдийг үл итгэгчдийн дээгүүр Сэхээрэлтийн Өдөр хүртэл эрхэмлэн дээдлэх болмой. Тэр*

*цагт та нар надад эргэн ирж, зөрчил маргааныг тань та нарын хооронд таслан шийдэх болно.” Сура, 3, 54*

*“Иудейчүүд хэлэхдээ, “Бурханы Мутар гав гинжснд хүлээстэй” гэжээ. Өөрсдийнх нь гар хүлэгдээж, хэлсэн үгнийхээ төлөө тэд цээрлэгдээсэй бишээ. Үгүй ээ! Түүний мутар хоёулаа чөлөөтэй тэнийнэ! Тэрээр Өөрийнхөө дураар бэлэг хишиг тараана. Эзэн тэнгэр чинь чамд илгээсэн тэр зүйл болбоос олон хүмүүсийг эсэргүүцэн босч, үл итгэхэд хүргэнэ. Бид дайсагнал, үзэн ядалт тэдний хооронд Сэхээрэлтийн Өдөр хүртэл үргэлжлэг хэмээн хүссэн юм. Гэвч дайны галыг асах бүрийд нь Бурхан түүнийг унтраах болмой.” Сура, 5, 69*

*“Бид Христчүүд” хэмээж буй хүмүүстэй Гэрээс байгуулав. Гэвч тэд сурсан мэдсэнийхээ тал хэсгийг мартжээ. Тиймээс Бид тэдний хооронд дайсагнал, үзэн ядалт Сэхээрэлтийн Өдөр хүртэл үргэлжлэг хэмээн болгоосон бөлгөө. Эцэст нь Бурхан тэдэнд бурууг нь хэлээд өгнө”. Сура, 5, 17*

Эдгээр үгс Иудейчүүд, Христчүүдийн хувьд бараг тэр аяараа биелсэн бөгөөд Мухаммед айлдвараа айлдсан тэр үеэс хойш Иудейчүүд, Христчүүд хоорондоо тэмцэлдэж, хагарал бутралд өртөж ирсэн билээ. Харин Бахайн Эрин (Сэхээрэлтийн Өдөр) эхлэснээс хойш эл байдал эцэс болох гэж байгаа шинж тэмдгүүд илэрч эхэлсэн юм.

### **Тэнгэр диваажин, газар дэлхий дээрх Шинж тэмдгүүд**

Амлагдсан Элч залран ирэхэд илрэх шинж тэмдгүүдийн талаар Иудейн, Христийн, Исламын судар бичгүүдэд хоорондоо тун төстэйгээр дүрслэн бичсэн байдаг.

Иоилын номонд бичсэн нь:

*“Тийнхүү би газар дэлхий ба диваажинд гайхамигийг үзүүлж, цус, гал, утаа униарыг үзүүлнэ. Эзэн тэнгэрийн агуу их аймшигт Өдөр ирэхээс өмнө нар харанхуйлж, сар цусанд будагдана... Учир нь, Иудей ба Иерусалимыг дахин боолчлох тэр өдрүүдэд, тэр цаг*

үед би бүх улс үндэстнүүдийг цуглуулж, тэднийг Иософатын хөндийд авчирч, тэднийг шийтгэн яллана... Шүүлтийн тэр хөндийд үй түм, үй түмээрээ цуглана. Учир нь шүүлтийн хөндийд Эзэн тэнгэрийн Өдөр ойр байна. Нар, сар хоёр харанхуйлж, од мичдийн гэрэл бөхнө. Эзэн тэнгэр Зион улнаас хашигирч, Иерусалимаас дуу хоолойгоо гаргах тэр үед тэнгэр диваажин ба газар дэлхий донслон чичирнэ. Гэвч Эзэн тэнгэр бол хүн ардынхаа итгэл найдвар нь болно”. Иовд, 2, 30.32д 3, 1.2, 14.16

Христ ингэж айлджээ:

“Эдгээр өдрийн гамшиг зовлон өнгөрмөгц нар харанхуй болох бөгөөд сар гэрэлгүй болж одод тэнгэрээс унах бөгөөд тэнгэрийн хүчнүүд цочрон доргих болно. Тэр цагт Хүний Хүүгийн шинэж тэмдэг нь тэнгэрт үзэгдэх бөгөөд бас газар дээрх бүх овог аймаг нь чангаар уйлалдан, Хүний Хүү эрх чадал хийгээд их цог жавхлантайгаар тэнгэрийн үүлийг хөлөглөн ирэхийг үзэх болно.” Матай, 24:29, 30

Коран Сударт ингэж бичсэн байна:

“Нар харанхуйд бүрхэж, од мичид бүдгэрч, уул хад газраас хөндийрөн хөдлөх тэр үе... номын хуйлаас тайлагдаж, тэнгэр хуулагдаж, там шатан дүрэлзэхэд...” Сура, LXXXI

“Китаб-и-Иган” судартаа Бахаулла тайлбарлахдаа, нар, сар, од мичид, тэнгэр диваажин, газар дэлхийн тухай эдгээр зөгнөл айлдвар нь бэлгэ тэмдгийн чанартай бөгөөд тэдгээрийг шууд утгаар нь үгчлэн ойлгох ёсгүй гэсэн юм. Зөнч мэргэд ихэнхдээ материаллаг биш оюун санааны зүйлс, бодит биш оюун санааны гэрлийн тухай айлддаг. Тиймээс нар гэж дурдвал тэр нь Шүүлтийн Өдөртэй холбоотой агаад Үнэн зөвийн Нарыг хэлж байгаа хэрэг юм. Нар бол гэрэл гэгээний дээд эх сурвалж, тиймээс Моисей бол Иудейчүүдийн хувьд нар байсан, Христ Христчүүдийн хувьд нар, Мухаммед Мусульманчуудын хувьд наран байсан юм.

Нар харанхуйллаа хэмээн зөнч мэргэд айлдсан бол тэр нь гэдгээр оюун санааны Нарнуудын ариун сургаал нь буруу тайлбар, буруу ойлголт болон атгаг сэжиг үзэлд автан харанхуйлж, хүмүүс оюун санааны хувьд харанхуй болсныг өгүүлсэн юм. Сар болон

од мичид бол гэрэл гэгээг цацруулдаг боловч нарыг бодвол арай бүдэг байдаг бөгөөд хүн ардыг удирдан чиглүүлэх шашны тэргүүн, багш нарыг сар од төлөөлж байгаа юм. Сар гэрлээ өгөхөө болилоо, эсвэл цусанд будагдлаа, од мичид тэнгэрээс уналаа гэж байгаа нь сүм хийдийн тэргүүн лам нар доройтож, тэмцэл маргаанд хутгалдан, ухаан нь богиносч, хурмастын зүйлсийн талаар бодохын оронд энэ газар дэлхийн юмст орооцолдох болжээ гэснийг илтгэж байна.

Эдгээр зөгнөл айлдварын утга учрыг ганцхан талаас нь тайлбарлаж болохгүй бөгөөд эдгээр бэлгэдлийг бас өөр бусад талаас нь тайлж болох юм. Бахаулла, “нар”, “сар”, “од мичид” гэсэн үгийг ашиглаж байгаа нь бас нэг утгаараа шашин бүрийн сургаал номлолтой холбоотой гэж хэлсэн юм. Шинэ шашин сургаал ирэхэд өмнөх шашин сургаалын ёс жаяг, хэв маяг, зан заншил, хууль журам цагийн эрхээр өөрчлөгддөг тул энэ утгаараа нар, сар өөрчлөгдөж, од мичид тарж бутардаг ажээ.

Аль ч утгаар нь аваад үзсэн эдгээр зөгнөл айлдвар нь яг үгчлэн биелэхийн аргагүй билээ. Жишээлбэл, сар цусанд будагдаж, од мичид тэнгэрээс унаж чадахгүй шүү дээ. Хамгийн бүдэг од гэхэд дэлхийгээс олон мянган удаа том байдаг. Тэгэхлээр нэг од тэнгэрээс дэлхий дээр бууж ирэх юм бол дэлхий гэж байхаа болино биз дээ! Түүнээс гадна эдгээр зөгнөл материаллаг хийгээд оюун санааны хувьд биелдэг юм. Жишээлбэл, зөнч мэргэдийн айлдсанчлан Ариун Газар олон зууны турш элсэн цөл болж, ямар ч үржил шимгүй аглаг газар болсон билээ. Харин Сэхээрэлтийн энэ Өдөр энэ нутаг Исаяагийн зөгнөсөнчлөн “сарнай цэцэг лугаа адил баясан цэцэглэж” эхлэсэн нь харагдаж байна. Хагас зуун жилийн өмнө элснээс өөр юу ч байгаагүй газар өнөөдөр хүмүүс олноороо суурьшиж, газар хөрсийг хагалан ургамал тариа ургуулж, цэцэрлэг байгуулж, чидун жимсний цэцэрлэгүүд цэцэглэн босч байна. Хүмүүс жад сэлмээ анжис, хадуур болгож дайтаж байлдахын оронд ажил хөдөлмөр эрхэлбэл аль ч нутгийн элсэн цөл, аглаг хээр газар ч өөрчлөгдөн цэцэглэж, хүнд хэцүү амьдрал ард үлдэж, нутгийн уур амьсгал ч зөөлөрч, хот тосгодын

агаар бохирдохоо больж, материаллаг утгаараа ч “шинэ диваажин, шинэ газар дэлхий” гэдэг нь бодитоор биелэх болно.

### Хэрхэн эргэж ирэх тухайд

Үеийн эцэст хэрхэн залран ирэх талаараа Христ ингэж айлджээ:

*“Тэр цагт Хүний Хүүгийн шинэ тэмдэг нь тэнгэрт үзэгдэх бөгөөд бас газар дээрх бүх овог аймаг нь чангаар уйлалдан, Хүнийхүүэрх чадалхийгээд их цогжавхлантайгаар тэнгэрийн үүлийг хөлөглөн ирэхийг үзэх болно. Бас тэр нь ер бусын элч нараа бүрээний их дуутай хамт шгээх бөгөөд тэд нь түүний сонгогдогсдыг тэнгэрийн нэг хязгаараас нөгөө хязгаар хүртэл дөрвөн зүгээс цуглуулна. Хүний Хүү нь сүр жавхлантайгаар бүх ариун, ер бусын элч нартай хамт ирэхэд Өөрийн цог жавхлантай хааны суудалд сууна. Мөн түүний өмнө бүх үндэстэн цугларахад хоньчин нь хонио ямаанаас ялгах мэт нэгийг нь нөгөөгөөс нь ялгана.”* Матай, 24, 30,31, 25,31,32

Эдгээр болон бусад сургаал айлдваруудын талаар Бахаулла “Китаб- и-Иган” судартаа ингэж айлджээ:

*“Диваажин” гэсэн үг нь өргөмжит, сүрлэг байдлыг илтгэж байгаа болой. Яагаад гэвээс, диваажин болбоос Ариун Гэгээн Тодруулагчид, өнө эртний Алдарын Эх булаг бологсдын үүдэл нээлтийн суудал болой. Эдгээр өнө эртний Биесүүд эхийнхээ хэвлийгээс төрсөн хэдий ч мөн чанартаа Бурханы хүсэл тааллын тэнгэрээс бууж ирсэн юм. Тэд хэдийгээр энэ газар дээр амьдарч байгаа боловч дээд тэнгэр дэх Алдарын өргөөнд жинхэнэ ёсоор оршдог бөлгөө. Үхэлт хүмүүсийн дунд алхлахдаа тэд тэнгэрлэг ахуйн диваажинд дүүлж явдаг. Тэд хөлгүйгээр сүнсний замаар гишгэлж, далавчгүйгээр тэнгэрлэг эв нэгдлийн өндөрлөгт манддаг.*

*Амьсгалах амьсгаа бүрээрээ тэд хэмжээлиггүй их орон зайг эзэлж, агишин мөч бүрт нүдэнд үзэгдэх ба үл үзэгдэх аймгуудыг хэрэн хэснэ.*” -“Китаб-и-Иган”

“Үүлс” гэдэг нь харин хүмүүсийн дур хүсэл, замд үл нийцэх зүйлсийг хэлнэ. Урьд нь иш татсан шад мөрөнд Түүний айлдсанчлан: “Хутагт шавь та нар дээр хүрч ирэн та нарын сэтгэлд үл нийцэх зүйлсийг авчрах бүрийд та нар өөрсдөөрөө эрэмшин бардаж, заримыг нь нэр зээлдэгч хэмээн буруутгаж, заримыг нь хороож байсан билээ.” (Коран, 2:87) Эдгээр “үүлс” нь нэг утгаараа хууль зарлигийг халах, өмнөх эрин үеийн ёсыг халах, хүмүүсийн дунд түгээмэл ёс жаяг, зан заншлыг няцааж, бичиг соёлгүй хэдий ч Шүтлэгт үнэнч хүмүүсийг Шүтлэгийг эсэргүүцэгч эрдэмтэн мэргэдээс өргөмжлөн дээдлэхийг бэлгэддэг юм. Бас нэгэн утгаараа энэ үг нь мөнхийн Гоо жавхлан болбоос идэж уух, баян хоосон, алдар нэр, гутамшиг доромжлол, унтах, алхах зэрэг хүний хязгаарлагдмал нөхцлүүдийг эзэмшин хүмүүний дүрээр тодорсон учраас зарим хүмүүсийн оюун ухаанд эргэлзээ төрүүлж, Түүнээс нүүр буруулахад нь нөлөөлдөг ажээ. Иймэрхүү саад хөшгийг ихэвчлэн “үүлс” хэмээх үгээр зүйрлэн ярьдаг.”

“Ийм л “үүлс” газар дэлхий дээр оришгч бүхний эрдэм мэдлэг ба ухаарлын тэнгэрийг таллан хуваадаг юм. “Тэр өдөр үүл тэнгэрийг хуваана” (Коран, 25:25) хэмээн Тэрээр хэлсэн билээ. Хүмүүсийн нүднээс нарыг үүл халхладаг шиг эдгээр зүйлс нь хүмүүс тэнгэрлэг Гэрлийг олж харахад нь саад болдог байна. Үүнийг үл итгэгчдийн амнаас унасан үгс ч бас гэрчилнэ. Ариун Сударт бичсэн нь: “Тийнхүү тэд хэлэхдээ, “Ямар хутагт шавь ийм байдаг юм бэ? Тэрээр хоол идэж, гудамжаар алхалж байна шүү дээ. Тэнгэрээс сахиусан тэнгэр бууж ирж, Түүнтэй хамтрахгүй л юм бол бид итгэхгүй” хэмээжээ.” (Коран, 25:7) Бусад Зөнч мэргэд



ч ялгаагүй ядуурал хоосролыг амсаж, зовлон зүдгүүрт өртөж, өлсөж цанган, энэ ертөнцийн өвчин эмгэг, хувь тавиланг бас эдэлдэг байжээ. Эдгээр ариун Хүмүүс ингээж дутагдан гачигдаж байгаад гайхаж хүмүүс эргэлзэн тээнгэлзэж, эндүүрэн төөрөгдөж байсан байна. “Чиний төлөө биш сэн бол Би тэнгэр диваажин ба газар дэлхий дээр байгаа бүхнийг бүтээхгүй байсан” гэж Бурхан айлдсан байтал тэрээр ийм их зовлон зүдгүүрт өртчихөөд дэлхийн бүх улс түмнүүдийг захирч, Өөрийгөө бүх орчлонгийн зорилго, Бурханы илгээсэн Элч хэмээн яаж зарлаж чадна вэ гэж хүмүүс боддог байсан байна. Бурханы Зөнч мэргэн бүр, мөн Түүний дагалдагч нар ямар их зовлон бэрхшээл, ядуурал хоосрол, өвчин эмгэгт автаж асар их гашуун амьдралыг туулсан талаар та эргэлзээгүй сонсоо биз ээ. Дагалдагч нарынх нь толгойг бэлэг болгон янз янзын хотууд руу илгээж, ариун үүргээ биелүүлэхэд нь ямар их саад тотгор учирч байсныг та бас дуулаа биз ээ. Тэд бүгдээрээ Бурханы Үйл хэргийн дайснуудын гарт золиос болж, дайснуудын эрхээр элдэв зовлонг амссан юм. “Китаб-и-Иган”

“Муу санаат хүмүүсийн хүсэл шуналд үл нийцэх зүйлсийг Яруу Алдарт Бурхан захирамжилж, үнэнч шударгыг худалч хуурмагаас, үнэнч тууштайг буруу номтноос ялган салгаж, шадар зарц нартаа нотлох түшиг тулгуур бөгөөд туг далбаа болгосон юм.” “Китаб-и-Иган” х46-47

“Одоо харин “Тэрээр тэгээд Өөрийн сахиусан тэнгэрүүдийг илгээж...” гэсэн Түүний айлдварын талаар хэлье. “Сахиусан тэнгэрүүд” гэдэг нь сүнсний хүч чадлаар бэхжиж, Бурханы хайрын галаар шатан дүрэлзэж, хүмүүний бүхий л хязгаарлагдмал, муу муухай чанараас ариусч, хамгаас өргөмжит Биес болон тэнгэрийн сүнснүүдийн дүрийг ологсдыг хэлнэ. “Китаб-и-Иган” х.49

“Есүсийн дагалдагч нар эдгээр үгсийн далд утга учрыг хэзээ ч ойлгож байгаагүй, тэд болон тэдний шашны толгойлогчдын хүсэн хүлээж байсан шинэ тэмдгүүд илэрч гараагүй учраас тэд Есүсийн өдрүүдээс хойш Ариун Гэгээн тэдгээр Тодруулагчдын үнэнийг өнөөг ч хүртэл хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан юм. Түүгээр тэд Бурханы ариун буян хийгээд Түүний тэнгэрлэг айлдварын гайхамшгаас татгалзсан юм. Сэхээрэлтийн энэ Өдөр тэдний байдал ийм дор ажээ! Тэр ч байтугай, хэрэв эрин үе бүхэнд Бурханы Тодруулагч нарын шинэ тэмдгүүд судар бичиг, тогтсон номлол сургаалд заасанчлан нүдэнд үзэгдэх байдлаар илэрсэн бол хэн ч түүнээс нүүр буруулж, түүнийг үгүйсгэх чадалгүй байхсан бөгөөд адист буянтныг арчаагүй доордоос, бурханлагийг нүгэлтнээс хэн ч ялган салгах боломжгүй байхсан гэдгийг ч тэд ойлгодоггүй юм. Шударгаар шүүгтүн: Евангелид заасан зөгнөл айлдварууд бүгд үгчлэн биелсэн бол, Мэригийн Хүү Есүс сахиусан тэнгэрүүдийнхээ хамт бодит тэнгэрээс үүлийг хөлөглөн буусан бол, хэн ч үл итгэх, үнэнийг няцаан үгүйсгэх хандлагыг гаргаж чадах байсан юм бэ? Үгүй ээ, ийм аймшигт явдал газар дэлхийн бүх оршин суугчдыг эзэмдэж, үг ч дуугарах чадалгүй, тэр ч бүү хэл үнэнийг хүлээн зөвшөөрөх юм уу үгүйсгэх ч чадалгүй болох байсан билээ.” “Китаб-и-Иган” х50-51

Дээрх тайлбараас харвал, Хүмүүний Хүү эхээс хүмүүний дүрээр төрж, ядуу зүдүү, боловсролгүй, эрх мэдэлтэн дээдсүүдийн дарлал мөлжлөгт өртөн, гадуурхагдан хавчигдсан байдлаар тодрон гарснаар малчин хүн хонь ямаагаа ялгадгийн адил ертөнцийн хүмүүсийг бие биенээс нь ялган салгадаг юм. Оюун санааны дотоод мэлмий нь нээгдсэн хүмүүс эдгээр үүлсийг цаана буй зүйлийг нэвт харж, тэдэнд нээгдсэн Бурханы “хүч чадал ба сүр жавхлан”-г олж мэдэрсэн юм. Харин атга сэжиг үзэл, алдас нүгэлдээ нүд нь

аниастай бусад нь харанхуй үүлнээс өөр юуг ч олж үзэлгүй адистат гэрэл гэгээнээс хүртэх хувьгүй харанхуй бүүдгэр орчинд гэлдэрнэ.

*“Харагтун: би өөрийн элчийг илгээж, тэрээр замыг минь засаж өгнө. Та нарын эрэн хайсан Эзэн тэнгэр гэнэт өөрийн сүмд ирж, мөн та нарын хүсэн мөрөөдсөн гэрээсийн элч бас адил... Гэвч түүнийг ирэх өдөр хэн тэсэх билээ? Түүнийг тодорч ирэх тэр өдөр хэн тэсвэрлэх билээ? Учир нь тэрээр шатаагч гал бөгөөд ариусгагч саван лугаа адил бөлгөө... Харагтун: халуун тогоонд мэт шатах өдөр ирнэ, тэгээд бардам зантангууд бүгдээрээ, муу нүгэлтнүүд бүгдээрээ сүрэл мэт шатна... Харин Миний Алдар нэрээс эмээдэг чиний хувьд Үнэн зөвийн Наран мандаж, жигүүртээ ашагаагч эмийг тээн авчирна”.* Мал.3:1,2, 4:1.2

ТЭМДЭГЛЭЛ: Судар бичиг дэх зөгнөл айлдварын биелэлийн тухай асуудал нь маш өргөн хүрээтэй асуудал бөгөөд бүрэн гүйцэд тайлбарлая гэвээс олон боть ном болох биз ээ. Нэгхэн бүлэгт энэ бүхнийг багтааж бичихдээ Бахай Шүтлэгт буй тайлбарыг тоймлон харуулах зорилго агуулсан болно. Даниэл ба Гэгээн Иоаны туурвисан дэлгэрэнгүй тайлбаруудыг ер хөндөж сөхсөнгүй. Уншигч авхай энэ талаар илүү дэлгэрэнгүйгээр “Учир нь тайлагдсан зарим асуудал” номноос уншиж болно. Бахауллагийн бичсэн “Китаб-и-Иган” судар, Мирза Абул Фадлын бичсэн “Бахай нотолгоо” болон Бахаулла, Абдул-Баха нарын олон Сургаал бичгүүдээс зөгнөл айлдваруудын талаар бас уншиж болно.

Арван дөрөвдүгээр бүлэг

**БАХАУЛЛА, АБДУЛ-БАХА НАРЫН  
МЭРГЭН ЗӨГНӨЛ**

*“Эзэн тэнгэрийн айлдаагүй үг гэдгийг бид хэрхэн мэдэх билээ гэж чи зүрхэндээ хэлэх аваас, Зөнч мэргэн Эзэн тэнгэрийн нэрээр үг хэлтэл тэр үг нь үл биелэх аваас хэлсэн тэр зүйл нь Эзэн тэнгэрийнх биш болой. Харин зөнч мэргэний өөрийх нь хэлсэн үг болой.” Деют., 18, 21-22*

**Бурханы Айлдварын бүтээлч хүч**

Гагцхүү Бурхан л хүссэн бүхнээ хийх чадалтай билээ. Бурханы Тодруулагчийн хамгийн шилдэг нотолгоо нь Бурханы үгийн бүтээлч хүч юм. Хүмүүний амьдралын бүхий л асуудлыг өөрчлөн хувьсгаж, хүмүүний бүхий л эсэргүүцлийг даван туулах чадалтай бүтээлч үг юм. Зөнч мэргэдээр дамжуулан Бурхан Өөрийн хүсэл тааллыг илтгэдэг агаад тухайн айлдвар гэр даруй биелвэл Зөнч мэргэний үнэн магадын, Бурханаас заяасан суут удвистайн тод нотолгоо болно.

*“Хур бороо, цас тунадас тэнгэрээс газарт унаж, тэнгэр лүүгээ эргэж очилгүй газрыг ундаалж, толжүүлэн цэцэглүүлж, ингэснээр тариаланч хүнд үр тариа өгч, хүн зонд идээ талх бэлэглэдгийн адил миний Үг айлдвар миний амнаас унаад хоосон эргэж ирдэггүй, харин миний хүссэн зүйлийг бүтээж, илгээсэн газраа цэцэглүүлэн гүйцэлдүүлнэ.” - “Исаяа, 4: 10, 11*

Загалмайлагч Иоан Есүс дээр ирэн: “Ирэх ёстой хүмүүн чи мөн үү, эсвэл бид өөр хүнийг хайх уу?” хэмээн асуужээ. Есүс хариулахдаа ердөө л өөрийнх нь үгс ямар үр нөлөө бүтээснийг л харахад болно хэмээсэн байна.

*“Та нар буцан яваад, юу сонссон, үзсэнээ Иоанд илтгээгтүн: Сохор нь үзэж, доголдон нь явж, уяман өвчтөн нь цэвэрлэгдэж, дуулий нь сонсож, үхсэн нь амилж, үгээгүйд нь байртай мэдээ*

*тунхаглаж байна. Надаас болж үл бүдрэгч хэн нь ч адислагдсан билээ.” Матай, 11: 4-6*

Одоо тэгвэл Бахауллагийн үг айлдварт Бурханы Үг айлдварт байх ёстой бүтээлч хүч чадал оршиж байж уу гэдгийн нотолгоо хэр байгааг харцгаая.

Бахаулла дэлхийн удирдагч нарт даян дэлхийн энх тайвныг тогтоохыг зарлиг болгосон боловч 1869-1870 оны хооронд дайн байлдааныхаа бодлогыг үргэлжлүүлсээр байсан тул хаант засгууд нурж, удаа дараагийн дайн дажинд ялалтанд хүрэхээ больж, эцэст нь 1914-1918 оны Европын дайнаар дайн байлдаан бол ялсанд ч, ялагдсанд ч адил хор хөнөөлтэй гэдэг нь тодорхой болсон билээ.<sup>1</sup>

Бахаулла мөн дэлхийн удирдагч нарыг өөрсдийн албат иргэдээ халамжлан тэтгэж, улс төрийн эрх мэдлээ нийтийн сайн сайханд зориулан ашиглахыг уриалсан юм. Түүнээс хойш нийгмийн хууль ёс асар ихээр хөгжин дэвшсэн билээ.

Бахаулла баян, адуугийн туйлшралыг хязгаарлахыг зарлиг болгосноос хойш амьжиргааны доод түвшнийг тогтоох хууль тогтоомж гарч, мөн баячуудыг эд баялагт орлогын татвар ногдуулж, өв хөрөнгийн татварыг бас нилээд анхаарчээ. Тэрээр мөн боолчлох ёсыг тэр аяар нь төдийгүй бас эдийн засгийн боолчлолын хамт халахыг айлдсан тэр цагаас хойш хүн ардын хөгжил дэвшил дэлхийн бүх өнцөг буланд гайхалтай хурдаар дэвшсэн билээ.

Бахаулла эрэгтэй эмэгтэйчүүд тэгш эрхтэй, эрх бөгөөд үүргээр тэнцүү байх ёстой хэмээн зарлан тунхагласан юм. Тэр тунхаглалаас хойш эмэгтэйчүүд олон зууны турш хавчигдан дарлагдаж байсан тэр хүлээснээс ангижирч, эрэгтэй хүнтэй эн зэрэгцэн байр сууриа олох талаар түргэн дэвшиж байна.

Тэрээр шашнуудын суурь нэгдмэл байдлыг зарлан тунхагласан бөгөөд энэ хугацаанд дэлхийн бүх өнцөг буланд шашин хоорондоо эвлэрэнгүй найрсаг, биеэ биеэ ойлгох, нийтийн тусын тулд хамтран ажиллах явдалд шинэ ахиц гаргахын тулд чин сэтгэлтэй хүмүүсийн эрс шийдэмгий хүчин чармайлт гарсаар

<sup>1</sup> Энэ нь Дэлхийн 2-р дайнаар бүр ч их нотлогдсон юм.

ирсэн билээ. Хаа сайгүй, шашны явцуу бүлэглэлүүд доройтож, түүхэн байр суурь нь ч улам ганхсан юм. Шашин дан ганцаараа нийгмээс тасархай байдаг ёс нь хязгаарлагдмал үндсэрхэг үзлийг халсан мөн л хүчнүүдийн дор арилан устсан юм.

Тэрээр бүх нийтээр боловсрол эзэмшихийг айлдаж, үнэнийг бие даан эрэлхийлэх нь хүн бүрийн оюун санааны бие даасан байдлын нотолгоо хэмээн айлдсан юм. Энэхүү шинэ хүчинд орчин үеийн соёл иргэншил ёроолдоо хүртэл булгилан буцалсан билээ. Хүүхэд багачуудад албан ёсны боловсрол олгох, мөн насанд хүрэгсдэд нэмэлт боловсрол олгох нь засгийн газруудын нэн тэргүүний бодлого болсон юм. Хүний чөлөөт бие даасан сэтгэлгээг хяхан хавчиж байсан орнуудыг гадны улс түмнүүд шүүмжлэж, тус орон дотроо хувьсгал тэмцэлд автсан байна.

Бахаулла даян дэлхийн туслах хэл бий болгохыг зарлиг болгосон бөгөөд Доктор Заменгоф болон бусад нөхөд энэ дуудлагыг хүлээн авч, энэхүү агуу үүрэг боломжинд өөрсдийн амьдрал, суу билгийг зориулжээ.

Үүнээс гадна Бахаулла хүн төрөлхтөнд цоо шинэ оюун санааг хайрлаж, хүмүүсийн зүрх сэтгэл, оюун бодолд нийгмийн эмх журмын тухай цоо шинэ хүсэл мөрөөдөл, үзэл санааг шингээсэн билээ. 1844 онд Бахайн эрин дөнгөж эхлэсэн тэр үеэс хойш ертөндөд биелсэн үйл явдлаас илүү гайхамшигтай зүйл энэ түүхэнд үгүй билээ. Жилээс жилд өнгөрсөн зууны хоцрогдсон үзэл бодол, зуршил хэвшил, хандлага, байгууллагууд доройтон элэгдэж, эдүгээ энэ дэлхийн ухаан билигт эрэгтэй эмэгтэй хүн бүр хүн төрөлхтөн хамгийн аймшигт хямралт үеэ үзэж байна гэдгийг нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч байна. Нэг талаас Бахауллагийн сургаалын гэрэл гэгээнээс ундарсан шинэ бүтээлт орчлон төрж, хөгжил өсөлтийнхээ шинэ замд ороод буйг харж байна. Нөгөө талаас нь харвал, тэрхүү гэрэл гэгээг үл тоомсорлон хяхаж хавчсан газар бүр гай гамшиг, сэтгэлийн мухардал ноёрхож буй нь харагдана.

Гэсэн хэдий ч үнэнч Бахай хүний хувьд үүнээс өөр тоо тоймшгүй баталгаа нотолгоо нь Бахауллагийн сүр хүчийн жинхэнэ хэмжээг илтгэж өгдөг билээ. Энэ хорвоо дээр туулсан



Түүний амьдрал, онгод хайрлагч үг сургаалынх нь няцаашгүй хүч чадал нь чухамдаа Бурханы хүсэл тааллын цорын ганц хэмжүүр болдог юм.

Бахауллагийн зөгнөл айлдвараас илүү дэлгэрэнгүй нухацтай судалж, тэдгээр айлдвар нь хэрхэн биелснийг ажиглан үзвэл Түүний үг үнэн байсны жинтэй нотолгоог олж харах болно. Эдгээр зөгнөл айлдвараас нь цөөн хэдийг толилуулж, нотлогдсон үнэн баримт жишээнээс дурдья. Эдгээр зөгнөл айлдварыг амьдралд бодитоор хэрэгжихээс нь ч өмнө өргөн нийтэлж гаргасан байсан юм. Дэлхийн хаад удирдагч нарт илгээсэн Бахауллагийн захидлууд дотор ийм мэргэн зөгнөл арвин ихээрээ агуулагдаж байдаг бөгөөд эдгээр захидлуудыг арван есдүгээр зууны эцэст Бомбей хотод эмхлэн хэвлүүлсэн юм. Түүнээс хойш хэд хэдэн хэвлэл гарчээ. Энд түүнчлэн Абдул-Бахагийн айлдсан мэргэн зөгнөлөөс жишээ дурдах болно.

### Гуравдугаар Наполеон

1869 онд Бахаулла 3-р Наполеонд захидал бичиж, түрүүнд бичсэн захидлыг үл тоомсорлосныг, мөн дайн байлдаанд хорхойсон дурласныг нь зэмлэн буруушаасан байна. Уг Илгээлт захидалд Бахаулла ингэж хагуу анхааруулжээ: *“Хийсэн нүглийн чинь төлөө хаант засаг чинь нурж, үйлдсэн гэмийн чинь төлөө шийтгэл болж эзэнт гүрэн гарнаас чинь мултрах болно. Тэр цагт чи алдас болжээ гэдгээ мэдэх болно. Чи энэ Үйл хэрэгт дэм болж, Бурханы Сүнс (Есүс Христ) Түүний Чиг шулуун энэ Замд үл туслах аваас улс орны чинь бүх хумуус үймээн самуунд автах болно. Ганган хээнцэр байдал чинь чамайг өөртөө бардахад хүргэв үү? Амьдралаараа өчсү! Энэ бүхэн удаан үргэлжлэхгүй, үгүй ээ, бат бөх энэ Олсноос чи чанга атгахгүй бол энэ байдал чинь мөдхөн эцэс болно. Чи үл тоомсорлонгуй хандаж байгаа учраас доромжлол гутамшиг чиний араас элдэн хөөж буйг бид харж байна.”*

Тэр үед нэр Алдарынхаа оргилд хүрсэн байсан Наполеон энэ анхааруулгыг хайхарч үзээгүй гэдгийг хэлэх нь илүүц биз

ээ. Дараачийн жил тэрээр Пруссэй байлдахаар болж, цэрэг арми нь маш амархан Берлиныг эзлээд авна гэж эндүүрч байжээ. Гэвч Бахауллагийн зөгнөсөн тэр эмгэнэлт төгсгөл ирэв. Тэрээр цэргүүдтэйгээ Саарбрук, Виссенбург, Метцийн тулалдаанд бут цохигдож, Седанд бүрмөсөн ялагджээ. Түүнийг олзлон Прусс руу авч явсан бөгөөд хоёр жилийн дараа тэрээр Англид эмгэнэлтэйгээр нас барсан байна.

## Герман

Хожим Бахаулла Наполеоныг бут цохисон байлдан дагуулагч нарт бас анхааруулга өгсөн боловч тэд мөн адил чихээ таглан үл тоомсорлосныхоо хариуд аймшигтай эцсээ үзжээ. Аккад хоригдож байхдаа туурвисан “Акдас” судартаа Бахаулла Германы Эзэн хаанд хандаж ингэж бичсэн байна:

“Аяа, Берлиний Хаан минь ээ! Энэхүү илэрхий Сүм дотроос дуудаж буй Дуу хоолойг чих тавин сонсогтун. Үнэнхүү, Мөнхийн, Хосгүй, Өнө эртнийн Надаас өөр Бурхан үгүй билээ. Тэнгэрлэг Үүдэл нээлтийг танин мэдэхэд бардам зан чинь саад болох вий, Дээд тэнгэрийн Сэнтий болон доод газрын Эзэн тэнгэрээс мунхаг дур тачаал чинь чамайг хаан далдлах вий хэмээн болгоомжил. Ийнхүү чамд Эрхэм Дээдийн Бийр зөвлөж байна. Тэрээр үнэнхүү Хамгаас Гоо жавхлант, Бүхнээс Буянтан билээ. Чамаас илүү хүч чадалтай, чамаас илүү байр суурьтай байсан түүнийг (3-р Наполеон) чи санаж байна уу? Тэр одоо хаачив? Түүний эд баялаг хаачив? Анхааралдаа энэ бүхнийг авч, гүн нойрондоо бүү нойрмогло. Дарангуйлагчдын гарт амссан зовлонгоо түүнд Бид мэдэгдэхэд тэрээр Бурханы Илгээлт бичгийг үл хайхран хаясан билээ. Тиймээс гутамшиг доромжлол түүнийг бүх талаас нь хүрээлж, тэрээр асар их алдагдалд орсоор газар шоронд булагдсан билээ. Хаан минь, түүний тухай болон улс хотыг эзэлж, хүмүүсийг захирдаг өөр шигээ бусад хүмүүсийн тухай гүнзгий тунгаан бод. Хамгаас Энэрэлт Бурхан тэднийг орд харшнаас нь гаргаж булш руу түлхэн оруулсан билээ. Үүнийг анхаарч, тунгаан бодож үз... Рейн мөрний эрэг минь! Өшөө хонзонгийн сэлэм чам руу чиглэгдсэн байгаа тул чиний ус цусаар будагдсан байхыг бид

олж харлаа. Энэ бас дахин давтагдана. Берлин хот өнөөдөр сүр жавхлантай байгаа хэдий ч түүний шаналах дууг Бид сонслоо.”

1914-1918 оны дайнд германчууд амжилтанд хүрч, ялангуяа 1918 онд давшиж байсан тэр үед Перст Бахай Шүтлэгийг эсэргүүцэгч хүмүүс дээрх алдартай зөгнөлийг иш татаж, Бахауллаг гутаах гэж оролддог байжээ. Гэвч ялалт байгуулсан германчууд тун удахгүй аймшигт гай гамшигт учирснаар Бахайн Үйл хэргийн дайснуудын энэ зүтгэл талаар өнгөрсөн төдийгүй уг зөгнөлийг тэд алдаршуулсны ачаар хүмүүс Бахауллаг улам ихээр таашаан зөвшөөрөх болсон байна.

## Перс

Дарангуйлагч хаан Насириддин Шах эрх хүчийнхээ оргилд байсан тэр үед бичсэн “Акдас” судартаа Бахаулла Персийн нийслэл болон Өөрийнхөө төрөлх хот болох Тегеран хотыг адислаж, ийннүү айлдсан юм:

*“Бурхан чамайг хүн төрөлхтний баяр жаргалын эх үүсвэр болгохоор сонгож авсан тул бүү уйтгарлан гунигла. Та (Тегеран) Нутаг минь. Түүний таалал оршвол, Тэрээр чамайг шударга ёсоор захирч, чононуудын тарааж бутраасан Бурханы хонин сүргийг нэгтгэх тэрхүү хүмүүний сэнтий болгох болмой. Энэхүү захирагч нь баяр жаргал гэрэлтсэн царайгаа Баха-н хүмүүст хандуулж, тэдэнд ивээл хайрлах болмой. Тэрээр үнэнхүү Бурханы мэлмийд хүмүүсийн дундаас эрдэнэ хэмээн тооцогддог болой. Түүнд Бурханы алдар, Түүний Үүдэл нээлтийн хаант улсад оршигч бүхний алдар оршиж байгаа билээ.*

*Бурханы Алдарын Тодруулагч чиний дотор мэндэлж, Бурхан чамайг “Түүний гэрэл гэгээний Үүрийн Туяа” болгосон тул баяр цэнгэлийн дээдийг эдлэгтүн. Чамд соёрхсон энэ нэр алдарт баярлаж яв, энэ нэрээр дамжуулан гоо жавхлангийн Өдрийн Од сүр жавхлангаа цацуулж, газар дэлхий ба диваажин хоёр гэрэлтэн гийж буй билээ.*

*Удахгүй чиний байдал өөрчлөгдөж, хүч чадлын цулбуур ард түмний гарт очих болно. Үнэнхүү Эзэн тэнгэр чинь Бүхнийг*

*Мэдэгч билээ. Түүний эрх мэдэл бүх л юмсыг хамарна. Эзэн тэнгэрийнхээ буян хишигт итгэл дүүрэн яв. Түүний хайр халамжийн харц үүрдийн үүрд чам руу чиглэсэн байх болно. Чиний үймээн самуун энх тунх, амарлингуй байдалд шилжих өдөр ойртож байна. Тийнхүү энэхүү гайхамшигт Сударт айлдсан болой.” - “Бахауллагийн Сургаалын Дээжис”, LVI*

Одоогоор Перс орон Бахауллагийн зөгнөсөн тэр үймээн самууны үеэсээ дөнгөж ангижраад байгаа бөгөөд үндсэн хуульт засгийн газар нь саяхан байгуулагдаж, гэрэлт ирээдүйн шинэж тэмдэг нилээд байна.

## Турк

Туркийн султан болон ерөнхий сайд Али Пашад хандан Бахаулла Туркийн шоронд хоригдож байхдаа захидал бичиж, анхааруулга өгсөн байна. Аккагийн шоронгоос Тэрээр Султанд ингэж бичжээ:

*“Өөрийгөө хамгийн агуу хүн гэж үздэг чи минь ээ... удахгүй алдар нэр чинь мартагдаж, чи асар ихийг алдах болно. Чиний бодлоор дэлхий ертөнцийг Амьдруулагч бөгөөд Энх тайвныг сахиулагч энэ хүн гэмт хэрэгтэн ажээ. Ямар гэм хийсэндээ тэдгээр эмэгтэйчүүд, хүүхэд багачууд чиний уур хилэн, чиний эсэргүүцэл, үзэн ядах сэтгэлийг өдоосон хэрэг вэ. Чиний улс орны эсрэг ямар ч тэмцэл хийгээгүй, чиний Засгийн газрын эсрэг ямар ч хувьсгал өдөөгөөгүй олон хүмүүсийг чи хяхан хавчсан билээ. Үгүй ээ, тэд өдөр шөнөгүй гагцхүү Бурханы нэрийг тайван дурсан суусан билээ. Чи тэдний эд хөрөнгийг булаан авч, харгис хэрцгий үйлдлээрээ тэдэнд байсан бүхнийг олзлон авсан билээ... Бурханы мэлмийд чиний улс гүрэн, алдар нэр, эрхшээл ноёрхлоос чинь атга шороо ч хамаагүй илүү. Тэрээр хүсэх л юм бол чамайг цөлийн элс шиг цацах болно. Удахгүй Түүний цээрлэл чамд хүртээгдэж, хүн ардын чинь дунд хувьсгал өрнөж, улс орон чинь хагаран бутарна! Тэр цагт чи уйлж гувиух боловч чамайг туслан хамгаалах хэн ч үл олдоно... Бурханы цээрлэл бэлэн байна, удахгүй Зарлигийн Бийрээр*

*бичсэн тэр бүхэн биелэхийг чи харах тул анхааран болгоомжил.*” (“Өрнөдийн Од”, 2-р боть, х. 3)

Али Пашад хандан Тэрээр ингэж бичжээ:

*“Дарга минь, чи Бурханы Хутагт шавь Мухаммедыг Хамгаас өргөмжит Диваажиндаа шаналан дуу алдахад хүргэж, аймгийгт нүгэл үйлдлээ. Ертөнц чамайг бардам болгож, чи Дээд тэнгэрийн чуулганыг гэрлээрээ гэрэлтүүлсэн Түүний дүр царайнаас нүүр буруулжээ. Удахгүй чи гарцаагүй алдагдалд унахаа харна. Би бээр Хүчирхэг, Азуу Бурханы Үүрийн туяа гэгээрсэн газраас чам дээр ирж, Бурханы хайрт шавь нарыг мэлмийг гийгүүлсэн Үйл хэргийг авчирсан атал чи Персийн захирагчтай хамтарч Намайг хохироох гэж оролдсон билээ...*

“Орчлон хорвоод асаасан Бурханы галыг чи унтрааж чадна гэж бодоо юу? Үгүй ээ! Түүний Үнэн Сүнснийг барин хэлье, чи ойлгодог ч болоосой. Түүгээр ч үл барам, чиний үйлдсэн бүхний үр дүнд тэр галын дөл улам ширүүсэн дүрэлзэж байна. Мөдхөн тэр гал дэлхий ертөнц болон түүний оршин суугчдыг нөмрөх болно... Далд Нууцын Нутаг (Адрианонополь) ба ойролцоох нутгууд өөрчлөгдөж, хааны гараас мултарч, үймээн самуунд автаж, уй гашуудлын дуу сонсдож, бүхий л талаас нь гай зовлон нөмөрч, дарангуйллын гарт энэхүү олзлогсодод учирсан зовлонгийн төлөө үймээн сандрал дэгдэх цаг ойртож байна. Эл үйл явдлын улмаас овоо толгод ёолон шаналж, мод ургамал, уул хад уйлан хашгирч, бүх талаас цус урсана. Тэр цагт хүмүүс туйлын гутралд орсон байхыг чи олж харна...

*“Ийнхүү Хамгаас мэргэн Бүтээгч Бурхан зарлиг болгосон бөлгөө. Түүний хүсэл тааллыг тэнгэр диваажин ба газар дэлхийн оршин суугчид үл дийлэх, бүхий л хаад удирдагч нар ч Түүнд хүссэнээ хийхэд нь саад хийж үл чадах билээ. Гай гамшиг болбоос энэхүү Дэнлүүнд тос болдог бөгөөд түүгээр Гэрэл гэгээ нь нэмэгддэг гэдгийг чи мэдэх болтугай! Харгис дарангуйлагчдын харуулсан эсэргүүцэл нь энэхүү Шүтлэгийг улам бадруулж, түүгээр дамжин Бурханы тодруулал ба Түүний Үйл хэрэг дэлхийн хүн ардын дунд улам өргөн хүртсэн болой.”*

“Акдас” судартаа Тэрээр бас бичсэн нь:

*“Хоёр далайн эрэг дээр орших Газар минь! Бурангуй ёсны сэнтий үнэнхүү чам дээр тогтоож, үзэн ядалтын дөл чиний цээжинд дүрэлзэж, дээд тэнгэрийн Чуулган бөгөөд Тэнгэрийн Сэнтийг хүрээлэгчид гаслан уйлж байна. Чиний дотор муухаг тэнэгүүд мэргэн ухаантнуудыг захирч, харанхуй гэрлийг ноёлж байгааг олж харлаа. Өнгөн талаараа ганган хээнцэрдээ чи эрдэн бардав уу? Хүн төрөлхтний Эзэн тэнгэр Түүний нэрээр өчсү! Энэ бүхэн мөдхөн дуусаж, охид бүсгүйчүүл, бэлэвсэн эхнэрүүд чинь, чиний дотор оршин суугч бүх хүмүүс уйлан гашуудах болно. Ийнхүү Бүхнийг мэдэгч, Бүхнээс мэргэн чамд мэдүүлж буй.”*

Эдгээр анхааруулга зөгнөлийг нийтэлсэн тэр цагаас хойш нэгэн үс хүчирхэг байсан энэхүү эзэнт гүрэн удаа дараалан гай гамшигт автсан нь эдгээр үгс зөнч мэргэн байсныг нотолсон юм.

## Америк

1873 онд Аккад туурвисан “Акдас” судартаа Бахаулла Америкт хандан ингэж айлджээ:

*“Ая, Америкийн удирдагч нар аа, Америкийн бүгд найрамдах улсуудын Ерөнхийлөгчид өө, сонсогтун! Сүр жавхлангийн Эх булгаас мандсан тэр зүйлийг чих тавин сонсогтун. Үнэнхүү, Айлдварын Эзэн тэнгэр, Бүхнийг мэдэгч Надаас өөр Бурхан үгүй. Дарлагдан зовсныг шударга ёсны мутраар аргадаж, Бүхнээс мэргэн Захирангуй Эзэн тэнгэрийнхээ зарлигийн ташуураар дарлан мөлжигчийг шийтгэгтүн.”*

Америк болон бусад газраар аялж явахдаа Абдул-Баха олон ч удаа олон улсын энх тайвны туг далбаа анх удаагаа Америкт мандаасай хэмээн хүсэн мөрөөдөж, мөргөн залбирдгаа илэрхийлсэн юм. 1912 оны 11 дүгээр сарын 5-нд Огайо мужийн Цинциннати хотод Тэрээр хэлэхдээ:

*“Америк бол эрхэм сайхан улс үндэстэн бөгөөд дэлхий ертөнц даяар энх тайвны далбааг өргөгч, энх тайвны гэрэл гэгээг бүх газар нутагт цацагч улс юм. Америкийн Нэгдсэн Улсыг бодвол*



бусад орнууд ийм амгалан тайван, эрх чөлөөтэй биш учраас тэд Даян дэлхийн Энх тайвныг байгуулж чадахгүй юм. Харин Бурханы авралаар Америк орон бүх л ертөнцтэй энх амгалан аж төрж, олон улсын энх тайван ба ах дүүгийн баршдлагааны далбааг мандуулах гавъяатай билээ. Олон улсын энх тайвны дуудлага Америкаас дуулдахад бүх ертөнц даяараа “Тийм ээ, бид зөвшөөрч байна” гэж хэлнэ. Тавь гаруй жилийн өмнө нээгдсэн Бахауллагийн сургаалыг бүх улс орны ард түмнүүд хамтран амьдралд хэрэгжүүлнэ. Өөрийн Илгээлт бичигтээ Тэрээр дэлхийн засгийн газруудыг өөрсдийн хамгийн шилдэг, хамгийн мэргэн цэцэн төлөөлөгчдөө олон улсын Парламентад илгээхийг уриалж, тэд ард түмнүүдийн хооронд гарсан аливаа асуудлыг шийдвэрлэж, энх тайвныг тогтооно гэж Тэрээр айлдсан билээ. Тэр цагт бид Хүн төрөлхтний парламенттай болох бөгөөд үүнийг зөнч мэргэд бүгдээрээ хүсэн мөрөөдөж байсан юм.” “Өрнөдийн Од”, 6-р боть, х. 81

Бахаулла, Абдул-Баха нарын уриалгыг Америкийн Нэгдсэн Улс ихээхэн хэмжээнд хүлээн зөвшөөрсөн бөгөөд дэлхийн аль ч улс оронд Бахайн сургаал ийм ихээр зөвшөөрөгдөж байгаагүй юм. Улс үндэстнүүдийг уриалан олон улсын энх тайвныг тогтоох гэсэн Америкт ногдсон үүргийн өчүүхэн хэсгийг л биелүүлсэн бөгөөд Бахайчууд ирээдүйд ямар үйл явдал болох бол хэмээн хүсэн хүлээж байна.<sup>1</sup>

## Дэлхийн дайн

Бахаулла ч тэр, Абдул-Баха ч тэр олон удаа 1914-1918 оны дэлхийн дайн болох гэж байгааг гайхалтай зөвөөр зөгнөн хэлж байжээ. 1912 оны 10 дугаар сарын 26-нд Калифорни мужийн Сакраменто хотод Абдул-Баха ингэж хэлсэн байна:

“Өнөөдөр Европ тив яг л зэвсгийн агуулах болсон байна. Энэ тив яг л тэсрэх бөмбөгийн хадгалах газар мэт болжээ. Ялангуяа Балканы асуудал дэлхийн өмнө тулгараад байгаа энэ

<sup>1</sup> Энэ нь Дэлхийн 2-р дайнаар бүр ч их нотлогдсон юм.

*үед бөмбөгнүүд мөдхөн дэлбэрч, оч цацраг нь бүх л Европ даяар тархаж магадгүй байна. ”*

Америк, Европоор аялж байхдаа айлдсан олон айлдварууд дотроо Тэрээр дайны тухай анхааруулга өгч байсан байна. 1912 оны 10 дугаар сард мөн л Калифорнид Тэрээр ингэж хэлж байжээ:

*“Үүдэл нээлтийн зургаадугаар бүлэгт дурдсан Армагеддоны тулалдаан мөдхөн болох гэж байна. Нэгхэн оч бүх л Европыг галд дүрэлзүүлж эхлэх хүртэл гэвч хоёр жил байна.*

*“Бүх улс орнуудын нийгмийн байдал намжмал бус, энд ч ажиглагдаж буй мянган жилийн ноёрхлын өмнөх шашны мухардмал байдал зэрэг нь Даниэлийн судар болон Иоаны сударт зөгнөн айлдсанчлан бүх л Европ тивийг асаан дүрэлзүүлэх болно.*

*“1917 он гэхэд хаант засгууд нурж, ертөнц дэлхийг нийгмийн эргэлт донсолгох болно.”* (“Норт Шор Ревью” сонинд Хатагтай Коринн Тругийн өгсөн мэдээллээс, 1914 оны 9 дүгээр сарын 26, Чикаго, АНУ)

Дэлхийн агуу их дайны яг өмнөхөн Тэрээр ингэж хэлж байжээ:

*“Соёлт улс гүрнүүдийн том мөргөлдөөн болох гэж байна. Аймиигтай тэмцэл дайн ойртсон байна. Дэлхий ертөнд хамгийн эмгэнэлт тэмцлийнхээ босгон дээр ирээд байна... Хүчирхэг цэрэг армиуд, сая сая хүмүүс хил хязгаарынхаа дагуу дайчлагдан жагссан байна. Тэд аймиигтай дайнд бэлтгэжээ. Өчүүхэн зөрчил тэднийг аймиигтай мөргөлдөөнд хутгаж, хүн төрөлхтний түүхэнд үзэгдээгүй их галд ертөнц дэлхий дүрэлзэх болно.”* - “Өрнөдийн Од”, 5-р боть, х. 163

### **Дайны дараах нийгмийн гамшиг**

Дэлхий дахинаа шашингүй байдал, атгаг сэжиг үзэл санаа, харанхуй мунхаг, мухар сүсэг газар авч энэ бүхний гарцаагүй үр дагавраар нийгэм бүхэлдээ асар их үймээн самуун, тэмцэл зөрчил, гай гамшигт автана хэмээн Бахаулла, Абдул-Баха хоёр хоёулаа зөгнөн хэлсэн юм. Дэлхийн агуу их дайн бол энэ гай гамшгийн зөвхөн нэг шат нь төдий байсан юм. 1920 оны 1 дүгээр

сард бичсэн нэгэн Илгээлт бичигт Абдул-Баха ингэж бичжээ:

*"Аяа, үнэнийг хайрлагчид аа! Аяа, хүн төрөлхтний шадар зарц нар аа! Та нарын оюун бодол, санаа зоригын анхилуун сайхан үнэр надад хүрмэгц та бүхэнтэй харилцах юмсан хэмээн миний сэтгэл догдлон тэмүүлсэн юм.*

*"Дэлхий ертөнц ямар уй гашуунтай үймээнд өртснийг зүрх сэтгэлдээ тунгааж үзэгтүн. Ертөнцийн улс орнууд хүний цусанд хутгалдаж, тэр ч бүү хэл, хөрс шороо нь цусан овоо болжээ. Дайны гал аймшигтай зэрлэг гамшигийг түйвээж, ийм явдлыг ертөнц анхан үедээ ч, дунд үедээ ч, орчин үедээ ч хэзээ ч үзэж байсангүй. Дайны тээрэм олон хүний толгойг тээрэмдэн бяцалсан, үгүй ээ, дайны золиос болсон хүмүүсийн тавилан үүнээс ч аймаар байлаа. Хөгжин цэцэглэж байсан орнууд эзгүйрэн үгүйрч, хот тосгод газартай нийлж, баян тосгод балгас болон үлджээ. Эцгүүд хүүгээ алдаж, хүү эцгээсээ хагацжээ. Эхчүүд залуусынхаа төлөө цусан нулимсаа асгаруулж, хүүхэд багачууд өнчирч, эмс бүсгүйчүүд гэр оронгүй тэнүүлчлэх заяатай үлджээ. Нэг үгээр хэлбэл, хүн төрөлхтөн бүхий л талаараа доройтон хямарчээ. Өнчин үрсийн уйлаан чанга дуулдаж, эхчүүдийн гашуун орилоон тэнгэрийг ч доргиолоо.*

*Энэ бүх үйл явдлын гол эх сурвалж нь үндэстэн ястан, улс орон, шашин шүтлэг, улс төрийн харъяаллаар ялгаварлан гадуурхдаг атгаг үзэл байсан бөгөөд энэ бүх атгаг үзлийн үндэс нь шашны, үндэстний, улс орны болон улс төрийн угжран илжирсэн хуучны уламжлалууд байсан юм. Эдгээр уламжлал оршоор байсан цагт хүний ертөнцийн үндэс суурь ганхаж, хүн төрөлхтөн өөрөө байнгын зовлон зүдгүүрт орших болно.*

*"Эдүгээ энэхүү гэрэлт эрин зуунд бүх л юмсын мөн чанар тодорч, бүх бодгаль юмсын далд нууц тайлагдаж, үнэн мөнхийн өглөөний туяа ертөнцийн харанхуйг гэрэл гэгээ болгосон энэ үед дэлхий ертөнцийг сэргээж босгошгүй балгас болгох ийм аймшигтай дайн байлдааныг зөвшөөрөх нь зүйд нийцнэ гэж үү? Бурханы нэрээр өчсү! Энэ бол утгагүй хэрэг юм.*

*“Христ бүх хүмүүсийг эвлэрэн нэгдээж, энх тунх амьдрахыг айлдсан. Тэрээр сэлмээ хуйнд нь буцааж хийхийг Питерт хэлсэн. Түүний хүсэл, Түүний зөвлөгөө ийм л байв. Гэвч Түүний нэрийг барьсан тэр хүмүүс фэлмээ сугалан гаргажээ! Евангелийн ариун үг үсэг ба тэдний ажлil үйлсийн хооронд ямар их ялгаа байна вэ!*

*“Жаран жилийн өмнө Бахаулла мандах нарны адилаар Персийн тэнгэрт мандаж, харанхуйн завагт унасан ертөндөд зарлан тунхаглахдаа, энэ харанхуй болбоос гай гамигийг авчирч, аймшигт дайн байлдаанд хөтлөнө гэж анхааруулж байсан билээ. Акка хотод хоригдож байхдаа Тэрээр Германы Хаан эзэнд алдаа мадаггүй үнэн үгээрээ дайн болно, Берлин уй гашиуд автана гэдгийг зөгнөн айлдсан юм. Үүний нэгэн адил Аккагийн цайзанд хоригдсон энэ хэлмэгдсэн хүмүүн Туркийн Султанд анхааруулахдаа, Константинополь асар их үймээн самууны үр дүнд нуран доройтож, эхнэр хүүхдүүд эмгэнэн гашиудан уйлна хэмээн тодорхой үгээр айлдсан юм. Товчоор хэлбэл, Тэрээр дэлхийн бүх томоохон удирдагч хаад нарг захидал илгээж, зөгнөл айлдварыг хэлсэн бөгөөд тэдгээр нь бүгд биелсэн билээ. Алдарын бийрэн дороос нь ирээдүйн үед дайн дажнаас урьдчилан сэргийлэх талаар гайхамшигт сургаал ундарч, хол ойрын нутгуудад түгэн цацагдсан юм.*

*“Түүний анхны сургаал нь үнэнийг эрэлхийлэх тухай сургаал байв. Бусдыг сохроор дуурайх нь хүний сүнснийг устгадаг бол бие даан үнэнийг эрэлхийлэх нь энэ ертөнцийн атгаг сэжгийг харанхуйгаас ангижруулдаг хэмээн айлдсан юм.*

*“Түүний хоёр дах сургаал бол хүн төрөлхтний эв нэгдлийн тухай сургаал байв. Бүх хүмүүс бол нэгэн сүрэг бөгөөд Бурхан болбоос халамжит Малчин нь юм. Тэрээр өөрийн сүрэгт хамгаас агуу энэрэл нигүүлслээ үзүүлж, тэднийгээ нэгэн сүрэг хэмээн тооцдог. “Та нар Бурханы амьтдын дунд ямар ч ялгаа үл гаргана”. Тэд бүгд Түүний шадар зарц нар бөгөөд бүгд Түүний буян хишгээс горьддог.*

*“Түүний гурав дах сургаал бол “шашин бол хамгийн хүчирхэг бат цайз юм” гэсэн сургаал байлаа. Шашин бол эв нэгдлийг авчрах ёстой болохоос биш хүмүүсийн хооронд дайсагнал, үзэн*

ядалтыг үүсгэх ёсгүй билээ. Шашин нь үзэн ядалт, дайсагнах хандлагын эх сурвалж болж байвал ийм шашин байхгүй байсан нь дээр. Учир нь шашин бол яг л анагаагч эм лугаа адил өвчин эмгэгийг эдгээх ёстой тул ийм биш бол шашингүй байсан нь дээр.

“Түүнчлэн, шашин шүтлэг, үндэстэн ястан, улс төрийн харъяаллаар ялгаварлан гадуурхах атгаг үзэл нь бүгд хүний нийгмийн үндэс суурийг ялзруулж, бүгд цус асгаруулалтанд хүргэж, бүгд хүн төрлөхтнийг балгас болгодог юм. Ийм атгаг үзэл оршоор байсан цагт дайны аюул ямагт оршоор байх болно. Цорын ганц анагаагч эм бол Даян дэлхийн энх тайван билээ. Энэ энх тайванд хүрэхийн тулд зайлшгүй дээд Шүүхийг байгуулж, түүнд бүх засгийн газар, бүх улс түмний төлөөлөгчид оролцох ёстой юм. Үндэсний болон олон улсын аливаа асуудлыг энэхүү шүүхээр шийдэж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ёстой. Аль нэгэн засгийн газар, эсвэл ард түмэн үүнийг зөрчих аваас бүгд тэр засгийн газар, ард түмний эсрэг босох ёстой юм.

“Түүний сургаал дотор эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийн сургаал ордог. Энэ болон ижил төстэй бусад сургаалыг Түүний бийрээр нээсэн билээ.

“Өнөө үед эдгээр зарчмууд бол ертөнцийн жинхэнэ амьдрал бөгөөд жинхэнэ сүнснийх нь илэрхийлэл юм гэдэг нь тодорхой илэрхий болжээ. Тиймээс одоо хүн төрөлхтний шадар зарц нар болсон та нар өөрсдийгөө дайчлан, зүрх сэтгэлээрээ дэлхий ертөнцийг материализм, атгаг сээжиг үзлийн харанхуйгаас гаргаж, Бурханы Хотын гэрлээр гэрэлтүүлвээс зохино.

“Та нар ертөнцийн олон янзын сургууль, байгууллага болон зарчмуудтай танилцсанд Түүнд талархал өргөө. Өнөөдөр эдгээр тэнгэрлэг сургаалаас өөр юу ч хүн төрөлхтний энх тайван, амарлингуй амьдралыг хангаж чадахгүй билээ. Эдгээр сургаалыг дагахгүйгээр харанхуй замхрахгүй, хууч өвчин эмгэг ч эдгэхгүй. Үгүй ээ, тэдгээр нь өдрөөс өдөрт улам ч их гаарна. Балканы хойг тайван бус хэвээр үлдэж, нөхцөл байдал нь улам доройтно. Ялагдсан орнууд намжисж тайвшрахгүй, харин дахин дайны галыг дүрэлзүүлэх гэж чадах бүхнээ хийнэ. Орчин үеийн түгээмэл хөдөлгөөнүүд өөрсдийн явцуу сонирхол зорилгоо биелүүлэх гэж

чадлаараа зүтгэнэ. Зүүнтний хөдөлгөөн асар их ач холбогдолтой болж, нөлөөлөл нь дэлгэрнэ.

*“Тиймээс гэрэлтэж гэгээрсэн зүрх сэтгэл, хурмастын сүнс, тэнгэрлэг хүч чадлаар Түүний гоо жавхлангийн дэмжлэгээр олон ертөнцөд Бурханы өгөөмөр буян хишиг, амгалан тайван амьдралын хишигийг бүхий л хүн төрөлхтөнд хүртээгтүн.*

1919 оны 11 дүгээр сард айлдсан айлдвартаа Тэрээр хэлсэн нь:

*“Нэгэн үе шашингүй үзэл, түүнээс үүдэж эмх замбараагүй байдал ноёрхоно хэмээн Бахаулла олон удаа урьдчилан зөгнөж байсан билээ. Хүмүүсийн эрх чөлөө хэтэрч, энэ бүхэнд хүмүүс бэлэн бус байснаас болж эмх замбараагүй байдал үүсч, улмаар хүмүүсийн ашиг сонирхлыг хамгаалах, мөн эмх замбараагүй байдлаас гарахын тулд албадлагын засгийн газрыг байгуулах шаардлага урган гарна. Зарим улс түмнүүд өнөөдөр бие даасан шийдвэр гаргаж, эрх чөлөөтэй үйл ажиллагаатай байхыг эрмэлзэж байгаа боловч тэд үүнд хараахан бэлэн болоогүй байгаа юм. Ертөнцөд ноёрхож буй өнөөгийн байдал бол Бурхангүй хандлага бөгөөд үүний улмаас эмх замбараагүй байдал, төөрөгдөл эндүүрэл үүсэх тавилантай юм. Агуу их дайны дараагаар гаргасан энх тайвныг тогтоох саналууд нь нар мандалт байгаагүй харин дөнгөж үүрийн цолмонгийн бүдэг туяа л байсан юм гэдгийг би олонтаа хэлсэн билээ.”*

## **Бурханы Ханлиг улс залрахуй**

Гэхдээ энэ бүх бэрхшээлтэй цаг үед Бурханы Үйл хэрэг хөгжин цэцэглэх болно Хувь хүний, намын, явцуу бүлэглэлийн эсвэл үндэсний ашиг хонжооны төлөө энэ хувиа хичээсэн тэмцлийн үр дүнд бий болсон гай гамшигийн улмаас хүмүүс сэтгэлийн мухардалд орох бөгөөд тэднийг анагаахын тулд Бурханы Үг хэрэгтэй болно. Гай гамшиг нэмэгдэх тусам хүмүүс цорын ганц үнэн эм рүү харцаа улам ч чиглүүлэх болно. Бахаулла Шагт илгээсэн Илгээлт бичигтээ ингэж хэлсэн юм:



*“Зовлон зүдгүүрийг Бурхан энэхүү ногоон бэлчээрийг ундаалах өглөөний хур, газар дэлхий ба диваажинг гэрэлтүүлэх Түүний Дэнлүүний гол болгосон болгоо... Зовлон зүдгүүрийн ачаар Түүний Гэрэл гэгээ гийж, Түүний Магтуу тасралтгүй тодоор гэрэлтсэн юм. Энэ бол халирч өнгөрсөн цаг үеийн турш Түүний хэрэглэсэн арга барил байсан болой.”*

Бахаулла, Абдул-Баха нар хоёулаа материализмыг оюун санаанлаг чанар удахгүй ялж, Агуу их энх тайван тогтоно гэдгийг маш тодорхойгоор зөгнөн хэлж байсан билээ. Абдул-Баха 1904 онд ингэж айлдаж байв:

*“Зовлон бэрхшээл, азгүй явдал нь өдрөөс өдөрт нэмэгдэж, хүмүүс улам их сэтгэлийн мухардалд орно гэдгийг мэдтүгэй. Баяр баясгалан, аз жаргалын үүд хаалга бүх талаасаа хаагдана. Аймшигт дайн дажин дэгдэнэ. Хүмүүсийг тал бүрээс нь урам хугарах, сэтгэл мухардах явдал хүрээлж, тэд эцсийн эцэст Бурханд хандахаас өөр замгүйд хүрнэ. Тэр цагт агуу их аз жаргалын гэрэл гэгээ тэнгэрийн хаягаар татаж, “Яа Бахаул-Абха!” гэсэн дуудлага бүх зүгт дуурсагдах болно.” (Л.Д.Б-д хандсан захидлаас “Дайн ба Энх ” түүвэрт иш татсан байдал, х. 187)*

1914 оны 2 дугаар сард Түүнээс хэн нэгэн агуу хүн сүсэгтэн болох эсэх тухай лавлахад Тэрээр ингэж хариулжээ:

*“Дэлхийн бүх хүмүүс сүсэгтэн болно. Үйл хэргийн эхэн үеийг өнөөдрийн байдалтай харьцуулах юм бол Бурханы Үг ямар хурдан нөлөөлдгийг чи ойлгох бөгөөд өнөөдөр Бурханы Үйл хэрэг бүх л дэлхийг хамарсан байна шүү дээ... Мэдээжийн хэрэг, бүх хүмүүс Бурханы Үйл хэргийн сүүдэр дор хорогдоно.” - “Өрнөдийн Од”, 9-р боть, х. 31*

Абдул-Баха дэлхийн эв нэгдэл нь энэ зуунд биелнэ хэмээсэн юм. Нэгэн Илгээлт бичигтээ Тэрээр ингэж бичжээ:

*“...Хүн төрөлхтний бүх гишүүд, ард түмнүүд болон засгийн газрууд, хот тосгод, бүгд улам ихээр харилцан хамааралтай болно. Учир нь аль нь ч дангаараа оршиж үл чадна. Улс төрийн холбоо бүх ард түмнүүд, бүх улс орнуудыг холбож байгаа бөгөөд*

худалдаа арилжаа, аж үйлдвэр, газар тариалан, боловсролын холбоо өдрөөс өдөрт бэхжиж байна. Тиймээс хүн төрөлхтний эв нэгдэл энэ эрин үед боломжтой юм. Үнэнхүү энэхүү гайхамшигтай эрин үе, энэхүү цог жавхлагт эрин зууны бас нэгэн гайхамшиг болой. Өнгөрсөн зуунуудад ийм гайхамшиг байгаагүй билээ. Учир нь, энэ зуун бол гэрэл гэгээт зуун бөгөөд хосгүй гайхамшигт алдар, хүч чадал, гэрэл гэгээг өөртөө агуулсан юм. Тиймээс өдрөөс өдөрт шинэ шинэ гайхамшиг нээгдэж байна. Эцэст нь хүмүүсийн энэ чуулганд асаж буй лааны оч гэрлүүд юутай тод вэ гэдгийг хэн бүхэн харна.”

Даниэлийн судрын эцсийн хоёр шад мөрөнд ийм сонин зөгнөлт үгс бий:

“Мянга гурван зуун гучин таван хоногийг хүлээн ирсэн тэр хүмүүн адистай билээ. Харин чи өөрийн замаар явж төгсгөлийг хүр. Учир нь чи амарч, цагийн эцэст өөрийн хувийг хүртэхээр босно.”

Олон ч хичээнгүй эрдэмтэд эдгээр үгсийн утга учрыг тайлах гэж оролдсон билээ. Нэгэн ярицлагын үеэр Абдул-Баха Даниэлийн энэ зөгнөлийг Мухаммедийн эриний эхэн үеэс биелэгдсэн гэж хэлсэн юм. Уг ярилцлагын үеэр зохиогч би өөрөө бас байлцаж байв.

Абдул-Баха Илгээлт бичигтээ тодорхой дурдсанаар энэхүү зөгнөл нь Багдад хотод хийсэн Бахауллагийн тунхаглалын зуун жилийн ойг буюу 1963 оныг зөгнөсөн юм хэмээсэн байдаг.

“Даниэлийн шад мөрийн талаар гэвэл, “Нэг мянга гурван зуун гучин таван хоног хүлээн ирсэн тэр хүмүүн адистай” гэсэн үгийг хэрхэн тайлбарлах вэ гэж та асуужээ. Эдгээр өдрүүдийг билгийн тооллоор биш аргын тооллоор авч үзэх ёстой. Учир нь энэ тооцоогоор бол, Үнэний Наран мандсанаас хойш нэг зуун өнгөрч, тэр цагт Бурханы сургаал энэ дэлхий дээр бат бөх тогтож, Тэнгэрлэг Гэрэл ертөнцийг Өрнөөс Дорно хүртэл гийгүүлэх юм. Тэр өдөр үнэнч сүсэгтнүүд баясан цэнгэнэ!”

## Акка ба Хайфа

Мирза Ахмад Сохраб өөрийн өдрийн тэмдэглэлд 1914 оны 2 дугаар сарын 14-нд Хайфа дах Бахайн мөргөлчдийн нэгэн байрны цонхны хажууд сууж байхдаа Абдул-Бахагийн айлдсан Акка, Хайфа хотуудын тухай дараах зөгнөлийг оруулсан байв:

*“Мөргөлчдийн байрны цонхоор харагдаж байгаа орчин ямар сайхан бэ. Ялангуяа Бахауллагийн Адист бунхан уруу харсан учраас үнэнхүү сайхан харагдаж байна. Ирээдүйд Акка, Хайфа хоёрын хоорондын зай багасч, зам тавигдаж, хоёр хот хоорондоо нийлж, нэгэн том хүчирхэг хотын хоёр зах болно. Энэ орчинг ажиглахад, ирээдүйд энэ нь дэлхийн хамгийн шилдэг худалдааны төв болох юм шиг санагдаж байна. Энэ том хагас дугуйн хэлбэртэй булан хамгийн үзэсгэлэнтэй боомт болон хувирч, бүх улс орноос усан онгоц ирж, энд буудаллах болно. Бүх ард түмнүүдийн том том хөлөг онгоцууд дэлхийн өнцөг булан бүрээс энэ боомтонд ирнэ. Уул толгод, тал хээр нь хамгийн орчин үеийн барилга, орд харшаар дүүрнэ. Аж үйлдвэр хөгжиж, буяны янз бүрийн байгууллагууд байгуулагдана. Бүх улс үндэстний соёл иргэнишл, урлаг соёлын сор цэцэгсийг энд авчирч, анхилуун үнэр нь хоорондоо холилдож, хүн төрөлхтний ах дүүгийн барилдлагааны зам мөрийг гэрэлтүүлнэ. Шөнө болоход их хот цахилгаан гэрэлд умбана. Аккагаас Хайфа хүртэл тэр аяараа гэрэл гэгээтэй болно. Усан онгоцуудыг хамгаалахын тулд Кармел Уулын хоёр талд хүчирхэг том гэрэл байрлуулна. Кармел Уул өөрөө ч бэлээс оргил хүртлээ гэрлийн далайд умбана. Кармел уулын орой дээр зогсож байгаа хүн мөн уулын бэлд ирж буй усан онгоцны зорчигчид дэлхий ертөнцийн хамгийн эрхэмсэг, хамгийн гайхамшигт дүр зургийг харан ширтэнэ.*

*“Уулын өнцөг булан бүрээс “Яа Баха-ул-Абха!” гэсэн аялгуу эгшиглэж, өглөөний эрт нарнаас сэтгэл сэргээгч хөгжмийн аялгуу уянгалаг дуу хоолойг дагалдан Хүчирхэг Бурханы сэнтийд дуурсагдана.*

“Үнэндээ Бурханы зам мөр ямагт далдын ид шидтэй, ойлгохын аргагүй байлаа. Шираз ба Тегеран, Багдад ба Константинополь, Адрианополь ба Акка, Хайфагийн хооронд гадна талаас нь харвал ямар халбоо байна? Бурхан Зөнч мэргэдийн зөгнөн айлдсан айлдвар, зөгнөл бүрийг биелүүлэхийн тулд шат шатаар маш тэвчээртэйгээр ажиллаж, эдгээр хотуудаар аялж, Өөрийн тодорхой бөгөөд мөнхийн төлөвлөгөөг биелүүлсэн юм. Мессиягийн мянган жилийн тухай энэхүү амлалтын алтан хэлхээс нь Библид агуулагдах агаад Бурхан Өөрийн цагийг ирэхэд түүнийг тодруулах учиртай юм. Тэрээр утга учиргүй нэг ч үгийг айлдаагүй ба нэг ч үгийг гээлгүй биелүүлдэг юм.”

## Арван тавдугаар бүлэг

### ӨНГӨРСӨН БА ИРЭЭДҮЙ

*“Аяа, анд ноход! Буян үйлдэж, учир тайлагдаж, нотолгоо бүрдэж, гэрч тогтоогдсоныг Би баталсугай. Энэ дэлхийн хүсэл шуналаас тусгаарлахын замд хичээл зүтгэл чинь хэр зэрэг тодрахыг үзсү. Тэнгэрт болон газар дээр аж төрөгч чамд ч олон бүхэнд ч Бурханы аврал ийнхүү төгс бүрдвэй. Орчлонгийн эзэн Бурханаа олон бүгдээр маг тиму”*  
- Бахаулла. “Эрдэнийн Нуугдмал Үгс”

#### Үйл хэргийн хөгжил дэвшил

Харамсалтай нь ийм бага зайнд Бахай Шүтлэг дэлхий даяар хэрхэн хөгжин дэвшиж байгаа тухай дэлгэрэнгүй бичье гэвэл боломжгүй юм. Энэ сонирхолтой сэдвээр олон бүлэг ном бичиж болох агаад Үйл хэргийг дэлгэрүүлж явсан пионерүүд болон амь бие золиослогсдын талаар үй түмэн онгод хайрлах түүх домгийг өгүүлж болох авч маш товч тоймыг энд толилуулъя. Перс оронд энэ шүтлэгийн анхны дагалдагчид харгис ширүүн эсэргүүцэлтэй тулгарч, эх орон нэгтнүүдийнхээ гарт хэрцүгийгээр хяагдан хавчигдаж байсан боловч тэд бүхий л зовлон зүдгүүрийг туйлын их эр зориг, хатуу үнэнч сэтгэл, гэсвэр хатуужилтайгаар угтаж авч байсан юм. Тэд өөрсдийн цусаар загалмайлагдсан байсан гэж хэлж болох бөгөөд олон мянган сүсэгтнүүд амь үрэгдэж, олон мянгыг нь шорон гянданд хорьж, зодож жанчиж, эд хөрөнгийг нь булааж, төрөлх нутгаас нь хөөж, элдэв муухайгаар доромжилдог байжээ. Жар гаруй жилийн турш Баб, Бахаулла нарын дагалдагч болохыг хүссэн хүмүүс өөрсдийн эд хөрөнгө, эрх чөлөө, бүр амьдралаа ч алдах аюултай байжээ. Гэвч ийм эрс шийдэмгий эсэргүүцэл нь уг Шүтлэгийн хөгжил дэвшлийг сааруулах гэж оролдсон нь нар мандахыг атга шороо зогсоож чаддаггүйтэй адил байжээ.

Персийн нэг өнцгөөс нөгөө өнцөгт хот тосгон бүрт Бахай Шүтлэгтнийг олж болох байсан агаад бүр нүүдэлчин түмний

дунд ч сүсэгтнүүд байжээ.<sup>1</sup> Зарим тосгоныхон хүн амаараа Бахай байсан агаад зарим газруудад оршин суугчдын ихэнх нь сүсэгтэн байв. Хоорондоо хөндий хүйтэн, дайсагнагч олон янзын цашин шүтлэг, урсгалаас гаралтай сүсэгтнүүд одоо ах дүүгийн барилдлагаанд орж, эвсэг найрсаг хамтран аж төрж эхлэсэн бөгөөд зөвхөн өөр хоорондоо ч биш бас бусад хүмүүстэй ийм харьцаатай болж, бүгд хүн төрөлхтний нэгдэл ба хөгжлийн төлөө, элдэв төрлийн атгаг сэжиг үзэл, тэмцэл зөрчлийг арилгахын төлөө, ертөнц дээр Бурханы Ханлиг улсыг тогтоохын төлөө ажил хөдөлмөрөө зориулж ирсэн юм.

Үүнээс илүү гайхамшигтай ид шид гэж байх уу даа. Тэр ид шид нь юу вэ гэвэл, эдгээр хүмүүс бүх л дэлхий даяар өөрсдийнхөө өмнө тавьсан зорилгоо биелүүлсэн явдал юм. Энэ гайхамшигтай ид шид улам хөгжин дэвшиж байгаагийн шинж тэмдэг элбэг байна. Энэ Шүтлэг эдүгээ гайхалтай их амьдрах чадварыг илтгэж байгаа агаад улам тархах тусам хүмүүс болон нийгмийг хувьсган өөрчилж байна.

Бусадэртний шашнуудын дагалдагч нарын тоотой харьцуулбал Бахайчуудын тоо харьцангуй цөөн байгаа ч тэд удахгүй Өрнө, Дорнын олон түмэнд Шинэ эмх журмыг тогтоож өгөхөд үйлчлэх агуу их завшааныг тэнгэрлэг Хүчнээс олж авсандаа итгэл дүүрэн байгаа юм.

Эх сурвалжийг нь олж мэдээгүй байгаа ч сэтгэл зүрхээр ариун хүмүүст Ариун Сүнс нөлөөлж, Бахай бус орчинд ч хүмүүс өөрсдөө үл мэдэн Бахаулагийн аль нэгэн сургаалыг хэрэгжүүлж,

---

<sup>1</sup> Бахаулла тэнгэрт хальсан онд буюу 1892 онд хэвлүүлсэн “Перс ба персийн асуудал” гэсэн номондоо Лорд Курзон ингэж бичжээ: “Хамгийн багаар тооцоход өнөөдөр Перет хагас сая Бабчууд байна. Би сайн мэдэх хүмүүстэй энэ асуудлаар ярилцсаны эцэст бараг нэг сая бабчууд би гэж таамаглаж байна. Тэднийг хааны орны сайд түшмэдүүдээс авахуулаад гудамжны цэвэрлэгч, зарц хүртэл нийгмийн бүх анги давхарга дотроос олж болно. Тэр ч бүү хэл Исламын лам санваартан нарын хүрээнд ч үр нөлөөтэй ажээ. Хэрэв Бабын хөдөлгөөн өнөөгийнхөө хурдаар өсөн нэмэгдсээр байвал Перс орноос Исламын шашныг түлхэн гаргах цаг үе ч ирж болох юм. Хэрэв Бабын хөдөлгөөн ямар нэгэн дайсагнагч шашин шүтлэгийн далбаан дор байсан бол ингэж дэлгэрэхгүй байсан гэж би бодож байна. Түүний эгнээнд эсрэг талынх нь хамгийн шилдэг дайчид элсэн орж байгаа учраас эцсийн эцэст энэ хөдөлгөөн ялан дийлнэ гэсэн дүгнэлт гаргах үндэслэл байгаа юм.”

Өнөөгийн тоо баримтаар дэлхий дээр эдүгээ 11 сая шахам Бахай Шүтлэгтэн амьдарч байна.



хүчин чармайлт гаргаж байгаа нь харагдаж байна. Гэвч хуучин эмх журмын үндэс суурь ганхсан явдал нь Бурханы Ханлиг улсын үзэл санаа зөвхөн Бахайн нийгэмлэгийн хүрээнд үр өгөөжөө өгч чадах юм гэдгийг илэрхий харуулж байна.

### **Баб, Бахаулла нарын мэргэн айлдвар**

Бид Баб, Бахаулла нарын амьдрал сургаалыг хэдий чинээ илүү судлах тусам төдий чинээ тэдний агуу чанарын шалтгаан нь Тэнгэрлэг Онгод байсан юм гэдгийг ойлгох болно. Тэд шашны фанатик (мухар сүсэг), үл эвлэрэнгүй үзлийн дунд өсөн бойжсон. Тэд зөвхөн наад захын анхан шатны боловсролыг олсон байсан. Тэд өрнөдийн соёлтой ямар ч харьцаагүй байлаа. Ямар ч улс төрийн эсвэл санхүүгийн хүч чадал тэдэнд байгаагүй. Тэд хүмүүсээс юуг ч гуйгаагүй, хүмүүсийн зүгээс гагцхүү шударга бус явдал, хяхалт хавчилтыг л амсаж байлаа. Ертөнцийн эрдэмтэн мэргэд тэднийг эсэргүүцэн хавчдаг байлаа. Тэд тамлагдан тарчилж, хоригдон, өөрсдийн ариун үүргийг биелүүлэхийн тулд гай гамшгийг туулах тавилантай байв. Тэд энэ ертөнцөд ганцаараа байсан бөгөөд Бурханаас өөр туслагч тэдэнд байсангүй, гэсэн ч тэдний ялалт илэрхий бөгөөд гайхамшигтай билээ. Тэдний эрхэм дээд, тэнгэрлэг үзэл санаа, тэдний эрхэмсэг буянт шинж чанар, өөрийгөө огоорсон, амьдралаа огоорсон сэтгэл, няцашгүй эр зориг, итгэл үнэмшил, гайхалтай мэргэн цэцэн ухаан мэдлэг, Өрнө, Дорнын хүмүүсийн шаардлага хэрэгцээг сайн мэдэрдэг байсан мэдлэг, сургаалынх нь бүрэн дүүрэн, нийцтэй өргөн чанар, дагалдагчдынхаа чин сэтгэлийн бишрэл, оргилуун тэмүүллийг өдөөх хүч чадал, нөлөөлийнх нь нэвтлэх хүч, үндэслэн байгуулсан Шүтлэгийнх нь хөгжил дэвшил - энэ бүгд нь тэдний Зөнч мэргэн увдисыг шашны түүхэнд нотолж байна.

### **Гэрэлт ирээдүй**

Бахайн баярт мэдээнд Бурханы Буян хишиг нээгдэж, хүн төрөлхтний ирээдүйн хөгжил дэвшил харагддаг бөгөөд энэ болбоос хүн төрөлхтөнд өгөгдсөн хамгийн агуу бөгөөд хамгийн

гайхамшигтай Үүдэл нээлт юм. Энэ Үүдэл нээлт нь өмнөх Үүдэл нээлтүүдийг цааш нь хөгжүүлэн хэрэгжүүлж байгаа юм. Түүний зорилго нь хүн төрөлхтний дахин амьдруулах “шинэ диваажин ба шинэ ертөнц”-ийг бүтээх явдал юм. Энэ нь Христ болон бусад Зөнч мэргэдийн амь амьдралаа зориулсан ариун үүрэгтэй ижил юм. Эдгээр Агуу багш нарын хооронд ямар ч өрсөлдөөн үгүй билээ. Энэ үүрэг нь энэ тэр гэх юмгүй бүх Тодруулагч нарын чармайлтаар биелэгдэх ёстой юм.

Абдул-Бахагийн хэлснээр:

*“Абрахамыг доошлуулж, Есүсийг дээшлүүлэх шаардлагагүй. Есүсийг доошлуулж, Бахаулаг өргөмжлөх шаардлагагүй. Хаанаас ч олж харсан хамаагүй бид Бурханы Үнэнийг л хүлээн авах ёстой юм. Эл асуудлын мөн чанар болбоос эдгээр агуу Элч нар бүгдээрээ Төгс төгөлдөрийн Тэнгэрлэг Далбааг өргөсөн явдал юм. Тэд бүгдээрээ Тэнгэрлэг Хүсэл тааллын Нэг л тэнгэрт гийжэ буй одод лугаа адил билээ. Тэд бүгд энэ ертөндөд Гэрэл авчрагчид юм.”* “Өрнөдийн Од”, 3-р боть, 8-р хэсэг, х.8

Энэ үүрэг болбоос Бурханых, Бурхан зөвхөн Зөнч мэргэдийг дуудаад зогсохгүй мөн бүх хүн төрөлхтнийг энэхүү бүтээлч үйл явцад Өөртэй нь хамт ажиллаасай гэж хүсч байгаа юм. Хэрэв Бид Түүний урилгыг хүлээн авах юм бол уг ажилд саад үл учирна. Учир нь, Бурханы хүссэн бүхэн биелнэ. Хэрэв бид үүргээ биелүүлж чадахгүй бол Тэрээр бидний оронд өөр хүмүүсийг олж, зорилгоо биелүүлэхдээ л биелүүлнэ. Гэвч бид жинхэнэ зорилгоо алдаж, амьдралынхаа тэмүүллээс хагацана. Бурхангай нэгдэх, Түүнийг хайрлагч байж, Түүний шадар зарц байж, Түүний Бүтээлч хүчийг дамжуулагч суваг байж, гагцхүү Түүний тэнгэрлэг бөгөөд арвин их амьдралаас өөр ямар ч амьдралыг ухамсартаа үл багтаах явдал бол үнэнхүү Бахайн сургаалд айлдсанчлан хүний оршин тогтнолын унтаршгүй, гайхамшигт зорилго болой.

Хүн төрөлхтөн гэвч зүрх сэтгэлээр цэвэр ариун байх ёстой. Учир нь Бурхан хүнийг “өөрийн дүр төрхөөр” бүтээсэн бөгөөд зүрх сэтгэл үнэнийг олж хармагц мунхаг тэнэгийн замаар замнахаа болино. Удахгүй Бурханы дуудлага нийт хүмүүн төрөлхтний дунд хүлээн зөвшөөрөгдөж, хүн төрөлхтөн нийтээрээ

үнэн зөв замдаа орж, Бурханы өмнө хүлцэнгүй болно хэмээн Бахауллагч батлан хэлж байна. “Уй гашуу баяр баясгалан болж, овчин эмгэг анаагаагдан эдгэх” агаад энэ орчлонгийн аймгууд “Эзэн тэнгэрийн ба Христийн Ханлиг улс болох бөгөөд Тэрээр үүрдийн үүрд захирна” (Рев., 11:15)

Зөвхөн дэлхийн оршин суугчид ч биш, харин тэнгэр диваажин ба газар дэлхий дээр орших бүхэн Бурханы дор нэг нэгдмэл болж, Түүнд мөнхийн мөнхөд талархах болно.

### **Шашин шинэчлэгдэх нь**

Өнөөгийн ертөнцийн байдлыг харвал, бүх шашны хүмүүс өөрсдийн шашны жинхэнэ утга учрыг шинээр тайлах хэрэгтэй байна. Чухамдаа ийнхүү шинээр утга учрыг нээж, шинээр сэргээхэд л Бахауллагчийн ариун үүрэг оршино. Христчүүдийг сайн Христчүүд болгож, Мусульманчуудыг сайн Мусульманчууд болгож, бүх хүмүүсийг Зөнч мэргэдийнхээ авчирсан тэрхүү сүнсэнд үнэнч болгохоор Тэрээр ирсэн билээ. Тэрээр мөн “сайн цагийн эхэнд” гайхамшигт Тодруулагч тодорч, ажил үйлсийг нь гүйцээн дуусгана хэмээн амласан тэрхүү Зөнч мэргэдийн өгсөн амлалтыг биелүүлсэн билээ. Тэрээр түүнчлэн өмнөх Элч нарын нээсэн оюун санааны үнэн сургаалыг илүү дүүрэн нээж, өнөөгийн ертөнцөд тулгарч буй хувь хүний болон нийгмийн амьдралын бэрхшээлт асуудлуудын талаар Бурханы Хүсэл тааллыг нээж өгсөн билээ. Тэрээр ирээдүйн шинэ соёл иргэншлийн үндэс суурийг тавих даян дэлхийн сургаалыг авчирч, уг сургаалаа эдүгээ эхлэсэн шинэ эрин үед ертөнцийн шаардлага хэрэгцээнд тохируулсан юм.

### **Шинэ Үүдэл нээлт байхын шаардлага**

Хүн төрөлхтнийг нэгтгэх, дэлхийн олон шашнуудыг эвлэрүүлж, шашин ба шинжлэх ухаан хоёрыг уялдуулж, даян дэлхийн энх тайвныг тогтоож, Олон улсын шүүх, Даян

Дэлхийн Шударга Ёсны Ордон, олон улсын туслах хэлийг бий болгох, эмэгтэйчүүдийг хөгжүүлэх, бүх нийтийн боловсролыг дэлгэрүүлэх, хүнийг боочлох ёс төдийгүй аж үйлдвэрийн боолчлолыг халах, хүн төрөлхтнийг нэгэн цогц мэтээр зохион байгуулж, хувь хүн бүрийн эрх, эрх чөлөөг сахин хамгаалах - энэ бүхэн нь асар их ач холбогдолтой хийгээд биелүүлэхэд туйлын хүнд хэцүү асуудлууд юм. Үеэс үед Христчүүд, Мусульманчууд болон бусад шашны дагалдагч нар энэ талаар хамгийн янз янзын, заримдаа эсрэг тэсрэг үзэл бодолтой байсан юм. Гэвч Бахаулла сургаал зарчмыг маш тодорхой ойлгомжтойгоор туурвисан бөгөөд эдгээр сургаалыг хүн төрөлхтөн нийтээрээ хүлээн зөвшөөрснөөр энэ ертөнцийг диваажин болгож чадна.

### **Бүх нийтэд зориулсан үнэн**

Олон хүн Бахайн сургаалыг Перс юм уу Дорно зүгийн хүн ардын хувьд гайхамшигтай сургаал байж болох юм гэж хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа хэдий ч Өрнөдийн улс түмнүүдэд ийм сургаал шаардлагагүй, тохиромжгүй гэж төсөөлдөг ажээ. Ийм үзэл бодлыг илэрхийлсэн цөөн хэдэн хүнд Абдул-Баха ингэж хариулжээ:

*“Бахауллагийн Үйл хэргийн утга санааны хувьд гэвэл, даян дэлхийн сайн сайхны төлөө юм бүхэн болбоос тэнгэрлэг, харин тэнгэрлэг юм бүхэн болбоос даян дэлхийн сайн сайхны төлөө байдаг. Хэрэв энэ үнэн бол бүх нийтэд зориулагдсан гэсэн үг. Хэрэв үгүй бол хэнд ч хэрэггүй. Тиймээс даян дэлхийн сайн сайхны төлөөх тэнгэрлэг эх сурвалж бол Дорно ч юм уу Өрнө зүгээр хязгаарлагдах ёсгүй, учир нь Үнэний Нарны цацраг туяа Дорныг ч тэр, өрнийг ч тэр адилхан гэрэлтүүлдэг агаад өөрийн илч дулааныг өмнө зүгт ч тэр, хойд зүгт ч тэр цацдаг. Хоёр туйлын хооронд ялгаа үгүй юм. Христийн үед Ром, Грекийн хүмүүс бодохдоо Христийн Үйл хэрэг зөвхөн Иудейчүүдэд тохирно гэж боддог байжээ. Тэд өөрсдийнхөө соёл иргэншлийг төгс төгөлдөр*

хэмээн үзэж, Христийн сургаал тэдэнд хэрэггүй гэж бодож байсан учраас Түүний Гоо жавхлангаас хүртэж чадаагүй юм. Үүний нэгэн адил Христийн зарчмууд болон Бхаауллагийн Зарлиг сургаалууд нь адил төстэй бөгөөд зам мөр нь ч адил гэдгийг мэдтүгэй. Өдөр бүр хөгжил дэвшил гарна. Нэгэн үе энэхүү тэнгэрлэг байгууллага нь үр хөврөлийнхөө шатанд байсан, дараа шинээр төрж, хүүхэд болж, идэр залуу болж, харин өнөөдөр гоо жавхлангаараа гэрэлтэн, туйлын тод цацрагаа цацруулж байна.

“Далд нууцад нэвтрэн, ертөнцийн гэгээрсэн хүмүүсийн дунд байр эзлэх тэр хүмүүн аз жаргалтай.”

### Абдул-Бахагийн Хүсэл зориг ба Гэрээслэл

Хайрт удирдагч Абдул-Бахагаас хагацсан Бахай Шүтлэг түүхийнхээ шинэ үе шатанд дэвшин оржээ. Энэхүү шинэ үе шатанд орсноор оюун санааны бие бие махбод нь улам дээд түвшинд хүрч, гишүүд нь сүсэг бишрэлээ илүү ухамсартай, илүү хариуцлагатай өндөр түвшинд илэрхийлэх болсон юм. Абдул-Баха Өөрийн хязгааргүй их хүч чадлыг, Бахауллад зориулсан хайраа Өрнө, Дорно дахинаа түгээхэд зарцуулсан билээ. Тэрээр тоо тоймшгүй хүмүүсийн зүрх сэтгэлд итгэл бишрэлийн дөлийг асааж өгсөн юм. Тэрээр тэдэнд оюун санааны амьдралын шинж чанаруудыг эзэмшүүлж, удирдан чиглүүлсэн юм. Абдул-Бахагийн “Хүсэл зориг ба Гэрээслэл”-ийн чухал ач холбогдлыг харуулж, түүний заалтуудын мэргэн ухаан, ба хөндөж тавьсан асуудлуудын чухлыг ойлгуулах үүднээс цөөн хэдэн ишлэлийг толилуулбал Абдул-Бахагийн амьдруулан чиглүүлсэн үзэл санаа болон тэргүүн зарчмууд, түүнчлэн Түүний үнэнч дагалдагч нарт шилжин очсон арвин баялаг өвийг тод томруунаар дүрслэн үзүүлэх болов уу.

“Эзэн тэнгэрийн хайрт шавь нар минь ээ! Энэхүү ариун Эрин үед тэмцэл зөрчлийг огтхон ч үл зөвшөөрмүй. Харгислагч бүр Бурханы гоо жавхлангаас өөрийгөө дутааж буй хэрэг. Хүн бүр туйлын их хайр, чиг шулуун зан төрх, шулуун шударга байдал болон анд нөхөд ч бай, үл таних хүмүүс ч бай, дэлхий ертөнцийн

бүх хүн ардад зориулсан эелдэг чин сэтгэлийг үзүүлвээс зохино. Үл таних хүн анд нөхөр болж, дайсан байсан хүн жинхэнэ ах дүү нь болж, тэдний хооронд ямар ч зөрчил оршихгүй болтол тэдний хайр, энэрлийн үзэл санаа тийм хүчтэй байх ёстой. 1

“Учир нь, бүх нийтийн чанар бол Бурханых, харин бүхий л хязгаарлагдмал чанар бол газар дэлхийнх юм.”

“Тиймээс, миний хайрт анд нар минь ээ! Сайн санааг өвөрлөн дэлхийн бүх ард түмэн, улс үндэстэн болон шашнуудтай туйлын шударга, чигшүлүүн, үнэнч, энэрэнгүй, нөхөрсөгөөр найрамдагтун. Улмаар бүх дэлхий ертөнц Баха-н гоо жавхлангийн ариун баяр жаргалгаар дүүрч, харанхуй мунхаг байдал, дайсагнал, үзэн ядалт болон өс хорсол арилж, хүмүүс, ард түмнүүдийн хоородын хүйтэн хөндий харьцааны харанхуй Эв нэгдлийн Гэрэл гэгээгээр солигдоно. Бусад хүмүүс, улс үндэстнүүд та нарт үнэнч бус хандваас та нар тэдэнд үнэнч сэтгэлийг үзүүл, хэрэв тэд та нарт шударга бус хандваас, та нар тэдэнд шударга ёсыг харуул, хэрэв тэд та нараас хөндийрвөл та нар тэднийг өөрсдөдөө тат. Хэрэв тэд та нарт дайсагнавал харин та нар тэдэнд нөхөрсөгөөр ханд, хэрэв тэд та нарын амьдралыг хордуулвал та нар тэдний сэтгэлийг баясга, хэрэв тэд та нарт шарх учруулбал та нар тэдний шархыг анагаах тан бологтун. Үнэнч сэтгэлтний шинж чанарууд нь ийм бөлгөө! Шударга үнэнч хүмүүний шинж чанарууд нь ийм бөлгөө.”

“Эзэн тэнгэрийн хайрт шавь нар минь ээ! Та нар шударга үнэнч хаадад захирагдаж, үнэнч буянтай хаан бүрт үнэнчээр хандваас зохилтой. Дэлхий ертөнцийн тэргүүдэд туйлын үнэнч шударга байдлаар үйлчлэгтүн. Тэдэнд захирагдаж, тэдэнд сайныг ерөөж яв. Тэдний зөвшөөрөл адисгүйгээр улс төрийн асуудалд бүү оролцогтун. Учир нь, шударга тэргүүн хаад нартаа үнэнч бусаар хандах нь Бурханд үнэнч бусаар хандахтай адил болой. Энэ бол миний зөвлөгөө богөөд та нарт өгсөн Бурханы зарлиг болой. Үүнийг даган мөрдөх тэр хүмүүн сайн болой.”

“Эзэн тэнгэр минь! Орчлонгийн бүх бодгаль юмс намайг өрөвдөн уйлж, харин миний төрөл нэгт ахан дүүс миний гай зовлонд баясан цэнгээж буйг Та харж байгаа билээ. Таны алдрыг



барья, Бурхан минь! Миний дайснуудын дотор ч зарим нь миний уй гашиуу, гай зовлонг өрөвдөн гасалж, надад атаархдаг хүмүүсийн дотор ч зарим нь миний зовлон зүдгүүр, цөллөгийн бэрх хүндийг өрөвдөж нулимсаа асгаруулсан билээ. Учир нь тэд миний дотор хайр ивээл, халамжит сэтгэлээс өөр зүйлийг олж хараагүй, миний энэрэл нигүүлсэл, эелдэг зөөлөн сэтгэлээс өөр юуг ч гэрчилж үзээгүй болой. Зовлон зүдгүүр, гай гамшигийн үерт намайг автаж, хувь тавилангийн сум над руу онилсон байхыг тэд хараад зүрх сэтгэл нь уйран хайлж, нүдэнд нь нулимс хурж, тэд тийнхүү "Эзэн тэнгэр бидний гэрч. Бид түүнээс үнэнч шударга, өгөөмөр, туйлын энэрэнгүй сэтгэлээс өөр юуг ч олж үзсэнгүй" гэж гэрчлэн зарласан юм. Муу санааны биет шлэрхийлэл болсон Гэрээс зөрчигчид харгис бурангуй явдалдаа улам ширүүсч, тэдний хамгийн аймшигтай сорштонд намайг золиос болон унахад баярлаж, миний эсрэг тэмцэж, намайг хүрээлсэн сэтгэл шимширмээр үйл явдлыг хараад баярлан жаргасан юм."

"Бурхан тэнгэр минь, тэдний харгис хэрцгий санаа, алдас нүгэл, муу муухай гэмт үйлдлийг нь бүү шийтгээч хэмээн би бүхий л зүрх сэтгэл, хэл амаараа Танаас хичээнгүйлэн гуйж байна. Учир нь, тэд мунхаг тэнэг учраас юу хийж буйгаа үл мэднэ. Тэд сайныг муугаас, зөвийг буруугаас, шударгыг шударга бусаас ялган салгаж үл мэднэ. Бурхан минь! Тэд өөрсдийн шунал хүслийг дагаж, хамгийн төгс бус, мунхаг тэнэгүүдийн алхаа гишгээнд уруу татагджээ. Эзэн тэнгэр минь! Тэднийг энэрэн өршөөж, энэхүү цэвүүн цаг үед бүхий л зовлон зүдгүүрээс тэднийг хамгаалж, харин бүх сорилт шалгуур, бэрх хэцүүг энэхүү харанхуй нүхэнд унасан Өөрийн энэ зарцдаа ноогдуулж хайрла. Гай зовлонг гагцхүү надад л дайруулж, хайрт шавь нарын төлөө намайг золиосонд ав! Эрхэм дээд Эзэн тэнгэр минь! Миний сүнс сэтгэл, миний амьдрал, миний бие, миний оюун санаа тэдний төлөө золиос болог! Бурхан минь, Бурхан минь! Намайг гомдоон зовоосон хэн бүхнийг өршөөж, миний эсрэг хуйвалдаж, намайг хохироох гэж тэмцсэн тэр хүнийг уучилж, надад шударга бусыг үйлдсэн тэдгээр хүмүүсийн нүгэл гэмийг ариусгахыг бүхий л сэтгэл зүрхээрээ би Таны өмнө хүлцэнгүйгээр сөгдөн хичээнгүйлэн

гуйя. Тэдэнд Өөрийн буян хишгээ хайрла. Тэдэнд баяр баясгаланг хайрлаж, уй гашуугаас чөлөөлж, энх тунх, элбэг хангалуун амьдралыг хайрла. Тэдэнд Өөрийн хишгийг хүртээж, Өөрийн буяныг тэдэнд өгөгтүн. Та болбоос Хүчирхэг, Гоо жавхланта, Зовлонд нэрвэгсдийн аврал, Дангаар оршигч билээ.” “Христийн шавь нар өөрсдийгөө болон газар дэлхийн зүйлсийг мартаж, эд хөрөнгө эзэмшил бүхнээ орхиж, “би” үзэл ба дур хүслээс өөрсдийгөө чөлөөлж, туйлын ангижран чөлөөлөгдсөн сэтгэлээр хол ойр аялж, ертөнцийн улс түмнүүдэд Тэнгэрлэг Удирдамжийг дагахыг уриалж, эцэст нь ертөнцийг шинэ ертөнц болгож, газар дэлхийн хөрсийг гэгээрүүлж, Бурханы тэрхүү Хайрт Шавийн зам мөрд эцсийн мөч хүртэл өөрсдийгөө золиослосон билээ. Эцэст нь тэд янз янзын харийн нутагт гайхамшигтайгаар амь үрэгдэж, амь биеэ золиослосон юм. Ажил үйлсээ эрхэмлэгч хүмүүн бүр тэдний алхаа гишгээг дагаг.”

“Бурхан минь, Бурхан минь! Таны хайрт шавь нар Таны Шүтлэгийг халамжлан хамгаалж, Таны чиг шулуун Замыг сахин өмгөөлж, Таны гайхамшигт Хуулийг даган мөрдөөсэй гэсэндээ би Таны нотолгоог дуустал тэдэнд зарлан тунхаглаж, бүх л зүйлсийг тодорхой захиж үлдээсэн гэдгийн гэрч болохыг Танаас, Таны Зөнч мэргэдээс, Таны Элч нараас, Таны Гэгээнтэн Ариун сүнснүүдээс хүсэн залбирч байна. Та болбоос үнэнхүү Бүхнийг мэдэгч, Бүхнээс мэргэн ухаантаан билээ!”

Абдул-Баха тэнгэрт хальсны дараа ирээдүйд байгуулагдах Бахауллагийн Дэлхийн Эмх журмын хэв загвар, үндэс суурь нь болох засаг захиргааны журмыг байгуулах цаг ирсэн билээ. Абдул-Бахагийн “Хүсэл зориг ба Гэрээслэл” нь Бахайн түүхэнд эргэлтийн чанартай байсан бөгөөд хараахан бүрэлдэн тогтоогүй балчир үеэс мултарч, Бахайчууд өөрсдийн оюун санаанлаг увдисыг хувь хүний туршлагыг нийгмийн эв нэгдэл, хамтын ажиллагааны талбарт шилжүүлэн хүрээг өргөтгөхөд хэрэгжүүлэх тавилантай тэр эрин үеийг нь нээж өгсөн юм. Бахай Шүтлэгийн засаг захиргааны журмыг хөгжүүлэх талаар Абдул-Бахагийн үлдээсэн төлөвлөгөөний гурван гол элементүүд нь:

1. “Бурханы Үйл хэргийн Асран тэтгэгч”

2. “Бурханы Үйл хэргийн Мутарууд”
3. “Орон нутгийн, Үндэсний, олон улсын Оюун Санааны Чуулгууд) юм.

### Бурханы Үйл хэргийн Асран тэтгэгч

Абдул-Баха өөрийн ууган зээ хүү Шоги Эффендиг “Үйл хэргийн Асран тэтгэгч” (Валие-Амрулла)-ээр томилсон юм. Шоги Эффенди бол Абдул-Бахагийн ууган охин Джаян Ханумын ууган хүү байсан юм. Түүний эцэг Мирза Хади нь Бабын төрөл садны хүн байсан ажээ. (Бабын ганц хүү нялхдаа нас барсан учраас шууд удам нь биш ч төрөл садны нь хүн). Шоги Эффенди өвөг эцгийгээ нас барахад хорин таван настай байсан ба Оксфордын Баллиолын дээд сургуульд суралцаж байв. Абдул-Баха түүнийг залгамжлагчаараа томилсон тухайгаа Гэрээслэлдээ ингэж бичжээ:

*“Миний хайрт анд нөхөд өө! Энэхүү хэлмэгдсэн хүмүүн насан өөд болсны дараа Ариун Модны Мөчрүүд (Баб, Бахаулла нарын төрөл садан), Бурханы Үйл хэргийн Мутарууд болон Абха-н Гоо жавхангийн хайрт шавь нар бүгд Хоёр Ариун модноос (Баб, Бахаулла нар) мөчирлөн төрсөн залуу Мөчир болон Ариун Гэгээн Модны хоёр салбар ишний дундаас ургасан үр жимс болох Шоги Эффендид хандаас зохино. Учир нь, Тэрээр Бурханы Шинж тэмдэг, Сонгомол Мөчир, Бурханы Үйл хэргийн Асран тэтгэгч бөгөөд бүхий л Мөчирүүд, Бурханы Үйл хэргийн мутарууд ба Түүний хайрт шавь нар түүн рүү л хандах ёстой. Тэрээр Бурханы Үг сургаалыг тайлбарлагч бөгөөд түүнээс түүний удмын анхны хүн төрөх болно.*

*“Энэхүү ариун залуу Мөчир, Бурханы Үйл хэргийн Асран тэтгэгч болон бүх нийтийн сонгуулиар сонгогдон байгуулагдах Даян Дэлхийн Шударга Ёсны Ордон нар нь хоёулаа Абха-н Гоо жавхангийн халамж хамгаалалтан дор орших бөгөөд Түүний Ариун гэгээн Өргөмжит Элчийн алдаа мадаггүй удирдамж нөмөр дор орших болно. Энэ хоёрын төлөө миний амьдрал золиос болог! Тэдний шийдсэн юу боловч Бурханы шийдвэр болой...”*

*“Эзэн тэнгэрийн хайрт шавь нар минь ээ! Бурханы Үйл хэргийн Асран тэтгэгч амьд сэрүүн байх үедээ ирээдүйд маргаан зөрчил гарахаас сэргийлэн өөрийн залгамжлагчийг томилвоос зохино. Томилогдсон тэр хүмүүн энэ ертөнцийн бүхий л юмсаас ангижирч, ариун нандин чанарын илэрхийлэл болж, Бурханаас эмгэх сэтгэлийг өөртөө шингээж, эрдэм мэдлэг, мэргэн ухааныг үзүүлэх ёстой. Тийнхүү Бурханы Үйл хэргийн Асран тэтгэгчээс төрсөн ууган хүмүүн “Тэр хүүхэд болбоос эцгийнхээ нуугдмал мөн чанар болой” гэсэн үгийн үнэний илэрхийлэл болж үл чадваас, тэрээр түүнд орших оюун санааны баялгийг үл өвлөж авбаас, түүний гайхамшигт удмын цус сайн чанарын булнтай үл нийцэх аваас Үйл хэргийн Асран тэтгэгч өөрийгөө залгамжлуулах өөр нэгэн Мөчрийг сонговоос зохино.*

*“Бурханы Үйл хэргийн Мутарууд өөрсдийнхөө дундаас есөн гишүүнийг сонгож, тэд Бурханы Үйл хэргийн Асран Тэтгэгчийн амин чухал ажилд бүхий л цаг үед оролцох ёстой юм. Эдгээр есөн хүнийг сонгохдоо санал нэгтгэйгээр, эсвэл олонхын саналаар Бурханы Үйл хэргийн Мутаруудын дундаас сонгох бөгөөд тэдгээр нь санал нэгтгэйгээр эсвэл олонхын саналаар Бурханы Үйл хэргийн Асран тэтгэгчийн залгамжлагчаар томилсон тэр хүмүүний сонголтонд өөрсдийн зөвшөөрлийг өгөх ёстой юм. Уг зөвшөөрлийг олгохдоо хичнээн нь дэмжсэн, хичнээн нь дэмжээгүй дуу хоолой гаргасныг мэдэгдэх ёсгүй юм.” - “Абдул-Бахагийн Хүсэл зориг ба Гэрээслэл” х10,11,12*

### **“Бурханы Үйл хэргийн Мутарууд”**

Бахаулла амьд сэрүүн байх үедээ цөөн хэдэн үнэнч сүсэгтэнд Шүтлэгийн үйл ажлыг удирдан чиглүүлэх үүрэгтэйгээр “Аяади-и-Амрулла” (“Бурханы Үйл хэргийн Мутар”) гэсэн цол хайрлажээ. Абдул-Баха Өөрийн гэрээслэлд Үйл хэргийн Асран тэтгэгчийн ажилд тусалж, Үйл хэрэгт үйлчлэх байнгын тушаалтай хүмүүсийг томиллох талаар заасан байдаг. Тэрээр ингэж бичжээ:

*“Анд нөхөд минь! Бурханы Үйл хэргийн Мутаруудын нэрийг дэвшүүлж, Бурханы Үйл хэргийн Асран тэтгэгчээс*

*тэднийг томилвоос зохино... Бурханы Үйл хэргийн Мутаруудын үүрэг нь Тэнгэрлэг анхилуун үнэрийг цацах, хүмүүсийн сэтгэл зүрхийг сурган хүмүүжүүлж... бүхий л цаг үед, ямар ч нөхцөлд газар дэлхийн зүйлсээс ангижран чөлөөлөгдсөн, ариуссан байх ёстой явдал юм. Тэд өөрсдийн зан төрх байдалд, өөрсдийн ажил үйлсээр Бурханаас эмээх буяныг илэрхийлж явах ёстой.*

*“Бурханы Үйл хэргийн Мутаруудын байгууллага нь Бурханы Үйл хэргийн Асран тэтгэгчийн удирдлага дор ажиллах ёстой. Тэрээр Бурханы анхилуун үнэрийг цацаж, дэлхий ертөнцийн хүн ардуудыг удирдан чиглүүлэхийн тулд чадах бүхнээ хийж чармайн ажиллахыг Тэрээр тэдэнд байнга уриалж байх ёстой. Учир нь, энэ болбоос бүхий л орчлон хорвоог гэгээрүүлэх Тэнгэрлэг Удирдамжийн гэрэл гэгээ юм.”<sup>1</sup> “Абдул-Бахагийн Хүсэл зориг ба Гэрээслэл” х13*

## **Засаг захиргааны журам<sup>2</sup>**

Өнөөг хүртэл ямар ч шашныг Үндэслэгч Өөрийн Шүтлэгийн засаг захиргааны байгууламжийг удирдан залах зарчмуудыг бүрэн дүүрэн, тодорхой байдлаар тогтоож өгөөгүй юм. Бахайн Үйл хэрэгт Бахаулла дэлхийн засаг захиргааны зарчмуудыг тогтоон танилцуулсныг Абдул-Баха Өөрийн “Хүсэл зориг ба Гэрээслэл”-д улам дэлгэрүүлэн хөгжүүлсэн билээ.

Энэхүү байгууллагын зорилго нь янз бүрийн улс үндэстэн, анги давхарга, ашиг сонирхол, зан чанар, уламжлалт итгэл үнэмшилтэй хүмүүсийн дунд жинхэнэ, бат бөх эв нэгдлийг бий болгоход оршино. Бахай Шүтлэгийн энэхүү онцлог талыг нягтлан судалж үзвэл Бахайн засаг захиргааны журмын зорилго, арга барил нь бие махбод нь сүнстэй хэрхэн холбоотой байдаг

1 Шогн Эффендигээс томилсон Үйл Хэргийн Мутаруудаас түүнийг 1957 онд насан өөд болох үед 27 нь амьд сэрүүн байв. Тэрээр 1954 онд Үйл Хэргийн Мутаруудын ажилд туслан зөвлөх Туслах Зөвлөлийг байгуулсан билээ. “Төгсгөлийн үг” –ийг харна уу.

2 Засаг захиргааны журмын тухай энэ хэсгийг 1933 онд “Бахайн ертөнц номын 5-р ботид Хорас Холлейн бичсэн “Бахайн Шүтлэгийн засаг захиргааны журмын өнөөгийн байдал” нэртэй нийтлэлээс авав.

яг л тийм холбоонд энэхүү Үүдэл нээлтийн үндсэн үзэл санаатай холбоотой байдаг нь харагдана. Үнэн хэрэгтээ Бахайн засаг захиргааны зарчмууд нь хамтын ажиллагааны ухааныг төлөөлөн илэрхийлж, энэхүү ухаан нь бодитоор хэрэгжсэнээр дэлхий дахинаа ёс суртахууны шинэ бөгөөд илүү дээд түвшний хэв маягийг тогтоож байгаа юм...

Бахайн нийгэмлэгийн бусад сайн дурын цуглаан цугларалтуудаас ялгаатай тал нь гэвэл, түүний үндэс суурь нь туйлын гүн бөгөөд өргөн хүрээнд тавигдсан учраас чин сэтгэлтэй хүн бүрийг багтаан оруулах чадалтай юм. Бусад холбоо нийгэмлэгүүд үзэл санаандаа биш юм аа гэхэд бодит амьдрал дээрээ явцуу байдаг бол Бахайн нийгэмлэг нь үзэл санаандаа ч тэр, арга барилдаа ч тэр нээлттэй бөгөөд хэний ч өмнө эв нөхөрлөлийнхөө үүд хаалгыг хаадаггүй юм. Аливаа цуглаан холбоонд хүнийг сонгон элсүүлэх ил буюу далд ямар нэгэн бодлого байдаг. Жишээлбэл, шашинд хүн түүхэн уламжлалдаа баригдсан сүсэг бишрэлийн хэмжээ их тусмаа илүү татагддаг. Улс төрд нам индэрийн харъяаллаас энэ нь хамаардаг. Эдийн засгийн хүрээнд хамтдаа азгүйдэх, хамтдаа амжилтанд хүрэхээс шалтгаална. Соёл, шинжлэх ухаанд тусгай сургууль, тусгай үйл ажиллагаа эсвэл сонирхолтойгоос хамааран ялгаа гардаг. Энэ бүх салбарт сонгон элсүүлэх хүрээ хэдий чинээ явцуу байна, төдий чинээ хөдөлгөөн нь хүчирхэгждэг. Харин энэ зарчим нь Бахай Үйл хэрэгт огт эсрэг байдаг. Тиймээс уг сургаал нь дагалдагчдынхаа тоо хэмжээний хувьд харьцангуй удаан түгэн дэлгэрдэг. Учир нь хүмүүс бүхий л ажилдаа явцуу, тусгаарлагдмал байдалд дасан зохицсон байдагтай холбоотой юм. Ийм тусгаарлагдмал байдлыг баталгаажуулан зөвтгөдөг зарчмууд байдаг. Бахай Шүтлэгт нэгдэн орно гэдэг бол ийм зарчмуудыг ардаа орхино гэсэн үг. Энэ нь эхэндээ тийм ч амаргүй бөгөөд тухайн хүн сорилт бэрхшээлийг гарцаагүй давах шаардлагатай болдог. Учир нь хүний хувиа хичээсэн чанар ямагт бүх нийтийн хайрын дээд зарчмын эсрэг байдаг. Эрдэмтэн мэргэд эгэл жирийн боловсролгүй хүмүүстэй хамт байж, баячууд ядуустай, цагаан арьстнууд өнгөт арьстнуудтай, далдын хүчийг шүтэгч хүн догматик (ягшмал үзэлтэй) хүнтэй, Иудейн шашинтан



Христийн шашинтан хүнтэй, Мусульман хүн Перс хүнтэй мөр зэрэгцэн хуучны тогтсон уламжлал, эрх ямбаасаа татгалзах шаардлагатай болдог.

Гэвч эхэн үедээ нилээн хэцүү мэт санагдавч жинхэнэ хэрэгтээ энэ нь тухайн хүнд гайхалтай буян болдог. Урлаг соёл нийт нийгмээсээ хөндийрөх тусам үр бүтээлгүй болдог, философийн ухаан ганцаарчлан тусгаарлах тусам эрхэм зорилгоо алддаг, улс төр ба шашин хүн төрөлхтний нийт шаардлага хэрэгцээнээс хэзээ ч хөндийрч чаддаггүй гэдгийг санацгаая. Хүний мөн чанар хараахан тайлагдаагүй байна. Учир нь бид сэтгэл санаа, ёс суртахуун, нийгмийн хувьд явцуурхаж ирсэн бөгөөд ингэж явцуурхах нь эцсийн эцэстээ тусгаарлагдахын нэр юм. Харин Бурханы хайр бол айдас түгшүүрийг арилгадаг бөгөөд айдас түгшүүр арилснаар нуугдмал хүч чадал нээгдэж, оюун санааны хайраа бусадтай хуваалцах нь энэхүү хүчийг эерэг байдлаар хэрэгжүүлдэг. Бахайн нийгэмлэг бол энэ эрин үед энэхүү үйл явц идэвхтэй явагдах цуглаан юм. Эхэндээ үйл явц удаан байх боловч шинэ эрч хүчээ авах тусмаа түргэн хөгжиж, гишүүд нь хүмүүсийн эв нэгдлийн цэцэг дэлгэрэхэд ямар их хүч чадал дэлхийд нээгддэгийг улам ойлгон ухамсарлах болно...

Бахай Шүтлэгийн орон нутаг дах үйл ажиллагааг хариуцан хянах ажлыг Оюун Санааны Чуулга хийж гүйцэтгэнэ. Энэ байгууллага (есөн гишүүнтэй) жил бүрийн 4-р сарын 21-ний өдөр буюу Ризваны анхны өдөр (Бахауллагийн Тунхаглалыг тэмдэглэх өдөр) нийгэмлэгийн насанд хүрсэн нийт сүсэгтэн дундаас сонгогддог. Сонгуулийн эрх бүхий хүмүүсийн нэрсийн жагсаалтыг улирч буй Оюун Санааны Чуулгаас гаргадаг. Энэхүү байгууллагын онцлог шинж чанар, үүрэг хариуцлагын талаар Абдул-Баха ингэж хэлжээ:

*"Юм бүхнийг эмх замбараатай, зохион байгуулалттай болгохын тулд хүн бүр Оюун Санааны Чуулгатай зөвлөлдөлдөггүйгээр ямар ч алхам хийх ёсгүй бөгөөд Чуулгын зарлиг сургаалыг зүрх сэтгэлээсээ даган мөрдөж, хүлцэнгүй байх ёстой. Чингэх үл аваас хүн болгон бие даан дураараа үйл ажиллагаа явуулж,*

зөвхөн өөрийн дүгнэлт хүслийг даган, улмаар Бурханы үйл хэрэгт харшлах болно.”

“Хамтаар мөрдөх нь зүйтэй нэн чухал шаардлага нь юу вэ гэвэл: цэвэр ариун бодол санааг барин, оюун санаагаар тугяран гэрэлтэх, Бурханаас бусад зүйлийг огоорон, Түүний Тэнгэрлэг хишгийг хүртэхийг тэмүүлэх, Бурханы шавь нарын дунд даруу хүлцэнгүй байх, хүнд бэрхшээлтэй үед тэсвэр тэвчээр гарган, Хурмастын Босгоны өмнө өөрийгөө зориулан зүтгэх сэтгэлээр дүүрэн байх явдал юм. Эдгээр чанаруудыг Бурханы ивээлээр хүртээж чадваас үл үзэгдэгч Баха-н Тэнгэрээс ялалт амжилт тэднийг хүрээлнэ. Энэ өдөр зөвлөлдөх Чуулгууд маш агуу ач холбогдолтой бөгөөд шаардлагатай байгууллагууд юм. Тэдэнд захирагдан дагах нь нэн чухал агаад зайлиггүй биелүүлэх үүрэг мөн. Тиймээс гишүүд нь ямар ч зорчил, үл итгэлцэл гаргахгүй байх тийм санаагаар хамтдаа зөвлөлдөх хэрэгтэй юм. Үүнийг биелүүлэхийн тулд гишүүн бүр өөрийн бодол санааг чөлөөтэй шлэрхийлж, өөрийн учир баримтыг шлэн далангүй дэвшүүлэх хэрэгтэй. Хэн нэгэн нь түүний бодлыг эсэргүүцэх аваас үүнд гомдон эмзэглэх хэрэггүй байдаг. Учир нь, тухайн асуудлаар бүрэн дүүрэн зөвлөлдөж дууссан цагт л үнэн зөв зам олдох учиртай. Үнэний гэрэлт цог зөвхөн өөр өөр үзэл бодлын мөргөлдөөнд үүсэн асч бадамлана. Хэлэлцүүлгийн эцэст санал нэгтгэйгээр шийдвэр гарвал сайн. Харин, Бурхан өршөөг, бодол санаа зөрөлдөхөд хүрвэл олонхын санал бүхнийг шийдэх ёстой.

“Нэгдүгээр нөхцөл нь юу вэ гэвэл, Чуулгын нийт гишүүд нь өөрсдийгөө нэгэн цэцэрлэгийн цэцэгс, нэгэн модны мөчрүүд, нэгэн нарны цацраг, нэгэн тэнгэрийн одод, нэгэн голын ус, нэгэн далайн давалгаа, нэгэн Бурханы шавь нар болохын тулд нэг нэгнээсээ хөндийрөх байдлаас бүрэн чөлөөлөгдөж, Бурханы нэгдэлд нягтран батэжж, туйлын хайр ивээл, нийцсэн сэтгэлийг барих явдал мөн. Нийцтэй сэтгээж, нэгдмэл байж чадахгүй бол цуглаан задарч, Чуулга нь юунд ч хүрч үл чадна “Хоёрдугаар нөхцөл нь юу вэ гэвэл, хуран чуулах цаг үедээ Хурмастын оронд сүсэглэн хандаж, Алдарын диваажингаас энэрэл ивээлийг хүсэх явдал юм... Хэлэлцүүлэг зөвлөлдөөндөө гагцхүү дэлхийн

*бүх анги давхарга, бүх улс түмний хүмүүсийн сэтгэлийг сурган хүмүүжүүлэх, хүүхэд багачуудыг сургах, ядуусыг тэтгэх, ядарсан зовсонд туслах, Бурханы анхилуун үнэрийг цацаж, Түүний Ариун Үг айлдварыг өргөмжлөхөд хамаатай оюун сүсгийн асуудлаар зөвлөлдөх ёстой. Ийм л нөхцөл болзлыг чармайн хичээж чадваас, Ариун Сүнсний гоо жавхлан тэднийг болгоон соёрхож, Чуулга нь Тэнгэрлэг өршөөлийн төв болон дэвшиж, Тэнгэрийн ивгээл сүр хүчээрээ тэдэнд туслан, Оюун санааны шинэ оргилт, ундрагыг өдрөөс өдөрт хүртээж байх болно.” - “Бахайн Үүдэл нээлт” х.305-306*

Эл сэдвийг Шогн Эффенди улам дэлгэрүүлэн ингэж бичжээ:

*“Аливаа хувь сүсэгтэн анд нөхөр нь аливаа асуудлыг өөрийн орон нутаг дах Оюун Санааны Чуулгаас бүрэн батлуулан зөвшөөрүүлэхээс нааш олон нийтэд юуг ч танилцуулан дэвшүүлэх ёсгүй билээ. Хэрэв уг асуудал нь тус орон дах Үйл хэргийн ерөнхий ашиг сонирхлыг хөндөж байх аваас Оюун Санааны Чуулга уг асуудлыг орон нутгийн бүх Чуулгуудыг төлөөлж буй Үндэсний Зөвлөлд танилцуулан батлуулваас зохино. Ном хэвлэн нийтлүүлэх асуудал төдийгүй тухайн орон нутаг дах Үйл хэргийн ашиг сонирхлыг хөндөж буй бусад бүх асуудлыг тусад нь болон хамтад нь тухайн орон нутаг дах Оюун Санааны Чуулгад дэвшүүлвээс зохилтой. Оюун Санааны Чуулга уг асуудлаар шийдвэр гаргах бөгөөд уг асуудал нь үндэсний шинэ чанартай байх аваас түүнийг Бахайн Үндэсний Чуулгад дэвшүүлвээс зохино. Үндэсний зөвлөл ялгаагүй тухайн асуудал орон нутгийн байна уу, үндэсний чанартай байна уу гэдгээс үл хамааран эцсийн шийдвэрийг гаргана. (Үндэсний чанартай асуудал гэдэг нь улс төрийн шинэ чанартай асуудлыг хэлж байгаа биш харин тухайн улс орон дах анд нөхдийн сүсэг бишрэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлнэ, учир нь дэлхий дахинаа буй Бурханы анд нөхөд улс төрийн асуудалд ямар ч байдлаар оролцох хориотой юм).*

*Гэхдээ олон Чуулгууд хоорондын болон гишүүд хоорондын, ялангуяа Чуулга ба Үндэсний Чуулга хоёрын хоорондын эвсэл зохицолдоо, хамтын ажиллагаа нь туйлын чухал ач холбогдолтой билээ. Учир нь Бурханы Үйл хэргийн эв нэгдэл, анд нөхдийн*

найрамдал, Бурханы хайрт шавь нарын сүсэг бишрэлийн оюун санааны үйл ажиллагаа түргэн шуурхай, үр ашигтай байх нь үүнээс л шалтгаална.

“Орон нутгийн болон Үндэсний Чуулгууд нь өнөөдөр ирээдүйд бат бөх байгуулагдах Даян Дэлхийн Шударга Ёсны Ордонь хувьд тулах түшиг тулгуур нь болох юм. Эдгээр байгууллагууд маань эрч хүчтэй, эвсэг найрамдалтайгаар ажиллахаас нааш энэхүү шилжилтийн үеийн итгэл найдвар биелэхгүйд хүрнэ... Бурханы Үйл хэргийн гол түлхүүр болбоос дарангуйлах эрх мэдэл биш харин даруу төлөв нөхөрлөл, захирах хүч биш харин илэн далангүй, хайр ивээлт зөвлөлдөөн юм гэдгийг ямагт санаж яв. Гагцхүү жинхэнэ Бахайн сүнс сэтгэл л чухамдаа нэг талаас энэрэл нигүүлсэл ба шударга ёс, эрх чөлөө ба хүлцэнгүй байдал, хувь хүний халдашгүй эрх ба захирагдах ёс, анхаарал сэрэмжтэй, мэргэн цэцэн, ухаалаг хашир ухааныг, нөгөө талаас эв нөхөрлөл, чин сэтгэл ба эр зоригийг хослуулан хэрэгжүүлж чадах юм.”...

Тухайн орны Орон Нутгийн Оюун Санааны Чуулгууд нь Үндэсний Оюун Санааны Чуулга хэмээх бас л есөн гишүүний бүрэлдэхүүнтэй сонгогддог байгууллагаар дамжин хоорондоо уялдаатай ажилладаг юм. Уг есөн гишүүнийг жил бүр газар зүйн бүс нутаг бүрт явуулсан Анхан шатны чуулганаас сонгогдсон төлөөлөгчдийн саналаар сонгодог юм... Уг төлөөлөгчдөөс бүрэлдсэн Үндэсний Чуулган нь тэнцүү хуваарилах зарчмаар байгуулагдсан сонгуульт байгууллага юм... Ийм Үндэсний Чуулганыг ихэвчлэн Ризваны үеэр буюу Бахауллагийн Тунхаглалыг тэмдэглэдэг өдрүүдэд, 4-р сарын 21-нээс эхлэн арван хоёр хоногийн дотор зохион явуулдаг. Тухайн төлөөлөгчийг улирч буй Үндэсний Оюун Санааны Чуулгаас батлан оролцуулна.

Үндэсний Чуулган бол хувь сүсэгтний хувьд Бахайн үйл ажиллагааны талаар мэдлэгээ гүнзгийрүүлж, өнгөрсөн жилд орон нутаг ба үндэсний түвшинд хийгдсэн ажлын тайлангаа бусадтай хуваалцах үйл явдал билээ... Бахайн төлөөлөгчийн үүрэг зөвхөн Үндэсний Чуулганд оролцож, Үндэсний Оюун Санааны Чуулгын гишүүдийг сонгосноор хязгаарлагддаггүй. Төлөөлөгчид хамтдаа хуран цугласан хойно зөвлөлдөх байгууллага болдог агаад түүний

санал зөвлөмжийг дөнгөж сонгогдсон Үндэсний Оюун Санааны Чуулгын гишүүд сайтар анхааран үздэг юм...

Орон Нутгийн Оюун Санааны Чуулгууд болон нийт сүсэгтнүүдтэй Үндэсний Оюун Санааны Чуулгын харилцах харилцааг Үйл хэргийн Асран тэтгэгчийн захидалд ингэж тодорхойлжээ:

*"Үндэсний Чуулгуудыг байгуулах тухайд гэвэл, нөхцөл байдлын хувьд зохистой, мөн анд нөхдийн тоо хэмжээ өсвөж зохих төвшинд хүрсэн бол улс орон бүрт тэр даруй тус орны анд нөхдийг төлөөлсөн Үндэсний Оюун Санааны Чуулгыг байгуулах нь туйлын чухал юм.*

*"Түүний нэн тэргүүний зорилт нь өөр дотроо үе үе зөвлөлдөн хуралдсанаар анд нөхдийн болон орон нутгийн Чуулгуудын олон талт үйл ажиллагааг эрчимжүүлэх, нэгтгэн зохицуулж, Ариун Газартай байнгын нягт холбоотой байснаар арга хэмжээг санаачилж, тухайн улс орон дах Үйл хэргийн ажил хэргийг удирдан чиглүүлэхэд оршино.*

*"Түүний бас нэгэн амин чухал зорилго болбоос Үндэсний Оюун Санааны Чуулга цагийн эрхээр яваандаа Үндэсний Шударга Ёсны Ордон (Абдул-Бахагийн "Тэрээслэл"-д "Хоёрдогч Шударга Ёсны Ордон" гэж нэрлэгдсэн) гэж нэрлэгдэх болтлоо хөгжин "Тэрээслэл"-д тодорхой заасны дагуу дэлхий дахин дах бусад Үндэсний Чуулгуудын хамтаар дэлхий ертөнц даяар Шүтлэгийн үйл хэргийг удирдан чиглүүлж, зохион байгуулан нэгтгэх Дээд Зөвлөл болох Олон улсын буюу Даян Дэлхийн Шударга Ёсны Ордоньг шууд сонгох явдал юм.*

*"Энэхүү Үндэсний Оюун Санааны Чуулга нь Даян Дэлхийн Шударга Ёсны Ордон байгуулагдах хүртэл жил бүр сонгогдон бүх орон нутаг дах Чуулгуудыг удирдаж, анд нөхдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, Бурханы Үйл хэргийг хашир ухаанаар хамгаалж, Шүтлэгийн ерөнхий ажил хэргийг хянан зохицуулах асар их үүрэг хариуцлагатай юм.*

*"Тухайн оронд Үйл хэргийн ашиг сонирхлыг хөндсөн амин чухал асуудлаар, жишээлбэл орчуулга хэвлэлийн асуудал,*

*Маширкул-Аскар, сургаал дэлгэрүүлэх болон бусад үндэсний чанартай асуудлаар шийдвэр гаргах нь Үндэсний Чуулгын эрх үүрэгт багтах юм.*

*“Эдгээр асуудал бүрийг Үндэсний Оюун Санааны Чуулга ... орон нутгийн Чуулгуудын адилаар тусгай хороонд даалгаж, уг хороодын гишүүдийг тухайн орны анд нөхдийн дундаас сонгох юм. Эдгээр хороод нь орон нутгийн хороод орон нутгийн Чуулгынхаа өмнө ямар үүрэгтэйн адил Үндэсний Оюун Санааны Чуулгын өмнө бас адил үүргийг хүлээнэ.*

*“Уг хороо нь түүнчлэн тухайн асуудал орон нутгийн чанартай байгаа эсэх, тиймээс орон нутгийн Чуулгаас шийдэгдэх, эсвэл тус хорооны хүрээнд шийдэгдэж, хорооноос тусгай анхаарал хандуулах шаардлагагай эсэхийг тодорхойлох ёстой.*

*“Бид бүхнийг хайрлан үйлчилдэг Үйл хэргийн ашиг сонирхлын үүднээс Чуулганы төлөөлөгчдийн саналаар шинээр сонгогдсон Үндэсний Чуулгын гишүүдийн зайлшгүй биелүүлэх үүрэг нь хуран цугласан толоолөгчдийн зөвлөгөө, санаа бодол, чин сэтгэлийн хүслийг тус бүрдээ болон хамтдаа талархан хүлээн авч, туйлын анхааралтай харгалзан үзэх явдал билээ. Далд нууцлаг, хөндий хүйтэн, захиргаадан тушаах хандлагын ул мөрийг өөрсдийн дотроос таягдан хаяж, өөрсдийг нь сонгосон төлөөлөгчдийн өмнө өөрсдийн төлөвлөгөө, итгэл найдвар, санал хүслээ илэн далангүй бөгөөд дэлгэрэнгүй байдлаар танилцуулваас зохино. Тэд ирэх жилд анхааран зохицуулах олон талын асуудлаа төлөөлөгчдөд танилцуулж, төлөөлөгчдийн санаа бодол, дүгнэлт зөвлөмжийг тайван ухамсартай байдлаар судлан дүгнэх ёстой. Шинээр сонгогдсон Үндэсний Чуулга нь Чуулганы хэдэн өдрийн турш болон төлөөлөгчид тарсны дараа ч ойлголт ухамсрыг дэмжснэ, санал бодлын солилцоог хөхүүлж, итгэлийг гүнзгийрүүлэх арга замыг эрэн хайхын зэрэгцээ нийтийн хүсэл зоригт үйлчилж, нийтийн сайн сайхныг хөгжүүлэн дэвшүүлэх хүсэл санаагаа илт байдлаар илэрхийлвээс зохино.*

*Гэхдээ Чуулганы хуралдааныг байн байн, удаан хугацаагаар явуулах боломжгүйг харгалзан үзэж, Үндэсний Оюун Санааны*



Чуулга нь Үйл хэрэг ашиг сонирхлыг хөндсөн аливаа асуудлыг эцсийн шийдвэр гаргах эрхээ өөртөө хадгалан үлдээх юм. Жишээлбэл, аль нэгэн орон нутгийн Чуулга Үйл хэргийг хөгжүүлэх зарчмуудын дагуу ажиллаж байгаа эсэх талаар эцсийн шийдвэрийг гаргана”...

Жил бүрийн орон нутгийн Бахайн сонгуулийг явуулахад сонгуулийн эрх бүхий хүмүүсийн жагсаалтыг гаргах талаар гэвэл: энэ үүрэг нь Орон Нутгийн Оюун Санааны Чуулга бүрт ногдох бөгөөд энэ талаар Асран тэтгэгч дараах удирдамжийг өгчээ:

“...Өнөөгийн нөхцөл байдалд тохируулан маш товчхон хэлбэл, тухайн хүн жинхэнэ сүсэгтэн мөн бишийг тодорхойлох асуудалд анхаарах хамгийн чухал зүйл нь болбоос: Бахай Шүтлэгийн Зарч, Үндэслэгч ба Жинхэнэ Үлгэр дууриалын байр суурийг “Абдул-Бахагийн Хүсэл зориг ба Гэрээслэл”-д заасны дагуу бүрэн хүлээн зөвшөөрч, тэдний Бийрээр туурвигдсан айлдвар бүхнийг чин сэтгэлээс хүлээн авч захирагдан, бидний Хайртын ариун Гэрээслэлийн зүйл заалт бүрт үнэнч тууштай байх, мөн Бахайн өнөөгийн засаг захиргааны үзэл санаа хийгээд хэлбэртэй нягт холбогдох явдал юм. Эдгээр нь ийм амин чухал шийдвэрт хүрэхийн өмнө шударгаар, ухаалгаар, бодолтойгоор анхааран үзэх нэн тэргүүний чухал асуудлууд юм.” “Бахайн засаг захиргааны зарчмууд” х.5

Бахайн байгууллагыг цааш нь хөгжүүлэх талаар Абдул-Баха заавар удирдамжаа үлдээсэн билээ. Үүнд:

“Одоо хамаг сайны эх үүсвэр бөгөөд алдаа мэдгээс эрх чөлөөтэй гэж Бурханаас заяагдсан Шударга Ёсны Ордон хувьд гэвэл, түүнийг бүх нийтийн оролцоотойгоор, өөрөөр хэлбэл, сүсэгтэн нараас сонгох ёстой юм. Түүний гишүүд нь Бурханаас эмээх буян, эрдэм мэдлэг, ухаарлын эх булгийн шэрхийлэл байх ёстой бөгөөд Бурханы шүтлэгт хатуу үнэнч, нийт хүмүүн төрөлхтөнд сайн сайхныг ерөөгч байх ёстой юм. Ордон гэдэг нь Даян Дэлхийн Шударга Ёсны Ордонг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, улс орон бүрт хоёрдогч Шударга Ёсны Ордонууд байгуулагдах ёстой бөгөөд эдгээр хоёрдогч Шударга Ёсны Ордонууд Даян Дэлхийн Шударга Ёсны Ордон гишүүдийг сонгох

ёстой.

“Энэ байгууллага бүхий л асуудлыг шийднэ. Уг байгууллага нь Ариун Сургаалд тодорхой заагаагүй аливаа асуудлаар бүхий л зарлиг, журмыг гаргах эрхтэй. Уг байгууллагын ачаар бүхий л бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх бөгөөд Бурханы Үйл хэргийн Асран тэтгэгч нь түүний тэргүүн бөгөөд бүх насаараа хүндэт гишүүн нь байх ёстой. Хэрэв тэрээр түүний хуралдаанд биеэр оролцож үл чадвал өөрийнхөө өмнөөс хэн нэгнийг томилбоос зохино... Шударга Ёсны Ордон хууль тогтоож, харин Засгийн газар хуулийг хэрэгжүүлнэ. Хууль тогтоогч байгууллага нь гүйцэтгэх байгууллагыг томилж, гүйцэтгэх байгууллага нь хууль тогтоогч байгууллагаа дэмжин ажиллах ёстой бөгөөд энэ хоёр хүчний ойр дотно холбоо нэгдлээр шударга ёсны үндэс суурь бэхжин хүчирхэгжиж, ертөнцийн бүх нутгууд Диваажин шиг болмой.

“Хамгаас Ариун Судар”-т хүн бүхэн хандах ёстой бөгөөд, түүнд заагдаагүй аливаа асуудлаар Даян Дэлхийн Шударга Ёсны Ордонд хандваас зохино. Энэхүү байгууллага санал нэгтэйгээр, эсвэл олонхын саналаар гаргасан аливаа шийдвэр нь үнэн бөгөөд Бурханы зорилго болой. Түүнээс холдсон хэн боловч тэмцэл маргаанд дурлагч муу санаатан бөгөөд Гэрээсийн Эзэн тэнгэрээс холдсон болой.”- “Абдул-Бахагийн Хүсэл зориг ба Гэрээслэл ” x15,16,17,18

Өнөө үед дэлхийн бүх өнцөг булан бүрийн Бахайчууд тогтмол захидал харилцаа хөтөлж, айлчлан зочлох замаар бие биетэйгээ байнгын, ойр дотнын харилцаатай байдаг билээ. Янз янзын улс үндэстэн, шашны уламжлалтай хүмүүсийн ингэж харилцаатай байгаа нь хагарал бутралыг үүсгэгч атгаг сэжиг үзэл болон түүхэн улиг болсон хүчин зүйлүүдийн ачааг Бахауллагийн тогтоосон нэг нэгдмэл амьдралын үзэл санаагаар ялан дийлж болно гэдгийг нотлон харуулж байна.

## Бахауллагийн Дэлхийн Эмх Журам

Энэхүү Эмх журмын талаар Шоги Эффенди 1929 оны 2-р сараас хойш Бахайчуудад удаа дараа хандан бичсэн захидлууддаа илүү дэлгэрүүлэн тайлбарласан юм. Үүнд:

“Өнөө үед давамгайлж буй үзэл бодол, тогтворгүй хэв загварыг эс тоож, өнөөдрийн соёл иргэншлийн явцгүй онол, ганхсан байгууллагуудаас тэдгээрийн эвдэрхий нуранги дээр сүндэрлэн босох тавилантай Бурханаас заяасан байгууллагууд эрс ялгаатай нь илрэх ёстой гэдгийг урьд өмнөхөөс ч илүү ухамсарлаасай хэмээн би Шүтлэгийн сүсэгтнүүдээс хүсэж байна...

“Учир нь, Бахаулла ... хүн төрөлхтөнд зөвхөн шинэ сэргээгч Хүчийг өгөөгүй, зөвхөн агуу их хүч чадал, утга санааг өөргөө агуулсан бүх нийтийг хамарсан тодорхой хэдэн нийгмийн зарчим, гүн ухааны тодорхой сургаалуудыг бий болгоод зогсоогүй гэдгийг бид ухамсарлах ёстой. Өнгөрсөн үеийн Сургаал номлолоос ялгаатай нь гэвэл, Тэрээр мөн Хууль зарлигийн цогцолборыг тодорхойлон, нэгд нэгэнгүй нарийвчлан үүсгэн байгуулж, бодит байгууллага байгууламжуудыг байгуулж, Тэнгэрлэг Эдийн засгийн амин чухал шаардлага хэрэгцээг хангаж өгсөн билээ. Эдгээр нь ирээдүйн нийгмийн хэв загвар, Нэн Агуу Энх Тайваныг тогтоох зэмсэг, дэлхий ертөнцийг нэгтгэх байгууллага болон газар дэлхий дээрх үнэн зөв журам, шударга ёсны ордын тунхаглал болох тавилантай юм...

“Христийн Эрин, Мухаммедын Эрин болон өнгөрсөн үеийн бусад Эрин үеийн номлолоос ялгаатай нь гэвэл, хаана ч ажиллаж хөдөлмөрлөж байсан, ямар ч оронд амьдарч байсан Бахауллагийн шавь нарт үүрэг даалгавраа биелүүлэхэд шарадлагатай, тод тодорхой, онч мэргэн хэлээр бичигдсэн бүхий л хууль, журам, зарчим, байгууллагууд, удирдамж нь буй юм... Чухам үүнд л Бахайн Үүдэл нээлтийн өвөрмөц онцгой шинж чанар оршино. Чухам үүнд л Шүтлэгийн эв нэгдэл, өмнөх Үүдэл нээлтүүдийг басамжлан устгах гэсэн ямар ч санаагүй, харин тэднийг холбон

нэгтгэж, зорилгыг нь биелүүлэх эрмэлзэлтэй энэхүү Үүдэл нээлтийн хүчин төгөлдөр шинж чанар оршино...

“Өнөөдөр манай Шүтлэг хүмүүсийн нүдэнд сул дорой мэт харагдаж, тэд түүнийг Исламын шашны цурав Мөчир юм уу өрнөдөд үй түмээрээ үржсэн шашны учир битүүлэг явцуу бүлэглэлийн нэг хэмээн буруутгаж байвч, Тэнгэрлэг Үүдэл нээлтийн энэхүү үнэлж баршгүй эрдэнэ болбоос өнөөдөр үр хөврөлийн шатнаасаа мултраагүй байгаа бөгөөд Түүний хууль зарлигийн лавайд хөгжин боловсорч, улмаар лавайнаасаа бүрэн бүтэн, хуваагдашгүй нэгэн цогцоор ил цухуйн гарч, эцэс сүүлдээ бүхий л хүмүүн төрөлхтнийг хамрах болно. Гагцхүү Бахауллагийн тэнгэрлэг байр суурийг хүлээн зөвшөөрсөн, Түүнд зориулсан хайраар зүрх сэтгэл нь бадамласан, Түүний сүнсний хүч чадлыг таньж ухаарсан тэдгээр хүмүүс л Түүнээс хүн төрөлхтөнд үнэлж баршгүй бэлэг болгон барьсан энэхүү Тэнгэрлэг Эмх журмын үнэ цэнийг бүрэн дүүрэн үнэлж чадах юм.” -1930 оны 3 дугаар сарын 21

Тэнгэрлэг гаралтай, бүхнийг хамрах хүрээтэй, зарчим сургаалдаа шударга, шинж чанараараа онцгой Дэлхийн шинэ Эмх журмыг байгуулах энэ зорилгод чухамдаа сандарч тэвдсэн хүн төрөлхтөн тэмүүлэх учиртай юм...

“Эрин үеийн оюун санааг огтхон ч үл анзааран, Бахауллагийн хэлснээр нэг бол дэлхий ертөнцийн эв нэгдэлд хүрэх, нэг бол мөхөх энэхүү эрин үеийн шаардлагад улс үндэстнүүд бие биеэсээ тасархай оршиж байсан балар эртний цагт л нийцэх үндэсний арга барилыг тохируулах гэж чармайж буй хүмүүний нийгмийн байгууллагуудын тэргүүн нарын оролдлого нь юутай өрөвдөлтэй вэ. Соёл иргэншлийн түүхэн дэх энэхүү эгзэгтэй үед дэлхийн том ч бай, жижиг ч бай, Дорных ч бай, Өрнийх ч бай, ялсан ч бай, ялагдсан ч бай, бүх улс үндэстнүүдийн тэргүүн нар бүгд Бахауллагийн бүрэн дуудлагыг чагнаархан анхаарч, Түүний Үйл хэрэгт үнэнч байж, дэлхий нийтийн хамтын нөхөрлөлийн үзэл санаагаар нэвт шингэн, Тэнгэрлэг Эмчийн өвчин эмгэгт нэрвэгдсэн хүн төрөлхтнийг анагаах цорын ганц төлөвлөгөөг бүхэлд нь хэрэгжүүлэн биелүүлэхээр зориглон босох хэрэгтэй

юм. Тэд нэгд нэгэнгүй аливаа атгаг үзэл бодол, аливаа үндэс угсаагаар ялгаварлах үзлээ таягдан хаяж, Бахауллагийн Сургаалын эрх бүхий Тайлбарлагч Абдул-Бахагийн эрхэм зөвлөмжийг анхаарваас зохилтгүй.

АНУ-ын холбооны засгийн газарт өндөр алба хашиж байсан нэгэн хүн засгийн газар ба ард түмнийхээ ашиг сонирхлыг хамгаалах хамгийн сайн арга замыг хэлж өгнө үү гэж Түүнээс асуусанд Абдул-Баха хариулахдаа:

*“Өөрийн албыг дэлхийн иргэний хувьд хашиж, орчин үед дэлхийн улс үндэстэн, ард түмнүүдийн хооронд оршиж буй харилцаанд танай орны Засгийн газрын үндэс болсон холбоот ёсыг аажмаар нэвтрүүлэхэд туслаж, хүч чадлаа дайчилваас та өөрийн орондоо хамгийн сайн зүтгэлийг үзүүлж чадна”* гэсэн байна...

“Дэлхийн дээд засаглалын ямар нэгэн хэлбэр хөгжин бий болж, үүний ачаар бүх улс үндэстнүүд аливаа дайн дажнаас сайн дураараа ангижирч, татвар оногдуулах тодорхой хэдэн эрх, тухайн нутгийнхаа дотоод дэг журмыг сахихаас өөр бусад зорилгоор зэвсэг хураах бүх эрхээсээ татгалзах болно. Ийм төр засаглалын бүрэлдэхүүнд хамтын нөхөрлөлийн аливаа дуулгаваргүй гишүүнд өөрийн дээд, маргашгүй эрх мэдлээ үзүүлэх ёстой олон улсын гүйцэтгэх байгууллага, тухайн улс орнуудын ард түмнээс сонгогдож, тухайн засгийн газраас нь зөвшөөрөгдсөн гишүүд бүхий Дэлхийн парламент, талууд өөрийн асуудлыг сайн дураараа дэвшүүлээгүй тохиолдолд гаргасан шийдвэр нь зайлшгүй мөрдөгдөх ёстой Дээд Шүүхийг багтаах юм. Эдийн засгийн аливаа саад тотгорыг арилгаж, хөрөнгө ба хөдөлмөрийн хооронд тодорхой харилцан үйлчлэл тогтож, шашны хэрүүл маргаан ба фанатизмын шуугиан үүрд намдаж, үндэс угсаа, арьсны өнгөөр ялгаварлах үзэн ядалт, дайсагналын гал мөнхөд унтарч, аливаа хууль зөрчигчийг тэр даруйд нь хүч хэрэглэн номхруулж, бүх нийтийн дэг журам, амгалан тайван байдлыг хангах үүргийг холбооны засгийн газруудын нэгдсэн хүчнүүдэд оногдуулах олон улсын хууль тогтоомжийн нэгдсэн цогцолбор бий болж, зөрүүд гөжүүд, дайсагнагч үндсэрхэг үзлийн уур хилэн

нь Дэлхийн Засгийн газартаа (ингэж Бахауллагийн зөгнөсөн Эмх журам өргөн утгаараа төсөөлөгддөг) хатуу үнэнч байх явдлаар солигдох дэлхийн хамтын нийгэмлэг нь аажим боловсрон гүйцэж буй эрин үеийн гайхамшигт үр жимс хэмээн тооцогдох ёстой эмх журам юм.

“Бахауллагийн Бүхнийг хамрагч Хуулийн эрмүүн зорилгын талаар ямар нэгэн эндүү ташаа ойлголт байх ёсгүй. Энэ зорилго нь одоогийн нийгмийн үндэс суурийг нураахад биш харин уг үндэс суурийг нь өргөжүүлж, байнга өөрчлөгдөн буй дэлхий ертөнцийн шаардлага хэрэгцээнд тохируулан байгууллагуудыг өөрчлөн байгуулахад оршиж байгаа юм. Энэ нь ухаалаг харъяалагтай зөрчилдөх юм уу төвийг сахих үндсэн зарчмыг үгүйсгэхгүй байгаа юм. Энэ хуулийн зорилго нь хүмүүсийн зүрх сэтгэлд эрүүл саруул бөгөөд ухаалаг эх оронч үзлийн галыг унтраахад биш, эсвэл үндэсний тусгаар тогтнолын тогтолцоог халахад биш харин хэт төвлөрлийн хор уршгаас зайлсхийхэд оршино. Энэ хууль нь дэлхийн улс үндэстэн, ард түмнүүд хоорондын гоо зүй, цаг уур, түүх, хэл яриа, зан заншил, сэтгэлгээ, зан үйлээр ялгагдах ялгааг үл тоомсорлож буй, эсвэл таягдан хаях гэж оролдож буй хэрэг биш юм. Энэ нь харин илүү өргөн хүрээний үйл явц, хүмүүн төрөлхтнийг урьд өмнө нь урин дуудаж байсан бусад өөр тэмүүлээс илүү эрхэм тэмүүлэлд уриалж байгаа юм...”

“Бахауллагийн дуудлага нь нэн тэргүүнд бөглүү тасархай, хөндий тусгаарлагдмал байдал болон аггаг сэжиг үзлийн бүх хэлбэрийн эсрэг чиглэж байдаг юм... Учир нь, аливаа хууль тогтоомж, улс төрийн болон эдийн засгийн онол нь хүн төрөлхтний ашиг сонирхлыг хамгаалан сахихын үүднээс бий болдгоос биш хүн төрөлхтөн өөрөө тодорхой нэгэн хууль юм уу догм номлолыг сахин хадгалахын тулд золиослогдох ёсгүй юм... Бахауллагийн бүх сургаалын тэнхлэг нь болсон Хүн төрөлхтний Эв нэгдлийн сургаал нь харанхуй бүдүүлэг сэтгэлийн хөдлөл юм уу сүсэг бишрэлийн бүдэг бадаг найдварын илэрхийлэл төдий бус юм... Түүний утга учир нь хавьгүй гүнзгий бөгөөд уриа дуудлага нь өмнөх үеийн Зөнч мэргэдийн хэзээ ч дэвшүүлж байгаагүйгээр агуу юм. Түүний илгээмж нь зөвхөн хувь хүнд хамаатай бус



харин нэн тэргүүнд бүх төр засаг, улс үндэстнүүдийг нэгэн гэр бүлийн гишүүд мэтээр хооронд нь холбож байдаг амин чухал харилцааны мөн чанарт хамаатай юм...

“Тэр<sup>1</sup> нь хүмүүний хувьсал хөгжлийн төгс боловсролыг төлөөлж байгаа юм...”

“Дэлхий дахиныг хамарсан гай гамшгийн хүч л ганцхан хүмүүний сэтгэлгээний ийм шинэ үе шатыг авчирч чадна гэдэг нь, харамсалтай нь, улам улам илэрхий болж ирж байна... Гагцхүү ийм нэгэн аймшигт сорилт шалгуурыг давснаар хал үзэж хашир суусан хүн төрөлхтөн шинэ эрин үеийн тэргүүн нарын үүрэх тэрхүү үүрэг хариуцлагын үзэл санааг ухамсарлаж чадах юм... Абдул-Баха Өөрөө зүйрлэшгүй хэлээрээ “Өмнөхөөс ч илүү ширүүн дайн лавтайяа дэгдэнэ” гэж хэлээгүй бус уу. 1931 оны 11 дүгээр сарын 28

“Энэхүү Засаг захиргааны Журмын бүхий л бүрэлдэхүүн хэсэг, үндсэн байгууллагууд нь үр дүнтэй, эрч хүчтэйгээр ажиллаж эхэлж, уриа дуудлагаа илэрхийлж, хүч чадавхиа нээн үзүүлэх тусам энэхүү Журмыг сайн цагийн эхэнд хүн төрөлхтнийг бүхэлд нь хамрах Дэлхийн Шинэ Эмх журмын үр хөврөл төдийгүй жинхэнэ хэв загвар нь юм гэж тооцох болно...”

“Өмнөх үед байсан бүхий л Үүдэл нээлтийн дундаас энэхүү Шүтлэг нь ... өөрийн хосгүй бүгцийг сүндэрлүүлэн босгож амжсан бөгөөд хоцрогдож нурсан итгэл үнэмшил, номлолын төөрөгдсөн дагалдагчид тэрхүү бүгцэнд ойртон дөхөж, шүүмжлэлтэйгээр шүүн үзээд цаг хугацаа оройтохоос өмнө дэлхийг ивээсэн түүний нөмөр дор халиршгүй энх тунх байдлыг олж болох юм...”

*“Энэхүү нэн агуу шинэ Дэлхийн Эмх журмын нөлөөгөөр дэлхий ертөнцийн тэнцвэр алдагдсан болой. Хүн төрөлхтний хэвийн амьдрал зуурдын орчлонд урьд өмнө нь хэзээ ч үзэгдэж байгаагүй энэхүү хосгүй гайхамшигт Тогтолцооны нөлөөгөөр хувьсгалжин шинэчлэгдсэн болой”.*

...Бахауллагийн энэ айлдвар ирээдүйн Бахайн хамтын нийгэмлэгийн үндэс суурь нь болсон энэхүү Засаг захиргааны

Журмын тодруулан нээх хүч чадал, сүр жавхлангаас өөр юу баталж байгаа юм бэ?

“Цорын ганц загвар нь, энэхүү Засаг захиргааны өргөн Журам болсон ирээдүйн Бахайн Хамтын нийгэмлэг нь онолын хувьд ч, бодит байдлаараа ч улс төрийн байгууллагуудын бүхий л түүхэнд урьд нь үзэгдэж байгаагүй онцгой өвөрмөц шинжтэй төдийгүй дэлхийд түгээмэл аливаа шашны тогтолцоотой зүйрлэхийн аргагүй хосгүй юм. Төгс төгөлдөр Уран барилгачийн уран Мутраар цогцлогдон бүрдсэн Засаг захиргааны Журмыг ардчилсан засаглалын ямар ч хэлбэр, хаант засаглал ч бай, эсвэл бүгд найрамдах улсын засаглал ч бай, эрх мэдэл дарангуйллын ямар ч тогтолцоо, цэвэр аристократ (засгийн эрх нь онцгой эрх бүхий хэсэг хүний мэдэлд байх-орч) эмх журмын завсрын тогтолцоо, тэр ч бүү хэл, Иудейн хамтын нийгэмлэг ч бай, Христийн шашны аливаа байгууллага ч бай, эсвэл Исламын шашны Имамын юм уу Халифагын засаглал ч бай, ер нь өнөө үед хүлээн зөвшөөрөгдсөн лам нарын ямар ч засаглалын хэлбэртэй адилтгах, харьцуулахын аргагүй юм...”

“Нялх балчир үедээ буй уг Тогтолцооны ач холбогдлыг нь хэн ч басамжлах юм уу зорилгыг нь гуйвуулах ёсгүй билээ. Энэхүү Засаг захиргааны Журмын үндэслэсэн тэр хөрс үндэс нь өнөөдрийн хүн төрөлхтөнд Бурханаас айлдсан цаазат төлөвлөгөө юм. Уг Журам өөрийн онгод хүчийг шавхдаг тэр Эх үүсвэр нь Бахауллагаас өөр хэн ч биш билээ... Энэ Журмын гол үндсэн зорилго нь болбоос Бахауллагийн айлдсаны дагуу Дэлхийн Шинэ Эмх Журмыг байгуулах явдал юм. Энэ Журмыг байгуулахад ашиглах арга барил, нэвтрүүлэх хэм хэмжүүр нь Өрнө, Дорнын алинд нь ч, Иудей, Иудей бишийн алинд нь ч, баян ядуугийн алинд нь ч, цагаан арьстан ба өнгөт арьстны алинд нь ч илүү нийцдэггүй юм. Түүний уриа нь бүх л хүн төрөлхтний нэгдэл, түүний тэмүүлэл нь “Нэн Агуу Энх тайван” юм.” 1934 оны 2 дугаар сарын 8

“Бурханы Шүтлэгийн Засаг захиргааны Журмын хөгжил өсөлтийг дагалдаж буй тогтвортой бэхжилтийн улам арвижиж буй нотолгоо болон ядарч туйлдсан нийгмийн бүтцийг ганхуулж буй

задраан бутраах хүчнүүдийн хоорондын эрс ялгаа нь тодорхой бөгөөд гайхалтай. Бахайн ертөнцийн дотор болон гадна нь Бурханы Үйл хэргийн Алтан Үеийг авчрах тэрхүү Дэлхийн Эмх Журам үүсэн төрөхийг оньсого мэт гайхалтай байдлаар зарлан зөгнөж буй шинж тэмдгүүд нь өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байна...

Бахаулла Өөрөө айлдсанчлан *“Удахгүй өнөө үеийн Эмх журам хураагдаж, оронд нь шинэ Эмх журам дэлгэгдэн дэвсгэгдэнэ.”*...

“Бахауллагийн Үүдэл нээлтийн ирснийг... хүмүүн төрөлхтөн нас бие гүйцэж буйн дохио, бэлгэдэл хэмээн үзвээс зохино. Энэ Үүдэл нээлтийг зөвхөн хүн төрөлхтний байнга өөрчлөгдөн буй хувь тавилан дах бас нэг оюун санааны сэргэлт, зөвхөн хөгжин дэвших Үүдэл нээлтүүдийн гинжин холбоон дах ээлжит үе шат, зөвхөн үе үе дараалсан Зөнч мэргэдийн тойргийн нэгэн цуврал дах оргил гэхээсээ энэ гараг дэлхий дээр хүмүүний хамтын амьдралын гайхалтай хувьсал өөрчлөлтийн сүүлчийн бөгөөд дээд үе шатыг төлөөлж байгаа хэмээн үзэх ёстой юм. Бахайн Эриний Алтан Үеийн анхны үе шатуудтай давхцах учиртай дэлхийн нийгэмлэгийн хөгжил, дэлхийн иргэншлийн ухамсар болон дэлхийн соёл иргэншлийн үүсэл нь хувь хүн хэдийгээр энэ бүхний улмаас хязгааргүйн харгуйд байнга хөгжин дэвших ёстой ч, гараг дэлхийн амьдралтай холбон дүгнэвэл мөн чанартаа хүний нийгмийн зохион байгуулалтын дээд хэлбэр юм.

“Бахауллагийн зөгнөсөн хүн төрөлхтний эв нэгдэл гэдэг нь дэлхийн бүх улс үндэстнүүд, үндэстэн ястнууд, анги давхаргуудыг хооронд нь нягт бөгөөд үүрд нэгтгэж, гишүүн орнуудынхаа тусгаар тогтнол болон тэдгээрийг бүрэлдүүлж байгаа хувь хүмүүсийн эрх чөлөө, санаачлагыг бүрэн дүүрэн сахин хамгаалсан дэлхий нийтийн хамтын нийгэмлэгийг байгуулна гэсэн утгатай юм. Бидний төсөөлж буйгаар энэ хамтын нийгэмлэгт дэлхийн хууль засаглал багтах бөгөөд гишүүд нь хүн төрөлхтний итгэлийг хүлээж, эцэс сүүлдээ бүх гишүүн орнуудын бүх нөөцийг хянаж, бүх улс үндэстэн, ард түмнүүдийн амьдралыг зохицуулж, шаардлага хэрэгцээг нь хангаж, харилцаа холбоог нь тохируулан нийцүүлэх хуулийг тогтоож өгөх юм. Дэлхийн гүйцэтгэх

байгууллага нь олон улсын Хүчнүүдийн тусламжтайгаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлж, дэлхийн шүүх засаглалаас тогтоосон хуулийг нэвтрүүлж, нийт хамтын нийгэмлэгийн эв нэгдлийг сахин хамгаалах юм. Дэлхийн шүүх нь энэхүү даян дэлхийн тогтолцоог бүрдүүлсэн янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хооронд гарсан аливаа маргааны талаар эцсийн бөгөөд зайлшгүй мөрдөгдөх шийдвэр ялыг тогтоон гаргах үүрэгтэй байх юм. Дэлхийн улс түмнүүдийн хоорондын харилцааны механизм бий болж, бүх л гараг дэлхийг хамарч, энэ нь ямар ч үндэстний саад хязгаарлалтаас чөлөөтэй байх бөгөөд гайхалтай хурдтайгаар тогтмол үйлчлэх болно. Дэлхийн нийслэл нь дэлхийн соёл иргэншлийн мэдрэлийн төв болж, амьдралын нэгтгэгч хүчнүүдийн тэмүүлэх төв хийгээд эрч хүч сэргээх нөлөөг цацруулах юм. Дэлхийн хэлийг зохион бүтээх юм уу эсвэл одоогийн хэлнүүд дотроос аль нэгийг нь сонгон авч, энэ хэлийг хамтын нийгэмлэгийн бүх улс орнуудад төрөлх хэлээс нь гадуур туслах хэл болгон бүх сургуулиудад заана. Дэлхийн бичиг, дэлхийн уран зохиол, мөнгөн тэмдэгт, жин хэмжүүр зэргийн нэгдсэн түгээмэл тогтолцоо нь хүн төрөлхтний ард түмнүүд, үндэстэн ястнуудын хоорондын харилцаа холбоо, бие биеэ ойлголцох явдлыг хялбаршуулан хөхүүлэн дэмжих болно. Ийм дэлхийн нийгэмд шинжлэх ухаан, шашин хоёр нь хүмүүний амьдралын нэн хүчирхэг хоёр хүчин зүйлийн хувьд хоорондоо эвсэн, хамтран ажиллаж, хамтын уялдаатайгаар хөгжин дэвших болно. Хэвлэл нийслэл нь ийм тогтолцоон дор хүн төрөлхтний олон ургалч үзэл бодол, итгэл үнэмшлийг бүрэн дүүрэн илэрхийлэх бөгөөд хэн нэгэнд ашигтай хувийн юм уу олон нийтийн ашиг сонирхлоор үл хөтлөгдөж, тэмцэлдэн зөрчилдөж буй засгийн газрууд, ард түмнүүдийн нөлөөнөөс ангижирна. Дэлхий ертөнцийн эдийн засгийн нөөцийг зохион байгуулж, түүхий эдийн нөөцийг олборлон бүрэн дүүрэн ашиглаж, зах зээлийг хөгжүүлэн зохицуулж, бүтээгдхүүнийг тэгш хуваарилна.

“Үндэстэн хоорондын өрсөлдөөн, үзэн ядалт, хуйвалдаан зогсож, үндэстэн ястны хоорондын дайсангал, атгаг сэжиг үзэл нь найрсаг харьцаа, ойлголцол болон хамтын ажиллагаагаар солигдоно. Шашны тэмцлийн эх үүсвэр нь үүрд орхигдож,

эдийн засгийн саад тогтгор хязгаарлалт нь бүрэн устаж, ангийн ялгааны явцуу ойлголт нь арчигдан алга болно. Ядуурал хоосрол нэг талаас, эд баялаг хэт их төвлөрөх явдал нөгөө талаас үгүй болно. Дайн дажин хийхэд зарцуулж үрсэн эдийн засгийн болон улс төрийн үлэмж их эрчим хүчийг шинэ зохиол бүтээл гаргах, техникийг хөгжүүлэх, хүн төрөлхтний үр бүтээмжийг нэмэгдүүлэх, өвчин эмгэгийг анагаан, хорогдуулах, шинжлэх ухааны судалгаа шинжилгээг өргөтгөх, бие бялдрын эрүүл ахуйн хэм хэмжээг өндөрсгөх, хүний оюун ухааныг хөгжүүлэн боловсруулах, гараг дэлхийн ашиглагдаагүй, урьд өмнө нь нээж байгаагүй нөөцийг олборлож, хүний амьдралыг уртасгах, бүхий л хүн төрөлхтний оюуны, ёс суртахууны болон сүсэг бишрэлийн амьдралыг баяжуулан эрчимжүүлэх аливаа үйлсийг урагшлуулахад чиглүүлэн зарцуулах юм.

“Бүх л дэлхийг захирч, элбэг дэлбэг нөөц баялгийг эзэмших дийлдэшгүй эрх мэдэлтэй, Өрнө, Дорнын алиных нь ч хүсэл тэмүүллийг илэрхийлэн хэрэгжүүлж, дайн ба дайны хор уршгаас ангижирсан, гараг дэлхийн гадаргуу дээрх эрчим хүчний бүх л эх үүсвэрийг олборлон ашиглахыг эрмэлзэх дэлхийн нийгэмлэгийн тогтолцоо, Хүч чадал нь Шударга Ёсны боол болж, амьдрал нь цорын ганц Бурханыг бүх нийтээрээ таньж мэдэх явдлаар тэтгэгдэх тогтолцоо нь чухамхүү амьдралын хүчээр нэгдсэн хүн төрөлхтний тэмүүлж буй зорилго юм...”

“Бүх л хүмүүн төрөлхтөн ёлон шаналж, эв нэгдэлдээ хүрч, он удаан түүхийнхээ зовлонгоос ангижрах юмсан хэмээн мөрөөсөж байна. Гэвч хүн төрөлхтөн зовлон шаналлаас ангижруулах, мөдхөн залгих гэж сүрдүүлж буй аймшигт гай гамшгаас холдуулж чадах тэрхүү цорын ганц Хүчийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзан зөрүүдлэж байна...”

“Бүх хүн төрөлхтний нэгдэл нь хүмүүний нийгмийн өнөөгийн ойртон дөхөж буй үе шат юм. Гэр бул, омог, хот, улс үндэстний эв нэгдэл нь үе шат дамжин хөгжиж, амжилттайгаар биелсэн билээ. Харин сандарч тэвдсэн хүн төрөлхтөн дэлхийн эв нэгдэлд одоо тэмүүлж буй. Улс үндэстний бүрэлдэн тогтох явдал эцэстээ хүрчээ. Төр улсын тусгаар тогтнолын нэгэн шинж болох анархи нь

оргил цэгтээ хүрч явна. Нас бие гүйцэж буй дэлхий ертөнц энэхүү төөрөгдлөөсөө холдож, хүмүүн хоорондын нэг нэгдмэл, бүрэн бүтэн байдлыг хүлээн зөвшөөрч, амьдралынхаа энэхүү үндсэн зарчмыг хамгийн ихээр нэвтрүүлэх тэр зохион байгуулалтыг бий болгох ёстой юм.”

*1936 оны 3 дугаар сарын 11*



## ТӨГСГӨЛИЙН ҮГ

Шоги Эффендигийн урамшуулан зоригжуулсан удирдлагын дор Бахай Шүтлэг хэмжээ хүрээний хувьд түргэн өсөж, улмаар Засаг захиргааны журмаа байгуулан 1951 он гэхэд арван нэгэн Үндэсний Оюун Санааны Чуулга ажиллаж байлаа. Энэ үед Асран тэтгэгч олон улсын түвшинд Шүтлэгийн байгууллагуудыг хөгжүүлэхэд хүч чармайлтаа чиглүүлж, Даян Дэлхийн Шударга Ёсны Ордоны замыг бэлтгэн тавих Олон улсын Бахайн Зөвлөлийг томилж, дараагаар нь Бурханы Үйл Хэргийн Мутаруудыг томилжээ. Түүний дотор Шоги Эффенди зарим гарамгай, нэрт хүндтэй Бахайчуудыг Үйл хэргийн Мутараар нөхөн томилсон бөгөөд энэ дунд Др.Жон Е.Ессемонтыг бас нөхөн томилсон юм. 1951 оноос хойш Асран тэтгэгч Бурханы Хэргийн Мутаруудын энэхүү чухал байгууллагыг бүрэн дүүрэн хөгжүүлж эхэлсэн юм. 1951-1957 оны хооронд тэрээр гучин хоёр Мутарыг томилж тэдний үйл ажиллагааг дэмжүүлэх зорилгоор тив бүрт Туслах Зөвлөлүүдийг байгуулсан бөгөөд Үйл хэргийн Мутарууд эдгээр Туслах Зөвлөлүүдийн Гишүүдийг өөрсдийн орлогч, туслагч, зөвлөгч нараар томилж байсан юм. Шоги Эффендиг тэнгэрт халих үед хорин долоон Мутар сэрүүн тунгалагаараа байжээ.

Дэлхий дахины Бахайчуудад болон заримдаа аль нэгэн орны Бахайчуудад хандан Асран тэтгэгч маш олон цуврал захидгуудыг бичиж, сургаалын талаарх тэдний ойлголтыг гүнзгийрүүлэн, Шүтлэгийн засаг захиргааны байгууллагуудыг хөгжүүлж сүсэгтнүүдийг энэ журмыг хэрхэн зөв үр ашигтай ашиглах талаар сургаж байсан бөгөөд 1937 онд Бахауллагийн Сургаалыг түгээн дэлгэрүүлэх Тэнгэрлэг Төлөвлөгөөг хэрэгжүүлэх гарааг тавих үүргийг Америкийн Бахайн нийгэмлэгт даалгасан байна. Энэхүү Тэнгэрлэг Төлөвлөгөөг Абдул Баха Өөрийн Илгээлт бичигт Дэлхийн нэгдүгээр дайны үеэр бичиж байсан бөгөөд эдгээр Илгээлт бичгүүд нь энэ Шүтлэгийг дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлэх ажлын даган мөрдөх дүрэм болдог билээ.

Энэхүү дүрмийн хүрээнд сургаалыг дэлгэрүүлэх хэд хэдэн төлөвлөгөөт ажлыг зохиож эхлээд бөмбөрцгийн баруун талд дараа

нь Евро Ази, Австралази, Африк тивд зохион байгуулсан бөгөөд 1953 онд Асран тэтгэгч “Арван жилийн хугацаатай, дэлхийг хамарсан оюун санааны давшилт”-ыг зарлаж дэлхий ертөнцийн бусад бүх өнцөг булан бүрт сургаал хүрээгүй тусгаар тогтносон улс гүрэн, газар нутаг бүрт Шүтлэгийг хүргэх төлөвлөгөөг уриалан зарласан юм.

1957 онд арван жилийн давшилт ид дундаа орох гэж байхад гучин зургаан жилийн турш цуцалтгүй хөдөлмөрлөсөн Асран тэтгэгч Лондонд ажлаар айлчиж байх үеэрээ тэнгэрт хальсан юм.

Шоги Эффенди залгамжлагчгүй байсан учраас 1957 оны 11 дүгээр сараас хойш Шүтлэгийн ажил хэргийг хорин долоон Бурханы Хэргийн Мутар гардан удирдаж байсан бөгөөд 1963 онд арван жилийн давшилтын төлөвлөгөө ялалт амжилттайгаар өндөрлөсөн тэр үед Үйл хэргийн Мутаруудын тусламжтайгаар Хайфа хот дах Бахайн Дэлхийн Төвд болсон Чуулганаар тавин зургаан Үндэсний Оюун Санааны Чуулгын гишүүдийн саналаар анх удаагаа Даян Дэлхийн Шударга Ёсны Ордоныг сонгосон билээ.

Энэхүү түүхэн сонгуулийн дараагаар гараг ертөнцийн өнцөг булан бүрээс ирсэн Бахайчууд Лондон хотод Бахай Шүтлэгийн дэлхий анхны Конгресст хуран цугларч Бахауллагийн Тунхаглалын зуун жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэж, мөн Бахауллагийн Шүтлэг дэлхий дахинаа түгэн дэлгэрсэн явдалд баярлан цэнгэлдсэн билээ.

Бахай Шүтлэгийн дээд байгууллага болох анх Бахауллагийн “Хамгаас Ариун Сударт” дурдагдсан Даян Дэлхийн Шударга Ёсны Ордон нь Бахайн сургаал бичмэлд тусгагдаагүй аливаа асуудлаар хууль шийдвэрийг гаргах эрхтэйг Ариун Сударт бас тодорхой заасан байдаг юм. “Хүсэл зориг ба Гэрээслэл”-дээ Абдул Баха Даян Дэлхийн Шударга Ёсны Ордоныг сонгох арга барилыг зааж энэ байгууллагын байр суурь, үүрэг хариуцлагыг илүү тодорхойлон бичиж энэхүү байгууллага нь Баб, Бахаулла нарын шууд удирдлага тусламжин дор алдаа мадаггүй шийдвэр гаргах байгууллага агаад бүгд түүн рүү хандах ёстой гэж айлдсан билээ.

Бахай Шүтлэгийн өвөрмөц онцлог нэгэн шинж болбоос Бахауллагийн Гэрээс юм. Уг Гэрээс нь Шүтлэгийн бүхий л бүтцийг тавьж өгөөд зогсоогүй мөн ирээдүйнх нь хөгжлийн эх суурийг тавьж өгсөн юм. Уг Гэрээсийн онцлог шинж нь цашны түүхэнд анх удаа Бурханы Тодруулагч маш тодорхой, уран яруу хэлээр Өөрийн Үгийг тайлбарлах албан ёсны эрх бүхий залгамжлагчийг томилж, үүгээр Шүтлэгийн Эх үүсвэрээс ундрах тэнгэрлэг эрх мэдэл үеийн үед үргэлжлэх ёстойг баталгаажуулсан юм.

Ариун судар бичгүүдийг дур мэдэн тайлбарлан ухуулах нь өмнөх шашнуудын хувьд хагарал бутрал үүсэх гол шалтгаан болж ирсэн юм. Бахаулла Өөрийн “Гэрээслэлийн Сударт” ууган хүү Абдул-Бахаг залгамжлагчаар томилон Өөрийн Сургаал айлдварыг албан ёсоор тайлбарлах эрх мэдлийг олгож, Үйл хэргийг удирдан чиглүүлэх тэргүүнээр томилсон юм. Абдул-Баха Өөрийн “Хүсэл зориг ба Гэрээслэл”-д ууган зээ хүү Шоги Эффендиг Шүтлэгийн Асран тэтгэгч ба Сургаал айлдварыг албан ёсоор тайлбарлах цорын ганц эрх бүхий хүнээр томилсон билээ. Бахай Шүтлэгт ямар ч лам хуврагын тогтолцоо байхгүй бөгөөд ямар ч хүнд бусдаас дээгүүр онцгой байр суурь олгогдоогүй бөгөөд бүх эрх мэдэл гагцхүү Бахайн сургаалд айлдсанчлан Шүтлэгийн байгууллагуудад ногддог юм.

Энэхүү өвөрмөц хуулийн ачаар Бахауллагийн Шүтлэг хагарал бутралаас аврагдаж өнгөрсөн цагт шашны эв нэгдлийг бутраахын эх сурвалж болсон албан ёсны бус нэг хүнийг тахин шүтэх явдал элдэв янзын зохиомол догм номлол онол сургаалаас хамгаалагдсан юм. Бахауллагийн Бүтээлч Үг айлдвар нь албан ёсны тайлбартайгаар ариун нандин, хөдлөшгүй үнэн хэвээр үлдэж энэхүү Эрин үеийн турш хүмүүст оюун санааны амьдралыг хайрлах алдаа Мадаггүй эх үүсвэр болж ирсэн билээ.

1968 онд Даян Дэлхийн Шударга Ёсны Ордоноос Бурханы Үйл хэргийн Мутаруудын Шүтлэгийг дэлгэрүүлэн хамгаалах үүргийг ирээдүйд биелүүлэх Тивийн Зөвлөхүүдийн Товчоодыг байгуулсан юм. Товчоо бүр нь Даян Дэлхийн Шударга Ёсны Ордоноос томилогдсон хэд хэдэн Зөвлөхүүдээс бүрддэг юм. Тэд Бурханы Үйл хэргийн Мутаруудтай дотно хамтран ажиллана.

Харин Туслах Зөвлөлүүдийг томилон чиглүүлэх үүрэг нь эдүгээ Зөвлөлүүдийн Товчооны үүрэг болсон юм. Бурханы Хэргийн Мутаруудаас эдүгээ гурав нь амьд сэрүүн байгаа бөгөөд тэдний буянт үйл ажиллагаа дэлхий дахиныг хамарч байна.<sup>1</sup>

Ирээдүйд Даян Дэлхийн Шударга Ёсны Ордоны удирдлаган дор хэрэгжүүлэгдэх дэлхий дахинд сургаал дэлгэрүүлэх төлөвлөгөөний талаар Асран Тэтгэгч айлдан бичсэний дагуу 1964-1973 онд 9 Жилийн Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн юм. Одоо 1972 онд Бахай Шүтлэг 130 гаруй тусгаар тогтносон улс оронд дэлгэрсэн болно.<sup>2</sup> Бахай сүсэгтнүүд дэлхий дахинаа 60 мянга гаруй хот тосгонд амьдарч<sup>3</sup>, Бахайн уран зохиол 430 гаруй хэлэнд орчуулагдан нийтлэгдсэн бөгөөд Бахайн мөргөлийн тав дах ордныг Панам хотод барьж дуусгасаны дээр 58 газар ирээдүйн Мөргөлийн ордныг байгуулах газрыг худалдан аваад байна<sup>4</sup>. Дэлхий даяар нийт 113 Үндэсний Оюун Санааны Чуулга 10000 гаруй Орон Нутгийн Оюун Санааны Чуулга ажиллаж байна.<sup>5</sup>

Хамгийн урам хайрласан мэдээ бол Африк, Энэтхэг, Зүүн өмнөд Ази, Латин Америкт эдгээр газар нутгийн уугуул иргэд үй түмээрээ энэ Шүтлэгт элсэн орж, дэлхийн Бахайн нийгэмлэгийн засаг захиргааны болон нийгмийн үйл ажиллагааны хөгжилд шинэ үе шатыг авчирсан билээ.

---

1 Энэхүү номыг бичиж байх үед гурван Бурханы Хэргийн Мутар сэрүүн тунгалаг байсан байсан бөгөөд эдүгээ бүгд Бурханы Оронд одсон юм.

2 Одоо 2013 оны байдлаар Бахай Шүтлэг 190 гаруй тусгаар тогтносон улс оронд дэлгэрсэн болно.

3 Бахай сүсэгтнүүд дэлхий дахинаа 100 мянга гаруй хот тосгонд амьдарч байна.

4 Бахайн мөргөлийн найм дах ордныг Чилийн Сантьяго хотод барьж байна

5 2008 оны мэдээгээр нийт 184 Үндэсний Оюун Санааны Чуулга сонгогдон ажиллаж байна.